Монгол Улс
Хүнс, Хөдөө Аж Ахуй, Хөнгөн Үйлдвэрийн Яам
Эдийн засаг, Хөгжлийн яам

Монгол Улсын Хөдөө Аж Ахуйн нэмүү өртгийн сүлжээний Мастер төлөвлөгөө боловсруулах төсөл

Мастер төлөвлөгөө

2024 оны 1 сар

Японы Олон Улсын Хамтын Ажиллагааны Байгууллага (ЖАЙКА)

NTC International Co., Ltd.

E D
J R
24−006

Монгол Улсын

Хөдөө Аж Ахуйн нэмүү өртгийн сүлжээний Мастер төлөвлөгөө боловсруулах төсөл

Хураангуй агуулга

1. Хөдөө Аж Ахуйн салбарын нэмүү өртгийн сүлжээг хөгжүүлэх Мастер төлөвлөгөөний тухай

1.1 Мастер төлөвлөгөө боловсруулах үндэслэл ба зорилго

Монгол Улсын Хөдөө аж ахуйн салбар нь уул уурхайн салбарын дараагаар ордог, ДНБ-ий 12.8%-г (2022 он) үйлдвэрлэдэг, хөдөлмөрийн насны хүн амны 30% орчим нь ажил эрхэлдэг, тус улсын эдийн засгийн голлох салбар юм. Сүүлийн жилүүдэд Монгол Улсын Засгийн газраас уул уурхайн салбараас хамааралтай эдийн засгийн бүтцээс ангижрах зорилтыг тавьж буй бөгөөд, Хөдөө аж ахуйн салбар нь Монгол Улсын эдийн засгийг төрөлжүүлэхэд томоохон үүрэг гүйцэтгэх салбар гэдгээрээ анхаарал татаж байна. Гэвч Мал аж ахуйн салбарын хувьд гэхэд хот суурины ойр орчмын бүсэд хэт олон мал төвлөрч, тоо толгойн өсөлтөөс хамааран бэлчээрийн даац хэтэрч, бэлчээр талхлагдах, ган зудын гамшигт нэрвэгдэх, түүнчлэн шүлхий зэрэг халдварт өвчний эсрэг авах арга хэмжээ хангалтгүй байгаа нь тулгамдсан асуудал болж байна. Мөн Газар тариалангийн салбарт төрөөс хэрэгжүүлсэн бодлогын үр нөлөөгөөр нийт тариалсан талбай болон хураан авах ургацыг хэмжээ нэмэгдэж, дотоодынхоо хэрэгцээг хангах хувь хэмжээ сайжирч байгаа хэдий ч хүйтэн сэрүүний улирлын турш дахь тогтвортой үйлдвэрлэл, нийлүүлэлтийн тогтолцоо бүрэн дүүрэн бүрдээгүй байна. Эдгээр нөхцлийг харгалзан ЖАЙКА байгууллагаас ХХААХҮЯ болон ЭЗХЯ-наас гаргасан төслийн хүсэлтийг хүлээн авч, МУ-ын бүс нутгийн онцлог хүчин зүйлсийг тусгасан стратегийн ХАА-н нэмүү өртгийн сүлжээг хөгжүүлэх Мастер төлөвлөгөөг боловсруулав.

1.2 Мастер төлөвлөгөөний байр суурь

Энэхүү Мастер төлөвлөгөөг Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичиг болох “Алсын хараа 2050” болон дунд хугацааны хөгжлийн төлөвлөгөө болох “Таван жилийн хөгжлийн үндсэн чиглэл” , мөн “Засгийн газрын мөрийн хөтөлбөр”-тэй уялдуулан боловсруулсан. Мөн 2022 оны 6 сарын 27-нд “Хүнсний хангамж аюулгүй байдлыг хангах зарим арга хэмжээний тухай” УИХ-ын 36 дугаар тогтоол батлагдсан. Энэхүү тогтоолоор Монгол Улсын хүнсний хангамж, аюулгүй байдлын талаар тодорхой хөгжлийн чиглэл, төлөвлөгөөг баталсан бөгөөд Мастер төлөвлөгөөг боловсруулахдаа тус тогтоолоор батлагдсан хөгжлийн чиглэл, төлөвлөгөөтэй уялдуулахыг зорьсон.

1.3 Хамрах хүрээ болон зорилтот хугацаа

Энэхүү Мастер төлөвлөгөөний хамрах хүрээ нь Монгол Улсын нийт нутаг дэвсгэрийг хамрах бөгөөд төлөвлөгөөний зорилтот хугацаа нь 2025-2034 он хүртэл 10 жилийг хамрах юм.

2. Монгол Улсын ХАА-н салбарын хөгжлийн стратеги

2.1 МУ-ын ХАА-н салбарын хөгжлийн түүх

(1) Бусад орнуудтай харьцуулсан харьцуулалт

Зураг 2.1-т өнгөрсөн 10-н жилийн (2012-2021) хугацаанд Монгол болон бусад орнуудын ХАА-н ДНБ-ий дундаж өсөлтийг харуулав. Монгол Улсад УУБ-ний үнийн уналтаас үүдэлтэй ЭЗ-ийн өсөлтийн зогсонги байдал болон Ковид-19-ийн нөлөө үргэлжилж байгаа хэдий ч ХАА-н ДНБ-ий дундаж өсөлт нь 4.25% буюу харьцангуй өндөр үзүүлэлттэй байна. Энэ нь дэлхийн дундаж болох 3.54%-иас өндөр үзүүлэлт бөгөөд ялангуяа ХАА-н салбарын өсөлт өндөртэй Зүүн Ази, Номхон далайн бүсийн орнуудын дундаж өсөлттэй бараг адил байна. Мэдээж хэрэг Энэтхэг, Хятад зэрэг ХАА-н салбарын өсөлт хурдацтай хөгжиж байгаа орнуудын эдийн засгийн цар хүрээ нь Монголтой харьцуулахад газар тэнгэр шиг зөрүүтэй, ХАА-н ДНБ-ий үнэмлэхүй үзүүлэлтээр Монгол Улс нь тэдгээртэй харьцуулахад хэд дахин дутуу ч ХАА-н үйлдвэрлэл явуулахад байгаль цаг уурын орчин нөхцөл төдийлэн таатай биш Монгол орны хувьд ХАА-н ДНБ энэ хэмжээний өсөлттэй байгаа нь яах аргагүй Засгийн газар болон ХАА-н салбарт ажиллагсдын хүчин зүтгэл, оруулж буй хувь нэмрийн үр дүн бизээ.



Зураг 2.1 Улс орнуудын ХАА-н ДНБ-ний дундаж өсөлт (2012-2021)
Эх сурвалж: ДБ-ны мэдээлэлд үндэслэн ЖАЙКА төслийн баг боловсруулав.

(2) ХАА-н салбарын хөгжлийн суурь

Тэгвэл яагаад Монголын ХАА ийнхүү огцом хөгжсөн байна вэ. Өнгөрсөн 10 жилийн хугацаан дахь ХАА-н ДНБ-ий өсөлтөд ХАА-н холбогдолтой статистикийн мэдээллийг ашиглан регрессийн шинжилгээ хийж, статистик үзүүлэлтүүдийг ХАА-н ДНБ-ийн өсөлтөд үзүүлж буй нөлөөллийг тодруулж үзэв. (Зураг 2.2)

Юуны өмнө хамааран хувьсагч болох ХАА-н ДНБ-ий хувьд, 2016-2017 онд УУБ-ний үнийн уналтаас шалтгаалж Монголын эдийн засаг нийтдээ зогсонги байдалд орж ХАА-н ДНБ-ний өсөлт ч зогсох магадлалтай үе байсан хэдий ч, нийт салбар ерөнхийдөө өсөх хандлагатай байжээ. Нөгөө талаар, шалтгаант (бие даасан) хувьсагчийг ерөнхийд нь 1) Зах зээл, 2) Үйлдвэрлэлийн хэмжээ, 3) Бүтээмж, 4) Үнэ цэнэ гэж ангилан, ангилал бүрт харгалзах статистик мэдээллийг ашиглан шинжилж үзэв.



Монгол улсын ХАА-н салбарын ДНБ (өнөөгийн үнээр)-ийн өсөлт (сая төг.)

- **Microsoft Excel ашиглан регресс шинжилгээ хийв.**
- **ХАА-н үйлдвэрлэлийн тоо баримтын хувьд MYCX-ны мэдээллийг ашигласан https://www.1212.mn/mn)**
- **Худалдааны холбогдолтой тоо баримтад HYБ-ын Comtrade-ын мэдээллийг ашигласан. https://comtradeplus.un.org)**

*** 5%-ийн ашгийн түвшин ** 1%-ийн ашгийн түвшин**
※2012-2021 оны тухайн бүтээгдэхүүний экспортын үнийн дүнг нийт экспортын хэмжээнд хуваах нэгжийн арилжаалсан дундаж үнийг олсон. Энэхүү нэгжийн дундаж үнийг доорхи байдлаар ангилсан.

Өндөр үнэ: Арилжааны дундаж үнэ＞100USD/ нэгж бүт.
Дундаж үнэ: 100USD /нэгж бүт> Арилжааны дундаж үнэ ＞ 10USD/ нэгж бүт.
Бага үнэ : Арилжааны дундаж үнэ ＜10 USD/нэгж бүт.

Ангилал	Индикатор	R^2	Ашиг
Зах зээлийн хэмжээ	Хүн ам (хүн)	0.8684	**
Зах зээлийн хэмжээ	МАА,ГТ-н бүтээгдэхүүний экспортын үнийн дүн (ам. доллар)	0.6902	**
Бүтээгдэхүүний хэмжээ	ГТ- нийт тариалсан талбар, га	0.8685	*
Бүтээгдэхүүний хэмжээ	ГТ – Улаанбуудай тариалсан талбай , га	0.5612	*
Бүтээгдэхүүний хэмжээ	ГТ – Арвай тариалсан талбай, (га)	0.2458	
Бүтээгдэхүүний хэмжээ	ГТ – Төмс тариалсан талбай (га)	0.3573	
Бүтээгдэхүүний хэмжээ	ГТ – байцаа тариалсан талбай (га)	0.1032	
Бүтээгдэхүүний хэмжээ	ГТ – Сонгино тариалсан талбай (га)	0.5951	**
Бүтээгдэхүүний хэмжээ	ГТ – Өргөст хэмх тариалсан талбай (га)	0.5450	*
Бүтээгдэхүүний хэмжээ	МАА – Нийт малын тоо (1,000 толгой)	0.6201	**
Бүтээгдэхүүний хэмжээ	МАА- Нийт үхэр сүрэг (1,000 толгой)	0.7893	**
Бүтээгдэхүүний хэмжээ	МАА-Нийт адуу (1,000 толгой)	0.7325	**
Бүтээгдэхүүний хэмжээ	МАА- Нийт хонь (1,000 толгой)	0.6260	**
Бүтээгдэхүүний хэмжээ	МАА- Нийт ямаа (1,000 толгой)	0.5432	*
Бүтээмж	ГТ – Үр тарианы ургац (тонн/га)	0.0059	
Бүтээмж	ГТ – Төмсний ургац (тонн/га)	0.1568	
Бүтээмж	ГТ – Хүнсний ногооны ургац(тонн/га)	0.0409	
Бүтээмж	ГТ – Тэжээлийн ургамлын ургац (тонн/га)	0.0273	
Бүтээмж	МАА – Махны гарц (тонн/1,000 толгой)	0.3815	
Бүтээмж	МАА - Ноосны гарц (тонн /1,000 толгой)	0.5610	*
Бүтээмж	МАА – Ноолуурын гарц (тонн /1,000 толгой)	0.2622	
Бүтээмж	МАА – Дайвар бүтээгдэхүүн (тонн /1,000 толгой)	0.3718	
Бүтээмж	Өндөр үнэтэй барааны экспортын нийт хэмжээ※	0.1622	
Бүтээмж	Дундаж үнэтэй барааны нийт экспортын үнийн дүн ※	0.5900	*
Бүтээмж	Бага үнэтэй барааны нийт экспортын үнийн дүн ※	0.8429	**

Зураг 2.2 ХАА-н салбарын ДНБ-ийн регрессийн шинжилгээний дүн

Эх сурвалж：ЖАЙКА төслийн баг

Доор, ангилал бүрийн регрессийн дүнг харуулав.

Хүснэгт 2.1 Регрессийн шинжилгээний дүн

Ангилал	Шинжилгээний дүн
Зах зээл	・ Зах зээлийн хүчин зүйлийн тухайд, дотоод зах зээлийн хэмжээг илэрхийлэх индекс болгож Монгол улсын хүн амыг, гадаад зах зээлийн тухайд ХАА-н гаралтай бүтээгдэхүүний нийт экспортын дүнг ашигласан. ・ Шинжилгээний үр дүнд **энэ хоёр үзүүлэлтийн аль аль нь ХАА-н ДНБ-тэй ихээхэн хамааралтай** болох нь харагдаж байв. ・ Хүн ам болон ХАА-н бүтээгдэхүүний нийт экспортын дүн жил ирэх тутам өсөх хандлагатай байгаа ба, зах зээлийн эрэлт нэмэгдэж байгаа нь ХАА-н ДНБ-ний өсөлтөд түлхэц болж байна гж үзэж байна.
Үйлдвэрлэлийн хэмжээ	・ Үйлдвэрлэлийн хэмжээний хамааралтай үзүүлэлтэд “Тариалах талбайн хэмжээ”, “Малын тоо толгойг” ашиглан шинжилгээ хийсэн. ・ Газар тариалангийн салбарын **нийт тариалах талбай болон улаан буудай, сонгино, өргөст хэмх тариалах талбай нь ХАА-н ДНБ-тэй ихээхэн хамааралтай байгаа** нь харагдсан. МАА-н хувьд, **нийт малын тоо болон үхэр, адуу, хонь, ямааны тооны нийт индекстэй ихээхэн хамааралтай** байв. ・ 1-3-р атрын аян зэрэг дахин сэргэлтийн төлөвлөгөө ХАА-н салбарын бодлогын нөлөөгөөр үйлдвэрлэлийн хэмжээ тэлэх хандлагатай байгаа ба энэ нь ХАА-н ДНБ-ий өсөлтөд түлхэц болох хүчин зүйл болж буй гэж таамаглаж байна.
Бүтээмж	・ Бүтээмжийн үзүүлэлтээр ГТ-ийн хувьд хураасан ургацын хэмжээг, МАА-салбарын хувьд мах, ноос, ноолуур, арьс ширний үйлдвэрлэлийн хэмжээг малын тоонд хуваах нэг малаас авах ашиг шимийн бүтээмжийг тооцоолов. ・ Тооцооллын дүнд **ГТ, МАА-н аль алиных нь үзүүлэлтийн хувьд ХАА-н ДНБ-тэй гүн хамааралтайг илтгэх индекс байсангүй.** Ямартай ч 2012-2021 оны 10 жилийн хугацаанд үйлдвэрлэлийн бүтээмж нь ХАА-н ДНБ-ий өсөлтөд

	нөлөөлөх хүчин зүйл байж чадаагүйг илтгэж байна.
Үнэ	• Үнэ цэнийн тухайд, экспортын бүтээгдэхүүн тус бүрийн арилжааны дундаж үнэд суурилсан бүтээгдэхүүнийг өндөр үнэтэй (100USD/кг-с дээш), дундаж үнэтэй (10USD/кг-с дээш,100USD/кг-с доош), хямд үнэтэй (10USD/кг-с доош) гэж ангилан, ангилал тус бүрийн нийт экспортын хэмжээний өсөлтийн харилцан хамаарлыг шинжлэв. • Үүний дүнд өндөр үнэтэй бүтээгдэхүүний бүлгийн экспортын хэмжээ гүн хамаарал байхгүй байгаа бол **дундаж болон хямд үнэтэй бүтээгдэхүүн экспортын хэмжээтэй гүн хамааралтай нь** харагдав. Иймд, ХАА-н ДНБ-ний өсөлтийг дэмжиж буй шалтгаанд дундаж болон хямд үнэтэй бүтээгдэхүүний экспортын өсөлт нөлөөлж байх магадлалтай нь харагдаж байна.

Эх сурвалж：ЖАЙКА төслийн баг

Дээрх үр дүнг сийрүүлбэл доорхи асуудлууд харагдаж байна.

- Өнгөрсөн 10 жилд (2012-2021) Монголын ХАА-н ДНБ-ийг урагш хөтөлсөн хүчин зүйл бол зах зээлийн тэлэлт, үйлдвэрлэлийн хэмжээний өсөлт болон дундаж ба бага үнэтэй бүтээгдэхүүний экспортын хэмжээ нэмэгдсэн нь нөлөөлсөн байна. Өөрөөр хэлбэл, өргөжин тэлэх хандлагатай байгаа дотоод зах зээлийн эрэлтийг дагаж ГТ, МАА-н үйлдвэрлэлийн хэмжээ өссөн нь нийт ХАА-н салбарыг өргөжүүлсэн байна. Мөн Хятад зэрэг ойр орчмын орнуудын түүхий эд, боловсруулалт багатай хагас боловсруулсан бүтээгдэхүүний эрэлттэй уялдан экспортын хэмжээ нэмэгдсэн.
- Нөгөө талаас ГТ, МАА-н салбарын аль аль нь бүтээмжийн хувьд ХАА-н ДНБ-ийг урагш хөтлөх хэмжээнд сайжирч дээшилсэн зүйл харагдсангүй. Мөн, нэмүү өртгийн шингээлт өндөртэй эцсийн бүтээгдэхүүний экспортын хэмжээний тухайд түүний үйлдвэрлэлийн бааз тогтвортой сайжирсан байлаа ч энэ нь ХАА-н салбарын ДНБ-ийг өсөлтийн хүчин зүйл болж чадаагүй байна.

2.2 Цаашид ХАА-н салбар хэрхэн хөгжих вэ

Өмнө өгүүлсэнчлэн өнгөрсөн 10 жилийн ХАА-н салбарын өсөлт нь зах зээлийг эс тооцвол үндсэндээ үйлдвэрлэлийн хэмжээний өсөлт голлох хүчин зүйл байлаа. Цаашдын гол асуудал болох бүтээмж нэмэгдүүлэх, нэмүү өртөг шингээх дээр нэмээд Монгол Улсын хүн амын өсөлт, олон улсын зах зээлийн өөрчлөлт, даац хэтэрснээс үүдэлтэй бэлчээрийн талхлагдалт, уур амьсгалын өөрчлөлт зэрэг олон хүчин зүйлийг харгалзан энэхүү Мастер төлөвлөгөөний төлөвлөлтийн хугацааны сүүлчийн жил болох 2034 он хүртэл ХАА-г хэрхэн хөгжүүлэх вэ гэдэг нь хамгийн чухал асуулт гэж хэлж болох бизээ. Ингээд ГТ болон МАА-н салбараар тус тусад нь, ХАА-н үйлдвэрлэл цаашид хэрхэн хөгжих боломжтой талаар авч үзье.

(1) Газар тариалангийн салбар

Монгол Улсын ГТ-гийн салбар хэрхэн хөгжих тухайд, юуны өмнө анхаарвал зохих асуудал бол улс үндэсний хувьд хүнсний аюулгүй байдлыг баталгаатай хангах үйлдвэрлэл, хангалтын тогтолцоог бүрдүүлэх явдал юм.

Хүснэгт 2.2-т газар тариалангийн гол нэрийн бүтээгдэхүүний нэг хүнд ноогдох жилийн дундаж хэрэглээг үзүүлсэн ба эдгээр бүтээгдэхүүний хэрэглээ сүүлийн 5 жилд төдий л их өөрчлөгдөөгүй байна. Тиймээс хүн амын нэг хүнд ноогдох жилийн хэрэглээний дундаж утгыг суурь болгон авч 2034 он гэхэд Монгол Улсын хүн амд шаардлагатай болох хүнсний бүтээгдэхүүний төрөл зүйлийн

хангамж нийлүүлэлтийн ирээдүйн төлөвийг гаргав. Энэхүү ирээдүйн төлөвт үндэслэн, бүтээгдэхүүн тус бүрийг хэр хэмжээгээр дотоодоосоо хангах боломжтой вэ гэдэг цаашид судалж шийдвэрлэх шаардлагатай асуудал юм.

Хүснэгт 2.2 Голлох газар тариалангийн бүтээгдэхүүний жилийн хэрэглээ, ирээдүнй төлөв

Нэр төрөл	2017	2018	2019	2020	2021	2034	
Хүн ам	3,096,030	3,163,991	3,232,430	3,294,335	3,347,783	3,887,004	
Улаанбуудайн жилийн хэрэглээ (кг/хүн)	83.85	83.25	81.67	81.59	81.88	82.4	Жилд шаардагдах хэмжээ 320,476 тн
Төмсний жилийн хэрэглээ (кг/хүн)	35.95	35.68	35.02	34.97	35.10	35.3	Жилд шаардагдах хэмжээ 137,382 тн
Хүнсний ногооны жилийн хэрэглээ (кг/хүн)	77.87	77.31	75.86	75.77	76.05	76.6	Жилд шаардагдах хэмжээ 297,631 тн
Жимсний жилийн хэрэглээ (кг/хүн)	59.92	59.45	58.35	58.28	58.49	58.9	Жилд шаардагдах хэмжээ 228,929 тн
Ургамлын тосны жилийн хэрэглээ (кг/хүн)	6.88	6.83	6.71	6.71	6.72	6.8	Жилд шаардагдах хэмжээ 26,314 тн

Эх сурвалж: МҮСХ-ний мэдээлэлд үндэслэн ЖАЙКА төслийн баг боловсруулав.

Нэр төрлөөр нь авч үзвэл, одоогийн байдлаар улаан буудай, төмсөөр 100% дотоодын хэрэгцээгээ хангаж байгаа ба өнөөгийн үйлдвэрлэлийн хэмжээ, хурааж буй ургацаар тооцвол хүн амын тоо өссөн байх 2034 онд ч мөн 100% дотоодын хэрэгцээгээ хангахаар байна. УИХ-ын 36-р тогтоолын хүрээнд жил бүр 100,000 тонн улаан буудай, 55,000 тонн төмс нөөцлөхөөр төлөвлөж буй бөгөөд, үүнийг нэмээд үзсэн ч шаардлагатай хэмжээний нийлүүлэлт нь тооны хувьд биелэх боломжтой гэж үзэж болно. Бэрхшээлтэй зүйл бол, тариалах талбай болон хураах ургацын хэлбэлзэл их байгаа явдал бөгөөд ялангуяа га-гаас авах ургацын хэмжээ өнгөрсөн 10 жилд улаан буудай: 0.56-1.68 тонн/ га, төмс: 8.04-14.62 гэх мэтээр хэлбэлзлэлийн хэмжээ их байна. Улаан буудай, төмсний тариалалт нь бараг дийлэнхдээ борооны усаар тэжээгддэг учраас ургац арвин байх, эсвэл ургац алдах хэлбэлзэл өндөртэй нөхцөлд байдаг бөгөөд энэ нь уур амьсгалын өөрчлөлтөөс үүдэн тулгамдсан асуудал болох магадлалтай. Дээрх байдлаас харахад улаан буудай, төмсний тариалалтын тогтвортой байдлыг бэхжүүлэх шаардлагатай байгаа бөгөөд, 1) Усны нөөцийг судалж усалгаатай тариалан хөгжүүлэх, 2) ХАА-г механикжуулах, зохистой цаг хугацаанд нь тариалж, хурааж авах, 3) Бордооны технологиос авахуулаад хөрсний шим тэжээлийг сайжруулах зэрэг арга хэмжээ авах шаардлагатай.

Харин хүнсний ногоо, жимс, ургамлын тосны дотоодын хэрэгцээгээ хангах үзүүлэлт бага 57%, 1%, 18% -тай байгаа тул үүнийг дээшлүүлэх шаардлагатай. Газар тариалангийн үйлдвэрлэлд төдийлэн тааламжтай бус цаг ууртайн дээр бүтээмж нь бусад орнуудтай харьцуулахад доогуур, цаашид зөвхөн үйлдвэрлэлийг өргөтгөх төдийгүй, ургацын хэмжээг нэмэгдүүлэхэд чиглэсэн арга хэмжээг эрчимжүүлэх шаардлагатай гэж үзэж байна. Жишээ нь MONMAP-AVC төслийн хүрээнд хэрэгжүүлсэн хүнсний ногооны туршилтын төслөөр сайн сортын үр ашиглаж, тариалалтын зохистой технологи нэвтрүүлснээр өргөст хэмх, улаан лоолийн ургац уламжлалт тариалалтын аргаас 30 орчим хувиар өссөн. Жимс, жимсгэний хувьд ч мөн адил, уур амьсгалд илүү дасан зохицсон сортын үр сонгож тариалснаар нэгж талбайгаас авах ургац нэмэгдэнэ. Ургамлын тосны түүхий эд болох рапсын

тариалангийн хувьд ч мөн тариалалтын зохистой технологи нэвтрүүлж түгээн дэлгэрүүлэх замаар бүтээмжийг нэмэгдүүлэх боломжтой.

Хүн амын өсөлттэй холбоотой хүнсний эрэлтийн өөрчлөлт

- **Монголын хүн ам 2034 онд 3 сая 890 мянгад хүрэх ба үүнтэй уялдан хүнсний эрэлт хэрэгцээг ч өснө .**
- **Ногооны жилийн хэрэглээ 260,215- 297,631 тонноор нэмэгдэх бол одоогийн жилийн үйлдвэрлэл нь 148,858 тонн орчим байна.**

Хотжилтын шалтгаант хүнсний хэрэглээний өөрчлөлт

- **УБ-с гадна,орон нутагт цөм хот үүсч хотжилт ихсэнэ.Хотын хүн ам жилээс жилд нэмэгдэнэ.**
- **Ногооны талаархи УБ-чуудын таашаал нь,① чанар,② эрүүл байдал③Монголынх ④ Үнэ гэсэн дараалаар ач холбогдол өгдөг.**

Төрийн бодлого

- **Гол нэрийн хүнсний бүтээгдэхүүнээр дотоодоос 100% хангахыг 5 жилийн төлөвлөгөө, ЗГ-ын мөрийн хөтөлбөрт тусгасан. 1 тэрбум мод тарих аян хэрэгжиж байгаа.**
- **Алсын хараа 2050-д хөдөө орон нутаг болон ядуу өрхийг ч аюулгүй, шимт хоол хүнсээр хангахаар тусгасан.**

Уур амьсгалын өөрчлөлт

- **Цаашид агаарын хэм аажмаар өснө. Энэ нь ГТ-ийн хувьд зарим талаар ашигтай байх таамнал байна.**
- **Эсрэгээрээ, агаарын хэм нэмэгдэхээр ууршилт эрчимжиж, ган болох магадлал ихсэнэ гэсэн таамаглал бий.**

Бүтээгдэхүүн тус бүрийн хөгжлийн чиглэл

	Жилийн хэрэглээний өөрчлөлт (тн)*	Тариалах талбай (га)*	Ургацын хэмжээ (тн/га)	2034 оны жилийн үйлдвэрлэл	Жич
Улаан буудай	290,217→ **320,476**	357,950→ 357,950	1.12→ **1.35**	**432,642**	ӨХК**: 145%
Төмс	120,111→ **137,381**	21,015→ 21,015	10.2→ **12.0**	**252,180**	ӨХК: 184%
Ногоо	260,215→ **297,631**	14,206→ **17,379**	10.5→ **13.7**	**238,092**	ӨХК: 80%
Жимс	200,150→ **228,929**	3,045→ **11,446**	0.85→ **1.00**	**11,446**	ӨХК: 5%
Ургамлын тос*	23,006→ **26,314**	22,000→ 22,000	0.40→ **1.00**	**7,260**	ӨХК: 28%

*2021-оны гүйцэтгэл →2034 оны таамаг **Өөрийгөө хангах коэффициент * Тосны гарцыг 33% гэж тооцов

Нэмүү өртгийн сүлжээ хөгжүүлэх чиглэл

Үе шат	Хөгжлийн чиглэл
Орц	• **Үр, үрсэлгээний үйлдвэрлэл, нийлүүлэлтийн тогтолцоо бүрдүүлэх** • **Үр, бордоо, ХАА-н техникийг импортыг дэмжих тогтолцоог өргөтгөх** • **Усны нөөцийн судалгаа**
Үйлдвэрлэл	• **Зах зээлийн баримжаат ХАА, үйлдвэрлэлийн зохистой технологийг дэлгэрүүлэх** • **Хөрс хамгаалал, усны хэмнэлттэй технологийг нэвтрүүлэх** • **Орон нутагт ногоо жимс тариалалтыг дэмжин сурталчлах**
Тээвэр ложистик, боловсруулалт	• **Тариачдын хоршоололд түшиглэсэн аюулгүй, найдвартай ГТ-ийн бүтээгдэхүүний түгээлтийн системийг бүрдүүлэх** • **Хүнс боловсруулах ААН-тэй гэрээт тариалалтыг хөхжүүлэх**
Борлуулалт, хэрэглээ	• **Шим тэжээлийг сайжруулах, махнаас бусад төрлийн хүнсний хэрэглээ (ногоо,мөөг, загас г.м) –г сурталчилах үйл ажиллагааг хэрэгжүүлэх**

Зураг 2.3 ХАА-н салбарын хөгжлийн чиглэл

Эх сурвалж: ЖАЙКА төслийн баг

(2) Мал аж ахуйн салбар

ГТ-ийн салбараас ялгаатай нь, МАА-н салбар нь Монгол улсад байгаа баялаг нөөцийг хэрхэн нэмүү өртөг шингээж дотоодын хэрэгцээ болон экспортыг нэмэгдүүлэхэд чиглүүлэх вэ гэдэг нь гол асуудал юм. Экспортын гол зах зээл болох Хятадаас гадна, цаашид зах зээл нь улам томрох зүүн өмнөд ази, ойрхи дорнод руу экспортоо нэмэгдүүлж болох төлөв байна. Олон улсын зах зээлийн чиг хандлага бол, ер нь хэрэгцээт хүнс, бүтээгдэхүүний аюулгүй, найдвартай байдал, чанар, үнэ, ашиг тус дээр нэмээд илүү тогтвортой, байгаль орчинд ээлтэй, мал амьтны сайн сайхныг харгалзсан бүтээгдэхүүний эрэлт нэмэгдэж байгаа бөгөөд эдгээр хүчин зүйлсийг мөн харгалзсан хүнс, бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг дэмжих нь чухал гэж үзэж байна. Нөгөө талаас Монгол Улсын малын тоо жилээс жилд нэмэгдсээр бэлчээрийн даац хэтрэн, бэлчээрийн байгалийн сэргэлт хангагдахгүй нөхцөлд хүрээд байна. Саяхнаас малын тоо толгойд татвар ноогдуулж эхэлсэн ба хурганы мах экспортлох оролдлогууд, ашиг шим муутай хөгшин малыг заазлах (гэрийн тэжээвэр амьтны хоол үйлдвэрлэх) зэргээр малын тоо толгойн өсөлтийг хязгаарлах шаардлага үүсч буй. Энэ нь уур амьсгалын өөрчлөлтийн эсрэг авч буй арга хэмжээтэй ч нийцэх бөгөөд, ган зуд болох магадлал нэмэгдэж, мал бэлчээх боломжгүй газар нутаг улам ихсэх таамаглал байгааг харгалзан, малын тоог хязгаарлах арга хэмжээ авах нь тэргүүн ээлжинд хэрэгжүүлэх зорилт болоод байна. Мөн, Зураг 2.4-т нэмүү өртгийн сүлжээг хөгжүүлэх чиглэлийг харуулсан байгаа бөгөөд хамгийн чухал нь бүтээгдэхүүний үнийг илэрхий унагаж байгаа хүчин зүйл болох түүхий эдийн чанарыг сайжруулах явдал бөгөөд үүний тулд түүхий эдийн бэлтгэн нийлүүлэлт, ложистикийн тогтолцоог сайжруулах шаардлагатай байна.

Хүн амын өсөлттэй холбоотой хүнсний эрэлтийн өөрчлөлт

- МУ-ын хот суурины хүн ам жилээс жилд нэмэгдэнэ. Чинээлэг давхаргын аюулгүй, найдвартай, нэмүү өртөг их шингэсэн хүнсний хэрэгцээ нэмэгдэнэ.
- Мах сүүн бүтээгдэхүүн ч мөн энэ хэрэгцээнд нийцэхийн тулд үр тариагаар тэжээж бордсон малын мах ч нэмэгдэнэ.

МАА-н бүтээгдэхүүний экспортын нэр төрлийн өөрчлөлт

- Худалдааны хэлэлцээр байгуулах, экспортын боломжийг нэмэгдүүлэх. Хятад улс чухал худалдан авагч хэвээр байж, ойрхи дорнод, ЗӨА-ийн зах зээл томрох хандлагатай бна
- Тогтвортой байдал, байгал орчны бодлого, амьтны тавлаг байдлыг харгалзсан бүтээгдэхүүний хэрэгцээ пэлхий даяар өсөх хандлагатай байна.

Малын тоо толгойн өөрчлөлт

- Малын тоо өнөөг хүртэл жил бүр өссөн. Гэвч нэг малчинд ноогдох малын тооны өсөлт, малын хөлийн татвартай холбоотой өсөлтийн хувь удаашрах магадлалтай. Гэвч бэлчээрийн даац хэтрэлт буурахгүй, бэлчээрийн тогтвортой байдлыг хангах нь хүндрэлтэй.

Уур амьсгалын өөрчлөлт

- Хуурай, халуун зун, цас ихтэй өвлийн улирал үргэлжлэх хугацаа нэмэгдэнэ. Ган зуд болох магадлал нэмэгдэнэ.
- Бэлчээрт ашиглах боломжгүй нутаг ихсэх (талхагдал, цөлжилт) магадлалтай байгаа нь , МАА-н салбарт нөлөөлөх нь гарцаагүй.

Бүтээгдэхүүн тус бүрийн хөгжлийн чиглэл

	Экспортын хэмжээ (тн) *	Дундаж үнэ (ам. дол/кг) *	Хөгжлийн чиглэл
Хонины мах	3,864	3.0	• Хурганы мах үйлдвэрлэл худалдааг дэмжих, үүний тулд хурга бордох хоршоодыг сурталчлах • Дайвар бүтээгдэхүүнээр ГТА-ны хоол үйлдвэрлэх
Угаасан ноолуур	9,097	29.0	• Боловсруулалт сайтай хагас бэлэн бүтээгдэхүүн үйлдвэрлэх
Угаасан ноос	11,387	1.3	• Самнасан ноолуур, ноосны худалдааг нэмэгдүүлэх,
Самнасан ноос, ноолуур	782	55.9	• Ноос угаах, самнах технологийг сайжруулах • Малчдын хоршоонд түшиглэсэн ноосны ложистикийн тогтолцоо бүрдүүлэх
Түүхий арьс	4,403	0.7	• Малчдын хоршоонд түшиглэсэн түүхий арьс цуглуулах, хяналтын тогтолцоо бүрдүүлэх
Элдэсэн арьс	8,118	2.5	• Үргэмлэн хандан идэлгийн технологийг дэлгэрүүлэх

*2017-2021оны мэдээлэл, НҮБ-ын UN Comtrade

Нэмүү өртгийн сүлжээг хөгжүүлэх чиглэл

Үе шат	Хөгжлийн чиглэл
Орц	• Ашиг шим өндөртэй мал бордох ферм байгуулах • Хөрсний үржил шимийг нэмэгдүүлэх буурцагт ургамал тарихыг дэмжих • Малын эмчийг сурган бэлтгэх
Үйлдвэрлэл	• Хурганы мах үйлдвэрлэх зорилгоор хурга маллах дундын хоршооны тогтолцоог бүрдүүлэх • МАА-н бренд бүтээгдэхүүн үйлдвэрлэхийг сурталчлах • Үржлийн менежментийн зохистой арга техникийг дэлгэрүүлэх
Тээвэр ложистик, боловсруу-лалт	• Малчдын хоршооны чадавхийг бэхжүүлэх замаар МАА-н бүтээгдэхүүний ложистикийн нөхцөлийг сайжруулах • Хүнсний бүтээгдэхүүний боловсруулалтын чанар, эрүүл ахуйн баталгаажуулалт хийлгэх (НАССР Халал зөрэг) , Шинжилгээний чадавхийг сайжруулах • Ээрмэлийн үйлдвэрлэлийн хүний нөөцийг сургах, байгальд ээлтэй бүтээгдэхүүн үйлдвэрлэх технологийг дэлгэрүүлэх
Борлуулалт, хэрэглээ	• Махны ангиллын тогтолцоо нэвтрүүлэх • Хүнсний аюулгүй байдал, эрүүл ахуйн талаархи ухуулга

Зураг 2.4 МАА-н нэмүү өртгийн сүлжээг хөгжүүлэх чиглэл

Эх сурвалж: ЖАЙКА төслийн баг

2.3 Хөгжлийн үндсэн үзэл баримтлал

1992 онд зах зээлийн эдийн засагт шилжих өөрчлөлтийг тусгасан үндсэн хуулийн өөрчлөлтөөс хойш Монгол Улсын ХАА-н салбар ихээхэн өөрчлөгдөн хөгжсөн. Социализмын үед байгуулагдсан нэгдэл, САА, улсын үйлдвэрийн газар задарч эдгээрт өмчлөгдөж байсан хөрөнгө, мал гишүүдэд тараагдан хувийн өмч болсон. Зах зээлийн эдийн засагт огцом шилжсэнтэй холбоотойгоор газар тариалангийн салбар уналтад орсон бол нөгөө талд МАА-н салбарт малын тоо өссөөр байгаа бөгөөд, сүүлийн жилүүдэд Монгол Улсын Засгийн газраас хэрэгжүүлсэн бодлогын үр дүнд газар тариалангийн талбайн хэмжээ нэмэгдэж, хүнс тэжээлийн үндсэн үр тариа болох улаан буудай, төмсөөр дотоодынхоо хэрэгцээг бүрэн хангах хүртлээ сэргэв. МАА-н салбарт дэлхий дахинаа тансаг материалд тооцогддог ноолуур нь экспортын гол нэрийн бүтээгдэхүүний нэг болж худалдааны орлогод жинтэй хувь эзлэх хүртлээ өссөн байна.

Хэдий тийм ч урт хугацааны хөгжлийн зорилтыг хэрэгжүүлэхэд шийдвэрлэх шаардлагатай олон асуудал урьдын адил байсаар байна. ХАА-н салбарт гол нэр төрлийн үр тариа, ургамлаас гадна хүнсний ногоо, жимс жимсгэний төрөл зүйл импортын хамааралтай хэвээрээ, ялангуяа үйлдвэрлэлийн бус улиралд ХАА-н бүтээгдэхүүний нийлүүлэлт, тээвэрлэлтийн системийг сайжруулах шаардлага хурцаар тавигдаж байна. МАА-н салбарт малын тоо толгойн огцом өсөлт нь бэлчээрээ сүйрүүлэх хүртлээ гүнзгийрч буйгаас гадна шүлхий зэрэг өвчний эсрэг авах арга хэмжээг багтаасан хорио цээрийн тогтолцоо хангалтгүй байгаа нь махны экспортод маш том тээг саад болж байна. Бас ноос ноолуур, арьс ширэн бүтээгдэхүүний хувьд хэдийгээр түүхий эдийн нөөц элбэг байгаа ч дотооддоо боловсруулалт муу байгааг дүгнэвэл, Монгол Улсын хэмжээгээр бүтээгдэхүүнд нэмүү өртөг шингээх ажил хангалтгүй байна.

Монголын ХАА-н бүтээгдэхүүний өрсөлдөх чадварыг бэхжүүлэхийн тулд эрэлт нь бүрэн хангагдаагүй зах зээлийг олж тогтоох, төр хувийн хэвшил хоёулаа тэрхүү зах зээлийн эрэлт хэрэгцээг

нухацтай авч үзэж, тэдний шаардлагад нийцүүлэхийн төлөө хүчин чармайлт гаргах шаардлагатай байна. 2025-2034 оны 10 жилд хэрэгжүүлбэл зохих үйл ажиллагаа, Монголын ХАА-н үйлдвэрлэлийн давуу талыг ашиглан зах зээлийн эрэлтэд үндэслэсэн бүтээгдэхүүн хөгжүүлэлт хийх, түүнийгээ тогтвортой нийлүүлэхийн тулд үйлдвэрлэл, тээвэрлэлт, боловсруулалт, борлуулалтын нэмүү өртгийн сүлжээг бүрдүүлж бэхжүүлэн, зорилтот зах зээлд Монголын ХАА-н бүтээгдэхүүний өрсөлдөх чадвар болон гадаад зах зээлийн итгэлийг нэмэгдүүлэх зорилготойг ухамсарлах явдал юм. Өнөөгийн нөхцөл байдлын шинжилгээнд үндэслэн ЖАЙКА-ийн судалгааны баг нь **“ХАА-н бүтээгдэхүүний зах зээлд өрсөлдөх чадварыг бэхжүүлэх замаар Монгол Улсад хүчирхэг ХАА-г хөгжүүлэх”**-ийг хөгжлийн суурь концепц болгон дэвшүүлж, түүнийг хэрэгжүүлэхэд чиглэсэн ХАА-н хөгжлийн стратегийг санал болгож байна.

2.4 ХАА-н нэмүү өртгийн сүлжээг хөгжүүлэх үндсэн чиглэл

Дээр өгүүлсэн **“ХАА-н бүтээгдэхүүний зах зээлд өрсөлдөх чадварыг бэхжүүлэх замаар Монгол Улсад хүчирхэгХАА-г хөгжүүлэх”** талаар авбал зохих арга хэмжээ олон байгаа бөгөөд “Алсын хараа 2050”-д тусгагдсан хөгжлийн хуваарьт хугацааны буюу 10 жилийн төлөвлөлтийн хугацаанд тэргүүн ээлжинд хэрэгжүүлэх ач холбогдол бүхий доорхи 4 хөгжлийн чиглэлийг зөвлөмж болгож байна.

(1) Хөгжлийн чиглэл 1. ХАА-н бүтээгдэхүүний тогтвортой нийлүүлэлт болон бүтээгдэхүүнд нэмүү өртөг шингээхийн тулд үйлдвэрлэл, ложистикийн бааз суурь бий болгох

Ирэх 10 жилд ХАА-н салбарыг хөгжүүлэхдээ үйлдвэрлэлийн хэмжээ төдийгүй ХАА-н бүтээгдэхүүний тогтвортой хангамж, чанар, эрүүл ахуйг сайжруулах зэргээр аль болохоор их нэмүү өртөг шингээхийг чухалчлан авч үзэх шаардлагатай. Иймд ХАА-н бүтээгдэхүүний нийлүүлэлтийг тогтворжуулж, нэмүү өртөг илүү шингээхийн тулд нийлүүлэлтийн сүлжээг бий болгоход шаардлагатай гэж үзсэн хөгжлийн чиглэлийг Хүснэгт 2.3-т харууллаа. Монгол Улсын газар тариалан, мал аж ахуйн гол нэрийн бүтээгдэхүүнүүдээр төлөөлүүлэн авч үзсэн бөгөөд бөгөөд нийлүүлэлтийн сүлжээг хөгжүүлэх үзэл баримтлалыг бусад бүтээгдэхүүнд ч хөрвүүлэн ашиглах боломжтой

Хүснэгт 2.3 ГТ-гийн салбарын хөгжлийн чиглэл

Үе шат	Нэр төрөл	No.	Хөгжлийн чиглэл
Орц	・Хүнсний ногоо ・Жимс (Чацаргана) ・Улаан буудай, Рапс, ・Мөөгний төрөл	1-1-1	Үр тариа, тосны ургамлын үр үйлдвэрлэх тогтолцоог бэхжүүлэх
		1-1-2	Сайн чанарын үр, сортыг түгээн дэлгэрүүлэхийг дэмжих
		1-1-3	Үр, суулгац үйлдвэрлэгчийг сурган бэлтгэх
		1-1-4	Усны нөөцийг хөгжүүлэн ашиглах, усалгаатай тариалалтыг дэмжих
		1-1-5	Газар тариалангийн механикжуулалтыг дэмжих
		1-1-6	Хүлэмжийн байгууламжийг өргөжүүлэх
Үйлдвэрлэл		1-1-7	Тариалалтын зохистой технологийг түгээн дэлгэрүүлэх
		1-1-8	Жижиг тариаланчдад зах зээлийн баримжаат тариалалтыг дэлгэрүүлэх
		1-1-9	Түргэтгэсэн тариалалтын технологийг түгээн дэлгэрүүлэх
Тээвэр ложистик, боловсруулалт		1-1-10	ХАА-н хоршоонд түшиглэн ХАА-н бүтээгдэхүүний ложистикийн (агуулах) тогтолцоог бүрдүүлэх
		1-1-11	Хүнсний боловсруулах үйлдвэртэй байгуулсан гэрээт тариалалтыг дэмжих
		1-1-12	Жижиг тариаланчдад чиглэсэн хүнс боловсруулах хялбар технологийг дэлгэрүүлэх
Борлуулалт, хэрэглээ		1-1-13	Шимт чанар, хүнсний аюулгүй байдлын чиглэлээр соён гэгээрүүлэх сурталчилгаа хийх
		1-1-14	Кластер хөгжүүлэх

Эх сурвалж：ЖАЙКА төслийн баг

Хүснэгт 2.4 МАА-н салбарын хөгжлийн чиглэл

Үе шат	Нэр төрөл	No.	Хөгжлийн чиглэл
Орц	・Мах ・Сүү, сүүн бүтээгдэхүүн ・Ноос ・Ноолуур ・Арьс шир, ・Зөгийн бал ・Загас	1-2-1	Малын шилмэл үүлдэр омгийн хангах нийлүүлэх бааз бий болгох
		1-2-2	Малын эмч (хувийн хэвшлийнхийг оруулан), мал зүйчийг сургах
Үйлдвэрлэл		1-2-3	Өсвөр малыг бордон тэжээх технологи нэвтрүүлэхийг дэмжих
		1-2-4	Ноос, ноолуурын бэлтгэн нийлүүлэх тоног төхөөрөмж нэвтрүүлэх, технологийн сургалт зохион байгуулах
		1-2-5	Маллагааны зохистой технологийг түгээн дэлгэрүүлэх
Тээвэр ложистик, боловсруулалт		1-2-6	Мал төхөөрөх үйлдвэр байгуулахыг дэмжих
		1-2-7	Дайвар бүтээгдэхүүнээр ГТА-ны хоол тэжээл хийх үйлдвэрлэлийг хөгжүүлэх
		1-2-8	Малчдын хоршоонд тулгуурласан ноос ноолуур, арьс шир, сүүний бэлтгэн нийлүүлэх тогтолцоо бүрдүүлэх
		1-2-9	Аж үйлдвэрийн хүний нөөцийг сургах (мах боловсруулах, ээрэх, арьс шир боловсруулах)
		1-2-10	Байгаль орчинд ээлтэй ээрэх, арьс шир боловсруулах технологи нэвтрүүлэх
		1-2-11	Мөшгөх тогтолцооны ашиглалтыг дэмжих
Борлуулалт, хэрэглээ		1-2-11	Зах зээлийн эрэлтэд нийцсэн махны ангилал нэвтрүүлэх, бренд хөгжүүлэхийг дэмжих
		1-2-12	Аялал жуулчлалын салбартай хамтрахыг дэмжих
		1-2-13	Кластер хөгжүүлэх

Эх сурвалж：ЖАЙКА төслийн баг

(2) Хөгжлийн чиглэл 2. ХАА-н бүтээгдэхүүний экспортыг дэмжихийн тулд чанар, эрүүл ахуйн хяналтын тогтолцоо болон холбогдох төрийн байгууллагын чадавхийг бэхжүүлэх

Ирээдүйд Монгол улсын ХАА-н салбарын өсөлтийн түлхүүр нь ХАА-н бүтээгдэхүүний экспортын борлуулалтаас ихээхэн хамааралтай байх бөгөөд, өнөөгийн байдлаар хүнсний бараа бүтээгдэхүүний чанар, эрүүл ахуйн хяналтын тогтолцооны эмзэг байдал нь ХАА-н бүтээгдэхүүний экспортод гол саад болж байгаа нь бодит бэрхшээл юм. Түүнчлэн ХАА-н бүтээгдэхүүний экспортыг дэмжихийн тулд, Засгийн газрын холбогдох байгууллагын худалдааны хэлэлцээр хийх чадавхийг бэхжүүлэх, экспортын бүрдүүлэлтийг (амьтан ургамлын хорио цээрийн асуудлыг оруулан) хялбаршуулах зайлшгүй шаардлагатай байна. Эдгээрийг харгалзан ХАА-н бүтээгдэхүүний экспортыг нэмэгдүүлэхэд шаардлагатай чанар, эрүүл ахуйн хяналтын тогтолцоо болон, холбогдох захиргааны байгууллагын чадавхийг бэхжүүлэх зорилготой хөгжлийн чиглэлийн талаар Хүснэгт 2.5-д үзүүлэв.

Хүснэгт 2.5 Чанар, эрүүл ахуйн хяналтын салбарын хөгжлийн чиглэл

Салбар	No.	Хөгжлийн чиглэл
2-1. Чанар эрүүл ахуйн хяналтын тогтолцоог бэхжүүлэх	2-1-1	Хүнсний аюулгүй байдлын системийг сайжруулах
	2-1-2	Хүнсний бүтээгдэхүүний шинжилгээний (хорио цээрийн) байгууллагын чадавхийг бэхжүүлэх
	2-1-3	Хувийн хэвшлийн чанар, эрүүл ахуйн хяналтын хүний нөөцийг сургах
	2-1-4	Чанар, эрүүл ахуйн хяналтын олон улсын баталгаажуулалт авахыг дэмжих
2-2. Экспортыг дэмжих	2-2-1	ХАА-н бүтээгдэхүүний экспортын бүрдүүлэлтийг хялбаршуулж, оновчтой болгох
	2-2-2	Худалдааны хэлэлцээр хийх чадавхийг бэхжүүлэх
	2-2-3	Олон улсын үзэсгэлэн худалдаанд оролцоход дэмжлэг үзүүлэх

Эх сурвалж：ЖАЙКА төслийн баг

(3) Хөгжлийн чиглэл 3. ХАА-н үйлдвэрлэлийг эрчимжүүлэхийн тулд ХАА-н чиглэлийн компани ААН, байгууллагуудыг дэмжих, тогтолцоо сайжруулах дэмжлэг үзүүлэх

Зах зээлийн шаардлагад илүү нийцэх боломжтой бүтээгдэхүүн үйлдвэрлэл, савлалт,

нийлүүлэлтийн тогтолцоо бүрдүүлэхэд хөрөнгө оруулалт, эргэлтийн зардал шаардагдана. Зээл авахад шаарддаг барьцаа болон хүү өндөр байдгаас ялангуяа ЖДҮ, ХАА-д ажиллагсдын хувьд санхүүгийн бэрхшээлтэй тулгарах нь их, чанаргүй зээлийн эзлэх хувь өндөр байгаа Монгол улсын хувьд цаашид ч төдийлэн хялбар шийдэгдэхгүй асуудал юм. Нэмүү өртгийн сүлжээг санхүүжүүлэх, агуулахын үнэт цаасны систем зэрэг санхүүгийн шинэ арга хэрэгсэл бий болгоход чиглэсэн арга хэмжээ авах шаардлагатай болох бизээ. Мөн мэдээжийн хэрэг, ЖДҮ, ХАА-н хоршоодын засаглалыг сайжруулах зэргээр зээл авахад хялбар байх менежментийн тогтолцоог бүрдүүлэх явдал ч бас нэг арга хэрэгсэл гэж хэлж болно. Үүнээс гадна, ХАА-н аж үйлдвэрлэлийн идэвхижүүлэлтэд шаардлагатай хуулийн эрхзүйн тогтолцоог сайжруулах замаар ХАА-н үйлдвэрлэлийн бизнесийн орчинг сайжруулж байх шаардлагатай. ХАА-н үйлдвэрлэлийг идэвхижүүлэхийн тулд ХАА-н чиглэлийн компани ААН, байгууллага холбоодод чиглэсэн дэмжлэг, тогтолцоог сайжруулахын тулд хэрэгжүүлэх шаардлагатай авах арга хэмжээний хөгжлийн бодлогын чиглэлыг Хүснэгт 2.6-д үзүүлэв.

Хүснэгт 2.6 ХАА-н чиглэлийн компани ААН, байгууллагуудын хөгжлийн чиглэл

Салбар	No.	Хөгжлийн чиглэл
3-1. Санхүүгийн дэмжлэг	3-1-1	Нэмүү өртгийн сүлжээг санхүүжүүлэх систем нэвтрүүлэх туршилт хийх
	3-1-2	Агуулахын үнэт цааны систем нэвтрүүлэх туршилт хийх
3-2. ААН, хоршоодын засаглалыг бэхжүүлэх	3-2-1	Хувийн ААН-ийн санхүүгийн удирдлагын чадавхийг бэхжүүлэх
	3-2-2	ХАА-н хоршоодын зохион байгуулалтын бүтэц, санхүүгийн удирдлагын чадавхийг бэхжүүлэх
3-3. ХАА-н үйлдвэрлэлийг идэвхижүүлэх хууль эрхзүйн тогтолцоог сайжруулах	3-3-1	ХАА-н салбарын хууль, эрх зүйн тогтолцоог шинэчлэх - ХАА-н хоршоолыг ААН-ийн татвараас чөлөөлөх - ХАА-н материал техникийг (үр, бордоо, УХБ)-ыг импортын татвараас чөлөөлөх - Гэрээт борлуулалтын нөхцөлтэй урамшууллын тогтолцоо нэвтрүүлэх
	3-3-2	МАА-н салбарын хууль, эрх зүйн тогтолцоог шинэчлэх - Малчдын хоршоог татвараас чөлөөлөх - Гэрээт борлуулалтын нөхцөлтэй урамшууллын тогтолцоо нэвтрүүлэх - Олон улсын баталгаажуулалт авахыг урамшуулах тогтолцоо нэвтрүүлэх

Эх сурвалж: ЖАЙКА төслийн баг

(4) Хөгжлийн чиглэл 4. Орон нутгийн онцлогтой газар тариалан, МАА-н үйлдвэрлэлийг дэмжих, ХАА-н үйлдвэрлэлийн кластер байгуулах

Орон нутгийн ХАА-н үйлдвэрлэлийг идэвхижүүлж, эдийн засгийг хөгжүүлэх нь УБ-ын хүн амын хэт төвлөрлийг сааруулахад чухал үүрэгтэй юм. Мөн бүс нутгийн хэмжээнд нэр хүндтэй бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг ААН-үүд болон эрдэм шинжилгээ, санхүүгийн байгууллагын сүлжээг бэхжүүлэх, өрсөлдөх чадвартай бүтээгдэхүүн үйлдвэрлэл бий болгох бааз суурь болдгийнх нь хувьд аж үйлдвэрийн кластер байгуулан хөгжүүлээхийг санал болгож байна. Монгол Улсад аж үйлдвэрийн кластерийн тухай тодорхойлолт өнөөгийн байдлаар тодорхой хуулийн үндэслэлгүй байгаа тул нэн яаралтай хуул эрхзүйн орчинг сайжруулах шаардлагатай байна. Тэгж байж аж үйлдвэрийн кластерийн үйл ажиллагааг эрчимжүүлэхэд чиглэсэн дэмжлэгийн тогтолцоо нэвтрүүлэх хэрэгтэй байх. Түүнээс гадна орон нутгийн аж үйлдвэрлэлийг идэвхижүүлэх талаас Монголд ч их яригддаг болсон “Нэг суурин - Нэг бүтээгдэхүүн” хөдөлгөөнийг дэмжих ч боломжтой. Орон нутгийн онцлогтой бүс нутгийн ХАА-н үйлдвэрлэлийг хөгжүүлэх, ХАА-н үйлдвэрлэлийн кластер хөгжүүлэх

хөгжлийн бодлогын чиглэлийг Хүснэгт 2.7-д үзүүлэв.

Хүснэгт 2.7 Орон нутгийн ХАА-н үйлдвэрлэлийг хөгжүүлэх талаархи хөгжлийн чиглэл

Салбар	No.	Хөгжлийн чиглэл
4-1. Кластер хөгжүүлэх	4-1-1	Кластер хөгжүүлэхэд чиглэсэн хуулийн орчин бүрдүүлэх
	4-1-2	Экспортын кластерийг дэмжих тогтолцоо нэвтрүүлэх
	4-1-3	Үйлдвэрлэл, ШУБ-ын хамтын ажиллагааны зохицуулагч ажиллуулах
4-2. Орон нутгийн аж үйлдвэрийн хөгжил	4-2-1	Бүс нутгийн ложистикийн зангилаа үүсгэх
	4-2-2	Нэг суурин - Нэг бүтээгдэхүүн хөдөлгөөнийг өрнүүлэх

Эх сурвалж：ЖАЙКА төслийн баг

3. ХАА-н салбарын нэмүү өртгийн сүлжээг хөгжүүлэх хөтөлбөр

3.1 Хөгжлийн хөтөлбөрүүдийн ерөнхий бүтэц

Монгол улсын ХАА-ын хөгжлийн стратегид тулгуурлан нийт 11 хөтөлбөр боловсруулав. Хөтөлбөр бүр хэд хэдэн Үйл Ажиллагааны Төлөвлөгөөнөөс бүрдэх ба уг төлөвлөгөөг ЖАЙКА-ын төслийн багийн хийсэн судалгаа, туршилтын төслүүдээс олж авсан туршлага сургамж, Япон болон гуравдагч орны туршлагад үндэслэн боловсруулав. Хөгжлийн стратегид заасан хөгжлийн чиглэл буюу үйлдвэрлэлийн цар хүрээг тэлэхээс гадна, илүү бүтээмж (Productivity), аюулгүй байдал, чанар, чиг үүргийн талаас болон байгаль орчинд ээлтэй байх, илүү үнэ цэнтэй (Value) байхад анхаарч боловсруулсан бөгөөд ялангуяа газар тариалангийн салбарт үйлдвэрлэлийг цаашид ч өргөжүүлэх нь чухал хэвээр гэдгийг тэмдэглэх нь зүйтэй. ҮАТ-г боловсруулахдаа 2020 онд шинэчлэн батлагдсан Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуульд заасан “Төлөвлөгөө боловсруулахдаа баримтлах зарчмууд”-ыг бүрэн тусгах чиглэлд анхаарч ажилласан.



Зураг 3.1 Хөгжлийн хөтөлбөрүүдийн бүтэц

Эх сурвалж: Жайка төслийн баг

3.2 Хүнсний ногооны нийлүүлэлтийн сүлжээг бэхжүүлэх хөтөлбөр

(1) Хөтөлбөрийн товч агуулга

Монгол улсын хүнсний ногооны үйлдвэрлэл,зах зээлд нийлүүлэх хэмжээ өсөх хандлагатай байгаа нь эрэлт нэмэгдэж, хүнсний ногооны үрийн татаасын тогтолцоо бий болсонтой холбоотой. Хойшид ч энэ систем үргэлжлэх төлөвтэй байгаа ч системээс гарах стратегийг бас судлах нь чухал. Үйлдвэрлэгчдийг зохион байгуулалтад оруулсан ХААЗД-ыг салбарын хэмжээнд хөгжүүлэхэд анхаарч, үйлдвэрлэгчдэд илүү их ашигтай байх механизмыг бүрдүүлэх нь нэн тулгамдсан асуудал болж байна. Түүнчлэн хүнсний ногооны хэрэглээг идэвхжүүлэх замаар дотоодын хүнсний ногооны хэрэглээг өргөжүүлэхийг эрмэлзэх.

	Орц	Үйлдвэрлэл	Боловсруулалт	Түгээлт, экспорт	Борлуулалт хэрэглээ
Оролцогч	Ханган нийлүүлэгч (үр бордоо, байгууламж г.м)	Тариачин, ГТ-ийн хоршоо, ХАА-н компани	Боловсруулах үйлдвэр, ААН-үүд	Чеженжүүд, ХАА-н хоршоо, түгээгч, экспортлогч ААН	Жижиглэнгийн дэлгүүр, нийтийн хоол, зочид буудал, боловсролын байгууллага
Гол бэрхшээл	Чанартай үр, бордоо, УХБ-ын дийлэнх нь импортын хараат. Ялангуяа орон нутагт орцын хүртээмж нэн хүндрэлтэй.	Үйлдвэрлэлийн хугацаа богино.Зах зээлийн хүртээмж тогтворгүй. Хөрөнгө санхүүгийн олдоц муу. Зарим газар усалгаа хүндрэлтэй. Өвлийн тариалалтын байгууламжийн өртөг өндөр. ХАА-н технологийг дэлгэрүүлэх тогтолцоо сул	Ногоо боловсруулагчид угаасаа цөөн. Дотоодын түүхий эд дутмаг, зарим нь импортын хараат. Түүхий эд, тоног төхөөрөмж авах санхүүжилт хүрэлцээгүй.	Түгээлтийн дийлэнх нь чеженжээс хараат. Агуулах, хадгалалтын технологи дутагдалтай. Тээврийн зардал өндөр. Орон нутаг руу хийх нийлүүлэлт хязгаарлагдмал	Ялангуяа хөдөөгийнхний ногооны хэрэглээ бага. Эх орны үйлдвэрийн ногооны эрэлт бий ч нийлүүлэлт хангалтгүй.
Авах арга хэмжээ	1.1 Чанартай үр, түргэтгэсэн тариалалт нэвтрүүлэх замаар хүнсний ногооны нийлүүлэлтийн хугацааг уртасгах төлөвлөгөө 1.2 Ногоочдод зах зээлийн баримжаат фермерийн менежментийг дэлгэрүүлэх төлөвлөгөө 1.3 ХАА-н хоршоогоор дамжуулан ХАА-н бүтээгдэхүүний түгээлтийн тогтолцоо бүрдүүлэх төлөвлөгөө 1.4 Хүнсний ногоо боловсруулах энгийн арга, хэрэглээний талаархи төрөл бүрийн сургалт, сурталчилгаа хэрэгжүүлэх төлөвлөгөө				

Монгол Улсын Засгийн газраас дотоодын хүнсний ногооны тариалалтыг дэмжиж, тарьж ургуулсан ногоонд (10 төрөл) урамшуулал олгох, өвлийн дулааны зардал зэрэгт татаас олгох тогтолцоогоор дэмжсээр ирсэн. Нэг хэсэгтээ энэ тогтолцоо үргэлжилнэ гэсэн хүлээлттэй байгаа ба энэ тогтолцоо зогсоход хамгийн бага хохиролтойгоор гарах стратегийг багтаасан судалгаа хийх нь чухал. Суурь концепц, хөгжлийн чиглэлд суурилсан хүнсний ногооны нийлүүлэлтийн сүлжээг бэхжүүлэхэд, 1) Чанартай үр, сорт, түргэтгэсэн (эрт) ургацын тариалалт нэвтрүүлэх замаар хүнсний ногооны нийлүүлэлтийн хугацааг уртасгах төлөвлөгөө, 2) Тариаланчдын зах зээлийн менежментийг хөгжүүлэх төлөвлөгөө, 3) Ногоочдын хоршоог хамруулсан газар тариалангийн бүтээгдэхүүний нийлүүлэлт түгээлтийн систем бүрдүүлэх төлөвлөгөө, 4) Хүнсний ногооны боловсруулалт, хэрэглээний талаар сургалт сурталчилгаа хийх төлөвлөгөөг боловсруулав.

Төлөвлөгөөг боловсруулахдаа бид өнөөг хүртэл Монгол Улсын Засгийн газар болон хандивлагчдын дэмжлэгтэй төслүүдийн үр дүнд бий болсон сайн туршлагын талаар тодруулж, Үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулахдаа эдгээр үр дүнгийн талаар иш татсан тусгасан. Швейцарийн хөгжлийн агентлагийн дэмжлэгтэйгээр хэрэгжиж буй MONVEGI (Inclusive and Sustainable Vegetable Production and Marketing) төсөл нь сайн чанарын үр, сортыг нэвтрүүлэх, үйлдвэрлэгч байгууллагуудыг бэхжүүлэх сайн туршлага гэдэг талаас оролцогч талуудад танигдсан. Эдгээр туршлага сургамж, үр дүнг Үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгаж, сайн туршлагыг өргөжүүлэн дэлгэрүүлэхэд анхаарч ажилласнаар асуудлыг үр дүнтэй шийдвэрлэхийг зорьж ажиллах юм.

Үйл ажиллагааны төлөвлөгөө тус бүрийн товч агуулгыг доор сийрүүлэв.

(2) Үйл ажиллагааны төлөвлөгөө тус бүрийн товч агуулга

No.	Үйл ажиллагааны төлөвлөгөө	Товч агуулга	Хэрэгжүүлэх байгууллага	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Хүрэх түвшин	Төслийн хугацаа	Төслийн өртөг (сая төг.)	Төлөвлөгөөний үндэслэл
1.1	Чанартай үр сорт, түргэтгэсэн тариалалтын технологи нэвтрүүлэх замаар хүнсний ногооны нийлүүлэлтийг нэмэгдүүлж, үйлдвэрлэлийн хугацааг уртасгах төлөвлөгөө	• Монголын нөхцөлд тохирсон дотоод гадаадын чанартай үр сортыг нэвтрүүлэх. Сортын онцлогт тохирсон түргэтгэсэн тариалалтыг нэвтрүүлэх замаар хүнсний ногооны үйлдвэрлэл нийлүүлэлтийн хугацааг уртасгахыг зорино • ХХААХҮЯ манлайлан чанартай үр сортын мэдээллийн сан байгуулах, хувийн ААН, байгууллагыг татан оролцуулах хэлбэрээр зах зээлийн эрэлт хэрэгцээнд нийцсэн ногооны тариалалт, түгээлт нийлүүлэлтийн тогтолцоог нэвтрүүлнэ	ХХААХҮЯ	Жилийн хүнсний ногооны үйлдвэрлэлийн хэмжээ	148,859 тн/жилд (2022он)	238,859 тн/жилд	2025 - 2034	16,103	Алсын хараа 2050 3.1.1 УИХ 36-р тогтоол 3.2.3
1.2	Тариаланчдад зах зээлийн баримжаатай менежментийг түгээн дэлгэрүүлэх төлөвлөгөө	• Жижиг тариаланчдын чадварыг бэхжүүлэх сургалтаар дамжуулан үйлдвэрлэлийн материал хэрэгсэл ба зах зээлийн хүртээмжийг сайжруулж, тариаланчдын менежментийн тогтвортой байдал, орлогыг нэмэгдүүлэхийг зорино. • Зах зээлийн баримжаатай менежментийг түгээн дэлгэрүүлэх удирдамж, заавар боловсруулж, түгээн дэлгэрүүлэх ажилтан болон өрхийн үйлдвэрлэгчдийг татан оролцуулах тогтолцоог бүрдүүлнэ.	ХХААХҮЯ СХ Төв	Тариаланчдын дундаж ашиг	3,600,000 төг/жилд	4,800,000 төг/жилд	2025 - 2032	5,599	Алсын хараа 2050 3.1.1 УИХ 36-р тогтоол 3.3.
1.3	ХАА-н хоршоодоор дамжуулан ХАА-н бүтээгдэхүүний түгээлт/нийлүүлэлтийн тогтолцоо байгуулах төлөвлөгөө	• Хоршооны зохион байгуулалтыг бэхжүүлж, бизнест суурилсан ХАА-н бүтээгдэхүүний бэлтгэн нийлүүлэлт болон, анхан шатны боловсруулалтын тогтолцоо байгуулахыг зорьж байна. • Хоршооны зохион байгуулалтыг бэхжүүлснээр өртгийн сүлжээний зардлыг багасгах, ашгийг дээшлүүлэх, тогтсон хэмжээ, нэр төрлөөр арилжаа хийх боломжтой болж борлуулалтын сувгийг төрөлжүүлэн, түгээлтийг сайжруулахыг эрмэлзэнэ.	ХХААХҮЯ	Чадавхи бэхжсэн хоршооны тоо	10 хоршоо	100 хоршоо	2025-2030	7,755	Алсын хараа 2050 3.1.1 УИХ 36-р тогтоол 4.2.1
1.4	Хүнсний ногоо боловсруулах энгийн арга, хэрэглээний сургалт, сурталчилгаа хийх төлөвлөгөө	• Дотоодод тариалсан хүнсний ногооны хэрэглээний талаар соён гэгээрүүлэх болон, орон нутагт ногоо тарих, боловсруулах хялбар технологи нэвтрүүлэх замаар дотоодын үйлдвэрийн ногооны хэрэглээ дэмжих, шим тэжээлийг сайжруулахыг эрмэлзэнэ.	ХХААХҮЯ	Иргэдийн хүнсний ногооны хэрэглээ	2.1кг /сар/хүн	3.0кг /сар/хүн	2025 - 2034	4,889	Алсын хараа 2050 3.1.1 УИХ 36-р тогтоол 5.10

3.3 Жимсний модны нийлүүлэлтийн сүлжээг бэхжүүлэх хөтөлбөр

(1) Хөтөлбөрийн товч агуулга

Монголын жилд үйлдвэрлэх жимсний хэмжээ 1800 орчим тонн. (зэрлэг сортыг оруулбал 6,000тонн) байхад жилийн хэрэглээ нь 30,000тонноос давж байгаа, эрэлт нийлүүлэлтийн зөрүү ихтэй. Харин, нэг тэрбум мод үндэсний хөдөлгөөн нь түлхэц өгч байгаа болохоор жимсний модны үйлдвэрлэл түгээлт өргөжинө гэх хүлээлт байна. Жимсний модны нийлүүлэлтийн сүлжээг бэхжүүлэхэд 1)Дотоодын суулгац үйлдвэрлэл, нийлүүлэлтийн тогтолцоог бүрдүүлснээр нийлүүлэлтийн сүлжээг бэхжүүлэх 2)Тариалалтын зохистой технологийг хөгжүүлэх замаар үйлдвэрлэлийн хэмжээг нэмэгдүүлэх 3)Чацарганы экспортыг дэмжих нь онцгой чухал байна.

	Орц	Үйлдвэрлэл	Боловсруулалт	Түгээлт, экспорт	Борлуулалт, хэрэглээ
Оролцогч	Үйлдвэрлэлийн багаж хэрэгсэл нийлүүлэгч ААН-үүд (Үр, бордоо, УХБ)	Тариаланч, ХАА-н хоршоо, газар тариалангийн компаниуд	Боловсруулах үйлдвэрүүд	Ченж, ХАА-н хоршоо,түгээлт, экспортын ААН	Жижиглэнгийн дэлгүүр, нийтийн хоол г.м
Гол бэрхшээл	Дотоодын суулгац үйлдвэрлэл, нийлүүлэлт хангалттүй. Таримал болон зэрлэг сорт холилдсон, зохих чанарын хяналт шаардлагатай	Усалгааны хүртээмж хүндрэлтэй, шувуу идэх зэргээр бүтээмж нь 2-3 тонн/га байгаа нь төсөөлснөөс бага ургацтай. Үйлдвэрлэлийн хугацаа богино. Тариалалтын зохистой технологи , тоног төхөөрөмж шаардлагатай.	Түүхий эд худалдан авах үед сорт холилдсон, ялгамж бренджүүлэлт хангалттүй. Үйлдвэрлэлийн ашиглалт бага. ЕХ-ны нормоор УХБ илэрсэн,үйлдвэрлэл боловсуулалтын шатанд сайжруулах боломжтой.	Агуулах хүрэлцээгүй.Тээврийн зардал өндөр. Ургац хураалтын үе болон үйлдвэрлэлийн бус улиралд түгээлт,үнийн хэлбэлзэл их. Чацаргана нь экспортлож байгаа цөөн жимсний нэг.	Нэг хүнд ноогдох хэрэглээ бага. Өсөн нэмэгдэх эрэлтээс үйлдвэрлэлийн хэмжээ нь бага. Хот хөдөөгийн хэрэглээний ялгаа бага.
Авах арга хэмжээ	2.1 Жимсний модны суулгацын төвд тулгуурласан нийлүүлэлтийн сүлжээг бэхжүүлэх төлөвлөгөө	2.2 Тариалалтын зохистой технологийг дэлгэрүүлэх төлөвлөгөө	2.3 Чацарганын экспортыг дэмжих төлөвлөгөө		

Монгол Улсын жимс жимсгэний жилийн хэрэглээ нь 30,000 тн байхад, жилийн үйлдвэрлэлийн хэмжээ нь 8,000 тн байгаа нь эрэлт нийлүүлэлтийн зөрүү хэт их байгааг харуулж байна. Мөн хүн ам зүйн талаас авч үзвэл ирээдүйд хүн ам өсөх хандлагатай байгаа, тэгэхээр эрэлт хэрэгцээ тасралтгүй нэмэгдэнэ гэж таамаглаж байна. Уур амьсгалын нөхцөл зэрэг хязгаарлал үүсгэх зүйлс бий ч Монгол Улсын жимсний нийлүүлэлтийн сүлжээний чиг хандлагаас харахад дотоодын жимс, жимсгэний үйлдвэрлэл түгээлтийг цаашид өргөжүүлэх шаардлагатай. Бас, жимснээс чацарганы үйлдвэрлэл харьцангуй их бөгөөд гадаадад экспортлодог жимс, жимсгэний төрөл тул цаашид ч экспортыг дэмжихийг зорьж байна. Бодлогын уялдааны хувьд 2022 онд зарласан тэрбум мод тарих үндэсний хөдөлгөөн нэлээд эрчимтэй өрнөж байгаа нь анхаарвал зохих зүйл мөн.

Өнөөгийн нийлүүлэлтийн сүлжээний гол хүндрэл гэвэл, ①Үйлдвэрлэлийн хэрэгслийн шатанд дотоодын суулгацын үйлдвэрлэл нийлүүлэлт хангалттүй, таримал болон зэрлэг сорт нь холилдсон байдалтай, ②Үйлдвэрлэлийн шатанд усалгааны хүртээмж муутай, шувуу идэх зэргээр бүтээмж нь төсөөлж байснаас бага, ③Боловсруулах шатанд түүхий эд худалдан авахад сортууд холилдсон, ялгарал болон бренджүүлэлт хангалттүй байгаа явдал, ④Түгээлт, экспортын шатанд хадгалах агуулахын дутагдал , тээврийн зардал өндөр, үнийн хэлбэлзэл их, ⑤Хэрэглээний шатанд нэг хүнд ноогдох хэрэглээний хэмжээ бага, мөн үйлдвэрлэл нь эрэлт хэрэгцээгээ гүйцдэггүй зэргийг дурдаж болно..

Үндсэн үзэл баримтлал, хөгжлийн чиглэлд тулгуурласан жимсний нийлүүлэлтийн сүлжээг бэхжүүлэх хөтөлбөр гэвэл, 1) Жимсний модны суулгацын төвд тулгуурласан нийлүүлэлтийн сүлжээг бэхжүүлэх төлөвлөгөө, 2) Тариалалтын зохистой технологийг хөгжүүлэх төлөвлөгөө, 3) Чацарганы экспортыг дэмжих төлөвлөгөө гэсэн 3 YAT боловсруулсан. Үйл ажиллагааны төлөвлөгөөнүүдийн товч агуулгыг доор сийрүүлэв.

(2) Үйл ажиллагааны төлөвлөгөөнүүдийн товч агуулга

No.	ҮАТ	Товч	Хэрэгжүүлэх байгууллага	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Төслийн хугацаа	Төслийн өртөг (сая төг)	Төлөвлөгөөний үндэслэл
2.1	Жимсний суулгацын төвд түшиглэсэн нийлүүлэлтийн сүлжээг бэхжүүлэх төлөвлөгөө	• Зонхилох бүс нутаг бүрт жимсний модны суулгацын төв байгуулж, төрөл бүрийн жимсний суулгац тарьж нийлүүлэхийг үйл ажиллагааг бэхжүүлэх, жимсний дотоодын үйлдвэрлэлийн хэмжээг нэмэгдүүлэх болон чанарыг сайжруулахыг зорино.	ХХААХҮЯ ХААИС	Үйлдвэрлэсэн суулгацын тоо	0 (2022 он)	1сая мод/ жилд	2025 - 2034	9,400	Алсын хараа 2050 6.2.4 УИХ 36-р тогтоол 3.10.2
2.2	Тариалалтын зохистой технологийг түгээн дэлгэрүүлэх төлөвлөгөө	• Засгийн газар судалгаа хөгжлийн байгууллагатай хамтран жимсний модны тариалалтын зохистой технологийг түгээн дэлгэрүүлэх тогтолцоо бүрдүүлнэ • Жимсний модны тариалалтын зохистой технологийг нэвтрүүлэх удирдамж, заавар боловсруулж, аймаг сумдын ХХААГ, тасгийн агрономчид болон жимсний модны тариаланчид үр өгөөжтэй ашиглах тогтолцоог бүрдүүлнэ	ХХААХҮЯ	Чадавхи сайжирсан жимсний тариаланчдын тоо	0 (2022 он)	2,500 хүн	2025 - 2030	4,199	Алсын хараа 2050 6.2.4 УИХ 36-р тогтоол 3.10
2.3	Чацарганы экспортыг дэмжих төлөвлөгөө	• МУ-д аль хэдийнэ үйл ажиллагаа явуулж байгаа чацарганын кластераар дамжуулан чацарганын бүтээгдэхүүний экспортыг дэмжих. • Төрийн албан хаагч мэргэжилтнүүдийн чадавхийг бэхжүүлэх, худалдааны бодлого боловсруулах болон төрийн байгууллагуудын бүрдүүлэлтийн журмын дэмжлэг, олон улсын зах зээлийн хэрэгцээ шаардлагыг судлах, зорилтот зах зээлийг тодорхойлох, тогтоосон зорилтот зах зээл дээрх борлуулалтыг эрчимжүүлэх маркетингийн үйл ажиллагаа, кластерийг бэхжүүлэх.	ХХААХҮЯ	Чацарганы экспортын үнэ	890 Сая төг (2021 он)	1,780 Сая төг	2025-2034	3,250	Алсын хараа 2050 6.2.4 УИХ 36-р тогтоол 3.10

3.4 Тосны ургамалын нийлүүлэлтийн сүлжээг хөгжүүлэх хөтөлбөр

(1) Хөтөлбөрийн агуулга

Ургамлын тосны дотоодын үйлдвэрлэл нийлүүлэлтээр 2027 он гэхэд хэрэгцээгээ бүрэн хангахад чиглэсэн нийлүүлэлтийн сүлжээ байгуулах. Тосны ургамлаас Монголд хамгийн тохиромжтой нь рапс бөгөөд түүнийг тариалах болон боловсруулах тогтолцоо ч бүрдээд байгаа. Улаанбуудайтай сэлгэн тариалах системд орсон ба Хятадад экспортлодог гичтэй өрсөлдөөний байдалтай, гичнээс рапс руу шилжих байх гэж найдаж байгаа. Тэгэхийн тулд үйлдвэрлэгчийг тасралтгүй дэмжиж, рапсын дотоодын үртэй болох,рапсын худалдааны нөхцлийг сайжруулах, рапсын тосны борлуулалтыг дэмжих шаардлагатай.

	Орц	Үйлдвэрлэл	Боловсруулалт	Түгээлт, экспорт	Борлуулалт, хэрэглээ
Оролцогчид	Үр, бордоо, УХБ-ын компани	Тариаланчид, газар тариалангийн компаниуд	Хүнсний боловсруулах үйлдвэрүүд	Ченж, ХАА-н хоршоо, түгээлт, экспортын ААН	Жижиглэнгийн дэлгүүр, нийтийн хоолны газрууд
Гол хүндрэл	Рапсын үр нь импортоос хараат, худалдан авахад хүндрэлтэй. Дотооддоо үйлдвэрлэдэг болох хэрэгтэй. Орцын материалыг хөнгөлөлттэй зээлээр дэмжих	Рапс үйлдвэрлэх технологи нь төлөвшөөгүй, бүтээмж нь 0.6 тн/га буюу дэлхийн дундажийн 1/3 орчим байна. Технологийг зохистой хөгжүүлэх, дэлгэрүүлэх үйл ажиллагаа зайлшгүй шаардлагатай.	Хүнсний боловсруулах үйлдвэрүүд	Хангалттай хүчин чадал, тоног төхөөрөмжтэй тос боловсруулагч бий ч тэр нь монополь байдалтай. Гичтэй өрсөлдөхийн тулд рапс худалдан авах уян хатан нөхцөл нь сорилт юм.	Дотоодын рапсын тос борлуулагчдын тоог нэмэгдүүлэх шаардлагатай. Дотоодын хэрэгцээг хангах нь тэргүүн зорилт ч Солонгос руу экспортлож буй	Олон төрлийн тос хэрэглэдэг ч рапсын тос нь бусад тосноос давуу талтай бөгөөд зохистой хэрэглэх нь хэрэглээг идэвхжүүлнэ.
Авах арга хэмжээ	3.1 Рапсын үрний дотоодын үйлдвэрлэл нийлүүлэлтийг бэхжүүлэх төлөвлөгөө	3.2 Рапс тариалах технологийг хөгжүүлэх болон үйлдвэрлэлийг дэмжих төлөвлөгөө	3.3 Рапсын худалдааны нөхцлийг сайжруулах төлөвлөгөө	3.4 Рапсын тосны хэрэглээг нэмэгдүүлэхэд чиглэсэн ухуулга сурталчилгаа хийх төлөвлөгөө	

Ургамалын тосны дотоодын хэрэгцээг 2027 он гэхэд өөрийгөө хангадаг болох үндэсний зорилтыг хэрэгжүүлэхэд нийлүүлэлтийн сүлжээ байгуулах шаардлагатай. Тосны ургамлаас Монголд хамгийн ирээдүйтэй нь рапс бөгөөд түүнийг боловсруулах үйлдвэрүүд ч бий болсон байна. Рапсыг улаан буудайтай сэлгэн тариалах тогтолцоо бүрдсэн хэдий ч Хятад руу экспортлох гич нь борлуулалтын нөхцөл илүү байдаг тул гич тариалах сонирхох их байна

Монгол Улсад рапсын тариалан харьцангуй шинэ бөгөөд үйлдвэрлэлийн зохистой технологи бий болгож, үйлдвэрлэгчдийн дунд түгээх шаардлагатай байна. MONMAP-AVC төслийн хүрээнд МУ-ын ХААИС-ийн судлаачдын боловсруулсан рапсын сурах бичигт үндэслэн тариаланчдад ашиглахад хялбар тариалалтын гарын авлагыг эмхэтгэн боловсруулсан. Үүнийгээн тулд рапстай холбоотой хурал уулзалтууд дээр үйлдвэрлэгч тариаланчдад тарааж ажилласан. Одоо Монгол Улсад хоёр төрлийн рапсын сортыг баталгаажуулсан байгаа бөгөөд цаашид зохих технологийг баталгаажуулж, бүтээмжийг сайжруулахыг зорих нь зүйтэй.

Гичнээс рапст шилжих байх гэсэн хүлээлт байна.Үүний тулд зайлшгүй хөгжүүлэх зүйл бол, 1) Рапсын үрийг дотооддоо тариалах ажлыг бэхжүүлэх, 2) Рапс тариалах технологийг хөгжүүлэх болон тариалалтыг дэмжих, 3) Рапсын борлуулалтын нөхцөлийг сайжруулах, 4) Рапсын тосны хэрэглээг өргөжүүлэхэд чиглэсэн ухуулга сурталчилгаа хийх зэргийг дурьдаж болно.

Үйл ажиллагааны төлөвлөгөөнүүдийн товч агуулгыг доор сийрүүлэв.

(2) Үйл ажиллагааны төлөвлөгөөнүүдийн товч агуулга

No.	ҮАТ	Товч	Хэрэгжүүлэх байгууллага	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Төслийн хугацаа	Төслийн өртөг (сая төг)	Төлөвлөгөөний үндэслэл
3.1	Рапсын үрийн дотоодын үйлдвэрлэлийг бэхжүүлэх	• Рапсын үрийн дотоодын үйлдвэрлэл, тогтвортой нийлүүлэлтэд чиглэсэн төрийн хяналтын тогтолцоог нэвтрүүлж, бататгах • Улаан буудайн дээр хэрэгжиж байгаа системтэй адил, газар тариалангийн шилдэг хуулийн этгээдийг үр үйлдвэрлэгчээр баталгаажуулж, Засгийн газар үрийн рапсыг зохих үнээр худалдан авч зохистойгоор агуухад хадгалан, дараа жилийн тариалах ААН-д тохирох нөхцөлөөр нийлүүлэх	ХХААХҮЯ	Рапс үрийн бүртгэгдсэн үйлдвэрлэлийн хэмжээ	0 (2022он)	500 тн	2025 - 2034	1,549	Алсын хараа 2050 2.5, 8.2 УИХ 36-р тогтоол 3.2.3
3.2	Рапсын тариалангийн технологи хөгжүүлэх, үйлдвэрлэлийг дэмжих	• Монгол Улсын га-гаас авах рапсын ургацын дундаж хэмжээ 0,6тн бөгөөд дэлхийн дундаж болох 2 тн/га-д дөхүүлэхийн тулд технологийг сайжруулахыг зорино. • Үр болон ХАА-н машин механизмийн түлш, бордоо, ургамал хамгааллын бодис худалдан авахад богино хугацаатай зээл олгох, болон ХАА-н техник авахад урт хугацаатай зээл олгох тогтолцоог үргэлжлүүлэх. • Ялангуяа газар тариалангийн машин механизмийн тухайд тариаланчдад зохих техник, тоног төхөөрөмжийг сонгох, ажиллуулах зөвлөгөө өгөх • Дотоодын тосны үйлдвэрлэлд зориулсан рапс тариалангийн урамшуулалын тогтолцоо нэвтрүүлэхийг судлан үзэх	ХХААХҮЯ, ХХААХУ-ийн СХТ	Рапсын ургацын хэмжээ	0.6 тн/га (2022 он)	1.0 тн/га	2025 - 2034	6,946	Алсын хараа 2050 2.5, 8.2 УИХ 36-р тогтоол 3.2.3
3.3	Рапсын худалдааны нөхцөлийг сайжруулах	• Рапс болон тосны ургамалын тариалалтыг тогтворжуулахын тулд худалдааны нөхцөлийг тариаланч болон тос шахах үйлдвэр хооронд урьдчилан тохиролцож байхыг дэмжих. • Газар тариалангийн холбоод эсвэл хувь тариаланч болон тос шахах ААН-ийн гэрээт тариалалтыг дэмжих.	ХХААХҮЯ	Рапс тариалангийн талбай	17,000 га (2022он)	50,000 га	2025-2034	200	Алсын хараа 2050 2.5, 8.2 УИХ 36-р тогтоол 3.2.3
3.4	Рапсын тосны хэрэглээг өргөжүүлэхэд чиглэсэн соён гэгээрүүлэх үйл ажиллагаа	• Импортын наранцэцэг болон шар буурцгийн тос давамгайлж байгаа Монголын ургамлын тосны зах зээлд дотоодын үйлдвэрийн рапсын тосны хэрэглээний хувь хэмжээг нэмэгдүүлэхийн тулд хэрэглэчдэд түүний давуу талыг сурталчлах, хэрэглээг өрөгжүүлэхийг дэмжих.	ХХААХҮЯ	Рапсын тосны хэрэглээний хувь	10 % (2022 он)	20 %	2025 - 2034	190	Алсын хараа 2050 2.5, 8.2 УИХ 36-р тогтоол 3.2.3

3.5 Мах, сүүний нийлүүлэлтийн сүлжээг бэхжүүлэх хөтөлбөр

(1) Хөтөлбөрийн агуулга

Монгол Улсын малын тоо социализм тарснаас хойш тасралтгүй өссөөр одоо 70 саяыг даваад байна. Нэг хүнд ноогдох МАА-н гаралтай бүтээгдэхүүний хэрэглээ их, ялангуяа махны хэрэглээгээр дэлхийд тэргүүлж байна. Гэсэн хэдий ч үйлдвэрлэл хэрэглээний тэнцвэрт байдал алдагдаж, мал өссөөр байна. Тийм учраас МАА-н арвин их нөөцийн үр дүнтэй ашиглах шаардлагатай байгаа бөгөөд үүний тулд МАА-н үйлдвэрлэлийг төрөлжүүлж, нэмүү өртөг шингээхийг дэмжиж гадаад зах зээлд гаргах зэрэг нь тулгамдсан асуудал болоод байгаа юм.Дээрх нөхцөл байдлыг харгалзан хэд хэдэн шинэ аргачлал нэвтрүүлж, МАА-н бүтээгдэхүүний нийлүүлэлтийн сүлжээг бэхжүүлэхийг зорьж байна.

	Орц	Үйлдвэрлэл	Нийлүүлэлт	Боловсруулалт	Борлуулалт, хэрэглээ
Оролцогч	Өвс тэжээл, түлш шатахуун борлуулагчид, малын эмч нар	Малчид, эрчимжсэн МАА эрхлэгчид	Мэргэжлийн боловсруулах компани болон мах сүүн бүтээгдэхүүн боловсруулах ААН	Экспортогч ААН , зарим дундын зуучлагчид	Жижиглэнгийн дэлгүүр, том супермаркет,экспортын төлөөлөгчийн газар
Тол бэрхшээл	Өргөн уудам нутагт тархан суугаа малчид, үйлдвэрийн холбоо муу, хот орчмын бэлчээрийн хомсдол, эрчимжсэн МАА-н хувьд тэжээл нийлүүлэлтийн тогтолцоо тогтворгүй	Эхлэлийн хөрөнгө оруулалт бараг байхгүй буюу хамгийн бага ч, нийлүүлэлт жигд биш, анхан шатны боловсруулалтын (хүнсний зориулалтаар төхөөрөх) үр ашгийг дээшлүүлэх зайлшгүй шаардлагатай байна. Эрчимжсэн мал аж ахуйн үр ашиг ч бага	Улирлын чанартай, жилийн туршид жигд үйлдвэрлэл эрхлэх боломжгүй, (агуулахын өгөөжтэй менежмент шаардлагатай). Шинэ үйлдвэрлэлийн системд технологийн хувьд зохицсон ААН маш цөөхөн. Эрүүл ахуйн менежмент, чанар сайжруулах ойлголт дутмаг	Нийлүүлэлтийн дийлэнх нь дундын зуучлагчдаас хараат,системчлэгдсэн бүтэц байхгүй (Ялангуяа малчдаас цуглуулж авах ажил)	Зарим орнуудад Монголын МАА н бүтээгдэхүүний эрэлт тодорхой хэмжээтэй байгаа нь тогтоогдсон ч бизнесүүдийг “холбох” боломж туйлын хомс, төрийн дэмжлэгийн тогтолцоо бүрдээгүй байна.
Авах арга хэмжээ	4.1 Малын үүлдэр угсааг сайжруулах тогтолцоо бүрдүүлэх төлөвлөгөө 4.2 Өсвөр мал бордох（хургыг оролцуулан）-ыг дэмжих төлөвлөгөө 4.3 Зах зээлийн эрэлтэд нийцсэн махны шинэ зэрэглэлийн стандарт гаргах, нэмүү өртөг шингээхийг эрчимжүүлэх төлөвлөгөө 4.4 Мал төхөөрөх үйлдвэр цех байгуулах төлөвлөгөө 4.5 МАА н бүтээгдэхүүн, түүний дайврыг ашиглан ГТА- ны хоол тэжээлийн үйлдвэрлэлийг бий болгох төлөвлөгөө 4.6 Сүү цуглуулах тогтолцоог бэхжүүлэх замаар сүүний нийлүүлэлтийг нэмэгдүүлэх төлөвлөгөө				

Хамгийн сүүлд гарсан ХАА-н ДНБ-ий (2022 он) 80 гаруй хувийг МАА салбар бүрдүүлж байгаа бөгөөд энэ өндөр үзүүлэлт нь Монголын соёлын өв гэж хэлж болох нүүдлийн МАА-с үүдэлтэй гэж хэлж болно. Тэр дундаа мах, сүүний нийлүүлэлтийн сүлжээ нь Монгол Улсын аль ч салбараас хамгийн урт түүхтэй ч хөгжлийн түвшин сайнгүй хэвээр байна. Хамгийн том онцлог нь махыг орчин үеийн төхөөрөх үйлдвэрт, сүүгээ хүйтэн хэлхээ бүхий боловсруулах үйлдвэрт нийлүүлэх, өөрөөр хэлбэл албан ёсны сувгаар дамжуулан үйлдвэрт нийлүүлж байгаа хувь хэмжээ мах, сүүний хувьд туйлын бага байна. Албан ёсны сувгаар нийлүүлэгдэж буй хувь хэмжээ махны хувьд ±10% гэж тооцдог бөгөөд сүүний хувьд бүс нутгийн ялгаа ихтэй, сүү цуглуулах дэд бүтэц сайн хөгжөөгүй газруудад огт нийлүүлэлт байхгүй гэж хэлж болно.

Дээрх нөхцөл байдлаас гадна, мах, сүүний нийлүүлэлтийн сүлжээнд олон талын бэрхшээл тулгардаг. Богино хугацаанд шийдвэрлэх гарц гаргалгаа хялбар биш хэдий ч Монгол улсын давуу талыг тусган аль болох олон асуудлуудад шийдэл гаргасан, асуудлыг хөнгөвчилсөн төлөвлөгөө байх нь зүйтэй юм. Дээрх зурагт харуулсан “4.1.Малын үүлдэр угсааг сайжруулах тогтолцоог бий болгох төлөвлөгөө”, “4.2 Өсвөр малыг бордох ферм (хурга зэрэг) нэвтрүүлэхийг эрчимжүүлэх төлөвлөгөө”, “4.3 Зах зээлийн эрэлт хэрэгцээнд нийцсэн мах ялган ангилах шинэ стандартыг нэвтрүүлэх, нэмүү өртөг шингээх үйл ажиллагааг дэмжих төлөвлөгөө”, “4.4 Мал төхөөрөх газар байгуулах төлөвлөгөө”, “4.5 МАА-н болон дайвар бүтээгдэхүүнээр тэжээвэр амьтдын хоолны үйлдвэрлэл бий болгох төлөвлөгөө”, “4.6 Сүү цуглуулах тогтолцоог бэхжүүлэх замаар сүүний байнгын үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх төлөвлөгөө” нь эдгээр асуудлуудыг харгалзан боловсруулсан төлөвлөгөөнүүд юм.

Үйл ажиллагааны төлөвлөгөөнүүдийн товч агуулгыг доор сийрүүлэв.

(2) Үйл ажиллагааны төлөвлөгөөнүүдийн товч агуулга

No.	ҮАТ	Товч	Хэрэгжүүлэх байгууллага	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Төслийн хугацаа	Төслийн өртөг (сая төг)	Төлөвлөгөөний үндэслэл
4.1	Малын үүлдэр угсааг сайжруулах тогтолцоог бий болгох төлөвлөгөө	• Малын үүлдэр угсааг сайжруулахын тулд аймаг бүрт ашиг шимтэй сайн үүлдрийн мал өсгөн үржүүлэх, сайн үүлдэр омгийн хөлдөөсөн үр ашиглах, үүлдэр угсааг сайжруулах тогтолцоог бий болгохыг зорино	ХХААХҮЯ	Үүлдэр угсааг сайжруулах тогтолцоо бүхий аймгийн тоо	5 (2022 он)	22	2025 - 2034	51,906	Алсын хараа 2050 3.1.1, 6.1
4.2	Өсвөр малыг бордон тэжээх фермийг (хурганы мах оруулан) дэмжих төлөвлөгөө	• Хавар төрсөн эр хургыг тухайн жилийнхээ өвлөөс өмнө хөнгөлж, бордож, төхөөрөх, боловсруулах үйлдвэрт борлуулж, малчдын хөдөлмөр хөнгөвчлөх, зардал буурах, малын хөлийн татвар багасах, бэлчээрийн даац хэтрэлтийг сааруулах	ХХААХҮЯ	Хонины махны экспортын хэмжээ	500 тн (2021он)	50,000 тн	2025 - 2034	1,506	Алсын хараа 2050 4.2.6
4.3	Мах ангилах шинэ стандарт нэвтрүүлэх, нэмүү өртөг шингээхийг дэмжих төлөвлөгөө	• Хэрэглэгчдийн хандлага таашаалын өөрчлөлтөд тохируулан махны ангиллын шинэ стандартыг боловсруулж, махны үйлдвэрүүдийн брэндэд нэмүү өртөг шингээх үндэслэл болгон нэвтрүүлж, дэлгэрүүлэх	ХХААХҮЯ, Махны холбоо	Шинэчлэн сайжруулсан махны ангиллын стандарт бий эсэх	Байхгүй	Байгаа	2025 - 2034	2,076	Алсын хараа 2050 4.2.6
4.4	Мал төхөөрөх үйлдвэр байгуулах төлөвлөгөө	• Баталгаажсан төхөөрөх үйлдвэрт эрүүл ахуйд нийцсэн тоног төхөөрөмжөөр эрүүл ахуйн шаардлага хангасан аргаар бэлтгэгдсэн, аюулгүй байдал хангагдсан махыг хэрэглэгчдэд тогтвортойгоор нийлүүлж, экспортыг дэмжих	ХХААХҮЯ	Тоноглогдсон мал төхөөрөх үйлдвэрийн хувь хэмжээ	10 % (2022он)	50 %	2025 - 2034	52,156	Алсын хараа 2050 4.2.6, 4.5.7
4.5	МАА-н болон дайвар бүтээгдэхүүнээр тэжээвэр амьтны хоолны үйлдвэрлэх	• МУ-д дэлхийн зах зээлд гэрийн тэжээвэр амьтдын хоолны түүхий эдийг нийлүүлэх шинэ бааз суурийг хөгжүүлэх	ХХААХҮЯ	Гэрийн тэжээвэр амьтны хоолны экспорт	106 тн (2021он)	150 тн	2025 - 2029	2,600	Алсын хараа 2050 3.1.1 УИХ 36-р тогтоол 4.2.1
4.6	Сүү цуглуулах тогтолцоог бэхжүүлэх замаар үйлдвэр цехэд хүлээн авах сүүний хэмжээг нэмэгдүүлэх	• Албан сувгаар цуглуулах сүүг нэмэгдүүлж, хот суурин газрын ЭА шаардлага хангасан, чанарын баталгаатай сүүний хангамжийг нэмэгдүүлэх	ХХААХҮЯ	Албан сувгаар цуглуулах сүүний хэмжээ	40,000 тн (2022 он)	60,000 тн	2025 - 2034	77,400	Алсын хараа 2050 3.1.1 УИХ 36-р тогтоол 4.2.1

3.6 Ноос ноолуур, арьс ширний нийлүүлэлтийн сүлжээг бэхжүүлэх хөтөлбөр

(1) Хөтөлбөрийн гол агуулга

Монгол Улсын хувьд ноос ноолуур, түүхий арьс шир нь хамгийн элбэг түүхий эдийн нэг юм. Хөгжүүлэх гол асуудал нь 1.Ноос ноолуурын түүхий эдийг чанарыг хадгалан боловсруулах үйлдвэрт нийлүүлэх тогтолцоо бүрдүүлэх, 2. Ноос ноолуур, арьс шир боловсруулах үйлдвэрийн техник хэрэгслийг шинэчлэх, сайн чанарын хагас болон бэлэн бүтээгдэхүүн үйлдвэрлэхийг дэмжих 3. Хүрээлэн байгаа орчин болон амьтны тавлаг байдлыг хангасан хандлагыг бүтээгдэхүүндээ шингээх чадвартай аж үйлдвэрийн хүний нөөцийг сургах зэргийг дурьдаж болно.

	Орц	Үйлдвэрлэл	нийлүүлэлт	Боловсруулалт	Борлуулалт, хэрэглээ
Оролцогч	Тэжээлийн худалдаачид, малын эмч, МАА-н асуудал хариуцсан тарийн байгууллагын төлөөлөл, малын эм нийлүүлэгчид	Малчид, малчдын хоршоо, МАА-н чиглэлийн ААН	Угаах ААН, утас үйлдвэрлэгч, хувцас, арьс ширэн эдлэлийн үйлдвэр	Экспортогч ААН, ноос арьс шир боловсруулагч ААН	Экспортлогч компани, хувцасны жижиглэнгийн дэлгүүр
Гол бэрхшээл	Тархмал амьдралтай малчид, ААН-ийн харилцаа дутмаг, ноос ноолуурын чанартай үүлдрийн сонгон үржүүлэг хангалтгүй	Хөгширсөн малын тоо ихсэж ноолуурын микрон бүдүүрч, чанар муудаж байна. Механик гэмтлийн улмаас үүсэх эсгэлт, шимэгчийн улмаас арьс нүхжих зэрэг арьсны хорогдол их, бүтээгдэхүүний үнэ цэнийг унагадаг	Түүхий ноосны анхан шатны арчилгаа (чанараар нь ангилан ялгах) хийлгүй нийлүүлдэг. Түүхий арьсны хадгалалтын нөхцөл муу, бүтээгдэхүүний үнэ цэнийг бууруулдаг	Чанартай ноос, арьс шир худалдан авахад хүндрэлтэй. Боловсруулах техник хэрэгсэл хуучирсан. Байгал орчинд ээлтэй бүтээгдэхүүн боловсруулахад технологи хоцрогдсон	Чиг хандлагын (орчны асуудал, амьтны тавлаг байдал) мэдрэмжтэй хүний нөөц дутагдалтай.
Авах арга хэмжээ	5.1 Малын үүлдэр угсааг сайжруулах тогтолцоо бүрдүүлэх төлөвлөгөө 5.2. Малчдын хоршоонд түшиглэсэн ноос, арьс ширний бэлтгэн нийлүүлэлтийн сүлжээг бэхжүүлэх төлөвлөгөө 5.3. Сүлжмэл, арьс ширний тогтвортой үйлдвэрлэлийн тогтолцоо бүрдүүлэх төлөвлөгөө 5.4. Ноос, арьс ширний салбарын хүний нөөцийг сурган бэлтгэх төлөвлөгөө				

Монгол Улсын хувьд ноос ноолуур, арьс шир нь хамгийн элбэг түүхий эдийн нэг төдийгүй үнэ цэнэтэй бүтээгдэхүүн болгох боломж хамгийн ихтэй түүхий эд юм. Экспортын боломжтой бүтээгдэхүүн болох хүлээлттэй түүхий эд боловч зах зээлд өрсөлдөх чадвар сайтай гэж хэлэх аргагүй, нийлүүлэлтийн сүлжээг нийтэд нь шинэчлэн сайжруулах зайлшгүй шаардлагатай гэж үзэж байна. Тодруулбал, 1.Ноос ноолуурын чанарыг сайжруулахын тулд үүлдэр угсааг сайжруулах тогтолцоо бүрдүүлэх, 2. Ноос ноолуур, арьс ширний бэлтгэн нийлүүлэлт, хагамжийн тогтолцоог сайжруулах, 3. Ноос ноолуур, арьс ширний боловсруулах технологийг сайжруулах, 4. Ноос ноолуур, арьс ширний салбарын хүний нөөцийг хөгжүүлэх зэрэг арга хэмжээнүүдийг хөгжлийн гол зорилт болгох боломжтой. Доор уг хөтөлбөрт багтсан Үйл ажиллагааны төлөвлөгөөнүүдийг тоймлон харуулав.

“**5.2 Малчдын хоршоонд түшиглэсэн ноос ноолуур, арьс шир бэлтгэн нийлүүлэлтийн сүлжээг бэхжүүлэх төлөвлөгөө”** нь ноос арьс ширний үйлдвэрлэлийн бааз болох малчдын хоршоонд суурилсан ханган нийлүүлэлтийн бааз суурийг бүрдүүлэх тухай юм. Малчид бэлтгэсэн ноос ноолуур, арьс ширээ хувиараа ченжүүдэд худалддаг хэлбэрийг аажмаар малчдын хоршоо нь нэгтгэн цуглуулж нийлүүлдэг тогтолцоонд шилжүүлэх, ноос арьс ширний хэрэглэгч үйлдвэр ААН-үүдийн шаардлага хангасан чанартай түүхий эд бэлтгэх тогтолцоог бүрдүүлэх юм.

“**5.3 Нэхмэл, арьс ширний үйлдвэрлэлийн тогтвортой систем бүрдүүлэх төлөвлөгөө**” нь 2021 онд батлагдсан “MNS 6926:2021- Нэхмэлийн тогтвортой үйлдвэрлэлийн стандарт”-ыг мөрдүүлэхийн тулд шаардлагатай тоног төхөөрөмжийн хөрөнгө оруулалтыг дэмжих, байгаль орчинд ээлтэй бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн технологийг нэвтрүүлэх ажлыг эрчимжүүлэх зорилготой төлөвлөгөө юм.

“**5.4 Нэхмэлийн салбарын аж үйлдвэрийн кластер хөгжүүлэх төлөвлөгөө”** нь илүү өрсөлдөх чадвартай ноос, арьс ширэн хагас боловсруулсан болон эцсийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл болон экспортыг дэмжхийн тулд тус салбарын кластер хөгжүүлэлтийг дэмжих төлөвлөгөө юм. нэхмэлийн боловсруулах процесс, тэр дундаа ээрмэлийн салбар дахь ЗГ-ын дэмжлэгийг чадавхижуулахын зэрэгцээ, нэхмэлийн үйлдвэрлэлийн анхан (түүхий эд бэлтгэл), дунд (угаах, хяргах, самнах, утас ээрэх), эцсийн (бэлэн хувцас гэх мэт эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх) шатны боловсруулагчид болон дотоодын их сургууль, судалгааны болон санхүүгийн байгууллага зэргийн хамтын ажиллагааг бэхжүүлэх зорилготойгоор кластер хөгжүүлэлтийг дэмжинэ.

Харин ”5.1 Малын үүлдэр угсааг сайжруулах тогтолцоо бүрдүүлэх төлөвлөгөө нь “Мах сүүний нийлүүлэлтийн сүлжээг бэхжүүлэх хөтөлбөрт дурьдсантай ижил агуулгатай тул энд товчлов.

(2) Үйл ажиллагааны төлөвлөгөөнүүдийн товч агуулга

No	ҮАТ	Товч	Хэрэгжүүлэх байгууллага	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Төслийн хугацаа	Төслийн өртөг (сая төг)	Төлөвлөгөөний үндэслэл
5.1	Малын үүлдэр угсааг сайжруулах тогтолцоог бий болгох төлөвлөгөө	• Малын үүлдэр угсааг сайжруулахын тулд аймаг бүрт ашиг шимтэй сайн үүлдрийн мал өсгөн үржүүлэх, сайн үүлдэр омгийн хөлдөөсөн үр ашиглах, үүлдэр угсааг сайжруулах тогтолцоог бий болгохыг зорино	ХХААХҮЯ	Үүлдэр угсаа сайжруулах тогтолцоо бүхий аймгийн тоо	5 (2022 он)	22	2025 - 2034	51,906	Алсын хараа 2050 3.1.1, 6.1
5.2	Малчдын хоршоонд түшиглэсэн ноос ноолуур, арьс шир бэлтгэн нийлүүлэлтийн сүлжээг бэхжүүлэх төлөвлөгөө	• Малчид бэлтгэсэн ноос ноолуур, арьс ширээ хувиараа ченжүүдэд худалдаг хэлбэрийг аажмаар малчдын хоршоо нь нэгтгэн цуглуулж нийлүүлдэг тогтолцоонд шилжих, ноос арьс ширний хэрэглэгч үйлдвэр, ААН-үүдийн шаарддаг чанарыг хангасан түүхий эд бэлтгэх тогтолцоог бүрдүүлэх. • Түүхий эдэд нэмүү өртөг шингээх арга хэмжээг авах (түүхий эдийн анхан шатны ангилан ялгах), түүндээ ашиглах байр сав,тоног төхөөрөмжийн (цахилгаан хайч, ноос пресслэгч, агуулах) дэмжлэг үзүүлэх.	ХХААХҮЯ	МАА-н хоршоодоос нийлүүлэхноос, арьс ширний нийлүүлэлтийн хэмжээ	Ноос: 50 тн Түүхий арьс: 3000 ширхэг	Ноос: 9600 тн Түүхий арьс: 1000,000 ширхэг	2025 - 2034	228,628	Алсын хараа 2050 3.1.1 36-р тогтоол 4.2.1
5.3	Нэхмэл, арьс ширний үйлдвэрлэлийн тогтвортой систем бүрдүүлэх төлөвлөгөө	• MNS 6926:2021- Нэхмэлийн тогтвортой үйлдвэрлэлийн стандарт”-ыг мөрдүүлэхийн тулд шаардлагатай тоног төхөөрөмжийн хөрөнгө оруулалтыг дэмжих, байгаль орчинд ээлтэй бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн технологийг нэвтрүүлэх ажлыг эрчимжүүлэх.	ХХААХҮЯ,	Стандарт хангасан нэхмэлийн үйлдвэр, байгаль орчинд ээлтэй технологи бүхий арьс ширний үйлдвэрүүдийн тоо	Нэхмэлийн үйлдвэр: 21 Арьс ширний үйлдвэр 17	Нэхмэлийн үйлдвэр: 43 Арьс ширний үйлдвэр: 44 компани	2025 - 2034	13,863	Алсын хараа 2050 4.2.7, 4.2.8
5.4	Нэхмэлийн салбарын аж үйлдвэрийн кластер хөгжүүлэх төлөвлөгөө	• Өрсөлдөх чадвартай ноос, арьс ширэн хагас боловсруулсан болон эцсийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл болон экспортыг дэмжихэд кластерыг хөгжүүлэх. • Нэхмэлийн боловсруулах процесс, тэр дундаа ээрмэлийн салбар дахь ЗГ-ын дэмжлэгийг чадавхижуулахын зэрэгцээ, нэхмэлийн үйлдвэрлэлийн анхан (түүхий эд бэлтгэл), дунд (угаах, хяргах, самнах, утас ээрэх), эцсийн (бэлэн хувцас гэх мэт эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх) шатны боловсруулагчид болон дотоодын их сургууль, судалгааны болон санхүүгийн байгууллага зэргийн хамтын ажиллагааг бэхжүүлэх зорилготойгоор кластер хөгжүүлэлтийг дэмжих.	ХХААХҮЯ	Утасны экспортын хэмжээ (HS5109), хувцас, хувцас хэрэгслийн экспортын хэмжээ (HS61)	Утас 7.8 тн Хувцас: 558 тн	Утас: 20.2 тн Хувцас: 908 тн	2025 - 2034	46,650	Алсын хараа 2050 4.2.7, 4.2.8

3.7 Зөгийн балны нийлүүлэлтийн тогтолцоог бэхжүүлэх хөтөлбөр

(1) Хөтөлбөрийн агуулга

Үйлдвэрлэл болон чанар тогтворгүй, өртөг өндөр. Дотоодын зах зээлд голчлон супермаркетуудаар борлуулдаг. Компаниуд гол тоглогч болж тогтвортой нийлүүлэлт хийж эхлээд байгаа. Гэвч, импортын хэмжээ их, байнга нийлүүлэлт нь хэрэглээгээ давдаг, ширүүн өрсөлдөөнтэй. Илүү тогтвортой нийлүүлэлт шаардлагатай. Дэлхийн зах зээлд ч маш их өрсөлдөөнтэй, Монголын зөгийн бал өрсөлдөх чадвар сул. Далайд гарцгүй нь сул тал болдог. Түгээлт болон экспортын бүрдүүлэлт гэх мэт зардал өсгөдөг хүчин зүйлүүдийг сайжруулахыг зорихын зэрэгцээ зорилтот зах зээлд нийцүүлж Монголын бүтээгдэхүүний давуу талыг харуулах шаардлага бий.

	Орц	Үйлдвэрлэл	Боловсруулалт	Түгээлт, экспорт	Борлуулалт, хэрэглээ
Оролцогч	УХБ нийлүүлэгч, зөгийчин, импортлогч, үүр хайрцаг үйлдвэрлэгч	Зөгийчин, зөгийн ААН	Зөгийчин, Зөгийн компани,бал савлагч ААН	Зөгийчин, Зөгийн компани,бал савлагч ААН	Зөгийнчин, жижиглэнгийн худалдаачин
Гол бэрхшээл	УХБ-ын зохистой хэрэглээ, УХБ үлдэх эрсдэл багатай сүрэгтэй болох нь асуудалтай. Дотоодын бараа нь олдоц муу. Сав нь импортын хараат, сонголт цөөн.	Хортон шавьж тархмал.бал хураах орчин найдваргүй, үйлдвэрлэлийн хугацаа богино. Маллагааны технологийг сайжруулах шаардлагатай.Үлдэгдлийн эрсдлийг шинжилж чадахгүй байгаа. Стандарт мөрдөх ойлголт муутай зөгийчид ч байна.	ААН-ийн бал худалдан авах өртөг өндөр. Үлдэгдэл ихтэй, ашиглалт бага.Хүнсний аюулгүй байдлын ойлголт дутуу.Чанарын шаардлага хангахгүй бараа их. Хуурамч гарал үүсэл, хуурамч бүтээгдэхүүн гэх үл итгэх байдал их.	Тээврийн зардал өндөр.Зөгийчид гар дээрээс худалдаа хийх нь элбэг,нийлүүлэлт тогтворгүй. Чанар үнийн хувьд өдөр тутмын хэрэглээний бүтээгдэхүүн байхгүй. Экспортод өрсөлдөх чадваргүй.	Нэг хүнд ноогдох хэрэглээ бага. Хэрэглэгчид балны чанар, стандартыг мэддэггүй. Худалдаалах үнэ өндөр. Бүтээгдэхүүний өрсөлдөх чадвар муу.
Авах арга хэмжээ	6.1 Зөгийн мэргэшсэн эмч бэлтгэх, хортон шавьжид тэсвэртэй зөгий өсгөх төлөвлөгөө 6.2 Зөгийн балыг чанарын баталгаатай болгож, өрсөлдөх чадварыг бэхжүүлэх төлөвлөгөө 6.3 Кластерийг бэхжүүлэх замаар зөгийн балны экспортыг дэмжих төлөвлөгөө 6.4 Зөгийн аж ахуйг бусад салбартай хамтран хөгжүүлэх төлөвлөгөө				

Монгол зөгийн балны үйлдвэрлэлийн салбарт (1) үйлдвэрлэлийн тогтворгүй байдал, (2) чанарын тогтворгүй байдал, (3) өртөг өндөр зэрэг асуудлууд байдаг ч дотоод болон гадаадад ирээдүйтэй зах зээл бий. Зах зээлээ тэлэхийн тулд үйлдвэрлэл болон чанарын тогтвортой байдлыг хангаж, нийлүүлэлтийг тогтворжуулах шаардлагатай. Дотоодын зах зээл дээр дотоодын үйлдвэрийн зөгийн бал өндөр үнэлэгддэг бөгөөд нийлүүлэлт тогтвортой байж чадвал импортыг орлох боломж дээшлэнэ. Дотоод зах зээлд өрсөлдөх чадварыг бэхжүүлэх гэхээс илүүтэй зах зээлийн хэмжээг тэлэхийг зорилго болгох нь зүйтэй.

"**6.1 Зөгийн аж ахуйн мэргэжилтнийг сургах, өвчин болон хортон шавьжид тэсвэртэй зөгийн аж ахуй хөгжүүлэх төлөвлөгөө**"-нд үйлдвэрлэлийн тогтвортой байдалд хамгийн их эрсдэл авчирдаг зөгийн бүлийн хорогдлоос сэргийлэхийн тулд өвчин, хортон шавьжтай тэмцэх шаардлагатай. Мал эмнэлгийн хяналт мониторингийн тогтолцоог бий болгох болон зөгийн аж ахуйн салбарын мэргэжлийн боловсон хүчнийг чадавхижуулах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.

"**6.2 Зөгийн балны чанарыг баталгаажуулах замаар өрсөлдөх чадварыг бэхжүүлэх төлөвлөгөө**" нь чанарын хяналтын тогтолцоог нэвтрүүлэх замаар дотоод болон гадаад зах зээл дээр нэмүү өртгийг сайжруулахыг зорино. Ялангуяа экспортын зах зээлд монгол зөгийн бал үнийн хувьд өрсөлдөх чадваргүй учраас бүтээгдэхүүний үнээс гадна өөр онцлог шинж чанар бүхий үнэ цэн бий болгон өрсөлдөж чадах зах зээлийг олж илрүүлэн, стратеги боловсруулан нэвтрэх нь чухал.

"**6.3 Кластерийг бэхжүүлэх замаар зөгийн балны экспортыг дэмжих төлөвлөгөө**" нь зөгийн балны экспорттой холбоотой байгууллагуудын хамтын ажиллагааг бэхжүүлэх замаар зорилтот зах зээлд дүн шинжилгээ хийж, экспортын зорилтот орнуудтай протокол байгуулахыг эрчимжүүлэх зорилготой. Зөгийчид болон компаниудын хамтын ажиллагааг бэхжүүлэх нь зөгийн балны бүтээгдэхүүний нөөцийг тэгшитгэж, нийлүүлэлтийг тогтворжуулахад хувь нэмэр оруулна. Зөвхөн зөгийн аж ахуйтай холбоотой компаниуд төдийгүй ложистикийн болон тээвэрлэгч компаниудтай хамтран ажиллах шаардлагатай.

"**6.4 Зөгийн аж ахуйг бусад салбартай хамтран хөгжүүлэх төлөвлөгөө**" нь бусад салбартай хамтран ажиллахыг дэмжих зорилготой. Газар тариалан болон МАА-н салбартай хамтран ажиллаж балт ургамалын нөөцийг тогтворжуулахыг зорихоос гадна зах зээлээ тэлэхийн тулд аялал жуулчлалын салбартай хамтран ажиллахыг дэмжинэ.

(2) Үйл ажиллагааны төлөвлөгөөнүүдийн товч агуулга

No.	ҮАТ	Товч	Хэрэгжүүлэх байгууллага	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Төслийн хугацаа	Төслийн өртөг (сая төг)	Төлөвлөгөөний үндэслэл
6.1	Зөгийн аж ахуйд ажиллах мэргэжилтнийг сургах, өвчин болон хортон шавьжид тэсвэртэй зөгийн аж ахуй хөгжүүлэх төлөвлөгөө	• Үйлдвэрлэлийн тогтвортой байдалд хамгийн их эрсдэл авчирдаг зөгийн бүлийн хорогдлоос сэргийлэхийн тулд өвчин, хортон шавьжтай тэмцэх. • Мал эмнэлгийн хяналт мониторингийн тогтолцоог бий болгох болон зөгийн аж ахуйн салбарын мэргэжлийн боловсон хүчнийг чадавхижуулах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.	ХХААХҮЯ	Мал эмнэлэг болон зөгийчдийн байгуулсан гэрээ	13%	80%	2025 - 2034	1,538	Алсын хараа 2050 3.1.1, 6.1
6.2	Зөгийн балны чанарыг баталгаажуулах замаар өрсөлдөх чадварыг бэхжүүлэх төлөвлөгөө	• Зөгийн балны мөшгөх систем болон зөгийн балны үйлдвэрлэлийн зохистой дадлыг нэвтрүүлж, дотоод болон гадаад зах зээлд нэмүү өртгийг дээшлүүлэхийг зорьно.	ХХААХҮЯ	Мөшгөх боломжтой зөгийн балны нийлүүлэлтийн хэмжээ	0 тн	200 тн	2025 - 2034	2,726	Алсын хараа 2050 3.1.1 36-р тогтоол 4.2.1
6.3	Кластерийг бэхжүүлэх замаар зөгийн балны экспортыг дэмжих төлөвлөгөө”	• Зөгийчид болон компаниудын хамтын ажиллагааг бэхжүүлж, нийлүүлэлтийг тогтворжуулах. • Зөгийн балны экспорттой холбоотой байгууллагуудын хамтын ажиллагааг бэхжүүлэх замаар зорилтот зах зээлд дүн шинжилгээ хийж, экспортын зорилтот орнуудтай протокол байгуулахыг эрчимжүүлэх.	ХХААХҮЯ, Зөгийн балны кластер	Зөгийн балны эксплртын хэмжээ	0.3 тн	100 тн	2025 - 2034	2,083	Алсын хараа 2050 4.2.7, 4.2.8
6.4	Зөгийн аж ахуйг бусад салбартай хамтран хөгжүүлэх төлөвлөгөө	• Газар тариалан болон МАА-н салбартай хамтран ажиллаж балт ургамалын нөөцийг тогтворжуулах. • Зах зээлээ тэлэх зорилгоор аялал жуулчлалын салбартай хамтран ажиллахыг дэмжих.	ХХААХҮЯ	Хамтран ажиллаж үйлдвэрлэсэн балны хэмжээ	0тн	70 тн	2025 - 2034	1,890	Алсын хараа 2050 4.2.7, 4.2.8

3.8 ХАА-н бусад бүтээгдэхүүний нийлүүлэлтийн сүлжээг бэхжүүлэх хөтөлбөр

(1) Хөтөлбөрийн гол агуулга

Монголд одоогоор мөөгний хэрэглээ бага, дотоодын үйлдвэрлэл бага байгаа хэдий ч хойшид эрүүл хооллолтын түүхий эд гэдэг утгаараа эрэлт өргөжих байх гэж төсөөлж байгаа. Тийм учраас импортоос хараат байгаа мөөгний дотоодын нийлүүлэлтийн сүлжээг бэхжүүлэхэд чиглэсэн, 1) Мөөг үйлдвэрлэлийн технологийн судалгаа, хөгжүүлэлтийг дэмжих , 2) Мөөгний үндэсний стандарттай болох, 3) Хэрэглээг өргөтгөхөд чиглэсэн ухуулга сурталчилгаа хийх. Эдгээр оролдлого нь мөөгнөөс гадна бага хэмжээний үйлдвэрлэл бүхий (minor) ургамал, бусад хүнсний хувьд ч нийтлэг байх гэж бодож байна.

	Орц	Үйлдвэрлэл	Боловсруулалт	Түгээлт, экспорт	Борлуулалт, хэрэглээ
Оролцогч	Хөрөнгө, мицели, мөөгөнцрийн үүр үйлдвэрлэгч	Үйлдвэрлэгч, холбоод, ХАА-н хуулийн этгээд	Хүнсний үйлдвэр	Ченж,үйлдвэрлэгч-дийн холбоо,түгээлт, экспортлогч ААН	Жижиглэнгийн худалдаа, нийтийн хоолны салбар
Гол бэрхшээл	Монголын нөхцөлд таарсан мөөгний төрөл цөөн. Мөн үйлдвэрлэлд шаардлагатай техник хэрэгсэл худалдаж авахад хүндрэлтэй.	Мөөг үйлдвэрлэлийн зохистой технологи төлөвшөөгүй.Үйлдвэрлэх хүсэлтэй хүмүүст технологи зааж өгч, үйлдвэрлэгчдийн тоог нэмэгдүүлэх шаардлагатай байна.	Мөөгний савлагааны технологийг сайжруулах шаардлага байна. Бас, дотоодын мөөгөөр хийсэн хүнс гаргах, үйлдвэрлэлийг бэхжүүлэх шаардлагатай.	Дотоодын мөөгний бизнес эрхлэгчдийг олшруулах шаардлагатай.	Эрүүл мэндийг дэмжихэд нэмэртэй мөөгний хэрэглээг өргөжүүлэхэд чиглэсэн ухуулга сурталчилгаа хийх шаардлагатай байна.
Авах арга хэмжээ	7.1 Мөөг үйлдвэрлэх технологийн сургалт хийж дэлгэрүүлэхийг дэмжих төлөвлөгөө 7.2 Мөөг тариалах үндэсний стандарт боловсруулах төлөвлөгөө 7.3 Мөөгний хэрэглээг өргөжүүлэхэд чиглэсэн ухуулга сурталчилгаа хийх төлөвлөгөө				

“7.1 Мөөг үйлдвэрлэх технологийн судалгаа, түгээн дэлгэрүүлэх ажлыг дэмжих”

Монгол Улсын хувьд өөрийн байгалийн онцлогт тохирсон мөөг үйлдвэрлэх технологийг боловсруулж, үүндээ тохирсон зүйл, сортыг сонгох, ХААИС, ШУА-ийн судалгааг дэмжиж ажиллах шаардлагатай. Түүнчлэн гарсан үр дүнг мөөг үйлдвэрлэгчдэд түгээх, чиглүүлэх ажлыг идэвхжүүлэх, мөөгний үйлдвэрлэлийн зориулалттай тариалалтыг өргөжүүлэх чиглэлээр төр, хувийн хэвшлийнхэн хамтран ажиллах шаардлагатай.

“7.2 Мөөгний үйлдвэрлэлийн үндэсний стандарт боловсруулах”

Мөөгний дотоодын үйлдвэрлэлийг өргөжүүлэхийн тулд үйлдвэрлэлийн үйл явцыг зөв удирдаж, борлуулалтын ашгийг сайжруулах нь чухал бөгөөд зохих стандартад нийцсэн үйлдвэрлэлийн тогтолцоог бүрдүүлэх шаардлагатай. Эхний шатанд үйлдвэрлэгчдийн бүлгүүд болон үйлдвэрлэл эрхлэгч ААН-үүдийн хүрээнд чанарын мэдээлэл цуглуулж эхэлнэ. Үйлдвэрлэлийн цар хүрээ өргөжиж, мэдээлэл хуримтлагдах үе шатанд тэдгээрт суурилан үндэсний стандартын баталгаажуулалтын гэрчилгээг СХЗГ-аас авч, зохих ёсоор үйл ажиллагаа явуулахад төрөөс дэмжлэг үзүүлнэ.

“7.3 Мөөгний хэрэглээг нэмэгдүүлэх, соён гэгээрүүлэх үйл ажиллагааг хэрэгжүүлэх”

Мөөгний хэрэглээ маш бага Монгол орны хувьд хоол хүнсний хэрэглээний хэв маяг өөрчлөгдөхийн хэрээр хүнсэн дэхь мөөгний хэрэглээг нэмэгдүүлэх боломж асар их байна. Үүний тулд мөөгний тэжээллэг чанар, үзүүлэх үр нөлөө болон дотоодын мөөгний импортын мөөгнөөс давуу талыг олон нийтэд сурталчлах нь зүйтэй юм. Мөн тогтвортой нийлүүлэлт хийхийн тулд жижиглэнгийн худалдаачид болон хүнсний бүтээгдэхүүн боловсруулах үйлдвэрүүдтэй хамтын ажиллагааг бэхжүүлэх нь чухал. Цаашлаад олон нийтийг хамарсан арга хэмжээнүүдийг зохион байгуулж, сурталчилах үйл ажиллагааг төрөөс дэмжиж, бизнес тохироо хийх боломжоор хангах зэрэг дэмжлэг үзүүлнэ.

“7.4 Загасны хэрэглээг нэмэгдүүлэх зорилгоор загас боловсруулах үйлдвэрийг хөгжүүлэх төлөвлөгөө” нь үйлдвэрлэлийн шатанд нөөцийн хомсдолд орохгүйн тулд нөөцийн судалгааг хийж, боловсруулах шатны хүчин чадлыг сайжруулж, нийлүүлэлтийн шатанд хөргүүртэй агуулахыг дэмжин хөгжүүлж, борлуулалт, хэрэглээний шатанд иргэдэд хүнсний тэжээлийн боловсрол олгох үйл ажиллагааг хэрэгжүүлэх зорилготой юм.

(2) Үйл ажиллагааны төлөвлөгөөнүүдийн товч агуулга

No.	ҮАТ	Товч	Хэрэгжүүлэх байгууллага	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Төслийн хугацаа	Төслийн өртөг (сая төг)	Төлөвлөгөөний үндэслэл
7.1	Мөөг үйлдвэрлэх технологийн судалгаа, түгээн дэлгэрүүлэх ажлыг дэмжих	• Байгаль орчны нөхцөлд тохирсон мөөг үйлдвэрлэх арга технологийг хөгжүүлэх, тохиромжтой нэр төрөл, сортыг сонгоход ХААИС, ШУА-ийн судалгааг дэмжих. • Гарсан үр дүнд үндэслэн мөөг үйлдвэрлэгчдэд түгээн дэлгэрүүлэх, чиглүүлэх ажлыг цаашид эрчимжүүлэх, мөөгний арилжааны зорилготой үйлдвэрлэлийг өргөжүүлэх чиглэлээр төр, хувийн хэвшлийнхэн хамтран ажиллана.	ХХААХҮЯ	Мөөг үйлдвэрлэгчдийн тоо	50	500	2025 - 2034	550	Алсын хараа 2050 2.5, 8.2
7.2	Мөөгний үйлдвэрлэлийн үндэсний стандарт боловсруулах	• Үйлдвэрлэгч байгууллага болон ААН-үүдэд суурилан бүтээгдэхүүний чанарын мэдээллийг нэгтгэн цуглуулах. • Тухайн мэдээлэлд үндэслэн үйлдвэрлэлийн үе шатыг зохистой хянах мөөгний стандартыг боловсруулж, нэвтрүүлэх.	ХХААХҮЯ Хувийн хэвшил, ААНБ	Мөөгний борлуулалтын дүн	100сая төг.	1,000 сая төг.	2025 - 2034	365	Алсын хараа 2050 2.5, 8.2
7.3	Мөөгний хэрэглээг нэмэгдүүлэх соён гэгээрүүлэх үйл ажиллагаа	• Мөөгний шим тэжээл, үр ашиг, импортын мөөгнөөс дотоодод үйлдвэрлэсэн мөөг ямар давуу талтайг олон нийтэд сурталчлах. • Жижиглэн худалдаа, хүнсний үйлдвэрлэгч аж ахуйн нэгжүүдтэй хамтын ажиллагааг бэхжүүлэх зорилгоор олон нийтийг хамарсан арга хэмжээнүүдийг дэмжих, бизнес холбоо тогтоох боломжоор хангах.	ХХААХҮЯ,	Мөөгний хэрэглээний хэмжээ	1,000 тн	2,000 тн	2025 - 2029	400	Алсын хараа 2050 2.5, 8.2
7.4	Загасны хэрэглээг түгээн дэлгэрүүлэх зорилгоор загас боловсруулах үйлдвэрийг хөгжүүлэх төлөвлөгөө	• Нөөцийн хомсдолоос сэргийлэх нөөцийн судалгааг хэрэгжүүлэх • Боловсруулах салбарыг сайжруулах замаар тогтолцоог бэхжүүлэх. • Хөргүүртэй агуулахыг дэмжин хөгжүүлэх. • Иргэдэд хүнс тэжээлийн боловсрол (загасыг хүнсэнд хэрэглэх) олгох үйл ажиллагаа хэрэгжүүлэх	ХХААХҮЯ	Загасны хэрэглээний хэмжээ	0.18кг	0.3кг	2025 - 2034	1,025	Алсын хараа 2050 2.6.2, 2.7.1

3.9 ХАА-н бүтээгдэхүүний чанар, эрүүл ахуйн хяналтын тогтолцоог бэхжүүлэх хөтөлбөр

(1) Хөтөлбөрийн гол агуулга

Эрүүл ахуйн хяналтын чиг үүрэг бүхий төрийн байгууллагад бүтцийн өөрчлөлт хийгдэж байгаа ба эрүүл ахуйн хяналтын ерөнхий түвшинг дээшлүүлэх шаардлагатай байгаа хэдий ч байгууллагуудын үүрэг тодорхойгүй, ойлгомжгүй байна. ААН-ийг зохих ёсоор дэмжихийн тулд төрийн хяналтын тогтолцоог яаралтай тодорхой болгох шаардлагатай байна.
Эрүүл ахуйн хяналт чухалд тавигддаг салбар бол гадаад худалдааны салбар хэдий ч хяналтын байгууллагын шинжилгээний чадавхи хангалттүй байна. Түүнчлэн, экспортыг дэмжихэд, олон улсын түвшний чанарын хяналт, хүнсний аюулгүй байдлын баталгаажуулалтыг нэвтрүүлэхийг эрчимжүүлэх, өрсөлдөх чадварыг бэхжүүлэх шаардлагатай байна.

Оролцогч	Засгийн газрын байгууллага	Хяналтын байгууллага	Олон нийтийн байгууллага (Магадлан итгэмжлэл, баталгаажуулалтын байгууллага)	ААН, үйлдвэрлэгчид
Гол бэрхшээл	Холбогдох яам, агентлагуудын зохицуулах үүргийг нөхөх? (хариуцах) бүтэц байхгүй. Хүнсний аюулгүй байдалтай холбоотой төрийн байгууллагад бүтцийн өөрчлөлт хийгдсэн. Мэргэжлийн хүний нөөц дутагдалтай.	Шинжилгээний багаж, урвалж хүрэлцээгүй. Дээж авах болон хяналтын байгууллагын хандлагад ААН-үүд сэтгэл дундуур байдаг. Бичиг баримт боловсруулах чадвар муу. Олон улсын баталгаажуулалт авсан хэдий ч импортлогч улс нь итгэдэггүй.	Баталгаажуулалтын байгууллагын аудит хийх чадвар, итгэл үнэмшилтэй холбоотой асуудал бий. Баталгаажуулалт авахад туслах зөвлөх хүрэлцээгүй. ААН-дийн хүний нөөцөө сургах нөөц /эх үүсвэр/ байхгүй.	Мэдээлэл цуглуулалт хангалттүй, худалдааны журам төвөгтэй. ОУ-ын баталгаажуулалт, мөшгих тогтолцоо нэвтрүүлэх зэрэг оролдлого жигд биш. ААН-ийн хүний нөөцийн сургалт хоцрогдсол.
Авах арга хэмжээ	8.1.Хүнсний аюулгүй байдлын төрийн хяналтын чадавхийг бэхжүүлэх төлөвлөгөө 8.2 Экспортын хяналтын чадавхийг бэхжүүлэх төлөвлөгөө 8.3 Бэлтгэн нийлүүлэлтийн дараах алдагдлыг бууруулах бэлтгэл судалгааны төлөвлөгөө 8.4. Эрүүл ахуй, чанарын хяналтын хүний нөөцийг сургах төлөвлөгөө 8.5 Олон Улсын баталгаажуулалт авах, экспортын өрсөлдөх чадварыг бэхжүүлэх төлөвлөгөө			

Өдгөө Монгол Улсад чанар, эрүүл ахуйн хяналтын удирдлагын тогтолцооны шинэчлэлтийн процесс явц дундаа байгаа бөгөөд энэхүү тогтолцоог ойрын хугацаанд үинэчлэн зохион байгуулах шаардлагатай байгаа. Чанарын хяналтыг олон улсын түвшинд хэрэгжүүлэхийн тулд, хяналт шалгалтын чадавхийг оролцуулаад ерөнхий сууриар нь сайжруулах шаардлагатай байна. Хууль хэдийгээр үйлчилж байгаа ч, ААН-д үзүүлэх дэмжлэг хязгаарлагдмал, жижиг дунд үйлдвэрүүд олон улсын түвшний чанарын хяналтыг хэрэгжүүлэхэд ААН-д оногдох ачаалал их байна. ААН, компаниудыг дэмжих мэргэжлийн боловсон хүчнийг бэлдэх шаардлагатай. Хөтөлбөрийн гол агуулгыг доор сийрүүлэв.

"**8.1 Хүнсний аюулгүй байдлын хяналтын төрийн байгууллагын чадавхийг дээшлүүлэх төлөвлөгөө**"-ний хүрээнд хүнсний аюулгүй байдлын тогтолцооны төрийн байгууллагуудын үүрэг, хууль эрх зүйн үндэслэлийг авч үзэж, хяналтын байгууллагуудын эрсдлийн хяналтын төлөвлөгөө болон мониторингийн төлөвлөгөөг боловсруулж хэрэгжүүлнэ.

"8.2 Экспортын хяналт шинжилгээний чадавхийг бэхжүүлэх төлөвлөгөө"-гөөр ХАА-н бүтээгдэхүүнийг экспортлоход шаардлагатай шинжилгээний чадавхийг бэхжүүлэхийг зорино. Хорио цээрийн талаарх мэдээллийг тогтмол шинэчилж байх тогтолцоог бүрдүүлж, шинжилгээний байгууллагыг экспортын шинжилгээг зохистой түвшинд хийж чадахуйц хэмжээнд тоноглох төлөвлөгөөг боловсруулна. Хяналт шинжилгээний байгууллагын туршилт шинжилгээний чадавхийг бэхжүүлж, олон улсын итгэмжлэл авах ажлыг өргөжүүлнэ.

"8.3 Бэлтгэн нийлүүлэлтийн дараах алдагдлыг бууруулах судалгааг хэрэгжүүлэх бэлтгэл судалгааны төлөвлөгөө" нь үйлдвэрлэлийн дараагийн шатнаас түгээх хүртэлх хүнсний алдагдлын бодит байдлыг тодруулж, алдагдлыг бууруулах төслийг боловсруулах зорилготой.

"8.4 Чанар, эрүүл ахуйн хяналтын хүний нөөцийг сургаж бэлтгэх төлөвлөгөө"-гөөр үйлдвэр, ААН-ийн чанар, эрүүл ахуйн хяналтын чадавхийг дээшлүүлэх чанар, эрүүл ахуйн хяналтын сургагч бэлтгэх тогтолцоог бүрдүүлж, сургагч багшийг бэлтгэнэ. Хүний нөөцийг тасралтгүй сургаж бэлтгэдэг тогтолцоо бий болгох, ЖДҮ-үүд олон улсын HACCP (Аюулын шинжилгээний чухал хяналтын цэг), FSSC22000 (Хүнсний аюулгүй байдлын удирдлагын тогтолцоо) зэрэг баталгаажуулалтуудыг авах орчныг бүрдүүлэхийг зорино.

"**8.5 Олон улсын баталгаажуулалт авах замаар экспортын өрсөлдөх чадварыг бэхжүүлэх төлөвлөгөө**" нь экспортын зорилтот зах зээлд хүлээн зөвшөөрөгддөг олон улсын баталгаажуулалт авч, экспортыг өргөжүүлэх зорилготой юм. Монгол улсын газар тариалан, мал аж ахуйн гаралтай бүтээгдэхүүнийг экспортлоход давуу тал болох олон улсын баталгаажуулалтуудыг судлан тодорхойлж, баталгаажуулалтын итгэмжлэлийн тогтолцоог бэхжүүлнэ.

(2) Үйл ажиллагааны төлөвлөгөөнүүдийн товч агуулга

No.	ҮАТ	Товч	Хэрэгжүүлэх байгууллага	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Төслийн хугацаа	Төслийн өртөг (сая төг)	Төлөвлөгөөний үндэслэл
8.1	Хүнсний аюулгүй байдлын хяналтын төрийн байгууллагын чадавхийг дээшлүүлэх төлөвлөгөө	· Хүнсний аюулгүй байдлын тогтолцооны төрийн байгууллагуудын үүрэг, хууль эрх зүйн үндэслэлийг авч үзэж, хяналтын байгууллагуудын эрсдлийн хяналтын төлөвлөгөө болон мониторингийн төлөвлөгөөг боловсруулах. · Хүнсний аюулгүй байдал, эрүүл ахуйн хяналтын чиг үүргийн байгууллагуудын үүрэг, хариуцлагыг тодорхой болгож, төрийн хяналтын боловсон хүчний чадавхийг бэхжүүлэх.	ХХААХҮЯ ХАБҮЛ лаборатори, УМЭАЦТЛ, ГЕГ	Бодлогын үнэлгээний систем бий эсэх	Байхгүй	Байгаа	2025 - 2034	1,882	Алсын хараа 2050 2.5.20
8.2	Экспортын хяналт шалгалтын чадавхийг бэхжүүлэх төлөвлөгөө	· Хорио цээрийн талаарх мэдээллийг тогтмол шинэчлэх тогтолцоо бий болгож, экспортын хяналт шалгалтыг зохих журмын дагуу явуулах хяналтын байгууллагыг хөгжүүлэх төлөвлөгөө боловсруулна. · Шаардлагатай хяналт шинжилгээг үр дүнтэйгээр хэрэгжүүлэх тоног төхөөрөмжийг ситемтэйгээр бүрдүүлж, шинжжчдийн байцаагч нарын ур чадварыг дээшлүүлэхийг зорино.	ХХААХҮЯ СХЗГ, ХАБҮЛ лаборатори, УМЭАЦТЛ	Лабораторийн засвар үйлчилгээ / менежментийн төлөвлөгөө	Байхгүй	Байгаа	2025 - 2034	7,600	Алсын хараа 2050 2.5.13 2.5.19 2.5.20
8.3	Бэлтгэн нийлүүлэлтийн дараах алдагдлыг бууруулах судалгааг хэрэгжүүлэх бэлтгэл судалгааны төлөвлөгөө	· Үйлдвэрлэлийн дараагийн шатнаас түгээх хүртэлх хүнсний алдагдлын бодит байдлыг тодруулж, алдагдлыг бууруулах төслийг боловсруулах зорилготой.	ХХААХҮЯ,	Төлөвлөгөөний хэрэгжилт	Байхгүй	Байгаа	2025 - 2026	1,266	Алсын хараа 2050 4.2.38 6.4.2, 6.4.4
8.4	Чанар, эрүүл ахуйн хяналтын хүний нөөцийг сургаж бэлтгэх төлөвлөгөө	· ААН-үүдийн чанар, эрүүл ахуйн хяналтын чадавхийг дээшлүүлэхэд чанар, эрүүл ахуйн хяналтын сургагч бэлтгэх тогтолцоог бүрдүүлж, сургагч багш нарыг бэлтгэх. · Хүний нөөцийг бэлтгэх тогтолцоо бий болгох, ЖДҮ-үүд олон улсын HACCP, FSSC22000 зэрэг баталгаажуулалтуудыг авах орчныг бүрдүүлэхийг зорино.	ХХААХҮЯ, ЭМЯ	Сургагчийн тоо	0 хүн	100 хүн	2025 - 2034	2,131	Алсын хараа 2050 2.5.19 2.5.20
8.5	Олон улсын баталгаажуулалт авах замаар экспортын өрсөлдөх чадварыг бэхжүүлэх төлөвлөгөө	· Экспортын зорилтот зах зээлд хүлээн зөвшөөрөгдөг олон улсын баталгаажуулалт авч, экспортыг өргөжүүлэх. · МУ-ын ХАА-н бүтээгдэхүүнийг экспортлоход давуу тал болох олон улсын баталгаажуулалтуудыг судлан тодорхойлж, баталгаажуулалтын итгэмжлэлийн тогтолцоог бэхжүүлэх.	ХХААХҮЯ СХЗГ ҮИТ	Баталгаажуулалт авсан тоо	0	114	2025 - 2034	14,990	Алсын хараа 2050 2.5.19 2.5.20 4.5.7

3.10 ХАА-н бүтээгдэхүүний экспортыг дэмжих бааз суурийг хөгжүүлэх хөтөлбөр

(1) Хөтөлбөрийн гол агуулга

Экспортын бичиг баримт бүрдүүлэлт нь давхардал ихтэй, процедуруу нь төвөгтэй, цаг их шаардаг. Алдаа ихтэй, ААН-үүдэд ирэх дарамт их. Худалдааны хэлэлцээр дээр ч гэсэн,яамд хоорондын мэдээллийн солилцоо хангалтгүй,хувийн сектор төрийн байгууллагын уялдаа холбоо дутмаг. Ганц хоёрхон байгууллага бэлдсэн стратегигүйгээр хэлэлцээрт ордог. Бизнесийн байгууллага нь экспортлох талын нөхцлийг бүрэн мэдэхэд хувийн байгууллагын хүчээр хийхэд хүндрэлтэй, туслах байгууллага нь уялдаа холбоогүй, бизнесийн байгууллагад хангалттай тусламж хүрдэггүй.

Оролцогч	Төрийн байгууллагууд	Олон нийтийн байгууллага, (ХАУТ, Мэргэжлийн холбоод)	Экспортлогч ААН-үүд
Гол бэрх-шээл	ААН нь олон байгууллагаас дэс дараатайгаар, экспорт хийхэд шаардлагатай бичиг авах ёстой. Үүнд цаг хугацаа, зардал их шаардагддаг, алдаа ч их гардаг. Засгийн газрын байгууллагууд хоорондоо уялдаагүй, экспортын зорилтот зах зээл болон хувийн ААН-ийн талаархи мэдээлэл хангалттүй.Хэлэлцээ хийх чадвар сул .	Хувийн сектор, төрийн байгууллагын (дундын) зуучлал сул. ААН-ийг хангалттай дэмждэггүй. ААН-ийг дэмжих төсөв ч хүний нөөц ч дутагдалтай, тусалж дэмжих хөтөлбөр бараг байхгүй.	Мэдээлэл цуглуулах үйл ажиллагаа хангалтгүй, худалдааны журам төвөгтэй. ЖДҮ эрхлэгчид дангаараа таатай зах зээл олж, тэдний шаардлагын дагуу бичиг баримт бүрдүүлэхэд хүндрэлтэй байдаг.
Авах арга хэмжээ	9.1.Худалдааны журмыг оновчтой болгох төлөвлөгөө 9.2. Худалдааны хэлэлцээр хийх чадавхийг бэхжүүлэх төлөвлөгөө 9.3.Экспортын дэмжлэгийг бэхжүүлэх төлөвлөгөө		

Экспортын бичиг баримт бүрдүүлэх журмууд төвөгтэй бөгөөд цаг хугацаа, зардал мөнгөний асуудлыг үйлдвэр, ААН өөрөө хариуцаж байгаа явдал нь экспортын саад тотгорын нэг юм. Мөн худалдааны яриа хэлэлцээрийн тухайд түнш орны мэдээлэл болон хувийн секторын эрэлт хэрэгцээний талаарх мэдээлэл дутагдалтай, холбогдох байгууллагуудын уялдаа, хамтын ажиллагаа дутагдалтай байдаг. Үйлдвэр ААН-үүдэд чиглэсэн дэмжлэг арга хэмжээ хязгаарлагдмал, ЖДҮ-үүдийн хувьд экспортын босго маш өндөр байдаг. Хөтөлбөрт багтсан Үйл ажиллагааны төлөвлөгөөнүүдийн агуулгыг доор сийрүүлэв.

“**9.1 Худалдааны бүрдүүлэлтийн журмыг оновчтой болгох төлөвлөгөө**”-гөөр экспортын бичиг баримт бүрдүүлэлтийн зардал, цаг хугацааг багасгах зорилгын үүднээс экспортлогч байгууллагын итгэмжлэллал, бүртгэлийн системийг нэвтрүүлэх, импортлогч улсаас шаардах бичиг баримт, мэдээллийг бэлтгэх тогтолцоог бий болгох, цахимжуулах зэргээр Нэг цэгийн үйлчилгээг /One stnop service/ хөгжүүлэх, холбогдох байгууллагын ложистикийн чадавхийг бэхжүүлнэ. Байгууллагуудын бичиг баримт бүрдүүлэлтийн тухайд зарцуулсан цаг хугацаа, алдаа мадагийн тоонд дүн шинжилгээ хийж, нийтэд мэдээлэхийн зэрэгцээ хувийн секторын санал хүсэлтийг тусгах тогтолцоог бүрдүүлж, бүрдүүлэлтийн журмыг зохистой болгохыг тасралтгүй зорьж ажиллана.

"9.2 Худалдааны хэлэлцээрийн чадавхийг бэхжүүлэх төлөвлөгөө"-д экспортын зорилтот улс, салбарын мэдээллийг тогтмол цуглуулж, худалдаа хариуцсан захиргааны байгууллагууд болон хувийн хэвшлүүдэд тараан, зорилтот улс орнуудтай хэлэлцээ хийхдээ хувийн хэвшлийн хэрэгцээ, өнөөгийн нөхцөл байдалд тулгуурлан хэлэлцээрийн стратегийг боловсруулж, хэлэлцээрийн үр дүнг хувийн хэвшилд шуурхай мэдээлэдэг байхыг зорино. Худалдааны хэлэлцээрийг хувийн хэвшлийн хэрэгцээ шаардлагад нийцүүлэн стратегийн дагуу явуулах тогтолцоог хөгжүүлэх зорилгоор ХАА-н бүтээгдэхүүний худалдаа экспорт хариуцсан захиргааны байгууллагуудад орон тооны мэргэжилтэн томилж, хувийн хэвшил болон холбогдох байгууллагуудын хамтран ажиллах тогтолцоог бүрдүүлнэ. Байгууллагуудын хариуцсан мэргэжилтнүүдийн хэлэлцээрийн ур чадварыг дээшлүүлэх сургалтыг тогтмол явуулж суурь чадавхийг дээшлүүлнэ. ХАА-н экспортын гол нэрийн бүтээгдэхүүн болон экспортын зорилтот улсуудыг тодорхойлж, худалдааны хэлэлцээр хийхэд бэлтгэнэ.

“9.3 Экспортыг дэмжих тогтолцоог бэхжүүлэх төлөвлөгөө" нь MYXAYT-ийн үйл ажиллагааг бэхжүүлэхэд чиглэсэн бөгөөд экспортыг өргөжүүлэх зорилгоор бизнесийн хэлэлцээрийг дэмжих, экспортлох орнуудын компаниудтай гэрээ байгуулахад дэмжлэг үзүүлэх, ашигтай тариф сонгох талаар мэдээлэл өгөх зэрэг бизнесийг дэмжих хөтөлбөрүүдийг боловсруулж, MYXAYT-ын чадавхийг бэхжүүлэх зорилготой. MYXAYT-ын чадавхийг бэхжүүлэх нь хувийн хэвшил болон төрийн байгууллагуудын хамтын ажиллагааг хөгжүүлэх, түүнчлэн мэдээлэл цуглуулах, хуримтлуулах үйл ажиллагааг дэмжих, худалдааны хэлэлцээрийн чадавхийг бэхжүүлэх, экспортын журмыг хялбарчлах, зардлыг бууруулахад хувь нэмэр оруулах юм.

(2) Үйл ажиллагааны төлөвлөгөөнүүдийн товч агуулга

No.	ҮАТ	Товч	Хэрэгжүүлэх байгууллага	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Төслийн хугацаа	Төслийн өртөг (сая төг)	Төлөвлөгөөний үндэслэл
9.1	Худалдааны бүрдүүлэлтийн журмыг оновчтой болгох төлөвлөгөө	· Экспортын бүрдүүлэлтийн журмын зардал, цаг хугацааг багасгах зорилгоор экспортлогч аж ахуйн нэгжүүдэд баталгаажуулалт, бүртгэлийн тогтолцоог нэвтрүүлэх, импортлогч орнуудад шаардлагатай бичиг баримтын мэдээллийг хөтлөх тогтолцоог бий болгох, компьютержуулах замаар нэг цэгийн үйлчилгээг сурталчлах, хамтын ажиллагааг дэмжин, холбогдох байгууллагуудын ложистикийн чадавхийг бэхжүүлэх.	ХХААХҮЯ	Бүрдүүлэлтэд зарцуулах цагийн тоо	260	106	2025 - 2034	1,793	Алсын хараа 2050 4.4.11 4.5.7, 4.5.8
9.2	Худалдааны гэрээ хэлэлцээрийн чадавхийг дээшлүүлэх төлөвлөгөө	· Экспортын зорилтот улс орон, чиглэлийн талаарх мэдээллийг худалдааны асуудал хариуцсан төрийн байгууллагууд болон хувийн хэвшлийн хоорондоо тогтмол нэгтгэн хуваалцаж, зорилтот улс орнуудтай хэлэлцээ хийхдээ хувийн хэвшлийн хэрэгцээ шаардлага, өнөөгийн нөхцөл байдалд үндэслэн стратегийг урьдчилан боловсруулж, үр дүнг хувийн хэвшилд шуурхай мэдээлж байх. · Стратегийн худалдааны хэлэлцээрийн тогтолцоог хөгжүүлэх зорилгоор ХАА-н бүтээгдэхүүний худалдаатай холбоотой захиргааны байгууллагуудад орон тооны албан тушаалтныг томилж, холбогдох байгууллага, хувийн хэвшлийн хамтын ажиллагааны механизмыг бүрдүүлэх. · ХАА-н экспортын тэргүүлэх ач холбогдол бүхий нэр төрөл, зорилтот улсуудыг сонгон тодорхойлж, худалдааны хэлэлцээрт бэлтгэх.	ХХААХҮЯ	Мэргэжлийн хэлэлцээр хийгчдийг томилон ажиллуулах	0	3	2025 - 2034	7,852	Алсын хараа 2050 4.4.11 4.5.7, 4.5.8
9.3	Экспортыг дэмжих бааз суурийг бэхжүүлэх төлөвлөгөө	· ААН-үүдийн экспортыг өргөжүүлэхийн тулд бизнесийн хэлэлцээр хийхэд дэмжлэг үзүүлэх, импортлогч улсын аж ахуйн нэгжүүдтэй гэрээ байгуулахад дэмжлэг үзүүлэх, ашигтай тариф сонгох мэдээллээр хангах зэрэг бизнесийг дэмжих хөтөлбөрүүдийг боловсруулж, МҮХАҮТ-ын чадавхийг бэхжүүлэх зорилготой.	ХХААХҮЯ, МҮХАҮТ	Дэмжлэгт хамрагдсан ААН-ний тоо	0	1,000	2025 - 2034	24,505	Алсын хараа 2050 4.4.11 4.5.7, 4.5.8

3.11 ХАА-н салбарын ААН, хоршоодын менежментийн бааз суурийг бэхжүүлэх хөтөлбөр

(1) Хөтөлбөрийн гол агуулга

ХАА-н үйлдвэрлэлийн нэмүү өртгийн сүлжээ байгуулахад холбогдох барааны түгээлт болон бүтээгдэхүүн хөгжүүлэх ААН, хоршооны менежментийн бааз суурийг бэхжүүлэх явдал зайлшгүй шаардлагатай. Хоршооны тухайд бол хоршооны хууль шинэчлэгдснээр зах зээлээс хөрөнгө босгох боломжтой болсон боловч менежментийн бааз сууль эмэг байгаа, засаглалын систем нь саад болж зээл авах болзлыг хангаж чадахгүй байна. ЖДҮ –ийн хувьд ч мөн ялгаагүй байдалтайгаас гадна, үйл ажиллагаа, харилцагчдад үйлчлэх (ерөнхий хэлтэс, санхүү бүртгэл, боловсон хүчин, агуулахын нярав г.м) шууд бус үйл ажиллагааг сайжруулах, үр өгөөжийг дээшлүүлэх шаардлагатай.

Оролцогч	Засгийн газар (ЖДҮГ)	Санхүүгийн байгууллага	Хувийн хэвшлийн ААН	ХАА-н хоршоо
Гол бэрх-шээл	ЖДҮ, хоршоонд бага хүүтэй зээл олгох бодлого хэрэгжүүлэх. Одоогоор ААН, хоршооны менежментийн баазыг бэхжүүлэх бодлого хязгаарлагдмал байна.	Сул дорой менежментийн баазтай ААН, байгууллагад зээл олгоход хүндрэлтэй. Хөдлөх хөрөнгийн үнэлгээний арга тодорхойгүй, зээлийн барьцаа болох боломжгүй	Сул дорой санхүүгийн тогтолцоо, засаглалтай. Барьцаа хөрөнгөгүй тул зээлийн хүртээмж дутагдалтай. Хөнгөлөлттэй зээл авах боломжгүй тул бэлэн мөнгө дутагдаж, хангалттай түүхий эд авч чаддаггүй.	Хоршоод өөрийн хөрөнгөгүй байх нь түгээмэл. Дүрмийн боловсруулалт хангалтгүй, зохион байгуулалтын бүтцэд хариуцлагын тогтолцоо тодорхойгүй. Эдгээрээс үүдэн зээл авахад туйлын хэцүү.
Авах арга хэмжээ	10.1 Нэмүү өртгийн сүлжээний зээлийн тогтолцоо нэвтрүүлэх бэлтгэл судалгаа хийх төлөвлөгөө гаргах 10.2 Агуулахын үнэт цаасны тогтолцоо нэвтрүүлэх бэлтгэл судалгаа хийх төлөвлөгөө гаргах 10.3 ЖДҮ-ийн менежментийн баазыг бэхжүүлэх төлөвлөгөө 10.4 ХАА-н хоршооны менежментийн баазыг бэхжүүлэх төлөвлөгөө			

ХАА-н бүтээгдэхүүний нийлүүлэлтийн сүлжээг дэмжихэд санхүүгийн секторыг сайжруулах нь ХАА-ийн үйлдвэрлэл бизнесийг өргөтгөх, бүтээгдэхүүний өрсөлдөх чадварыг бий болгох талаас туйлын чухал арга хэмжээ юм. Энэ хөтөлбөрт үл хөдлөх болон хөдлөх хөрөнгийг барьцаалах зээлээс гадна санхүүгийн шинэ системд хамаарах үйл ажиллагаа, ХАА-н салбарын ААН компаниуд, хоршоодын зохион байгуулалтыг бэхжүүлэх чиглэлээр боловсруулсан Үйл ажиллагааны төлөвлөгөөг санал болгож байна. Доор төлөвлөгөөний товч агуулгыг сийрүүлэв.

“**10.1 Нэмүү өртгийн сүлжээний зээлийн системийг нэвтрүүлэх бэлтгэл судалгаа хийх төлөвлөгөө**” -нд зээлийн эрсдэлийн улмаас зээл авахад хүндрэлтэй байгаа ЖДҮ, хөдөө аж ахуйн хоршоодод зээлийн хүртээмжийг сайжруулахын тулд нэмүү өртгийн сүлжээгээр түүхий эдийг худалдан авагч тал худалдан авалтын баталгаа гаргаж, түүнийг нь арилжааны банкууд барьцаалж ЖДҮ, ХАА-н хоршоодод зээл олгох механизмыг бүрдүүлнэ.

“**10.2 Агуулахын үнэт цаасны тогтолцоо нэвтрүүлэх бэлтгэл судалгааны төлөвлөгөө**”-нд тодорхой хөрөнгийн үнэлгээтэй ХАА-н бүтээгдэхүүнээ хадгалуулж буй хүмүүст агуулахын үйлчилгээ үзүүлэгч ААН агуулахын үнэт цаас гаргаж олгодог тогтолцоо бүрдүүлнэ.Агуулахын үнэт цаас нь хадгалуулсан хувь хөрөнгийг шилжүүлэх болон, ломбардад тавих гэх мэтээр захиран зарцуулах, мөн үүнийг барьцаалж банкнаас зээл авах боломжтой.Монголд ХАА-н бүтээгдэхүүний дотроос барьцаалж хадгалуулах боломжтой барааг тогтоохыг судлах шаардлагатай, тийм учраас бэлтгэл судалгааг хэрэгжүүлэх шаардлагатай юм.

“**10.3 ЖДҮ-ийн менежментийн баазыг бэхжүүлэх төлөвлөгөө**”-нд ХАА-н үйлдвэрлэл эрхэлдэг ЖДҮ-дэд илүү өгөөжтэй, тогтвортой менежментийг дэмжих тогтолцоог өргөжүүлэх.Өөрөөр хэлбэл, менежментийн салбарын зөвлөлгөө өгөх мэргэжилтэн илгээж, санхүүгийн удирдлагыг зохистой болгох, өртөг бууруулах, борлуулалтыг идэвхижүүлэх, маркетингийг сайжруулах зэрэг зөвлөмж өгөхөд хялбар орчин бүрдүүлэх.

“**10.4 ХАА-н хоршоодын менежментийн бааз суурийг бэхжүүлэх төлөвлөгөө**”-нд хөгжиж буй ХАА-н хоршоодод, ХАА-н бүтээгдэхүүнд нэмүү өртөг шингээж, борлуулалтын салбарт санаачлагатай ажиллаж буй хоршоодын туршлага судлах, хоршооны менежментийн судалгаа хийх зэргээр ХАА-н хоршооны бүтцийг бэхжүүлэхийг зорино.

(2) Үйл ажиллагааны төлөвлөгөөнүүдийн товч агуулга

No.	ҮАТ	Товч	Хэрэгжүүлэх байгууллага	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Төслийн хугацаа	Төслийн өртөг (сая төг)	Төлөвлөгөөний үндэслэл
11.1	Өртгийн сүлжээний санхүүжилтийн тогтолцоог нэвтрүүлэх бэлтгэл судалгааг хэрэгжүүлэх төлөвлөгөө	• Зээлийн эрсдэлийн улмаас санхүүжилт авахад хүндрэлтэй байгаа ЖДҮ, ХАА-н хоршоодын санхүүгийн хүртээмжийг сайжруулах зорилгоор түүхий эд худалдан авагч тал баталгаа гаргаж, түүнийг арилжааны банкууд барьцаа болгон ашиглаж зээл олгодог механизм бий болгох.	ХХААХҮЯ ЖДҮГ	Тогтолцоо бий эсэх	Байхгүй	Байгаа	2025 – 2026	931	Алсын хараа 2050 4.1.17 4.3.20
11.2	Агуулахын үнэт цаасны системийг нэвтрүүлэх бэлтгэл судалгааг хэрэгжүүлэх	• Тодорхой хөрөнгийн үнэлгээгээр баталгаажсан ХАА-н бүтээгдэхүүн хадгалуулагчдад зориулж агуулахын үйл ажиллагаа эрхлэгч агуулахын үнэт цаас гаргах тогтолцоог бий болгох. • Монгол Улсын ХАА-н бүтээгдэхүүн дотроос хадгалуулах боломжтой нэр төрлийг тодорхойлохоос эхлээд бэлтгэл судалгааг хийх шаардлагатай байна	ХХААХҮЯ ЖДҮГ	Тогтолцоо бий эсэх	Байхгүй	Байгаа	2025 - 2026	655	Алсын хараа 2050 4.1.17 4.3.20
11.3	ЖДҮ-ийн менежментийн бааз суурийг бэхжүүлэх	• ХАА-н чиглэлийн ЖДҮ-үүдийг дэмжих тогтолцоог өргөжүүлэн илүү үр ашигтай, тогтвортой менежментийг хэрэгжүүлэх. • Менежментийн чиглэлийн зөвлөгөө өгөх мэргэжилтнүүдийг томилон ажиллуулахыг хэсэгчлэн дэмжиж, санхүүгийн зохистой менежмент, зардал бууруулах, борлуулалтыг дэмжих, маркетингийг сайжруулах талаар зөвлөгөө авахад хялбар орчинг бүрдүүлнэ.	ХХААХҮЯ ЖДҮГ	Дэмжлэгт хамрагдсан ААН-ийн тоо	0	100	2025 - 2034	500	Алсын хараа 2050 4.1.17 4.3.20
10.4	ХАА-н хоршоодын удирдлагын баазыг бэхжүүлэх төлөвлөгөө	• ХАА-н хоршоодод нэмүү өртөг шингээх, арилжаа худалдааны чиглэлээр дэвшилтэт санаачилга хэрэгжүүлж буй хоршоодтой танилцах, хоршооны менежментийн чиглэлээр сургалт явуулах, хоршоодын зохион байгуулалтыг бэхжүүлэх.	ХХААХҮЯ ЖДҮГ	Цуглуулах / тээвэрлэх, анхан шатны боловсруулалт хийх бизнесийн үйл ажиллагаа эрхэлдэг хоршоодын тоо	10	230	2025 - 2034	1,897	Алсын хараа 2050 3.3.1

3.12 Орон нутгийн ХАА-н үйлдвэрлэлийг хөгжүүлэх хөтөлбөр

(1) Хөтөлбөрийн гол агуулга

Монголд хөгжлийн түншлэгчдийн дэмжлэгтэйгээр экспортын баримжаатай төрөл бүрийн кластерүүд үүсч байна. Одоогийн байдлаар МҮХАҮТ-д төвлөрсөн гоо сайхны бараа, чацаргана, зөгийн балны кластерүүд үүсч, ЕХ, Япон, Хятадын зах зээлд экспортлох оролдлогууд хийж байна. Цаашид авбал зохих арга хэмжээ гэвэл эдгээр оролдлого нь ганц удаа хийгээд зогсчихоргүй тогтолцоо бүрдүүлэхийн хамт кластерийг дэмжих тогтолцоог өргөжүүлэх шаардлагатай байна. Дээр нь нэмээд орон нутгийн ХАА-н үйлдвэрлэлийг хөгжүүлэх зорилгоор "Нэг тосгон нэг бүтээгдэхүүн" хөдөлгөөнийг өрнүүлэх, АҮП байгуулахыг багтаасан АҮ-ийн түшиц газар байгуулах шаардлагатай.

Оролцогч	Засгийн газар (ЭЗХЯ, ЖДҮГ)	ИДС, судалгааны байгууллага	МҮХАҮТ	ХАА-н үйлдвэрлэлийн ААН, холбоод
Гол бэрхшээл	АҮ-ийн кластерийн хууль гараагүй. Ийм учраас АҮК гэдэг тодорхойлолт ч тогтсон зүйлгүй, кластерт чиглэсэн тусламжийн тогтолцоо ч бүрдээгүй байна.	Зах зээлийн өрсөлдөөн үүсгэх боломжтой технологийн судалгаа хийх ИДС, болон ЭШБ цөөн байна.Бас хувийн ААН-үүдийн хамтарч ажиллах туршлага хязгаарлагдмал	Хөгжлийн түншлэгчдийн дэмжлэгтэйгээр экспортын кластерын сүлжээ үүсгэх тусламжийн бүтэц үүсч байгаа ба бие даасан кластерт үзүүлэх үйлчилгээг илүү төгөлдөржүүлэх шаардлагатай байна.	Технологи хөгжүүлэлт болон дэлхийн зах зээл дээр маркетингээ бэхжүүлэхэд зарцуулах хөрөнгийн ба хүний нөөцийн дутагдалтай байна.
Авах арга хэмжээ	11.1 Аж үйлдвэрийн кластерийг бойжуулахад чиглэсэн дэмжлэгийн тогтолцоо бүрдүүлэх төлөвлөгөө			
		11.2 Зах зээлд өрсөлдөх чадварыг сайжруулахад чиглэсэн үйлдвэрлэл-ЭШБ-ын уялдааг бэхжүүлэх төлөвлөгөө		
			11.3 "Нэг суурин-нэг бүтээгдэхүүн" хөдөлгөөнийг өрнүүлэх төлөвлөгөө	

Орон нутагт ХАА-н үйлдвэрлэлийг хөгжүүлэх хөтөлбөр нь хөдөө орон нутгийн ХАА-н бүтээгдэхүүний зах зээлд өрсөлдөх чадварыг бэхжүүлэх орчныг бүрдүүлэх зорилготой хөтөлбөр юм. Хөтөлбөрт баггсан Үйл ажиллагааны төлөвлөгөөнүүдийн агуулгыг доор сийрүүлэв.

"**11.1 Үйлдвэрлэлийн кластер бойжуулах дэмжлэгийн тогтолцоо бүрдүүлэх төлөвлөгөө**" нь өнөөгийн байдлаар систем тогтолцооны хувьд тодорхойгүй байгаа үйлдвэрлэлийн кластерийг системчлэхийг зорихын хамт бий болсон кластерийг дэмжих тогтолцоо бүрдүүлэхийг зорино. MONMAP-AVC төслийн хүрээнд боловсруулсан кластерын гарын авлагад үндэслэн, кластер хөгжүүлэхэд төр хувийн хэвшлийн үүргийг тодорхой тусгасан тогтолцоо бүрдүүлэхийг зорихын хамт хувийн хэвшлийн манлайлал бүхий олон улсын зах зээлд хамтарсан маркетинг хийхийг дэмжих тогтолцоо бүрдүүлэх.

"**11.2 Зах зээлд өрсөлдөх чадварыг дээшлүүлэхийн тулд үйлдвэрлэгч - ЭШБ-ын уялдаа холбоог бэхжүүлэх төлөвлөгөө**" нь үндсэндээ ХАА-н салбар чиглэлийн их дээд сургуульд үйлдвэрлэгч-ЭШБ-ийг холбох зохицуулагчийг ажиллуулж, хоёр талыг холбох, уялдааг бэхжүүлэх төлөвлөгөө юм. Их сургуульд бий болсон мэдлэг, арга технологийг үйлдвэрлэлийн салбарт нэвтрүүлэхийг дэмжих зорилготой бөгөөд, энэ үйл ажиллагааг дэмжихэд чиглэсэн систем бүрдүүлэхийг зорино.

"**11.3 Нэг суурин нэг бүтээгдэхүүн хөдөлгөөнийг идэвхжүүлэх төлөвлөгөө**"-гөөр орон нутгийн ХАА-н онцлог бүтээгдэхүүний үйлдвэрлэл, борлуулалтыг идэвхижүүлэхийн тулд "Нэг суурин нэг бүтээгдэхүүн" хөдөлгөөний загварыг дэлгэрүүлэх юм. Мөн хөдөө орон нутгийн ХАА-н бүтээгдэхүүний брендийг баталгаажуулах брендийн зөвлөл байгуулах болон, ХАА-н бүтээгдэхүүн хөгжүүлэлтийг дэмжих бүтцийг бий болгосноор Монгол Улсын хот суурины иргэд болон жуулчдад борлуулах боломжтой бүтээгдэхүүн үйлдвэрлэх тогтолцоо бүрдүүлэх юм.

(2) Үйл ажиллагааны төлөвлөгөөнүүдийн товч агуулга

No.	ҮАТ	Товч	Хэрэгжүүлэх байгууллага	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Төслийн хугацаа	Төслийн өртөг (сая төг)	Төлөвлөгөөний үндэслэл
11.1	Үйлдвэрлэлийн кластер бойжуулах дэмжлэгийн тогтолцоо бүрдүүлэх төлөвлөгөө	• Өнөөг хүртэл систем тогтолцооны хувьд тодорхойгүй байгаа үйлдвэрлэлийн кластерийг системчлэхийг зорихын хамт бий болсон кластерийг дэмжих тогтолцоо бүрдүүлэх. • Хувийн хэвшлийн манлайлал бүхий олон улсын зах зээлд хамтарсан маркетинг хийхийг дэмжих тогтолцоо бүрдүүлэх.	ХХААХҮЯ ЖДҮГ ЭЗХЯ	Тогтолцоо бий эсэх	Байхгүй	Байгаа	2025 – 2034	9,031	Алсын хараа 2050 4.2.20
11.2	Зах зээлд өрсөлдөх чадварыг дээшлүүлэхийн тулд үйлдвэрлэгч-ЭШБ-ын уялдаа холбоог бэхжүүлэх төлөвлөгөө	• ХАА-н салбар чиглэлийн их дээд сургуульд үйлдвэрлэгч-ЭШБ-ийг холбох зохицуулагчийг ажиллуулж, хоёр талыг холбох, уялдааг бэхжүүлэх төлөвлөгөө юм	ХХААХҮЯ ЖДҮГ	Тогтолцоо бий эсэх	Байхгүй	Байгаа	2025 - 2030	1,906	Алсын хараа 2050 4.2.20
11.3	Нэг суурин нэг бүтээгдэхүүн хөдөлгөөнийг идэвхжүүлэх төлөвлөгөө	• Орон нутгийн ХАА-н онцлог бүтээгдэхүүний үйлдвэрлэл, борлуулалтыг идэвхижүүлэхийн тулд “Нэг суурин нэг бүтээгдэхүүн” хөдөлгөөний загварыг дэлгэрүүл, сургалт суртчилгаа хийх. • Хөдөө орон нутгийн ХАА-н бүтээгдэхүүний брендийг баталгаажуулах брендийн зөвлөл байгуулж, бүтээгдэхүүн хөгжүүлэлтийг дэмжих бүтцийг бий болгосноор Монгол Улсын хот суурины иргэд болон жуулчдад борлуулах боломжтой бүтээгдэхүүн үйлдвэрлэх тогтолцоо бүрдүүлэх.	ХХААХҮЯ ЖДҮГ ЭЗХЯ	“Нэг суурин нэг бүтээгдэхүүн” хөдөлгөөнийг эхлүүлсэн орон нутгийн тоо	0	22	2025 - 2034	1,090	Алсын хараа 2050 4.2.20

4. Хөгжлийн хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх тогтолцоо

4.1 Хөгжлийн хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх механизм

ХАА-н үйлдвэрлэлийн нэмүү өртгийн сүлжээг хөгжүүлэхтэй холбоотой тулгардаг асуудлууд ихээхэн өргөн хүрээг хамардаг. Нэг нэр төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх, боловсруулах, нийлүүлэх, борлуулах, экспортлох бүх цогц асуудлуудыг өртгийн сүлжээний үе шат бүрт үйл ажиллагаа явуулдаг байгууллага нэгжүүд хариуцан шийдвэрлэж байдаг бөгөөд Монгол Улсад ч мөн адил тогтолцоотой. Тухайлбал, хүнсний ногооны үйлдвэрлэлтэй холбоотой асуудлыг Газар тариалангийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар хариуцдаг бол хүнсний ногооны түгээлт нийлүүлэлт, борлуулалт, хүнсний аюулгүй байдлыг хангах зэрэг асуудлыг Хүнсний үйлдвэрлэлийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар хариуцдаг. Нөгөөтэйгүүр ХАА-н салбарын бодлого боловсруулах, төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг газар хэлтэс тус бүрээр боловсруулдаг нь тодорхой нэр төрлийн бүтээгдэхүүний өртгийн сүлжээг хөгжүүлэхтэй холбоотой асуудлыг хөндлөн тогтолцоогоор авч үзэж, зохих арга хэмжээ авахад хүндрэлтэй байдаг. Иймээс газар тариалан, мал аж ахуй, хөнгөн үйлдвэр, хүнсний аюулгүй байдал, аж үйлдвэрийн хөгжил, хоршооны хөгжил зэрэг бүх салбарын хариуцсан мэргэжилтнүүд бүхий Бодлого төлөвлөлтийн газар нь салбар хоорондын бодлогын уялдаа холбоо, тэргүүлэх чиглэлийг тодорхойлоход оролцдог. Энэхүү Мастер төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд удирдлага хяналтыг хялбарчлах үүднээс одоо хэрэгжиж буй бодлого төлөвлөлтийн процессийг хэвээр хадгалан, хэрэгжилтийг хангахаар тусгасан. Тодруулбал:

- Хөгжлийн хөтөлбөрүүдийг Газар тариалангийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар, Мал аж ахуйн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар, Хөнгөн үйлдвэрийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар, Хүнсний үйлдвэрлэлийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар гэсэн алба нэгжүүдийн аль нэг нь хариуцна.
- Хөгжлийн хөтөлбөрүүдийг түүнийг бүрдүүлж буй үйл ажиллагааны төлөвлөгөөний агуулгад (бүтээгдэхүүний нэр төрөл, онцлог шинж чанар) нийцүүлэн хамгийн хамаарал өндөртэй газар нэгж хариуцна.
- Хөгжлийн хөтөлбөр тус бүрийн бодлого төлөвлөлтөд салбар дамнасан болон яам агентлаг хоорондын арга хэмжээ шаардлагатай үед Бодлого төлөвлөлтийн газар эдгээрийг зохицуулах эсвэл арга хэмжээний хэрэгцээ шаардлагыг тодорхойлоход гол үүрэг гүйцэтгэнэ.

Дээрхээс гадна Бодлого төлөвлөлтийн газраас нэгтгэн Дээрхээс гадна Бодлого төлөвлөлтийн газраас нэгтгэн боловсруулсан бодлоготой уялдуулан төсвийн удирдлагыг Санхүү, хөрөнгө оруулалтын газар хариуцаж, хэрэгжүүлэх бодлого болгон боловсруулсан хөгжлийн хөтөлбөрүүдийн хэрэгжилтэд Хяналт шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар мониторинг хийж, хөгжлийн шалгуурт тулгуурлан бодлогын үнэлгээ хийх тогтолцоотой байна.



Зураг 4.1 Хөгжлийн хөтөлбөрүүдийг хариуцах бүтэц, удирдлагын тогтолцоо

4.2 Үйл ажиллагааны төлөвлөгөөний тэргүүлэх чиглэл

Энэхүү Мастер төлөвлөгөөг боловсруулах явцдаа хөгжлийн хөтөлбөрүүдийн хариуцах газар нэгж болон Бодлого төлөвлөлтийн газрын мэргэжилтнүүдийг хамарсан зөвлөлдөх семинар зохион байгуулж, шаталсан шийдвэр гаргах аргачлалаар хариуцсан газар хэлтэст хамаарах ҮАТ-үүдийг үнэлэн эрэмбэлсэн (Хүснэгт 4.1). Үр дүнгээс харахад, Мастер төлөвлөгөөг боловсруулах явцад нэн тэргүүнд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг газар хэлтэс тус бүрээр эхний 3 төсөл, нийт 12 төслийг сонгосон бөгөөд эдгээр нь бодлогын асуудал хариуцсан мэргэжилтнүүдийн байр сууринаас харж сонгосон ҮАТ гэдгийг тэмдэглэх нь зүйтэй. Үүнийг харгалзан төсөв боловсруулахдаа дээд шатны төлөвлөгөө, хувийн хэвшил ААН байгууллагуудын хүсэл сонирхолтой нийцэж байгаа эсэхийг харгалзан Бодлого төлөвлөлтийн газар арга хэмжээг сонгох, хэрэгцээ шаардлагын зохицуулалтыг хийх шаардлагатай.

Хүснэгт 4.1 Үйл ажиллагааны төлөвлөгөөг эрэмбэлсэн жагсаалт

Хөгжлийн хөтөлбөр	Үйл ажиллагааны төлөвлөгөө	Эрэмбэ	Нэн тэргүүнд хэрэгжүүлэх ҮАТ
Газар тариалангийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар			
•1. Хүнсний ногооны нийлүүлэлтийн сүлжээг бэхжүүлэх хөтөлбөр	1-1. Чанартай үр, түргэтгэсэн тариалалтын аргыг нэвтрүүлэх замаар хүнсний ногооны нийлүүлэлтийн хугацааг уртасгах	2.593	✓
	1-2. Тариаланчдад /ногоочдод / зах зээлд чиглэсэн фермерийн менежментийг эзэмшүүлэх	2.221	
	1-3. ГТ-ын хоршоодоор дамжуулж ГТБ-ний нийлүүлэлтийн тогтолцоог бүрдүүлэх	2.395	✓
	1-4. Хүнсний ногоо боловсхуулах энгийн арга болон хэрэглээний чиглэлийн сургалт, сурталчилгаа хийх	2.127	
•2. Жимсний модны нийлүүлэлтийн сүлжээг бэхжүүлэх хөтөлбөр	2-1. Жимсний модны суулгацын төвийг түшиглэсэн нийлүүлэлтийн сүлжээг бэхжүүлэх	2.266	
	2-2. Тариалалтын зохистой технологийг түгээн дэлгэрүүлэх	2.366	
	2-3. Чацарганы экспортыг дэмжих	2.524	✓
•3. Тосны ургамлын	3-1. Рапсын үрийн дотоодын үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх	2.264	

Хөгжлийн хөтөлбөр	Үйл ажиллагааны төлөвлөгөө	Эрэмбэ	Нэн тэргүүнд хэрэгжүүлэх ҮАТ
нийлүүлэлтийн сүлжээг бэхжүүлэх хөтөлбөр	3-2. Рапс тариалах технологийг хөгжүүлэх, үйлдвэрлэлийг дэмжих	2.329	
	3-3. Рапсын худалдааны нөхцлийг сайжруулах	2.077	
	3-4. Рапсын тосны хэрэглээг өргөжүүлэхэд чиглэсэн сурталчилгаа	2.025	
•7. Газар тариалангийн бусад бүтээгдэхүүний нийлүүлэлтийн сүлжээг бэхжүүлэх хөтөлбөр	7-1. Мөөг тарих технологийн сургалт, түгээн дэлгэрүүлэлтийг эрчимжүүлэх	2.312	
	7-2. Мөөгний үндэсний стандарттай болох	2.132	
	7-3. Мөөгний хэрэглээг өргөжүүлэхэд чиглэсэн сурталчилгаа	2.188	
	7-4. Загасны хэрэглээг дэлгэрүүлэх зорилготой загас боловсруулах үйлдвэр байгуулах төлөвлөгөө	2.065	
Мал аж ахуйн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар			
• 4.Мах, сүүний нийлүүлэлтийн сүлжээг бэхжүүлэх	4-1. Малын үүлдэр угсааг сайжруулах тогтолцоо бүрдүүлэх	3.000	✓
	4-2. Өсвөр мал (хурга) бордох бизнесийг нэвтрүүлж дэмжих	2.661	✓
	4-3. Зах зээлийн эрэлт хэрэгцээнд нийцсэн махны шинэ зэрэглэл нэвтрүүлэх, нэмүү өртөг шингээхийг дэмжих	1.577	
	4-4. Мал төхөөрөх үйлдвэр байгуулах	2.068	✓
	4-5. МАА-н болон дайвар бүтээгдэхүүнээр гэрийн тэжээвэр амьтны хоол үйлдвэрлэл бий болгох	1.277	
	4-6. Сүү цуглуулах тогтолцоог бэхжүүлж,үйлдвэр цехэд сүү хүлээн авах хэмжээг нэмэгдүүлэх	1.039	
Хөнгөн үйлдвэрийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар			
•5. Ноос арьс ширний нийлүүлэлтийн сүлжээг бэхжүүлэх	5-2. Малчдын хоршоог түшиглэсэн ноос, арьс шир бэлтгэн нийлүүлэлтийн сүлжээг бэхжүүлэх	2.433	✓
	5-3. Нэхмэл сүлжмэл, арьс ширэн эдлэлийн тогтвортой үйлдвэрлэлийн тогтолцоо бүрдүүлэх төлөвлөгөө	2.303	
	5-4. Нэхмэлийн салбарт АҮ кластер хөгжүүлэх төлөвлөгөө	2.433	✓
•10. ХАА-н чиглэлийн ААН, хоршооны менежментийн чадавхийг бэхжүүлэх хөтөлбөр	10-1. Нэмүү өртгийн сүлжээний зээлийн тогтолцоог нэвтрүүлэх бэлтгэл судалгаа хийх	2.275	
	10-2. Агуулахын үнэт цаасны тогтолцоо нэвтрүүлэх бэлтгэл судалгаа хийх	2.065	
	10-3. ЖДҮ-ийн менежментийн бааз суурийг бэхжүүлэх	2.325	
	10-4. ХАА-н хоршооны менежментийн бааз суурийг бэхжүүлэх	2.422	✓
•11. Орон нутгийн ХААҮ-ийг дэмжих хөтөлбөр	11-1. Аж үйлдвэрийн кластер бойжуулахад чиглэсэн дэмжлэгийн тогтолцоо бүрдүүлэх	2.236	
	11-2. Зах зээлд өрсөлдөх чадварыг сайжруулах зорилгоор үйлвэрлэл-ЭШБ-ын уялдааг бэхжүүлэх	2.201	
	11-3. Нэг суурин нэг бүтээгдэхүүн хөдөлгөөнийг дэмжих	2.322	
Хүнсний үйлдвэрийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар			
•6. Зөгийн балны нийлүүлэлтийн сүлжээг бэхжүүлэх хөтөлбөр	6-1. Зөгийн мэргэшсэн малын эмч сурган бэлтгэх, өвчин, хортон шавьжид тэсвэртэй зөгийн АА-г дэмжих	2.193	
	6-2. Зөгийн балны чанарын баталгааг сайжруулж, өрсөлдөх чадварыг бэхжүүлэх	2.022	
	6-3. Кластерийг бэхжүүлэх замаар зөгийн балны экспортод түлхэц өгөх	2.171	
	6-4. Үйлдвэрлэлийн бусад салбартай хамтран ажиллаж зөгийн аж ахуйг сурталчилж дэмжих	1.967	
•8. ХАА-н бүтээгдэхүүний чанар эрүүл ахуйн тогтолцоог бэхжүүлэх хөтөлбөр	8-1. Хүнсний аюулгүй байдлыг хангах засаглалын чадавхийг сайжруулах	2.459	✓
	8-2. Экспортын хяналтын чадавхийг бэхжүүлэх	2.077	
	8-3. Бэлтгэн нийлүүлэлтийн дараах алдагдлыг бууруулах бэлтгэл судалгааны төлөвлөгөө	2.270	✓
	8-4. Чанар, эрүүл ахуй хяналтын хүний нөөцийг сургаж бэлтгэх	2.280	✓
	8-5. Олон улсын баталгаажуулалт авах замаар экспортын өрсөлдөх чадварыг бэхжүүлэх	2.183	
•9. ХАА-н бүтээгдэхүүний экспортыг эрчимжүүлэх бааз суурийг бий болгох хөтөлбөр	9-1. Худалдааны журмыг оновчтой болгох	2.226	
	9-2. Худалдааны хэлэлцээрийн чадавхи бэхжүүлэх	2.114	
	9-3. Экспортын дэмжлэгийг бэхжүүлэх	2.248	

Эх сурвалж: Жайка төслийн баг

Монгол Улсын

Хөдөө Аж Ахуйн нэмүү өртгийн сүлжээний Мастер төлөвлөгөө боловсруулах төсөл

Мастер төлөвлөгөө

Агуулга

1.-Р БҮЛЭГ. ХАА-н салбарын нэмүү өртгийн сүлжээг хөгжүүлэх Мастер төлөвлөгөөний тухай.1-1

1.1 Мастер төлөвлөгөө боловсруулах үндэслэл ба зорилго....1-1

1.2 Мастер төлөвлөгөөний байр суурь....1-1

1.3 Хамрах бүс нутаг ба зорилтот хугацаа....1-2

1.4 Мастер төлөвлөгөөний бүтэц....1-2

2.-Р БҮЛЭГ. ХАА-н нэмүү өртгийн сүлжээний хөгжлийн хэтийн төлөв....2-1

2.1 Монгол Улсын гадаад орчны нөхцөл байдал....2-1

2.1.1 Эдийн засаг....2-1

2.1.2 Нийгэм....2-4

2.1.3 Тээвэр, ложистикийн дэд бүтэц....2-6

2.1.4 Байгаль орчин....2-7

2.1.5 Хөгжлийн төлөвлөгөө, хуулийн тогтолцоо....2-10

2.2 Монгол Улсын ХАА-н салбарын ерөнхий төлөв ба бүс нутгийн онцлог....2-12

2.2.1 Газар тариалан....2-12

2.2.2 Мал аж ахуй....2-14

2.2.3 ХАА-н салбарын аж ахуйн нэгжүүд....2-18

2.3 ХАА-н гол нэр төрлийн бүтээгдэхүүний нийлүүлэлтийн сүлжээг хөгжүүлэх чиглэл....2-18

2.3.1 Хүнсний ногоо....2-18

2.3.2 Үр тариа, тосны ургамал....2-22

2.3.3 Жимс, жимсгэнэ....2-26

2.3.4 Мах (Гэрийн тэжээвэр амьтны хоолыг оруулан)....2-29

2.3.5 Хонины ноос....2-38

2.3.6 Ноолуур....2-44

2.3.7 Арьс шир....2-50

2.3.8 Зөгийн бал....2-55

2.3.9 Бусад ирээдүйтэй ХАА-н бүтээгдэхүүн (Мөөг / загас)....2-61

2.4 ХАА-н нэмүү өртгийн сүлжээ хөгжүүлэхэд шаардлагатай бусад хэтийн төлөв....2-69

2.4.1 Худалдааны хэлэлцээр....2-69

2.4.2 Чанар, эрүүл ахуйн хяналт....2-72

2.4.3 Санхүүгийн систем....2-75

2.4.4 Аж үйлдвэрийн кластер....2-77

2.4.5 Хөгжлийн түншүүдийн үйл ажиллагаа....2-78

3.-Р БҮЛЭГ. Монголын ХАА-н салбарын хөгжлийн стратеги....3-1

3.1 ХАА-н нэмүү өртгийн сүлжээг хөгжүүлэх үндсэн үзэл баримтлал....3-1

3.1.1 Өнөөг хүртэлх Монголын ХАА-н хөгжил 3-1
3.1.2 Цаашид ХАА-н салбар хэрхэн хөгжих вэ 3-4
3.1.3 Хөгжлийн үндсэн үзэл баримтлал 3-7
3.2 ХАА-н нэмүү өртгийн сүлжээг хөгжүүлэх үндсэн чиглэл 3-11
3.2.1 Хөгжлийн чиглэл 1. ХАА-н бүтээгдэхүүний тогтвортой нийлүүлэлт болон өндөр нэмүү өртөг шингээсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэхийн тулд үйлдвэрлэл, түгээлт нийлүүлэлтийн бааз бүрдүүлэх 3-11
3.2.2 Хөгжлийн чиглэл 2. ХАА-н бүтээгдэхүүний экспортыг дэмжихийн тулд чанар, эрүүл ахуйн хяналтын тогтолцоо болон холбогдох захиргааны байгууллагын чадавхийг бэхжүүлэх3-13
3.2.3 Хөгжлийн чиглэл 3. ХАА-н үйлдвэрлэлийг эрчимжүүлэхийн тулд ХАА-н чиглэлийн компани ААН, байгууллагуудыг дэмжих, хүний нөөцийг хөгжүүлэх.....3-13
3.2.4 Хөгжлийн чиглэл 4. Орон нутгийн онцлогтой газар тариалан, мал аж ахуйн үйлдвэрлэлийг дэмжих, ХАА-н үйлдвэрлэлийн кластерийг байгуулах 3-14
4.-Р БҮЛЭГ. ХАА-н салбарын нэмүү өртгийн сүлжээг хөгжүүлэх хөтөлбөр.....4-1
4.1 Хөгжлийн хөтөлбөрүүдийн ерөнхий бүтэц 4-1
4.2 Хөгжлийн хөтөлбөрүүдийн тойм.....4-1
4.2.1 Хүнсний ногооны нийлүүлэлтийн сүлжээг бэхжүүлэх хөтөлбөр 4-1
4.2.2 Жимсний модны нийлүүлэлтийн сүлжээг бэхжүүлэх хөтөлбөр 4-15
4.2.3 Тосны ургамлын нийлүүлэлтийн сүлжээг бэхжүүлэх хөтөлбөр 4-24
4.2.4 Мах, сүүний (гэрийн тэжээвэр амьтны хоолыг оруулан) нийлүүлэлтийн сүлжээг бэхжүүлэх хөтөлбөр 4-33
4.2.5 Ноос ноолуур, арьс ширний нийлүүлэлтийн сүлжээг бэхжүүлэх хөтөлбөр 4-61
4.2.6 Зөгийн балны нийлүүлэлтийн тогтолцоог бэхжүүлэх хөтөлбөр.....4-70
4.2.7 ХАА-н бусад бүтээгдэхүүний нийлүүлэлтийн сүлжээг бэхжүүлэх хөтөлбөр 4-82
4.2.8 ХАА-н бүтээгдэхүүний чанар, эрүүл ахуйн хяналтын тогтолцоог бэхжүүлэх хөтөлбөр .4-93
4.2.9 ХАА-н бүтээгдэхүүний экспортыг дэмжих бааз суурийг хөгжүүлэх хөтөлбөр 4-107
4.2.10 ХАА-н салбарын ААН, хоршоодын менежментийн бааз суурийг бэхжүүлэх хөтөлбөр 4-115
4.2.11 Орон нутгийн ХАА-н үйлдвэрлэлийг хөгжүүлэх хөтөлбөр 4-123
5.-Р БҮЛЭГ. Хөгжлийн хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх тогтолцоо 5-1
5.1 Мастер төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд холбогдох байгууллагууд 5-1
5.2 Хөгжлийн хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх механизм 5-2
5.2.1 Хөгжлийн хөтөлбөрүүдийг хариуцах бүтэц нэгжүүд 5-2
5.2.2 Хөгжлийн хөтөлбөрүүд / YAT-ний төсөв боловсруулах 5-3
5.2.3 Хөгжлийн хөтөлбөр / Үйл ажиллагааны төлөвлөгөөг хэрэгжүүлэх 5-6
5.2.4 Хөгжлийн хөтөлбөр / Үйл ажиллагааны төлөвлөгөөнүүдийн хөгжлийн шалгуур үзүүлэлт, мониторинг 5-6
5.3 Хөгжлийн хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх төслийн өртөг 5-10
5.3.1 Төслийн өртөг.....5-10
5.3.2 Төсвийн эх үүсвэр бүрдүүлэхийн тулд авах арга хэмжээ 5-13
6.-Р БҮЛЭГ. Дүгнэлт ба зөвлөмж.....6-1

6.1 Дүгнэлт 6-1
6.2 Зөвлөмж 6-3

Хүснэгтийн жагсаалт

Хүснэгт 1.1 Мастер төлөвлөгөөний бүтэц 1-2
Хүснэгт 2.1 Монголын ложистикийн гүйцэтгэлийн индекс 2-7
Хүснэгт 2.2 Монголын уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөллийн хэтийн таамаглал 2-9
Хүснэгт 2.3 УИХ-ын 36 дугаар тогтоолын товч агуулга 2-11
Хүснэгт 2.4 Сүүлийн жилүүдэд гаргасан/шинэчилсэн хууль тогтоомжууд 2-12
Хүснэгт 2.5 Нэг хүнд ногдох жилийн хүнсний хэрэглээний хэмжээ, бүтээгдэхүүн тус бүрээр (2013-2022 он) 2-14
Хүснэгт 2.6 Азийн бүс нутаг дахь мах, сүүн бүтээгдэхүүний хэрэглээ (грамм/өдөр/хүн) 2-15
Хүснэгт 2.7 Гол нэр төрлийн ногооны үйлдвэрлэл (1,000 тонн) 2-19
Хүснэгт 2.8 Хүнсний ногооны нийлүүлэлтийн сүлжээний тулгамдсан асуудал ба авах арга хэмжээ 2-21
Хүснэгт 2.9 Рапсын нийлүүлэлтийн сүлжээний тухай, асуудал ба авах арга хэмжээ 2-25
Хүснэгт 2.10 Жимс жимсгэний нийлүүлэлтийн сүлжээний асуудлууд ба авах арга хэмжээ 2-28
Хүснэгт 2.11 Монголд үйлдвэрлэсэн ГТА-ны хоолны экспортын өсөлт 2-35
Хүснэгт 2.12 Мах сүүний нийлүүлэлтийн сүлжээний тулгамдсан асуудал ба авах арга хэмжээ 2-35
Хүснэгт 2.13 Монгол Улсын хонины ноосны экспортын нийт дүн (5 жилээр: 2017-2021) болон экспортлогч улс орон 2-41
Хүснэгт 2.14 Ноос нийлүүлэлтийн сүлжээний тулгамдсан асуудал, авах арга хэмжээ 2-42
Хүснэгт 2.15 Монгол Улсын ноолуурын экспортын нийт дүн (5 жилээр: 2017-2021) болон экспортын түнш улс орнууд 2-47
Хүснэгт 2.16 Ноолуурын нийлүүлэлтийн сүлжээний асуудал, авах арга хэмжээ 2-48
Хүснэгт 2.17 Монгол Улсаас 2017-2021 оны 5 жилд экспортлосон арьс ширний үнэ ба экспортлосон улс 2-52
Хүснэгт 2.18 Арьс ширний нийлүүлэлтийн сүлжээний асуудал ба авах арга хэмжээ 2-53
Хүснэгт 2.19 Зөгийн балны нийлүүлэлтийн сүлжээний тулгамдсан асуудал ба авах арга хэмжээ 2-58
Хүснэгт 2.20 Мөөгний нийлүүлэлтийн сүлжээний асуудал ба авах арга хэмжээ 2-63
Хүснэгт 2.21 Загасны жилийн хэрэглээ бүс нутгаар (кг/хүн/ жил) 2-65
Хүснэгт 2.22 Монгол Улсын загас агнуурын үйлдвэрлэл, импорт, экспортын хэмжээ 2-66
Хүснэгт 2.23 Загасны нийлүүлэлтийн сүлжээний асуудал ба авах арга хэмжээ 2-66
Хүснэгт 2.24 Монголын худалдааны хэлэлцээрүүд 2-70
Хүснэгт 2.25 Худалдаанд тулгардаг асуудал ба авах арга хэмжээ 2-71
Хүснэгт 2.26 Чанар, эрүүл ахуйн хяналттын тулгамдсан асуудал, авах арга хэмжээ 2-75
Хүснэгт 2.27 Хөгжлийн түншүүдийн үйл ажиллагаа 2-78
Хүснэгт 3.1 Газар тариалангийн гол нэрийн бүтээгдэхүүний жилийн хэрэглээ 3-5
Хүснэгт 3.2 Монголын ХАА-н бүтээгдэхүүнд тулгарч буй асуудлууд 3-9

Хүснэгт 3.3 Монголын ХАА-н бүтээгдэхүүний давуу тал 3-10
Хүснэгт 3.4 Газар тариалангийн салбарын хөгжлийн чиглэл 3-12
Хүснэгт 3.5 МАА-н салбарын хөгжлийн чиглэл 3-12
Хүснэгт 3.6 Чанар, эрүүл ахуйн хяналтын салбарын хөгжлийн чиглэл.....3-13
Хүснэгт 3.7 ХАА-н чиглэлийн компани ААН, байгууллагуудын хөгжлийн чиглэл 3-14
Хүснэгт 3.8 Орон нутгийн ХАА-н үйлдвэрлэлийг хөгжүүлэх талаархи хөгжлийн чиглэл.....3-15
Хүснэгт 4.1 Хүнсний ногооны нийлүүлэлтийн сүлжээг бэхжүүлэх хөтөлбөр, хөгжлийн чиглэлийн хамаарал.....4-3
Хүснэгт 4.2 Жимсний нийлүүлэлтийн сүлжээг бэхжүүлэх хөтөлбөр, хөгжлийн чиглэлийн хамаарал 4-16
Хүснэгт 4.3 Тосны ургамлын нийлүүлэлтийн сүлжээг бэхжүүлэх хөтөлбөр болон хөгжлийн чиглэлийн хамаарал.....4-25
Хүснэгт 4.4 Мах, сүүний нийлүүлэлтийн сүлжээг бэхжүүлэх хөтөлбөр, хөгжлийн бодлогын чиглэлийн хоорондын хамаарал 4-34
Хүснэгт 4.5 Ноос, арьс ширний нийлүүлэлтийн сүлжээг бэхжүүлэх, хөгжлийн чиглэлийн хамаарал 4-61
Хүснэгт 4.6 Зөгийн балны нийлүүлэлтийн сүлжээг бэхжүүлэх хөтөлбөр болон хөгжлийн бодлогын чиглэл хоорондын хамаарал 4-70
Хүснэгт 4.7 Мөөгний нийлүүлэлтийн сүлжээг бэхжүүлэх хөтөлбөр, хөгжлийн бодлого хоорондын хамаарал 4-83
Хүснэгт 4.8 ХАА-н бүтээгдэхүүний чанар, эрүүл ахуйн хяналтын тогтолцоог бэхжүүлэх хөтөлбөр болон хөгжлийн чиглэлийн хамаарал холбоо 4-94
Хүснэгт 4.9 ХАА-н бүтээгдэхүүний экспортыг дэмжих дэд бүтцийг хөгжүүлэх хөтөлбөр болон хөгжлийн чиглэлийн хамаарал.....4-107
Хүснэгт 4.10 ХАА-н салбарын ААН, хоршоодын менежментийн бааз суурийг бэхжүүлэх хөтөлбөр ба хөгжлийн чиглэлийн хамаарал 4-116
Хүснэгт 4.11 ХАА-н чиглэлийн ААН, хоршооны менежментийн бааз суурийг бэхжүүлэх хөтөлбөр ба хөгжлийн чиглэлийн хамаарал 4-123
Хүснэгт 5.1 Үйл ажиллагааны төлөвлөгөөг эрэмбэлсэн жагсаалт 5-4
Хүснэгт 5.2 ҮАТ-ний хөгжлийн шалгуур үзүүлэлт 5-7
Хүснэгт 5.3 ҮАТ-г хэрэгжүүлэх хуваарь, төслийн өртөг.....5-11
Хүснэгт 5.4 ХХААХТГ-ийн /FADPG/ хурлаар хэлэлцэх асуудлууд (төсөл).....5-14

Зургийн жагсаалт

Зураг 1.1 Мастер төлөвлөгөөний байр суурь.....1-2
Зураг 2.1 Монгол Улсын нэг хүнд ноогдох ДНБ (1,000 USD) ба ДНБ-д эзлэх ХАА-н салбарын нэмүү өртгийн хэмжээ (%) 2-1
Зураг 2.2 Монгол Улсын хүн амын өсөлт, таамаг(сая хүн).....2-3
Зураг 2.3 Бүс нутаг тус бүрийн хүн амын өсөлт, таамаг (сая хүн) 2-3
Зураг 2.4 Нийт хүн амд эзлэх УБ-ын оршин суугчдын хувь 2-4
Зураг 2.5 Хот суурин ба ХАА-н суурины оршин суугчдын харьцаа.....2-4

Зураг 2.6 Монгол Улсын нийт тариалангийн талбай ба ногоочид, газар тариалангийн компаний тоо 2-6
Зураг 2.7 Монгол Улсын нийт мал сүрэг ба малчны тоо 2-6
Зураг 2.8 Монгол Улсын нийтийн тээврийн сүлжээ 2-7
Зураг 2.9 Монгол Улс (Улаанбаатар хот)-ын жилийн хур тундас, агаарын хэм....2-8
Зураг 2.10 1982-1996 оноос 1997-2012 он хүртэлх хугацааны дундаж биомассын өөрчлөлт....2-9
Зураг 2.11 Тариалсан талбайн орон зайн тархалт (2022 он)....2-13
Зураг 2.12 Гол нэр төрлийн бүтээгдэхүүний тариалангийн талбайн байршил (2022) 2-13
Зураг 2.13 Малын тоо толгойн орон зайн тархалтын байдал (2022 он) 2-17
Зураг 2.14 Таван хошуу малын орон зайн тархалтын байдал (2022 он)....2-17
Зураг 2.15 ХАА-н салбарын ААН-үүдийн орон зайн тархалтын байдал(2023 он)....2-18
Зураг 2.16 Монголын хүнсний ногооны нийлүүлэлтийн сүлжээ....2-19
Зураг 2.17 Хүнсний ногооны дотоодын үйлдвэрлэл ба импортын өсөлт (2012-2021 он)....2-20
Зураг 2.18 Хүнсний ногооны нийлүүлэлийн шинжилгээний SWOT шинжилгээ 2-22
Зураг 2.19 Монголын улаан буудайн борлуулалтын суваг 2-23
Зураг 2.20 Монгол дахь рапс, гичний нийлүүлэлтийн сүлжээ 2-23
Зураг 2.21 Монголын хүнсний тосны импортын хэмжээний өсөлт (төрөл тус бүрээр) 2-24
Зураг 2.22 Монголын рапс, гичний үйлдвэрлэлийн хэмжээний өсөлт 2-25
Зураг 2.23 Монголын рапсын нэмүү өртгийн сүлжээний SWOT шинжилгээ 2-26
Зураг 2.24 Монголын жимс, жимсгэний нийлүүлэлтийн сүлжээ 2-27
Зураг 2.25 Жимсний төрлийн үйлдвэрлэл, импортын хэмжээ (2012-2021 он) 2-27
Зураг 2.26 Жимс жимсгэнийн нийлүүлэлтийн сүлжээний SWOT шинжилгээ 2-29
Зураг 2.27 Монголын мах, сүүний нийлүүлэлтийн сүлжээ 2-30
Зураг 2.28 МАА-н бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн хэмжээ (тонн) ба үнийн (төг) өөрчлөлт, 2017-2021 он 2-31
Зураг 2.29 МУ-аас экспортлосон махан бүтээгдэхүүний хэмжээний өөрчлөлт: 2014-2021 он2-32
Зураг 2.30 Хурга бордох фермийн тоо ба бордсон малын тооны өсөлт: 2010-2019 он....2-33
Зураг 2.31 Үйлдвэрлэгчид ашиглах сүү цуглуулж хөргөх цэг (зүүн), Нээлтийн ёслол (баруун) 2-34
Зураг 2.32 Мах сүүний нийлүүлэлтийн сүлжээний тухай хөндлөнгийн SWOTшинжилгээ 2-37
Зураг 2.33 Ноосны нийлүүлэлтийн сүлжээний өнөөгийн байдал....2-40
Зураг 2.34 Ноосны нийлүүлэлтийн сүлжээний SWOT шинжилгээний дүн 2-44
Зураг 2.35 Ноолуурын нийлүүлэлтийн сүлжээний өнөөгийн байдал....2-46
Зураг 2.36 Ноолуурын нийлүүлэлтийн сүлжээний SWOT шинжилгээний дүн 2-50
Зураг 2.37 Арьс ширний нийлүүлэлтийн сүлжээний схем 2-51
Зураг 2.38 Арьс ширний нийлүүлэлтийн сүлжээний SWOT шинжилгээний үр дүн 2-54
Зураг 2.39 Зөгийн балны нийлүүлэлтийн сүлжээний өнөөгийн байдал 2-55
Зураг 2.40 Монголын зөгийн балны үйлдвэрлэл, зах зээлийн хэмжээ 2-56
Зураг 2.41 Дэлхийн зөгийн балны зах зээл (2019 оны байдлаар) 2-57
Зураг 2.42 Зөгийн балны нийлүүлэлтийн сүлжээний SWOT шинжилгээ....2-61
Зураг 2.43 Мөөгний нийлүүлэлтийн сүлжээ....2-61

Зураг 2.44 Мөөгний нэмүү өртгийн сүлжээний SWOT шинжилгээ 2-64
Зураг 2.45 Монгол Улсын түүхий загасны нийлүүлэлтийн сүлжээ 2-65
Зураг 2.46 Түүхий загасны нэмүү өртгийн сүлжээний SWOT шинжилгээ.....2-68
Зураг 2.47 Монгол Улсын зээлийн үлдэгдлийн өсөлт (2012~2023) 2-76
Зураг 2.48 ХАА, боловсруулах үйлдвэрлэлийн салбарт олгосон зээлийн дундаж хүүгийн өсөлт 2-76
Зураг 3.1 Улс орнуудын ХАА-н ДНБ-ний дундаж өсөлт (2012-2021).....3-1
Зураг 3.2 ХАА-н салбарын ДНБ-ийн регрессийн шинжилгээний дүн.....3-3
Зураг 3.3 ХАА-н салбарын хөгжлийн чиглэл 3-6
Зураг 3.4 МАА-н нэмүү өртгийн сүлжээг хөгжүүлэх чиглэл 3-7
Зураг 4.1 Хөгжлийн хөтөлбөрүүдийн бүтэц.....4-1
Зураг 4.2 Хүнсний ногооны нийлүүлэтийн сүлжээг бэхжүүлэх хөтөлбөр.....4-2
Зураг 4.3 Жимсний модны нийлүүлэлтийн сүлжээг бэхжүүлэх хөтөлбөр.....4-15
Зураг 4.4 Тосны ургамлын нийлүүлэлтийн сүлжээг бэхжүүлэх хөтөлбөр.....4-24
Зураг 4.5 Мах, сүүн бүтээгдэхүүний нийлүүлэлтийн сүлжээг бэхжүүлэх хөтөлбөр 4-33
Зураг 4.6 Ноос ноолуур, арьс ширний нийлүүлэлтийн сүлжээг бэхжүүлэх хөтөлбөр.....4-61
Зураг 4.7 Зөгийн балны нийлүүлэлтийн сүлжээг бэхжүүлэх хөтөлбөр.....4-70
Зураг 4.8 Мөөгний нийлүүлэлтийн сүлжээг бэхжүүлэх хөтөлбөр.....4-82
Зураг 4.9 Түүхий загасны нийлүүлэлтийн сүлжээг бэхжүүлэх хөтөлбөр 4-89
Зураг 4.10 ХАА-н бүтээгдэхүүний чанар, эрүүл ахуйн хяналтын тогтолцоог бэхжүүлэх хөтөлбөр 4-93
Зураг 4.11 ХАА-н бүтээгдэхүүний экспортыг дэмжих дэд бүтцийг хөгжүүлэх хөтөлбөр 4-107
Зураг 4.12 ХАА-н чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг ААН, хоршоодын менежментийн бааз суурийг бэхжүүлэх хөтөлбөр.....4-115
Зураг 4.13 Бүс нутгийн ХАА-н үйлдвэрлэлийгхөгжүүлэх хөтөлбөр.....4-123
Зураг 5.1 Мастер төлөвлөгөөг хэрэгжүүлэх ХХААХҮЯ-ны бүтэц 5-1
Зураг 5.2 Хөгжлийн хөтөлбөрүүдийн хариуцах бүтэц, удирдлагын тогтолцоо 5-3
Зураг 5.3 Төсвийн төлөвлөгөө батлах процесс 5-3

Валют хөрвүүлэх ханш (2023 оны 11-р сарын 1)

	MNT	USD	JPY
1MNT=		0.00038	0.05737
1USD=	2,620		150.708
1JPY=	17.3825	0.00663	

※ OANDA Rate

1.-Р БҮЛЭГ. ХАА-н салбарын нэмүү өртгийн сүлжээг хөгжүүлэх Мастер төлөвлөгөөний тухай

1.1 Мастер төлөвлөгөө боловсруулах үндэслэл ба зорилго

Монгол Улсын ХАА-н салбар нь уул уурхайн салбарын дараагаар орох, ДНБ-ий 12.8%-г (2022 он) эзэлдэг, хөдөлмөрийн насны хүн амны 30% орчим нь ажил эрхэлдэг тус улсын эдийн засгийн голлох салбар юм. Түүнчлэн боловсруулах үйлдвэрлэлийн чиглэлийн хүнс болон нэхмэлийн үйлдвэрлэлийн хоёр салбар нь боловсруулах салбарын нийт борлуулалтын 21% орчмыг (2019 он) эзэлж байна. Сүүлийн жилүүдэд Монгол Улсын Засгийн газар нь уул уурхайн салбарын өндөр хамаарлыг бууруулах зорилго тавьж буй бөгөөд, ХАА-н салбар нь эдийн засгийг төрөлжүүлэхэд томоохон үүрэг гүйцэтгэх салбар гэдгээрээ анхаарал татаж байна.

Гэвч МАА-н салбарын тухайд гэхэд хот орчмын бүсэд хэт олон мал төвлөрч, тоо толгойн өсөлтөөс хамааран бэлчээрийн даац хэтэрч, бэлчээр талхлагдах, ган зудын гамшигт нэрвэгдэх, түүнчлэн шүлхий зэрэг халдварт өвчний эсрэг авах арга хэмжээ хангалтгүй байгаа зэргийг тус салбарын тулгамдсан асуудлууд гэж үзэж байна. Мөн, газар тариалангийн салбарт төрөөс хэрэгжүүлсэн бодлогын нөлөөгөөр тариалах талбай болон хураан авах ургацыг хэмжээ нэмэгдэж, дотоодын хэрэгцээгээ хангах хувь хэмжээ сайжирч байгаа хэдий ч хүйтэн сэрүүний улирлын турш дахь тогтвортой үйлдвэрлэл, нийлүүлэлтийн тогтолцоо бүрэн дүүрэн бүрдээгүй байна. Боловсруулалт, түгээлтийн хувьд ч гэсэн боловсруулах технологийн түвшин доогуур, хүйтэн хэлхээг багтаасан түгээлтийн сүлжээ бий болоогүй, олон улсын стандартын шаардлагыг хангасан чанар, эрүүл ахуйн хяналт хэрэгжихгүй байгаа нь салбарын хөгжилд саад болж бүрэн хэмжээгээр өрсөлдөх чадвар сул хэвээр байна. Ийм нөхцөл байдлыг харгалзан ХХААХҮЯ болон ЭЗХЯ-ны хамтын ажиллагааны хүрээнд орон нутгийн онцлогийг тусгасан стратегийн ХАА-н нэмүү өртгийн сүлжээний Мастер төлөвлөгөө боловсруулахад Япон улстай хамтран ажиллах хүсэлт тавьсан юм.

1.2 Мастер төлөвлөгөөний байр суурь

Энэхүү Мастер төлөвлөгөөг МУ-ын урт хугацааны хөгжлийн төлөвлөгөө болох “Алсын хараа 2050” болон дунд хугацааны хөгжлийн төлөвлөгөө болох “Таван жилийн хөгжлийн үндсэн чиглэл”, түүнчлэн “Засгийн газрын мөрийн хөтөлбөр”-тэй уялдуулан боловсруулав. Иймээс ХАА-н салбарын урт хугацааны хөгжлийн хэтийн төлөв нь “Алсын хараа 2050”-ийг баримжаалан, богино дунд хугацаандаа “Таван жилийн хөгжлийн үндсэн чиглэл” болон ”Засгийн газрын мөрийн хөтөлбөр”-ийн төлөвлөлтөд тусгах чиглэл болон агуулгыг тусгасан болно. Түүнчлэн 2022 оны 6 сарын 27-нд “Хүнсний хангамж аюулгүй байдлыг хангах зарим арга хэмжээний тухай” УИХ-ын 36 дугаар тогтоол батлагдсан бөгөөд энэхүү тогтоолоор МУ-ын хүнсний хангамж, аюулгүй байдлын талаар баримтлах хөгжлийн тодорхой чиглэл, төлөвлөгөө батлагдаж, хэрэгжүүлэх хугацаа нь 2022-2026 оныг хамарч байна. Энэхүү Мастер төлөвлөгөөнд мөн уг тогтоолоор шийдвэрлэхээр заасан хөгжлийн чиглэл, төлөвлөгөөг ч мөн харгалзан тусгасан болно.



Зураг 1.1 Мастер төлөвлөгөөний байр суурь

Эх сурвалж: Жайка төслийн баг

1.3 Хамрах бүс нутаг ба зорилтот хугацаа

Энэхүү Мастер төлөвлөгөө нь Монгол Улсын бүх нутаг дэвсгэрийг хамрах бөгөөд төлөвлөгөө хэрэгжих зорилтот хугацаа 2025-2034 оныг хүртэл 10 жил байна.

1.4 Мастер төлөвлөгөөний бүтэц

Мастер төлөвлөгөө нь доорхи бүлгүүдээс бүрдэнэ.

Хүснэгт 1.1 Мастер төлөвлөгөөний бүтэц

Бүлэг	Гарчиг	Агуулга
1-р бүлэг	ХАА-н нэмүү өртгийн сүлжээг хөгжүүлэх Мастер төлөвлөгөөний тухай	МУ-аас тус Мастер төлөвлөгөөг боловсруулах хүсэлтийг Япон улсад тавьсан үндэслэлийг Монголын ХАА-н өнөөгийн байдалтай уялдуулан тайлбарласан. Түүнчлэн Монгол Улсын Засгийн газраас боловсруулж, хэрэгжүүлж буй үндэсний хөгжлийн бодлого, төлөвлөгөөтэй уялдсан байдлыг тайлбарлахын зэрэгцээ тус Мастер төлөвлөгөө нь МУ-ын хөгжлийн үндэсний бодлогод ямар байр суурь эзлэх талаар дурьдсан.
2-р бүлэг	ХАА-н нэмүү өртгийн сүлжээг хөгжүүлэх хэтийн төлөв	МУ-ын гадаад орчин болон нийгмийн байдлын талаарх мэдээллийг нэгтгэсэн. Цаашлаад ХАА-н гол нэр төрлийн бүтээгдэхүүн болон хөгжүүлэх нөөц боломж бүхий бараа бүтээгдэхүүнийг сонгон авч, нийлүүлэлтийн сүлжээний өнөөгийн байдал, тулгамдаж буй асуудал, хөгжлийн чиглэл тус бүрийг дэлгэрэнгүй авч үзсэн. Мөн хөгжлийн чиглэлийг бүс нутаг тус бүрээр нь судлан авч үзэж, тодорхойлсон. Эцэст нь ХАА-н нэмүү өртгийн сүлжээг хөгжүүлэхэд шаардлагатай бусад дэд бүтцийн хэтийн төлөвийг салбар тус бүрээр (гадаад худалдаа, чанар-эрүүл ахуйн менежмент, санхүүгийн тогтолцоо гэх мэт) эмхэтгэсэн.
3-р бүлэг	МУ-ын ХАА-н салбарын	Мастер төлөвлөгөөний “ХАА-н бүтээгдэхүүний зах зээлийн өрсөлдөх чадварыг бэхжүүлэх замаар Монголын ХАА-н хүчирхэг

Бүлэг	Гарчиг	Агуулга
	хөгжлийн стратеги	үйлдвэрлэлийг бий болгох” гэсэн үзэл баримтлал нь ХАА-н нэмүү өртгийн сүлжээг хөгжүүлэх үндэслэл болох талаар шинжлэх ухааны үүднээс тайлбарласан. МУ-д ХАА хэрхэн хөгжиж ирсэн замналыг дүгнэж, өнөөгийн нөхцөл байдалд дүн шинжилгээ хийсэн. Түүнчлэн энэхүү үзэл баримтлалыг хэрэгжүүлэхэд нэн тэргүүнд анхаарах ёстой хөгжлийн дөрвөн чиглэлийг танилцуулав.
4-р бүлэг	ХАА-н нэмүү өртгийн сүлжээг хөгжүүлэх хөтөлбөр	2-р бүлгийн Хөгжлийн бодлогын чиглэл болон 3-р бүлгийн Хөгжлийн стратегид үндэслэн нийт 11 хөтөлбөр боловсруулж, нэгтгэсэн. Хөтөлбөр тус бүрт хэрэгжүүлэх шаардлагатай Үйл ажиллагааны төлөвлөгөөг санал болгосон ба нийт 44 Үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулсан. Үйл ажиллагааны төлөвлөгөө тус бүрийг ямар байгууллага хариуцаж, ямар асуудлаар, хэзээ, юуг хэрэгжүүлэх шаардлагатайг төсвийн хамт тусгав.
5-р бүлэг	Хөгжлийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх тогтолцоо	Тус Мастер төлөвлөгөөний хэрэгжүүлэх тогтолцооны талаар энэ бүлэгт дурдсан. Үйл ажиллагааны төлөвлөгөө тус бүрийн зорилгод хүрэх хөгжлийн шалгуур үзүүлэлт, хэрэгжилт-мониторингийн тогтолцоо болон хуваарь, зардлын жагсаалтыг нэгтгэсэн. ХХААХҮЯ хэрэгжүүлэх тогтолцоонд голлох үүрэг гүйцэтгэн, холбогдох төрийн байгууллагууд болон хандивлагч байгууллагуудыг зохион байгуулж, төслийг эхлүүлэх ба хэрэгжүүлэх зардлыг төр, хувийн хэвшил хамтран гаргах хэлбэрийг түлхүү санал болгов.
6-р бүлэг	Дүгнэлт ба зөвлөмж	Энэхүү бүлэгт Мастер төлөвлөгөөний гол агуулгыг нэгтгэн дүгнэж, МУ-ын ХАА-н нэмүү өртгийн сүлжээг хөгжүүлэхэд чиглэсэн зөвлөмжийг тусгав.

Эх сурвалж: Жайка төслийн баг

2.-Р БҮЛЭГ. ХАА-н нэмүү өртгийн сүлжээний хөгжлийн хэтийн төлөв

2.1 Монгол Улсын гадаад орчны нөхцөл байдал

2.1.1 Эдийн засаг

(1) Эдийн засгийн өсөлтөд ХАА-н салбарын оруулах хувь нэмэр

Монгол Улс нь зэс, нүүрс гэх мэт эрэлт өндөртэй уул уурхайн түүхий эдийн нөөцөөр нэн баялаг бөгөөд, 2000-аад оноос Хятад зэрэг ойр орчмын улсуудын хэрэгцээ нэмэгдснээс уул уурхайн салбарын олборлолт огцом өсч, үүний улмаас нэг хүнд ноогдох ДНБ ч нэмэгдсэн байна (Тодруулбал 2000 онд 520-иод доллар байсан бол 2012 онд 4280 орчим доллар болж нэмэгдсэн байна[1].). Нөгөө талаар 2012-2021 он хүртэлх 10 жилд, 2015-2016 онд тохиолдсон дэлхий дахины уул уурхайн бүтээгдэхүүний үнийн уналт болон 2020 оноос эхэлсэн шинэ корона вирусын нөлөөгөөр мэдэгдэхүйц эдийн засгийн өсөлт ажиглагдаагүй (Зураг 2.1). Мөн ДНБ-нд эзлэх ХАА-н салбарын нэмүү өртгийн[2] хэмжээ дээрх 10 жилд ерөнхийдөө тогтвортой байна. Өдгөө Монгол Улсын эдийн засгийн бүтэц уул уурхайгаас хамаарал өндөр, эдийн засгийг төрөлжүүлэх нь нэн яаралтай хийх ажил болоод байгаа бөгөөд дээрх 10 жилийн хугацаанд ХАА-н салбарын эдийн засагт оруулах хувь нэмэр бараг өөрчлөгдөөгүй нь бодит байдал билээ. “Алсын хараа 2050” бодлогын баримт бичигт мөн ДНБ-нд эзлэх боловсруулах үйлдвэрлэлийн (ХАА-н салбарыг оруулаад) хэмжээг нэмэгдүүлэхээр тусгасан байгаа бөгөөд, Монгол Улсын эдийн засгийг тогтворжуулахад ч бас ХАА-н салбарын эдийн засагт оруулах хувь нэмрийг нэмэгдүүлэхэд чиглэсэн арга хэмжээг хэрэгжүүлэх зайлшгүй шаардлагатай.

Зураг 2.1 Монгол Улсын нэг хүнд ноогдох ДНБ (1,000 USD) ба ДНБ-д эзлэх ХАА-н салбарын нэмүү өртгийн хэмжээ (%)
Эх сурвалж:ДБ (https://databank.worldbank.org/reports.aspx?source=2&country=MNG#) -д үндэслэн ЖАЙКА төслийн баг боловсруулав.

[1] ОУВС (https://www.imf.org/en/Countries/MNG#countrydata) -ыг үзнэ үү.
[2] "ХАА-н салбарын нэмүү өртөг (ДНБ-д эзлэх харьцаа)" нь ХАА, ой, загас агнуурын салбарын улс орны эдийн засагт оруулж буй хувь нэмрийг харуулдаг индекс юм. Энэхүү нэмүү өртөг нь эдгээр салбарт үйлдвэрлэсэн эдийн засгийн нийт бүтээгдэхүүнээс бусад салбараас худалдан авсан түүхий эд болон орц нийлүүлэлтийн дүнг хассаныг хэлнэ.

(2) Дотоод ба гадаад зах зээлийн хэмжээ

Цаашид, ХАА-н салбарын эдийн засагт оруулах хувь нэмрийг нэмэгдүүлэхийн тулд дотоодын зах зээл дэх Монголд үйлдвэрлэсэн бараа бүтээгдэхүүний хэмжээг нэмэгдүүлэх шаардлагатай. Монгол Улсын хүн ам нь 2022 оны байдлаар 3,4 сая орчим байгаа бол 2050 он гэхэд 4 сая 510 мянгад хүрнэ гэж таамаглаж байгаа бөгөөд, түүний зах зээлийн багтаамж нь хөрш Хятад улс (2022 оны байдлаар 1 тэрбум 411 сая 750 мянган хүн), Орос (2022 оны байдлаар 145 сая 800 мянган хүн) тай харьцуулахад туйлын бага байна. (Зураг 2.2). Бүс нутгаар авч үзвэл Хятадыг оролцуулаад Зүүн Азийн бүс нутаг хамгийн олон хүн амтай байгаа ба 2050 он гэхэд цөөрөх таамналтай ч гэхдээ л аварга том зах зээл хэвээрээ байх нь. Бусад бүс нутагт, ЗӨА болон Баруун Азийн бүсэд хүн ам өсөх хандлагатай байгаа бөгөөд 2050 он гэхэд ЗӨА-ийн хүн ам 800-аад сая хүн, Баруун Азийн бүс 400 сая орчим хүнтэй болох прогноз байна (Зураг 2.3). Хүнсний аюулгүй байдлын өнцгөөс авч үзвэл Монгол Улсын дотоодын хүн амын өсөлтөөс хамаарах хүнсний хэрэгцээний талаар авах арга хэмжээ шаардлагатай, нөгөө талаар тус улсын хүн амын тоо нь угаасаа цөөн гэдэг талаас нь авч үзвэл ХАА-н салбарын эдийн засагт оруулах хувь нэмрийг нэмэгдүүлэхийн тулд олон улсын зах зээлд өрсөлдөх чадвартай ХАА-н бүтээгдэхүүнийг нэмэгдүүлэх, тухайн зах зээлээс хувь хүртэхийг зорихоос өөр арга зам алга байна. Хөрш орнууд болох Хятад, Оросын уламжлалт зах зээл, жил ирэх тусам зах зээл нь улам томрох ЗӨА болон Баруун Азийн улсуудыг зорилго болгон тэдгээр орнуудын хэрэгцээнд нийцсэн, өрсөлдөх чадвартай бүтээгдэхүүн үйлдвэрлэлд анхаарах шаардлагатай.

Мөн, мэдээж хэрэг олон улсын зах зээлд өрсөлдөх чадвар гэдэг нь, хэрэглэгчийн сэтгэл татахуйц бүтээгдэхүүн үйлдвэрлэх төдийгүй улс хоорондын худалдааны хэлэлцээр, гэрээ, экспортын шат дамжлагыг хурдасгах, бараа материалын аюулгүй байдал, чанарын тогтвортой байдал, бараа бүтээгдэхүүнийг цаг тухайд нь хэрэглэгчид хүргэх ложистикийн дэд бүтэц хөгжүүлэх гэх зэрэг төрөл бүрийн хүчин зүйлсийг шийдвэрлэх шаардлагатай байдаг. Эдгээрийг тус тусад нь (дэс дараалан) сайжруулаад явах шаардлагатай.

Дээр дурдсан асуудлууд нь Монгол орны ХАА-н салбарын оролцогчдын хувьд туйлын зүй ёсны бодит байдал гэж хүлээн зөвшөөрөгдсөн асуудлууд бөгөөд Мастер төлөвлөгөө боловсруулахад Монгол Улсын ХАА-н салбарт тулгарч буй энэхүү байдлыг өөрчлөн сайжруулах ёстойг ойлгон тунгааж, эдгээр сорилтыг хэрхэн даван туулах талаар судлах шаардлагатай.



Зураг 2.2 Монгол Улсын хүн амын өсөлт, таамаг(сая хүн)
Эх сурвалж: НҮБ-ын мэдээллийн портал (2023)



Зураг 2.3 Бүс нутаг тус бүрийн хүн амын өсөлт, таамаг (сая хүн)
Эх сурвалж: НҮБ-ын мэдээллийн портал (2023)

(3) Олон улсын зах зээлийн эрэлтийн өөрчлөлт

Олон улсын зах зээлийн эрэлт хэрэгцээг сайтар судалж түүнд тохирох бүтээгдэхүүн буй болгохыг дэмжих нь гадаад зах зээлээс ашиг олох замаар ХАА-н салбараа хөгжүүлэх шаардлагатай байгаа Монгол Улсын хувьд тэр зах зээлийн шаардлагыг хангасан бүтээгдэхүүн бий болгохыг дэмжих нь туйлын чухал арга хэмжээ байх болно гэж хэлж болно. Түүнээс гадна орчин үед олон улсын зах зээлийн эрэлт хэрэгцээнд нэг томоохон чиглэл их хүчтэй орж ирж байна. Өөрөөр хэлбэл тогтвортой байдал ба байгаль орчныг хамгаалах гэх мэт үг хэллэгээр дамжих “байгальд ээлтэй” бүтээгдэхүүний эрэлт хэрэгцээ юм. Өрнөдөд болон Японд ёс зүйтэй хэрэглэ[3] гэгддэг хэрэглэгчийн худалдан авалт хийх зан үйлийн өөрчлөлт нь, зөвхөн тухайн орны төдийгүй дэлхий нийтийн чиг хандлага болж байна гэхэд хэтрүүлэг болохгүй,”тогтвортой бараа”-г эрэлхийлэх хэрэглэгчид 2016-2021 оны хооронд 71%-иар нэмэгдсэн ба “ялангуяа ийм хэрэглээний ухамсарын өөрчлөлт нь Энэтхэг, Пакистан, Индонези зэрэг цаашид эдийн засгийн өсөлттэй байх төлөвтэй Азийн орнууд анхаарал татаж байна[4]. Мөн дэлхий нийтэд хэрэглэгчийн худалдаа хийх хандлагын өөрчлөлт нь хувь хөрөнгө оруулагчийн хөрөнгө оруулалтын норм (шалгуур үзүүлэлт)-д ч хүчтэй нөлөөлж байна. IBM Institute for Business Value-ийн тайланд дурьдахдаа, судалгаанд хамрагдсан хувь хөрөнгө оруулагчдын 65% нь ,тогтвортой байдал ба байгаль орчинд ээлтэй үйл ажиллагаа явуулдаг компанид хөрөнгө оруулах, тэд санхүүгийн ашиг олдоггүй хүмүүсээс илүү их хүлээлттэй байдаг гэж хариулжээ[5]. Бүтээгдэхүүний үнэ цэнэ нь уламжлалт үзүүлэлт болох аюулгүй, амар амгалан байдал, чанар үнэ, үйл ажиллагаа гэдэг хэмжүүрээс гадна, тухайн бүтээгдэхүүн хэр зэрэг тогтвортой, байгаль орчинд ээлтэй байна вэ гэх шинэ шаардлагыг тавих болжээ гэдгийг ойлгож, ийм үзүүлэлт (үзэл бодлоор бүтээсэн) шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг дэмжих шаардлага тулгарч байна.

[3] Хэрэглэгч бүр нийгмийн асуудлаа шийдвэрлэхэд санаа тавьж, тухайн асуудалд анхаардаг бизнес эрхлэгчийг дэмжсэн хэрэглээний үйл ажиллагаа

[4] The Economist, 2021, An Eco-wakening, Measuring global awareness, engagement and action for nature

[5] IBM Institute for Business Value, 2022, Balancing sustainability and profitability

2.1.2 Нийгэм

(1) Монгол орны хүн амын нутагшилт

Монгол Улс нь зах зээлийн эдийн засагт шилжсэнтэй холбоотойгоор хотжилт тэлж, ялангуяа Улаанбаатарт олон хүн ажил сургууль, эмчилгээ хийлгэх зорилгоор шилжин амьдрах болсон. Одоогоос 20-иод жилийн өмнөх 2003 онд Улаанбаатар хотын оршин суугчдын тоо нийт хүн амын 40 орчим хувийг эзэлж байсан бол 2022 он гэхэд 49% болтлоо нэмэгдсэн байна (Зураг 2.4). Мөн хотын оршин суугч болон ХАА-н суурины оршин суугчдын хүн амын харьцааг харвал ХАА-н суурины хүн ам энэ 20-иод жилд бараг өөрчлөгдөөгүй бол хотын оршин суугчдын тоо л өсөх чиглэлтэй байгааг харж болно (Зураг 2.5). Нийслэл Улаанбаатарын хүн амын огцом төвлөрөл нь тухайн бүс нутгийн нийгмийн дэд бүтэц болон амьдрах орчин зэрэг нийгмийн суурь дэд бүтцийн дутагдлыг урхагшуулж байна[6]. Байнга гардаг замын түгжрэл, агаарын бохирдол эрүүл бус орчин, гэр хорооллын тэлэлт зэрэг олон асуудлыг үүсгэж байна. Ийм учраас Монголын засгийн газар 1)Улааанбааатар хотын дэд бүтцийн асуудлыг шийдэх, 2)Хөдөөд бүсийн төв хот хөгжүүлэх, 3)Бүс нутгийн аж үйлдвэржилтийг идэвхижүүлэх замаар Улаанбаатар хотын орчныг сайжруулах, Улаанбаатарын хүн амын механик өсөлтийг сааруулахыг зорьж байна.



Зураг 2.4 Нийт хүн амд эзлэх УБ-ын оршин суугчдын хувь
Эх сурвалж: https://www.1212.mn/mn



Зураг 2.5 Хот суурин ба ХАА-н суурины оршин суугчдын харьцаа
Эх сурвалж: https://www.1212.mn/mn

Нөгөөтэйгүүр, ХАА-н салбарын өнцгөөс харвал хүн ам нь хот суурин газар, тэр дундаа Улаанбаатар хотод төвлөрч, тодорхой хэмжээний зах зээл бүрэлдэн бий болсноор томоохон жижиглэнгийн худалдаачид сүлжээ супермаркетуудыг өргөнөөр хөгжүүлж эхэлсэн. Хүнсний хангамжийн шинэ сүлжээ, ялангуяа стандартчилал, хүнсний аюулгүй байдлыг хангах, цаг тухайд нь тээвэрлэх боломжтой ХАА-н бүтээгдэхүүний үйлдвэрлэл, хангамжийн тогтолцоог бий болгох шаардлагатай байна. Энэ үзэгдэл одоогоор Улаанбаатар хотоор хязгаарлагдаж байгаа ч ойрын ирээдүйд орон нутгийн зангилаа хотуудад үүнтэй төстэй өөрчлөлт гарах боломжийг анхаарч үзэх хэрэгтэй байх аа.

[6] АХБ, 2022, URBAN SECTOR FACT SHEET

(2) Малчид ба тариаланчид

ХАА нь социализмын үед өргөн далайцтай хөгжиж, 1980-аад онд ХАА-н бүтээгдэхүүнээ гадаадад экспортлох хэмжээнд хүрч байсан байна.[7] Тариалах талбайн хэмжээ дээд тал нь 1989 онд 837,868 га-д хүрч байсан бол, зах зээлийн эдийн засагт шилжснээс хойш төвлөрсөн төлөвлөгөөт ХАА-н үйлдвэрлэл бус зах зээлийн эрэлтэд нийцсэн ХАА-н үйлдвэрлэлээр солигдсны дээр хүнсний бүтээгдэхүүний импорт нэмэгдсэн нь тариалангийн талбайн ихэнх нь хаягдаж, тариалах талбай огцом буурсан. Харин Монголын засгийн газраас сүүлийн жилүүдэд бодлогоор (1-3 дахь ГТ-г сэргээх төлөвлөгөө) тариалах талбайг төлөвлөгөөт эдийн засгийн үеийн хэмжээнд ойртуулснаар 2021онд зах зээлийн эдийн засагт шилжснээс хойш хамгийн их буюу 678,232 га-д хүрчээ. Нөгөө талаар 2014-2021 онд ГТҮ эрхлэгч, ГТ-ийн ААН-ийн тоо бараг өөрчлөгдөөгүй байгаа ба үйлдвэрлэгчид ноогдох талбайн хэмжээ нэмэгдэх хандлагатай байгаа нь харагдаж байна (Зураг 2.6) . Цаашид хүн амын өсөн нэмэгдэх явц хүнсний эрэлтийн улмаас тариалах талбай нэмэгдэх хандлагатай байгаа тул усан хангамж, ХАА-н механикжуулалтын талаар арга хэмжээ авах зайлшгүй шаардлагатай байна.

МАА-н тухайд, социализмын үед малын тоо 20-25 саяын хооронд хэлбэлздэг байсан байна[8]. Гэтэл зах зээлийн эдийн засагт шилжиж төрийн өмч байсан мал сүргийг нүүдэлч малчдын хувийн өмчид буцааж,хувийн өмч болсон малын худалдаа наймаа нь малчин өрхийн өөрсдийн үзэмжийн асуудал болсон. Монгол Улсад 1990-д оны эхэнд тохиолдсон их инфляци ч нөлөөлж, олон малчин малаа худалдахаас татгалзах болсон нь мал нь хадгаламж /хөрөнгө/-ийн үүргээ улам бэхжүүлсэн, социализм дампуурснаас хойш 30 жил ч өнгөрөөгүй өнөөдрийг хүртэлх энэ хооронд зуд турханд мал сүргийн 20-30% нь үрэгдсэн их гамшиг 2 ч удаа тохиолдсон хэдий ч малын тоо толгой бараг 3дахин өссөн байна. Малын тоо толгой одоо ч өсөх хандлагатай байгаа ба 2022 онд хамгийн олон буюу 71 сая 120 мянган толгойд хүрчээ. Харин малчдын тоо өнгөрсөн 10 жилд бараг өөрчлөгдөөгүй ба нэг малчинд 158 толгой мал ноогдож байсан бол 233 толгой болж 67%-иар өссөн байна (Зураг 2.7). Монголын ХААБ-ийн тайланд[9] зах зээлийн эдийн засагт шилжихийн өмнө, нэг малчинд 50 толгой мал ноогдож байсан гэхээр малчны ачаалал огцом нэмэгдсэн гэдэг нь харагдаж байна. Социализмын үе шиг мал сүргийг адуулах ажиллах хүчин одоогийн малчдад байхгүй, чухамдаа үүнээс болж малын түүхий эдийн (ноос, арьс, мах) чанар муудах, халдварт өвчин тархаж байгаа нь бодитой бөгөөд нэг малаас авах ашиг шимийг нэмэгдүүлэх нь нэн тулгамдсан асуудал гэж хэлэхээр байна.

[7] 「Монголын ХАА-н хөгжлийн түүх」 Конагая Юүки (Konagaya Yuki), 2010, Үндэсний угсаатны зүйн музейн судалгааны тайлан 35(1) : 9– 138
[8] Humphrey, C. 1978. Pastoral nomadism in Mongolia: the role of herdsmen's cooperatives in the national economy. *Development and Change* **9**: 133-160.
[9] МХААБ, 2021, "Загвар сумын түүхий эд бэлтгэлийн анхан шатны боловсруулалт хийх төсөл"ийн илтгэлийн материал



Зураг 2.6 Монгол Улсын нийт тариалангийн талбай ба ногоочид, газар тариалангийн компаний тоо
Эх сурвалж: https://www.1212.mn/mn



Зураг 2.7 Монгол Улсын нийт мал сүрэг ба малчны тоо
Эх сурвалж: https://www.1212.mn/mn

2.1.3 Тээвэр, ложистикийн дэд бүтэц

Монгол Улсын ХАА-н салбарын хөгжилд, ХАА-н бүтээгдэхүүнийг экспортлоход тээвэр ложистикийн дэд бүтэц чухал үүрэг гүйцэтгэх учиртай юм. Далайд гарцгүй Монгол Улс нь агаарын ба хуурай замын тээврээр хязгаарлагддаг, хуурай замын тээвэр нь авто ба төмөр зам хоёр юм. Агаарын тээврийн тухайд Монгол оронд дотоодын 18 байршилд нисэх буудалтай, Улаанбаатарын Чингисхаан олон улсын нисэх онгоцны буудлыг 2021онд Японы засгийн газрын хөгжлийн албан ёсны тусламж иэний зээлийн төслөөр барьж нээсэн бол автозамын тухайд Хятад улс, нийслэл Улаанбаатар, Оросыг холбосон АН-2, мөн Ховдоор дайрч Хятад Оростой холбогдсон АН-4 автозамын сүлжээ бий. Бас нийслэл Улаанбаатар-Ховдыг холбосон АН-32 замын барилгын ажил 2020 онд баригдаж дууссан. Төмөр замын тухайд, АН-2-ын дагуу хойт урьд хилийг холбосон шугамаас гадна Дорнод аймгийн Чойбалсан хотыг Оросын Борзятай холбосон шугам бий. Бас 2022 онд Тавантолгой-Гашуунсухайтын хооронд болон Зүүнбаян-Ханги чиглэлийн Монгол-Хятадыг холбосон 2,3 дахь төмөр замын шугамууд баригдаж дууссан ч хил холболтын ажил хараахан эхлээгүй зураг төсөл хийгдсэн[10]. Цаашилбал Эрдэнэтийг Оросын хилтэй Өрнө-Дорно чиглэлд холбох Арц суурийн замыг барьж байгаа[11]. Том өнцгөөр харвал, Хятад Орос гэдэг хоёр аварга зах зээлд нэвтрэх тээвэр ложистикийн чиглэлийг ашиглах нь юуны өмнө чухал ба Монголын засгийн газар Өрнө-Дорно болон Умард-Өмнөд чиглэлийн автозамыг яаралтай барьж байгаа бөгөөд Улаанбаатар хот бүх аймгийн төвүүдтэй хатуу хучилттай замаар холбогдсон ч, босоо чиглэлд ихэнх аймгуудын хооронд холбох гол замын ихэнх нь хайрган зам (Gravel road) бол сумдыг холбосон зам нь бараг тэр чигтээ хээрийн шороон зам (Earth Road) байна. Бас төмөр замын цариг нь Хятадынхаас өргөн учир хилийн өртөөн дээр ачааг шилжүүлэн ачих шаардлага гардаг нь хүндрэлтэй асуудал юм.[12].

[10] https://www.railjournal.com/freight/mongolia-opens-third-railway-to-chinese-border/
[11] Ministry of Road and Transport Development, 2018, Transport Strategy of Mongolia
[12] World bank, 2019, Mongolia Central Economic Corridor Assessment



Зураг 2.8 Монгол Улсын нийтийн тээврийн сүлжээ

Эх сурвалж:The Humanitarian Data Exchange-д үндэслэж ЖАЙКА төслийн баг боловсруулав.

Түүнчлэн ложистикийн дэд бүтцийн байгууламж төдийгүй, ложистик үйлчилгээ, бүх төрлийн процедур зэргийн үүрэг (утга учир), шуурхай байдал ч бас чухал үзүүлэлт мөн. Дэлхийн банкнаас гаргадаг ложистик гүйцэтгэлийн индексээр бол[13] (Logistics Performance Index: LPI) Монгол нь дэлхийн зэрэглэлээр 2014 онд 135-р байрт байсан бол 2023 онд 97-д орж нэлээд урагшилсан байна (Хүснэгт 2.1). Гэхдээ л бодит байдалд ложистик гүйцэтгэдийн индексийн пункт нь дөнгөж 0,1-р нэмэгдснээс хэтрээгүй, ялангуяа ложистикийн дэд бүтэц, үйлчилгээ үзүүлэгчийн (provider) чадвар, чанарын хувьд бага оноотой байна. Дээр өгүүлсэнчлэн, Монголын засгийн газраас ложистикийн дэд бүтцийн байгууламжийг тууштай барьж байгуулж байгаа ч ложистикийн найдвартай байдал бүхэлдээ хангалттай биш байгаа нь бодит байдал дээр ХАА-н гаралтай бүтээгдэхүүний экспортод томоохон саад болж байгааг хүлээн зөвшөөрөх хэрэгтэй байх.

Хүснэгт 2.1 Монголын ложистикийн гүйцэтгэлийн индекс

	Зэрэглэл	оноо	Гаалийн оноо	Дэд бүтцийн оноо	ОУ-ын тээвэр Зуучийн оноо	Логистикийн ур чадвар, чанарын оноо	Цаг баримтлах оноо	Хяналт, мөшгилтийн оноо
2014	135	2.4	2.2	2.3	2.6	2.3	2.5	2.1
2018	130	2.4	2.2	2.1	2.5	2.2	3.1	2.1
2023	97	2.5	2.5	2.3	2.5	2.3	2.7	2.4

Эх сурвалж: ДБ-ны ложистик гүйцэтгэлийн индекс ба шалгуурт үндэслэж ЖАЙКА төслийн баг боловсруулав

2.1.4 Байгаль орчин

(1) Уур амьсгал

Монгол Улсын ХАА-н үйлдвэрлэлийг хамгийн том хязгаарлагч хүчин зүйл нь уур амьсгал юм. Газар тариалангийн тухайд хүлэмжийн тариалалтыг тооцохгүйгээр дөнгөж 4-9 сар хүртэл богинохон хугацаанд үйлдвэрлэл явагддагаас гадна, жилд унах хур тундас 370 мм орчим бага

[13]Дэлхийн банкнаас хоёр жил тутамд гаргадаг улс нэг бүрийн ложистикийн гүйцэтгэлийг хэмждэг индекс. (1) гаалийн бүрдүүлэлт, (2) дэд бүтэц, (3) зардал, (4) чанар, (5) мөшгилт, (6) цаг баримтлах гэсэн зургаан зүйлийг таван онооны системээр үнэлж, тухайн үнэлгээний дундаж утгыг ложистик гүйцэтгэлийн индекс гэж зарладаг.

байгаа, усан хангамж хүнд асуудал болдог байна (Зураг 2.9). Мөн МАА-н хувьд хүнд асуудал бол ялангуяа агаарын хэм буурдаг 12-1-р сарын хүйтэн цаг агаараас (зуд) мал олноор хорогддог явдал юм. Энэхүү хатуу ширүүн орчинд ГТ-ийн хувьд хүлэмж болон ургацаа хадгалах агуулах барих, МАА-н хувьд уур амьсгалын гамшгийн тухай эрт анхааруулах систем байгуулах болон тэжээлийн үйлдвэрлэл, нөөцлөх шаардлагатайг анхааруулдаг ба олон улсын тусламжийн байгууллагууд янз бүрээр тусалж байна[14].



Зураг 2.9 Монгол Улс (Улаанбаатар хот)-ын жилийн хур тундас, агаарын хэм
Эх сурвалж: Climate-data.org-д тулгуурлан ЖАЙКА төслийн баг боловсруулав.

(2) Бэлчээр

Евроазийн эх газарт оршдог Монгол Улс нь хойгуураа ОХУ, өмнө талаараа БНХАУ-тай хиллэдэг, 156.40 мянган км2 нутагтай эх газрын улс юм. Японоос бараг 4 дахин том газар нутагтай, нутгийн бараг 80% нь байгалийн бэлчээртэй. Монголд байгалийн энэ нөөцийг ашигласан нүүдлийн МАА-н соёл хэдэн мянган жилээр хөгжиж ирсэн. Японд ч мөн Монголыг “Тал нутгийн орон” гэж төсөөлдөг ба ХАА-н салбар гэдэг ЭЗ-ийн ухагдахуун талаас нь харвал МАА-н үйлдвэрлэлийн төлөв байдал нь дараахь онцлогтой. Тухайлбал Монголын нийт нутагтай харьцуулбал бэлчээрийн эзлэх хувь нь дэлхийд 1-д ордог ба[15], нүүдлийн, тэр бүү хэл таримал тэжээлд бараг найддаггүй өөр хаана ч байхгүй, Австрали, Шинэ Зеланд, Ботствани, Намибия зэргийг бэлчээр ихтэй хэдий ч суурин хэлбэрийн таримал тэжээл хавсардаг эрчимжсэн МАА-с огт өөр юм. Энэ нь МАА-н үйлдвэрлэл нь тэжээлийн өртгийг бага байлгах боломжтой гэдгээрээ давуу талтай ч эсрэгээрээ, малын идэш тэжээлийн дийлэнх нь бэлчээрээс хамааралтай байгаа нь эмзэг байдлыг дагуулдаг. 1992 оноос хойш зах зээлийн эдийн засагт шилжиж мал хувийн өмч болсон нь малын тооны өсөлтийг хурдасгаад зогсоогүй, мал сүргийн бүтцийн өөрчлөлт болон малчид тодорхой нэг газарт төвлөрөх зэрэг, удаан жилийн турш хадгалагдаж ирсэн малын бэлчээрийн даацын цаг хугацаа, орон зайн хуваарийн системийн хурдацтай өөрчлөлт нь бэлчээрийн эко системд муугаар нөлөөлж байна. Ялангуяа мал сүргийн бүтцийн өөрчлөлтийн тухайд ноолуурыг нь авах зорилгоор өвсийг үртэй, үндэстэй нь иддэг ямааны тоо нэмэгдсэн нь бэлчээрийн даац хэтрэхэд хүргэж байна[16]. Зураг 2.10-д Монголын ургамлын биомассын хэмжээний өөрчлөлт (1982-1996 оныг 1997-2012 оныг

[14] Ж нь: Mersy Corp-ын мессеж ашиглан эрт анхааруулах систем нэвтрүүлэх, ШХА болон АХБ-ны ХАА-н бүтээгдэхүүнийг хадгалах агуулах барих.зэрэг
[15] Миаки Нао. 1995он. Монгол- нүүдэлчний ертөнц (3): Нүүдэлчин ахуйг дэмждэг ургамлын төрөл зүйл. мал аж ахуйн судалгаа **49**: 834-838.
[16] БОЯ, Монгол малчдын бэлчээрийн зохистой ашиглалт, менежмент

харьцуулсан)-ийг харуулсан ба тодорхой бүс нутгаас бусад газарт ургамлын биомассын хэмжээ багасах хандлагатай байгаа нь ойлгомжтой байна. Бэлчээрийн тогтвортой байдал (зохистой ашиглалт) нь, Монгол Улсын МАА-н үндэс болохоос гадна, "Тогтвортой байдал" нь өөрөө МАА-н бүтээгдэхүүнд нэмүү өртөг шингэж буй өнөөгийн нөхцөлд бэлчээрийн талхагдлын нөлөөллийг нь нэн даруй шийдвэл зохих томоохон асуудал болгож байна.



Зураг 2.10 1982-1996 оноос 1997-2012 он хүртэлх хугацааны дундаж биомассын өөрчлөлт
Эх сурвалж: Монголын эдийн засгийн судалгааны хүрээлэн, 2017, Бэлчээрийн доройтол ба малын татвар

(3) Уур амьсгалын өөрчлөлт

Бас, Монгол Улсын ирээдүйн ХАА-н төлөв байдлыг авч үзэхдээ уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөллийг харгалзан үзэх шаардлагатай. Хүснэгт 2.2-т үзүүлсэнчлэн,өнөөг хүртэл олон судлаач, Олон улсын байгууллагууд Монгол Улсын уур амьсгалын өөрчлөлтийн прогнозыг гаргасан бөгөөд, прогноз тус бүрийн агуулга нь өөр өөр ч ерөнхийдөө доорхи нөлөө үзүүлнэ гэж үзэж байгаа ба үүнийг харгалзсан сааруулах арга хэмжээ авах шаардлагатай.

- Агаарын хэм аажмаар нэмэгдэж, орох хур тундасны хэмжээ ч мөн нэмэгдэх боломжтой. ХАА-н үйлдвэрлэлийн хувьд ашигтай ажиллах боломж байж болох ч ууршилт бас нэмэгдэх тул ган гачиг үүсэх магадлал ч мөн нэмэгдэнэ. Сааруулах арга хэмжээ гэх юм бол тогтоол ус, цөөрөм байгуулах болон дуслын услалтын систем байгуулах зэрэг ус хэмнэх технологи ашиглах зэрэг байж болно. Бэлчээрт тохиромжгүй газар аажмаар нэмэгдсээр цөлжилт гүнзгийрнэ.
- Мөн өвлийн улиралд зуд болох магадлал ч аажмаар нэмэгдэнэ. Сааруулах арга гэвэл, зундаа хадлан сайн авах, нөөцлөх, малчдад зуд болох эрсдлийн тухай эртнээс сэрэмжлүүлж мэдээлэх систем нэвтрүүлж болох юм.

Хүснэгт 2.2 Монголын уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөллийн хэтийн таамаглал

	Уур амьсгалын өөрчлөлт	ХАА-дүзүүлэх нөлөөлөл
Батжаргал (2013)*	• Хуурай, халуун зун, цас ихтэй өвөл аль аль нь урт удаан хугацаагаар үргэлжлэх • Орох хур тундасны нэмэгдэх хэмжээнээс давж	• Бэлчээрт тохиромжгүй газар одоогийн 40%-иас 2050 он гэхэд 70%-д хүрнэ.

	ууршилт дэгдэлт явагдах • 2080 он хүртэл ган гачиг тохиолдох магадал 2 дахин нэмэгдэх	• Уур амьсгалын өөрчлөлтийн үр дүн нь МАА-н хөгжилд мэдэгдэхүйц саад учруулах ба түүний хохирол нь ирэх 80 жилд маш их нэмэгдэнэ.
ЖАЙКА (2021)**	• Ган болох магадлалтай жилийн нөлөө нь өмнөд, төв болон зүүн бүсийн нутагт өргөжинө. • Уур амьсгалын өөрчлөлтийн улмаас агаарын хэм нэмэгдэж, 2100 оны орчим Монголын нийт нутгаар цасны хэмжээ буурч, хавар зундаа цасны хайлалт багасах эрсдэлтэй. • Зуд болох магадлалтай жилийн тоо цөөрөх ч говь цөлтэй Өмнө, Төв,Зүүн бүсэд зудын эрсдэл арилахгүй • УБ, Алтай, Сайншандад зуны улиралд сарын хамгийн их тундасны хэмжээ нэмэгдэж, үерийн эрсдэл ихсэнэ.	
Дэлхийн эдийн засгийн, уур амьсгалд тэсвэртэй хөгжлийн хөтөлбөр (2023)***	• 21-р зууны эцэс гэхэд агаарын хэм 1.5-5.5℃ -ээр нэмэгдэнэ. Энэ нэмэгдэлт ньдэлхийн дунджаас их. • 21-р зууны эцэс гэхэд орох хур тундасны хэмжээ 8~14%-р нэмэгдэнэ. Мөн цас ч гэсэн 50-75%-р нэмэгдэнэ.Хэдийгээрощ орох хур тундасны хэмжээ нэмэгдэх ч дулаарлын улмаас ууршилт дэгдэлт ч нэмэгдэнэ. • Ган зуд тохиох магадлал нэмэгдэнэ.Зуд болох магадлал 21-рзууны эцэс гэхэд 40%-р нэмэгдэнэ.	• Агаарын хэм нэмэгдэх нь ХАА-д эерэгээр нөлөөлж магадгүй. • Гэвч хэрэглэх усны хэмжээ багасч хөрсний үржим шим буурч бэлчээрийн бүтээмж (даац) муудан,цөлжилт ихсэх зэргээр нийтдээ бол сөрөг нөлөөлөл гарах магадлал өндөр гэж таамагласан байна

Фүжита Нобору , Като Сатошиши, Кусано Эичи, Рёосүкэ Кода (2013), Монголын бэлчээрийн экосистемийн сүлжээний сүйрэл ба сэргэлт, ** ЖАЙКА (2021), Монгол Улсын Үндэсний хөгжлийн цогц төлөвлөгөө боловсруулах төслийн төгсгөлийн тайлан、*** Дэлхийн эдийн засгийн, уур амьсгалд тэсвэртэй хөгжлийн хөтөлбөр (CRED) (2023), Монгол Улсын уур амьсгалын өөрчлөлт, дасан зохицох нөлөөллийн эдийн засагт үзүүлэх нөлөө

2.1.5 Хөгжлийн төлөвлөгөө, хуулийн тогтолцоо

(1) Холбогдох хөгжлийн төлөвлөгөө

Монгол Улсад урт хугацааны хөгжлийн төлөвлөгөө гэвэл “Алсын хараа-2050” бодлогын баримт бичиг бий бөгөөд, энэ төлөвлөгөөнд үндэслэсэн дунд хугацааны төлөвлөгөө болох “5 жилийн хөгжлийн үндсэн чиглэл ” болон “Засгийн газрын мөрийн хөтөлбөр” 5 жил тутамд боловсруулагддаг. Харин сүүлийн жилүүдэд үүнээс өөр арга хэмжээ гэвэл “Хүнсний хангамж, аюулгүй байдал хангах талаар авах зарим арга хэмжээний тухай” нэртэй УИХ-ын 36 дугаар тогтоол батлагдсан бөгөөд. ХАА-н салбарын тогтолцоог шинэчлэх бодлогыг хэрэгжүүлэх зорилгоор хяналтын тогтолцоо болон ГТ, МАА түүнчлэн хүнс боловсруулах талаар хөгжлийн чиглэл болон хүрэх зорилтыг тусгасан байна (Хүснэгт 2.3). Энэ тогтоолоор ялангуяа хүнсний аюулгүй байдал-эрүүл ахуйн хяналт, удирдлагын тогтолцоог сайжруулахад чиглэсэн заалт олон байгаагаараа онцлогтой, ард түмний хүнсний талаархи эргэлзээг арилгах арга хэмжээ болгож цаашилбал эх орны үйлдвэрийн хүнсний бүтээгдэхүүний экспортыг дэмжих бодлогын хувьд чухал ач холбогдолтой болох нь харагдаж байна. МХЕГ-ыг татан буулгах зэргээр Монголын Улсын Засгийн газар хүнсний аюулгүй байдал, эрүүл ахуйн хяналтын талаар бүтцийн өөрчлөлтийг шуурхай хийж буйн зэрэгцээ хүнсний аюулгүй байдлыг хангах, цаашилбал хүнсний бүтээгдэхүүний экспортыг нэмэгдүүлэхэд чиглэсэн тодорхой бодлого, цаашид хэрэгжүүлэх холбогдох арга хэмжээний хяналт-мониторингийн тогтолцоо бүрдээгүй байгаа нь энэхүү Мастер төлөвлөгөөний агуулга зорилттой ч гүн гүнзгий холбоотой асуудал болж байна.

Хүснэгт 2.3 УИХ-ын 36 дугаар тогтоолын товч агуулга

Зүйл	Товч агуулга
1)Хууль,эрх зүйн орчин бүрдүүлэх	①Импортын хамаарлыг сааруулах, экспортыг дэмжихэд чиглэсэн хууль журам боловсруулах, **②Хүнсний аюулгүй байдлын хяналтын талаархи бүх төрлийн тогтолцоо (хүнсний стандарт, мөшгих тогтолцоог ашиглах)** бусад, ③Хүнс, ХАА, хөнгөн үйлдвэрийн салбарт олгох татаас, урамшууллын тогтолцоог бэхжүүлэх зэрэг заалт оржээ.
2)Хэрэгжүүлэх хяналтын тогтолцоо	**①МАА, ГТ, хүнсний үйлдвэрлэл, хадгалалт, тээвэр, борлуулалт, нийтийн хоол, үйлчилгээний салбарын стандарт, технологийн горимыг хатуу мөрдөх, ②Хүнсний аюулгүй байдалтай холбоотой байгууллагын бүтцийн өөрчлөлт болон удирдлага, аудитын системийг бэхжүүлэх,** ③ХАА-н салбарын их дээд сургууль, МСҮТ-ийн сургалтын чанарыг дээшлүүлэх, мэргэжилтэй хүний нөөцийг сургах, их дээд сургууль, судалгааны байгууллагад захиалга өгч судалгаа шинжилгээ хийлгэх төсвийг нэмэгдүүлэхээр заажээ.
3)Газар тариалан	①Тариалангийн талбайг өргөтгөх、②Үрээр хангах төв байгуулах、③Тэжээлийн ургамлын үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, ④Хүлэмжийн аж ахуйг нэмэгдүүлэх, ⑤Дотоодод бордоо үйлдвэрлэх бааз байгуулах чиглэлээр судалгаа хийж эхлэх, ⑥Нөөцийн агуулах байгуулахыг дэмжих, ⑦Нийлүүлэлтийн сүлжээнд оролцогчдын үйл ажиллагааг дэмжих зорилгоор кластер хөгжүүлэлт (агропарк байна гэж төсөөлж байгаа), ⑧"Тэрбум мод тарих" хөдөлгөөн зэрэг зүйлүүд тусгагдсан байна.
4)Мал аж ахуй	①Бэлчээрийн газрын даацад тохирсон тооны мал, төрлийн зохистой харьцааг зохицуулах, 1 малаас авах ашиг шимийг нэмэгдүүлэх, ②Загвар хоршоо байгуулах бүтцийн дэмжлэг үзүүлэх, ③Эрчимжсэн МАА, зөгийн аж ахуйг дэмжих, **④ Мал эмнэлэгийн лабораторийн үйлчилгээг бэхжүүлэх зэрэг** заалт оржээ.
5)Хүнсний боловсруулалт, үйлдвэрлэл	①Дотоодоос олдох түүхий эдийг дотооддоо боловсруулахыг дэмжих, тослогийг нь ялгасан хуурай сүү боловсруулах үйлдвэр байгуулахад зориулж төсвийн дэмжлэг үзүүлэх тогтолцоо бүрдүүлэх, ②Хүнсний сав баглаа боодлыг дотооддоо үйлдвэрлэхийг дэмжих, ③Функциональ хүнстэй холбоотой системийн бүтэц, **④Хүнсний аюулгүй байдлын нормыг шинэчлэх, Хорио цээрийн хяналтын цэг, хүнсний лабораторийг бэхжүүлэх, ⑤Хоол хүнсний зохистой хэрэглээний талаар сургалт сурталчилгаа, ухуулан таниулах үйл ажиллагаа хэрэгжүүлэхээр заасан.**

Эх сурвалж: УИХ-ын 36-р тогтоолд үндэслэн ЖАЙКА төслийн баг боловсруулав.

(2) Шинээр батлагдсан, шинэчлэгдсэн хуулийн тогтолцоо

Энэхүү Мастер төлөвлөгөөг боловсруулахдаа, ирээдүйд ХАА-н салбарт үзүүлэх нөлөөлөл их гэж үзсэн хуулийн тогтолцоог шинэчлэх саналын талаар доор сийрүүлэв (Хүснэгт 2.4). Ургамлын үрийн тухай хууль 1999 онд батлагдснаас хойш, бараг 20 жил өнгөрсний хойно шинэчлэгдэж, ургамлын үрийн сортыг хамгаалахтай холбоотой журмыг шинээр гаргасан. Энэхүү шинэчлэлд дөрөөлж, Монгол Улс нь ургамлын шинэ сортыг хамгаалах олон улсын холбоонд (International Union for the Protection of New Varieties of Plants: UPOV) элсэх хүсэлтээ гаргаад байгаа[17]. Мөн, үрийн арилжаа, экспорт импорттой холбоотой журмыг нэмж оруулсны үр дүнд, Монголын засгийн газар улсын хувиар хүнсний ногооны импортын үрэнд зориулж татаас өгөх тогтолцоо буй болгох зорилгоор хуулийн үндэслэл, дэмжлэг зохион байгуулж, 2022 оноос бодитоор хүнсний ногооны үрэнд татаас олгож эхлээд байна. Хоршооны тухай хууль ч мөн 1998 онд хэрэгжиж эхэлснээс хойш анх удаа нэмэлт өөрчлөлт орж, хоршооны эрх өргөжиж, банкнаас зээл авах хууль ёсны статустай болсон. Малын тоо толгойн татварын хууль 2020 оноос шинээр хэрэгжиж эхэлсэн бөгөөд, малын тоо толгойд тогтоосон тарифаар татвар төлөхийг хуульчилж, жил бүр нэмэгдсээр байгаа малын тоо толгойг сааруулахөд нөлөө үзүүлэх болов уу гэсэн хүлээлттэй байна. Эдгээр хуулиудын нэмэлт өөрчлөлт, шинээр гарч байгаа хууль тогтоомж нь Монголын ХАА-н салбарын тариаланчид малчдын хувьд ямар өөрчлөлт боломж гарч байгааг Мастер

[17] https://www.upov.int/export/sites/upov/members/en/pdf/status.pdf

төлөвлөгөө боловсруулахад онцгойлон анхаарах ёстой асуудал гэж үзэж байна.

Хүснэгт 2.4 Сүүлийн жилүүдэд гаргасан/шинэчилсэн хууль тогтоомжууд

Нэрс	Агуулга
Таримлын үрийн тухай хууль	2021 оны 10 сарын 29-нд шинэчлэгдсэн. Таримлын үрийн арилжаа, үрийн экспорт, импортоос гадна ургамлын сортыг хамгаалахад чиглэсэн журмыг шинээр гаргаж, үүний үр дүнд ургамлын сорт үржүүлэгч, бойжуулагчийн эрхийг баталгаажуулсан.
Хоршооны хууль	2021 оны 5сарын 6-нд шинэчилсэн. Хоршооны эрхийг өргөтгөж, хуулийн хүрээнд хөдлөх болон үл хөдлөх хөрөнгө эзэмших,ашиглах, удирдах, захиран зарцуулах, шилжүүлэх, түрээслэх, зээлдүүлэх эрхтэй болсон. Мөн хоршооны үйл ажиллагаанд сөрөг нөлөөгүй бол иргэн, хуулийн этгээдээс зээл, хандив авах боломжтой болсон.Түүнчлэн хоршоо хөгжүүлэх сан байгуулж, ЖДҮГ уг санг удирдах болсон байна.
Малын татварын хууль	2020 оны 11 сарын 13-ны өдөр батлагдсан. Монголын нутагт байгаа малын тоо толгойд татвар ноогдуулахыг журамласан хууль. Жилд 1 толгой малд ноогдох татвар нь 0-2,000 төгрөг байх ба татварын хэмжээг сумын ИТХ тогтооно. Мөн хураасан татварын орлогын зарцуулалтыг сумын ИТХ-ын шийдвэрээр зарцуулах ба хуулиар тогтоосон нь (Сайн үүлдрийн мал нутагшуулах, малчдын үйл ажиллагаанд тус дэмтэй зүйлд зарцуулах г.м) хязгаарлагдмал зарцуулалттай байна.

Эх сурвалж: https://legalinfo.mn/mn-ий мэдээлэлд үндэслэн ЖАЙКА төслийн баг боловсруулав.

2.2 Монгол Улсын ХАА-н салбарын ерөнхий төлөв ба бүс нутгийн онцлог

2.2.1 Газар тариалан

Газар тариалангийн хувьд, социализмын үеэс далайцтайгаар хөгжүүлж, үйлдвэрлэлийн хэмжээг өсгөн, 1980-аад онд гадаадад газар тариалангийн бүтээгдэхүүн экспортлох хэмжээнд хүрсэн байв[18]. Тариалалт хийх талбайн хэмжээ, оргил үеийн 1989 онд 837,868 га байсан боловч 2010 он гэхэд 316,388 га болж огцом буурч байв. Гэвч сүүлийн үед, тариалангийн талбайн хэмжээ аажмаар нэмэгдэж, 2022 онд 621,622 га болж нэмэгдэх хандлагатай байна. Монгол Улс зах зээлийн эдийн засагт шилжсэнээс хойш газар тариалангийн салбар ингэж ихээхэн хэмжээгээр уналтад орсон хэдий ч, сүүлийн үед хэрэгжүүлсэн “Атрын 3 дугаар аян”-ы (Third Crop Rehabilitation Campaing) үр дүнд сэргэлт гарч, төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгийн үеийн хэмжээнд ойртож байна[19].

Зураг 2.11-д 2022 оны байдлаар тариалсан нийт талбайн орон зайн тархалтыг харуулав. Тариалангийн талбайн ихэнх хэсэг нь монгол улсын хойт хэсэг төвлөрсөн байгаагийн гол шалтгааны нэг нь цаг уурын нөхцөл байдал юм. Монгол Улсын төвийн бүсийн хойд хэсгийн нутагт хур тундасны хэмжээ харьцангуй ахиу, жилийн дундаж агаарын температур дунд хавьд байдаг. Тухайлбал Сэлэнгэ аймагт жилийн дундаж хур тундасны хэмжээ 284 мм, агаарын температур 1 сард -22.6°C, 7 сард 20.1°C байдаг. Гэтэл төвийн бүсийн өмнөд хэсгээр агаарын температур харьцангуй өндөр боловч хур тундас бага тул байгалийн усалгаатай газар тариалан эрхлэхэд хүндрэлтэй.

[18] “Монголын газар тариалангийн хөгжлийн түүх” Юки Конагаяа, 2010, Үндэсний түүхийн музейн судалгааны тайлан.(1) : 9– 138
[19] Омияа Ямахиро (2016) Зүүн хойд Азийн хуурай бүс нутгийн хөдөө аж ахуй -Монгол улсын жишээн дээр-, Олон улсын бүс нутгийн хөгжлийн шинэ өрнөл, Цүкүба шёбо, 55-69



Зураг 2.11 Тариалсан талбайн орон зайн тархалт (2022 он)
Эх сурвалж: https://www.1212.mn/mn-ийг үндэслэн ЖАЙКА төслийн баг боловсруулав.

Зураг 2.12-т ургамлын тариалангийн талбайн орон зайн тархалтыг харуулав. Улаанбуудай бол хамгийн том триалангийн талбай эзэлдэг үндсэндээ монгол улсын төвийн бүсийн хойд хэсэгт төвлөрсөн байна. Энэ бүс нутагт газар тариалангийн ААН-үүд их хэмжээний үйлдвэрлэл явуулах бөгөөд газар триалангийн үйл ажиллагаа нь бараг бүхэлдээ механикжсан байдаг.

Зурагт харуулаагүй боловч сэлгэн тариалалтад орж байгаа хар рапс зэрэг бусад ургамал улаан буудайн адилаар тархах хандлагатай байна. Жимсний хувьд жимсгэний төрлийн тариалалт харьцангуй их бөгөөд энэ дотроо чацаргана нийт жимсний үйлдвэрлэлийн 90%-ийг эзэлж байна. Чацарганыг газар тариалангийн бүсэд ихээхэн тариалж байгаа боловч Монгол орны баруун бүсэд, ялангуяа Увс аймагт өргөн хэмжээний үйлдвэрлэл явагддаг бөгөөд 2022 онд Германы Худалдаа аж үйлдвэрийн танхимын дэмжлэгээр “Увсын чацаргана” газар зүйн заалтыг Европын Холбоонд бүртгүүлж гэрчилгээ авсан[20]. Төмс, хүнсний ногооны хувьд мөн л төвийн бүсийн хойд хэсэгт тариалангийн талбай ихээхэн тархасан байдалтай харагдах боловч бусад бүс нутагт ч хэмжээ нь арай бага боловч тариалж байгаагаараа улаан буудай ба жимснээс ялгаатай юм. Зурагт харуулаагүй боловч тэжээлийн ургамлын тариалангийн тархалтын байдал мөн дээрхийн нэгэн адил харагдах бөгөөд эдгээр бүтээгдхүүнийг төвийн бүсийн хойд хэсгийн том үйлдвэрлэгчдээс гадна өрхийн хэрэгцээнд хэрэглэж, нэг хэсгийг нь ойр хавийн зах зээлд борлуулдаг жижиг аж ахуйнууд тариалдаг байна.



Зураг 2.12 Гол нэр төрлийн бүтээгдэхүүний тариалангийн талбайн байршил (2022)
Эх сурвалж: https://www.1212.mn/mn-ийг үндэслэн ЖАЙКА төслийн баг боловсруулав.

Монгол Улс бол нүүдлийн аж ахуйн суурин дээр эдийн засаг, нийгмийн тогтолцоог

[20] https://www.mongolchamber.mn/a/858

бүрдүүлж ирсэн орон. Тиймээс уламжлалт хоол хүнс нь мал аж ахуйн гаралтай мах, сүү, цагаан идээ байсаар ирсэн. Социализмын үед газар хагалж тариалан эрхлэх болсноор улаанбуудайн хэрэглээ өргөжиж, хүнсний гол нэрийн бүтээгдэхүүн болсон. Мөн мах, цагаан идээ, улаан буудайн хэрэглээний түвшин ч өмнөхөөс нэмэгдэх хандлагатай болсон (Хүснэгт 2.5). Хожим зах зээлийн эдийн засгийн тогтолцоонд шилжсэнээр хоол хүнсний хэрэглээнд өөрчлөлт гарч, сүүлийн үед төмс, хүнсний ногооны хэрэглээ нэмэгдсээр байгаа. Ялангуяа хотын оршин суугчдын хэрэглээг хөдөөгийнхтэй харьцуулахад хүнсний ногоо 50%-иар их байна. Нөгөө талаар хотынхны хувьд мах, цагаан идээний хэрэглээ нь хөдөөгийнхнөөс мах 30%, цагаан идээ 50%-иар бага гэх мэтчилэн хот хөдөөгийн хүн амын хооронд хоол хүнсний хэрэглээний ялгаа мэдэгдэхүйц болж ирж байна[21].

Хүснэгт 2.5 Нэг хүнд ногдох жилийн хүнсний хэрэглээний хэмжээ, бүтээгдэхүүн тус бүрээр (2013-2022 он)

Commodities	Consumption Rate (kg/person/year)									
	2013	2014	2015	2016	2017	2018	2019	2020	2021	2022
Flour& bakery	121.2	127.2	126.0	122.4	122.4	121.2	121.2	123.6	115.2	110.4
Rice	21.6	22.8	21.6	21.6	21.6	21.6	22.8	22.8	21.6	22.8
Sugar	16.8	15.6	9.6	8.4	9.6	13.2	13.2	14.4	12.0	10.8
Potato	38.4	36.0	33.6	33.6	32.4	31.2	31.2	32.4	28.8	31.2
Vegetables	24.0	25.2	24.0	22.8	22.8	22.8	25.2	26.4	25.2	25.2
Fruits	8.4	9.6	8.4	7.2	7.2	7.2	7.2	7.2	6.0	7.2
Vegetable oil	6.0	6.0	6.0	6.0	6.0	4.8	6.0	6.0	4.8	4.8

Эх сурвалж: NSO Mongolian Statistical Yearbook 2022-т үндэслэн, ЖАЙКА төслийн баг боловсруулав.

2.2.2 Мал аж ахуй

Японоос 4 дахин уудам газар нутагтай, түүний бараг 80% нь байгалийн бэлчээр гэгддэг Монголд бэлчээр нутгаа байгалийн баялагт тооцон ашиглаж үр шимийг нь хүртдэг нүүдлийн мал аж ахуйн соёл хэдэн мянган жилийн туршид бүрэлдэн хөгжиж иржээ. Монгол Улс нь Үндсэн хуулиндаа өнөөдрийг хүртэл "мал сүрэг нь ард түмний баялаг бөгөөд төрийн хамгаалалтанд байна" хэмээн заасан, мөн бэлчээр хувьчлахыг зөвшөөрдөггүй ихээхэн онцлог бүхий орон. Монгол Улсын МАА-н үйлдвэрлэлийн гол үндэс нь нүүдлийн МАА-н хэв маягт зохицуулан сүргийн бүтцээр хариулан малладаг адуу, үхэр, хонь, ямаа, тэмээ гэсэн 5 төрлийн мал бөгөөд уламжлалт нэршлээр Монголын таван хошуу мал хэмээн нэрлэдэг[22]. Мал аж ахуйн гол бүтээгдэхүүн мах, сүү, ноос (ноос, ноолуур г.м.) болон арьс шир нь үндсэндээ энд өгүүлж буй 5 хошуу малаас гардаг бүтээгдэхүүн юм. Түүний дотор, ялангуяа мах, сүү нь улсын эдийн засагт чухал нөлөөтэй, ард түмний хоол хүнсний хэрэгцээний амин чухал бүтээгдэхүүн бөгөөд мах сүүний хэрэглээний хэмжээгээр ч Азийн бүс нутагтаа ихээхэн ялгаатай. Хүснэгт 2.6-д үзүүлсэнчлэн, эдгээр бүтээгдэхүүний өдөр тутмын хэрэглээний хэмжээ өндөр, Азийн бүс нутгийн дундаж үзүүлэлттэй харьцуулахад махны хэрэглээ 2 дахин, цагаан идээний хэрэглээ бараг 3 дахин их байдаг. Хөгжиж буй улс орнуудад, орлого өсөхийн хирээр сүүн бүтээгдэхүүн, махны хэрэглээ нэмэгдэх хандлага байдаг. Харин

[21] NSO Mongolian Statistical Yearbook 2019, p129

[22] Монголд энэ 5 төрлийн малаа гол мал сүрэг хэмээн тооцон адуулж хариулж ирсэн бөгөөд статистикийн материалд ч төрлөөр нь ялгахгүйгээр мал сүргийн нийт тоог дурдсан байх нь цөөнгүй бий. Гэхдээ мал тус бүрийн хувьд шаардагдах өвс тэжээлийн хэмжээ харилцан адилгүй байдгаас үндэслэн, бусад малыг хониор төлөөлүүлэн тооцох "хонин толгойд шилжүүлсэн тоо" гэдэг нэр томьёог хэрэглэх нь бий. "Хонин толгойд шилжүүлсэн тоо"-гоор ойролцоогоор 1 адуу=7 хонь, 1 үхэр =6 хонь, 1 ямаа =0.9 хонь, 1 тэмээ = 5 хонь хэмээн үздэг.

Монголд энэ хандлага ажиглагдахгүй байгаа бөгөөд үүнийг судлаачид угаас мал аж ахуйн бүтээгдэхүүний хэрэглээ өндөр байсантай холбон тайлбарлах нь бий[23]. Мөн дээр дурьдсанчлан өндөр орлогтой чинээлэг давхаргынхан оршин суудаг хот суурин газарын мах болон сүүний хэрэглээ хөдөө орон нутгаас бага байдаг[24].

Хүснэгт 2.6 Азийн бүс нутаг дахь мах, сүүн бүтээгдэхүүний хэрэглээ (грамм/өдөр/хүн)

Нэр төрөл	Монгол	Азийн бүс нутаг	Япон	Хятад	Өмнөд Солонгос
Махан бүтээгдэхүүн	190	80	130	150	150
Сүүн бүтээгдэхүүн	400	140	210	80	70

Эх сурвалж: Нишино, Кусано (2013 он)[25]

Социализм задарснаас хойш өнөөг хүртэл Монголын мал сүргийн тоо тэсрэлтийн байдалтай өсч, өнгөрсөн (2022) оны байдлаар түүхэнд анх удаа 70 гаруй сая толгойд хүрлээ. Энэ явцыг, бодит өсөлтийн хувиар үзүүлбэл, өнгөрсөн 30 жилийн хугацаанд жил тутмын дундаж өсөлтийн үзүүлэлт 4.2% болж байна. Энэ 30 жилийн дэлхийн дундаж үзүүлэлт 0.7% байгаа юм. Цаашилбал социализмын үед малын тоо толгойн жилийн дундаж өсөлт 0.5% байсныг харсан ч, сүүлийн үед ямар богино хугацаанд малын тоо хэрхэн өссөн нь тодорхой байна[26]. Нөгөө талаар малын өсөлтийн энэ хандлага Монголын 5 хошуу малын бүх төрөлд харилцан адилгүй байгаа юм. Хонь, ямааны тоо толгой мэдэгдхүйц өсөн нэмэгдэж, ялангуяа ямаа эрс олширчээ. Социализмын үед ч, монголын нүүдлийн мал аж ахуйн эртнээс тогтсон уламжлалаар ч таван хошуу мал, тухайлбал адуу үхэр, хонь ямаа, тэмээний тоо, толгойн харьцаа 1:1:7:3:0.5-ийн хэмжээнд явж ирсэн бөгөөд мал сүргийн хариулга маллагааны зохион байгуулалтад энэ харьцааг хамгийн зохистой бүтэцэд тооцож иржээ[27]. Гэтэл энэ тэнцвэрт харьцаа ихээхэн хэмжээгээр алдагдахад хүрээд байгаа. Ийм байдалд хүрсэний гол шалтгаан ноолууртай холбоотой. Ноолуур бол хүйтэн бүсэд маллан хариулдаг ноолуурын ямаанаас самнаж авдаг түүхий эд. Өмсөж эдлэхэд биед нэн тааламжтай, бас дулаан барих чанар онцгой сайн учраас тансаг зэргийн материалд тооцогддог, бүтээгдэхүүн нь эрэлт ихтэй. Монгол Улс бол Хятадтай эн зэрэгцэн дэлхийд цөөнд орох түүхий ноолуур бэлтгэдэг улс бөгөөд малчдын хувьд мөнгөн орлого олох хамгийн гол эх үүсвэр нь ноолуур болдог. Мөн улс орны хувьд ч хөдөө аж ахуйн салбарын экспортын гол бүтээгдэхүүн бол ноолуур. Ийм утгаар ноолуурын үнэ дотоодын зах зээлээс биш харин олон улсын зах зээлийн нөлөөнөөс ихээхэн хамаардаг, үйлдвэрлэгчдийн үнэ ч олон улсын зах зээлийн нөлөөнд байдаг гэж хэлж болно.

Мөн таван хошуу малын дотор тэмээн сүргийн тоо толгой дангаараа буурсаар ирснийг, уламжлалт нүүдлийн мал аж ахуйд шинэчлэлийн давалгаа түрэн орж байгааг харуулах баримт гэж үзэж болно. Тэмээ нь сүүг нь сааж ашигладаг, ноос нь ч ховор нандин эдэд тооцогддог, махыг нь ч хүнсэнд хэрэглэдэг, малчдын хувьд хамгийн гол нь ердийн хөсгийн зориулалтаар ашигладаг,

[23] Нишино Изүрү, Кусано Эйичи, 2013, Тавдугаар бүлэг. Зах зээлийн эдийн засгийн үеийн мал аж ахуй, Фүжита Нобору, Като Сатоши, Кусано Эйичи, Сада Рёокай (эмхэтгэл) Монголын тал нутгийн экологийн системийн эвдрэл болон нөхөн сэргээлт. Киото их сургуулийн эрдэм шинжилгээний хэвлэлийн зөвлөл
[24] Нишино Изүрү, Кусано Эйичи, 2013, өмнөх зохиол
[25] Нишино Изүрү, Кусано Эйичи, 2013, өмнөх зохиол
[26] FATOSTAT болон Mongolian Statistical Yearbook--ийн материалд тулгуурлан тооцоолов.
[27] Ялангуяа хонь болон ямааны тоо толгойн харьцааг хамгийн чухалд тооцдог. Эдгээр бог мал нь адуу, үхэр, тэмээ зэрэг бод малтай харьцуулахад хүйтэнд тэсвэр муутай, тиймээс ноос нь хүйтнээс хамгаалах өндөр чанартай хонин сүргийн дотор, хонины тооны тал хувь, түүнээс цөөн тоонд багтах ямаатай байх нь өвлийн улирлыг давах хамгийн зөв арга гэж үзэж иржээ. (Humphrey, C. 1978. Op.cit.).

амьдардаг орон гэрээсээ эхлээд тавилга хэрэгслээ бүгдийг нь ачиж зөөх "тээврийн хэрэгсэл"-ийн үүрэг гүйцэтгэж ирсэн байдаг. Гэвч сүүлийн үед, малчин өрхийн дотор автомашинтай айлын тоо олширч[28], тэр хэрээр тэмээн сүрэг хариулж маллах хэрэгцээ шаардлага буурсаар байгаа юм[29].

Нөгөө талаар, тэмээнээс бусад малын тоо толгой төрөл тус бүрээр өссөөр ирсэн нь, нэг талаар мал сүргийн өөрийнх нь үржлийн физиологийн процессоор явагдсан үзэгдэл хэдий ч ерөнхийдөө эрчимжүүлсэн мал аж ахуйн хувьд, менежментийн ойлголтын үүднээс малын байгалийнх нь үржилд даатгах аргаар үйлдвэрлэл явуулах төлөвлөгөө байх боломжгүй. Учир нь тэжээл бордооны үнэ нэмэгдэхээс эхлээд хашаа хороо бэлтгэх гэх зэргээр аж ахуйн цар хэмжээ нэмэгдэхэд түүнийг дагалдан зардлын асуудал гардагтай холбоотой. Энэ талаас нь аваад үзсэн ч, Монголд малын тоо толгой тэсрэлтийн байдалтай өссөний цаад талд, эрчимжсэн мал аж ахуйд бол зардлын ихэнх хувийг эзэлдэг тэжээл, хашаа байр бэлтгэх хөрөнгө зардал бараг шаардагдахгүй гэдэг бодит нөхцөл оршдог юм. Монголын нүүдлийн мал аж ахуй нь улсын нутаг дэвсгэрт хаа сайгүй цэлийн үргэлжлэх байгалийн бэлчээрийн баялагтаа түшиглэж байдаг юм. Малын бэлчээрийн тухайд хатуу ширүүн цаг уурын нөхцлөөс шалтгаалж газар тариалан эрхлэх боломжоор маш хязгаарлагдмал, харин энэ талаараа бол мал сүрэг бэлчээрлүүлэхэд ёстой л диваажингийн орон болж байдаг бөгөөд түүний дээр ингэж мал сүргээ адуулан нүүдэллэсний хүчээр тал нутаг нь тал нутаг хэвээрээ үлдэж чадсанд хамгийн гол учир байгаа юм. Эндээс мал бэлчээр хоёр үнэхээрийн бие биеэ харилцан нөхөх шүтэлцээтэй гэж хэлж бүрэн болно[30]. Гэхдээ л хэчнээн уудам байлаа ч тал нутагт хэмжээ хязгаар гэж байх агаад нэгж талбай тутамд ногдох малын тоо толгой хэт олширвол бэлчээрийн даац хэтэрч, бэлчээр нутаг сүйрэх эхлэл болдог аж. Хэрэг дээрээ ийм уршигт байдал Монголын тал нутагт ч олон газарт нэгэнт эхлээд байгаа бөгөөд сүүлийн жилүүдэд малын тоо толгойн огцом өсөлтөөс үүссэн хамгийн ноцтой асуудал гэж болно[31].

Гэвч бэлчээрийн доройтлын асуудал Монгол Улсын бүх нутаг дэвсгэрийг хамарсан ноцтой хэмжээнд хүрээгүй байна. Малын тоо толгойн нягтрал ихтэй бүс нутагт энэ асуудал даамжрах хандлага бий. Зураг 2.13-т таван хошуу малын нийт тоо, мал сүргийн төрөл тус бүрийн тархалтын байдлыг харуулсан бөгөөд улсын нутаг дэвсгэрийн төв хэсэг, түүнчлэн хойд бүс нутагт малын тоо толгойн нягтрал хамгийн их байгаа бөгөөд энэ бүс нутгаар төвлөн улмаар баруун зүүн, өмнө тийш холдох тусам малын тоо толгойн нягтрал сийрэгжих байдал ажиглагдаж байна. Үүний шалтгаан нь ургамлын чанар сайны зэрэгцээ газрын гарц ч сайн[32], түүнээс гадна Улаанбаатар хотыг оролцуулаад төвийн бүс нутгийн томоохон зах зээлд харьцангуй ойр байгаад оршино[33].

[28] Сүүлийн үед энэ хандлага улам нэмэгдэж байгаа. Автомашинтай малчин өрхийн тоо 2010 оны байдлаар 27.8% байсан бол 2019 онд энэ тоо 51.2% болж нэмэгдсэн байна. (Mongolian Statistical Yearbook, 2019).
[29] Janzen, J. 2005. Mobile livestock keeping in Mongolia: Present problems, spatial organization, interactions between mobile and sedentary population groups and perspectives for pastoral development. *Senri Ethnological Studies* **69**: 69-97.
[30] Humphrey, C. and Sneath, D. 1999. The end of nomadism? : Society, state and the environment in Inner Asia. Duke University Press, Durham, NC.; Loreau, M. 1995. Consumers as maximizers of matter and energy flow in ecosystems. *American Naturalist* **145**: 22-42.
[31] Малын тоо толгойн ихсэхийн зэрэгцээ уур амьсгалын өөрчлөлт, цөлжилт, үлийн цагаан оготно, хотжилт, газар тариалан, хүнд даацын автомашины хөдөлгөөн, уул уурхай гэх зэрэг бэлчээрийн сүйрэлд нөлөөлж буй олон янзын хүчин зүйлс дурдагддаг. (JICA. 2016 он. Өмнө дурдсан судалгаа)
[32] Миаки Такэши, 1995b, Монгол- бэлчээрийн мал аж ахуйн ертөнц (4): Нүүдлийн мал аж ахуйг тэтгэх олон янзын ургамал. Мал аж ахуйн салбарын судалгаа 49: 934-940
[33] JICA. 2016 он, өмнө өгүүлсэн судалгаа



Зураг 2.13 Малын тоо толгойн орон зайн тархалтын байдал (2022 он)

Эх сурвалж: https://www.1212.mn/mn-ийг үндэслэн ЖАЙКА төслийн баг боловсруулав.

Таван хошуу мал тус бүрээр авч үзвэл, адуу, үхэр болон хонины тархалтын байдал ерөнхийдөө жигд байгаа бол ямаа болон тэмээний хувьд байршлын налуу эсрэг чиглэлтэй, төвөөс холдох тусам тоо нь олширч байна. Ялангуяа тэмээний хувьд энэ хандлага илэрхий харагдана (Зураг 2.14). Эндээс Монголын байгалийн бүс бүслүүрийн онцлог, ямаа болон тэмээний бусад малаас ялгарах онцлогийг олж харж болохоор байна. Монголын орны төвийн бүсийн хойд хэсэг бол өндөрлөг хээр хийгээд ууархаг бүс нутаг зонхилдог, мал сүрэг хариулж адуулахад тохирсон бэлчээр сайтай бол өмнөд хэсэг нь говь цөл гэгдэх хуурай бүс нутагтай залган оршдог. Энэхүү хуурай бүс нутаг нь газрын гарц багатайн зэрэгцээ усны хангамж тааруу, ерөнхийдөө мал бэлчээрлэхэд тохиромж муутай. Тийм ч учраас энд таван хошуу малын дунд өл даах чадвараар сайн, ямар ч усыг ууж чаддаг болохоор ямаа болон тэмээний[34] тоо толгой ахиу байдалтай байгаа юм.



Зураг 2.14 Таван хошуу малын орон зайн тархалтын байдал (2022 он)

Эх сурвалж: https://www.1212.mn/mn-ий мэдээлэлд үндэслэн ЖАЙКА төслийн баг боловсруулав.

[34] Mattiello, S. 2016. Husbandry practices, animal health In Non-bovine milk, and milk production. Tsakalidu, E. and Papadimitriou, K. (Eds.). Elsevier, UK.

2.2.3 ХАА-н салбарын аж ахуйн нэгжүүд

Зураг 2.15-д ХАА-н салбарын ААН-үүдийн орон зайн тархалтын байдлыг харуулав. Газар 2023 оны байдлаар нийт 11354 ААН үйл ажиллагаа явуулж байгаагийн 89% нь улаан буудай ба хүнсний ногоо тариалж байна. Эдгээрийн тархалт нь Монголын төвийн нутгийн хойд хэсэгт орших газар тариалангийн бүс нутгийн байршилтай үндсэндээ давхцаж байгаа юм. Үйлдвэрлэлийн салбарт 2023 оны байдлаар 16,559 ААН үйл ажиллагаа явуулж байгаагийн 33% нь хүнсний үйлдвэрлэл, 12% нь хувцас үйлдвэрлэл, 6% нь нэхмэл, 4% нь арьсан эдлэлийн үйлдвэрлэлийн салбарт үйл ажиллагаа явуулж байна[35]. Эдгээр ААН-үүд нь нийслэл Улаанбаатар хотын ойролцоо их хэмжээгээр тархсан байхаас гаднаа хүн амын нягтрал ихтэй аймгийн төвүүдэд бас олшрох хандлагатай байна. Ийм ААН-үүдийн байршил нь боловсруулах зорилгоор ХАА-н түүхий эдийг цуглуулдаг төв, ХАА-н бүтээгдхүүний нийлүүлэлтийн сүлжээний чухал бааз болж байна.



Зураг 2.15 ХАА-н салбарын ААН-үүдийн орон зайн тархалтын байдал(2023 он)
Эх сурвалж: https://www.1212.mn/mn-ий мэдээлэлд үндэслэн ЖАЙКА төслийн баг боловсруулав.

2.3 ХАА-н гол нэр төрлийн бүтээгдэхүүний нийлүүлэлтийн сүлжээг хөгжүүлэх чиглэл

2.3.1 Хүнсний ногоо

(1) Хүнсиий ногооны нийлүүлэлтийн сүлжээний өнөөгийн нөхцөл байдал

[35] ХАА болон үйлдвэрлэлийн салбарын ААН-үүдийн тоо нь бүртгэлтэй ААН-үүдийн тоо бөгөөд идэвхтэй үйл ажиллагаа явуулж буй ААН-үүдийн тооноос өөр болохыг анхаарна уу



Зураг 2.16 Монголын хүнсний ногооны нийлүүлэлтийн сүлжээ

Эх сурвалж: ЖАЙКА төслийн баг

Монголд өмнө үндсэндээ төмс, лууван, байцаа, манжин тарьдаг байсан бол саяхнаас сонгино, сармис, өргөст хэмж, улаан лооль, тарвас, навчит ногоо гэх мэтээр төрөл нь олширч, хүнсний ногооны тариалалт, хэрэглээ аль аль нь өсөх хандлагатай байна. Доорхи хүснэгтэд үзүүлсэнчлэн, 2022 оны ногооны үйлдвэрлэлийн хэмжээ ойролцоогоор 148,900 тонн, тариалангийн гол бүс нутаг нь Сэлэнгэ, Төв, Дархан-Уул зэрэг төвийн бүс бөгөөд улсын нийт хүнсний ногооны 60-с дээш хувийг үйлдвэрлэж байна[36] (Хүснэгт 2.7).

Хүснэгт 2.7 Гол нэр төрлийн ногооны үйлдвэрлэл (1,000 тонн)

Бүтээгдэхүүн	Мянган тонн									
	2013	2014	2015	2016	2017	2018	2019	2020	2021	2022
Хүнсний ногоо	101.8	104.8	72.3	94.4	82.1	100.7	99.5	121.2	121.7	148.9
байцаа	20.6	18.7	15.4	16.7	15.2	18.8	21.9	24.4	26.8	37.0
лууван	34.5	34.7	18.5	31.0	21.7	26.3	28.9	33.8	26.6	40.0
манжин	22.4	23.9	17.6	21.2	16.6	24.1	21.5	21.6	19.7	24.4
сонгино	9.3	9.4	6.7	10.0	12.1	14.1	9.5	11.4	20.4	17.3
сармис	1.0	1.0	0.7	0.7	0.4	0.5	0.8	1.4	1.5	1.6
өргөст хэмх	4.3	4.7	3.8	3.7	3.9	3.8	4.7	3.1	3.5	1.6
лооль	2.5	2.4	1.9	2.2	2.0	1.9	1.9	2.3	2.0	2.2
тарвас	5.4	6.3	6.5	7.2	8.8	9.6	9.1	10.2	10.5	8.6

Эх сурвалж: NSO Mongolian Statistical Yearbook-д үндэслэн ЖАЙКА төслийн баг боловсруулав.

Монголд үндсэндээ төмс, лууван, байцаа, манжин тарьдаг байсан бол саяхнаас түгээлт, боловсруулалтын тухайд ченж гэгдэх дундын борлуулагчид түгээлтийн шатанд хүч түрэн орж, Улаанбаатарын баруун, зүүн захад их гарын ченжүүд 1,000 тоннын багтаамжтай том агуулах барьж, дотоодод тарьсан болон импортын ногоог хадгалж байна. Сүүлийн үед, хөлдөөх болон хүйтэн тоноглолтой зоорь ч нэмэгдэж байна. Хүлэмжийн ногооны хувьд, үйлдвэрлэгчид шууд супер маркет, жижиглэнгийн худалдаачдад борлуулах, боловсруулах компанид зардаг гэрээт тариалалт

[36] Монгол Улсын Үндэсний Статистикийн Хороо, Статистикийн эмхэтгэл, 2021 он

гэх арилжааны шинэ хэлбэр ажиглагдаж байна. Харин задгай талбайн ногоочид нь ихэвчлэн ченжүүдэд зардаг. Ногооны хэрэглээний тухайд 1 хүний сарын хэрэглээ улсын дунджаар 2.1кг, хотод бол 2.5кг, хөдөөгийнхөн 1,5кг байна[37]. Хэрэглээ жилээс жилд нэмэгдэх хандлагатай байгаа ба дэлхийн дундажтай харьцуулахад илэрхий бага ч хот сууринд нэг хүнд ноогдох хэрэглээ өсөх хандлагатай байна.

(2) Хүнсний ногооны зах зээлийн орчин

Хүнсний ногооны зах зээлийн орчин нь үйлдвэрлэл, импортын аль аль нь Зураг 2.17-т харуулсанчлан өсөх хандлагатай байна. Ногооны дотоодын хангамж нь уур амьсгалын байдлаас хамаарч хэлбэлзлэлтэй байдаг ч 2012 онд 58%-иас саяхны 2021 онд 65% болж өөрийгөө хангах хэмжээ тогтмол нэмэгдэж байна. Хүн ам зүй болон дээр өгүүлсэн нэг хүнд ноогдох хэрэглээ нэмэгдэж байгаа учраас цаашид ч зах зээлийн хэмжээ өргөснө гэж үзэж байна. Тийм учраас импортын ногоог орлох үйлдвэрлэлийг дэмжих бодлого барих нь зүйтэй.



Зураг 2.17 Хүнсний ногооны дотоодын үйлдвэрлэл ба импортын өсөлт (2012-2021 он)
Эх сурвалж: ЖАЙКА төслийн баг боловсруулав.

(3) Хүнсний ногооны нийлүүлэлтийн сүлжээний тулгамдсан асуудал ба авах арга хэмжээ

Хүнсний ногооны нийлүүлэлтийн сүлжээний үе шат бүрийн тулгамдсан асуудал ба авах арга хэмжээг Хүснэгт 2.8-т сийрүүлсэн бөгөөд,түүний гол асуудал гэвэл, дотоодын ногооны хэрэгцээ өндөр байгаа ч үйлдвэрлэл нь эрэлтээ гүйцдэггүй, өөрийгөө хангаж чадахгүй байгаа, хур тунадас багатай, эх газрын хүйтэн уур амьсгалтай тул тариалалтын хугацаа богино, үйлдвэрлэлийн өртөг өндөр, ложистикийн сүлжээ хангалтгүй, тиймээс түгээлтийн өртөг ч өндөр тул өрсөлдөх чадварыг бууруулдаг, ногооны хэрэглээ дэлхийн дундажаас харьцангуй доогуур,эрсдэлд өртөх хамгийн бага онолын түвшин[38] (Theoretical minimum risk exposure level : TMREL)-с маш доогуур, эрүүл мэндэд нөлөөлөх эрсдэл буй зэргийг дурьдаж болно. Бас төр хариуцах эрүүл мэндийн зардал (нэг хүнд ноогдох) 2015 онд 256 ам. доллараас 2040 онд 508 ам доллар болно гэж тооцоолж байгаа, төрийн

[37] NSO Mongolian Statistical Yearbook2021
[38] онолын хамгийн бага өртөлт (Theoretical minimum risk exposure level) нь, ХН-ын бордоо, УХБ-ын улмаас үүсэх өвчлөлийг хамгийн бага байлгах хэмжээ

зүгээс хоол хүнсний чанарыг сайжруулах талаар ажиллах шаардлагатай гэж үзэж байна. Дээрх асуудлуудын талаар авах арга хэмжээг Хүснэгт 2.8 хүснэгтэд нэгтгэсэн бөгөөд, Засгийн газар, хувийн компаниуд, хандивлагчид энэ чиглэлээр арга хэмжээнүүдийг авч хүнсний ногооны урамшуулал, өвлийн тариалалтыг дэмжих, боловсруулах ААН-үүд хувьцаагаа хөрөнгийн зах зээлд борлуулж хөрөнгө босгох, үйлдвэрлэгчийн бүтэц зохион байгуулалтыг бэхжүүлэх зэрэг авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн гарч эхлээд байна.

Хүснэгт 2.8 Хүнсний ногооны нийлүүлэлтийн сүлжээний тулгамдсан асуудал ба авах арга хэмжээ

Үе шат	Асуудал	Авах арга хэмжээ
Орц	• Үр, ХАА-н үйлдвэрлэлийн хэрэгслийн дийлэнх нь импортын хамааралтай байгаа • Төмснөөс бусад ногооны үр үйлдвэрлэлийн тогтолцоо хангалтгүй.	• Гол нэр төрлийн төмс, ногооны төрлийн хувьд дотоддоо үр үрсэлгээний үйлдвэрлэл, нийлүүлэлтийн систем бий болгох
Үйлдвэрлэл	• Орчны нөхцөл (хүйтэн сэрүүн цаг агаар, том талбай) шалтгаант тариалалт борлуулалтын өртөг өндөр. • Үйлдвэрлэгчийн зохион байгуулалт хангалтгүй • ГТ-ийн түгээн дэлгэрүүлэх тогтолцоо сул	• Хүнсний ногооны урамшуулал • Ногоочдын бүлэг хоршоог дэмжих • ГТ-ийн түгээн дэлгэрүүлэх тогтолцоог сайжруулах (ажиллах хүчин,төсвийн хуваарилалт г.м)
Тээвэр ложистик, боловсруулалт	• Үйлдвэрлэгчийн зохион байгуулалт хангалтгүй, үр ашиг муутай • Түгээлт нийлүүлэлтийн дийлэнхи хэсэг нь ченжээс хамааралтай • Хадгалах агуулах дутмаг, тээврийн зардал өндөр • Хөрөнгө оруулалтын хүртээмж муу	• Тариаланчдыг хоршоололд хамруулж түгээлт-анхан шатны боловсруулалтын үр ашгийг нэмэгдүүлэх • Ченжийн биш зах зээлийн эрэлт (бодит хэрэглэгч)-д үндэслэсэн зах зээлийн баримжаат ГТ болон гэрээт тариаланг дэмжих • Хадгалах агуулах, зам харилцааг сайжруулах зэрэг дэд бүтцийг хөгжүүлэх • Боловсруулах, үйлдвэрлэх ААН-үүд хөрөнгийн зах зээлээс хөрөнгө босгох
Борлуулалт, хэрэглээ	• Нэг хүнд ноогдох ногооны хэрэглээ бага • Өвлийн улиралд Хятадаас импортлосон ногоо л зардаг	• Дотоодын ногооны шим тэжээллэг чанарыг сайжруулах талаар сурталчлах • Өвлийн (сэрүүний улирлын) болон, хүлэмжийн тариаланг дэмжих

Эх сурвалж: ЖАЙКА төслийн баг боловсруулав.

(4) Хөгжлийн чиглэл

SWOT шинжилгээнд үндэслэсэн нийлүүлэлтийн сүлжээний төлөв байдлаас хөгжлийн үндсэн чиглэлийг схем Зураг 2.18-д сийрүүлэв. Өргөн хүрээгээр авч үзвэл хөгжлийн чиг хандлагыг ерөнхийд нь дараах байдлаар хуваж болно: хэрэгцээг хангахад чиглэсэн татаас олгодог тогтолцоо, сайн чанарын үр зэрэг орцын материалыг сайтар нэвтрүүлэх замаар хүнсний ногооны үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх.зах зээлийн хэрэгцээнд үндэслэсэн ГТ-ийн менежемент болон гэрээт тариаланг дэмжих, үйлдвэрлэгчдийн зохион байгуулалтыг бэхжүүлэх замаар үйлдвэрлэгч ААН-ийн орлого ашгийг нэмэгдүүлж чадах уу гэдэг асуудал.

Ногооны нийлүүлэлтийн сүлжээний SWOT шинжилгээ

Гадаад орчин

Боломж

- Дотоодын ногооны эрэлт нэмэгдэх хандлагатай ЭМЯ-наас нэг хүнд ноогдох хэмжээг нэмэгдүүлэхийг урналж буй
- Хүн амын өсөлт үргэлжлэх прогнозтой, хүн амын бүтцэд залуусын эзлэх хувь өндөр
- Хүнсний аюулгүй байдлын талаар хэрэглэгчийн ухамсар өндөр, дотоодын бүтээгдэхүүний эрэлт өндөр
- Зуны уур амьсгалын орчин нь ногоо тарихад тохиромжтой
- Хятад оростой дэд бүтцээр холбогдсон

Аюул

- Эх газрын эрс тэс сэрүүн уур амьсгалтай учир үйлдвэрлэлийн хугацаа богино. Уур амьсгалын өөрчлөлтийн нөлөө ч анхаарвал зохих асуудал мөн.
- Хятадын хямд ногооны интервенцтэй үнээр өрсөлдөх боломжгүй.
- Хятад,Орос гэх ХАА-н аварга хоёр зах зээлд хавчигдсан орон зай

Дотоод орчин

Давуу тал

- төмс,гол нэрийн ногооны үр үйлдвэрлэх тогтолцоо бүрдсэн
- УХБ, хогийн ургамал устгагчийн хэрэглээ бага,хөрш орноо бодвол аюулгүй ногоо тарьж, нийлүүлдэг
- УБ-т төрийн өмчит зах, агуулах зэрэг дэд бүтэц бүрдэж байгаа
- Ногоо боловсруулдаг үйлдвэр хоршоод бий
- Монгол маягийн ХААЗД г.м хүнсний аюулгүй байдлын тогтолцоо бүрдсэн. дотоодын баталгаажуулалтын байгууллагатай, судалгаа хөгжлийн байгууллага ч харьцангуй сайн төлөвшсөн

Сул тал

- Үр гэх мэт ХАА-н үйлдвэрлэлийн орцын дийлэнх нь импортоос хамааралтай
- Ялангуяа хөдөөд хүртээмж муу.Зарим бүсэд усалгаатай тариалангийн төхөөрөмж хангалттүй
- Ногооны үйлдвэрлэлийн бүс хязгаарлагдмал, хэлбийлттэй, өвлийн хүлэмжийн тариалалтын өртөг өндөр
- -Ногоочдын хоршоолол хангалттүй
- ХАА-н технологи ядмаг тогтолцоотой
- -Борлуулалт, ложистикийн дийлэнх нь чөнжид эзлэгдсэн,агуулах, хадгалах технологи дутмаг, өртөг өндөр
- Хөрөнгө оруулалтын хүртээмж хүндрэлтэй
- Дотоодын түүхий эд дутагдалтай, зарим нь импортын хамааралтай. Боловсруулах үйлдвэрийн а.ү,к бага, үйлдвэрлэлийн өртөг өндөр

Давуу тал*боломж

- **Импортыг орлох санаачлага их, татаасын бодлогыг үргэлжлүүлж буй**
- **Дотоодын ногооны хэрэглээний талаар ухуулга сурталчилгаа, ногоо боловсруулах хялбар арга техник нэвтрүүлж, дотоодын ногооны хэрэглээг өөрчлөх болон шим тэжээлийг сайжруулахыг дэмждэг**

Давуу тал *аюул

- **ГТ-ийн хоршооллыг байгуулж ГТ-гийн бүтээгдэхүүний ложистик тогтолцоо бүрдүүлэх төлөвлөгөө боловсруулах, зохион байгуулалтыг дэмжих**
- **Хүнсний аюулгүй байдал талаасаа дотоодод тарьсан ногооны чанарыг сайжруулах, Хятад зэрэг импортын ногоонд ялгаварлал тогтоох**

Сул тал*боломж

- **Дотоод гадаадын сайн чанарын үр, сорт ашиглан түргэтгэх тариалалт зэргийг идэвхитэй нэвтрүүлэн, ногооны үйлдвэрлэлийн хэмжээ, нийлүүлэлтийн хугацааг уртасгах**
- **Тариачдыг зах зээлийн баримжаат ГТ-гийн менежментэд шилжүүлэх, ГТ-гийн тогтвортой менежмент , ашиг орлогыг нэмэгдүүлэх**

Сул тал *аюул

- **ГТ-ийн хоршооллыг байгуулж ГТ-гийн бүтээгдэхүүний ложистик тогтолцоо бүрдүүлэх төлөвлөгөө боловсруулах**
- **Үйлдвэрлэх ААН-үүд нээлттэй ХК болох зэргээр хөрөнгө босгох**
- **ХАА-н бирж, бөөний зах зээлийн үйл ажиллагааг бэхжүүлэх, ложистик тогтолцоог сайжруулах, нийлүүлэлтийн сүлжээг бэхжүүлэх**

Зураг 2.18 Хүнсний ногооны нийлүүлэлийн шинжилгээний SWOT шинжилгээ

Эх сурвалж: ЖАЙКА төслийн баг

2.3.2 Үр тариа, тосны ургамал

(1) Үр тариа, тосны ургамалын нийлүүлэлтийн сүлжээний өнөөгийн байдал

Монгол Улсын ГТ-нд хамгийн их тариалдаг үр тариа бол улаан буудай бөгөөд 2022 онд нийтдээ 417 мянган тонн үр тариа хураасны 394 мянган тонн нь улаан буудай байна. Үр тарианы талбайн хэмжээгээр Сэлэнгэ аймаг 137 орчим мянган га, дараа нь Төв, Булган аймаг орж байна. Хур тундас ховорхон ордог, хуурайшилт ихтэй өмнөд бүсэд үр тарианы тариалалт бага.Улаан буудай тарьсан тариаланч ургацаа хурааж аваад хувийн гурилын үйлдвэрт тушаасны дараа тушаасан хэмжээгээрээ засгийн газрын татаас авна. Томоохон тариалангийн ААН нь өөрийн компаний гурилын үйлдвэртэй, өөрийн компаний бренд болгож зардаг жишээ ч байна. Өмнө нь зөвхөн буудайн гурил хийж зардаг байсан бол одоо талх, гоймон, гурилан боов зэрэг бэлэн бүтээгдэхүүн болгож зарах явдал нэлээд түгээмэл болж байна. Хүнсний аюулгүй байдал, сайн чанарын үртэй болохын тулд засгийн газрын тариаланг дэмжих санд нөөцөлдөг. 2022 оны улаан буудайн талаас илүү хувь нь борлогдоод байсан 11 сарын сүүл гэхэд хаана нийлүүлсэн, зориулалт тус бүрээр авч үзвэл 59% нь гурилын үйлдвэрүүдэд, 11% нь улсын нөөцөд, 12% нь үрэнд, 10% нь малын тэжээлд хуваарилагдсан байна.

Зураг 2.19 Монголын улаан буудайн борлуулалтын суваг

Эх сурвалж: ЖАЙКА төслийн баг боловсруулав.

Улаан буудайн тариалалт нь, тосны ургамал (napus) (рапс, гич) болон тэжээл (арвай, овьёос, царгас г.м) хослуулсан сэлгэн тариалалтын систем зонхилдог байна. Гичийг Хятад руу экспортлодог бол рапсыг дотоодын тос шахах үйлдвэрт нийлүүлдэг. 2023 оны тосны ургамал (napus) (рапс, гич) тариалахаар төлөвлөсөн талбайн хэмжээ нь 66,410 га байна. Одоогийн байдлаар тариаланчид борлуулалт сайтай гич тариалах хандлагатай /сонирхолтой/ ба рапс гич хоёрыг ангилж ялгасан албан ёсны статистик байхгүй бөгөөд, тосны ургамлын 70-80% нь гич, үлдэх 20-30% нь рапс байх гэж таамаглаж байна.



Зураг 2.20 Монгол дахь рапс, гичний нийлүүлэлтийн сүлжээ

Эх сурвалж: ЖАЙКА төслийн баг боловсруулав.

Түүнээс гадна, Монголд үр тарианы нэг төрөл болох гурвалжин будаа (buckwheat)-ны эрэлт тодорхой хэмжээтэй бий бөгөөд Оросоос импортлосон гурвалжин будаа зах зээлд борлогдож байгаа боловч түүнийг дотооддоо тариалах нь хязгаартай байлаа. Харин Японы ААН-ийн хөрөнгө оруулалтаар 2014 оноос тариалах хэмжээ нэмэгдэж, Японд экспортлох санаатайгаар тариалалтыг нэмэгдүүлж байгаа. Түүний үр дүнд, 2021 онд тариалах талбай 22,500 га, хураасан ургац нь 3,000 тоннд хүрч огцом нэмэгдсэн байна (FAOSTAT).

(2) Улаанбуудай, тосны ургамлын зах зээлийн орчин

Гол хүнс болох улаан буудайгаар дотоодын хэрэгцээг бараг хангаж байгаа. Засгийн газрын худалдан авалтын тухайд, хэмжээ болон үнийн хувьд тогтвортой байдал шаардлагатай. Мөн хүнсний тосны түүхий эд болох рапсын тухайд засгийн газрын чиг шугам нь хүнсний тосны импортыг орлох явдал гэж байгаа. Монголын дотоодын ургамлын тосны хэрэгцээг хангах хэмжээтэй хүчин чадалтай тос шахах үйлдвэр 2014 онд баригдаж, тэр үйлдвэрт нийлүүлэлт нэмэгдсэн тул тосны ургамлын тариалалт ч өсч байна. Гэхдээ одоогоор тэр үйлдвэр монополь байдалтай байна. Монголын хүнсний тосны дийлэнхи нь Хятад Оросоос импортын хараат байна. Ойрын жилүүдэд импортлох хэмжээ 25 мянган тоннд хүрнэ. Төрөл тус бүрээр үзвэл наранцэцэгийн тос 40%, шар буурцийн тос 30%, дал модны самрын тос 24%, рапсын тос дөнгөж 1% байна (2021он).



Зураг 2.21 Монголын хүнсний тосны импортын хэмжээний өсөлт (төрөл тус бүрээр)
Эх сурвалж: ЖАЙКА төслийн баг боловсруулав.

Рапс, гичний нийт үйлдвэрлэл 20,000-60,000 тоннын хооронд хэлбэлзэж байгаа ба өнгөрсөн 3 жилд дунджаар 40,000 тонн байна. Үүнээс 25% нь рапс гэвэл 10,000 тоннын ургац хураасан гэж үзээд үүнийг тосонд шилжүүлж тооцвол барагцаалбал 3,000 тоннтой тэнцэнэ. Импортын хэмжээтэй харьцуулбал түүний 10 гаруй хувиас хэтрэхгүй байна.



Зураг 2.22 Монголын рапс, гичний үйлдвэрлэлийн хэмжээний өсөлт
Эх сурвалж: ЖАЙКА төслийн баг боловсруулав.

(3) Улаанбуудай, тосны ургамлын нийлүүлэлтийн сүлжээний асуудал ба авах арга хэмжээ

Энэ хэсэгт одоогийн байдлаар чухалчлагдаж буй хүнсний тосны түүхий эд болох рапсын нийлүүлэлтийн сүлжээний тухай, асуудал ба авах арга хэмжээг сийрүүллээ (Хүснэгт 2.9).

Хүснэгт 2.9 Рапсын нийлүүлэлтийн сүлжээний тухай, асуудал ба авах арга хэмжээ

Үе шат	Асуудал	аргахэмжээ
Материал тоног төхөөрөмж: рапсын үр	Сайн чанарын рапсын үр нь импортоос хамааралтай, нийлүүлэлт нь тогтворгүй, өндөр үнэтэй.	Одоогийн байдлаар хоёр сортын рапс (тогтмол зүйл) бүртгэгдээд байгаа бөгөөд дотоодын үйлдвэрлэлийг өргөжүүлэх, үйлдвэрлэгчдэд тэгш нөхцлөөр нийлүүлэх тогтолцоо бүрдүүлэх.
Рапс тариалалт	Рапсыг тарьж ургуулсан түүх богино, үйлдвэрлэгчдийн тариалах арга техник хангалтгүйгээс бүтээмж бага байдаг. (Монголын дундаж 0.6 тн/га, дэлхийн дундаж 2.0 тн/га орчим)	Бүтээмжийг дээшлүүлэхийн тулд рапс тариалахад тохирох арга техникийг бий болгож, үйлдвэрлэгчдэд зориулсан техникийн зааварчилгааг сайжруулах шаардлагатай байна.
Ложистик, арилжааны үнэ	Рапс худалдан авах үнийг хүнсний тосны үнээр тодорхойлдог тул Хятадуудад гич худалдах үнээс доогуур байлгадаг. Түүнчлэн рапсын үнэ, төлбөрийн нөхцөл нь хатуу.	Рапсын тариаланч, тос шахах компани хоёр арилжааны нөхцлөө урьдчилан тохиролцдог гэрээт тариалалтын тогтолцоог нэвтрүүлэх нь ашигтай гэж үзэж байна.
Боловсруулалт: Тос шахах	Томоохон аж ахуйн нэгжүүдийн хүнсний тос үйлдвэрлэх технологийн түвшин хангалттай ч монополь байдалтай, өрсөлдөөний зарчим үйлчилдэггүй.	Алс хэт нь шинэ компаниуд орж ирэхэд төрөөс үзүүлэх дэмжлэгийг ч мөн авч үзэх.

Эх сурвалж: ЖАЙКА төслийн баг боловсруулав.

(4) Хөгжлийн чиглэл

Ерөнхийдөө улаан буудай, рапс, арвай зэргийг хослуулсан ээлжлэн тариалах системийг ашигладаг. Эдгээрээс улаан буудайн тариалалт болон хураан авах ургацаар дотоодын хэрэгцээг хангах хэмжээнд хүрсэн бөгөөд түүний үйлдвэрлэлийн хэрэгсэл (үр, түлш гэх мэт)-ийн худалдан авалтыг дэмжих тогтолцоо болон улаан буудайн үйлдвэрлэлд татаас олгох, улсын нөөц бүрдүүлэх

тогтолцоо гэх мэт өнөөгийн бодлогыг тууштай хэрэгжүүлэх. Мөн 2022 онд зарлаж, эхлүүлсэн "Хүнсний хувьсгал" хөдөлгөөний хүрээнд хүнсний тосоор өөрийгөө хангах хэмжээг нэмэгдүүлэх бодлогыг дэмжихийн тулд рапсын нийлүүлэлтийн сүлжээг бэхжүүлэх чиглэлээр дараах SWOT шинжилгээг хийж, чиглэлийг тодорхойлов.

Ургамлын тосны нийлүүлэлтийн сүлжээний SWOT шинжилгээ		Гадаад орчин	
		Боломж	**Аюул**
		● Чанар, хүчин чадлын хувьд хангалттай тос шахах үйлдвэртэй ● Үйлдвэрлэлийн хэрэгсэл худалдан авахад засгийн газрын дэмжлэг авах боломжтой. ● Дотоодын судлаач мэргэжилтнүүдтэй, технологийн зааварчилгаа өгөх боломжтой. ● Газар тариалангийн үйлдвэрлэлийн холбоотой	● Хятадад экспортлодог гич тариалах нь дотоодын зориулалттай рапсаас худалдах үнэ илүү, төлбөрийн нөхцөл ч сайн. ● Рапс худалдан авагч нь ганцхан монополь компани байна. ● Бордоо зэрэг үйлдвэрлэлийн хэрэгслийн үнэ өндөр байна.
Дотоод орчин	**Давуу тал** ● Хөрсний үржил шимийг хадгалах зорилгоор үр тариатай сэлгэн тариалалт хийхэд ач тустай ● ХАА-н үндсэн машин техник нь үр тарианыхтай адил тул нэмэлт хөрөнгө оруулалт шаардлагагүй. ● Усалгаагүй талбайд ч тариалах боломжтой. ● Монголын цаг агаарт тохиромжтой хоёр сорт батлагдсан	**Давуу тал *боломж** ● **Рапс тариалалтын техник тоног төхөөрөмжид зориулсан дэмжлэгийн бодлогыг хэвээр байлгаж, өргөтгөх** ● **Рапс тариалагчдаас бүрдсэн газар тариалангийн бизнесчдийн холбооны хүчээр рапс тариалалт үйлдвэрлэлийн хөтөлбөр хэрэгжүүлэх**	**Давуу тал *аюул** ● **Гичгэй үнээр өрсөлдөхийн тулд рапсын тариалалтыг төсвийн татаасаар дэмжих тогтолцоотой болох** ● **Рапс тариалалтын техник тоног төхөөрөмжид зориулсан дэмжлэгийн бодлогыг хэвээр байлгаж, өргөтгөх**
	Сул тал ● Рапс тариалсан туршлага нимгэн, тариаланчдын технологийн чадвар бага ● Үр нь импортоос хараат тул худалдан авахад төвөгтэй. ● Ургац хураалт нь үр тариатай давхцдаг тул зохистой хураалт хийхэд хүндрэлтэй ● Рапсын зориулалтын комбайн байхгүй тул алдагдал ихтэй.	**сул тал *боломж** ● **Рапс, дотоодын ургамлын тосны талаар семинар, арга хэмжээ зохион байгуулах зэргээр рапс тариалалтыг идэвхижүүлэх** ● **Рапс тариалах заавар боловсруулж тараах** ● **Рапсын үрийг дотоддоо үйлдвэрлэх, тараахад чиглэсэн дэмжлэгийн тогтолцоо бүрдүүлэх**	**сул тал *аюул** ● **Рапсын худалданы нөхцөлийг сайжруулахын тулд тариаланч тос шахах компани хоёр гэрээгээр тариалдаг болгоход түлхэц өгөх** ● **Тос шахах компанийг НӨАТ-аас чөлөөлөх бодлогыг үргэлжлүүлэх**

Зураг 2.23 Монголын рапсын нэмүү өртгийн сүлжээний SWOT шинжилгээ

Эх сурвалж: ЖАЙКА төслийн баг боловсруулав.

2.3.3 Жимс, жимсгэнэ

(1) Жимсний нийлүүлэлтийн сүлжээний өнөөгийн байдал

Монголын жимс жимсгэнийн үйлдвэрлэлийн хэмжээ, тарималын ургац нь 2,357тонн (2021 он) болж 5 жилийн өмнөх 1,488тонн (2017 он)-с 50%-р нэмэгдсэн байна. Үйлдвэрлэсэн жимсний бараг 90% нь чацаргана бөгөөд жимсний тариалалтын дийлэнхийг эзэлж байна. Түүнчлэн, зэрлэг сортуудын ургац нь таримал сортуудынхаас хэд дахин их, цар хүрээ нь таримал сортуудынхаас их байдаг гэнэ. Таримал сортын үндсэн үйлдвэрлэлийн бүс нь Увс аймаг бөгөөд баруун бүсийн нийт тариалалтын 58%-ийг (1,369 тн, 2021) эзэлж байв. Нийлүүлэлтийн сүлжээг бүхэлд нь авч үзвэл жижиг, дунд үйлдвэрлэгчид үйлдвэрлэлийн талдаа анхаарч,тээвэр ложистик, боловсруулагчдад түүхий эд нийлүүлэх, орон нутгийн зах зээлд худалдаалдаг байна. Нөгөө талд том ААН-д дотор өөрийн тариалангийн талбай, үйлдвэртэй, үйлдвэрлэх, тээвэрлэх боловсруулах борлуулалт хүртэл бүтэн циклээр ажилладаг компани ч байна. Хэрэглээний хувьд нэг хүнд ноогдох жимс, жимсгэний төрлийн сарын хэрэглээ нь улсын хэмжээнд дунджаар 0,5кг/сар, үүнээс хот сууринд 07 кг/хүн, орон нутагт 0,4кг/хүн байна[39]. Дэлхийн дундажтай харьцуулахад хэрэглээ нь жигд, бага байна.

[39] Монгол Улсын Үндэсний Статистикийн Хороо Статистикийн эмхэтгэл, 2021

Зураг 2.24 Монголын жимс, жимсгэний нийлүүлэлтийн сүлжээ

Эх сурвалж: ЖАЙКА төслийн баг боловсруулав.

(2) Жимсний зах зээлийн орчин

Жимсний жимсгэнийн төрөл зах зээлийн орчин нөхцөлийн талаар үйлдвэрлэл ба импортын хэмжээг Зураг 2.25-т харуулснаас үзвэлц хэрэгцээ аажмаар өсөх хандлагатай байна. Монгол орон нь эх газрын хүйтэн сэрүүн уур амьсгалтай учир тариалах боломжтой жимс, жимсгэний нэр төрөл цөөн, тарилаа ч ургац муутай байх магадлалтай. Дотоодын хангалт нь 2012 оны байдлаар барагцаалбал 3.9% байсан бол саяхан буюу 2021 онд 4.8% орчим байна, уур амьсгалын нөхцлөөс хамаарч жил жилийн хэлбэлзэл нь 4.0%-иас 6.0% орчмын хооронд байна. Дээр дурьдсанчлан нэг хүнд ноогдох хэрэглээ нь жигдхэн байгаа ч хүн ам зүйн улмаас хэрэгцээ аажмаар нэмэгдэнэ гэж үзэн, цаашид зах зээлийн хэмжээ өргөсөх байх. Тийм учраас жимс жимсгэний импортыг орлох үйлдвэрлэлийг дэмжих бодлогоо үргэлжлүүлэх нь зүйтэй.



Зураг 2.25 Жимсний төрлийн үйлдвэрлэл, импортын хэмжээ (2012-2021 он)

Эх сурвалж: ЖАЙКА төслийн баг боловсруулав.

(3) Жимсний нийлүүлэлтийн сүлжээний асуудал ба авах арга хэмжээ

Жимс жимсгэний нийлүүлэлтийн сүлжээний үе шат тутмын асуудлыг Хүснэгт 2.10-т сийрүүлсэн, гол асуудал бол дотоодод үйлдвэрлэсэн жимсгэний эрэлт их байдаг ч тэрхүү эрэлтийг нийлүүлэлт нь гүйцэхгүй байгаагаас өөрийгөө хангах хэмжээнд хүрээгүй байгаа, орц материал, үйлдвэрлэлийн хураах шатанд өөр сорттой холилдон, энэ нь боловсруулалт, борлуулалтын шатанд бүтээгдэхүүнийг ангилан ялгах, бренджүүлэх боломжгүй болгох, нэг хүнд ноогдох жимсний хэрэглээ бага байгаа зэргийг дурьдаж болно. Эдгээр асуудал тус бүрийг шийдвэрлэх аргын тухай хүснэгт Хүснэгт 2.10-т сийрүүлсэн ба засгийн газар, хандивлагчид энэ талаар арга хэмжээ авч эхлээд байгаа нь сайн чанарын сортын үр үрсэлгээ үйлдвэрлэх зорилгоор үрсэлгээ бойжуулахыг дэмжиж чацарганын экспортыг дэмжих зорилготой үйлдвэрлэгч, төр, ШУБ-ын хамтарсан кластер хөгжүүлэх эхлэл тавигдсан байна.

Хүснэгт 2.10 Жимс жимсгэний нийлүүлэлтийн сүлжээний асуудлууд ба авах арга хэмжээ

Үе шат	Асуудал	Арга хэмжээ
Орц	• **Сайн чанарын үр сортын үйлдвэрлэлтийн тогтолцоо хангалтгүй**	• **Дотоод үйлдвэрийн чацарганын суулгац үйлдвэрлэл нийлүүлэлтийн тогтолцоо бүрдүүлэх**
Үйлдвэрлэл	• **Орчны нөхцөл (хүйтэн сэрүүн цаг агаар, том талбай) шалтгаант тариалалт борлуулалтын өртөг өндөр.** • **Таримал ба зэрлэг сорт холилддог** • **Шувуу идэж гэмтээх, усалгааны тоноглолын хүндрэлтэй байдал, ургацын хэмжээг сайжруулах боломж бий.** • **Үйлдвэрлэгчдийн зохион байгуулалт хангалтгүй**	• **Жимс жимсгэнэд татаас өгөх бодлого** • **Хураахдаа зүйл, сортыг холихгүй байх** • **Шувуунаас хамгаалах материал техник, технологи, тариалалтын үр дүн, ашиг сайтай технологи, тоног төхөөрөмжийн шийдэл, хөгжүүлэлт** • **Услалтын системийг сэргээн засварлах, усны зохистой хэрэглээ** • **Үйлдвэрлэгчдийн бүлэг, хоршоог дэмжих**
Ложистик, боловсруулалт	• **Агуулахын дутагдал, тээврийн зардал өндөр** • **Түүхий эд, сортууд холилдох, бүтээгдэхүүнийг ангилан ялгах бренджүүлэхэд хүндрэлтэй** • **Үйлдвэрийн ашиглалтыг сайжруулах (боловсруулалтын өртөг өндөр)**	• **Агуулах, зам засвар зэрэг дэд бүтцийг хөгжүүлэх** • **Бүтээгдэхүүний ялгаатай байдалд тулгуурлан түүхий эд бэлтгэх, боловсруулах үед сортлон ялгаж борлуулах, бүтээгдэхүүний боловсруулалт хийх.** • **Үйлдвэрийн ашиглалтын түвшинг нэмэгдүүлэх ,агуулах барих, үйлдвэрлэгчдийг зохион байгуулалтад оруулах, ургац хураалтын дараах анхан шатны боловсруулалтын үр ашгийг дээшлүүлэх**
Борлуулалт, хэрэглээ	• **Нэг хүнд ноогдох жимсний хэрэглээ бага**	• **Эх орны үйлдвэрийн жимс, жимсгэний хэрэглээг дэмжих** • **Кластер хөгжүүлэх, үйлдвэрлэгч, төр, эрдэм шинжилгээний байгууллагуудын хамтын ажиллагаа**

Эх сурвалж: ЖАЙКА төслийн баг боловсруулав.

(4) Хөгжлийн чиглэл

Зураг 2.26-д хөндлөнгийн SWOT шинжилгээнд үндэслэн нийлүүлэлтийн сүлжээний

ерөнхий төлөв, хөгжлийн чиг хандлагыг харуулав. Хөгжлийн чиг хандлагыг ерөнхийд нь томъёолбол, эрэлт хэрэгцээг хангах сайн чанарын үр, бусад орц материалыг нэвтрүүлэх, суулгац үйлдвэрлэлийн тогтолцоо бүрдүүлэх,жимс үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, дотоод гадаадын зах зээлийн эрэлтэд суурилсан бүтээгдэхүүний хөгжүүлэлтийг идэвхитэй хийх,үйлдвэрлэлд шаардлагатай орцын материал, зах зээлийн эрэлтэд нийцсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэх, тариалахдаа тодорхой сортуудыг сонгож хэрэглэх, олон улсад өрсөлдөх чадвартай жимс, жимсгэний бүтээгдэхүүний экспортыг дэмжих.

Жимсний нийлүүлэлтийн сүлжээний SWOT шинжилгээ		Гадаад орчин	
		Боломж	**Аюул**
		● Үйлдвэрлэлж буй хэмжээ нь дотоодын жимсний эрэлтийг гүйцдэггүй ● Тэрбум мод үндэсний хөдөлгөөн гэх мэт холбогдох бодлого эрчимжиж байна ● Хүн амын тоо нэмэгдэх прогнозтой, хүн амын бүтцийн хувьд залуу хүн ам ихтэй ● Хүнсний аюулгүй байдлын талаар хэрэглэгчдийн ухамсар сайжирч байгаа, дотоодын бүтээгдэхүүний хэрэгцээ өсч байгаа ● Хятад, Оростой дэд бүтцээр холбогдсон	● Эх газрын эрс тэс сэрүүн уур амьсгалтай байгаль орчин. Уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөлөл ч бас анхаарах асуудал мөн ● Хятадаас хямд үнэтэй орж ирдэг жимс,жимсгэнэтэй үнээр өрсөлдөх боломжгүй ● Далайд гаргүй, ХАА-н аварга үйлдвэрлэгч Хятад Орос хоёрт хавчуулагдсан
Дотоод орчин	**Давуу тал** ● Байгалийн сэрүүн бүсэд өвөрмөц жимс, жимсгэнэ үйлдвэрлэдэг ● Экспортод гаргадаг цөөхөн жимсний нэг нь чацаргана ● Жимс, жимсгэнэ боловсруулдаг үйлдвэр,ААН, холбоо хүртэл бий. ● Улаанбаатарт нийтийн зах зээл, агуулах зэрэг дэд бүтэц байгуулагдаж байна ● Монгол/маягийн/ ХАА-н зохистой дадал г.м хүнсний аюулгүй байдлын тогтолцоотой. Дотоодын баталгаажуулалтын болон судалгаа сургалтын байгуулллагууд бий.	**Давуу тал *Боломж** ● **Дотоодын жимсний үйлдвэрлэл, нийлүүлэлт нэмэгдэх хандлагатай, импортыг орлох бүтээгдэхүүнийг үргэлжүүлэх дэмжих** ● **Олон улсын стандартын шаардлага хангасан чацарганаар хийсэн бүтээгдэхүүнийг дэмжих төлөвлөгөө** ● **ЕХ руу экспортлох хэлэлцээрийг үргэлжлүүлэх,бөрлуулалтын сувгийг өргөтгөх**	**Давуу тал *аюул** ● **Үр сортын судалгаа хөгжлийн тогтолцоо бүрдүүлж,өвөрмөц бөгөөд аюулгүй жимс гаргаж авахыг дэмжих, Хятадаас импортлодог жимснээс ялгарах шаардлага** ● **Үйлдвэрлэл төр хувийн хэвшлийн хамтын ажиллагаа, мөшгих тогтолцоог бэхжүүлж, дотоодын жимсний хангамж, түүхий эдийн тогтвортой нийлүүлэлтийг хэрэгжүүлэх**
	Сул тал ● Үрнээс эхлээд ХАА-н орц материалын дийлэнх нь импортоос хамааралтай ● Дотоодын үр,суулгацын үйлдвэрлэл нийлүүлэлтийн сүлжээ хангалттүй,услалтын системийн хүртээмж муу, шувуу идэх зэргээр бүтээмж нь 1га-гаас 2-3 тонноос хэтэрдэггүй, ● Боловсруулалтын шатанд, түүхий эд худалдан авахад (талбайд ч гэсэн) сортууднь холилдсон байдаг тул, ялгалт болон бренджүүлэлт хангалттүй ● Үйлдвэрийн ашигт ажиллагаат сайжруулах шаардлагатай, үйлдвэрлэлийн өртөг өндөр ● Бүтээгдэхүүнд УХБ, бордооны үлдэц илрэх явдал бий, үйлдвэрлэл боловсруулалт дамжлагыг сайжруулах шаардлагатай ● Агуулах, хадгалалтын технологи дутагдалтай, тээврийн зардал өндөр	**Сул тал *Боломж** ● **Дотоод гадаадын сайн чанарын сортын үйлдвэрлэлийг бэхжүүлэх,үр суулгацын төвд тулгуурласан нийлүүлэлтийн сүлжээг бэхжүүлэх** ● **Тариалалтын тохиромжтой технологийг түгээн дэлгэрүүлэх төлөвлөгөө гарган хэрэгжүүлэх, бүтээмжийг нэмэгдүүлэх, чанарыг сайжруулах**	**Сул тал *аюул** ● **Үйлдвэрлэгч ААН нь нээлттэй хувьцаат компани болох зэргээр зах зээлээс хөрөнгө босгох** ● **ХАА-н бирж, бөөний захуудын тогтолцоог бэхжүүлэх, түгээлт нийлүүлэлтийн тогтолцоог сайжруулах, зах зээлийн мэдээллээр хангах**

Зураг 2.26 Жимс жимсгэнийн нийлүүлэлтийн сүлжээний SWOT шинжилгээ

Эх сурвалж: ЖАЙКА төслийн баг боловсруулав.

2.3.4 Мах (Гэрийн тэжээвэр амьтны хоолыг оруулан)

(1) Махны нийлүүлэлтийн сүлжээний өнөөгийн байдал

Энэ хэсэгт мах, сүүний нийлүүлэлтийн сүлжээний өнөөгийн байдлын талаар мөн ГТА-ны хоол тэжээлийн тухай товч тайлбарлана.Та бүхний мэдэж байгаачлан Монголчуудын хоол хүнсэнд мах сүү нэн чухал байр суурь эзэлдэг. Өнөөгийн байдлаар нийтэд мэдээлэгдсэн, ХАА-н нийт үйлдвэрлэлийн хамгийн сүүлийн (2021 он) баримтаас харахадд МАА-н салбар 80 гаруй хувийг эзэлж байгаа бөгөөд[40] энэ өндөр үзүүлэлтээс харахад л Монголын соёлын үнэт зүйл гэж хэлэх ёстой нүүдлийн МАА-с улбаатай гэж хэлж болно. Тийм ч учраас Монголын үйлдвэрлэлийн

[40] Монголын статистикийн эмхэтгэл , 2021.

дотроос нийлүүлэлтийн сүлжээний хувьд хамгийн урт түүхтэй нь юм. Гэхдээ, түүхтэй хэдий ч боловсронгуй гэж хэлэхэд хэцүү. Хамгийн том онцлог нь мах гэвэл орчин үеийн төхөөрөх байгууламж, сүү гэхэд хүйтэн хэлхээ бүхий боловсруулах үйлдвэрт нийлүүлэх, тухайлбал албан ёсны маршрутаар дамжуулан нийлүүлж байгаа хэмжээ нь мах сүү аль аль нь нэн бага хэмжээтэй байна. Махны хувьд ±10% гэгдэж байгаа бол сүү нь бүс нутгийн ялгаа ихтэй бөгөөд сүү цуглуулах бааз суурь бүрдээгүй орон нутагт бол огт байхгүй гэхэд болно[41]. Нийлүүлэлтийн сүлжээний үндсэн нөхцөл байдлыг Зураг 2.27-т үзүүлэв.



Зураг 2.27 Монголын мах, сүүний нийлүүлэлтийн сүлжээ

Эх сурвалж: ЖАЙКА төслийн баг боловсруулав.

(2) Махны зах зээлийн орчин

Өмнөх хэсэгт МАА-н гаралтай хүнсний үйлдвэрлэлийн нийлүүлэлтийн сүлжээнд их өөрчлөлт гараагүй тухай өгүүлсэн, сүүлийн жилүүлэд Ковид-19 болон Украины нөхцөл байдлын нөлөөгөөр түүний суурийг доргиох хэмжээний өөрчлөлт гараагүй ч энэ нийлүүлэлтийн сүлжээний зах зээлийн орчинд бага зэрэг хэлбэлзэл гарсан. Энэ талаар *Ковидын нөлөөгөөр зах зээлийн хэлбэлзэлгүй байх үеийн арилжааны үнийн төсөөлөл

Зураг 2.28 -т дурьдсан.

[41] Монголын мах үйлдвэрлэгчдийн холбоо болон сүүний томоохон үйлдвэрүүдээс тодруулсан. Дээрх хэсэгт дурьдсанчлан “Сүү цуглуулах бааз суурь” буй болсон нутагт орчин үеийн сүү боловсруулах үйлдвэрт нийлүүлэх хэмжээ нэмэгдэж бараг 100%-д хүрээд байгаа нөхцөл байдалд хэд хэдэн сүүний компаниуд нийлүүлэгчээ булаацалдах байдал ч үүсээд байгаа гэнэ.



*Ковидын нөлөөгөөр зах зээлийн хэлбэлзэлгүй байх үеийн арилжааны үнийн төсөөлөл

Зураг 2.28 МАА-н бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн хэмжээ (тонн) ба үнийн (төг) өөрчлөлт, 2017-2021 он

Эх сурвалж: Монголын статистикийн эмхэтгэл (2021)

Дээрх тоон үзүүлэлтийн өөрчлөлт нь Монголд Ковид-19 эхэлснээс хойш намдах үеийг хүртэлх хугацааг хамарч байгаа ба юуны өмнө үйлдвэрлэлийн хэмжээ (шугаман графикийг харах) мах, сүү хоёулаа Ковид-19 их дэлгэрснээс хойш мэдэгдэхүйц буурсан нь ажиглагдаж байна (2021он). Харин, энэ хугацааны гарц нь Ковидын өмнөх үетэй бараг тэнцүү өсөлтийн хувьтай байна. Энэхүү урвуу хамааралтай гэмээр үзэгдэл нь ижил хугацааны МАА-н үйлдвэрлэл, болон үйлдвэрлэлтэй холбоотой материал тоног төхөөрөмжийн[42] арилжааны үнэ өртөг огцом нэмэгдсэн нь инфляцийг хөөрөгдөж, үр дүнд нь нийт үйлдвэрлэлийн хэмжээ буурсан ч МАА-н нийт гарц /үнэ өртөг/ өссөнийг илэрхийлж байна. Энэ нь мөн схемд үзүүлсэн “виртуал гарц”, тухайлбал бодит МАА-н ДНБ-ээр тайлбарлаж болно. Энэхүү виртуал гарц нь инфляц үнийн өөрчлөлтийг тусгалгүйгээр тооцоолж гаргасан таамаг үзүүлэлт /утга/ бөгөөд нийт үйлдвэрлэлийн хэмжээний бууралтад сөргөөр нөлөөлсөн нь тодорхой байна.

Бас дээр дурьдсан хандлага нь экспортын тухайд ч үндсэндээ адилхан байна. Монголын хувьд мах, сүүнээс мах нь экспортын бүтээгдэхүүн бөгөөд 2010-2011 оны зудын нөлөөгөөр буурсан бол 2014 оноос нааш тогтвортой нэмэгдэж, 2018-2019 онд социализмын үеийнхээс хойш анх удаа хамгийн их экспорт хийсэн бол 2020 оноос эхлэн ковидын улмаас маш их буурчээ. Бас схемд үзүүлээгүй ч 2022 онд ч гэсэн Хятад руу хийх экспорт удаан хугацаагаар хориотой байснаас болсон уу, махны экспорт их хэмжээгээр унажээ гэж таамаглаж байна. Харин 2023 он гарсаар экспорт сэргэж, мөн ковид-19-ын шалтгаант хязгаарлалт ч зөөлөрч, өсөлт нь дахиад тогтворжих байх гэсэн

[42]Байгалийн бэлчээрийг дээд зэргээр ашигладаг Монголын ХАА нь үйлдвэрлэгчдийн түвшний хөрөнгө оруулалт бага мөн импортын хамааралч багатай. Харин боловсруулах цэгийн тоног төхөөрөмж нь угаасаа савлагааны материал, урвалж хүртэл байнгын хэрэглээний үйлдвэрийн хэрэгслийн дийлэнх нь импортын бүтээгдэхүүн байдаг.Тийм учраас COVID-19 гарсны дараа импортын хориглогдож үүний улмаас үйлдвэрлэлийн хэмжээ тал хувиар буурсан гэнэ. (Сүүний том үйлдвэр болон махны үйлдвэрээс авсан мэдээлэл)

хүлээлттэй байна.[43]



Зураг 2.29 МУ-аас экспортлосон махан бүтээгдэхүүний хэмжээний өөрчлөлт: 2014-2021 он
Эх сурвалж：МУ-ын статистикийн эмхэтгэл (2019, 2021 он)

Нэмж хэлэхэд, сүүлийн жилүүдийн экспортын үзүүлэлтийг харвал ойролцоогоор 1тэрбум 300 сая долларт хүрч 2019 оны үйлдвэрлэлийн 80 илүү хувийг Хятад эзэлж байгаа нь тасархай түрүүлж байна. 2-рт яваа Иран нь 16 орчим хувийг эзэлж, энэ хоёр улс бараг 90%-г авч байна. Бусад нь аль нь ч хувилах хэмжээний биш өчүүхэн бага, Солонгос, Вьетнам, Орос, Казакстан гэсэн дараалалтай байна. Экспортлож байгаа махны дийлэнх нь адууны мах бөгөөд 82% -г, дараа нь хонь, ямааны мах орж байна[44]. Дээрх улсуудаас жишээ нь Иран зэрэг нь Монголоос дийлэнх нь бордсон залуу хони(хурга төлөг)-ны мах авсан байна (18-24 сартай).

Түүнээс гадна, мах сүүний нийлүүлэлтийн сүлжээнд ил, далдаар нөлөөлж байгаа эсвэл нөлөөлнө гэж таамаглаж байгаа зүйлүүдийн талаар доор харууллаа.

1) Малын хөлийн албан татварын хуулийн хэрэгжилт

Малын тоо болон ашиглах бэлчээрт хамаарах бүс нутагт тохируулан хураах татварын тогтолцоо[45] нь социализмийн цаг үеэс хойш Монгол Улсад анх удаа боловсруулагдаж, 2009 оны 6 сарын 11-ний өдөр батлагдсан “орлогын албан татварын хууль”-ийн дотроос хамгийн сүүлд нэмэлт өөрчлөлт оруулсан. Гэвч энэ хууль бодит байдал дээр хэрэгжээгүй байсан гэхэд болно. Ийм түүхэн үеийг туулж 2021 оны 1 сарын 1-нээс дээрх хууль хэрэгжиж эхэлсэн бөгөөд,онцлог нь хураасан татварыг сумын түвшинд захиран зарцуулж тухайн нутаг орныг сайжруулахад ашиглах явдал юм. Гэтэл ковидоос болж хэрэгжүүлж эхлэхээр төлөвлөж байсан хугацаа хойшилсон, бодит тодорхой үр нөлөөг дүгнэхэд эртдэх байдалтай байна. Харин өмнөх хуулиудын хэрэгжилт үр дүн багатай, төрийн захиргааны төв байгууллагаас удирддаг байсантай харьцуулахад энэ татварын хууль нь тухайн орон нутгаас цугларч орон нутагтаа ашиглах гэдэг нь шинэлэг бөгөөд сайн үр дүнтэй байна

[43] Махны үйлдвэрийн удирдлагаас сонссон (2023 оны 4 сард).
[44] UNCTAD. 2021. Survey on the Domestic and Export Meat Value Chain in Mongolia. United Nations Conference on Trade and Development, Switzerland.
[45] Малын тоо нь хонин толгойд шилжүүлснээр, адуу, үхэр нь 5 хоньтой, тэмээ= 6-7 хонь, ямаа=1.5-р шилжүүлэн тооцож нийт малын тоог гаргаад тэр тоон утгад бүс нутаг бүрийн суурь доод үнээр үржүүлнэ.Нийслэлийн бүс, Дархан-Уул, Орхон, Сэлэнгэ Төв аймагт 100 төг, Баян-Өлгий, Говь-Алтай, Завхан, Увс, Ховд аймагт 50 төг, бусад аймагт 75 төг гэж хуваадаг.

гэсэн хүлээлттэй байна.

2) Мах боловсруулах чиглэлийн зохицуулалт

Одоо ч гэсэн COVID-19 -ийн үед 2022 оны 6 сард маханд гаднын бодис хольсон байсан гэх үйл явдлын нөлөөгөөр Монголын махны үйлдвэрүүд маш их хохирол амссан. Ер нь тэр хэрэглэх хориотой бодис[46] нь зах зээлд байгаа махнаас илэрсний хариуд эрх бүхий байгууллага нь өргөн цар хүрээг хамарсан арга хэмжээ авсан нь махны олон үйлдвэрлэгчдийн үйл ажиллагааг зогсоож тэр нь удаан хугацаагаар үргэлжилсэн. Ийм нөхцөл байдалд мах боловсруулах талаар шинэ заавар журам батлагдаж энэ жилээс үе шаттайгаар, эхлээд эмнэлэг, сургуулийн хоолонд хэрэглэх маханд туршихаар болсон байна. Эдгээр байгууллагад нийлүүлэх махыг зөвхөн албан ёсны мал төхөөрөх хэрэгслээр тоноглогдсон үйлдвэрт төхөөрч боловсруулсан мах хэрэглэхээр заасан байна. Үр дүнд нь мах бэлтгэх боловсруулах ажлын эрүүл ахуйн нөхцөл сайжирвал махны салбарынхы хувьд эргэлт гаргах сайн үйл болно гэж хэлж болно.

3) Хурга бордон тэжээх

Сүүлийн жилүүдэд, Монгол хурганы мах тухайлбал нэг нас хүрээгүй хургыг махлах зорилгоор тэжээх бизнест хойно (4-р бүлэгт) өгүүлэх шинэ технологи нэвтрүүлж эхлээд байгаа ба, 1-2 настай (төлөг, шүдлэн) хонь бордох бизнесээс илүү түрүүлээд идэвхитэй хийгдэж байсан нь сонирхол татаж байна. ХХААХҮЯ-ны эрчимжсэн мал аж ахуй хариуцсан ажилтны яриагаар бол энэхүү хурга төлөг бордох бизнес эрхлэгчийн тоо болон бордож буй малын тоо нь Зураг 2.30-д үзүүлсэнчлэн 2017 оноос хойш үйлдвэрлэгчийн тоо ч тэр малын тоо ч тэр хурдацтай нэмэгдэж байгаа гэлээ. Схемд харуулсан үйлдвэрлэгчийн олонх нь Францаас 4 төрлийн үүлдэр оруулж ирж эрлийз сүрэг үүсгэж байгаа гэнэ. Монголд хонь, тэр дундаа хурга бордох нь одоо цагт хамгийн их анхаарвал зохих бизнесийн загвар байх болов уу.



Зураг 2.30 Хурга бордох фермийн тоо ба бордсон малын тооны өсөлт: 2010-2019 он
Эх сурвалж: ХХААХҮЯ-ны эрчимжсэн мал аж ахуй хариуцсан мэргэжилтний ярилцлага

[46] Натрийн тетраборат декахидрат илэрсэн гэж яригдаж байгаа. Хүнсний нэмэлтээр энэхүү бодисыг хэрэглэхийг Японд ч бас хориглосон байдаг. Нөгөө талаар, илэрсэн нь формалдегид байсан гэх яриа бас сонссон. (Улаанбаатарын махны үйлдвэр).

4) Үйлдвэрлэгчдэд түшиглэсэн сүү цуглуулах бүлэг байгуулах

Энд дурьдсан бүлгээр хийх бизнес нь, мөн чанартаа ХАА-н хоршоотой ойролцоо бүтэцтэй. Гэвч Монголын, ”ХАА-н хоршоо”[47]-нд хамаарагдахгүй байна. Энэ бүлэг нь хүйтэн хэлхээ бүхий орчин үеийн боловсруулах үйлдвэрт сүү нийлүүлэхийг зорилгоо болгодог, төслийн (бизнесийн) хамтрагч нь Монголын сүүний том үйлдвэрлэгч компанийн нэг юм. Энэ хамтарсан бизнест хамрагдсан үйлдвэрлэгч нь найдвартай зах зээл (нийлүүлэх үйлдвэр)-тэй болох боломжтой бөгөөд хамтрагч сүүний үйлдвэр нь цуглуулсан сүүг баталгаатай авна. Мөн засгийн газраас хэрэгжүүлж байгаа сүү нийлүүлэгчдийг дэмжих мөнгө[48] нь зөвхөн албан ёсны үйлдвэрт өгч байгаа саальчинд өгч байгаа ба энэ бүлгийн (хоршооны) гишүүн бол энэ нөхцөлд хамрагдана. Монголд анхны бүлгийн төсөлд зориулсан “сүү цуглуулах цэг”-ийг 2020 онд Төв аймагт байгуулагдсан (Зураг 2.31) ба өнөөг хүртэл уг сүүний үйлдвэрээс 12 газарт ийм маягийн цэг байгуулаад байна. Уг компанийн удирдлагын яриагаар бол 2023 оноос хойш нэмж 10 газарт шинээр сүү цуглуулах тоноглогдсон цэг байгуулахаар төлөвлөж байгаа юм байна.

Зураг 2.31 Үйлдвэрлэгчид ашиглах сүү цуглуулж хөргөх цэг (зүүн), Нээлтийн ёслол (баруун)

5) Гэрийн тэжээвэр амьтны хоол үйлдвэрлэлийн боломж

Саяхнаас гэрийн тэжээвэр амьтдын хүнсний үйлдвэрлэлд бүтээгдэхүүний төрөл зүйл, чанарыг сайжруулах тал дээр маш их анхаардаг болжээ. Тухайлбал Японд дээр үед ГТА-ны хоол тэжээлээр ашиглаж байгаагүй малын дайвар бүтээгдэхүүнүүд (шөрмөс, туруу, эвэр г.м) одоо супермаркетийн нэг буланг эзлэн зарагдаж, хүн идэхэд ямар ч асуудалгүй, харшил үүсгэдэггүй ГТА-ны эрүүл мэндийн хүнс хүртэл худалдаалагдаж байна[49]. Монголд одоогоор ийм дэлгүүр харагдахгүй байгаа ба МАА-н орны давуу талаа ашиглан ГТА-ны хоол тэжээлийн материал нийлүүлэгч болох боломж туйлын их байгааг салбарын холбогдох хүмүүс баталж байгаа[50]. Монголд ч гэсэн жижиг боловч ГТА-ны хоол тэжээл боловсруулалтыг дагнан хийдэг үйлдвэр энд

[47] З.Золзаяа. 2006. Монголын ХАА-н хоршооны өнөөгийн байдал ба шаардлага. ХАА-н менежментийн судалгаа **44**: 178-182.
[48] Нийлүүлсэн сүүний 1 литр тутамд 450 төгрөг олгож байгаа
[49] Улсын хэмжээний ГТА-ны хоол тэжээл хэрэглийн холбооны судалгаа
[50] Улсын хэмжээний ГТА-ны хоол тэжээл хэрэглийн холбооны гүйцэтгэх захирал Монголд айлчлах үеийн уулзалт

тэнд үзэгдэж эхэлж, 2020 оны гаалийн мэдээнээс үзвэл анх удаагаа “Монголд үйлдвэрлэсэн ГТА-ны хоолны экспортын хэмжээ” гэсэн жагсаалт гарсан байна. Хүснэгт 2.11-д үзүүлсэнчлэн экспортын барааны төрөл зүйл нь төдий л олон биш ч гэсэн өсөх хандлагатай байгаа тул цаашид анхаарах ёстой үйлдвэрлэл гэж болно.

Хүснэгт 2.11 Монголд үйлдвэрлэсэн ГТА-ны хоолны экспортын өсөлт

2020 он	2021 он	2022 он (эхний хагас жил)
69,252 kg	106,310 kg	85,287 kg

Эх сурвалж: ТЕГ-ын мэдээлэлд үндэслэн ЖАЙКА төслийн баг боловсруулав.

(3) Махны нийлүүлэлтийн сүлжээний асуудал ба авах арга хэмжээ

Өмнө дурьдсанчлан Монгол Улсын мах, сүүний нийлүүлэлтийн сүлжээ нь тухайн орны уламжлал, соёлтой нягт холбоотой бөгөөд зөвхөн нийлүүлэлтийн сүлжээг бизнес гэдэг үүднээс авч үзэх боломжгүй хүчин зүйл ч олон бий. Жнь: мал сүргийн хурдацтай өсөлтөөс үүдэлтэй бэлчээр талхагдлын асуудал нь одоо ч гэсэн ихэнх үйлдвэрлэгчид (=малчид) байгалийн бэлчээрт түшиглэсэн хэвээр байгаагийн дээр мах, сүүний нийлүүлэлтийн сүлжээний хувьд ч туйлын чухал асуудал гэж болно. Гэсэн хэдий ч энэ асуудлыг үйлдвэрлэл, боловсруулалтыг сайжруулах нийлүүлэлтийн сүлжээний техникийн асуудалтай ижил түвшинд авч үзэх боломжгүй гэж үзэж байна. Үүний нэгэн адил одоо ч гэсэн олон жижиг үйлдвэрлэгч, боловсруулагчдын хувьд ердийн гэрийн /уламжлалт/ муулгах арга хэвээрээ байгаа, энэ нь нийлүүлэлтийн сүлжээг бий болгоход эрүүл ахуйн менежментийг сайжруулах талаасаа муу уламжлал гээд нэг мөр устгая гэх хандлага бол яавч бодитой арга хэмжээ байхгүй. Ингэхээр, энд мах сүүний нийлүүлэлтийн сүлжээнд ялангуяа бизнес болгох зорилготой тохиолдолд асуудал ба авах арга хэмжээнд төвлөрч өгүүлье. Түүний агуулгыг Хүснэгт 2.12-т нэгтгэв. Хүснэгтэд (*) тэмдэгтэй байгаа арга хэмжээний тухай хойно өгүүлэх “Хөгжлийн хөтөлбөр” (4-р бүлэг)-ийн дотор ч бас түүний бүрэлдэхүүн хэсэг багтсан байгаа болно.

Хүснэгт 2.12 Мах сүүний нийлүүлэлтийн сүлжээний тулгамдсан асуудал ба авах арга хэмжээ

Үе шат	Асуудал	Арга хэмжээ
Орц	• Малчин, тоног хэрэгсэл нийлүүлэгчийн харилцаа холбоо муу • Хот орчмын бүсийн бэлчээрийн хомсдол, талхагдал • Үйлдвэрлэлийн хэрэгслийн ханган нийлүүлэлтийн тогтолцоо тогтворгүй (ялангуяа эрчимжсэн МАА-д шаардлагатай тэжээлийн эх үүсвэр,материал г.м)	• Малчдыг нэгдсэн зохион байгуулалтад оруулж худалдаа арилжааны хамтарсан систем байгуулах боломжийг судлах* • Бэлчээр ашиглалтыг захиргааны аргаар шийдвэрлэх (малын татварын хуулийг хэрэгжүүлэх г.м) • Дотоодын нийлүүлэлтийн тогтолцоо байгуулах
Үйлдвэрлэл	• Улирал, уур амьсгалаас шууд хамааралтай байдал (ялангуяа нүүдлийн МАА) • Үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийг цуглуулах тогтолцоо бүрдээгүй (мах сүүний аль аль нь албан ёсны үйлдвэрт нийлүүлэх хэмжээ бага байгаа нь хамгийн том шалтгаан) • Үйлдвэрлэгчийн боловсруулалтын түвшин муу (ялангуяа дайвар бүтээгдэхүүн ашиглалт	• Улирлын хамаарлаас үл шалтгаалах үйлдвэрлэл (бэлтгэл) боловсруулалтын тогтолцоо, нөөцлөх агуулах байгуулах замаар нийлүүлэлтийн хэмжээг жигдрүүлэх * • Үйлдвэрлэгчдийг зохион байгуулалтад оруулах, үйлдвэрлэгч ба сум, хоршоо болон ААН-ийн нийлүүлэлтийн нэгдсэн тогтолцоо байгуулах* • Хэрэгцээ шаардлагатай уялдуулан шинэ арга

Үе шат	Асуудал	Арга хэмжээ
	муу) • Бүтээмж муу (ялангуяа хурга бордох, сүүний ферм хэлбэрийн аж ахуйн хувьд)	техникийн сургалтын тогтолцоо байгуулах (Засгийн газар болон хандивлагчидтай хамтрах)* • ААН, албан секторын судалгааны байгууллага болон их сургуулиудтай хамтарсан судалгааны ажил хийж маллагааны арга болон сүрэг сайжруулалт хийх гэх мэт *
Боловсруулалт	• Улирлын хамаарал их тул жилийн турш жигд үйлдвэрлэл эрхлэх нөхцөл бүрдээгүй • Эрүүл ахуйн хяналт, чанарыг сайжруулах талаар ойлголт тааруу (ялангуяа алс зайнаас нийлүүлэлт хийдэг сүлжээ болон экспортын бүтээгдэхүүнд онцгойлон анхаарах шаардлагатай) • Үйлдвэрлэлийн шинэ технологи нэвтрүүлэх чадвартай боловсруулах үйлдвэрлэгч цөөн (хурганы мах болон ГТА-ны хоол тэжээл үйлдвэрлэл зэрэг)	• Шинэлэг хэвээр нь хадгалах агуулахын тоног төхөөрөмж, технологи нэвтрүүлэх* • Хууль журмын дагуу эрүүл ахуйн хяналтын тогтолцоог сайжруулах, зэрэглэх системийг нэвтрүүлэх замаар мах, сүүн бүтээгдэхүүнийн чанарыг сайжруулах * • Хэрэгцээ шаардлагатай уялдуулан шинэ арга техникийн сургалтын тогтолцоо байгуулах (Засгийн газар болон хандивлагчидтай хамтрах боломжийг судлах)*
Тээвэр ложистик	• Ложистикийн систем бүрдээгүй (ялангуяа аймаг алгасах тохиолдолд) • Ложистикийн дийлэнхи нь дундын зуучлагч (ченж)-аас хамааралтай, худалдаа арилжааны ил тод байдал дутмаг (ялангуяа малчдаас цуглуулах түвшинд)	• Үйлдвэрлэгчдийг зохион байгуулалтад оруулах, үйлдвэрлэгч ба сум, хоршоо болон ААН-ийн нийлүүлэлтийн нэгдсэн тогтолцоо байгуулах *
Худалдаа, хэрэглээ	• Нийлүүлэлтийн эх үүсвэр хэт ихэссэн төлөв байдал (хэт олширсон малын тоо улам өссөөр байгаа) • Зохистой харьцааны дутагдал (гадаад улсуудад Монголын МАА-н зарим бүтээгдэхүүний хэрэгцээ байгаа нь тодорхой болсон ч ААН хоорондын мэдээлэл солилцох боломж цөөн байгаа) • Засгийн газраас Монголын бүтээгдэхүүнийг сурталчлах чиглэлийн дэмжлэгийн тогтолцоо дутагдалтай	• Малчдын малын тооны хяналт (ялангуяа ямаа) болон бэлчээр хамгаалах талаар суртал ухуулгын ажил хийх • Олон тооны мал хэрэглэж МАА-гаас бүтээгдэхүүн гаргах бизнесийг буй болгох (ялангуяа хонь, ямаа)-г засгийн газар, хувийн сектор хамтдаа дэмжих * • Засгийн газраас Монголын МАА-н бүтээгдэхүүний сурталчилгааг сайтар хийх *

Эх сурвалж: ЖАЙКА төслийн баг боловсруулав.

(4) Хөгжлийн чиглэл

Өмнө дурьдсанчлан мах сүүний нийлүүлэлтийн сүлжээг буй болгох, эсвэл одоо байгаа сүлжээг улам бататгах чиглэлийн талаар өгүүлнэ. Энэ санаанд үндэслэн гаргасан SWOT шинжилгээг доор үзүүлэв.

Мах,сүүний нийлүүлэлтийн сүлжээний SWOT шинжилгээ	Гадаад орчин	
	Боломж ● Эко хошуурлын энэ цаг үед бэлчээрийн малын мах, махан бүтээгдэхүүн үнэд хүрнэ. ● Монгол хурганы махыг шинэ технологи ашиглан боловсруулах боломжтой болсон. ● ГТА-ны хоол тэжээлийн үйлдвэрлэл дэлхийн хэмжээнд нэмэгдэж байгаа ч үхэр гахай,шувууны гаралтай түүхий эд илүүдэж байхад бусад малын махны хэрэгцээ нэмэгдэнэ.	**Аюул** ● Далайн чанадаас гаралтай халдварт өвчин (шүлхий г.м) дэлгэрснээс болж экспорт зогсох ● Салбарын тогтворгүй байдал (ялангуяа ГТА-ны хоол тэжээлийн салбарын чиг хандлага)
Дотоод орчин **Давуу тал** ● Малын тоо толгой, төрлийн хувьд нэн арвин нөөцтэй (адуу,үхэр, хонь, ямаа,тэмээ) ● Харьцангуй хямд үнэтэй ● Тэмээний мах сүү,сарлагийн сүү, хонины өлөн нь дэлхийн хэмжээнд ховор,сонин бүтээгдэхүүнд орно ● Ялангуяа малын дайвар бүтээгдэхүүн нь үндсэндээ үнэгүй шахам	**Давуу тал*боломж** ● **Талын бэлчээрээр таргалсан Монгол малын эко бүтээгдэхүүний үнэ цэнийг нэмэгдүүлэх** ● **Монголд хамгийн элбэг байгаа мал аж ахуйн нөөц(хонь)-ийг их хэмжээгээр боловсруулж экспортлохыг дэмжих** ● **МАА-н элбэг баян нөөц (ялангуяа хонь, ямаа, адуу)-ийг ашиглан улам бүр эрэлт нь нэмэгдэж байгаа ГТА-ны хоол тэжээлийн үйлдвэрлэлд хувь нэмэр оруулах.**	**Давуу тал *аюул** ● **Боловсруулах үйлдвэрт технологийн шинэчлэл хийж, төрөлжсөн бүтээгдэхүүний үйлдвэрлэл, төрөл бүрийн эрэлтэд уян хатан зохицох** ● **Эрүүл бүсчлэлийг *хөгжүүлж, бүтээгдэхүүний чанарыг баталгаажуулах (* эрүүл бүсийг тусгаарлан МАА-н үйлдвэрлэл эрхлэх)**
Сул тал ● Түүхий эдийн бэлтгэл нь хэт улирлын хамааралтай ● Үйлдвэрлэгч(ихэнх нь малчид) нь өргөн уудам нутагт тархан суудаг тул түүхий эд бэлтгэл нь үр ашгийг бууруулдаг ● Үйлдвэрлэлийн шинэ арга барил, боловсруулах шинэ аргад суралцах үйлдвэрлэгч,мэргэжлийн ААН нөөн ● Хилийн чанадаас гаралтай халдварт өвчин(шүлхий г.м) нутагшсан газар их ● Дайвар бүтээгдэхүүн хэрэгцэх тохиолдолд ялангуяа нядалгааны газраас авах нь дийлэнх бөгөөд, анхан шатны боловсруулалт муу тул бүтээгдэхүүний үнэ цэнийг бууруулах тохиолдол их ● Монголын МАА-н бүтээгдэхүүнийг сурталчлах ажиллагаа сул	**Сул тал*боломж** ● **Боловсруулалтын горимыг өөрчлөн, тохируулах, хадгалах аргыг сайжруулах замаар жилийн турш жигд үйлдвэрлэл явуулахыг зорих.** ● **Үйлдвэрлэл, боловсруулах үйлдвэрийн тоног төхөөрөмжийн шинэчлэл, судалгаа хөгжил, зах зээл тэлэх үйл ажиллагааг торийн бодлогоор дэмжих (бага хүүтэй зээл олгох, судалгааны тогтолцоо нэвтрүүлэх г.м).**	**Сул тал *аюул** ● **Малчин, нядалгааны газар, боловсруулах үйлдвэрийн уялдаа холбоог бэхжүүлэх (нөхцөл байдалтай уялдуулан хоршоог хамруулах)** ● **Үйлдвэрлэгчдийг зохион байгуулалтад оруулах(кластер)-ыг бодлогоор дэмжиж засгийн газрын оролцоотой төр,хувийн хэвшлийн түншлэлээр үйлдвэрлэлийг хөгжүүлэхийг эрмэлзэх** ● **Засгийн газар, үйлдвэрлэлийн кластерын оролцоотойгоор Монголын бүтээгдэхүүнийг сурталчлах тогтолцоо байгуулах**

Зураг 2.32 Мах сүүний нийлүүлэлтийн сүлжээний тухай хөндлөнгийн SWOTшинжилгээ

Эх сурвалж: ЖАЙКА төслийн баг боловсруулав.

Дээрх SWOT шинжилгээнд үндэслэн мах сүүний нийлүүлэлтийн сүлжээг бэхжүүлэх тодорхой чиглэлийг доор үзүүлэв.

1) **Стандартын дагуу боловсруулсан, чанарын шаардлага хангасан МАА-н бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэхэд чиглэсэн дэмжлэгийн тогтолцоо бүрдүүлж хэрэгжүүлэх**

Дотоодын хэрэгцээнд нийлүүлэх, эсвэл экспортын шаардлагаас үл хамааран, өргөжин тэлж буй нийлүүлэлтийн сүлжээнд бүтээгдэхүүний чанарын хяналт туйлын чухал юм. Иймд стандартын дагуу үйлдвэрлэсэн мах, сүүн бүтээгдэхүүний хэмжээг нэмэгдүүлэх явдал тулгамдсан асуудал бөгөөд ялангуяа экспортлох бол зайлшгүй шаардлага мөн. Тиймээс аль болох олон үйлдвэрлэгч (бэлтгэн нийлүүлэгч) стандартын дагуу нийлүүлэх, боловсруулах үйлдвэрлэгч аль болох их мах сүү хүлээн авахад чиглэсэн дэмжлэг урамшууллыг засгийн газраас хэрэгжүүлэх. Одоогоор стандартын дагуу нийлүүлсэн сүү үйлдвэрлэгч (саальчид, малчид)-д урамшуулал өгч байгаа тогтолцоог маханд бас хэрэглэх, түүнчлэн боловсруулах үйлдвэрт хүчин чадлаа нэмэгдүүлэх шинэ хөрөнгө оруулалт хийхэд нь татвараас чөлөөлөх арга хэмжээ авч хэрэгжүүлэх.

2) **МАА-н зарим тухайлсан бүтээгдэхүүнд урамшуулал, хөнгөлөлттэй зээл олгох тогтолцоо бүрдүүлэх**

Хэт олширсон малын тоог бэлчээрийн даацад тохируулан цөөлөх арга хэмжээ авах[51], ялангуяа өсөлт ихтэй ямаа, хонины /махны/ нийлүүлэлтийн сүлжээг бэхжүүлэхийг засгийн газраас урималах, Энэ урималгыг дэмжиж ажилласан бэлтгэн нийлүүлэгч малчин, боловсруулагчдад татаас

[51] Социализмын үед 20-30 сая толгойд хэлбэлздэг байсан бол одоо 70 саяыг давсан байна. 40-50 сая байх нь зохистой байх.

олгох, эсвэл энэ чиглэлийн бизнесээ өргөжүүлэхэд хөнгөлөлттэй зээл олгох. Түүнчлэн ямааны хувьд нэгжээс авах ноолуураа нэмэгдүүлэхийн тулд өтөл болтол нь маллах хандлагатай байна. Гэтэл, хөгшин ямааны ноолуурын чанар мууддаг (микрон нь бүдүүрдэг) нь тодорхой болсон тул 4-с дээш настай ямаагаа нядалбал татаас олгох тогтолцоо байж болох эсэхийг ч судлах шаардлагатай.

3) МАА-н бүтээгдэхүүний тогтвортой үйлдвэрлэлийн талаар ухуулга сурталчилгаа хийх, шинэ арга технологийн сургалт зохион байгуулах

Олон үйлдвэрлэгч (бэлтгэн нийлүүлэгч-малчин) уламжлалдаа тулгуурласан нүүдлийн МАА эрхэлж байгаа ба малын тооны хэт өсөлт, шинэ гарч байгаа өвчинтэй тэмцэх шаардлагын улмаас шинээр сурах шаардлагатай зүйл ч олон бий. Өмнө өгүүлсэнчлэн хурга бордох, ГТА-ны хоол үйлдвэрлэх, түүнчлэн стандартын дагуу нийлүүлсэн бол шинэ салбарт хамруулах, нийлүүлэлтийн сүлжээний тоглогчийн хувьд сурч мэдвэл зохих технологи, мэдээлэл их бий. Тиймээс ХХААХҮЯ, МЭЕГ-ын ИТА-нууд ХААИС, ХАА-н инженерүүдийн холбоо, МАА, сүүний чиглэлийн ААН-д хамтран сурталчилгаа, технологийн заавар боловсруулж, тараах, мөн технологийн сургалт, сурталчилгааг тасралтгүй хийх.

4) Монголын МАА-н түүхий эд ашигласан бүтээгдэхүүн хөгжүүлэлтийг дэмжин сурталчлах үйл ажиллагааг өргөтгөхөд чиглэсэн дэмжлэг (ялангуяа гадаад зах зээлд)

SWOT шинжилгээнд дурьдсанчлан, Монголын МАА-н бүтээгдэхүүн нь дан өвсөн тэжээлтэй байдаг, түүнчлэн сарлагийн болон ингэний сүү нь нэн өндөр үнэ цэнэтэй бүтээгдэхүүн боловч одоогоор танигдсан бүтээгдэхүүн болж хөгжөөгүй байна. Энэ тал дээр “Монголын МАА-н гаралтай бүтээгдэхүүн” сурталчилгаа дутмаг, шинэ бүтээгдэхүүний хөгжүүлэлт хангалтгүй байдгийг MONMAP-AVC төслийн хүрээнд явуудсан бизнесийг холбох үйл ажиллагааны явцад тодруулсан. Тухайлбал, адууны махаар хийсэн ГТА-ны хоолны дээжийг Японы ГТА-ны хоолны чиглэлийн байгууллагад явуулахад ихээхэн сонирхож тус байгууллагаас үзэсгэлэн худалдаанд тавьж үзсэнд хэд хэдэн компани авах хүсэлтэй байсан байна. Улмаар тухайн байгууллагаас адууны дайвраар шинэ бүтээгдэхүүн хийх санал ирж, захиалгат үйлдвэрлэлээр эхлэх шатандаа яваа ба энэ мэт бизнесийг холбох ажлыг өргөтгөх сурталчилгаа болон шинэ бүтээгдэхүүн хөгжүүлэхийг засгийн газраас системтэйгээр дэмжих боломжийг судлууштай.

2.3.5 Хонины ноос

(1) Хонины ноос нийлүүлэлтийн сүлжээний өнөөгийн байдал

Хонины түүхий ноос бол малчин өрхөөс бэлтгэн нийлүүлдэг мал аж ахуйн бүтээгдэхүүний дотор хамгийн хямд үнэтэй нь. Бусад малаас бэлтгэдэг, тухайлбал ямааны ноолуур, тэмээний ноостой харьцуулахад үнийн хувьд эрс ялгаатай. Мөн монгол хонины хувьд нэг хониноос гарах ноосны гарц маш доогуур. Монгол хонь бие бялдрын хувьд ерөнхийдөө жижиг, эрчимжсэн мал аж

ахуйд тэжээдэг тусгай үүлдрийн хониноос жингийн хувьд бага байдаг нь ноосны гарцын хамгийн том шалтгаан гэж хэлж болох бөгөөд ноосны чиглэлийн корридейл хонины нэг толгойгоос 4-6 кг ноос авах боломжтой байдаг бол[52] ердийн монгол хонины ноос ±1 кг/толгой байдаг нь маш бага үзүүлэлт. Энэ үзүүлэлт, дан махны үүлдэр гэгддэг southdown, өөрөөр хэлбэл ноосны гарц багатай үүлдрийн хониноос авах ноосны хэмжээ болох 2.25 кг/толгой-гоос ч доогуур байгаа юм. Мөн ердийн монгол хонины ноос нь ноосны чиглэлийн миренос хоньтой харьцуулахад ерөнхийдөө эслэг нь бүдүүвтэр, зах зээлд борлуулалт бага байх хандлагатай гэж тэмдэглэгдсэн байдаг[53]. Энд онцлон хэлэхэд, ноосны ач холбогдлын тухайд, монголчууд хонь бол мах бэлтгэлийн зориулалттай, ноос бол түүний дайвар бүтээгдэхүүн гэх өнгө аяс зонхилж ирсэн бөгөөд энэ талаараа ямаа, түүний ноолуур хоёрын учир холбогдолтой харьцуулахад ихээхэн ялгаатай. Ялангуяа орчин үеийн Монголд, ямаа өсгөхийн гол шалтгаан нь мах биш, ноолуур бэлтгэхэд гол зорилго оршдог гэхэд болно. Нөгөө талаар зөвхөн ноосны чиглэлийн хонь үржүүлэх боломжгүй гэдэг нь ч бодит нөхцөл юм.

Өмнө өгүүлж буй хэлэлцүүлэгт үндэслэн, хонины ноосны нийлүүлэлтийн сүлжээний өнөөгийн байдлыг тоймлон авч үзье. Монгол дахь хонины ноос үйлдвэрлэлийн хэмжээ 2012 онд 17,486 тн байсан бол түүнээс 10 жилийн дараа 2021 онд 33,199 тн болж нэмэгджээ[54]. Энэ нь 52%-иар өссөн үзүүлэлт, харин хонины толгой тутмаас авах 1 кг/толгой гэсэн ноосны гарц өөрчлөгдөөгүй байгаа учир энгийнээр бодоод хонины тоо толгой өссөн нь гол шалтгаан гэж хэлж болно. Малчдын бэлтгэсэн түүхий ноос ченжийн гараар дамжин, ноос боловсруулах үйлдвэрт хүргэгдэж, ангилан ялгалт, угаалт, хатаалт, хусалт, самналт, ээрэлт зэрэг шат дамжлагаар дамжин, эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэгддэг. Монгол Улсад хонины ноос боловсруулах 360 үйлдвэр ажилладаг гэдэг ч, жилдээ 1,000 тн-оос дээш ноос боловсруулах чадалтай үйлдвэр цөөн, 10-хан үйлдвэр бий. Боловсруулж буй бүтээгдэхүүн нь зориулалтын хувьд, материалын төрлийн нэхмэл, ноосон утас, эсгийнээс эхлээд бэлэн бүтээгдэхүүн тухайлбал, хувцас, хивс, гутал г.м олон янз байдаг. Сүүлийн үед барилгын дулаалгын материал, тээвэрлэлтийн сав, баглаа боодлын зориулалт бүхий материалын хөгжүүлэлт, үйлдвэрлэлийн үйл явцад ахиц дэвшил гарч байна, түүнээс гадна ноос ашиглаж органик бордоо үйлдвэрлэх, худалдах үйл ажиллагаа явагдаж байна.

[52] Ямамото Мики, 2016, Японы ноосны судалгаа. Япон хонь 18.
[53] Монгорү цүүшин. 2019 он, дугаар 726, 5-р нүүр.
[54] https://www.1212.mn/en



Зураг 2.33 Ноосны нийлүүлэлтийн сүлжээний өнөөгийн байдал

Эх сурвалж: ЖАЙКА төслийн баг боловсруулав.

(2) Хонины ноосны зах зээлийн орчин

2022 онд түүхий ноосны үйлдвэрлэлийн нийт хэмжээ 34,900 тн байсныг дээр өгүүлсэн. Малчны хотонд бэлтгэсэн түүхий ноос нь ченжээр дамжин ноос угаах үйлдвэрт хүргэгдэж, тэнд ангилан ялгах, угаах, хатаах боловсруулалт хийгддэг. Эдгээр шат дамжлагын эцэст угаагдсан ноос гарч ирэх бөгөөд түүхий ноосноос угаагдсан ноос бий болох гарцын хэмжээ 55%-тай байдаг[55]. Энэ үзүүлэлтээр авч үзвэл, 34,900 тн түүхий ноосноос 19,195 тн угаасан ноос гарна гэсэн үг. Монголд хусах, самнах шатны боловсруулалт хийлгүйгээр угаасан ноосоо тэр чигээр нь экспортод гаргах явдал маш их, тухайлбал 2022 оны гүйцэтгэлээр 17,569 тн[56] ноос буюу нийт ноосны 90% нь гадаадад экспортлогдож, үлдсэн хэсэг нь дотоодод борлуулагдсан тооцоо гарсан[57] байна. Мөн дотоодод үйлдвэрлэгдсэн хагас боловсруулсан бүтээгдэхүүн (хусалт, самналт хийгдсэн ноос, ээрсэн утас г.м.) болон эцсийн бүтээгдэхүүн (хивс, эсгий бүтээгдэхүүн г.м) ч экспортод гардаг, эдгээрээс үзэхэд Монгол Улсын хонины ноосны зах зээл ерөнхийдөө гадаад зах зээлд түшиглэж байгаа нь өнөөгийн бодит байдал юм гэж хэлэхэд хилсдэхгүй.

Угаасан ноос болон хагас боловсруулсан бусад бүтээгдэхүүний экспортын хэмжээ болон экспортод гаргасан улс орнуудыг Хүснэгт 2.13-аар харуулав. Угаасан ноос, самнаж боловсруулсан ноосыг ерөнхийдөө цөмийг нь зөвхөн Хятад улсад экспортолж байгаа нь хүснэгтээс ойлгогдож

[55] Хөнгөн аж үйлдвэрийн судалгаа, хөгжлийн төв болон ноос боловсруулагчидтай хийсэн ярилцлага судалгаа. Угаасан ноосны гарцын тухайд түүхий ноосны үйлдвэрлэсэн газар, үйлдвэрлэгчээс хамаарч эрс тэс ялгаатай. Нийүүлэгдсэн түүхий ноос бохирдол ихтэй, ноосны урт нь жигд биш зэргээс ихэнх нь боловсруулалтад тэнцэхгүй байх явдал ч бий.

[56] HS5101-ийг үзнэ үү. Энэ код нь, нарийндаа угаагдаагүй ноосыг ч хамруулдаг, гэхдээ статистикийн тоо баримтад ноос угаах үйлдвэрээс ирүүлсэн түүхий ноосны хэмжээгээр бодож тооцсон байгаа учир угаагдаагүй ноосны харьцаа үүнээс бага хэмээн үзэж байна.

[57] Монгол Улсын Гаалийн ерөнхий газрын мэдээллээс ашиглав. Ноос боловсруулагчдын ихэнх нь зориулалтын агуулах ашигладаг, нийлүүлэгдсэн ноос үлдсэн тохиолдолд дараагийн жилд боловсруулахаар хадгалах нь ч байдаг, иймээс энд өгүүлж буй ноосны хэмжээнд өмнөх оноос үлдсэн ноос ч орсон байх боломжтой.

байна. Нөгөө талаар самнаж, ээрсэн утасны экспортын тухайд Орос тэргүүлж, Хятад дараагийн байранд оржээ. Худалдааны дундаж үнийн хувьд, боловсруулалтын хэмжээ өндөр байх тусам үнэ нэмэгддэг хэдий ч, нэгжийн үнэ хамгийн хямдтай угаасан ноосны худалдааны үнэ экспортын хэмжээнд хамгийн өндөр байгаа нь Монголын ноос ямар хямд үнээр экспортод гарч буйг бодитойгоор харуулж байна. Харьцуулсан давуу байдлын индекс (Revealed Comparative Advantage: RCA)[58]-ээс үзэхэд, угаасан ноос болон самнасан ноос нь RCA-ийн утга 1-ээс их байгаа тул харьцуулсан давуу байдалтай, харин самнаж ээрсэн бүтээгдэхүүний хувьд RCA-ийн утга 1-ээс бага байгаа учир харьцангүй давуу байдал байхгүй гэсэн үг. Өөрөөр хэлбэл, өнөөгийн байдлаар, монгол хонины ноосон бүтээгдэхүүний хувьд, бараг түүхий ноосны түвшингийн, өөрөөр хэлбэл боловсруулалтын хэмжээ нь доогуур бүтээгдэхүүнээс бусад нь экспортын чадваргүй, нэмүү өртөг шингээсэн бүтээгдэхүүний зах зээлд өрсөлдөх чадвар маш сул байна гэдэг дүгнэлтэд хүрлээ.

Хүснэгт 2.13 Монгол Улсын хонины ноосны экспортын нийт дүн (5 жилээр: 2017-2021) болон экспортлогч улс орон

Барааны нэр	Тохирлын код	Нийт (1000ам. ол)	1-р түнш (1000ам. дол)	2-р түнш (1000ам. дол)	Нэгжийн дундаж үнэ (USD/kg)	Харьцуулсан давуу байдлын индекс RCA*
Түүхий ноос	5101	Нийт: 75,501	Хятад:75,040	Энэтхэг:192	1.3	10.38
Самнасан ноос	510510	Нийт: 508	Хятад 508		4.8	6.08
Ноосон утас	5107	Нийт: 1,887	Орос:1,598	Хятад:260	42.4	0.65

Эх сурвалж: UN Comtrade-д тулгуурлан ЖАЙКА-гийн төслийн багт боловсруулав. *Revealed Comparative Advantage Харьцангуй давуу байдлын индекс.

(3) Хонины ноосны нийлүүлэлтийн сүлжээний тулгамдсан асуудал, авах арга хэмжээ

Монгол дахь хонины ноос нийлүүлэлтийн сүлжээний тулгамдсан асуудал, авах арга хэмжээний талаар Хүснэгт 2.14-өөр үзүүлэв.

Түүхий ноос үйлдвэрлэлийн тухайд өмнө өгүүлснээр, малчдын хонь өсгөж үржүүлж буй гол зорилго мах үйлдвэрлэхэд оршдог, тийм ч учраас ноосны чанарт хяналт анхаарал тавихдаа маш бага. Одоогоор түүхий ноосны 1 кг тутмын үнэ түүхий ноолуурын 1 кг тутмын үнэтэй харьцуулахад түүний 100-ны 1-тэй тэнцэх хэмжээнд байгаа бөгөөд малчид цаг зав гаргаж түүхий ноосны чанарыг хянах хүсэл эрмэлзлэл хомс байгаа ийм үед, бодит байдлыг үндсээр нь засч сайжруулахад амар биш байх болов уу. Ийм нөхцөлд, түүхий ноосны чанарыг ямар нэгэн хэмжээгээр сайжруулах шаардлага тулгарч байгаа, үүнтэй холбогдуулан илүү давуу тал бүхий ноос махны хосолсон үүлдрийг бий болгож өсгөх, ноос авахад хяргагч багаж техник нэвтрүүлэх, түүнтэй нэгэн зэрэг технологийн сургалт явуулах шаардлагатай гэж үзэж байна.

Тээвэрлэлтийн асуудлын тухайд, үйлдвэрлэлийн шатанд түүхий ноосны ангилан ялгалт хийлгүйгээр, чанарын хувьд шаардлагад нийцэх, үл нийцэх ноосыг хольж тээвэрлэдэг. Энэ нь бизнесийн хувьд ямар ч үнэ цэнэгүй түүхий ноос дэмий тээвэрлэгдэж байна гэсэн үг бөгөөд өргөн уудам нутаг дэвсгэртэй Монголын хувьд тээврийн зардлыг улам ихэсгэх шалтгаан болж байна. Энэ

[58] Экспортын өрсөлдөх чадварыг харуулах индексийн үзүүлэлт. “Аль нэг улсын экспортын нийт хэмжээнд тухайн тодорхой бүтээгдэхүүний эзлэх хэмжээ”-г “дэлхийн экспортын нийт хэмжээнд эзлэх тухайн бүтээгдэхүүний хэмжээ (=дэлхийн дундаж)”-нд харьцуулж, тухайн бүтээгдэхүүний экспортын өрсөлдөх чадварын давуу талыг тодорхойлдог. Ерөнхийдөө RCA-н утга 1-ээс их байвал харьцангуй давуу талтай хэмээн үздэг.

байдлыг засч сайжруулахын тулд ноос бэлтгэж буй тухайн газарт, түүхий ноосыг ямар нэгэн хэмжээгээр ангилан ялгах шаардлага үүсч байна. Ноос ялгалтыг малчдын хоршоод (ложистикийн компани ч байж болно) бизнес болгон ажиллаж болохуйц тодорхой бүтцийг бий болгох шаардлагатай. Бодит байдал дээр, ноос боловсруулах ихэнх үйлдвэрүүд ангилан ялгасан түүхий ноосонд дээд үнэ санал болгодог[59] хэдий ч, ченжид түшиглэн ноос бэлтгэх арга барилаар ажиллаж буй нөхцөлд, ноосны чанарыг анхаарсан бэлтгэн нийлүүлэлт хийхэд бэрхшээлтэй.

Боловсруулалт, худалдааны асуудлын тухайд, юуны өмнө үйл ажиллагааны эхний үе шат, тухайлан түүхий ноосны үйлдвэрлэл, тээвэрлэлтийн шатанд оршиж буй асуудлын уршгаар сайн чанарын түүхий ноос нийлүүлэхэд бэрхшээл учирч байгааг дурдаж болно. Мөн түүхий ноос бэлтгэн нийлүүлэх үе нь жил бүрийн зөвхөн 6-8-р сар сараар хязгаарлагддаг бөгөөд тухайн үед түүхий ноос бэлтгэн нийлүүлэлтийн өрсөлдөөн их, ялангуяа Хятадын зах зээлд ноос нийлүүлдэг ченжүүд хөрөнгө мөнгөөр дулдуйдан, ноос худалдаж авахаар Монголын бүх нутгаар давхилддагаас болж сайн чанарын түүхий ноос олж авахад улам хүндрэлтэй болдог. Мөн утас зэрэг хагас боловсруулсан бүтээгдэхүүн, улмаар хивс, эсгий эдлэл зэрэг эцсийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн тухайд боловсруулах үйлдвэрийн машин техникийн элэгдэл хуучрал, бүтээгдэхүүн хөгжүүлэлтэд ажиллах мэргэжлийн хүний нөөцийн дутагдал гэх мэт шалтгаанаар зах зээлийн олон талт эрэлт хэрэгцээг хангаж чадахгүй байх, мөн гадаадын захиалгат OEM үйлдвэрлэл ч амжилтгүй болох нь олонтаа. Монгол Улсын Засгийн газраас дэмжлэг[60] үзүүлсний үр дүнд сүүлийн жилүүдэд ноосны үйлдвэрүүдэд технологийн шинэчлэл хийгдэж байгаа хэдий ч, үйлдвэрлэлийн хамгийн эхний шатнаас түүхий ноосны чанарыг сайжруулах, аж үйлдвэрийн хүний нөөцийг бэлтгэх, ноос боловсруулах аж ахуйн нэгжид хүү багатай зээл олгох гэх зэрэг арга хэмжээ авах шаардлагатай байгаа нь өнөөгийн бодит байдал[61] юм.

Хүснэгт 2.14 Ноос нийлүүлэлтийн сүлжээний тулгамдсан асуудал, авах арга хэмжээ

Үе шат	Асуудал	Авах арга хэмжээ
Үйлдвэрлэл	• **Ноосны чанар доогуур:** Хонины үүлдрийн асуудал, мөн сүргийн бүтцэд хөгшин малын тоо олон г.м шалтгаан бий. Ноолууртай харьцуулахад үнэ цэнэ багатай, тиймээс ч ноосны чанарт тавих малчдын хяналт анхаарал сул. Гар хайчаар хяргадагаас ноосны урт жигд бус.	• Ноосны чанар сайтай хонь бий болгох • Ноос боловсруулах талаар технологийн сургалт явуулах • Цахилгаан хайч зэрэг багаж техник нэвтрүүлэх
Тээвэрлэлт	• **Түүхий ноосны ангилан ялгалт хийдэггүй:** Үйлдвэрлэлийн шатанд ангилан ялгалт (биеийн аль хэсгийнх, өнгө зэргээр) хийлгүйгээр ченжүүд тэр чигээр нь тээвэрлэдэг, боловсруулах үйлдвэрт ялгах, угаах зардал нэмэгддэг. • **Ноосны тээврийн зардал өндөр:** Хэрэглээний үнэ цэнэ муутай ноосыг хамтад нь тээвэрлэдэг. Ноосны пресслэгч байхгүйгээс тээвэрлэлтийн үр ашиг доогуур.	• Мал аж ахуйн хоршоодын ноос цуглуулах, ангилан ялгах, худалдах чадавхийг бэхжүүлэх • Мал аж ахуйн хоршоодын ноос цуглуулах агуулахыг сайжруулах, ноос шахагч пресстэй болгох • Мал аж ахуйн хоршоодод агуулахын ажиллагаа, ашиглалтын хяналт удирдагын талаар сургалт явуулах • Ноосны бодит хэрэглэгчид (ноос угаах үйлдвэр, боловсруулах бусад үйлдвэр)

[59] Ноос боловсруулах үйлдвэрт хийсэн ярилцлага судалгаанаас үзэхэд, худалдан авах үед зах зээлийн үнэ ямар байхаас хамаарах хэдий ч, ерөнхийдөө түүхий ноос худалдан авах үнэ 800-1,000 төг/кг байдаг, дээд үнийн хувьд 1,500-2,000 төг/кг орчим байдаг гэнэ.
[60] Нэр заасан компанид түүхий ноосоо худалдвал тухайн үйлдвэрлэгчид урамшуулал олгодог тогтолцоо нэвтрүүлсэн, мөн гадаадын үйлдвэрийн боловсруулах машин техник импортоор авбал импортын татварыг буулгах, чөлөөлөх зэрэг дэмжлэг бий.
[61] Монгол ноосны холбооны мэдээнээс үзвэл, 2012 оноос хойших 10 жилийн хугацаанд, Монголын дотоодын үйлдвэрүүд дэх ноос самналтын боловсруулалтын чадавхи 5 дахин нэмэгджээ (552 тн/жил→3,289 тн/жил).

Үе шат	Асуудал	Авах арга хэмжээ
		болон мал аж ахуйн хоршоодын хоорондын холбоо сүлжээг бэхжүүлэх
Боловсруулалт, худалдан борлуулалт	• **Чанар сайтай ноос нийлүүлэхэд тулгарч буй бэрхшээл:** Түүхий ноос нийлүүлэлтийн ажлыг ченж нарт түшиглэдэг, чанарын шаардлага хангасан ноос нийлүүлэх явдал хангалтгүй. Ижил компаниуд болон гадаадын ченж нартай хийх өрсөлдөөн, ноос нийлүүлэх хөрөнгө мөнгөний хүрэлцээ муу зэрэг бэрхшээл бий. • **Үйлдвэрүүдийн ашиглалтын хугацаа хязгаарлагдмал:** Ноос бэлтгэн нийлүүлэх хугацаа хязгаарлагдмал, эрэлт хэрэгцээ тогтвортой биш зэргээс хамаарч үйлдвэр ажиллах хугацаа богино. • **Боловсруулах тоног төхөөрөмжийн элэгдэл муудалт:** Боловсруулах тоног төхөөрөмж элэгдэж хуучирсан, ялангуяа гадаад зах зээлийн эрэлт хэрэгцээнд нийцсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэх боломжгүй. Ээрсэн утас, утас ээрэх тухайд стандарт хангах үйлдвэр одоогоор цөөн. • **Ноос боловсруулах салбарын аж үйлдвэрийн хүний нөөц цөөн:** Трендэд нийцсэн ноосон эдлэлийн үйлдвэрлэл хөгжүүлэлтээр ажиллах чадвар бүхий аж үйлдвэрийн хүний нөөц дутагдаж байна. Үйлдвэр улирлын чанартай ажилладгаас боловсон хүчин тогтвор суурьшилтай ажилладаггүй.	• Ноос бэлтгэн нийлүүлэх хөрөнгө мөнгөний хүртээмжийг сайжруулах • Ноосны агуулахад засвар сайжруулалт хийх, агуулахын баримтын систем нэвтрүүлэх. Эдгээрийн үр дүнд түүхий ноос болон угаасан ноосоор жилийн турш ханган нийлүүлэлт хийдэг болох. • Борлуулалтын сувгийг төрөлжүүлэх: Сайн чанарын, урт эслэгт ноосоор хийсэн бүтээгдэхүүн (ноосон хөнжил зэрэг)-ий хөгжүүлэлтэд ахиц гаргах • Ээрсэн утас, утас ээрэх салбарт хөрөнгө оруулалт хийх • Утас ээрэх компанид Олон улсын Үзэсгэлэн худалдаанд оролцоход нь дэмжлэг үзүүлэх • Бүтээгдэхүүн хөгжүүлэлтийн чиглэлээр аж үйлдвэр, төр, эрдэм шинжилгээний байгууллагын хамтын ажиллагааг дэмжих • Ээрэх компанийн тоног төхөөрөмжийн хөрөнгө оруулалтын хүү багатай зээлийн системийг өргөжүүлэх • Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн сургуулийн нэхмэлийн салбарын элсэлтэд дэмжлэг олгох тогтолцоо нэвтрүүлэх

Эх сурвалж: ЖАЙКА төслийн баг боловсруулав.

(4) Хөгжлийн чиглэл

Дээрх хэлэлцүүлэгт үндэслэн, Монгол Улсын хонины ноосны нийлүүлэлтийн сүлжээний SWOT шинжилгээний дүнг Зураг 2.34-ээр үзүүлэв. Ерөнхийдөө монгол хонины ноос нь, ширхэгийн хувьд бүдүүн, хувцас хэрэглэлд тохиромэ муутай, харин эсгий эдлэлийн үйлдвэрлэлд тохиромжтой[62]. Энэ давуу талаа ашиглан барилгын дулаалгын материал, сав баглаа боодлын материалын чиглэлээр борлуулалтын суваг хайж олох хэрэгтэй болов уу хэмээн үзнэ. Нөгөө талаар тоног төхөөрөмжийн шинэчлэл хийсэн ноос боловсруулах үйлдвэрийн хувьд, хусалт, самналт хийгдсэн түүхий эдээр өндөр чанарын бүтээгдэхүүн (ноосон хөнжил зэрэг) үйлдвэрлэхийг санал болгож байна. Хонины ноос бол байгалийн эслэг бөгөөд тогтвортой хөгжлийн зорилт (SDGs)-д зохицсон түүхий эд гэдгээрээ байгаль орчинд ээлтэй бүтээгдэхүүний үйлдвэрлэлд тус дөхөм үзүүлж, мөн үнэ ихтэй өндөр зэрэглэлийн зах зээл дээр ч өрсөлдөх бүрэн чадвартай байх магадлалтай. Нөгөө талаар, өмнө дурдсанаар бүтээгдэхүүний үйлдвэрлэлд зохих ахиц дэвшил гаргахын тулд нийлүүлэлтийн сүлжээний эхний үе шат, өөрөөр хэлбэл түүхий ноос үйлдвэрлэлийн шатнаас эхлээд тээвэрлэлт хүртэлх тогтолцоог бүхэлд нь бэхжүүлэх шаардлага зайлшгүй тулгарч байна. Ченжээр гүйцэтгүүлж буй тээвэрлэлтийг бага багаар мал аж ахуйн хоршоодод даалгаж,

[62] Монгол Улсын Хөнгөн үйлдвэрийн судалгаа, хөгжлийн төвд хийсэн судалгаагаар, монгол хонины ноосыг 80-95% нь ширхэгийн диаметр нь бүдүүн Sourse wool, үлдсэн хэсэг нь үирхэгийн диаметр нарийн Fine wool хэмээн тодорхойлсон.

хоршооны гишүүн малчдад хонь хяргах үйлчилгээ, ноос цуглуулах худалдах үйлчилгээ зэргийг бизнесийн хэмжээнд хийх чадвартай болоход нь Монгол Улсын Засгийн газрын зүгээс арга хэмжээ авах, дэмжлэг үзүүлэх шаардлагатай байна.



Зураг 2.34 Ноосны нийлүүлэлтийн сүлжээний SWOT шинжилгээний дүн

Эх сурвалж: ЖАЙКА төслийн баг боловсруулав.

2.3.6 Ноолуур

(1) Ноолуурын нийлүүлэлтийн сүлжээний өнөөгийн байдал

Ноолуур бол хүйтэн сэрүүн бүс нутагт өсгөн үржүүлдэг ноолуурын ямаанаас самнаж авдаг амьтны гаралтай үс ноосны төрөл бөгөөд хүрэхэд маш зөөлөн, дулаан хадгалах чанар өндөртэй тул дээд зэрэглэлийн түүхий эд гэдгээрээ алдартай. Ноолуур бэлтгэдэг улс орон, бүс нутгийн тоо маш цөөн тул ховор түүхий эдэд тооцогддог. Монгол Улс нь Хятадтай эн зэрэгцэн дэлхийд цөөхөнд тооцогдох түүхий ноолуур бэлтгэн нийлүүлдэг улс бөгөөд ноолуур нь малчдын хувьд бэлэн мөнгөний орлогын хамгийн чухал эх үүсвэр болдог. Мөн улс орны хувьд ч ХАА-н гаралтай экспортын хамгийн чухал бүтээгдэхүүний нэг нь ноолуур бөгөөд, гадаад худалдааны тэнцлийн үүднээс МАА-н гаралтай бүтээгдэхүүнүүдийг авч үзвэл, хамгийн ач холбогдолтой эдийн засагт үр нөлөө бүхий экспортын бүтээгдэхүүн нь зөвхөн ноолуур байдаг. МАА-н гаралтай бусад бүтээгдэхүүнтэй харьцуулахад хол давсан өндөр ашигтай, дээд зэрэглэлийн түүхий эдийн хувьд дэлхий дахинд сайшаагддаг, түүхий эдийн үйлдвэрлэлийн ихэнх хэсэг нь малчдын бичил бүрэлдэхүүнийг багтаасан уламжлалт үйлдвэрлэгчдийн гараар бий болдог зэрэг хүчин зүйлс нь зах зээлийн эдийн засагт шилжих шилжилтийн үед ядуурлыг бууруулах онцгой нөлөөтэй аврагч бүтээгдэхүүний байр суурind ноолуурыг өргөж аваачсан гэж хэлж болно[63]. Засгийн газраас ч

[63] Дэлхийн банк 2003. From goats to coats: Монголын ноолуурын салбарын институцийн шинэчлэл. Тайлан No. 26240-MOG. Songwe, V. (ed.). Дэлхийн банк групп.

ноолуурын аж үйлдвэрийн сэргэлтийг дэмжиж, дотоодод нэмүү өртөг шингээхийг нэмэгдүүлэх зорилгоор түүхий ноолуурын экспортод татвар тогтоох, экспортод хориг тавих зэрэг тогтоолууд гаргаж байв[64]. Эдгээр арга хэмжээ хэрэгжсэнээр салбарын орлого нэмэгдэж, эерэг үр дүн гарсан боловч ноолуурын салбарын хөгжил нь өөрөө малын тоо толгой огцом өсөхөд нөлөөлж, өдгөө бэлчээрийн мал аж ахуй эрхлэх суурь үндэс болсон бэлчээр талхлагдахад нөлөөлж байгаа нь цаашид ноолуурын бэлтгэн нийлүүлэлтийн сүлжээг тогтвортой хөгжүүлэхэд онцгой анхаарах асуудал болж байна.

Зураг 2.35-т ноолуурын нийлүүлэлтийн сүлжээний өнөөгийн байдлыг үзүүлэв. Хонины ноосны нэгэн адил, жилд авах ноолуурын хэмжээ нэмэгдэх хандлагатай байгаа, 2012 онд 6,326 тн ноолуур авч байсан бол энэ хэмжээ 2021 оны байдлаар 10,092 тн болж өсчээ[65]. Энэ хугацаанд ямааны тоо жилдээ 17,558-аас 26,456 толгойгоор нэмэгдэж ирсэн, мөн 1 ямаанаас авах ноолуурын хэмжээ бараг өөрчлөгдөөгүй, дунджаар 0,36 кг-0,38 кг байгаагаас үзэхэд, ноолуурын үйлдвэрлэлийн хэмжээ нэмэгдэхэд ямааны тоо толгойн өсөлт нөлөөлжээ гэдэг нь ойлгогдож байна. Ноолуур тээвэрлэлтийн хувьд ч хонины ноосны нэгэн адил худалдааны журмаар явагддаг, ганц ялгаатай тал нь түүхий ноолуурын хамгийн анхан шатны ангилан ялгалтыг малчдаар хийлгэдэг, голдуу өнгөөр (цагаан, хар, бор) нь ангилан ялгалт хийдэг. Энэ нь худалдан авах үнийг ноолуурын өнгөөр тогтоодогтой холбоотой, бас хонины ноостой харьцуулахад үнэ цэнээр 100 хувь илүү бараа гэдэг утгаар малчид ч ноолуураа ангилан ялгахад цаг заваа харамгүй зарцуулдаг тал байгаа болов уу. Гол нь ченжээр дамжуулж бэлтгэн нийлүүлсэн түүхий ноолуур хонины ноостой адилхан үе шатыг туулж, хагас боловсруулсан бүтээгдэхүүн утас, эцсийн бүтээгдэхүүн хувцас үйлдвэрлэгддэг. Түүхий ноолуурын хэмжээнд жишихэд Монголын дотоодод боловсруулах хэмжээ нь маш бага байгаа хэдий ч, ложистикийн талыг оролцуулаад хонины ноосноос илүү бэхэжсэн, мөн OEM хүлээн авч чадахуйц үйлдвэртэй гэх зэрэг талаас нь үзэхэд ноолуурын салбар илүү хүчирхэг гэж хэлж болно[66].

[64] Дэлхийн банк. 2003. *Op.cit*
[65] https://www.1212.mn/en
[66] Салбарын томоохон үйлдвэрийн нэг Эвсэг компани захиалгаар үйлдвэрлэл явуулдаг.

Зураг 2.35 Ноолуурын нийлүүлэлтийн сүлжээний өнөөгийн байдал

Эх сурвалж: ЖАЙКА төслийн баг боловсруулав.

(2) Ноолуурын зах зээлийн орчин

Өмнө өгүүлсэнчлэн, 2021 онд түүхий ноолуурын үйлдвэрлэлийн хэмжээ 10,092 тн, мөн тухайн онд Монгол Улсаас гаргасан түүхий ноолуурын (HS 510211) экспортын хэмжээ 9,129 тн гэсэн мэдээлэл байна[67]. Үүнээс үзэхэд, нийт ноолуурын 90% нь маш доогуур боловсруулалттайгаар экспортод гарч байна гэсэн үг. Мөн хонины ноосны нэгэн адил, ноолууран хагас боловсруулсан болон эцсийн бүтээгдэхүүн (хувцас г.м.) ч экспортод их гардаг, ноолуурын зах зээл ч гадаад зах зээлээс хамааралтай байгаа. Хүснэгт 2.15-д голлох ноолууран бүтээгдэхүүний экспортын нийт хэмжээ (2017-2021) болон экспортолж буй улс орныг үзүүлсэн бөгөөд боловсруулалтын түвшингээр хамгийн доогуур угаасан ноолуурын экспортын нийт хэмжээ хамгийн их, нийт экспорт бараг бүхэлдээ Хятад Улс руу гарсан байна. Нөгөө талаар хагас боловсруулсан бүтээгдэхүүн болох самнасан, бөмбөгөн ноолуурыг Итали, Их Британи зэрэг улс руу, эцсийн бүтээгдэхүүн болох хувцас (өмсгөл, кардиган г.м.)-ыг Их Британи, Өмнөд Солонгос улс руу экспортолжээ. Худалдааны нэгжийн дундаж үнээс харвал, хамгийн доогуур боловсруулалттай угаасан ноолуур гэхэд 31.1 ам.долл/кг байгаа нь хонины ноостой харьцуулахад (1.3 ам.долл/кг), өмнө бичсэнчлэн үнийн асар их ялгаатайг харуулах бөгөөд боловсруулалтын түвшин дээшлэх тутам нэгжийн үнэ өссөн байна[68]. RCA-г харвал, угаасан ноолуур болон самналт, топс боловсруулалт хийгдсэн ноолуур маш өндөр дүнтэй байгаа бөгөөд угаас олон улсын зах зээл дээр худалдаалагдаж буй угаасан ноолуурын 90% нь монгол ноолуур гэдгийг бодож үзвэл байж болох үр дүн (Ноолуур үйлдвэрлэгч гол улс болох БНХАУ-аас боловсруулалтын түвшин доогуур угаасан ноолуурын экспорт хийх нь маш ховор) юм. Мөн эцсийн бүтээгдэхүүн (өмсгөл, гадуур цамц г.м.)-ий тухайд ч 17.5 гэсэн өндөр үзүүлэлттэй

[67] Холбогдох хүмүүстэй хийсэн ярилцлага судалгаанаас үзэхэд ноолуурын хувьд статистикт тусгагдаагүй хууль буй худалдаа их байдаг гэнэ. Тиймээс статистикийн тоо баримт үнэмшил багатай байх магадлалтай.

[68] Yarn of fine animal hair нь жинхэнэдээ ноолуураас өөр хольцтой байдаг, Тийм учир арилуааны үнэ доогуур байдаг.

байгаа нь ноолууран хувцасны хувьд нэгэнт олон улсын хэмжээнд өрсөлдөх чадвартай болсныг харуулж байна.

Хүснэгт 2.15 Монгол Улсын ноолуурын экспортын нийт дүн (5 жилээр: 2017-2021) болон экспортын түнш улс орнууд

Бараа	Уялдуул Сан код	Нийт (1000 ам. дол)	1-р түнш (1000 ам. дол)	2-р түнш (1000 ам. дол)	Дундаж үнэ (1 кг/дол)	RCA*
Түүхий ноолуур	510211	Нийт: 1,278,432	Хятад: 1,278,339	Герман: 22	31.1	2,230.8
Угааж, самнасан ноолуур	510531	Нийт: 196,033	Итали:161,892	Англи: 18,570	77.9	1,749.1
Утас	5109	Нийт: 940	Орос: 314	Япон: 249	55.8	2.6
Ноолууран цамц, свитер, гадуур цамц зэрэг	611012	Нийт: 60,024	Англи:11,809	Солонгос:11,801	199.3	17.5

Эх сурвалж: UN Comtrade-д тулгуурлан ЖАЙКА төслийн баг боловсруулав. *Revealed Comparative Advantage

(3) Ноолуурын нийлүүлэлтийн сүлжээний тулгамдсан асуудал, авах арга хэмжээ

Монголын ноолуур нийлүүлэлтийн сүлжээний тулгамдсан асуудал болон авах арга хэмжээний тухай Хүснэгт 2.16-аар үзүүлэв.

Түүхий ноолуурын үйлдвэрлэлийн тухайд ямааны үүлдрийг сайжруулах хэрэгтэй гэсэн дуу хоолой их байдаг. Ноолуур нь ширхэгийн урт болон нарийны хэмжээгээр үнэлэгддэг бөгөөд сүүлийн үед монгол ямааны ноолуурын ширхэг бүдүүрэх хандлагатай байгаа, түүнийг ямааны үүлдрийн сайжруулалтаар засч болно гэсэн санал[69] бий. Ноолуурын чанар муудаж байгаа ийм үед шилэн сонголт хийж асуудлыг шийдвэрлэх нь яаралтай арга хэмжээ гэж хэлж болох ч, монгол ноолуурын ширхэглэгийн тогтсон үнэлэмж болсон туяатай өнгө болон уртын хэмжээ зэргийн талаар ярилгүйгээр монгол ямаан сүргийн нэгэнт бүрдсэн сүргийн бүтцийн тогтвортой чанарыг алдагдуулж болохгүй гэдгийг анхаарах хэрэгтэй юм. Нөгөө талаар, ноолуурын ширхэг нь бүдүүвтэр болж эхэлдэг хөгшин ямаанаас ч ноолуурыг нь самнан нийлүүлдэг байдалтай байгаа бөгөөд иймэрхүү үр ашиг муудсан малыг яаж үр дүнтэй ашиглах талаар ч бодох хэрэгтэй байна.

Тээвэрлэлтийн асуудлын тухайд, дээр дурдсанчлан хөгшин ямааны ноолуурыг өндөр чанартай ноолууртай холин ачуулдаг. Түүхий ноолуурын тээвэр болон боловсруулалтын үр ашгийн талаас авч үзвэл ямааны насыг харгалзан ноолуурт ангилан ялгалт хийх, мөн худалдан авах үнийн тогтолцоог бий болгох шаардлага тулгарч байна. Тээвэрлэлтийн асуудлыг ченжид түшиглэсээр ирснийг, хонины ноосны нэгэн адил мал аж ахуйн хоршоод ноолуур цуглуулах, ялгах болон боловсруулах үйлдвэрлүү тээвэрлэх, арилжаалах зэрэг ажлыг бизнесийн хэмжээнд эрхэлдэг тогтолцоо бий болгож өөрчлөх шаардлагатай байгаа юм. Харин ноолууртай холбоотой ажил нь хонины ноосыг бодвол хүндрэл ихтэй гэдгийг бодолцох хэрэгтэй. Яагаад гэвэл ноолуурын худалдааны нэгжийн үнэ ноосны үнэтэй харьцуулахад эрс ялгаатай бөгөөд ноолуурын худалдаа

[69] Restall, B. J. 2001. USAID cashmere breeding program evaluation: Mongolia. USAID.

эрхлэхэд зохих хэмжээний хөрөнгө мөнгө, зээлийн чадвараас гадна ноолуурын чанартай холбоотой мэдлэг, олны хэлдэгээр "таних" чадвартай байх хэрэгтэй, тийм ч учраас мал аж ахуйн хоршоод ноолуурын худалдааны ажил эрхлэхдээ бодит хэрэглэгчид (ноолуур угаах болон боловсруулах үйлдвэр)-тэй нягт холбоотой ажиллах тогтолцоо зайлшгүй хэрэгтэй болно.

Ноолуурын боловсруулалт, худалдааны асуудлын тухайд тэмдэглэн хэлэх зүйл гэвэл, ноолуур боловсруулах үйлдвэрийн боловсруулалтын хүчин чадал болон үйлдвэрийн ашиглалтын хувь доогуур байгаа явдал юм. Боловсруулалтын хүчин чадлын тухайд ноолуурт самналт хийх чадвартай үйлдвэрийн тоо цөөн учир түүхий ноолуурын ихэнхийг зөвхөн угаалт хийж экспортолдог байв. Харин МУ-ын Засгийн газраас хөнгөлөлттэй санхүүжилтын тогтолцоо бий болгож дэмжсний үр дүнд 2023 он гэхэд 10,000 тн түүхий ноолуур самнах хүчин чадал бүхий боловсруулалтын тогтолцоо бий болно гэсэн мэдээлэл[70] бий. Нөгөө талаар боловсруулах үйлдвэрийн ашиглалтын хувь доогуур байгаа асуудлын тухайд, компаниуд харилцан адилгүй боловч үйлдвэрийн ашиглалтын хувь 20-60% орчим байна[71]. Үүнд хэд хэдэн учир шалтгаан бий. Боловсруулах үйлдвэрийн захиалга хүлээн авалт тогтвортой бус, түүхий ноолуур бэлтгэн нийлүүлэлтийн өрсөлдөөн их, худалдан авах хөрөнгө мөнгөний хүрэлцээ муу, эдгээрээс болж ноолуур хангалттай нөөцөлж чадаагүйгээс үйлдвэрийн ашиглалтын хугацаа богиносдог гэх зэрэг шалтгаан байгаа бололтой. Захиалга хүлээн авах хэмжээ тогтвортой бус байгаагийн шалтгаан ч боловсруулах үйлдвэрүүдэд өөр өөр, ялангуяа түүхий ноолуурын үнэ цэнэ эрс ахиж, зах зээлийн үнэ дээшилж буй энэ үед үйлчлүүлэгчийн тасалдал бий болох, ээрсэн утас болон утас ээрэгч машины элэгдэл хуучралын улмаас хэрэглэгчийн эрэлт хэрэгцээнд нийцэхүйц чанартай бүтээгдэхүүн үйлдвэрлэж чадахгүй байгааг ч дурдаж болно. Одоогийн байдлаар Монгол Улсын Засгийн газраас түүхий ноолуурын экспортыг хориглож, наад зах нь "угаасан" ноолуурын экспортыг зөвшөөрч байгаа бөгөөд дотоодод самнах хүчин чадал нэмэгдэхтэй зэрэгцүүлэн "самналт хийгдээгүй ноолуурыг экспортод гаргахгүй" байх системийг хэрэглэх талаар ч авч хэлэлцэж байгаа[72]. МУ-ын хэмжээнд дотоодод түүхий ноолуур боловсруулалтын түвшингээ дээшлүүлэх арга хэмжээ авах нь тус салбарын холбогдох хүмүүсийн хувьд жинхэнэ хүсч байсан зорилго мөн бөгөөд нөгөө талаар түүхий ноолуурын чанар сайжруулах асуудлын зэрэгцээ дэлхийн зах зээл дээрх эрэлт хэрэгцээний өөрчлөлт, ялангуяа тогтвортой, байгаль орчинд ээлтэй, амьтан хайрлаж хамгаалах гэх зэрэг олон талын агуулгыг шингээсэн бүтээгдэхүүн хөгжүүлэлтийг хийх чадавхи бүхий аж үйлдвэрийн хүний нөөцийн болон технологийн хүчин чадал хангалтгүй байгааг дурдахгүй өнгөрч болохгүй. Тэгээд ч өмнө дурдсан тогтолцооны өөрчлөлтийг хэрэгжүүлэхэд эдгээр асуудлыг тусгаж тун нухацтай авч үзэх шаардлагатай.

Хүснэгт 2.16 Ноолуурын нийлүүлэлтийн сүлжээний асуудал, авах арга хэмжээ

Үе шат	Асуудал	Авах арга хэмжээ
Үйлдвэрлэл	• **Түүхий ноолуурын чанар тогтвортой бус:** Ноолуурын чанарыг сайжруулсан үүлдэр бий болгоогүй. Ширхэгт нь аяндаа бүдүүрэх хөгшин ямаанаас ч ноолуур авч байгаа. Ширхэгтийн урт нь өөр өөр ноолуур холилдон нийлүүлэгддэг	• Сайн чанарын ноолуурын ямаа өсгөх • Үр ашиг доогуур хөгшин ямааг заазлах, хүнсэнд ашиглахыг дэмжих • Ямааны насны байдлаар түүхий

[70] https://the ubposts.com/ Монгол Улс ноолуурын салбарын хөгжлөөс нэг алхам ухарлаа/
[71] ХХААХҮЯ-ны Хөнгөн үйлдвэрийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газарт хийсэн ярилцлага судалгаа
[72] https://the ubposts.com/ Монгол Улс ноолуурын салбарын хөгжлөөс нэг алхам ухарлаа/

Үе шат	Асуудал	Авах арга хэмжээ
	бөгөөд одоогоор ноолуурын чанарт тохируулан үнэ тогтоох ажил бараг байхгүйтэй адил.	ноолуурт ангилан ялгалт хийх, ноолуурын үнийн тогтолцоо бий болгох
Тээвэрлэлт	• **Түүхий ноолуурт чанарыг нь харгалзан ангилан ялгалт хийхгүй байгаа:** Хөгшин ямааны ноолуурыг хольж ачуулдаг, ширхэгтийн уртаар өөр өөр ноолуур холилдон нийлүүлдэг бөгөөд одоогоор ноолуурын чанарыг харгалзан үнэ тогтоох ажил бараг байхгүйтэй адил. • **Түүхий ноолуурын тээврийн зардал өндөр:** Ашиглалтын үнэ цэнэ муутай түүхий ноолуурыг ч цуг тээвэрлэдэг.	• Мал аж ахуйн хоршоодын ноолуур цуглуулах, ангилан ялгах, худалдах чадавхийг бэхжүүлэх • Мал аж ахуйн хоршоодын агуулахын засвар үйлчилгээг сайжруулах • Мал аж ахуйн хоршоодод агуулахын ашиглалтын хяналт удирдлагын чиглэлээр сургалт явуулах • Ноолуурын бодит хэрэглэгчид (угаах үйлдвэр, боловсруулаах бусад үйлдвэр) болон мал аж ахуйн хоршоодын холбоо сүлжээг бэхжүүлэх
Боловсруулалт, худалдаа	• **Сайн чанарын түүхий ноолуур бэлтгэн нийлүүлэхэд хүндрэлтэй:** Түүхий ноолуур бэлтгэн нийлүүлэх ажлыг ченжид түшиглэдэг, зохих чанарын шаардлагыг хангасан ноолуур бэлтгэж чадахгүй байгаа. Ижил компуниуд болон гадны улсын ченж нартай хийх өрсөлдөөн, ноолуур бэлтгэх хөрөнгө мөнгөний дутагдал гэх зэрэг шалтгаан бий. • **Үйлдвэрийн ашиглалтын хугацаа хязгаарлагдмал:** Түүхий ноолуур бэлтгэн нийлүүлэх хугацаа хязгаартай, эрэлт тогтворгүй зэргээс үйлдвэрийн ашиглалтын хугацаа богино. • **Ноолуур боловсруулах салбарын хүний нөөцийн хомсдол:** Трендэд нийцсэн ноолууран бүтээгдэхүүн хөгжүүлэх чадвар бүхий хүний нөөц дутагдаж байгаа. Үйлдвэрийн ашиглалтын хугацаа богино, хүний нөөцийн тогтвор суурьшил муу. • **Тогтвортой чанар/ амьтан хамгаалах үзэл шингээсэн бүтээгдэхүүний үйлдвэрлэл, маркетинг:** Эцсийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл, экспортыг нэмэгдүүлэхэд анхаарах хэрэгтэй, гэвч энэ чиглэлийн хүний нөөц болон хүчин чармайлт хангалтгүй байгаа.	• Түүхий ноолуур бэлтгэн нийлүүлэх хөрөнгө мөнгөний хүртээмжийг сайжруулах • Агуулахад засвар сайжруулалт хийх, агуулахын баримтын систем нэвтрүүлэх, үүний үр дүнд түүхий ноолуур нийлүүлэлтийг жилийн турш хийдэг болох • Ээрмэл, утас ээрэх салбарт хөрөнгө оруулалт татахад дэмжлэг үзүүлэх • Ээрмэл, утас ээрэх үйлдвэрт олон улсын Ехро-д оролцоход нь дэмжлэг үзүүлэх • Бүтээгдэхүүн хөгжүүлэлтийн чиглэлээр аж үйлдвэр, төр, эрдэм шинжилгээний байгууллагын хамтын ажиллагааг хөгжүүлэх • Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн сургуулийн нэхмэлийн салбарын элсэлтэд дэмжлэг үзүүлэх тогтолцоо бий болгох • Байгаль орчинд ээлтэй, амьтны тавлаг байдалд анхаарсан бүтээгдэхүүн хөгжүүлэлтийг дэмжих, энэ чиглэлээр аж үйлдвэрийн хүний нөөц бэлтгэх

Эх сурвалж: ЖАЙКА төслийн баг боловсруулав.

(4) Хөгжлийн чиглэл

Дээрх хэлэлцүүлэгт үндэслэн Монгол Улсын ноолуурын нийлүүлэлтийн сүлжээний SWOT шинжилгээний дүнг Зураг 2.36-д үзүүлэв. Өмнө өгүүлсэнчлэн, Монгол Улс бол дэлхийд тоотой цөөн түүхий ноолуур үйлдвэрлэдэг орны нэг бөгөөд цаашид монголын ноолууран брендийн дэлхийд танигдах чадварыг дээшлүүлэхэд чиглэсэн арга хэмжээг авах, захиалгын үйлдвэрлэлийг өргөжүүлэхийн тулд тоног төхөөрөмжийн шинэчлэл хийх, үйлдвэрлэлийн шугамыг өргөтгөх шаардлагатай байгаа. Мөн сүүлийн үед ээрэх үйлдвэрийн боловсруулалтын хүчин чадал дээшилж байгааг ашиглан, хагас боловсруулсан бүтээгдэхүүн (самнасан ноолуур, ээрсэн утас)-ий үйлдвэрлэл, экспортыг нэмэгдүүлэхэд анхаарал тавих шаардлагатай. Нөгөө талаар ямаан сүрэг бэлчээр талхагдлалтын уг шалтгаан болж буй явдал нь, байгаль орчинд ээлтэй бүтээдэхүүний эрэлт

хэрэгцээ улам нэмэгдсээр байгаа орчин үед ноолуурын салбарын томоохон сул тал гэж хэлж болох бөгөөд энэ байдлыг засахын тулд малын тоо толгойг цөөрүүлэх, 1 малаас авах ашиг шимийг дээшлүүлэх арга хэмжээ шаардагдаж байна. Цаашилбал, байгаль орчинд ээлтэй бүтээгдэхүүний үйлдвэрлэлтэй холбогдуулан зохих технологи, мэдлэг эзэмшсэн аж үйлдвэрийн хүний нөөцийг бэлтгэх явдал ч зайлшгүй хэрэгтэй байна. Мөн хагас боловсруулсан болон эцсийн бүтээгдэхүүний чанарын зохих түвшинг хадгалахын тулд ченжээс хамааралтай бэлтгэн нийлүүлэлтийн тогтолцооноос ноолуурын чанарт хяналт тавих боломжтой мал аж ахуйн хоршоодоор дамжуулсан ноолуурын нийлүүлэлтийн тогтолцоонд шилжих шаардлагатай.

Зураг 2.36 Ноолуурын нийлүүлэлтийн сүлжээний SWOT шинжилгээний дүн

Эх сурвалж: ЖАЙКА төслийн баг боловсруулсан.

2.3.7 Арьс шир

(1) Арьс ширний нийлүүлэлтийн сүлжээний байдал

Бүх арьсан эдлэлийг элдсэн арьсаар хийх бөгөөд түүний түүхий эд бол махны зориулалтаар төхөөрсөн малын арьс юм. Тиймээс түүхий арьс нь махны нийлүүлэлтийн сүлжээний дайвар бүтээгдэхүүн бөгөөд үндсэндээ бүх мал төхөөрөх газар болон амьд малыг төхөөрөх газраас гардаг. Гэтэл Монголд бусад улсаас ялгаатай нь зөвхөн мал төхөөрөх газраас төдийгүй, малчин өрхөөс ч бас түүхий арьс гарна. Өөрөөр хэлбэл малчид нь зах зээлд амьд малаас гадна, өөрсдөө малаа төхөөрөөд арьс, махаа нийлүүлэх нь ч бий. Түүнчлэн амьдаар нь нийлүүлсэн мах бүгдээрээ мал төхөөрөх газарт ирж байгаа хэрэг биш. Хээрийн нядалгаагаар төхөөрөх тохиолдол ч бий гэх мэтээр албан бусаар бэлтгэгдэх малын тоо маш их, дайвар болох арьсны анхан шатны боловсруулалт, хадгалалт ихэнхдээ жигд биш, амархан муудах нөхцөлтэй байдаг. Дээрхийн улмаас Монголын арьс ширний үйлдвэрлэлийн түүхий эдийн нийлүүлэлт нь албан ёсны мал нядлах газраас болон

малчдаас ирдэг болохоор чанарын хувьд жигд бус байх нь олонтаа.

Зураг 2.37-д арьсны нийлүүлэлтийн сүлжээний схемийг харууллаа. Дээр өгүүлсэнчлэн, арьсан бүтээгдэхүүний үндсэн материал болох түүхий арьс нь малчид, ченжүүд, бойны газар зэрэг янз бүрийн замаар арьс шир боловсруулах болон арьсаар бүтээгдэхүүн хийдэг ААН-дэд ирдэг. Нийлүүлэгдсэн арьсны үсийг хяргаж, ариутгасны дараа идээлэх дамжлагад орно. Монголд арьс идээлгийн 70-75%-ийг хромон идээлэг эзэлдэг[73]. Дараа нь хөх шир чигээр нь экспортлох болон багаахан хэсгийг нь гүн боловсруулж өнгө будаг оруулж эцсийн бүтээгдэхүүн-хэтэвч, гутал зэргийг хийх тохиолдол бий ч одоогоор дийлэнхийг нь хөх арьс чигээр нь гаргаж байгаа.



Зураг 2.37 Арьс ширний нийлүүлэлтийн сүлжээний схем
Эх сурвалж: ЖАЙКА төслийн баг боловсруулав.

(2) Арьс ширний зах зээлийн орчин

Монгол Улсад 2012 онд 877 мянган ширхэг арьс нийлүүлэгдэж байсан бол энэ тоо 2021онд 1 сая 798 мянга болж 10 жилд 2 гаруй дахин нэмэгдсэн байна[74]. Нийлүүлэгдэж буй түүхий арьс нь нядалсан малын тоотой тэнцүү гэж үзвэл, адуу, үхэр, хонь, ямаа, тэмээ дараалаар тус бүр 633 мянга, 943 мянга, 9,653 мянга, 6,671 мянга, 58 мянган толгой болох ба арьсны жин нь тус бүр 10кг, 10кг, 4кг, 4кг, 12кг бөгөөд хамгийн багаар бодоход 78 мянган тонн болох ёстой ч бодит байдал дээр дөнгөж 20 мянган тонныг л боловсруулж байгаа гэнэ. 2017-2021 онд түүхий болон хөх шир хэлбэрээр жилийн дундаж экспортын хэмжээг, боловсруулах дамжлагын гарцаар тооцвол түүхий арьсны жингээр барагцаалбал 23 мянган тонн болно[75]. Ашигласан мэдээлэл баталгаагүй байх магадлалтай бөгөөд дээрх тооцоо бодит байдалд хэр нийцэх нь тодорхойгүй ч үндсэндээ бараг бүх арьсыг түүхийгээр нь,эсвэл хөх шир хэлбэрээр экспортлож байгааг харуулж байна. Түүнээс гадна

[73] JICA, 2019, Монгол улс рассет идээлгийн технологи ашигласан арьсны бренд гаргах суурь судалгааны дуусгавар тайлангаас
[74] https://www.1212.mn/en
[75] Үхэр, адуу, тэмээний түүхий ширийг хөх шир болгох явцын гарц нь 50%, хонь, ямааных 30% гэж тооцсон. Экспортын тоо хэмжээний мэдээг НҮБ-ын Comtrade-с авав.

эцсийн бүтээгдэхүүн болох хэтэвч, гутлыг ч мөн экспортлож байгаа учир арьс шир ч мөн ноос ноолуурын адил экспортын зах зээлийн төрөлжсөн бүтээгдэхүүн гэж ойлгогдож байна.

Хүснэгт 2.17-д 2017-2021 онд экспортлосон арьсны нийт үнэ болон экспортлосон улсыг сийрүүлэв. Монголоос гарсан түүхий болон ширний экспортын орлого хамгийн их, гол зах зээл нь Хятад байна. Харин бэлэн бүтээгдэхүүний тухайд Хятадаас гадна Япон, Солонгос улсууд бас гол импортлогч байна. Борлуулах үнийн тухайд түүхий болон хөх шир 0.3~1.8 ам. доллар/кг байгаа бол, боловсруулалтын түвшин нэмэгдэх тутам үнэ нь нэмэгдэж байна. RCA-с харахад ялангуяа хонь, бусад малын (ямааны арьс ороод) хөх арьс шир 37.1, 20.7 буюу үнэтэй, зах зээлд өрсөлдөх чадвартай нь харагдана. Харин бэлэн бүтээгдэхүүний хувьд 0.01~0.04 туйлын бага буюу Монголын арьс ширэн бүтээгдэхүүн нь зах зээлд өрсөлдөх чадвар бараг байхгүйтэй адил байна.

Хүснэгт 2.17 Монгол Улсаас 2017-2021 оны 5 жилд экспортлосон арьс ширний үнэ ба экспортлосон улс

Түүхий эд	Тохирлын код	Нийт (мянган USD)	1-р түнш (мянган USD)	2-р түнш (мянган USD)	Нэгжийн дундаж үнэ (USD/kg)	Харьцуулсан үзүүлэлт*
Адуу үхрийн түүхий шир	4101	Нийт: 5,978	Хятад: 5,967	Герман: 10	0.3	0.9
Бог малын арьс	4103	Нийт: 499	Америк: 305	Хятад: 70	1.4	0.6
Адуу үхрийн идээлсэн шир	4104	Нийт: 28,095	Хятад: 19,415	Итали: 4,086	1.8	3.9
Бог малын идээлсэн арьс	4105	Нийт: 9,780	Хятад: 9,087	Голланд: 212	0.9	20.7
Бог малын идээлсэн арьс	4106	Нийт: 20,797	Хятад: 9,343	Итали: 5,730	1.5	37.1
Идээлж, цардсан арьс, шир	4107	Нийт: 57	Хятад: 33	Солонгос: 19	7.3	0.00
Савхин юбка,өмд; савхин хүрэм, үнэт эдлэлийн хайрцаг, савхин хутганы гэр	4202	Нийт: 1,994	Япон: 1,066	Хятад: 402	33.7	0.01
Хувцас, бусад эдлэл, арьс орсон эдлэл	4203	Нийт: 621	Хятад: 546	Солонгос: 11	53.3	0.04

Эх сурвалж: НҮБ-ийн Comtrade-г ашиглан ЖАЙКА төслийн баг боловсруулав.*Хувь хэмжээ

(3) Арьс ширний нийлүүлэлтийн сүлжээний асуудал ба авах арга хэмжээ

Хүснэгт 2.18-д арьс ширний нийлүүлэлтийн сүлжээний асуудал ба авах арга хэмжээг сийрүүллээ.

Түүхий арьс бэлтгэлийн шатны чанар муу байгаа нь гол асуудал гэж хэлж болно. Учир нь маллагааны явцад үүсэх гэмтэл /шарх/ болон паразитад идэгдэж цоорохоос гадна нядалгааны үед арьс эсгэгдэх гэмтэл нь бүтээгдэхүүний үнэ цэнийг илэрхий бууруулдаг. Мөн өвчих, хуулах технологийн асуудал ч байна. Ховд аймгийн арьс шир цуглуулж борлуулдаг малчдын хоршооны даргын яриагаар бол, малчдын нийлүүлж байгаа арьс нь, өвчих, шулах үед зүсэгдэхээс гадна, жижигрэх тул 1 арьс 1,000 төгрөгөөс хэтрэхгүй үнэтэй, худалдан авагч олоход төвөгтэй байдаг

гэнэ[76]. Эдгээр асуудлыг шийдэхийн тулд малын арчилгаа маллагааг сайжруулах, албан ёсны нядалгааны газарт бэлтгэхэд арьс өвчих хуулахдаа гэмтээхгүй байх шаардлагатай ч нядалгааны газартай холбогдож чадахгүй малчид ч олон тул энэхүү үндсэн асуудлыг шийдэхэд төвөгтэй. Малчид өвлийн хүнсээ нөөцлөх бэлтгэх үед хоршоо нь тохирох тоног төхөөрөмжөөр төхөөрч өгдөг тогтолцоог алс хэтдээ бүрдүүлэх шаардлагатай гэж үзэж байна. Түүхий арьсны тээвэр ложистикийн шатанд бол хадгалалтын асуудал бий. Энд тэмдэглэж буй нь малчдын хувийн хүнснээс гарч байгаа арьс төдийгүй, бага оврын бойны газарт ч мөн шулсан арьсыг гадаа давхарлаж хураасан байдлаар хадгалах тохиолдол байдаг. Ийм янзаар хадгалах нь элс шороо наалдах, өт хорхой идэх зэргээр арьсны үнийг унагах шалтгаан болж байна. Арьс ширийг хаягдалгүй ашиглахын тулд дундын агуулах барих, агуулахад хадгалахдаа зохих ёсоор хураах, малчдад хүртээмжтэй байх талаас нь харахад яах аргагүй малчдын хоршоо эдгээрийг хийх тогтолцоо бүрдүүлэх нь зүйтэй байна. Боловсруулах борлуулалтын тухайд, үйлдвэрлэл, тээвэр ложистиктийн шатанд дарагдаж үрчийх гэм мэтээр сайн чанарын арьс олж авахад хүндрэлтэй байдгийг онцлож байв. Нэмж хэлэхэд Монгол Улсад түүхий арьсны 75%-ийг хромон идээлгээр боловсруулж байгаа нь маш ноцтой асуудал гэдгийг онцолж байна.

Дэлхий нийтээрээ байгаль орчинд ихээхэн анхаарах болсон, хромон идээлгийн оронд ургамлын хандан идээлгийг илүүд үзэж байгаа учраас ялангуяа экспортлох зорилгоор элдэж буй бол, идээлэх үйлдвэрийн хаягдал усны шүүлтийг сайжруулах зэргээр байгаль орчныг хамгаалахад чиглэсэн идээлгийн технологи болох ургамлын хандаар хийсэн идээлэг хэрэглэх нь ашигтай[77]. Тиймээс Монгол Улсын арьс ширний үйлдвэрлэлийн салбарт байгаль орчинд ээлтэй идээлгийн технологи нэвтрүүлэх, түүнийг гардан хийх хүний нөөцөө сургах шаардлагатай байна.

Хүснэгт 2.18 Арьс ширний нийлүүлэлтийн сүлжээний асуудал ба авах арга хэмжээ

Дамжлага	Асуудал	Арга хэмжээ
Үйлдвэрлэл	• **Түүхий арьсны чанар муу:** Механик гэмтлээс гадна паразит идэж нүхэлснээс түүхий арьсны хорогдол туйлын их байгаа нь бүтээгдэхүүний үнэ цэнийг бууруулдаг байдал. • **Зүсэх хуулах технологи муу, түүхий арьсыг жижигрүүлдэг:**Мэргэжлийн технологи эзэмшээгүй малчин арьс бэлтгэхдээ зүсэж, хуваадаг нь арьсны үнэ унагах шалтгаан болж байна.	• Зохистой арчилгаа маллагаа, паразитаас хамгаалах арга хэмжээ авах • Нядалгааг мэргэжлийн ААН хийх, малчдын хоршоо нь хүнс бэлтгэх үйлчилгээний тогтолцоо буй болгох
Тээвэр, ложистик	• **Түүхий арьсны хадгалалт муу:** Цуглуулсан арьсаа ил задгай хураах явдал түгээмэл, тэр нь хог шороо шигж бүтээгдэхүүний үнийг бууруулах шалтгаан болдог.	• Түүхий арьс ширний дундын агуулах байгуулах,үүнийг малчдын хоршоо,эсвэл ложистикийн ААН хариуцдаг байх нь зүйтэй.
Боловсруулах, борлуулах	• **Сайн чанарын арьс бэлтгэхэд хүндрэлтэй:** Бэлтгэл, тээвэрлэх шатны хяналт муу тул чанартай түүхий арьс бэлтгэхэд хүндрэлтэй байдаг. • **Арьсны ашигтай гарц бага:** Бэлтгэл, тээвэрлэх шатны хяналт муу тул бүтээгдэхүүн бололгүй гологдож хаягдах нь их байна. • **Арьс шир боловсруулах салбарын мэргэшсэн**	• Агуулах байгуулах, баталгаат агуулахын систем нэвтрүүлснээр арьс ширийг жилийн турш бэлтгэх систем тогтворжих • Арьс ширний салбарт хөрөнгө оруулалт татах • Арьс ширний компанийг гадаадын

[76] Хэрвээ зохих багаж техник ашиглан өвчиж, зүсвэл 1 шир 15,000 төгрөгөөр авах худалдан авагч ч олдоно.
[77] JICA, 2019, Монголд рассет идээлгийн арга хэрэглэсэн арьсны бренд бий болгох суурь судалгааны эцсийн тайлан

Дамжлага	Асуудал	Арга хэмжээ
	хүний нөөцийн дутагдал: Арьс ширэн эдлэлийн үйлдвэрлэлд шаардлагатай ажиллах хүч дутагдалтай. Үйлдвэрийн ажиллах хугацаа богино тул үндсэн ажилчин тогтворгүй байдаг. • **Байгаль орчинд халгүй, амьтан хамгааллын ойлголт бүхий бүтээгдэхүүний үйлдвэрлэл, зах зээл эзлэлт:** Бэлэн бүтээгдэхүүний үйлдвэрлэл, экспортлоход анхаарах шаардлагатай асуудал бол энэ чиглэлийн хүний нөөц болон авах арга хэмжээ дутмаг байна.	үзэсгэлэнд оролцоход дэмжлэг үзүүлэх • Арьс ширэн бүтээгдэхүүн хөгжүүлэхэд чиглэсэн ЭШБ, төр хувийн хэвшлийн хамтын ажиллагааг дэмжих • MCYT-өөр арьс шир боловсруулах салбарын сургалт явуулахыг дэмжих тогтолцоо нэвтрүүлэх • Байгаль орчинд халгүй, бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг дэмжих, тэр чиглэлийн аж үйлдвэрийн хүний нөөцийг бэлтгэх

Эх сурвалж: ЖАЙКА-төслийн баг боловсруулав.

(4) Хөгжлийн чиглэл

Дээрх зүйлсийг харгалзан Зураг 2.38-д Монгол Улсын арьс ширний салбарын нийлүүлэлтийн сүлжээнд хийсэн SWOT шинжилгээний дүнг харуулав. Сүүлийн жилүүдэд Улаанбаатарын хаяанд МАА-н томоохон ААН-ийн менежмент бүхий компани нэмэгдэж байгаа ба үүнтэй холбоотойгоор албан ёсны мал төхөөрөх газарт бэлтгэгдсэн малын тоо нэмэгдэх хандлагатай байна. Энэхүү, МАА-н компани, мал төхөөрөх газар, арьс шир боловсруулах үйлдвэрийн уялдааг сайжруулах, чанартай арьс бэлтгэж бэлэн бүтээгдэхүүн үйлдвэрлэх нь нэн чухал ач холбогдолтой юм. Нөгөө талаар түүхий арьсыг хаягдалгүй ашиглахын тулд малчдад ойр газарт мал төхөөрөх, арьс бэлтгэх, борлуулах үйлчилгээ үзүүлдэг малчдын хоршоо, ложистикийн компани байх нь зайлшгүй чухал бөгөөд үүний тулд шаардлагатай тоног хэрэгслийн хөрөнгө оруулалт, малчдын хоршооны чадавхийг бэхжүүлэх шаардлагатай гэж үзэж байна. Арьс ширний үйлдвэрлэлийн салбар боломжийн хэрээр хромон идээлгээс татгалзаж, ургамлын хандан идээлэгт үе шаттайгаар шилжих шаардлагатай гэж үзэж байгаа ба үүнийг хэрэгжүүлэх аж үйлдвэрийн хүний нөөцийг сургах явдал зайлшгүй чухал байна.



Зураг 2.38 Арьс ширний нийлүүлэлтийн сүлжээний SWOT шинжилгээний үр дүн
Эх сурвалж:ЖАЙКА төслийн баг боловсруулав.

2.3.8 Зөгийн бал

(1) Зөгийн балны нийлүүлэлтийн сүлжээний өнөөгийн байдал

Монголд зөгийн балны худалдаа нь зөгийчид хэрэглэгчид шууд худалдах, үзэсгэлэн худалдааны үеийн спот худалдаа, эсвэл зам дагуу хийх гудамжны худалдаа голлож ирсэн. Зөгийчид чанарын хяналт, эрүүл ахуйн талаар ойлголт сонирхолгүй байсан бөгөөд, өөрсдийн үзэмжээр "хийсэн юмаа зарагдах цагт нь зарах" хэв маягтай, нийлүүлэлт нь тогтворгүй байлаа. Гэтэл COVID-19-ийн улмаас шил, савны нийлүүлэлт саатаж, сав ховордохын хамт дэлхийн хэмжээнд инфляц нэмэгдэж төгрөгийн ханш унан савлагааны материалын үнэ огцом өссөн. Мөн супермаркетууд олноор нээгдэж, зөгийн балыг дэлгүүрээс авах хэрэглэгчид нэмэгдэж байгаа,супермаркетуудад тогтвортой нийлүүлэлт хийх шаардлагатай болж ирсэн. Ийм нийлүүлэлтийг хувь зөгийчид хангахад хүндрэлтэй учир зөгийн бал нийлүүлдэг компаниар дамжуулсан борлуулалт өргөжиж байна. Зөгийчид, компаниуд нийлүүлэх нь ихэсч байгааг дагаад,борлуулалтын өртөг буурч борлуулалтын орлого тогтворжих давуу талыг мэдэрч байгаа нь харагдаж байна. Бодит байдалд, 2019 онд А компанид 2 тонн байсан бол 2022 онд 13,7 тонн, мөн хугацаанд Б компанийн цуглуулсан бал 2 тонн байснаас 5 тонн болж нэмэгдсэн. Мөн супермаркетийн лангуунд ч бас Монголын зөгий бал харагдах болж, ААН-ийн тоо, бүтээгдэхүүний төрөл ч нэмэгдэж байна. Чанар ч мөн сайжирч байна. Зам дагуу болон хөдөөгийн зах дээр зарагдаж байгаа зөгийн балнуудад илэрхий чихэрлэг багатай бал харагддаг бол супермаркетэд тийм бал эрс цөөрсөн. Бас HACCP-ийн гэрчилгээтэй зөгийн балны аж ахуйнууд бий бөгөөд (С супермаркетэд нийлүүлдэг 15 ААН-ийн 3 нь) тэдний эрүүл ахуйн хяналтын тухай ойлголт сайжирч байгаа нь ажиглагдсан.



Зураг 2.39 Зөгийн балны нийлүүлэлтийн сүлжээний өнөөгийн байдал
Эх сурвалж:ЖАЙКА төслийн баг боловсруулав.

(2) Зөгийн балны зах зээлийн орчин

Зөгийн бал одоогоор дотоодын зах зээлд голлон нийлүүлэгдэж байгаа ба ирээдүйд гадаад зах зээлд гарах зорилго тавьж байгаа.



Зураг 2.40 Монголын зөгийн балны үйлдвэрлэл, зах зээлийн хэмжээ

Эх сурвалж: Үйлдвэрлэлийн хэмжээ FAOSTAT, импорт, экспортын мэдээлэл ITC, хэрэглээний мэдээлэл FAOSTAT, нэг хүнд ноогдох зөгийн балны хэмжээг хүн амын тоогоор үржиж гаргасан тооцоо. Хүн амын тоонд Монголын статистикийн мэдээг ашигласан. Бүх мэдээлэл 2023 оны 3 сарын 14-ний байдлаар.

Дотоод хэрэглээ нь, үйлдвэрлэсэн, импортлосны нийлбэрээс бага хэвээр үргэлжилж байна. (Зураг 2.40) 2020, 2021 оны хандлагад COVID-19-ийн нөлөө хүчтэй илэрсэн. 2020 онд шил сав олдохоо байснаас гадна хилийн хориг хатуу байсан тул, савгүй хоцорсон олон зөгийчин балаа хадгалахаас аргагүй байсан гэж үзэж болно. 2021 оны үйлдвэрлэлийн өссөн дүнгээс өмнөх жилийн үлдэгдэл нөлөөлснийг хасах хэрэгтэй. 2020 онд импорт огцом буурсан ч COVID-19-ийн тархалт буурснаас хойш өмнөх түвшиндөө хүрч сэргээд байна. COVID-19 нь импортыг орлох нэг боломж олгосон ч үйлдвэрлэл ложистикийн хязгаарлалтаас болоод тэр боломжийг бүрэн дүүрэн ашиглаж чадаагүй. Дэлхийн зах зээлд 2017 оноос хойш, Хятад бусдаас илүү тоглолт хийх болсон, нэгжийн дундаж үнэ гэхэд л 1 кг нь 3 ам. доллар орчим байгаа бол зөвхөн Шинэ Зеландын бал л 1 кг нь 25 ам. доллар орчимд өөрчлөлтгүй байна. Шинэ Зеландын үнэ цэн нь Манука нэрт омгийн зөгийн өвөрмөц шинж болон чанарын хяналтын тогтолцоонд байгаа бөгөөд түүнийг нэг өдрийн дотор дуурайх боломжгүй (Зураг 2.41).



Зураг 2.41 Дэлхийн зөгийн балны зах зээл (2019 оны байдлаар)
Эх сурвалж: 25 тонноос дээш экспорлодог 91 улсын ITC-ийн экспортын мэдээнд тулгууран ЖАЙКА төслийн баг боловсруулав.

Монголын зөгийн балны зөгийчдийн гарааны үнэ нь 4.5-5.7ам.доллар байна[78]. Үнээр өрсөлдөх боломжгүй ч төгрөгийн ханш сул байгаа өнөө цагт зах зээлээ зөв сонгох, бүтээгдэхүүний үнээс өөр үнэ цэнийг нь өсгөх боломжийг эрэлхийлэх шаардлагатай.

(3) Зөгийн балны нийлүүлэлтийн сүлжээний хүндрэлтэй асуудал ба авах арга хэмжээ

Монголын зөгийн балны гол асуудал 3 үндсэн зүйл байна. 1) Үйлдвэрлэл тогтворгүй, 2) Чанар жигд биш, 3) Өртөг ихтэй (Хүснэгт 2.19).

Хорио цээрийн хяналт болон мал эмнэлэгийн үйлчилгээ хангалтгүйгээс өвчин хортон шавж тархаж, үйлдвэрлэл буурахын хамт хүнсний аюулгүй байдалд заналхийлж байна.

Үйлдвэрлэлийн (бал цуглуулах, хураах) хугацаа богино, балт ургамлын нөөцийн хэлбэлзэл их, мөн бүтээмж багатай олон тооны жижиг зөгийн аж ахуй эрхлэгчид байгаа нь нийлүүлэлтийн сүлжээг тогтворгүй болгож зардал өсгөх үндсэн шалтгаан болж байна. Монгол Улсад системчилсэн технологи арай хийж бүрдсэн ч одоо хир нь зөгийн аж ахуй эрхлэгчдийн арчилгаа маллагааны арга, халдвар хамгааллын технологи ихээхэн гажуудалтай байгаа нь хортон шавжийн эрсдлийг нэмэгдүүлж байна. ААН, зөгийчдийн хоршоо зэрэг боловсруулах, түгээх, борлуулалтыг хариуцдаг нэмүү өртгийн сүлжээний зуучлалын бүтэц сайн хөгжөөгүй байгаа нь нийлүүлэлт төдийгүй чанарын тогтвортой байдалд ихээхэн саад учруулж, зардал өсөхөд хүргэдэг байна. Түүнчлэн, зөгийн балны чанарын стандартын талаарх ойлголт сул, бүтээгдэхүүний хэрэглээ ч бага байна. Зах зээлээс ирэх шаардлага нь үйлдвэрлэлийн эхний шат дамжлагыг цэгцэлж сайжруулахад хамгийн үр нөлөөтэй байдаг ба энэ нь чанарыг сайжруулах, брэнджүүлэхэд онцгой чухал болов

[78] 3 сарын 15 –ны ханшаар 1 ам. доллар≒MNT3,536.39

тэрхүү дарамт шахалт сул байгаа нь сайжруулалтад саад болж байна.

Дотоодын гол зах зээл болох Улаанбаатар хотын хэрэглэгчдийн 46 хувь нь супермаркетаас зөгийн балаа авч байна[79]. Супермаркетуудын борлуулалт нь чанар, стандартын шаардлага хангасан барааг тасралтгүй нийлүүлж байхыг шаарддаг. Экспортод гаргах тухайд бол их хэмжээгээр үйлдвэрлэх шаардлагатайгаас гадна олон улсын стандартад нийцсэн аюулгүй зөгийн бал үйлдвэрлэх шаардлагатай. Хэмжээ, чанараас гадна тогтвортой нийлүүлэлтийг хамгийн ихээр чухалчилдаг.

Хүснэгт 2.19 Зөгийн балны нийлүүлэлтийн сүлжээний тулгамдсан асуудал ба авах арга хэмжээ

Үе шат	Асуудал	Арга хэмжээ
Орц	• **Хөрөнгө оруулалт дутагдалтай учир өвчин хортон шавьжтай зохих ёсоор тэмцэж чаддаггүй:** Зөгийн эмийг зохисгүй хэрэглэх явдал байна. Хорио цээрийн зөвшөөрөлгүй зөгийн бүлийг импортоор оруулж ирдэгээс хортон шавьж, өвчин тархах эрсдэл өндөр	• Дотоодод эмийн үйлдвэрлэлийг өргөжүүлж, импортын эмийн бүртгэл, зохицуулалтыг эхлүүлэх. • Хорио цээрийн хяналтыг сайжруулах.
Үйлдвэрлэл	• **Хортон шавьж, өвчин ихсэх хандлагатай байгаа:** Зөгий аж ахуйн мэдлэгтэй малын эмч байхгүй. Хортон шавьжтай тэмцэх технологи дутагдалтай, өргөн дэлгэрээгүй. • **Үйлдвэрлэлийн хэмжээ тогтворгүй:** Үйлдвэрлэлийн хугацаа богино, балт ургамалын нөөц уур амьсгалаас хамааран ихээхэн хэлбэлздэг. Аж ахуйн хэмжээ жижиг, технологийн түвшин зөрүүтэй. • **Үйлдвэрлэлийн зардал өндөр:** Бүтээмж бага. Үйлдвэрлэлийн хугацаа богино. Санхүүгийн хүртээмж сул учраас үйлдвэрлэлийн хэмжээг тэлэхэд хүндрэл учруулдаг.	• Малын эмч нарыг сургах. • Маллагааны арга техникийг сайжруулах. • Газар тариалан, МАА салбартай хамтран балт ургамалын нөөцийг тогтворжуулах. • Зөгийчдийн санхүүгийн чадавхийг бэхжүүлэх, санхүүгийн шинэ тогтолцоог хөгжүүлж нэвтрүүлэх, санхүүгийн байгууллагуудтай хамтарсан сүлжээ байгуулах.
Нийлүүлэлт, боловсруулалт	• **Нийлүүлэлт, боловсруулалтын зардал өндөр:** Бичил аж ахуй эрхлэгчид олон, түгээлтийн зардал өндөр. ААН-ийн агуулахын зардал өндөр, савлах үйлдвэрийн ашиглалтын түвшин бага. • **Нийлүүлэлт тогтворгүй:** Бичил АА эрхлэгч зөгийчид шууд худалдаалах нь их. Үйлдвэрлэлийн хугацаа нь төвлөрсөн байдаг. Компани, түгээлт нийлүүлэлтийн байгууллагуудын хөгжил сул. • **Бүтээгдэхүүний материал импортоос хамааралтай:** Шил сав зэрэг материалыг импортоор авдаг, сонголт багатай байдаг нь бүтээгдэхүүн хөгжүүлэлтэд саад болдог.	• Зохион байгуулалттай борлуулалтыг өргөжүүлэх, компани, зөгийн аж ахуй эрхлэгчдийн байгууллагуудыг хөгжүүлэх, зохион байгуулалтад орсонд нь төлбөрийн баталгаа гаргах. • Аялал жуулчлалын салбартай хамтрах замаар үйлчлүүлэгчдийг салбартай танилцуулах. • Кайзен аргачлалыг нэвтрүүлэх. • Тариалангийн аргаар балт ургамалын нөөцийг нэмэгдүүлэх, тогтворжуулах. • Компаниудын санхүүгийн чадавхийг бэхжүүлэх, өртгийн сүлжээний санхүүжилт нэвтрүүлэх.
Чанарын хяналт	• **Чанарын аюулгүй байдлын хяналт хангалтгүй:** Эмийн заавар гадаад хэл дээр, хэрэглэх заавар нь тодорхойгүй. Тариалангийн талбайд пестицид цацах талаар мэдээлэл хүрдэггүй. Хүнсний эрүүл ахуй, стандартын хэрэгжилтийн талаарх ойлголт сул.	• Мал эмнэлгийн хяналтыг бэхжүүлэх. • Газар тариалангийн салбартай хамтран ажиллах, мэдээлэл солилцох. • Зөгийн АА-н зохистой дадал нэвтрүүлж, эрүүл ахуйн хяналтын анхан шатны сургалт зохион байгуулах.

[79] 2021 онд хэрэгжүүлсэн MONMAP-AVC төслийн "Зөгийн балны зах зээлийн судалгаа"-наас.

Ye шат	Асуудал	Арга хэмжээ
	• **Бүтээгдэхүүний чанар тогтворгүй:** Зах зээлийн эрэлт хэрэгцээ шаардлагын талаарх мэдээлэл зөгийчид хүрдэггүй. Боловсруулах технологи сул, амт чанар тогтворгүй.	• Компани болон зөгийн АА эрхлэгчдийн хооронд гэрээ байгуулахыг дэмжих. • Зах зээлийн судалгаа хийх. • Зөгийчид болон компаниудын технологийн хөрөнгө оруулалтыг дэмжих.
Борлуулалт	• **Брэндийн үнэ цэн сул:** Сайжруулан хөгжүүлсэн шинэ бүтээгдэхүүн цөөхөн. Хэрэглэгчид зөгийн балны талаар мэддэггүй. Амт чанарын ялгааг тоодоггүй. Өдөр тутмын хэрэглээнд зориулсан чанар, үнийн ангилалд багтсан бүтээгдэхүүн байхгүй. Бүтээгдэхүүний пирамид үүсээгүй. Хуурамч гарал үүсэл, бүтээгдэхүүнтэй холбоотой зах зээлийн үл итгэх хандлага бий. • **Дотоодын зах зээл хөгжөөгүй:** Нэг хүнд ногдох хэрэглээ бага. Чанар стандартын талаарх ойлголт сул (хэрэглэгч/салбарын оролцогч талууд). Бүтээгдэхүүний ялгаралд ач холбогдол өгдөггүй (хэрэглэгч/салбарын оролцогч талууд). • **Экспорт хийдэггүй:** Экспортын зах зээлийн талаар мэдээлэл байхгүй. Хэлэлцээрт ахиц гарахгүй байгаа. Хувийн хэвшлийн хэрэгцээ, тулгамдаж буй асуудал, өнөөгийн нөхцөл байдлын мэдээлэл төрд хүрдэггүй. Экспортын журам төвөгтэй. Баримт бичиг алдаатай.	• Бүтээгдэхүүн хөгжүүлэлтийг дэмжих • Кластераар дамжуулан сурталчлан таниулах • Шүүс ихтэй балт ургамалын нөөцийг бий болгох, дагнасан ургамалын балыг нэмэгдүүлэх. • Зөгийн АА-н зохистой дадал /GAP/ нэвтрүүлж, үйлдвэрлэлийн түүхийг баталгаажуулах. • Хэрэглээг нэмэгдүүлэх арга хэмжээ зохион байгуулах, аялал жуулчлал, нийтийн хоолны салбартай хамтран ажиллах, • Импортлогч орнуудын шаардлагын талаарх мэдээллийг тогтмол цуглуулах, нэгтгэх, хуваалцах тогтолцоо бий болгох, кластераар дамжуулан мэдээлэл хуримтлуулах, • Экспортын журмыг хялбарчлах, нэг цэгийн үйлчилгээ, бүх бичиг баримтыг нэгдмэл загвартай болгох.

Эх сурвалж: Жайка төслийн баг боловсруулав.

Тэмдэглэл: Зөгийн аж ахуйд тулгарч буй бэрхшээл

Хувиараа зөгийн бал үйлдвэрлэгчид хэмжээ, чанарын тогтвортой байдлыг хадгалах боломжгүй учраас зөгийн аж ахуй эрхлэгч ААН балыг нь цуглуулж боловсруулах нь чухал юм.

MONMAP-AVC төслийн туршилтын үйл ажиллагаанд хамрагдсан 2 компаний бал худалдаж авч байгаа байдалд мониторинг хийхэд бодит байдал дээр тэд маш ачаалалтай байдаг нт ажиглагдсан.

Туршилтын төсөлд оролцсон А компани 2022 оны сар тутмын худалдан авсан байдлыг харвал жилийн турш худалдан авсан хэмжээнийхээ 75%-ийг зөвхөн 8-10 сард, тэр дотроо 9 сард 42%-ийг нь авсан байна. Үүнийг бага зэрэг хэлбэлзлэлтэй ч нэг жилийн хугацаанд худалдан борлуулж байна. Жилийн эцэст үлдэгдэл нь худалдан авсан балны 30 гаруй хувийг эзэлж, хамгийн их үлдэгдэлтэй сард онолын хувьд жилийн нийт борлуулалтын 90%-тай тэнцэж байлаа. ААН нь зөгийчнөөс балыг бэлэн мөнгөөр авна. Харин борлуулахдаа томоохон супермаркетуудад дараа тооцоогоор өгөх нь элбэг тул худалдан авалт ба борлуулалтын зөрүүг ААН хариуцаж байна. Гэтэл эргэлтийн хөрөнгийн шаардлага маш их тул зээл авахаас аргагүй бөгөөд, ингэснээр ашиг муутай байдаг байна.

Үйлдвэрлэлийн хугацаа богинотой Монгол Улсад татан авалтын өрсөлдөөн ихтэй салбарт адилхан асуудлууд тулгарч байгаа байх. Санхүүгийн секторооc ААН-ийг дэмжих нь зайлшгүй, нэмүү өртгийн сүлжээн доторх агуулахын нөөцийг тэгшитгэх болон гүйлгээний орлогоо буцааж авахтай холбоотой бизнесийн уламжлалаа сайжруулах талаар салбарын хэмжээнд судлан үзүүштэй.

А компаний зөгийн балны худалдаа, худалдан авалтын сар тутмын өөрчлөлт

(4)Хөгжлийн чиглэл

2021 оны үйлдвэрлэл нь өмнөх жилийн үлдэгдлийг гаргаж нэмсэн гэж бодож байгаа учир, түүнийг хассан ч гэсэн их хэмжээгээр өссөн байна. Зах зээлийг нээж /эзлэх/ цаашид үйлдвэрлэлээ өргөтгөх боломжтой цаг хугацаа юм. Зөгийн балны тогтвортой нийлүүлэлт хийж чадвал, зах зээлээ тэлэх боломж нэмэгдэнэ. Дотоодын зах зээлд хэрэглээ өргөсөх орон зай их бий. Монголын нэг хүнд ноогдох зөгийн балны жилийн хэрэглээ дэлхийн дунджийн 3/2 -с бага, Европ, Америкийн 6/1-ээс хэтрэхгүй байна[80].

Тэмдэглэл: Зөгийн балны зах зээлийн судалгаа (2021 он)

MONMAP-AVC төслийн хүрээнд хэрэгжүүлсэн зөгийн балны зах зээлийн судалгаанаас үзэхэд хэрэглэгчдийн зөгийн бал хэрэглэх арга маш энгийн байна. Хэрэглэгчдийн 90 гаруй хувь нь халуун усанд уусгаж уудаг гэж хариулсан бол цайнд (14.3%) хийх, сүүнд (12.2%) хийх, хоол хийхэд ашигладаг 10%, өөр зүйлтэй хамт хэрэглэдэг 5% орчим байна. Худалдан авалт хийхдээ хэрэглэгчдийн 46.1% нь сүлжээ супермаркетаас, 17.9% нь супермаркет эсвэл ойролцоох дэлгүүрээс худалдаж авсан гэж хариулсан буюу нийт 64% орчим нь супермаркет эсвэл ойролцоох дэлгүүрээс зөгийн бал худалдан авдаг гэжээ. УБ хотод томоохон супермаркетуудын тоо нэмэгдсээр байна. Цаашид супермаркетуудаас зөгийн бал худалдан авах хүмүүсийн тоо нэмэгдэх хандлагатай. Супермаркетуудын лангуун дээр монгол зөгийн балны бүтээгдэхүүн олширч байгаа нь хэрэглэгчдийн хэрэгцээг хангахын тулд гаргаж буй энэ салбарын хүчин чармайлтыг харуулж байна. Нөгөөтэйгүүр, хэрэглэгчдийн 55% нь зөгийн балыг чанар, 38% нь амтыг нь анхаарч худалдан авдаг ч 28% нь “сайн зөгийн балыг хэрхэн сонгохоо мэдэхгүй байна” гэжээ. Японд зөгийчид зөгийн балны амтанд тохирсон хоолны жор санал болгодог. Зөгийн арчилгаа маллагааны талаарх мэдээлэл түгээх тал дээр ч санаа тавьдаг. Олон зөгийчид зөгийн балаа хэрэглүүлэхийн тулд орон нутгийн нарийн боовны цех, ресторантай хамтран ажилладаг. Янз бүрийн газарт зөгийн балны үзэсгэлэн худалдаа зохион байгуулж, зөгийн аж ахуй эрхлэгчид, зөгийн балны компаниуд цуглардаг арга хэмжээнүүд зохион байгуулагддаг. Монголын зөгийн аж ахуйн салбарт цаашид хэрэглээг нэмэгдүүлэхийн тулд хийх зүйлс олон бий.

Курода зөгийн цэцэрлэгийн зөгийн балтай бялуу

Зөгийн аж ахуйн өнөөгийн байдлын тухайд, дэлхий дахинд өвчин үүсгэгч хортон шавьж тархаж, хүндрэлтэй байгаа ч шүлхийтэй адил бусад улс дамжин тархахаас сэргийлэх шаардлагатай зөгийн өвчин болон хортон шавьж Монголд одоогоор бүртгэгдээгүй. Чихэрийн агууламж өндөртэй, хүнсний бүтээгдэхүүний хувьд тогтмол шинж чанар бүхий зөгийн балыг экспортлох боломжтой ыүтээгдэхүүн гэж хэлж болно. Бас зөгийн бал нь тансаг хэрэглээний бүтээгдэхүүн бөгөөд дэлхийн зах зээл дээр амттай бөгөөд ховор сонин бал, эрүүл мэндэд сайн тусгай бал идмээр байна гэх өвөрмөц эрэлт ч бас бий бөгөөд зөвхөн бүтээгдэхүүний өртгөөс өөр үнэ цэн байдаг. Нөгөө талаар зөгийн балны онцлог нь дуураймал, эсвэл гарал үүслийг дуурайсан гэж сэжиглэгдэхдээ амархан. Дэлхийн зах зээлийн сонирхолд нийцэхийн тулд хүнсний аюулгүй байдлыг анхаарч үзэх нь чухал бөгөөд, чанарын баталгаа болон мөшгих тогтолцоо бүрдүүлэхийг зорилго болгох шаардлагатай. Зөгийн аж ахуй нь орон нутгийн тогтвортой үйлдвэрлэл төдийгүй, ХАА-н бүтээмжийг нэмэгдүүлэх, бэлчээр хамгаалахад ч хувь нэмэртэй. “Суралцах” болон “тогтвортой байдлыг” эрхэмлэх болсон аялал жуулчлалын салбартай ч зохицол сайтай. Монголын эрс тэс уур амьсгалд зохицсон балт ургамалын тогтвортой эх үүсвэр бүрдүүлэх нь ялангуяа чухал бөгөөд, зөгийн аж ахуй төдийгүй

[80] FAOSTAT2019 (2023 оны 3 сард холбогдсон)

газар тариалан, МАА-д ч давхар анхаарснаар балт ургамалын нөөцийн асуудлыг сайжруулах боломжтой юм. Салбарын хана хязгаарыг даван аль аль салбарын хөгжлийг дэмжихэд хөрөнгө зарцуулах талаар судалж үзүүштэй санагдана.



Зураг 2.42 Зөгийн балны нийлүүлэлтийн сүлжээний SWOT шинжилгээ
Эх сурвалж: Жайка төслийн баг боловсруулав.

2.3.9 Бусад ирээдүйтэй ХАА-н бүтээгдэхүүн (Мөөг / загас)

(1) Мөөг

1) Мөөгний нийлүүлэлтийн сүлжээний өнөөгийн байдал

Зураг 2.43 Мөөгний нийлүүлэлтийн сүлжээ
Эх сурвалж: Жайка төслийн баг боловсруулав.

Улаанбаатарт шиитакэ болон даршилсан мөөг зэрэг мөөгний төрлүүд худалдаалагдаж байна. Одоогоор эдгээрийн дийлэнхийг Хятадаас импортлож байна. Хотын оршин суугчдад мөөгний хэрэглээ тодорхой хэмжээгээр ажиглагдсан тул импортыг орлох дотоодын мөөгний үйлдвэрлэлийг хөгжүүлэх боломжийг судлах хэрэгтэй.

Саяхнаас Монголд хаан хясаа (Oyster Mushroom) мөөгийг мицелит үүсгэх, үртсэн субстрат тариалалт хэлбэрээр тариалж эхлээд байна. Импортын мөөгийг бодвол шинэлэг, чанар ч сайн тул ресторан зоогийн газруудын хэрэглээ нэмэгдсээр байна. Мөөг үйлдвэрлэл нь жижигхэн ААН гэрийн тариалан эрхлэгчдийг татан оролцуулах хэлбэрээр явагдаж байна. Ийнхүү хувь хүн, ААН нэгдэж мөөг үйлдвэрлэгчдийн холбоо байгуулан үйлдвэрлэл, хэрэглээг өргөтгөх зорилготой ажиллаж байна. 2023 оны эхний байдлаар гишүүдийн тоо 23 орчим,үүний тал нь хувь хүн, тал нь ААН байна. Эдгээр нь мицел үүсгэх, субстракт тариалах, мөөг үйлдвэрлэл (ногоогоор жишээлж тайлбарлавал үр үйлдвэрлэл, үрсэлгээ суулгац тариалах, ногоо тарихтай дүйнэ) гэсэн 3 үе шаттай борлуулалтаа салгаж, кластер хэлбэрийн үйлдвэрлэл худалдааны үйл ажиллагаа явуулж байна. 2022 онд хясаан дэрвээлж (болон King Oyster Mushroom (хаан хясаа мөөг)) 22 тонныг үйлдвэрлэсэн. Мөн мөөг үйлдвэрлэгчдийг нэмэгдүүлэх зорилгоор Улаанбаатар болон орон нутагт сард 20 орчим хүнийг хамруулсан сургалт зохион байгуулжээ.

2) Мөөгний зах зээлийн орчин

Монголд худалдаалагдаж байгаа мөөгний ихэнхийг Хятадаас импортлодог бөгөөд нойтон мөөгнөөс гадна, хатаасан мөөг ч зарагддаг болж байна. Худалдаанд байгаа мөөгнүүд гэвэл хясаа мөөг, эноки такэ (Flammulina velutipes хусны мөөг) хаан хясаа мөөг, mushroom (цагаан мөөг) зэрэг болно. Эдгээр нь, төв суурин газрын зах болон жижиг мухлаг, супермаркет зэргээр худалдаалагдахаас гадна, ресторан болон түргэн хоолны газруудаар хоол хийж боловсруулсан байдлаар борлуулагдаж байна. Үүнээс гадна байгалийн зэрлэг мөөг болох цагаан мөөг (Монгол шимэжи, цагаан мөөг) ч мөн хүнсэнд хэрэглэгддэг.

Монголд мөөгний дотоодийн хэрэглээ бага хэвээр, импортын хэмжээ жилд 270 тонн орчим байна (2020). Нэг хүнд ногдох жилийн дундаж хэрэглээ ердөө 0,1 кг буюу Японы 13 кг-ын 1/100-д ч хүрэхгүй байна. Цаашид Монгол Улсын ЭЗ-ийн өсөлт, ЭМ-ийн ухамсар дээшлэхийн хэрээр хооллох зуршилд өөрчлөлт орж, эрэлт хэрэгцээ тодорхой хэмжээнд нэмэгдэх төлөвтэй байна. Одоогийн байдлаар мөөгний хэрэглээг нэмэгдүүлэхийн тулд мөөгний ашиг тус, хоол хийх аргатай зэргийг сурталчилах ажил идэвхитэй явагдаж байна. Одоогийн дотоодын үйлдвэрлэл 10 тонн орчим гэж үзвэл дотоодын хэрэглээний 4% орчмыг л өөрөө хангаж байна. Борлуулалтанд байгаа хясаа мөөг болон тариалж байгаа мөөгний төрөл өөр өөр байгаа тул, хясаа мөөгний хэрэглээний талаар олон нийтэд таниулах сурталчилгаа онцгой чухал юм. Үүний зэрэгцээ эрэлт ихтэй шиитакэ мөөгийг үйлдвэрлэлийн зорулалтаар тариалахад чиглэсэн судалгааны ажил хийгдэж байна.

3) Мөөгний нийлүүлэлтийн сүлжээний асуудал ба авах арга хэмжээ

Мөөг нь доорх хүснэгт 2.20-д үзүүлсний дагуу мицел үүсгэх, субстракт тариалах, мөөг үйлдвэрлэл (ногоогоор жишээлж тайлбарлавал үр үйлдвэрлэл, үрсэлгээ суулгац тариалах, ногоо тарихтай дүйнэ) гэсэн 3 үе шат болон борлуулалт хэрэглээний үе шатанд хувааж асуудал ба авах арга хэмжээг сийрүүлье.

Хүснэгт 2.20 Мөөгний нийлүүлэлтийн сүлжээний асуудал ба авах арга хэмжээ

Үе шат	Асуудал	Арга хэмжээ
Мицел үйлдвэрлэл	• Монголын нөхцөлд зохицсон мөөгний төрөл сортын судалгаа сайн хийгдээгүй. • Мицел үйлдвэрлэлийн норм, стандарт гараагүй	• Мөөгний судалгаа, хөгжүүлэлт /үйлдвэрлэл/-ийг дэмжих • СХЗГ мөөгний улсын стандартыг батлах
Мицелит үйлдвэрлэл	• Мицелит үйлдвэрлэгчийг цөөн тоонд хязгаарласан • Мицелит үйлдвэрлэгчийн үйлдвэрлэлийн хэмжээ хязгаарлагдмал • Мицелит үйлдвэрлэлийн норм, стандарт гараагүй	• Мицелит үүсгэгчийг санхүүгээр дэмжих • СХЗГ мөөгний улсын стандартыг батлах
Мөөг үйлдвэрлэл	• Мөөг үйлдвэрлэгчийг цөөн тоонд хязгаарласан • Мөөг үйлдвэрлэлд шаардлагатай субстракт тариалах хөрөнгө санхүү материал тоног төхөөрөмжөөр хангах тогтолцоо бүрдээгүй • Мөөг үйлдвэрлэлийн норм, стандарт байхгүй.	• Мөөг үйлдвэрлэлийн талаар сургалт хийх • Мөөг үйлдвэрлэлийн санхүү болон тоног төхөөрөмжийн ханган нийлүүлэлтийн тогтолцоо бий болгох • СХЗГ мөөгний улсын стандартыг батлах
Мөөгний борлуулалт, хэрэглээ	• Дотоодын мөөгний хэрэглээ туйлын бага • Дотоодод тариалсан мөөгний боловсруулалт, ложистикийн тогтолцоо бүрдээгүй	• Мөөгний хэрэглээг нэмэдүүлэх сурталчилгаа хийх • Дотоодод тариалсан мөөгний боловсруулалт, ложистикийг сайжруулах

Эх сурвалж: ЖАЙКА төслийн баг боловсруулав.

4) Хөгжлийн чиглэл

ГТ-ийн хавсарга бүтээгдэхүүн талаас нь мөөгний дотоодын үйлдвэрлэлийг дэмжиж импортыг орлох аргын талаар SWOT шинжилгээ хийж үзлээ (Зураг 2.44). Түүнийг хөгжүүлэх чиглэл нь, 1)Дотоодын судалгааны байгууллагатай хамтран туршилт судалгаа хийх, 2)Хэрэглээг нэмэгдүүлэх талаар сурталчилгаа хийх, борлуулалтын сувгийг нээх, 3)Мөөгний улсын стандарт боловсруулан хэрэгжүүлэх хэрэгтэй юм.

Мөөгний нийлүүлэлтийн сүлжээний SWOT шинжилгээ		Гадаад орчин: Боломж	Гадаад орчин: Аюул
		● Дотоодын мөөг судлаач, сургагч багштай, мөөг тариалах сонирхолтой оюутан нэмэгдэх хандлагатай байгаа ● Мөөг үйлдвэрлэлийн тоног төхөөрөмж нийлүүлдэг хувийн ААН байгуулагдаж байна. ● Дотоодод хүнс боловсруулах компани байгаа	● Хэрэглэгчид дотоодын мөөгний тариалалтын талаархи сонирхол бага ● Зах, жижиглэнгийн дэлгүүрээр дандаа импортын мөөг зарагддаг
Дотоод орчин	Давуу тал ● Мөөгний холбоо нь мөөгний үйлдвэрлэл, борлуулалтын систем бүрдүүлээд байна ● Хувийн ААН мицел үйлдвэрлэж эхлээд байна ● Сургалт зохион байгуулснаар мөөг тариалагчдын тоо нэмэгдэж байна	Давуу тал *боломж ● Мөөг үйлдвэрлэлийн технологийн судалгаа хөгжлийг дэмжих ● Мөөг үйлдвэрлэгчдийг сургаж, үргэлжлүүлэн дэмжих ● Мөөг үйлдвэрлэлийн процессуудыг салбарлуулж уялдааг бэхжүүлэх	Давуу тал *аюул ● Мөөгний эрэлтийг нэмэгдүүлэхэд чиглэсэн мөөгний ашиг шим, ач холбогдол, хоол хийх аргын талаар сурталчилгаа сайн хийх ● Сургуулийн хоолны цэсэнд мөөг оролцуулах арга хэмжээ авах ● Мөөг тариалагчид, жижиглэнгийн дэлгүүр, рестораны уялдаа холбооог сайжруулах
	Сул тал ● Мицелийн материалын хязгаарлалтаас болж тариалах мөөгний төрөл цөөн байна. ● Мөөгний үндэсний стандарт, сортыг хамгаалах зэрэг тогтолцоо бүрдээгүй байна ● Жилийн турш тариалдаг болохын тулд өвлийн тариалалтын орчныг бүрдүүлэх шаардлагатай байна.	сул тал *боломж ● Монголын нөхцөлд тохирсон мөөг үйлдвэрлэлийн технологийн хөгжлийн дэмжих ● Мөөг үйлдвэрлэлийн явцад үндэсний стандарт боловсруулж мөрдөх ● Мөөг үйлдвэрлэх өвлийн хүлэмж байгуулах ● Өвлийн эрэлтийг хангахын тулд хатаах, чанах зэрэг боловсруулсан бүтээгдэхүүнийг хөгжүүлэх	сул тал *аюул ● Эх орны үйлдвэрийн мөөгний чанар аюулгүй байдлыг сурталчилж импортын мөөгнөөс ондооших ● Эх орны үйлдвэрийн мөөгний импортын мөөгтэй үнээр өрсөлдөх чадварыг сайжруулахад шаардлагатай дэмжлэгийн тогтолцоо бүрдүүлэхийг судлах

Зураг 2.44 Мөөгний нэмүү өртгийн сүлжээний SWOT шинжилгээ

Эх сурвалж: Жайка төслийн баг боловсруулав.

(2) Загас

1) Загасны нийлүүлэлтийн сүлжээний өнөөгийн байдал

Монгол Улс нийтдээ 67,000 км урт том жижиг 3,800 гаруй гол мөрөнтэй, 3,000 гаруй нуур, намагтай, 6 нь 500 гаруй км квадрат, 4 нь 1,000 гаруй км квадрат талбайтай[81]. Эдгээр усанд 1м хүртэл урттай хилэм загас, амрын тул, цурхай зэрэг том загаснаас гадна зэвэг, хадран, мөрөг, гутаарь, мөнгөлөг хэлтэг зэрэг 40 гаруй төрлийн загас амьдардаг[82].

1950-иад оны дундуур ЗХУ-ын зааврааар нууруудаас үйлдвэрлэлийн зориулалттай загас агнуур хийж эхэлсэн ба барьсан загасны ихэнхийг Орос улсруу экспорт хийдэг байсан байна[83]. 1990-ээд онд зах зээлийн эдийн засагт шилжсэнээс хойш Хятадаас заламгайн тор ихээр оруулж, гол мөрөн, нууруудаар хяналтгүй загасчлах болсоноор загасны нөөц огцом хорогдсон. Одоо голоос загас агнуур хийхийг хориглосон ба олон нууруудад үйлдвэрлэлийн зориулалттай загас агнуур хийхийг хориглосон байгаа. 1999 онд гадаад улс руу хийсэн экспорт 525 тонн болж оргилдоо хүрч байсан бол 2018 онд ердөө 9 тонн болтлоо буурсан (Хүснэгт 2.22). Загас агнуурын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгж цөөхөн, анхнаасаа экспорт хийх зорилготойгоор бизнесээ эхлүүлсэн тул дотоодын зах зээл хөгжөөгүй. Одоо ч гэсэн дотоодын загасны хэрэглээний хэмжээ бага, хөлдөөсөн, боловсруулсан загасан бүтээгдэхүүн нь хот суурин газрын зарим томоохон супермаркетуудад харагдах төдий байна.

[81] "Монгол Улсын намгархаг газрын экосистемийг хамгаалах, тогтвортой ашиглах ус цуглуулах менежментийн загвар төсөл: Урьдчилсан үнэлгээний судалгааны тайлан (2006 оны 3-р сар)" ЖАЙКА-гийн Дэлхийн байгаль орчны хэлтэс.

[82] Зонхилох загас (Алтайн сугас, Амарын цурхай, булуу цагаан, сахалт эрээлж, цэнгэг усны сагамхай загас, улаан живэрт, хадран, Гүрц, зэвэг, Монголын улаан далбайт, мөнгөлөг хэлтэг, алгана, өлгөр цагаан гэх мэт).

[83] 1954-1993 онд загас агнуурын гол бүс нутаг нь Буйр нуур, Өгий нуур, Цагаан нуур, Дархадын хотгор байсан бөгөөд байршил бүрт цех байрлаж байсан (ШУА-ийн Биологийн хүрээлэн).

Нуурын эргэн тойронд оршин суугчид хувиараа загас барьж, барьсан загасаа утаж боловсруулан, ил гудамжинд зардаг ч ихэнхийг нь өрхийн хэрэглээнд хэрэглэдэг.

Зураг 2.45 Монгол Улсын түүхий загасны нийлүүлэлтийн сүлжээ

Эх сурвалж: Жайка төслийн баг

2) Загасан бүтээгдэхүүний зах зээлийн орчин

Монгол Улс бол эрт дээр үеэс уламжилан ирсэн нүүдэлчин ард түмэн бөгөөд МАА-д түшиглэсэн, мах идэх хоолны соёл түлхүү хөгжисөн улс тул одоо ч загасны хэрэглээ маш бага байна. Нэг хүнд ногдох жилийн загасны хэрэглээ 0.18 кг, нийт уургийн хэрэглээний дөнгөж 0.13 хувийг загас эзэлдэг. Нийслэл Улаанбаатар хотод бөөний худалдаачид болон томоохон супермаркетууд импортолсон загасаа нийлүүлдэг тул хүнсэндээ хэрэглэх загасны олдоц элбэг, загасан хоолоор үйлчилдэг гадаадын ресторанууд ч олон байдаг тул хэрэглээ хөдөө орон нутгаас арай өндөр ажиглагддаг. Гэсэн хэдий ч жилийн хэрэглээ 0.28 кг төдий байна.

Хүснэгт 2.21 Загасны жилийн хэрэглээ бүс нутгаар (кг/хүн/ жил)

Улаанбаатар	Төв	Өндөр уулархаг	Баруун	Зүүн
0.28	0.17	0.12	0.07	0.07

Эх сурвалж: Ази, Номхон далайн бүс нутгийн загас, загасан бүтээгдэхүүний хэрэглээ, өрхийн судалгаанд үндэслэв, FAO, 2015/12

Харин сүүлийн жилүүдэд залуу үеийнхний эрүүл мэндээ хамгаалах ухамсар нэмэгдэж байгаа болон “Эрүүл хүнс - эрүүл монгол хүн” үндэсний хөтөлбөрөөр загасны хэрэглээг дэмжсэнтэй холбоотойгоор загасны эрэлт хэрэгцээ нэмэгдэх хандлагатай байна. Өнгөрсөн хугацаанд хэрэглэгчдийн дунд явуулсан судалгаагаар загас худалдаж авахгүй байгаа эхний шалтгаан нь “загас зах зээл дээр байхгүй” байсан бөгөөд шинэ, түүхий загас бэлэн байвал авах хүсэлтэй хэрэглэгч олон байгаа нь ажиглагдсан. Одоогоор зах зээл дээр байгаа далайн гаралтай бүтээгдэхүүний дийлэнх нь импортоор орж ирдэг ба нийлүүлэлтийн тогтолцоог сайжруулснаар

дотоодын загасны хэрэглээг нэмэгдүүлэх боломж байна.

Олон улсын зах зээл дэх экспортын хэмжээ жилээс жилд буурч байгаа ч тодорхой хэмжээний эрэлт байсаар байна. Тухайлбал, Хятадтай хил залгаа Буйр нуур нь Хятадад загасны эрэлт нэмэгдэх цагаан сарын баярын үед төвлөрсөн экспортын борлуулалт хийдэг.

Хүснэгт 2.22 Монгол Улсын загас агнуурын үйлдвэрлэл, импорт, экспортын хэмжээ

Он	Цэнгэг усны загас	Загас, загасан төрөлтөн	
	Үйлдвэрлэсэн хэмжээ (тн)	Импортын хэмжээ (тн)	Экспортын хэмжээ (тн)
2014	49	1,319	61
2015	63	862	93
2016	15	922	31
2017	22	1,021	22
2018	25	1,251	9

Эх сурвалж: ХХААБ-ын статистикийн мэдээнд үндэслэн, ЖАЙКА төслийн баг боловсруулав.

3) Загасны нийлүүлэлтийн сүлжээнд тулгамдаж буй асуудал болон авах арга хэмжээ

Монгол Улсын түүхий загасны нийлүүлэлтийн сүлжээнд “Нөөцийн хомсдолоос сэргийлэх”, “Загас агнуурын салбартай холбоотой мэдлэг, технологийг эзэмших”, “Дотоодын зах зээл хөгжөөгүй” гэсэн гурван том асуудал бий.

Хүснэгт 2.23 Загасны нийлүүлэлтийн сүлжээний асуудал ба авах арга хэмжээ

Орц	Асуудал	Авах арга хэмжээ
Үйлдвэрлэл: Загас агнуур	• **Хэт их загас агнуураас үүдэх нөөцийн хомсдолоос сэргийлэх** ・Нөөцийн судалгааг зохих ёсоор хийдэггүй ・Байгаль хамгаалагч дутмаг • **Загас агнуур хийх хугацаа хязгаарлагдмал** ・Зөвхөн өвлийн улиралд загас агнах нь нөөцийн зохисгүй хэрэглээнд хөтлөх эрсдэлтэй	• Нөөцийн судалгааг тогтмол хийх • Нөөцийн чиглэлээр мэргэшсэн боловсон хүчнийг хөгжүүлэх • Байгаль хамгаалагчдыг томилох замаар нөөцийн менежментийг чангатгах • Загас үржүүлгийн ажлыг хөгжүүлэх, түгээх • Нөөц хамгаалах тухай хуулиудыг хянаж, шинэчлэн найруулах
Боловсруулалт	• **Загас агнуурын салбартай холбоотой мэдлэг, технологийг эзэмших** ・Боловсруулах тоног, төхөөрөмж байхгүй ・Боловсруулах технологи хангалтгүй, боловсронгуй бус ・Боловсруулсан бүтээгдэхүүний төрөл цөөн ・Цэнгэг усны загасны боловсруулалт, эрүүл ахуйн талаар мэдлэг дутмаг	• Боловсруулах үйлдвэр барихад дэмжлэг үзүүлэх • Далайн бүтээгдэхүүнийг боловсруулах сургалт явуулах • Болгосон, боловсруулсан гэх мэт бүтээгдэхүүний төрлийг нэмэгдүүлэх • Зах зээлийн эрэлтийн судалгаа явуулах
Түгээлт	• **Тогтворгүй нийлүүлэлт** ・Том оврын хөрг үүртэй хадгалах төхөөрөмж байхгүй тул түүхий эд, бүтээгдэхүүнийг удаан хугацаагаар хадгалах боломжгүй ・Хөргүүр, хөлдөөгчтэй машин байхгүй тул зуны улиралд хол тээвэрлэхэд хүндрэлтэй	• Хадгалах агуулах, хүйтэн сүлжээг хөгжүүлэхэд дэмжилэг үзүүлэх
Борлуулалт, хэрэглээ	• **Дотоод зах зээл хөгжөөгүй** ・Нэг хүнд ногдох хэрэглээ бага ・Хоол хийх арга мэдэхгүй	• **Загасны хэрэглээг нэмэгдүүлэхийн тулд загастай хоол дэлгэрүүлэх үйл ажиллагаа** ・Боловсролын газар, ресторан, жижиглэнгийн дэлгүүр гэх мэт хүнсний боловсролын үйл ажиллагаа ・Хүнсэнд хэрэглэх аргуудыг сурталчлах ・Аялал жуулчлал, нийтийн хоолны салбартай хамтран ажиллах

Эх сурвалж: ЖАЙКА төслийн баг боловсруулав.

Далайн загасны аж ахуйтай харьцуулахад нуур, гол мөрөн дэх загас агнуур нь хялбар, амархан баригддаг тул нөөцийн хомсдолд орох магадлал өндөр. Тэр дундаа Монгол орны өвлийн загас агнуур нь хөлдөж нарийсан загасны амьдрах орчин нь хязгаарлагдсан, барихад хялбар орчинд явагддаг, зүй зохисгүй агнуурт өртөмтгий тул анхааралдаа авах шаардлагатай. Нөөцийн хомсдолоос сэргийлэхийн тулд нөөцийн судалгааг тогтмол хийх шаардлагатай ч судалгаан хийх мэргэжлийн боловсон хүчин болон хөрөнгө хүрэлцэхгүйн улмаас хангалттай судалгаа хийгддэггүй. Нөөцийн менежментийн тогтолцооны хувьд зарим бүс нутагт мэргэшсэн боловсон хүчин, ажил горилогч дутмаг байгаагаас загасны нөөцийн менежментийг хариуцдаг байгаль хамгаалагчийн ажлын байр эзэнгүй байна. Мөн үйлдвэрлэлийн зориулалттай загас агнуур явагдах тохиолдолд заавал хийх ёстой үржүүлгийн ажил нь тоног төхөөрөмж, хүн хүч, хөрөнгө мөнгөгүйгээс үүдэн өнөөг хүртэл хэрэгжисэн жишээ хараахан алга байна[84]. Одоогоор аймаг, нуур бүр Байгаль орчин, аялал жуулчлалын яамнаас тогтоосон загас агнуурын квотонд заасан хэмжээ хүртэл загас агнуур хийхгүй байгаа ч нөөцийн судалгаа, менежментийн тогтолцоо хангалтгүй байгаа өнөөгийн нөхцөлд хэт өөдрөгөөр харж болохгүй.

Загас боловсруулах технологийн хувьд Монгол Улсын загас агнуурын аж үйлдвэр анхнаасаа өрхийн хүнсний хэрэглээ, аялал жуулчлалын зориулалтаар цөөхөн хэдэн нуур, гол мөрөнөөр хязгаарлагдаж ирсэн тул дотоодод загас боловсруулах байгууламж, тоног төхөөрөмж бараг байдаггүй. Загасны үндсэн боловсруулалт, эрүүл ахуйн менежментийн технологи, цэнгэг усны загасны өвөрмөц шимэгч хорхойн эсрэг авах арга хэмжээ зэрэг нөү-хаугийн хуримтлал байхгүй. Тиймээс дотоодын загас агнуурын үйлдвэрлэлийг дэмжихдээ боловсруулах үйлдвэрүүдийг сайжруулахаас гадна боловсруулахтай холбоотой мэдлэг, технологийг хөгжүүлэх шаардлагатай.

Ирээдүйд хүнс төрөлжсөнөөр загасны эрэлт нэмэгдэх төлөвтэй байгаа ч одоогийн байдлаар нэг хүнд ногдох хэрэглээ маш бага буюу 200 гр хүрэхгүй байна. Хэрэглээний тэлэлтийн хурдасгахын тулд хэрэглээнд уриалсан арга хэмжээ, үйл ажиллагаа зайлшгүй чухал. Зарим хэрэглэгчид загас идэх сонирхолтой байдаг ч яаж хоол хийх аргаа мэдэхгүйгээс худалдаж авахгүй байх тохиолдол гарна[85]. Иймээс загас зарахтай зэрэгцэн хоол хийх аргыг сурталчлах, түгээх нь хэрэглээг нэмэгдүүлэх гол түлхүүр болно. Мөн хоол хийхэд хялбар, боловсруулсан бүтээгдэхүүнийг хөгжүүлснээр хэрэглэгчдийн боловсруулах ачааллыг бууруулж, худалдан авалтыг дэмжих ч мөн чухал юм.

4) Хөгжлийн чиглэл

[84] Байгалийн нөхцөлд загас үржүүлэх, хамгаалах төсөл хэрэгжүүлдэг хэд хэдэн байгууллага байдаг (Нэрлэвэл, ТББ: Жижиг горьхи, Туул Ижий сан, Чулуут тул сан, Таван толгой (Сэлэнгэ аймаг, Хушаат сум), Компани: Зөгийн-Үүр, Хилэм-Ост компани гэх мэт).
[85] Auburn их сургуулийн доктор Амит Моригийн Монголд хийсэн хэрэглэгчийн хандлагын судалгаа.

Түүхий загас нийлүүлэлтийн сүлжээний SWOT дүн шинжилгээ	Гадаад хүчин зүйлс	
	Боломж	**Эрсдэл**
	● Хоолны орцыг төрөлжүүлэх замаар улсын хэмжээнд эрүүл хооллолтыг сурталчлах ● Залуу үеийнхэний дунд эрүүл мэндийн ухамсар түлхүү нэмэгдэж байгаа ● Хүнсний даяаршлын улмаас далайн бүтээгдэхүүний эрэлт нэмэгдсэн ● Хэрэглэгчдийн дотоодод үйлдвэрлэсэн болон шинэхэн загасны эрэлт, хэрэгцээ ● Жижиг загасыг хамгаалахын тулд том загасыг барих шаардлага ● Хятад, Оросын загасны эрэлт ● Хөрш орнуудаас хямд материал, төхөөрөмж авах боломжтой байршил ● Аялал жуулчлал, нийтийн хоолны үйлдвэрлэлийн салбарын эрчимтэй хөгжил	● Хэт их агнуурын улмаас нуурын загасны нөөц шавхагдах ● Хятад, Орос бүх загасыг худалдаж авах ● Далайн боловсруулсан (лаазалсан, хөлдөөсөн) бүтээгдэхүүний импорт ● Нөөцийг хамгаалах тухай хууль тогтоомжийн хэрэгжилт, хяналтыг чангатгах
Дотоодын нөхцөл		
Давуу тал ● Хөгжөөгүй тул байгаль орчны бохирдол бага, ашиглаагүй загас агнуурын нөөц байгаа ● Дотоодын загас агнуурын брэнд болон ховор байдал ● Төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгийн үеийн загас агнуурын томоохон технологитой ● Загас үржүүлэх төсөл хэрэгжүүлж, судалгаа хийдэг төрийн бус байгууллага, хоршоод байдаг ● БНХАУ-аас үржүүлгийн технологийн хамтын ажиллагааны зөвшөөрөл авсан	**Давуу тал × Боломж** ● **Дотоодын нуурууудын загасны нөөцийг ашиглах** ● **Их хэмжээний үйлдвэрлэл хийхэд тохирсон загас агнуурын техник технологийг нэвтрүүлэх** ● **Аялал жуулчлал, рестораны салбартай хамтран ажиллах**	**Давуу тал × Эрсдэл** ● **Хятадын тусламжтайгаар загас үржүүлгийн ажлыг хөгжүүлэх, түгээн дэлгэрүүлэх** ● **Үржүүлгийн ажлыг зохих ёсоор хэрэгжүүлэх, түүний үр нөлөөг урьдчилан тооцоолсноор загасны нөөцийг хамгаалах тухай хуулийн төслийг боловсруулж, хэрэгжүүлэх**
Сул тал ● Загас барих, боловсруулах технологи хангалтгүй, боловсронгуй бус ● Хөргөгчтэй агуулах, хүйтэн сүлжээ дутмаг ● Иргэд загас боловсруулах, хоол хийх аргыг мэдэхгүй байгаа. ● Загас агнуурын нөөц хязгаарлагдмал ● Үржүүлгийн төсөлд төрөөс дэмжлэг үзүүлдэггүй ● Ажиллах хүчний хомсдлоос хамаараад загасны нөөцийн менежментийн тогтолцоо хангалтгүй ● Загасны нөөцийн судалгаа хийх хөрөнгө мөнгө дутмаг	**Сул тал × Боломж** ● **Загас барих боломжтой нуурууудын эргэн тойронд боловсруулах үйлдвэрүүдийг хөгжүүлэх (тоног төхөөрөмж, түүхий эд, бүтээгдэхүүн хадгалах агуулах нэвтрүүлэх)** ● **Загас боловсруулагч ААН-үүдийг боловсруулалт, эрүүл ахуйн менежментийн сургалтанд хамруулах** ● **Загасан бүтээгдэхүүний хэрэглээг сурталчлах үйл ажиллагааг хэрэгжүүлэх (хоолны сургалт, хоол хийх аргыг сурталчлах)**	**Сул тал × Эрсдэл** ● **Загасны нөөцийн (хамгаалалт, ашиглалт) мэргэжилтнийг хөгжүүлэх, байгаль хамгаалагчдын тоог нэмэгдүүлэх** ● **Нөөцийг хамгаалах зорилгоор экспортын хэмжээг хязгаарлах, барьж болох хэмжээг загасны зүйл тус бүрээр тогтоох** ● **Нөөцийн тоо хэмжээний судалгааг тогтмол хэрэгжүүлэх** ● **Тоног төхөөрөмж худалдан авалт болон үржүүлгийн ажилд татаас олгох тогтолцоо нэвтрүүлэх**

Зураг 2.46 Түүхий загасны нэмүү өртгийн сүлжээний SWOT шинжилгээ
Эх сурвалж: Жайка төслийн баг боловсруулав.

Загасны хэрэглээ бага, хүнсэнд яаж хэрэглэхийг мэдэхгүй хүмүүс ихтэй тус улсад хэрэглэхэд хялбар боловсруулсан бүтээгдэхүүн үйлдвэрлэж нийлүүлэх нь дадал болоогүй загасаг хүнсэнд хэрэглэхэд учрах саад тотгорыг багасгаж, худалдан авах сонирхлыг нэмэгдүүлнэ. Өөрөөр хэлбэл, боловсруулах үйлдвэрүүдийг хөгжүүлэх нь загасны хэрэглээг дэлгэрүүлэх эхний алхам юм. Байгалийн тусгай хамгаалалттай газарт ороогүй, загасны нөөц ашиглахад хязгаарлалт байхгүй, загас агнуурын нөөцөөр баялаг нуурын ойр орчмыг боловсруулах байгууламж барих зорилтот газраар сонгох хэрэгтэй. Энэ нь нөөц шавхагдах эрсдэлийг бууруулахын зэрэгцээ шинэхэн загас боловсруулах боломжыг бий болгоно. Загасны хэрэглээг дэлгэрүүлэх үйл ажиллагааны тухайд эхний ээлжинд сурталчлах нэг орон нутгийг сонгоно. Тухайн нутагт загасаар хийсэн хоол тогтсон хэрэглээ болж чадвал загас тухайн нутгийн онцлог бүтээгдэхүүнээр зогсохгүй аялал жуулчлалын бүтээгдэхүүн болно.

Нөөцийн хомсдолоос зайлсхийх нь арилжааны загас агнуурын гол нөхцөл юм. Нөөц хомсдохоос урьдчилан сэргийлэхийн тулд нөөцийн судалгааг тогтмол хийж, нөөцийн хэмжээг тодорхойлох, үржүүлгийн төслөөр нөөцийг нөхөх явах хэрэгтэй. Өмнө нь ОХУ-аас загасны нөөцийн нарийвчилсан судалгаа хийж, үр дүнд нь тулгуурлан загас агнуурыг хийдэг байсан бол зах зээлийн эдийн засагт шилжсэнээс хойш ижил хэмжээний судалгаа хийх нь ховордсон. Загас үржүүлгийн ажлын тухайд дотооддоо загас үржүүлгийн чиглэлээр судалгаа хийдэг төрийн бус байгууллага, холбоод байдаг ч өнөөг хүртэл бодитоор бүрэн хэрэгжиж чадаагүй байна. Дотоодын зарим холбогдох хүмүүс Хятадаас загас үржүүлгийн технологийн хамтын ажиллагаа явуулах

зөвшөөрөл авсан байна[86]. Хятадын дэмжлэгийг аван үржүүлгийн технологийг хөгжүүлж, үр дүн гаргахад зорьж ажиллах шаардлагатай. Нөөцийн судалгаа, үржүүлгийн ажил аль аль нь их хэмжээний хөрөнгө мөнгө, мэргэшсэн хүний нөөц шаардах тул хүний нөөцөөр хангах, сургах, бэлтгэх, урт хугацааны зардлыг төлөвлөх шаардлагатай.

2.4 ХАА-н нэмүү өртгийн сүлжээ хөгжүүлэхэд шаардлагатай бусад хэтийн төлөв

2.4.1 Худалдааны хэлэлцээр

(1) Худалдааны хэлэлцээр

Одоогийн байдлаар Монгол Улсад бусад улстай байгуулсан болон нэгдэн орсон экспортыг дэмжихэд чиглэсэн 16, зөвлөлдөж эхэлсэн 5 гэрээ хэлэлцээр байна (Хүснэгт 2.24). Үүнээс Хятад, Солонгос, Евразийн эдийн засгийн холбоо нь ХАА-н бүтээгдэхүүний экспорт хийх хүлээлттэй зах зээл мөн. Орос улсруу экспорт хийх гаалийн процедур, эрүүл ахуйн нөхцлийн журам нь Евразын журмын дагуу бөгөөд, Евразийн эдийн засгийн холбоо руу хийх экспортын процедурын туршлага Монголд хуримтлагдаж (бүрдэж) байна. ITC-ийн шинжилгээгээр, экспортын боломж болон одоогийн нөхцөл байдлын ялгаа ихтэй орнуудаас хэлэлцээр байгуулаагүй орнууд нь Тайвань, Тайланд, Вьетнам, Иран зэрэг орнууд байна[87]. Гэхдээ бүс нутгийн ердийн болон хөнгөлөлттай худалдааны хэлэлцээр нь тухайлбал гарал үүслийн гэрчилгээ нэгтэй ч тухайн хэлэлцээрээр гарал үүслийн норм ба журам нь өөр байх ба түүний агуулга, процедур нь ихээхэн төвөгтэй байдаг. Бүтээгдэхүүнээ экспортлох хүсэлтэй ХАА-н салбарын ААН-үүд дотор ЖДҮ эрхлэгчид олон байгаа бөгөөд тэдний хувьд хэлэлцээрийг бүрэн ойлгож хамгийн ашигтай нөхцлийг сонгон, тогтоосон журмын дагуу процедурыг гүйцэтгэхэд төвөгтэй. Энэ чиглэлээр жижиг, дунд бизнес эрхлэгчид хялбархан ашиглаж болохуйц, дэмжлэг үзүүлэх хөтөлбөр хэрэгтэй байна. Засгийн газар хоорондын хэлэлцүүлгээр харилцагч улсаас ирүүлсэн нөхцөлийг хувийн хэвшлийнхэнд танилцуулахгүйгээр Засгийн газрын хүрээнд шийдвэрлэх явдал байдаг. Засгийн газрын байгууллага хоорондын хамтын ажиллагаа сул, хувийн хэвшлийнхний хэрэгцээ, тулгамдаж буй асуудал Засгийн газарт хүрэхгүй байна. Хэлэлцээрт ахиц гардаггүй шалтгаан нь харилцагч орны нөхцөл байдлаас хамаарах асуудал бий ч хувийн хэвшил болон бусад холбогдох талуудын оролцоо зохицуулалт байдаггүй явдал мөн. Монгол Улсад одоо хүчинтэй байгаа цорын ганц эдийн засгийн түншлэлийн хэлэлцээр нь Японтой байгуулсан ЭЗТХ байгаа ч Япон руу хийх экспортын хувьд энэхүү ЭЗТХ-ийн хүрээнд МАА, ГТ-ийн бүтээгдэхүүний давуу тал нь ДХБ-ын хэлэлцээр болон ердийн хөнгөлөлттэй нөхцөлтэй хэлэлцээртэй харьцуулахад хязгаарлагдмал байна. Хонины өлөн гэдэс, гурвалжин будаа, хушны самар, жимсгэний төрөл зэргийн хувьд давуу талтай ч бусад бүс нутгийн хэлэлцээртэй харьцуулахад түүний давуу тал нь тийм ч сайн биш байна. Цаашилбал сүүн бүтээгдэхүүн болон махны хувьд эрүүл ахуй, ургамлын хорио цээрийн дэглэмээс болоод туйлын хязгаарлагдмал, энэ нөхцөл байдал олон жил үргэлжилж байна. Япон-Монголын ЭЗТХ-ийн төр

[86] Б.Мэндсайхан, ШУА-ийн Газарзүй, геоэкологийн хүрээлэнгийн Усны нөөц, ус ашиглалтын хэлтэс.
[87] ITC Экспортын потенциалийн зураглал 2023 оны 3 сард холбогдсон

хувийн хэвшлийн хамтарсан судалгаагаар Монголоос хүнс, МАА-н болон ГТ-ийн хувьд ургамлын хорио цээр (SPS) болон худалдааны техникийн саадын хэлэлцээр (TBT) -ийн салбар болон "Өндөр нэмүү өртөг шингэсэн ХАА-н бүтээгдэхүүний үйлдвэрлэл" болон "Чимэглэлийн цэцэг, МАА, ГТ"-н чиглэлээр хамтран ажиллах хүсэлт тавьсан байдаг. Гэвч одоог хүртэл ГТ, МАА-н бүтээгдэхүүний Япон руу хийх экспорт хязгаарлагдмал хэвээрээ байна.

Хүснэгт 2.24 Монголын худалдааны хэлэлцээрүүд

Хэлэлцээрийн нэр	Статус	Байгуулсан/ хэрэгжиж эхэлсэн он
Улс хоорондын хэлэлцээр		
ЭЗТХ Монгол-Япон	Хүчин төгөлдөр	2016
Монгол-Каналдын чөлөөт худалдааны хэлэлцээр	Хэлэлцээр эхэлсэн	2010
Монгол-Хятадын ЧХХ	Хэлэлцээр эхэлсэн	2010
Монгол-Солонгосын ЧХХ	Хэлэлцээр эхэлсэн	2016
Монгол- Камбожийн ЧХХ	Хэлэлцээр эхэлсэн	2020
Монгол-ЕХ-ны ЧХХ	Хэлэлцээр эхэлсэн	2020
Бүс нутаг хоорондын хэлэлцээр		
АРТА(Хуучнаар Бангконгийн гэрээ)	Хүчин төгөлдөр	2021
Тарифийн хөнгөлөлт		
Австралитай байгуулсан тарифын хөнгөлөлтийн ерөнхий хэлэлцээр	Хүчин төгөлдөр	1966
Японтой байгуулсан тарифын хөнгөлөлтийн ерөнхий хэлэлцээр	Хүчин төгөлдөр	1971
Норвегтай байгуулсан тарифын хөнгөлөлтийн ерөнхий хэлэлцээр	Хүчин төгөлдөр	1971
Шинэ Зеландтай байгуулсан тарифын хөнгөлөлтийн ерөнхий хэлэлцээр	Хүчин төгөлдөр	1972
Швейцарьтай байгуулсан тарифын хөнгөлөлтийн ерөнхий хэлэлцээр	Хүчин төгөлдөр	1972
Канадтай байгуулсан тарифын хөнгөлөлтийн ерөнхий хэлэлцээр	Хүчин төгөлдөр	1974
Америктай байгуулсан тарифын хөнгөлөлтийн ерөнхий хэлэлцээр	Хүчин төгөлдөр	1976
Турктай буурай хөгжилтэй орнууд	Хүчин төгөлдөр	2002
Европын холбоотой байгуулсан тарифын хөнгөлөлтийн ерөнхий хэлэлцээр	Хүчин төгөлдөр	2005
Арментай хөгжиж буй орнуудын хэлэлцээр	Хүчин төгөлдөр	2015
Киргизстантай хөгжиж буй орнуудын хэлэлцээр	Хүчин төгөлдөр	2015
Беларустай (EAEU) хөгжиж буй орнуудын хэлэлцээр	Хүчин төгөлдөр	2016
Казакстантай (EAEU) хөгжиж буй орнуудын хэлэлцээр	Хүчин төгөлдөр	2016
ОХУ-тай (EAEU) хөгжиж буй орнуудын хэлэлцээр	Хүчин төгөлдөр	2016
Англитай байгуулсан тарифын хөнгөлөлтийн ерөнхий хэлэлцээр	Хүчин төгөлдөр	2021

Эх сурвалж: ITC-ийн судалгаа

(2) Худалдааны журам

Монголын ХАА-н бүтээгдэхүүн ерөнхийдөө өндөр үнэтэй. Тэр нь эрс тэс уур амьсгал, өргөн уудам нутагт цөөн хүн амтай, эх газрын улс г.м аятай бус нөхцлөөс шалтгаалах нь их. Нөгөө талаар, экспортын журам нь маш их чирэгдэлтэй, удирдлагын босоо тогтолцоо нь зардлыг улам нэмэгдүүлдэг. Худалдааны ложистикийн тухайд, дэлхийн банк 2007 оноос тогтмол судалгаа хийж, ложистикийн гүйцэтгэлийн индекс (LPI)-г нийтэлж байгаа бөгөөд гаалийн журмын үр ашиг, ложистикийн чанарыг үнэлж байгаа бөгөөд[88], Монгол нь ложистикийн гүйцэтгэлийн индексээр 2018 онд 2,37 пунктээр 160 улсаас 130-д орж байв. 2023 онд 2,5 пунктээр 139 улсаас 97-д, Тажикстан, Гана улстай зэрэгцэж байна[89].Хэдийгээр COVID-19-ийн нөлөөнд байсан ч гэсэн дэлхий нийтээрээ ложистикийн гүйцэтгэлийн индекс (LPI)-ийг хялбаршуулах чиглэлд шилжиж, Монголд ч бас сайжирч байна. Жишээ нь, стратегийн хүнс болох махыг экспортлох тохиолдолд Мэргэжлийн Хяналтын Ерөнхий Газрыг (МХЕГ-ыг) (GASI) татан буулгахаас өмнө очих газар хаана ч байсан МХЕГ-ыг оролцуулаад 7 байгууллагаас бичиг авах шаардлагатай, тэдгээрийг бүрэн бүрдүүлэхэд нийтдээ 312 цаг, 245,500 төгрөгийн зардал гардаг байв[90]. Мах экспортлодог компани 7 байгууллагад хүсэлт өгөхөд шаарддаг бичиг баримт нь 29 төрөл, түүнээс 8 нь 2-оос дээш удаа өгөх давхардалтай бичиг байдаг байна. Гаалийн тарифын хувь хэмжээг тогтоохын тулд импортлогч улсын гаалийн байгууллага зарим тусгай барааны тодорхойлолтыг тогтоох явдал байдаг. Импортлогч улсын шаардлагыг бичиг баримт /гэрчилгээ/ гаргагч байгууллага мэдэхгүй байх, ААН-ийн лавлагаа хангалтгүй байх зэрэг тохиолдол гардаг бөгөөд энэ нь бүтээгдэхүүний алдагдал, өртөг нэмэгдүүлэхэд хүргэдэг байна. Энэ байдлыг сайжруулахын тулд Монгол Улсын Засгийн газар төрийн үйлчилгээг цахимжуулах, нэг цонхны үйлчилгээг хөгжүүлэх зэрэг арга хэмжээнүүдийг хэрэгжүүлж байна. Үүний нэг нь ХХААХҮЯ-наас удирдан ажиллуулдаг вэбсайтаас[91] мах, махан бүтээгдэхүүний эрүүл ахуйн гэрчилгээ, Хятад улс руу үхрийн мах экспортлоход шаардагддаг малын эмнэлгийн гэрчилгээ, Хятад улсруу экспортлох дулааны аргаар боловсруулсан үхэр, хонь, ямааны махан бүтээгдэхүүний мал эмнэлгийн гэрчилгээг авах боломжтой болсон.

Хүснэгт 2.25 Худалдаанд тулгардаг асуудал ба авах арга хэмжээ

Асуудал, бэрхшээл	Арга хэмжээ
• **Шаардлага хангаагүй гэрээ хэлэлцээр:**Хоёр улсын болон бүс нутгийг хамарсан худалдааны хэлэлцээр цөөн, худалдааны хэлэлцээр ахицгүй, хувийн секторын хэрэгцээ, бодит байдал худалдааны бодлогод тусгагдагүй, өмнөх ажлуудын сургамжийг ашигладаггүй, экспортын стратеги бүрхэг	• Худалдааны хэлэлцээрээр мэргэшсэн ТАХ, төрийн байгууллагын хүний нөөцийг сургах • Төрийн байгууллага хоорондын мэдээлэл солилцох тогтолцоо бүрдүүлж үүрэгжүүлэх • Холбогдох төрийн байгууллагууд, мэргэжлийн холбоодыг оролцуулсан зөвлөлдөх уулзалтыг тогтмолжуулах • Түнш оронтой бодлогын уулзалт зөвлөлгөөн хийх, орон нутгийн хүний нөөц, гадаад дахь байгууллагыг ашиглах
• **Төвөг чирэгдэлтэй, үр ашиггүй худалдаа:** Холбогдох байгууллагын ажил хариуцсан хүмүүсийн мэдлэггүй байдал, мэдээлэл,	• Мэдээллээ тогтмол шинэчилж, ил тод мэдээлж байх системтэй болох • Нэг цэгийн үйлчилгээ, цахимжуулалт,урьдчилсан

[88] Индексийг бүрэлдэхүүн элемент ба Монголын оноо нь, ① Гаалийн журмын үр ашигтай байгаа эсэх =(2.5),② Тээврийн дэд бүтцийн чанар=(2.3), ③ Олон улсын тээврийн сүлжээнд дэх үнийн өрсөлдөөн =(2.5),④ Ложистикийн чанар (чадвар)=(2.3), ⑤ Ачаат мөшгих боломж =(2.4),⑥ Ачаат хүлээн авагчид цагт нь хүлээлгэн өгөлт =(2.7),Нийт оноо=2.5. Бүрэн оноо нь 5.2018 онд 1-р байрт Герман =4.2,2023 онд Сингапур=4.3 байв.
[89] https://lpi.worldbank.org/ (2023 оны 4 сарын 26-нд холбогдов)
[90] Дэлхийн банк (2021) Экспортын бүрдүүлэлтэд хийсэн шинжилгээ
[91] MOFALI One Window Service: https://export.mofa.gov.mn

Асуудал, бэрхшээл	Арга хэмжээ
холбогдох байгууллагын бичиг баримт боловсруулах чадваргүй байдал, хугацаа их зарцуулдаг, алдаа гаргадаг, албан хаагчид өөрийн үзэмжийн журамтай, шаардлага хангахгүй ложистик үйлчилгээ	бүртгэлийн тогтолцоог нэвтрүүлэх • Бичиг баримтыг дахин боловсруулах, журмуудыг ил болгох, хялбаршуулах (маягт, шалгах хуудастай болох) • Бүх бизнесийн хэрэгжүүлэх удирдамж, тодорхой журам боловсруулах, албан хаагчдыг сургах • Экспедиторуудыг сургах
• **ААН-ийн чадвар дутах:** Зорилтот зах зээлийн тухай мэдээлэл цуглуулах, анализ хийх чадвар сул,худалдааны хэлэлцээрийн тэргүүлэх дараалыг ашиглахад хүндрэлтэй, гааль, шаарддаг зүйлсийн анализын чадвар дутмаг, харилцагч орны шаардлагыг сайн ойлгодоггүй, дутуу дулимаг, хууль бус журам, худалдан авагчтайгаа сул харилцаатай	• ААН-д тусалдаг институцыг сургаж бэлтгэх, төрийн байгууллага хувийн секторын уулзалт зөвлөлгөөнийг тогтмолжуулах • ААН-д зориулсан сургалт хийх, ААН-ийн үйлдвэрлэлийн хэрэгслийн хөрөнгө оруулалтыг дэмжих, худалдааны хэлэлцээр хийхэд нь туслах • Өмнөх жишээ, тохиолдлын мэдээлэл цуглуулж хуримтлуулах, нийтэд мэдээлэх, мэдээллээр хангах үйлчилгээ, хэлэлцээрт туслах • ААН-д зориулсан сургалт хийх

Эх сурвалж: ЖАЙКА төслийн баг боловсруулав.

Тэмдэглэл： Экспортын бичиг баримт бүрдүүлэлтэд тулгардаг саад бэрхшээл

Жишээ 1: Монголын хонины өлөн гэдэс сонирхдог Япон компани Японы талын зөвшөөрөлтэй үйлдвэрээс хонины (ямааны) өлөнгийн дээжийг Япон руу авч орох гэсэн байна. Гэвч, экспортлогч ААН-ийн бүрдүүлсэн бичиг баримтад бичсэн үйлдвэрийн хаяг нь бүртгүүлсэн хаягтай зөрсөн тул хорио цээрийн алба нэвтрүүлээгүй байна. Үүний улмаас худалдаа амжилтгүй дууссан.

Жишээ 2: Байгалийн цэцэгсийн зөгийн балыг Японд экспортлох тохиолдолд, Японы гаалийн байгууллагад экспортлогч улсын холбогдох байгууллагын гаргаж өгсөн найрлагын шинжилгээний хуудсыг явуулах шаардлагатай байдаг. 2022 онд Японд 340 кг бал экспортлосон бөгөөд, Японы гаалиар нэвтрэх гэж 4 долоо хоног зарцуулсан. Энэ хугацаанд мэдээж агуулахын зардал гарсан. 4 долоо хоног саатсны учир нь шинжилгээ хийсэн байгууллагын гаргаж өгсөн найрлагыг тодорхойлсон хуудсанд бичилтийн алдаа байсан, компаний нэрийг буруу бичсэн, бусад бичиг баримттай зөрж байсан гэнэ. Японы тээвэрлэгч компани ч, импортлогч ААН ч зөгийн бал импортлож байсан туршлага байхгүй байсан нь бүр их цаг алдуулсан. Мөн Монголоос гарахаас өмнө ч шинжилгээний хуудсыг дахин гаргуулах зэргээр ердийнхөөс их хугацаа зарцуулсан. ААН, шинжилгээний лабораторийн хоорондын үл ойлголцлын улмаас зөгийн балны очих газар, ААН-ийн Англи нэр, Японы гаалийн шаардсан зүйлүүдийн талаар мэдээллээ өгөөгүй байсан нь гол шалтгаан болсон байна.

Дээрх хоёр тохиолдол нь мэдүүлгийн тогтсон маягттай, шалгах хуудастай байсан бол сэргийлэх боломжтой асуудал юм. Мөн импортлогч компаниар дамжуулан Японы хорио цээр болон гаалийн дэглэмийн талаар урьдчилан зөвлөлдсөн тохиолдолд эрсдлийг бууруулах боломжтой байж.

2.4.2 Чанар, эрүүл ахуйн хяналт

(1) Төрийн хяналтын чиг үүрэг

Өнгөрсөн жил МХЕГ татан буугдаж, бусад холбогдох салбарын яамдын бүтцэд багтах болсон. Байгууллагуудын ажил үүргийн хуваарилалтын зарим асуудал одоо тогтворжоогүй байна. Ажиллах хүчний урамшуулал дэмжлэг, салбарын төрийн албан хаагчдыг сургаж бэлтгэх хөтөлбөр боловсруулахтай уялдуулахын зэрэгцээ аль болох хурдан цэгцлэх шаардлагатай. ХАА-н бүтээгдэхүүнийг экспортлохын тулд импортлогч улсын засгийн газартай ХАА-н бүтээгдэхүүний эрүүл ахуйн нөхцлийг тохирч, тэр нөхцлийг хангаж байгааг баталгаажуулж байж экспортлох боломжтой болдог ч МУ нь шүлхий зэрэг хил дамнасан малын халдварт өвчний голомттой улс бөгөөд бусад улстай нутаг нь хил залгаа оршдгийн дээр бэлчээрийн МАА зонхилдог учир

Монголын дотооддоо авдаг арга хэмжээг импортлогч улс нь зөвшөөрдөггүй тохиолдол бий. Тиймээс бодит байдал дээр экспорт нь зарим нэг улс, эсвэл ганц нэгхэн бүтээгдэхүүнээр хязгаарлагдаж байна. Импортлогч улс нь Монголын дотоодод хэрэгжүүлдэг бодлого, арга хэмжээг зөвшөөрөх эсэх нь импортлогч улсын зах зээлийн эрэлт хэрэгцээ, улс төрийн хүчин зүйл зэргээс болж жигд биш байдаг ч экспорт хийхэд импортлогч улсын шаардлагад нийцүүлэхээс өөр аргагүй юм. Импортлогч улсын шаарддаг, шинжилгээ хийж дүгнэлт гаргадаг байгууллага нь ISO17025 стандартаар магадлан итгэмжлэгдсэн лаборатори байх ёстой гэх мэт нөхцлийг импортлогч тал тавих нь түгээмэл байдаг. Монгол дотроо ISO-ийн гэрчилгээтэй байсан ч импортлогч улсын итгэмжлэлийн байгууллагаар баталгаажуулахыг шаардах тохиолдол бий бөгөөд энэ нь Монгол Улсын дотоодын магадлан итгэмжлэх байгууллагад итгэхгүй байгаа хэрэг юм. Магадлан итгэмжлэх байгууллагын үнэлгээний чадавхийг сайжруулах шаардлагатай. Экспортын барааг шинжилдэг лаборатори нь төсөв багатай, шинжилгээний багаж төхөөрөмжүүд нь хандиваар цугларсан, шинжилгээг үр дүнтэй хийж чаддаггүй. Мөн тоног төхөөрөмж дутах, урвалж бодис хүрэлцээгүйгээс болж CAC стандартын шаардлагын дагуу шинжилгээ хийх боломжгүй тохиолдол бий. Шинжилгээ хийлгэх дээж цөөн байх юм бол туршлага сууж шинжлэх чадварыг сайжруулахад бэрхшээлтэй. ААН-үүд нь МХЕГ-аас хийсэн шалгалт, дээж авах, эсвэл лабораторийн харилцааны талаар сэтгэл дундуур байдаг яриа ч сонсогддог. Хувийн сектор болон төрийн байгууллага хоорондын мэдээлэл солилцоо, санал солилцох зэрэг чухал асуудлыг зохион байгуулж шийдвэрлэх шаардлагатай.

(2) ААН-үүдийн үйл ажиллагаа

ХАА-н бүтээгдэхүүнийг экспортлох тохиолдолд импортлогч улсын хорио цээрийн алба нь бичиг баримт шалгах, түүвэр шалгалт хийдэг бөгөөд тэгэхэд ургамал хамгаалах бодисын үлдэгдлийн стандарт утга ихэвчлэн зөрдөг. Энэ мэт өөрчлөлтийн /ялгаа зөрөөний/ талаар импортлогч талын сүүлийн үеийн мэдээлэл цуглуулах нь ААН-үүдэд ихээхэн дарамттай байдаг, энэ талаар төрийн байгууллага болон салбарын мэргэжлийн холбоодын дэмжлэг туйлын хязгаарлагдмал байна. Экспортлох зах зээлдээ гарахын тулд экспорт хийх гэж байгаа зах зээлийн шаардлагын түвшинд хүрсэн чанарын хяналт, баталгаа шаардагдана. Илүү саадгүй арилжаа хийхийн тулд гэрчилгээ авах ажил дэлхий нийтэд өрнөж байгаа ба Монголд мөн адил байна. Хүнс үйлдвэрлэлийн салбарт бол HACCP (эгзэгтэй цэгийн хяналт) шаарддаг улс олон бол, лалын шашинт улс руу экспортлоход Халалын гэрчилгээ шаарддаг. Гэрчилгээний тухайд, ААН дангаараа нэвтрүүлэхэд ачаалал ихтэй, зөвлөх үйлчилгээ шаардлагатай байдаг. Монголын баталгаажуулалтын байгууллагууд нь зөвлөх үйлчилгээний нэгжтэй хэдий ч баталгаажуулалтын бие даасан байдал хангагдаагүй байна. Баталгаажуулалтын байгууллагын үнэлгээний чадварт эргэлздэг ААН ч байна. Монголын баталгаажуулалтын байгууллагын өгдөг Халалын гэрчилгээ нь зөвхөн Монголд л хүчинтэй бөгөөд импортлогч улсын хувьд хүлээн зөвшөөрөгдөөгүй байдаг. НҮБ-ын АҮХБ-аас хэрэгжүүлж байгаа экспортыг дэмжих төсөл (UNIDO Export Promotion Project)-өөр магадлан итгэмжлэх байгууллагыг чадавхижуулах, баталгаажуулалтын байгууллагыг бэхжүүлэх, ААН-ийн гэрчилгээ авахыг дэмжихийн зэрэгцээ Монголын гаргадаг Халалын

гэрчилгээ, импортлогч орны зөвшөөрөг гэрчилгээг харилцан зөвшөөрөг болгохыг зорьж байгаа бөгөөд, энэхүү тусламжийг үргэлжлүүлэх шаардлагатай. Мөшгих тогтолцоо нь мах сүү, арьс шир, зөгийн балыг хамарч байгаа ч мөшгих боломжтой бүтээгдэхүүн цөөн тоотой байна. Дотоодын зах зээлд цөөхөн бараанд QR код хадсан харагдавч хамралт багатай,харин экспортын тухайд мөшгих тогтолцооны бүрдүүлэлт нь ахицтай байна.

Нэмүү өртгийн сүлжээний оролцогчдод үйлчлэх хүртээмжийг сайжруулах, түгээн дэлгэрүүлэх нь чухал байдаг. Монголд Хүнсний тухай хууль, Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлын тухай хууль батлагдаж, хүнсний бизнес эрхлэгчид ХАА-н зохистой дадал (ХААЗД) (GAP), Эрүүл ахуйн зохистой дадал (ЭАЗД) (GHP), Үйлдвэрлэлийн зохистой дадлыг (ҮЗД) (GMP) нэвтрүүлж хүнсний аюулгүй байдлыг хангахыг албажуулсан байдаг. Хууль батлагдсан хэдий ч хэрэгжилт хоцрогдолтой байна. Боловсруулах шатны хүнсний эрүүл ахуйн хяналтын тухайд, том ААН болон экспорт хийдэг ААН-үүд ХАА-н болон Үйлдвэрлэлийн зохистой дадлыг нэвтрүүлж, HACCP болон ISO 22000, FSSC22000 гэрчилгээтэй ААН-үүд нэмэгдэж байна. Харин ЖДҮ эрхлэгчдийн бталагаажуулалт авах ажил хоцронгуй байна. ХААЗД-ын хувьд албан ёсоор хуульчлагдсан бүтээгдэхүүн нь жимс жимсгэнэ төдий бөгөөд дөнгөж нэвтрүүлж эхэлж байна. Жимс, ногооны ХААЗД-ын хувьд ч гэсэн, 3-дагч этгээдийн гэрчилгээний зардлыг төлөх чадвартай өрхийн тариаланч цөөн, ахиц удаан байна. Дотоодын зах зээлд ХААЗД болон HACCP (эгзэгтэй цэгийн хяналт)-ийн гэрчилгээ авахыг шаардахгүй, ялангуяа хөдөөгийн зах зээлд бол Монголын стандартын шаардлагыг хангаагүй хүнс ч зарагдаж байна. Одоогоор дотоод зах зээлд баталгаажуулалт авсан ч үнэ өртөгтөө шингээх боломжгүй, ААН-үүд нэвтрүүлэх зардлыг төлөх хэрэгтэй болдог. Гэрчилгээ авахад зөвлөх үйлчилгээ, тоног төхөөрөмжийн хөрөнгө оруулалт,үнэлгээний зардал гэх мэт нэвтрүүлэлтийн үеийн зардлаар зогсохгүй гэрчилгээгээ хадгалах зардал ч мөн шаардлагатай бөгөөд, ААН-ийн хувьд дарамт ихтэй байна. Нийлүүлэлтийн сүлжээний экспортын чиглэлд болон дотоод нийлүүлэлтэд тавигддаг чанарын хяналтын түвшин ч ялгаатай байна. Дотоодод бол хотод болон хөдөөд тавигддаг шаардлагын түвшин хүртэл өөр байна. Энэ байдал нь чанарын хяналтыг сайжруулахад саад болж байна. Экспортын чиглэл болон дотоодын шаардлага нь өөр өөр учир улсын хэмжээнд чанарын хяналтын түвшин доогуур байгааг, дээшлүүлэх шаардлагатай боловч зах зээлд нийлүүлэгдэх барааны чанар болон баталгаажуулалтын байдал өөр байгаагаас,хүнсний бизнес эрхлэгчдийн чанарын хяналтын ач холбогдлын тухай ойлголт янз бүр байх нь ойлгомжтой. Одоогоор зах зээлийн дарамт шахалт байхгүй ч супермаркетаар дамжуулж борлуулах нь ердийн үзэгдэл болж, иргэдийн сонирхол хандлага дээшилж ирвэл дотоодын зах зээл дээр ч чанар, аюулгүй байдалд илүү мэдрэмтгий болж эхэлнэ гэж таамаглаж байна. Хүнсний бизнес эрхлэгчид зах зээлийн хувиралд бэлэн байх шаардлагатай ч, чанарын хяналтын тухай мэдээллийг хүнсний бизнес эрхлэгчдэд түлхүү хүргэх мэргэжлийн байгууллага дутмаг байна. Үйлдвэрлэгч болон ААН-ийн удирдах менежерүүд нь чанарын хяналтын тухай ойлголттой, чанарын хяналтын мэдлэгтэй мэргэжлийн хүний нөөцийг ажиллуулах, ажилчдаа сургадаг байх шаардлагатай. Өнөөг хүртэл МХЕГ-аас хүнсний бизнес эрхлэгчдийг хамруулсан хүнсний аюулгүй байдалтай холбоотой сургалт хийдэг байсан. Сургалтыг тогтмол хийж ирсэн ч сургалтын чанар, үр дүнг үнэлэх ажил хангалтгүй байна.

Хүснэгт 2.26 Чанар, эрүүл ахуйн хяналттын тулгамдсан асуудал, авах арга хэмжээ

Асуудал, бэрхшээл	Авах арга хэмжээ
• **Төрийн байгууллагын удирдах чадвар бүрэн дүүрэн дайчлагддаггүй :** ・ Хүнсний аюулгүй байдлын асуудал хариуцсан ТБ-уудад бүтцийн өөрчлөлт хийгдэж байгаа, ажлын байрны тодорхойлолт, гүйцэтгэх үүрэг нь тодорхой бус байна, тавьж буй зорилго нь бүрхэг, хянах үүрэг нь тогтворгүй байгаа, уялдаа холбоогүй. ・ Хил дамнасан малын халдварт өвчний дэгдэлт ・ Хүнсний аюулгүй байдлын чиглэлийн хүний нөөц болон, ТАХ-чийн сургалтын хөтөлбөр хангалтгүй ・ Хувийн хэвшлийнхний хүндрэл, сэтгэл дундуур байдал төрийн байгууллагад хүрдэггүй ・ Хийж гүйцэтгэсэн сургалтын үнэлгээг хийдэггүй.	• Хүнсний аюулгүй байдлын асуудал хариуцах төрийн байгууллагыг бүрдүүлэх, хариуцлагыг тодорхой болгох • Хүнсиний аюулгүй байдлын хяналтын зөвлөлийн хурлыг тогтмолжуулах • Малын эмч нарын төлөвлөгөөт сургалтыг үүрэгжүүлэх, вакцинжуулалтыг сайжруулах, мэдээлэлжүүлэлтийг эрчимжүүлэх • Зөвлөх урих, ТХА-ны төсөл хэргжүүлэх • Хувийн сектортой тогтмол зөвлөлдөх уулзалт хийх, мэргэжлийн холбоотой санал солилцох уулзалт • Бодлогын үнэлэлт хийх үр дүнг хэмжих, мониторингийн үйл ажиллагааг бэхжүүлэх
• **Хяналтын байгууллагын сургалт хангалтгүй :** ・ Мониторинг хийх туршилт хангалтгүй ・ Магадлан итгэмжлэлийн үнэмшил доогуур ・ Лабораторийн шинжилгээний чадвар хүрэлцээгүй ・ Экспор хийх гэж буй улсын шаарддаг шинэ мэдээлэл дутмаг	• Баталгаажуулалтын байгууллагын шинжилгээний чадварыг дээшлүүлэх, хуулв эрх зүйн үндэслэлтэй болгох • Төсвийн хуваарилалт, хяналтын байгууллага байгуулах төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлэх, лаборантын сургалт
• **Олон улсын түвшний чанарын баталгаа хязгаарлагдмал** : ・ Баталгаажуулалтын талын мэдээлэл хомс тэнцэх чадваргүй ・ Баталгаажуулалтын байгууллага болон шинжээчийн тоо хүрэлцээгүй, баталгаажуулалтын чадвар дутмаг ・ Баталгаажуулалтын зардал ААН-д дарамт болдог ・ Мөшгилтийн систем дутмаг	• МХАҮТ болон мэргэжлийн холбоодын мэдээлэл цуглуулах, түгээх чадварыг бэхжүүлэх • Гадаадтай сүлжээ үүсгэхэд дэмжлэг үзүүлэх, харилцан зөвшөөрөх оролдлого/үйл ажиллагаа/ зохицуулалт хийх • Хандивлагчийн тусламжийг ашиглах, гадаадын баталгаажуулалтын байгууллага орж ирэхийг дэмжих • Төсвийн дэмжлэгийн бодлогыг хөгжүүлэх, бага хүүтэй зээл олгох, тоног төхөөрөмжийн импортын татварыг бууруулах • Олон улсын үзэсгэлэнд оролцох, гадаадад сурталчлах үйл ажиллагаа,хүнсний бизнес эрхлэгч ААН-дэд зориулсан сургалт хийх
• **ААН-ийн чадвар дутмаг байна :** ・ Түгээж /нийлүүлж/ байгаа барааны чанар жигд биш ・ Хүнсний үйлдвэрийн үйл ажиллагаа чжигд биш ・ ААН-үүдэд хүнсний аюулгүй байдлын чиглэлийн мэдээлэл өгөх мэргэжлийн байгууллага дутмаг. ・ ААН-д зориулсан сургалтын өгөөж төдий л сайнгүй байна.	• Хяналтын байгууллагын мониторингийн чадавхийг бэхжүүлэх • Хүнсний бизнесийн ААН-д сургалт хийх мэргэжлийн холбоодыг төрийн байгууллагаас мэдээллээр хангах үйлчилгээ сайжруулах, хандивлагчдын тусламжийг ашиглах • Хувийн сектортой хамтран үнэлгээ хийх, нэн тэргүүний асуудлуудыг тодорхойлох

Эх сурвалж: ЖАЙКА төслийн баг боловсруулав.

2.4.3 Санхүүгийн систем

Монгол Улсын банк төвтэй санхүүгийн сектор нь найдваргүй зээл, хөрөнгийн дутагдал, засаглалын ядуу байдлаас болж тогтвортой байдлаа алдсан. Зураг 2.47-т Монгол Улсын санхүүгийн байгууллагаас гаргасан зээлийн үлдэгдлийн өсөлтийг харуулав. Зээлийн үлдэгдэл огцом өсөх хандлагатай байгаа бөгөөд, 2023 оны 3 дугаар сарын үлдэгдлийг 2012 оны 1 дүгээр сарынхтай харьцуулахад 411%-иар өссөн байна. Үүнээс чанаргүй зээл гэгдэх зээлийн үлдэгдлийн харьцаа ч аажмаар нэмэгдэх хандлагатай байна, ялангуяа ковидын нөлөөгөөр 2020 оны 10 сараас

2021 оны 2 сарын хооронд 12% хүрч өссөн[92]. 2023 оны 3 сарын байдлаар 10% хүртэл буурсан ч дэлхийн улсуудын чанаргүй зээлийн харьцаа дунджаар 6.49%[93] байгаагаас харахад энэ үзүүлэлт өндөр хэвээр байхаар байна.



Зураг 2.47 Монгол Улсын зээлийн үлдэгдлийн өсөлт (2012~2023)

Эх сурвалж: https://www.1212.mn/en-д үндэслэн ЖАЙКА төслийн баг боловсруулав.

Мөн зээлийн хүүний тухайд, ковидын нөлөөллийг сааруулахын тулд ХАА, боловсруулах үйлдвэрлэлийн салбарт бага хүүтэй зээл олгох бодлого баримталсан бөгөөд буурах хандлага ажиглагдаж байна. Нөгөө талаар үүнийг нэг удаагийн арга хэмжээ гэж үзвэл ковидын халдвар дэлхийд тархахаас өмнөх үе, өөрөөр хэлбэл, 2020 оны 3 сараас өмнөх үеийг суурь болговол, тэр үеийн ХАА-н секторт олгосон зээлийн дундаж хүү 20.3%, боловсруулах үйлдвэрлэлийн салбарынх 15.2%, байна.Тэгэхээр ХАА-н секторынх өндөр байгаа нь харагдаж байна (Зураг 2.48).



Зураг 2.48 ХАА, боловсруулах үйлдвэрлэлийн салбарт олгосон зээлийн дундаж хүүгийн өсөлт

Эх сурвалж: https://www.1212.mn/en- д үндэслэн ЖАЙКА-ийн судалгааны баг боловсруулав

Ийнхүү санхүүгийн секторын байдлаас харахад зээлийн үлдэгдэл өндөр өсөлттэй байгаа ч эсрэгээрээ зээл авах нөхцлийг улам муутгаж, ялангуяа ЖДҮ гэх мэт барьцаа болох үнэ цэнэтэй хөрөнгөгүй хүмүүст тэр нь нөлөөлж байна. Бас саяхан хоршооны хуульд нэмэлт өөрчлөлт оруулж,

[92] ADB, FINANCE SECTOR FACT SHEET
[93] https://www.theglobaleconomy.com/rankings/nonperforming_loans/

ГТ, МАА-н хоршоо нь санхүүгийн байгууллагаас зээл авах боломжтой болсон хэдий ч одоогоор хоршоо зээл авсан практик төдий л нэмэгдэхгүй байна. Үүний учир нь 1) ГТ, МАА-н хоршоонд барьцаанд тавих үнэ цэнэтэй хөрөнгө байхгүй, 2) Тийм учраас хоршоо нь гишүүдээс барьцаа хөрөнгө авах шаардлагатай болж, 3) үүний улмаас банкны зүгээс хэт их хүчин чармайлт гаргаж (хэт хатуу шалгуур шаардаж), зардал эрсдлийн харьцаа нийцэхгүй болох шалтгаан байна[94]. Үл хөдлөх, хөдлөх, биет бус хөрөнгийн үнэлгээнд суурилсан зээл төдийгээр ийм хөрөнгөгүй ЖДҮ, ХАА эрхлэгч болон ХАА-н хоршооны санхүүгийн хэрэгцээг хангах боломжгүй нөхцөл байдалтай бөгөөд, нэмүү өртгийн санхүүжилт (Value-Chain Finance)[95], агуулахын баримт барьцаалсан зээл (Warehouse Receipt[96] гэх мэт санхүүгийн шинэ механизмыг нэвтрүүлэх шаардлагатай байна.

2.4.4 Аж үйлдвэрийн кластер

Монгол Улсад хөгжлийн түншлэгчдийн тусламжаар бүтээгдэхүүн тус бүрээр кластер үүсч байна [97] . Кластеруудад тухайн бүтээгдэхүүний үйлдвэрлэл, боловсруулалт, тээвэрлэлт, борлуулалтын асуудал хариуцсан хүмүүсээс гадна засгийн газраас ХХААХҮЯ-ны мэргэжилтэн зэрэг бүрэлдэхүүн оролцдог бөгөөд,тухайн бүтээгдэхүүний нэмүү өртгийн сүлжээг бэхжүүлэхэд саад болж байгаа хүчин зүйлсийг тогтоож асуудлыг шийдэх талаар зөвлөлддөг байна. Анхаарал татахуйц энэхүү төр хувийн хэвшлийн хамтын ажиллагааны хүрээнд үйлдвэрлэлийн салбар бүрийн кластер үүсгэх хөдөлгөөн санаачлагад сүүлийн жилүүдэд анхаарч байгаа ба хойшид ч гэсэн хөгжлийн түншлэгчдийн дэмжлэгтэйгээр кластеруудын хэмжээ томорч, төрөл хэлбэр олшрох төлөвтэй байгаа бөгөөд эдгээр кластеруудын бие даасан хөгжлийг баталгаажуулах асуудал түүний туршилт баталгаажуулалтын ажлыг нэгэн зэрэг хэрэгжүүлэх байх гэж харж байна.

ХХААХҮЯ-ны ЖДҮГ-ын мэдээллээр бол, хойшид хөгжүүлэх кластерууд нь 1) Аймгийн хэмжээнд хэрэгжих кластер, 2) хэд хэдэн аймаг дамжсан бүс нутгийн кластер, 3) Экспортын баримжаатай кластер байх юм. Эдгээрээс 1) Нэг аймгийн кластерын төлөөлөл болгож, PRO-VALUE төсөл (Германы ХАҮТ) ба МҮХАҮТ-ийн хамтын ажиллагааны хүрээнд байгуулсан Увсын чацарганын кластерыг дурьдаж болно. Мөн 3) Экспортын баримжаатай кластер гэвэл EU-TRAM -ын төсөл болох гоо сайхны барааны кластер, сарлагийн хөөврийн кластераас гадна MONMAP-AVC-төслийн дэмжлэгтэйгээр зохион байгуулсан зөгийн балны кластерыг дурьдаж болно. 2) Бүс нутгийн кластерийн талаар одоогоор жишээ болгох мэдээлэл алга байгаа ч зэргэлдээ аймгуудын ижил бүтээгдэхүүн үйлдвэрлэгчид кластер хэлбэрээр зохион байгуулагдах боломжтой.

Цаашид кластер хөгжүүлэхтэй холбоотой удирдамж, төлөвлөгөө боловсруулахад дэмжлэг үзүүлэхэд кластерийн асуудлыг хариуцах байгууллага агентлаг болох ЖДҮГ голлох үүрэг гүйцэтгэж, үйлдвэрлэл, төр засаг, эрдэм шинжилгээний байгууллагуудын оролцогч талууд Монгол Улсын кластерийн тодорхойлолт болон кластерийн хөгжлийн ирээдүйн төсөөлөл, нэгдсэн

[94] Төрийн банкны зээлийн мэргэжилтнийн ярилцлага
[95] ААН нь өөрийн нэмүү өртгийн сүлжээг хөгжүүлэхэд санхүүжилт шаардлагатай үед холбогдох оролцогчдыг (Жнь: ХАА-н бүтээгдэхүүний нийлүүлэгч болох тариаланч юм уу хоршоо г.м) дэмжснээр, тухайн ААН-ийн нэмүү өртгийн сүлжээний бүтээмж, ашиг орлого нь нэмэгдэнэ.
[96] Нөөцийн агуулахад хадгалсан ХАА-н бүтээгдэхүүний хадгалалтын байршил, тоо хэмжээ, чанарыг баталгаажуулах хувьцаа гаргах систем. Энэхүү агуулахын хувьцааг барьцаалж санхүүжилт авах боломжтой.
[97] Кластерийн тодорхойлолт: “Тодорхой салбарт хамрагдах, харилцан уялдаатай ААН байгууллагаас бүрдэх, газар зүйн хувьд хөрш зэргэлдээ оршдог бүлэг” гэсэн байна. Харин Монголд яг энэ тодорхойлолтын дагуу үйл ажиллага явуулахгүй байгаа тохиолдол ч олон бийг анхаарах хэрэгтэй.

ойлголттой болох нэн чухал юм. Үүний үндсэн дээр кластерийн төрөл хэлбэрүүдийн онцлог, чиг үүрэг, зохион байгуулалтын бүтэц зэргийг тодруулж, түүнийг хэрэгжүүлэх эрх зүйн орчныг боловсронгуй болгох шаардлагатай байна.

2.4.5 Хөгжлийн түншүүдийн үйл ажиллагаа

Монголд АХБ, НҮБ-ын ХХААБ, Дэлхийн банк зэрэг хөгжлийн түншлэгчид ХАА-н салбарт тусламж дэмжлэг үзүүлж байна. Энэхүү Мастер төлөвлөгөөг боловсруулахдаа ЖАЙКА, бусад хөгжлийн түнш байгууллагуудын өнөөг хүртэлх үйл ажиллагааны явцад гарсан олон тооны сайн жишээ, гарын авлага, туршлага сургамжийг тусган боловсруулах шаардлагатай гэж үзэв. Хүснэгт 2.27-т энэхүү Мастер төлөвлөгөөг боловсруулахтай холбоотойгоор онцгойлон судалж үзэх төслүүд, тэдгээрийн нэрс, товч агуулгыг сийрүүлэв.

Хүснэгт 2.27 Хөгжлийн түншүүдийн үйл ажиллагаа

Хөгжлийн түнш	Төслийн нэр	Хугацаа	Товч агуулга
АХБ	Иргэдийн оролцоотойгоор хүнсний ногоо тариалалтыг дэмжих, амьжиргааг сайжруулах төсөл	2017.12-2022.6	Төв, Дархан-Уул, Увс, Сэлэнгэ аймгуудад ХАА-н бүтээгдэхүүний нэмүү өртгийн сүлжээний загвар төслөөр жижиг ногоочнд, үр үйлдвэрлэл, боловсруулалт, үйлдвэрлэлийн бус улиралд өрхийн аж амьжиргааг дэмжих үйл ажиллагааг хэрэгжүүлсэн.
АХБ	Хөдөө аж ахуй, хөдөөгийн хөгжлийн төсөл	2016-2021	ГТ, МАА-н чиглэлээр шинэ бизнес эхлэх хүсэлтэй ААН-д зээл олгох, бренд хөгжүүлэлтийг дэмжих. Буцалтгүй тусламжаар эхэлсэн бөгөөд амжилттай болсон ААН-д зээлийн төсөл хэлбэрээр үргэлжлүүлж байгаа.
ЕХ	Монгол Улсад ажлын байр бий болгоход дэмжлэг үзүүлэх (SECiM) төсөл: Мал аж ахуй, хүнсний ногооны нэмүү өртгийн сүлжээн дэх хувийн хэвшлийн туршилтын арга хэмжээ	2016-2020	НҮБ-ын АҮХБ болон ХХААБ-аас хэрэгжүүлсэн. ХАА-н бүтээгдэхүү (мах, сүүн бүтээгдэхүүн, сүлжмэл, арьс шир, хүнсний ногоо) -ний нэмүү өртгийн сүлжээг хөгжүүлж, ажлыг байрыг нэмэгдүүлэх. Хувийн сектор болон орон нутгийн ТАХ-чийн чадавхийг бэхжүүлэх, бүтээмжийг нэмэгдүүлэх, чанарыг сайжруулах, ургацын хаягдлыг бууруулахад чиглэсэн арга хэмжээ хэрэгжүүлсэн.
ЕХ	Монголын худалдааг дэмжих төсөл (TRAM Project)	2017.3-2021.3	Чацарганаар гоо сайхны бүтээгдэхүүн үйлдвэрлэх, МАА-н дайвар бүтээгдэхүүн экспортлох зорилготой, Монголын ХАҮТ-тай түншлэн, ЕХ-ны зах зээлд гаргахын тулд шаардлагатай тогтолцоо бүрдүүлэх, хувийн компаниудын чанарын стандартыг дагаж мөрдөх чадавхийг бэхжүүлэх гэх мэт.
НҮБ ХХААБ	Эмэгтэйчүүдийг дэмжих замаар орон нутгийн сүүн бүтээгдэхүүний боловсруулалтыг сайжруулах	2017-2019	6 аймагт (Ховд, Хөвсгөл, Дорнод, Төв, Сэлэнгэ, Дархан-Уул) нэмүү өртөг шингэсэн сүүн бүтээгдэхүүний үйлдвэрлэл, зах зээлийг дэмжих төслийг хэрэгжүүлэв.
Германы ХАҮТ	Нэмүү өртгийн төсөл	2015-2021	Чацаргана болон ноосны нэмүү өртгийн сүлжээг бэхжүүлэхэд дэмжлэг үзүүлэх. Увсад чацарганы кластер байгуулсан. Монголд анхны газар зүйн заалтын хамгаалалтын гэрчилгээ олгох төслийг дэмжсэн.
ЖАЙКА	Улсын хэмжээний хөгжлийн нэгдсэн төлөвлөгөө боловсруулах төсөл	2018-2021	Улсын хэмжээний хөгжлийн нэгдсэн төлөвлөгөө боловсруулах төслийн хүрээнд ХАА-н салбарын хөгжлийн төлөвлөгөө боловсруулж байгаа.
ЖАЙКА	Төрийн болон хувийн малын	2020-2025	Төрийн албан хаагч болон хувийн секторын малын

Хөгжлийн түнш	Төслийн нэр	Хугацаа	Товч агуулга
	эмч нарын практик чадварыг бэхжүүлэх төсөл		эмчийн практик чадавхийг дээшлүүлэх зорилготой төсөл
ЖАЙКА	Сонгинын сортыг сайжруулах замаар шинэ брендийг тогтворжуулах, хүнсний нэмүү өртгийн сүлжээ байгуулах	2020-2025	Сонгинын үр / бөөрөнхий сонгинын үйлдвэрлэл, сонгино тариалалтын технологи нэвтрүүлэх болон нийлүүлэлтийн сүлжээг бэхжүүлэх ажил хийгдэж байна.
ШХА	Хүртээмжтэй, тогтвортой хүнсний ногоо, маркетингийн төсөл (MON-VEGI) (Монгол ногоо)	2016-2019	1) Жижиг тариаланчдад тариалах технологи зааж мэдлэг түгээх замаар дотоодын хүнсний ногооны үйлдвэрлэлийн хэмжээг нэмэгдүүлэх 2) Зах зээлийн хүртээмжийг сайжруулах замаар жижиг тариаланчид, эмэгтэйчүүдийн өрхийн орлогыг нэмэгдүүлэх 3) Хүнсний ногоо тариалах үйл ажиллагааг дэмжих замаар ядуу өрхийн хүнсний ногооны үйлдвэрлэл, хэрэглээг нэмэгдүүлэх.
ШХА	Ногоон алт төсөл	2017.1-2020.12	2004 оноос хойш урт хугацаагаар хэрэгжиж байгаа төсөл бөгөөд, маш олон сайн туршлага үлдээсэн. Малчдын амьдралыг дээшлүүлэх зорилгоор бэлчээрийг хуваарьтай ашиглахыг дэмжих, бэлчээр хяналтын бүлгийн зохион байгуулахыг дэмжих. Цахим ХАА-н салбарыг дэмижх
ДБ	Экспортыг хөгжүүлэх төсөл	2020-2023	Монголын Уул уурхайн бус албарын экспортыг нэмэгдүүлэх, экспортын зах зээлтэй холбох ажлыг өргөтгөх зорилготой 1)Экспортлох боломжтой санхүүгийн бүтээгдэхүүнийг хөгжүүлэх, 2)Үүний менежментийг хариуцах ХАА-н давхар даатгал ХХК-ний чадавхийг бэхжүүлэх, 3)ЖДААН-дэд гадаад худалдааны талаар сургалт хийх, холбож өгөх буцалтгүй тусламж үзүүлэх г.м үйл ажиллагаа
ДБ/ХХААБ	Мал аж ахуйн товарлаг байдлыг сайжруулах төсөл	2020-2025	Малын халдварт өвчний хяналт хийх шинжилгээний байгууллагыг бэхжүүлэх, мах, сүүний нэмүү өртгийн сүлжээ байгуулах

Эх сурвалж: ЖАЙКА төслийн баг боловсруулав.

3.-Р БҮЛЭГ. Монголын ХАА-н салбарын хөгжлийн стратеги

3.1 ХАА-н нэмүү өртгийн сүлжээг хөгжүүлэх үндсэн үзэл баримтлал

3.1.1 Өнөөг хүртэлх Монголын ХАА-н хөгжил

(1) Бусад орнуудтай харьцуулсан харьцуулалт

Зураг 3.1-т өнгөрсөн 10-н жилийн (2012-2021) хугацаанд Монгол болон бусад орнуудын ХАА-н ДНБ-ийн дундаж өсөлтийг харуулав. Монгол улсад УУБ-ний үнийн уналтаас үүдэлтэй ЭЗ-ийн өсөлтийн зогсонги байдал болон Ковид-19-ийн нөлөө үргэлжилж байгаа хэдий ч ХАА-н ДНБ-ийн дундаж өсөлт нь 4.25% буюу харьцангуй өндөр үзүүлэлттэй байна. Энэ нь дэлхийн дундаж болох 3.54%-иас өндөр үзүүлэлт бөгөөд ялангуяа ХАА-н салбарын өсөлт түргэнтэй Зүүн Ази, Номхон далайн бүсийн дундаж өсөлттэй бараг адил байна. Мэдээж хэрэг Энэтхэг, Хятад зэрэг ХАА-н салбарын өсөлт хурдацтай хөгжиж байгаа орнуудын эдийн засгийн цар хүрээ нь Монголтой харьцуулахад газар тэнгэр шиг зөрөөтэй, ХАА-н ДНБ-ны үнэмлэхүй үзүүлэлтээр Монгол Улс нь тэдгээртэй харьцуулахад тооны орноор дутуу ч ХАА-н үйлдвэрлэлд байгаль цаг уурын орчин нөхцөл таатай биш Монгол улсын хувьд ХАА-н ДНБ нь өдий хэмжээний өсөлттэй байгаа нь яах аргагүй Монголын засгийн газар болон ХАА-н салбарт ажиллагсдын хүчин зүтгэл, оруулж буй хувь нэмрийн үр дүн биз ээ.



Зураг 3.1 Улс орнуудын ХАА-н ДНБ-ний дундаж өсөлт (2012-2021)

Эх сурвалж: ДБ-ны мэдээлэлд үндэслэн ЖАЙКА төслийн баг боловсруулав.

(2) ХАА-н салбарын хөгжлийн суурь

Тэгвэл яагаад Монголын ХАА ийнхүү огцом хөгжсөн юм болоо. Өнгөрсөн 10 жилийн хугацаанд ХАА-н ДНБ-ний өсөлтөд ХАА-н холбогдолтой статистикийн мэдээллийг ашиглан регрессийн шинжилгээ хийж, тухайн статистик мэдээллийн ХАА-н ДНБ-ийн өсөлтөд үзүүлж буй

нөлөөллийг тодруулж үзэв. (Зураг 3.2)

Юуны өмнө хамааран хувьсагч болох ХАА-н ДНБ-ийн хувьд, 2016-2017 онд УУБ-ний үнийн уналтаас шалтгаалж Монголын эдийн засаг нийтдээ зогсонги байдалд орж ХАА-н ДНБ-ний өсөлт ч зогсох магадлалтай үе байсан хэдий ч, нийт салбар ерөнхийдөө өсөх хандлагатай байжээ. Нөгөө талаар, шалтгаант (бие даасан) хувьсагчийг ерөнхийд нь 1) Зах зээл, 2) Үйлдвэрлэлийн хэмжээ, 3) Бүтээмж, 4) Үнэ цэнэ гэж ангилан, ангилал бүрт тохирох статистик мэдээллийг ашиглан шинжилж үзэв. Доор, ангилал бүрийн регрессийн дүнг харууллаа.

1) Зах зээл

Зах зээлийн хүчин зүйлийн тухайд, дотоод зах зээлийн хэмжээг илэрхийлэх индекс болгож Монгол улсын хүн амыг, гадаад зах зээлийн тухайд ХАА-н гаралтай бүтээгдэхүүний нийт экспортын дүнг ашигласан. Шинжилгээний үр дүнд энэ хоёр индекс нь ХАА-н ДНБ-тэй ихээхэн хамааралтай болох нь харагдаж байв. Бодит байдал дээр хүн ам ч тэр, ХАА-н гаралтай барааны экспортын дүн ч тэр жил ирэх тутам өсөх хандлагатай байгаа ба, зах зээлийн эрэлт нэмэгдэж байгаа нь ХАА-н ДНБ-ний өсөлтөд түлхэц болж байна гэж үзэж байна.

2) Үйлдвэрлэлийн хэмжээ

Үйлдвэрлэлийн хэмжээний хамааралтай үзүүлэлтэд, тариалах талбайн хэмжээ, малын тоог ашиглан шинжилгээ хийсэн. Газар тариалангийн салбарын нийт тариалах талбай болон улаан буудай, сонгино, өргөст хэмх тариалах талбай ХАА-н ДНБ-тэй ихээхэн хамааралтай байгаа нь харагдсан. МАА-н хувьд, нийт малын тоо болон үхэр, адуу, хонь, ямааны тоо нь нийт (ерөнхий) индекстэй ихээхэн хамааралтай байв. Малын тооны хувьд өмнө дурьдсан ба газар тариалангийн тухайд Монгол улсын засгийн газраас манлайлан хэрэгжүүлсэн 1-3-р дугаар дахин сэргэлтийн төлөвлөгөө зэрэг ХАА-н бодлогын нөлөөгөөр үйлдвэрлэлийн хэмжээ тэлэх хандлагатай байгаа ба энэ нь ХАА-н ДНБ-ий өсөлтөд түлхэц болох хүчин зүйл болж буй гэж таамаглаж байна.

3) Бүтээмж

Бүтээмжийн үзүүлэлтээр ГТ-ийн хувьд хураасан ургацын хэмжээг, МАА-салбарын хувьд мах, ноос, ноолуур, арьс ширний үйлдвэрлэлийн хэмжээг малын тоонд хуваж нэг малаас авах ашиг шимийн бүтээмжийг тооцоолов[98]. Тооцооллын дүнд ГТ, МАА-н аль аль үзүүлэлтийн хувьд ХАА-н ДНБ-тэй гүн хамааралтайг илтгэх индекс бараг байсангүй. Ганцхан нэг хонинд ноогдох ноосны ашиг шим л гүн хамааралтай нь харагдсан бөгөөд энэ нь ХАА-н ДНБ-тэй сөрөг хамааралтайг харуулсан үр дүн байв. Өөрөөр хэлбэл нэг хонинд ноогдох ноосны ашиг шим нь

[98] Мах, арьс ширний хувьд нэг толгойд ногдох ашиг шимийг нядалсан малын тоогоор тооцох ёстой ч холбогдох статистик мэдээлэл байхгүй тул нийт малын тоонд үндэслэн тооцов.

сүүлийн 10 жилд буурах хандлагатай байна гэсэн үг юм[99]. Дээр дурьдсан 2012-2021 оны 10 жилийн туршид бүтээмж (ашиг шим) нь ХАА-н ДНБ-ийг хөдөлгөх хүчин зүйл болж чадаагүйг илтгэж байна.

4) Үнэ

Үнэ цэнийн тухайд, ХАА-н бүтээгдэхүүн тус бүрийн экспортын нийт үнийн дүнг нийт экспортын хэмжээнд хуваах тооцоолсон дундаж арилжааны үнэд суурилан бүтээгдэхүүнийг өндөр үнэтэй (100USD/кг-с дээш), дундаж үнэтэй (10USD/кг-с дээш,100USD/кг-с доош), хямд үнэтэй (10USD/кг-с доош) гэж ангилан, ангилал тус бүрийн нийт экспортын хэмжээний өрчлөлтийн харилцан хамаарлыг шинжлэв.



Монгол улсын ХАА-н салбарын ДНБ (өнөөгийн үнээр)-ийн өсөлт (сая төг.)

- Microsoft Excel ашиглан регресс шинжилгээ хийв.
- ХАА-н үйлдвэрлэлийн тоо баримтын хувьд МҮСХ-ны мэдээллийг ашигласан https://www.1212.mn/mn)
- Худалдааны холбогдолтой тоо баримтад НҮБ-ын Comtrade-ын мэдээллийг ашигласан. https://comtradeplus.un.org/)

* 5%-ийн ашгийн түвшин ** 1%-ийн ашгийн түвшин
※2012-2021 оны тухайн бүтээгдэхүүний экспортын үнийн дүнг нийт экспортын хэмжээнд хуваах нэгжийн арилжаалсан дундаж үнийг олсон. Энэхүү нэгжийн дундаж үнийг доорхи байдлаар ангилсан.

Өндөр үнэ: Арилжааны дундаж үнэ > 100USD/ нэгж бүт.
Дундаж үнэ: 100USD /нэгж бүт> Арилжааны дундаж үнэ > 10USD/ нэгж бүт.
Бага үнэ : Арилжааны дундаж үнэ < 10 USD/нэгж бүт.

Ангилал	Индикатор	R^2	Ашиг
Зах зээлийн хэмжээ	Хүн ам (хүн)	0.8684	**
Зах зээлийн хэмжээ	МАА,ГТ-н бүтээгдэхүүний экспортын үнийн дүн (ам. доллар)	0.6902	**
Бүтээгдэхүүний хэмжээ	ГТ- нийт тариалсан талбар, га	0.8685	*
Бүтээгдэхүүний хэмжээ	ГТ – Улаанбуудай тариалсан талбай , га	0.5612	*
Бүтээгдэхүүний хэмжээ	ГТ – Арвай тариалсан талбай, (га)	0.2458	
Бүтээгдэхүүний хэмжээ	ГТ – Төмс тариалсан талбай (га)	0.3573	
Бүтээгдэхүүний хэмжээ	ГТ – байцаа тариалсан талбай (га)	0.1032	
Бүтээгдэхүүний хэмжээ	ГТ – Сонгино тариалсан талбай (га)	0.5951	**
Бүтээгдэхүүний хэмжээ	ГТ – Өргөст хэмх тариалсан талбай (га)	0.5450	*
Бүтээгдэхүүний хэмжээ	МАА – Нийт малын тоо (1,000 толгой)	0.6201	**
Бүтээгдэхүүний хэмжээ	МАА- Нийт үхэр сүрэг (1,000 толгой)	0.7893	**
Бүтээгдэхүүний хэмжээ	МАА-Нийт адуу (1,000 толгой)	0.7325	**
Бүтээгдэхүүний хэмжээ	МАА- Нийт хонь (1,000 толгой)	0.6260	**
Бүтээгдэхүүний хэмжээ	МАА- Нийт ямаа (1,000 толгой)	0.5432	*
Бүтээмж	ГТ – Үр тарианы ургац (тонн/га)	0.0059	
Бүтээмж	ГТ – Төмсний ургац (тонн/га)	0.1568	
Бүтээмж	ГТ – Хүнсний ногооны ургац(тонн/га)	0.0409	
Бүтээмж	ГТ – Тэжээлийн ургамлын ургац (тонн/га)	0.0273	
Бүтээмж	МАА – Махны гарц (тонн/1,000 толгой)	0.3815	
Бүтээмж	МАА - Ноосны гарц (тонн /1,000 толгой)	0.5610	*
Бүтээмж	МАА – Ноолуурын гарц (тонн /1,000 толгой)	0.2622	
Бүтээмж	МАА – Дайвар бүтээгдэхүүн (тонн /1,000 толгой)	0.3718	
Бүтээмж	Өндөр үнэтэй барааны экспортын нийт хэмжээ※	0.1622	
Бүтээмж	Дундаж үнэтэй барааны нийт экспортын үнийн дүн ※	0.5900	*
Бүтээмж	Бага үнэтэй барааны нийт экспортын үнийн дүн ※	0.8429	**

Зураг 3.2 ХАА-н салбарын ДНБ-ийн регрессийн шинжилгээний дүн

Эх сурвалж: ЖАЙКА төслийн баг боловсруулав.

Үүний дүнд өндөр үнэтэй бүтээгдэхүүн экспортын хэмжээтэй гүн хамаарал байхгүй байгаа бол дундаж болон хямд үнэтэй бүтээгдэхүүн экспортын хэмжээтэй гүн хамааралтайг харуулав. Иймд, ХАА-н ДНБ-ний өсөлтийг дэмжиж буй шалтгаанд дундаж болон хямд үнэтэй бүтээгдэхүүний экспортын өсөлт нөлөөлж байх магадлалтайг харуулж байна.

Дээрх үр дүнгээс үзэхэд доорхи асуудлууд харагдаж байна.

- Өнгөрсөн 10 жилд (2012-2021) Монголын ХАА-н ДНБ-ийг урагш хөтөлсөн хүчин зүйл бол зах зээлийн тэлэлт, үйлдвэрлэлийн хэмжээний өсөлт болон дундаж ба бага үнэтэй бүтээгдэхүүний экспортын хэмжээ нэмэгдсэн нь нөлөөлсөн байна. Өөрөөр хэлбэл, өргөжин тэлэх хандлагатай байгаа дотоод зах зээлийн эрэлтийг дагаж ГТ, МАА-н

[99] Ноосны үйлдвэрлэлийн ашиг 2012 онд 1,04 кг/толгой байсан бол 2021 онд 0,94 кг/толгой болж бага зэрэг буурчээ.

үйлдвэрлэлийн хэмжээ өссөн нь нийт ХАА-н салбарыг өргөжүүлсэн байна. Мөн Хятад зэрэг ойр орчмын орнуудын түүхий эд, боловсруулалт багатай хагас боловсруулсан бүтээгдэхүүний эрэлттэй уялдан экспортын хэмжээ нэмэгдсэн.

- Нөгөө талаас, ГТ, МАА-н аль аль нь бүтээмжийн хувьд ХАА-н ДНБ-ийг урагш хөтлөх хэмжээний сайжирсан дээшилсэн зүйл харагдсангүй. Мөн нэмүү өртгийн шингээлт өндөртэй эцсийн бүтээгдэхүүний экспортын хэмжээний тухайд түүний үйлдвэрлэлийн бааз тогтвортой сайжирсан байлаа ч энэ нь ХАА-н ДНБ-ийг түлхэх хүчин зүйл болж чадаагүй байна.

3.1.2 Цаашид ХАА-н салбар хэрхэн хөгжих вэ

Өмнө өгүүлсэнчлэн өнгөрсөн 10 жилийн ХАА-н секторын өсөлт нь зах зээлийг эс тооцвол үндсэндээ үйлдвэрлэлийн хэмжээний өсөлт голлох хүчин зүйл байлаа. Өнгөрсөн хугацаанд бүтээмжийг өсгөх болон нэмүү өртөгж шингээх арга хэмжээ хэрэгжээгүй биш, бас бүтээмжийн өсөлт болон нэмүү өртөг шингээх арга хэмжээ нь үйлдвэрлэлийн хэмжээг өргөтгөхөөс ялгаатай бөгөөд үр дүн гарахад цаг хугацаа шаарддаг зүйл юм. Энэ утгаараа бүтээмжийн өсөлт нэмүү өртөг шингээх тал дээр хойшид өсөх боломжтой гэж хэлж болно. Энэ боломж дээр бас Монголын хүн амын өсөлт, олон улсын зах зээлийн өөрчлөлт, даац хэтэрснээс үүдэлтэй бэлчээрийн талхлагдалт, уур амьсгалын өөрчлөлт зэрэг олон хүчин зүйлийг харгалзан энэхүү Мастер төлөвлөгөөний төлөвлөлтийн (хэрэгжих хугацааны) сүүлчийн жил болох 2034 он хүртэл ХАА-г хэрхэн хөгжүүлэх вэ гэдэг нь хамгийн чухал асуулт гэж хэлж болох бизээ. ГТ, МАА-н салбар тус бүрээр нь хуваж, ХАА-н сектор цаашид хэрхэн хөгжих талаар авч үзье.

(1) Газар тариалангийн салбар

Монгол Улсын ГТ-гийн салбар хэрхэн хөгжих тухайд, юуны өмнө анхаарвал зохих асуудал бол улс үндэсний хувьд хүнсний аюулгүй байдлыг баталгаатай хангах үйлдвэрлэл, хангалтын тогтолцоог бүрдүүлэх явдал юм.

Хүснэгт 3.1-д газар тариалангийн гол нэрийн бүтээгдэхүүний нэг хүнд ноогдох жилийн дундаж хэрэглээг үзүүлсэн ба эдгээр бүтээгдэхүүний хэрэглээ сүүлийн 5 жилд төдий л их өөрчлөгдөөгүй байна. Тиймээс хүн амын нэг хүнд ноогдох жилийн хэрэглээний дундаж утгыг суурь болгон авч 2034 он гэхэд Монгол Улсын хүн амд шаардлагатай болох хүнсний бүтээгдэхүүний төрөл зүйлийн хангамжийн прогнозыг гаргав. Энэхүү прогнозын үр дүнд суурилан, бүтээгдэхүүн тус бүрийг бүрийг хэр хэмжээгээр дотоодоосоо хангах боломжтой вэ гэдэг нь судлалж шийдэх шаардлагатай асуудал юм.

Хүснэгт 3.1 Газар тариалангийн гол нэрийн бүтээгдэхүүний жилийн хэрэглээ

Нэр төрөл	2017	2018	2019	2020	2021		2034	
Хүн ам	3,096,030	3,163,991	3,232,430	3,294,335	3,347,783		3,887,004	
Улаанбуудайн жилийн хэрэглээ (кг/хүн)	83.85	83.25	81.67	81.59	81.88		82.4	Жилд шаардагдах хэмжээ 320,476 t
Төмсний жилийн хэрэглээ (кг/хүн)	35.95	35.68	35.02	34.97	35.10		35.3	Жилд шаардагдах хэмжээ 137,382 t
Хүнсний ногооны жилийн хэрэглээ (кг/хүн)	77.87	77.31	75.86	75.77	76.05		76.6	Жилд шаардагдах хэмжээ 297,631 t
Жимсний жилийн хэрэглээ (кг/хүн)	59.92	59.45	58.35	58.28	58.49		58.9	Жилд шаардагдах хэмжээ 228,929 t
Ургамлын тосны жилийн хэрэглээ (кг/хүн)	6.88	6.83	6.71	6.71	6.72		6.8	Жилд шаардагдах хэмжээ 26,314 t

Эх сурвалж: Монголын ҮСХ-ний мэдээлэлд үндэслэн ЖАЙКА төслийн баг боловсруулав.

Нэр төрлөөр нь авч үзвэл, одоогийн байдлаар улаан буудай, төмсөөр 100% дотоодын хэрэгцээгээ хангаж байгаа ба өнөөгийн үйлдвэрлэлийн хэмжээ, хурааж буй ургацаар тооцвол хүн амын тоо өссөн байх 2034 онд ч мөн 100% дотоодын хэрэгцээгээ хангахаар байна. (Зураг 3.3: Бүтээгдэхүүн тус бүрийн хөгжлийн чиглэлийг харна уу). УИХ-ын 36-р тогтоолын хүрээнд жил бүр 100,000 тонн улаан буудай, 55,000 тонн төмс нөөцлөхөөр төлөвлөж буй бөгөөд, үүнийг нэмлээ гэсэн ч шаардлагатай хэмжээний нийлүүлэлт нь тооны хувьд биелэх боломжтой гэж үзэж болно.

Бэрхшээлтэй асуудал нь тариалах талбай болон хураах ургацын хэлбэлзэл их байгаа явдал бөгөөд ялангуяа га-гаас авах ургацын хэмжээ өнгөрсөн 10 жилд улаан буудай: 0.56-1.68 тонн/ га, төмс:8.04-14.62 гэх мэтээр хэлбэлзлэлийн хэмжээ их байна[100]. Улаан буудай,төмсний тариалалт нь бараг бүхэлдээ борооны усаар тэжээгддэг учраас ургац арвин байх, эсвэл ургац алдах хэлбэлзэл өндөртэй нөхцөлд байдаг бөгөөд энэ нь уур амьсгалын өөрчлөлтөөс үүдэн тулгамдсан асуудал болох магадлалтай. Дээрх байдлаас харахад улаан буудай, төмсний тариалалтын тогтвортой байдлыг бэхжүүлэх шаардлагатай байгаа бөгөөд, 1) усны нөөцийг судалж усалгаатай тариалан хөгжүүлэх, 2) ХАА-г механикжуулах, зохистой цаг хугацаанд нь тариалж, хурааж авах, 3) Бордооны технологиос авахуулаад хөрсний шим тэжээлийг сайжруулах зэрэг арга хэмжээ авах шаардлагатай.

Харин хүнсний ногоо, жимс, ургамлын тосны дотоодын хэрэгцээгээ хангах үзүүлэлт бага 57%, 1%, 18% -тай байгаа тул үүнийг сайжруулах шаардлагатай байна. Газар тариалангийн үйлдвэрлэлд төдийлэн тааламжтай бус цаг ууртайн дээр бүтээмж нь бусад орнуудтай харьцуулахад доогуур, цаашид зөвхөн үйлдвэрлэлийг өргөтгөх төдийгүй, хураах ургацын хэмжээг нэмэгдүүлэхэд чиглэсэн арга хэмжээг эрчимжүүлэх шаардлагатай гэж үзэж байна.

[100] Монголын Статистикийн Ерөнхий Газар

Жишээ нь MONMAP-AVC төслийн хүрээнд хэрэгжүүлсэн хүнсний ногооны туршилтын төслөөр сайн сортын үр ашиглаж, тариалалтын зохистой технологи нэвтрүүлснээр өргөст хэмх, улаан лоолийн ургац уламжлалт тариалалтын аргаас 30 орчим хувиар өссөн. Жимсний хувьд ч мөн адил, уур амьсгалд илүү зохицсон сортын үр сонгож тариалснаар нэгж талбайгаас авах ургац нэмэгдэнэ. Ургамлын тосны түүхий эд болох рапс тариалалтын хувьд мөн тариалалтын зохистой технологи нэвтрүүлж түгээн дэлгэрүүлэх замаар бүтээмжийг нэмэгдүүлэх боломжтой.

Хүн амын өсөлттэй холбоотой хүнсний эрэлтийн өөрчлөлт

- **Монголын хүн ам 2034 онд 3 сая 890 мянгад хүрэх ба үүнтэй уялдан хүнсний эрэлт хэрэгцээг ч өснө .**
- **Ногооны жилийн хэрэглээ 260,215- 297,631 тонноор нэмэгдэх бол одоогийн жилийн үйлдвэрлэл нь 148,858 тонн орчим байна.**

Хотжилтын шалтгаант хүнсний хэрэглээний өөрчлөлт

- **УБ-с гадна,орон нутагт цөм хот үүсч хотжилт ихсэнэ.Хотын хүн ам жилээс жилд нэмэгдэнэ.**
- **Ногооны талаархи УБ-чуудын таашаал нь,① чанар,② эрүүл байдал③Монголынх④ Үнэ гэсэн дараалаар ач холбогдол өгдөг.**

Төрийн бодлого

- **Гол нэрийн хүнсний бүтээгдэхүүнээр дотоодоос 100% хангахыг 5 жилийн төлөвлөгөө, ЗГ-ын мөрийн хөтөлбөрт тусгасан. 1 тэрбум мод тарих аян хэрэгжиж байгаа.**
- **Алсын хараа 2050-д хөдөө орон нутаг болон ядуу өрхийг ч аюулгүй, шимт хоол хүнсээр хангахаар тусгасан.**

Уур амьсгалын өөрчлөлт

- **Цаашид агаарын хэм аажмаар өснө. Энэ нь ГТ-ийн хувьд зарим талаар ашиггай байх таамнал байна.**
- **Эсрэгээрээ, агаарын хэм нэмэгдэхээр ууршилт эрчимжиж, ган болох магадлал ихсэнэ гэсэн таамаглал бий.**

Бүтээгдэхүүн тус бүрийн хөгжлийн чиглэл

	Жилийн хэрэглээний өөрчлөлт (тн)*	Тариалах талбай (га)*	Ургацын хэмжээ (тн/га)	2034 оны жилийн үйлдвэрлэл	Жич
Улаан буудай	290,217→ **320,476**	357,950→ 357,950	1.12→ **1.35**	**432,642**	ӨХК**: 145%
Төмс	120,111→ **137,381**	21,015→ 21,015	10.2→ **12.0**	**252,180**	ӨХК: 184%
Ногоо	260,215→ **297,631**	14,206→ **17,379**	10.5→ **13.7**	**238,092**	ӨХК: 80%
Жимс	200,150→ **228,929**	3,045→ **11,446**	0.85→ **1.00**	**11,446**	ӨХК: 5%
Ургамлын тос*	23,006→ **26,314**	22,000→ 22,000	0.40→ **1.00**	**7,260**	ӨХК: 28%

*2021-оны гүйцэтгэл →2034 оны таамаг **Өөрийгөө хангах коэффициент * Тосны гарцыг 33% гэж тооцов

Нэмүү өртгийн сүлжээ хөгжүүлэх чиглэл

Үе шат	Хөгжлийн чиглэл
Орц	• Үр, үрсэлгээний үйлдвэрлэл, нийлүүлэлтийн тогтолцоо бүрдүүлэх • Үр, бордоо, ХАА-н техникийг импортыг дэмжих тогтолцоог өргөтгөх • Усны нөөцийн судалгаа
Үйлдвэрлэл	• Зах зээлийн баримжаат ХАА, үйлдвэрлэлийн зохистой технологийг дэлгэрүүлэх • Хөрс хамгаалал, усны хэмнэлттэй технологийг нэвтрүүлэх • Орон нутагт ногоо жимс тариалалтыг дэмжин сурталчлах
Тээвэр ложистик, боловсруулалт	• Тариачдын хоршоололд түшиглэсэн аюулгүй, найдвартай ГТ-ийн бүтээгдэхүүний түгээлтийн системийг бүрдүүлэх • Хүнс боловсруулах ААН-тэй гэрээт тариалалтыг хөхүүлэх
Борлуулалт, хэрэглээ	• Шим тэжээлийг сайжруулах, махнаас бусад төрлийн хүнсний хэрэглээ (ногоо,мөөг, загас г.м) –г сурталчилах үйл ажиллагаат хэрэгжүүлэх

Зураг 3.3 ХАА-н салбарын хөгжлийн чиглэл

Эх сурвалж: ЖАЙКА төслийн баг боловсруулав.

Дээрх схемд гол нь хүнсний аюулгүй байдлын талаас ХАА-н салбарын төлөв байдлыг харуулсан бөгөөд, зах зээлийн эрэлт хэрэгцээнд нийцсэн ХАА-н бүтээгдэхүүнээр хангахын тулд нэмүү өртгийн сүлжээг хөгжүүлэх талаасаа ч гэсэн мөн чухал сэдэв юм. Монголд хот суурины хүн ам жилээс жилд нэмэгдэж байгаа ба хүмүүсийн хүнсний бүтээгдэхүүнд хандах хандлага үнэ ханшаар зогсохгүй чанар, эрүүл ахуй, гарал үүсэл зэрэгт их анхаардаг болж байна[101]. Түүнчлэн, орон нутагт болон ядуу өрхөд чиглэсэн аюулгүй, тэжээллэг хүнсээр хангах тогтолцоог мөн бүрдүүлэх шаардлагатай болно. Эдгээр нөхцөл байдлыг харгалзан Зураг 3.3: ХАА-н салбарын хөгжлийн чиглэлд дурьдсан арга хэмжээг хэрэгжүүлэх шаардлагатай болно.

(2) Мал аж ахуйн салбар

МАА-н салбарын хувьд ГТ-ийн салбараас ялгаатай нь Монгол орны арвин баялаг нөөцийг хэрхэн нэмүү өртөг шингээж дотоодын хэрэгцээ болон экспортыг нэмэгдүүлэхэд чиглүүлэх вэ

[101] MONMAP-AVC, 2022, Монголын ХАА-н бүтээгдэхүүний нийлүүлэлтийн сүлжээн дэх Ковид-19-ийн нөлөө

гэдэг нь гол асуудал юм. Экспортын гол зах зээл болох Хятадаас гадна, цаашид зах зээл нь улам томрох зүүн өмнөд ази, ойрхи дорнод руу экспортоо нэмэгдүүлж болох төлөв байна. Олон улсын зах зээлийн чиг хандлага бол, ер нь хэрэгцээт хүнс, бүтээгдэхүүний аюулгүй, найдвартай байдал, чанар, үнэ, ашиг тус дээр нэмээд илүү тогтвортой, байгаль орчинд ээлтэй, мал амьтны сайн сайхныг харгалзсан бүтээгдэхүүний эрэлт нэмэгдэж байгаа бөгөөд эдгээр хүчин зүйлс мөн харгалзсан хүнс, бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг дэмжих нь чухал гэж үзэж байна. Нөгөө талаар Монголд малын тоо жилээс жилд нэмэгдсээр бэлчээрийн даац хэтрэн, бэлчээрийн байгалийн сэргэлт хангагдахгүй нөхцөлд хүрээд байна. Саяхнаас малын тоо толгойд татвар ноогдуулж эхэлсэн, мөн хурганы мах экспортлох оролдлогууд, ашиг шим муутай хөгшин малыг заазлах (гэрийн тэжээвэр амьтны хоол үйлдвэрлэх) зэргээр малын тоо толгойн өсөлтийг хязгаарлах шаардлагатай байна. Энэ нь уур амьсгалын өөрчлөлтийн эсрэг авч буй арга хэмжээтэй нийцэх бөгөөд, ган зуд болох магадлал нэмэгдэж, мал бэлчээх боломжгүй газар нутаг улам ихсэх таамаглал байгааг харгалзан, малын тоог хязгаарлах арга хэмжээ авах нь тэргүүн ээлжинд хэрэгжүүлэх зорилт болоод байна. Зураг 3.4 -т нэмүү өртгийн сүлжээг хөгжүүлэх чиглэлийг харуулав. Хамгийн чухал нь бүтээгдэхүүний үнийг илэрхий унагаж байгаа асуудал болох түүхий эдийн чанарыг сайжруулах явдал бөгөөд үүний тулд түүхий эдийн бэлтгэн нийлүүлэлт, ложистикийн тогтолцоог сайжруулах шаардлагатай байна.



Хүн амын өсөлттэй холбоотой хүнсний эрэлтийн өөрчлөлт

- МУ-ын хот суурины хүн ам жилээс жилд нэмэгдэнэ. Чинээлэг давхаргын аюулгүй, найдвартай, нэмүү өртөг их шингэсэн хүнсний хэрэгцээ нэмэгдэнэ.
- Мах сүүн бүтээгдэхүүн ч мөн энэ хэрэгцээнд нийцэхийн тулд үр тариагаар тэжээж бордсон малын мах ч нэмэгдэнэ.

МАА-н бүтээгдэхүүний экспортын нэр төрлийн өөрчлөлт

- Худалдааны хэлэлцээр байгуулах, экспортын боломжийг нэмэгдүүлэх. Хятад улс чухал худалдан авагч хэвээр байж, ойрхи дорнод, ЗӨА-ийн зах зээл томрох хандлагатай бна
- Тогтвортой байдал, байгал орчны бодлого, амьтны тавлаг байдлыг харгалзсан бүтээгдэхүүний хэрэгцээ пэлхий даяар өсөх хандлагатай байна.

Малын тоо толгойн өөрчлөлт

- Малын тоо өнөөг хүртэл жил бүр өссөн. Гэвч нэг малчинд ноогдох малын тооны өсөлт, малын хөлийн татвартай холбоотой өсөлтийн хувь удаашрах магадлалтай. Гэвч бэлчээрийн даац хэтрэлт буурахгүй, бэлчээрийн тогтвортой байдлыг хангах нь хүндрэлтэй.

Уур амьсгалын өөрчлөлт

- Хуурай, халуун зун, цас ихтэй өвлийн улирал үргэлжлэх хугацаа нэмэгдэнэ. Ган зуд болох магадлал нэмэгдэнэ.
- Бэлчээрт ашиглах боломжгүй нутаг ихсэх (талхагдал, цөлжилт) магадлалтай байгаа нь , МАА-н салбарт нөлөөлөх нь гарцаагүй.

Бүтээгдэхүүн тус бүрийн хөгжлийн чиглэл

	Экспортын хэмжээ (тн) *	Дундаж үнэ (ам. дол/кг) *	Хөгжлийн чиглэл
Хонины мах	3,864	3.0	• Хурганы мах үйлдвэрлэл худалдааг дэмжих, үүний тулд хурга бордох хоршоодыг сурталчлах • Дайвар бүтээгдэхүүнээр ГТА-ны хоол үйлдвэрлэх
Угаасан ноолуур	9,097	29.0	• Боловсруулалт сайтай хагас бэлэн бүтээгдэхүүн үйлдвэрлэх • Самнасан ноолуур, ноосны худалдааг нэмэгдүүлэх,
Угаасан ноос	11,387	1.3	• Ноос угаах, самнах технологийг сайжруулах
Самнасан ноос, ноолуур	782	55.9	• Малчдын хоршоонд түшиглэсэн ноосны ложистикийн тогтолцоо бүрдүүлэх
Түүхий арьс	4,403	0.7	• Малчдын хоршоонд түшиглэсэн түүхий арьс цуглуулах, хяналтын тогтолцоо бүрдүүлэх
Элдэн арьс	8,118	2.5	• Ургамлын хандан идээлгийн технологийг дэлгэрүүлэх

*2017-2021оны мэдээлэл, НҮБ-ын UN Comtrade

Нэмүү өртгийн сүлжээг хөгжүүлэх чиглэл

Үе шат	Хөгжлийн чиглэл
Орц	• Ашиг шим өндөртэй мал бордох ферм байгуулах • Хөрсний үржил шимийг нэмэгдүүлэх буурцагт ургамал тарихыг дэмжих • Малын эмчийг сурган бэлтгэх
Үйлдвэрлэл	• Хурганы мах үйлдвэрлэх зорилгоор хурга маллах дундын хоршооны тогтолцоог бүрдүүлэх • МАА-н бренд бүтээгдэхүүн үйлдвэрлэхийг сурталчлах • Үржлийн менежментийн зохистой арга техникийг дэлгэрүүлэх
Тээвэр ложистик, боловсруулалт	• Малчдын хоршооны чадавхийг бэхжүүлэх замаар МАА-н бүтээгдэхүүний ложистикийн нөхцөлийг сайжруулах • Хүнсний бүтээгдэхүүний боловсруулалтын чанар, эрүүл ахуйн баталгаажуулалт хийлгэх (HACCP Халал зэрэг) , Шинжилгээний чадавхийг сайжруулах • Ээрмэлийн үйлдвэрлэлийн хүний нөөцийг сургах, байгальд ээлтэй бүтээгдэхүүн үйлдвэрлэх технологийг дэлгэрүүлэх
Борлуулалт, хэрэглээ	• Махны ангиллын тогтолцоо нэвтрүүлэх • Хүнсний аюулгүй байдал, эрүүл ахуйн талаархи ухуулга

Зураг 3.4 МАА-н нэмүү өртгийн сүлжээг хөгжүүлэх чиглэл

Эх сурвалж: ЖАЙКА төслийн баг боловсруулав.

3.1.3 Хөгжлийн үндсэн үзэл баримтлал

Монгол улсад ХАА нь ядуурлыг бууруулах, ажлын байр нэмэгдүүлэх төрийн бодлогыг

хэрэгжүүлэхэд туйлын чухал салбар юм. Одоогийн байдлаар хөдөлмөрийн насны хүн амын 1/3 нь ХАА-н салбарт ажиллаж байгаа бөгөөд үүнээс 84% нь МАА-н салбарт ажиллаж амьдарч байна. Монгол улсын ХАА-н салбарын боломж, түүн дотроо МАА-н хувьд мах, сүүн бүтээгдэхүүн, арьс шир, болон амьтны гаралтай материал зэрэгт нэмүү өртөг шингээж аж үйлдвэрийн хэлбэрээр хөгжүүлэх боломж маш их гэж харж байгаа боловч одоогийн байдлаар ХАА-н салбарын ДНБ-нд оруулах хувь нэмэр 12% орчим л байна.

Ийм нөхцөл байдалд 2020 оны 5 сарын 13-нд УИХ-аас баталсан Алсын хараа-2050 бодлогын бичиг баримтад “2050 хүртэл Монгол улс унаган байгаль, хэл, хил, соёлоо тогтвортой хадгалж, нийгэм эдийн засгийн хөгжлийн хувьд хөгжингүй орон болох”-ыг алсын хараа болгож, 9 том зорилго тавьсан. Энэ төслөөр боловсруулах Мастер төлөвлөгөө нь Алсын хараа-2050-д тавьсан том зорилгуудыг хэрэгжүүлэхэд, 2025-2034 оны 10 жилд хэрэгжүүлэх хөгжлийн үндсэн чиглэл, үйл ажиллагааны төлөвлөгөөг тусгасан баримт бичиг болох юм. Мөн тус Мастер төлөвлөгөө нь дунд хугацааны бодлого болох Хүнс, ХАА-н салбарын төрийн бодлогын дараагийн үе шатны хугацааг (2025-2034 он) хамарч байгаа болно.

1992 онд зах зээлийн эдийн засагт шилжих өөрчлөлтийг тусгасан үндсэн хуулийн өөрчлөлтөөс хойш Монгол Улсын ХАА-н салбар ихээхэн өөрчлөгдсөн. Социализмын үед байгуулагдсан нэгдэл, САА, улсын үйлдвэрийн газар задарч эдгээрт өмчлөгдөж байсан хөрөнгө, мал гишүүдэд тараагдан хувийн өмч болсон. Зах зээлийн эдийн засагт огцом шилжсэнтэй холбоотойгоор газар тариалангийн салбар уналтад орсон бол нөгөө талд МАА-н салбарт малын тоо өссөөр байгаа бөгөөд, сүүлийн жилүүдэд Монголын засгийн газраас хэрэгжүүлсэн бодлогын үр дүнд газар тариалангийн талбайн хэмжээ нэмэгдэж, хүнс тэжээлийн үндсэн үр тариа болох улаан буудай, төмсөөр дотоодынхоо хэрэгцээг бүрэн хангах хүртлээ сэргэв. МАА-н салбарт дэлхий дахинаа тансаг материалд тооцогддог ноолуур нь экспортын гол нэрийн бүтээгдэхүүний нэг болж худалдааны орлогод жинтэй хувь эзлэх хүртлээ өссөн байна.

Гэсэн хэдий ч урт хугацааны хөгжлийн зорилтыг хэрэгжүүлэхэд шийдвэрлэх олон асуудал урьдын адил байсаар байна. ХАА-н салбарт гол нэрийн ургамлаас гадна хүнсний ногоо, жимсний төрөл зүйл импортын хамааралтай хэвээрээ, ялангуяа үйлдвэрлэлийн бус улиралд хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний нийлүүлэлт, тээвэрлэлтийн системийг сайжруулах шаардлага хурцаар тавигдаж байна. МАА-н салбарт малын тоо толгойн огцом өсөлт нь бэлчээрээ сүйрүүлэх хүртлээ гүнзгийрч буйгаас гадна шүлхий зэрэг өвчний эсрэг авах арга хэмжээг багтаасан хорио цээрийн тогтолцоо хангалтгүй байгаа нь махны экспортод маш том тээг саад болж байна. Бас ноос ноолуур, арьс ширэн бүтээгдэхүүний хувьд хэдийгээр түүхий эдийн нөөц элбэг байгаа ч дотооддоо боловсруулалт муу байгааг дүгнэвэл, Монголд бүтээгдэхүүнд нэмүү өртөг шингээх ажил хангалтгүй байна. Хүснэгт 3.2-т Монголын ХАА-н тулгамдсан асуудлыг сийрүүлсэн ба ерөнхийдөө бүх төрлийн бүтээгдэхүүний зорилтот зах зээл дэх өрсөлдөх чадвар сул, өрсөлдөх

чадварын үндэс суурь болсон үйлдвэрлэл, нийлүүлэлт тээвэрлэлтийн тогтолцоо эмзэг байдал нь гол шалтгаан хэвээр байсаар байна.

Монголын ХАА-н бүтээгдэхүүний өрсөлдөх чадварыг бэхжүүлэхийн тулд эрэлт нь бүрэн хангагдаагүй зах зээлийг олж тогтоох, төр хувийн хэвшил хоёулаа тэрхүү зах зээлийн эрэлт хэрэгцээг нухацтай авч үзэж, тэдний шаардлагад нийцүүлэхийн төлөө хүчин чармайлт гаргах шаардлагатай байна. 2025-2034 оны 10 жилд хэрэгжүүлбэл зохих үйл ажиллагаа нь Хүснэгт 3.3-т харуулсан Монголын ХАА-н үйлдвэрлэлийн давуу талыг ашиглан зах зээлийн эрэлтэд үндэслэсэн бүтээгдэхүүн хөгжүүлэлт хийх, түүнийгээ тогтвортой нийлүүлэхийн тулд үйлдвэрлэл, тээвэрлэлт, боловсруулалт, борлуулалтын нэмүү өртгийн сүлжээг бүрдүүлж бэхжүүлэн, зорилтот зах зээлд Монголын ХАА-н бүтээгдэхүүний өрсөлдөх чадвар болон гадаад зах зээлийн итгэлийг нэмэгдүүлэх зорилготойг ухамсарлах явдал юм. Дээрх өнөөгийн нөхцөл байдлын шинжилгээнд үндэслэн ЖАЙКА-ийн судалгааны баг нь **“ХАА-н бүтээгдэхүүний зах зээлд өрсөлдөх чадварыг бэхжүүлэх замаар Монгол улсад хүчирхэг ХАА-г хөгжүүлэх”**-ийг хөгжлийн суурь концепц болгон дэвшүүлж, түүнийг хэрэгжүүлэхэд чиглэсэн ХАА-н хөгжлийн стратегийг санал болгож байна.

Хүснэгт 3.2 Монголын ХАА-н бүтээгдэхүүнд тулгарч буй асуудлууд

Бүтээгдэхүүн	Нийтлэг асуудал	Бүтээгдэхүүн тус бүрт тулгардаг асуудлууд
Үр тариа	• Тариалангийн үйлдвэрлэлийн хугацаа богино • Ургац хураах хугацаа давхацдаг • Хадгалах байгууламж, технологи дутмаг • Өвлийн хүлэмжийн дулааны зардал өндөр • Тариалдаг нэр төрөл сорт цөөн • ХАА-н түгээн дэлгэрүүлэх систем сул дорой • Маркетингийн чадавхи сул (Ихэвчлэн үйлдвэрлэгчийн)	• Хур тундаснаас хамааралтай ургацын хэмжээ тогтворгүй • Механикжуулалтыг эрчимжүүлэх шаардлагатай
Тосны ургамал		• Тосны рапсын үйлдвэрлэлийн батлагдсан технологигүй • Тариаланчдын тосны рапсын үйлдвэрлэлийн талаархи ойлголт мэдлэг дутуу
Төмс		• Сүүлийн жилүүдийн илүү тариалалт, хадгалалтын хорогдол • Боловсруулах үйлдвэрлэгч байхгүй
Хүнсний ногоо		• Үйлдвэрлэл нь эрэлтээ гүйцдэггүй. • Нийлүүлэлт тогтворгүй (Ялангуяа өвлийн улиралд) • Түгээлт нийлүүлэлтийн тогтолцоо ченжээс хамааралтай • Үр суулгац импортоос хамааралтай
Жимс (чацаргана г.м)		• Үйлдвэрлэл нь эрэлтээ гүйцдэггүй • Үйлдвэрлэл тогтворгүй (шувуу идэх, хураалтын зардал өндөр г.м) • Найрлага, үр ашгийн талаарх баримт нотолгоо хангалтгүй • Үр суулгац импортоос хамааралтай
Мах	• Малчин өрхүүдийн малын тоо толгой өссөн • Бэлчээрийн доройтлын улмаас өвс тэжээл дутмаг • Малын өвчлөлөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээ хангалтгүй • МАА-н технологийг түгээн	• Үйлдвэрийн аргаар бэлтгэдэг махны хэмжээ бага • Боловсруулсан бүтээгдэхүүний төрөлжүүлэн хөгжүүлэлт хоцрогдсон • Зохих эрүүл ахуйн хяналтын тоног төхөөрөмж бүхий мал төхөөрөх үйлдвэр цөөн • Ямааны махны хэрэглээ бага
Сүү, сүүн бүтээгдэхүүн		• Боловсруулах үйлдвэрт нийлүүлдэг хэмжээ бага • Хүйтэн хэлхээний байгууламж хангалтгүй • Зуны илүүдэл, өвлийн хомсдол хоорондын тэнцвэргүй байдал • Чанарын хяналт (ялангуяа сүүний эрүүл ахуй)
Ноос		• Дотоодын боловсруулалтын хувь бага • Ширхэг (микрон) нь хатуу,бүдүүн

Бүтээгдэхүүн	Нийтлэг асуудал	Бүтээгдэхүүн тус бүрт тулгардаг асуудлууд
	дэлгэрүүлэх систем хөгжөөгүй ・Цаг улирлын нөлөөлөл ихтэй, түүнтэй холбоотой бүтээгдэхүүний үнийн хэлбэлзэл өндөр ・Үүлдэр угсааг тасралтгүй сайжруулах тогтвортой төлөвлөгөө дутмаг ・Тариаланчдын бүтээгдэхүүнээ нийлүүлэх харилцагч тогтворгүй ・Зах зээлийн сүлжээ хангалтгүй ・Маркетингийн чадавхи сул (Ихэвчлэн үйлдвэрлэгчийн)	・Түүхий эдийн чанар муу ・Боловсруулах тоног төхөөрөмж хуучирсан, үйлдвэр ажиллах хугацаа улирлын чанартай
Ноолуур		・Дотоодын боловсруулалтын хувь бага ・Сүргийн хөгшрөлтөөс болж ширхэг /микрон/ бүдүүрэх ・Боловсруулах тоног төхөөрөмж хуучирсан, ээрэх тоног төхөөрөмж дутмаг, үйлдвэр ажиллах хугацаа улирлын чанартай
Арьс шир		・Арьсны хаягдал их ・Шимэгчийн гэмтлээс болсон арьсны гологдол их ・Арьсны хадгалалтын нөхцөл муу ・Идээлэх үйлдвэрт хром хэрэглэж буй нь байгаль орчныг бохирдуулдаг ・Үйлдвэр ажиллах хугацаа улирлын чанартай
Зөгийн аж ахуй		・Бүтээмж бага, зөгийн сүргийн арчилгаа маллагаа төвөг бэрхшээл ихтэй (өвөлжилтийн эрсдэл) ・Бал хураах хугацаа богино ・Хортон шавжаас сэргийлэх арга хэмжээ оновчгүй (ялангуяа эмийн хэрэглээ) ・Балт ургамалд цацдаг пестицидийн үлдэгдлийн эрсдэл ・Чанарын хяналтын тогтолцоо сул ・Үйлдвэрлэл, нийлүүлэлт болон борлуулах зардал өндөр

Эх сурвалж: ЖАЙКА төслийн баг боловсруулав.

Хүснэгт 3.3 Монголын ХАА-н бүтээгдэхүүний давуу тал

Бүтээгдэхүүн	Нийтлэг	ХАА-н бүтээгдэхүүнүүд
Үр тариа	・Социализмын үед хөгжүүлсэн өргөн уудам тариалангийн газар ・Хортон шавьж цөөн (УХБ-ын хэрэглээ бага) ・Бүх төрлийн боловсруулах үйлдвэр болон мэргэжлийн холбоодын үйл ажиллагаа ・Хүнсний хэрэглээний өөрчлөлттэй уялдан эрэлт нэмэгдэж буй	・Улаан буудай үйлдвэрлэгчдэд ЗГ-аас татаас өгдөг ・Хуучин САА-г өвлөн авсан том аж ахуйнуудтай
Тосны ургамал		・Сэлгэн тариалах систем нэвтрүүлсэн ・Тосны рапс тариалалтыг ЗГ-аас дэмжих чиглэлтэй ・Тосны үйлдвэр байгуулагдсан
Төмс		・Үйлдвэрлэлийн технологи тогтворжиж түгэн дэлгэрсэн ・Дотоодын тээвэр ложистикийн тогтолцоо бүрдсэн
Ногоо		・Дотоодын эрэлт хэрэглээ нэмэгдэх хандлагатай (түүхий болон боловсруулсан бүтээгдэхүүн) ・Импортын бүтээгдэхүүнтэй харьцуулахад шинэлэг ・Үйлдвэрлэгчдэд зориулсан ЗГ-ын урамшууллын тогтолцоотой (хүлэмж, дулааны зардал зэрэг)
Жимс (чацаргана г.м)		・Дотоодын эрэлт хэрэглээ нэмэгдэх төлөвтэй ・Үйлдвэрлэлээс экспорт хүртэл цогц менежмент хийх чадавхи бүхий том компаниудтай ・Уур амьсгалдаа зохицсон жимс, ховор ургамал ・Дотоодын зах зээлийн өндөр эрэлт хэрэгцээ ・Импортын бүтээгдэхүүнтэй харьцуулахад шинэлэг
Мах	・Түүхий эдийн олдоц сайн ・Бага зардалтай үйлдвэрлэлийн тогтолцоо ・Үйлдвэрлэлийн үндсэн технологийн жигд байдал ・“Органик” МАА-н үйлдвэрлэл ・ЗГ-аас хэрэгжүүлдэг дэмжлэг арга хэмжээнүүд	・Зах зээлийн боломж өндөр (адуу, хонины мах) ・Өсвөр мал бордон тэжээх технологи, хурганы махны үйлдвэрлэлийг тэлэх
Сүү, сүүн бүтээгдэхүүн		・Түүхий эдийн ховор чанар (сарлагийн сүү, ингэний хоормог) ・Бүтээгдэхүүний ховор чанар (айраг)
Ноос		・Ховор чанар (сарлагийн хөөвөр, тэмээний ноос) ・Органик бордоо болон барилгын дулаалгад ашиглах боломжтой
Ноолуур		・Ховор чанар ・Микроны ширхэгийн чанар өндөр ・Гадаад дотоодын зах зээлийн өндөр эрэлт
Арьс шир		・Арьс ширний аж үйлдвэрийн парк байгуулагдана
Зөгийн аж ахуй		・Мал эмнэлгийн зааварчилгаа, хүнсний бүтээгдэхүүний

Бүтээгдэхүүн	Нийтлэг	ХАА-н бүтээгдэхүүнүүд
		шинжилгээний систем, MNS стандарт зэрэг чанарын хяналтын тогтолцоо ・Орон нутгуудад зохион байгуулалтад орсон зөгийчдийн хоршоотой ・Дотоодын зах зээлийн эрэлт өндөр ・Монгол орны өвөрмөц балт ургамал болон ховор чанар ・Тариалангийн ургамалд тоос хүртээх зэргээр бусад салбартай хамтрах боломжтой, бэлчээр хамгаалах, сэргээхэд хувь нэмэртэйг сурталчлах боломжтой ・Монгол орны тал нутгийн тухай эерэг төсөөлөл

Эх сурвалж: ЖАЙКА төслийн баг боловсруулав.

3.2 ХАА-н нэмүү өртгийн сүлжээг хөгжүүлэх үндсэн чиглэл

Дээр өгүүлсэн **“ХАА-н бүтээгдэхүүний зах зээлд өрсөлдөх чадварыг бэхжүүлэх замаар Монголын хүчирхэг ХАА-г хөгжүүлэх”** талаар авбал зохих арга хэмжээ олон байгаа бөгөөд Алсын хараа 2050-д тусгагдсан хөгжлийн хуваарьт цаг хугацааны буюу 10 жилийн төлөвлөлтийн хугацаанд тэргүүн ээлжинд авах шаардлага өндөртэй асуудал гэж үзэн доорхи 4 хөгжлийн чиглэлийг зөвлөмж болгож байна.

1. ХАА-н бүтээгдэхүүний тогтвортой нийлүүлэлт болон нэмүү өртөг шингээхийн тулд үйлдвэрлэл, тээвэр ложистикийн баазыг бүрдүүлэх
2. ХАА-н бүтээгдэхүүний экспортыг дэмжих зорилготой чанар, эрүүл ахуйн хяналтын тогтолцоо болон холбогдох төрийн байгууллагын чадавхийг бэхжүүлэх
3. ХАА-н үйлдвэрлэлийг идэвхижүүлэхийн тулд ХАА-н чиглэлийн компани ААН, холбоодыг дэмжих, хүний нөөцийг сургахад дэмжлэг үзүүлэх
4. Орон нутгийн онцлогтой ХАА-н үйлдвэрлэлийг дэмжих, кластер хөгжүүлэх

3.2.1 Хөгжлийн чиглэл 1. ХАА-н бүтээгдэхүүний тогтвортой нийлүүлэлт болон өндөр нэмүү өртөг шингээсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэхийн тулд үйлдвэрлэл, түгээлт нийлүүлэлтийн бааз бүрдүүлэх

Ирэх 10 жилд ХАА-н салбарыг хөгжүүлэхдээ үйлдвэрлэлийн хэмжээ төдийгүй, аажмаар ХАА-н бүтээгдэхүүний тогтвортой хангамж, чанар, эрүүл ахуйг сайжруулах зэргээр аль болохоор их нэмүү өртөг шингээхийг чухалчлах шаардлагатай. Иймд ХАА-н бүтээгдэхүүний нийлүүлэлтийг тогтворжуулж, нэмүү өртөг илүү шингээхийн тулд нийлүүлэлтийн сүлжээг бий болгоход шаардлагатай гэж үзсэн хөгжлийн чиглэлыг Хүснэгт 3.4 Хүснэгт 3.5-д харууллаа. Монгол Улсын газар тариалан, мал аж ахуйн гол бүтээгдэхүүнүүдийг авч үзсэн байгаа бөгөөд бөгөөд нийлүүлэлтийн сүлжээг сайжруулах үзэл баримтлалыг бусад бүтээгдэхүүнд ч тохируулан ашиглаж болно.

Хүснэгт 3.4 Газар тариалангийн салбарын хөгжлийн чиглэл

Үе шат	Нэр төрөл	No.	Хөгжлийн чиглэл
Орц	· Хүнсний ногоо · Жимс (Чацаргана) · Улаан буудай, Рапс, · Мөөгний төрөл	1-1-1	Үр тариа, тосны ургамлын үр үйлдвэрлэх тогтолцоог бэхжүүлэх
		1-1-2	Сайн чанарын үр, сортыг түгээн дэлгэрүүлэхийг дэмжих
		1-1-3	Үр, суулгац үйлдвэрлэгчийг сурган бэлтгэх
		1-1-4	Усны нөөцийг хөгжүүлэн ашиглах, усалгаатай тариалалтыг дэмжих
		1-1-5	Газар тариалангийн механикжуулалтыг дэмжих
		1-1-6	Хүлэмжийн байгууламжийг өргөжүүлэх
Үйлдвэрлэл		1-1-7	Тариалалтын зохистой технологийг түгээн дэлгэрүүлэх
		1-1-8	Жижиг тариаланчдад зах зээлийн баримжаат тариалалтыг дэлгэрүүлэх
		1-1-9	Түргэтгэсэн тариалалтын технологийг түгээн дэлгэрүүлэх
Нийлүүлэлт, боловсруулалт		1-1-10	ХАА-н хоршоонд түшиглэн ХАА-н бүтээгдэхүүний ложистикийн (агуулах) тогтолцоог бүрдүүлэх
		1-1-11	Хүнсний боловсруулах үйлдвэртэй байгуулсан гэрээт тариалалтыг дэмжих
		1-1-12	Жижиг тариаланчдад чиглэсэн хүнс боловсруулах хялбар технологийг дэлгэрүүлэх
Борлуулалт, хэрэглээ		1-1-13	Шимт чанар, хүнсний аюулгүй байдлын чиглэлээр соён гэгээрүүлэх сурталчилгаа хийх
		1-1-14	Кластер хөгжүүлэх

Эх сурвалж: ЖАЙКА төслийн баг боловсруулав.

Хүснэгт 3.5 МАА-н салбарын хөгжлийн чиглэл

Үе шат	Нэр төрөл	No.	Хөгжлийн чиглэл
Орц	· Мах · Сүү, сүүн бүтээгдэхүүн · Ноос · Ноолуур · Арьс шир, · Зөгийн бал · Загас	1-2-1	Малын шилмэл үүлдэр омгийн хангах нийлүүлэх бааз бий болгох
		1-2-2	Малын эмч (хувийн хэвшлийнхийг оруулан), мал зүйчийг сургах
Үйлдвэрлэл		1-2-3	Өсвөр малыг бордон тэжээх технологи нэвтрүүлэхийг дэмжих
		1-2-4	Ноос, ноолуурын бэлтгэн нийлүүлэх тоног төхөөрөмж нэвтрүүлэх, технологийн сургалт зохион байгуулах
		1-2-5	Маллагааны зохистой технологийг түгээн дэлгэрүүлэх
Нийлүүлэлт, боловсруулалт		1-2-6	Мал төхөөрөх үйлдвэр байгуулахыг дэмжих
		1-2-7	Дайвар бүтээгдэхүүнээр ГТА-ны хоол тэжээл хийх үйлдвэрлэлийг хөгжүүлэх
		1-2-8	Малчдын хоршоонд тулгуурласан ноос ноолуур, арьс шир, сүүний бэлтгэн нийлүүлэх тогтолцоо бүрдүүлэх
		1-2-9	Аж үйлдвэрийн хүний нөөцийг сургах (мах боловсруулах, ээрэх, арьс шир боловсруулах)
		1-2-10	Байгаль орчинд ээлтэй ээрэх, арьс шир боловсруулах технологи нэвтрүүлэх
		1-2-11	Мөшгөх тогтолцооны ашиглалтыг дэмжих
Борлуулалт, хэрэглээ		1-2-11	Зах зээлийн эрэлтэд нийцсэн махны ангилал нэвтрүүлэх, бренд хөгжүүлэхийг дэмжих
		1-2-12	Аялал жуулчлалын салбартай хамтрахыг дэмжих
		1-2-13	Кластер хөгжүүлэх

Эх сурвалж: ЖАЙКА төслийн баг боловсруулав.

3.2.2 Хөгжлийн чиглэл 2. ХАА-н бүтээгдэхүүний экспортыг дэмжихийн тулд чанар, эрүүл ахуйн хяналтын тогтолцоо болон холбогдох захиргааны байгууллагын чадавхийг бэхжүүлэх

Ирээдүйд Монгол улсын ХАА-н салбарын өсөлтийн түлхүүр нь ХАА-н бүтээгдэхүүний экспортын борлуулалтаас ихээхэн хамааралтай байх бөгөөд, өнөөгийн байдлаар хүнсний бараа бүтээгдэхүүний чанар, эрүүл ахуйн хяналтын тогтолцооны эмзэг байдал нь ХАА-н бүтээгдэхүүний экспортод гол саад болж байгаа нь бодит бэрхшээл билээ. Түүнчлэн ХАА-н бүтээгдэхүүний экспортыг дэмжихийн тулд, засгийн газрын холбогдох байгууллагын худалдааны хэлэлцээ хийх чадавхийг бэхжүүлэх,экспортын бүрдүүлэлтийг (амьтан ургамлын хорио цээрийн асуудлыг оруулан) хялбаршуулах явдал зайлшгүй шаардлагатай байна. Эдгээрийг харгалзан ХАА-н бүтээгдэхүүний экспортыг нэмэгдүүлэхэд шаардлагатай чанар, эрүүл ахуйн хяналтын тогтолцоо болон, холбогдох захиргааны байгууллагын чадавхийг бэхжүүлэх зорилготой хөгжлийн чиглэлийн талаар Хүснэгт 3.6-д үзүүлэв.

Хүснэгт 3.6 Чанар, эрүүл ахуйн хяналтын салбарын хөгжлийн чиглэл

Салбар	No.	Хөгжлийн чиглэл
2-1. Чанар эрүүл ахуйн хяналтын тогтолцоог бэхжүүлэх	2-1-1	Хүнсний аюулгүй байдлын системийг сайжруулах
	2-1-2	Хүнсний бүтээгдэхүүний шинжилгээний (хорио цээрийн) байгууллагын чадавхийг бэхжүүлэх
	2-1-3	Хувийн хэвшлийн чанар, эрүүл ахуйн хяналтын хүний нөөцийг сургах
	2-1-4	Чанар, эрүүл ахуйн хяналтын олон улсын баталгаажуулалт авахыг дэмжих
2-2. Экспортыг дэмжих	2-2-1	ХАА-н бүтээгдэхүүний экспортын бүрдүүлэлтийг хялбаршуулж, оновчтой болгох
	2-2-2	Худалдааны хэлэлцээр хийх чадавхийг бэхжүүлэх
	2-2-3	Олон улсын үзэсгэлэн худалдаанд оролцоход дэмжлэг үзүүлэх

Эх сурвалж: ЖАЙКА төслийн баг боловсруулав

3.2.3 Хөгжлийн чиглэл 3. ХАА-н үйлдвэрлэлийг эрчимжүүлэхийн тулд ХАА-н чиглэлийн компани ААН, байгууллагуудыг дэмжих, хүний нөөцийг хөгжүүлэх

Зах зээлийн шаардлагад илүү нийцэх боломжтой бүтээгдэхүүн үйлдвэрлэл, савлалт, нийлүүлэлтийн тогтолцоо бүрдүүлэхэд хөрөнгө оруулалт, эргэлтийн зардал шаардагдана. Зээл авахад шаарддаг барьцаа болон хүү өндөр байдгаас ялангуяа ЖДҮ, ХАА-д ажиллагсдын хувьд санхүүгийн бэрхшээлтэй тулгарах нь их, чанаргүй зээлийн эзлэх хувь өндөр байгаа Монгол улсын хувьд цаашид ч төдийлэн хялбар шийдэгдэхгүй асуудал юм. Нэмүү өртгийн сүлжээг санхүүжүүлэх, агуулахын үнэт цаасны систем зэрэг санхүүгийн шинэ арга хэрэгсэл бий болгоход чиглэсэн арга хэмжээ авах шаардлагатай болох бизээ. Мөн мэдээжийн хэрэг, ЖДҮ, ХАА-н

хоршоодын засаглалыг сайжруулах зэргээр зээл авахад хялбар байх менежментийн тогтолцоог бүрдүүлэх явдал ч бас нэг арга хэрэгсэл гэж хэлж болно. Үүнээс гадна, ХАА-н аж үйлдвэрлэлийг идэвхижүүлэхийн тулд хууль эрх зүйн тогтолцоог сайжруулах замаар ХАА-н үйлдвэрлэлийн бизнесийн орчинг сайжруулж байх шаардлагатай. ХАА-н үйлдвэрлэлийг идэвхижүүлэхэд компани ААН, байгууллага холбоодод чиглэсэн дэмжлэг, тогтолцоог сайжруулж, хэрэгжүүлэх шаардлагатай арга хэмжээний хөгжлийн бодлогын чиглэлийг Хүснэгт 3.7-д үзүүлэв.

Хүснэгт 3.7 ХАА-н чиглэлийн компани ААН, байгууллагуудын хөгжлийн чиглэл

Салбар	No.	Хөгжлийн чиглэл
3-1. Санхүүгийн дэмжлэг	3-1-1	Нэмүү өртгийн сүлжээг санхүүжүүлэх систем нэвтрүүлэх туршилт хийх
	3-1-2	Агуулахын үнэт цааны систем нэвтрүүлэх туршилт хийх
3-2. ААНБ, хоршоодын засаглалыг бэхжүүлэх	3-2-1	Хувийн ААН-ийн санхүүгийн удирдлагын чадавхийг бэхжүүлэх
	3-2-2	ХАА-н хоршоодын зохион байгуулалтын бүтэц, санхүүгийн удирдлагын чадавхийг бэхжүүлэх
3-3. ХАА-н үйлдвэр-лэлийг идэвхижүүлэх хууль эрхзүйн тогтолцоог шинэчлэх	3-3-1	ХАА-н салбарын хууль, эрх зүйн тогтолцоог шинэчлэх - ХАА-н хоршоолыг ААН-ийн татвараас чөлөөлөх - ХАА-н материал техникийг (үр, бордоо, УХБ)-ыг импортын татвараас чөлөөлөх - Гэрээт борлуулалтын нөхцөлтэй урамшууллын тогтолцоо нэвтрүүлэх
	3-3-2	МАА-н салбарын хууль, эрх зүйн тогтолцоог шинэчлэх - Малчдын хоршоог татвараас чөлөөлөх - Гэрээт борлуулалтын нөхцөлтэй урамшууллын тогтолцоо нэвтрүүлэх - Олон улсын баталгаажуулалт авахыг урамшуулах тогтолцоо нэвтрүүлэх

Эх сурвалж: ЖАЙКА төслийн баг боловсруулав.

3.2.4 Хөгжлийн чиглэл 4. Орон нутгийн онцлогтой газар тариалан, мал аж ахуйн үйлдвэрлэлийг дэмжих, ХАА-н үйлдвэрлэлийн кластерийг байгуулах

Орон нутгийн ХАА-н үйлдвэрлэлийг идэвхижүүлж, эдийн засгийг хөгжүүлэх нь УБ-ын хүн амын хэт төвлөрлийг сааруулахад чухал үүрэгтэй юм. Мөн бүс нутгийн хэмжээнд нэр хүндтэй бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг ААН-үүд болон эрдэм шинжилгээ, санхүүгийн байгууллагын сүлжээг бэхжүүлэх, өрсөлдөх чадвартай бүтээгдэхүүн хийдэг болгох бааз суурь болдгийнх нь хувьд аж үйлдвэрийн кластер үүсгэхийг санал болгож байна. Монгол Улсад аж үйлдвэрийн кластерийн тухай ойлголт өнөөгийн байдлаар тодорхой хуулийн үндэслэлгүй байгаа тул нэн яаралтай хууль эрхзүйн орчин бүрдүүлэх шаардлагатай байна. Тэгж байж аж үйлдвэрийн кластерийн үйл ажиллагааг эрчимжүүлэхэд чиглэсэн дэмжлэгийн тогтолцоо нэвтрүүлэх хэрэгтэй байх. Түүнээс гадна орон нутгийн аж үйлдвэрлэлийг идэвхижүүлэх талаас Монголд ч их яригддаг болсон “Нэг тосгон - Нэг бүтээгдэхүүн” хөдөлгөөнийг дэмжих ч боломжтой. Орон нутгийн онцлогтой бүс нутгийн ХАА-н үйлдвэрлэлийг хөгжүүлэх, ХАА-н үйлдвэрлэлийн

кластер үүсгэх хөгжлийн бодлогын чиглэлийг Хүснэгт 3.8-д үзүүлэв.

Хүснэгт 3.8 Орон нутгийн ХАА-н үйлдвэрлэлийг хөгжүүлэх талаархи хөгжлийн чиглэл

Салбар	No.	Хөгжлийн чиглэл
4-1. Кластер хөгжүүлэх	4-1-1	Кластер хөгжүүлэхэд чиглэсэн хуулийн орчин бүрдүүлэх
	4-1-2	Экспортын кластерийг дэмжих тогтолцоо нэвтрүүлэх
	4-1-3	Үйлдвэрлэл, ЭШБ-ын хамтын ажиллагааны зохицуулагч ажиллуулах
4-2. Орон нутгийн аж үйлдвэрийн хөгжил	4-2-1	Бүс нутгийн ложистикийн бааз үүсгэх
	4-2-2	Нэг суурин - Нэг бүтээгдэхүүн хөдөлгөөнийг өрнүүлэх

Эх сурвалж: ЖАЙКА төслийн баг боловсруулав.

4.-Р БҮЛЭГ. ХАА-н салбарын нэмүү өртгийн сүлжээг хөгжүүлэх хөтөлбөр

4.1 Хөгжлийн хөтөлбөрүүдийн ерөнхий бүтэц

Гуравдугаар бүлэгт авч үзсэн Монгол улсын ХАА-ын хөгжлийн стратегид тулгуурлан нийт 11 хөтөлбөр боловсруулав. Хөтөлбөр тус бүр хэд хэдэн Үйл Ажиллагааны Төлөвлөгөөнөөс (ҮАТ) бүрдэх бөгөөд тус төлөвлөгөөнүүдийг ЖАЙКА төслийн багийн хийсэн судалгаа, туршилтын төслүүдээс олж авсан туршлага сургамж, Япон болон гуравдагч орны туршлагад үндэслэн боловсруулав. Хөгжлийн стратегид заасан хөгжлийн чиглэл буюу үйлдвэрлэлийн цар хүрээг тэлэхээс гадна, илүү бүтээмж (Productivity), аюулгүй байдал, чанар, чиг үүргийн талаас болон байгаль орчинд ээлтэй байх, илүү үнэ цэнтэй (Value) байх талаас анхаарч боловсруулсан бөгөөд тэр дундаа газар тариалангийн салбарт үйлдвэрлэлийн хэмжээг цаашид ч өргөжүүлэх нь чухал хэвээр байна гэдгийг тэмдэглэх нь зүйтэй. ҮАТ-г боловсруулахдаа 2020 онд шинэчлэн батлагдсан Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуульд заасан “Төлөвлөгөө боловсруулахдаа баримтлах зарчмууд”-ыг бүрэн тусгах чиглэлд анхаарч ажилласан.



Зураг 4.1 Хөгжлийн хөтөлбөрүүдийн бүтэц

Эх сурвалж: Жайка төслийн баг боловсруулав.

4.2 Хөгжлийн хөтөлбөрүүдийн тойм

4.2.1 Хүнсний ногооны нийлүүлэлтийн сүлжээг бэхжүүлэх хөтөлбөр

Монгол улсын хүнсний ногооны үйлдвэрлэл,зах зээлд нийлүүлэх хэмжээ өсөх хандлагатай байгаа нь эрэлт нэмэгдэж, хүнсний ногооны үрийн татаасын тогтолцоо бий болсонтой холбоотой. Хойшид ч энэ систем үргэлжлэх төлөвтэй байгаа ч системээс гарах стратегийг бас судлах нь чухал. Үйлдвэрлэгчдийг зохион байгуулалтад оруулсан ХААЗД-ыг салбарын хэмжээнд хөгжүүлэхэд анхаарч, үйлдвэрлэгчдэд илүү их ашигтай байх механизмыг бүрдүүлэх нь нэн тулгамдсан асуудал болж байна. Түүнчлэн хүнсний ногооны хэрэглээг идэвхжүүлэх замаар дотоодын хүнсний ногооны хэрэглээг өргөжүүлэхийг эрмэлзэх.

	Орц	Үйлдвэрлэл	Боловсруулалт	Түгээлт, экспорт	Борлуулалт хэрэглээ
Оролцогч	Ханган нийлүүлэгч (үр бордоо, байгууламж г.м)	Тариачин, ГТ-ийн хоршоо, ХАА-н компани	Боловсруулах үйлдвэр, ААН-үүд	Чеижүүд, ХАА-н хоршоо, түгээгч, экспортлогч ААН	Жижиглэнгийн дэлгүүр, нийтийн хоол, зочид буудал, боловсролын байгууллага
Гол бэрхшээл	Чанартай үр, бордоо, УХБ-ын дийлэнх нь импортын хараат. Ялангуяа орон нутагт орцын хүртээмж нэн хүндрэлтэй.	Үйлдвэрлэлийн хугацаа богино.Зах зээлийн хүртээмж тогтворгүй. Хөрөнгө санхүүгийн олдоц муу. Зарим газар усалгаа хүндрэлтэй. Өвлийн тариалалтын байгууламжийн өртөг өндөр. ХАА-н технологийг дэлгэрүүлэх тогтолцоо сул	Ногоо боловсруулагчид угаасаа цөөн. Дотоодын түүхий эд дутмаг, зарим нь импортын хараат. Түүхий эд, тоног төхөөрөмж авах санхүүжилт хүрэлцээгүй.	Түгээлтийн дийлэнх нь чеижээс хараат. Агуулах, хадгалалтын технологи дутагдалтай. Тээврийн зардал өндөр. Орон нутаг руу хийх нийлүүлэлт хязгаарлагдмал	Ялангуяа хөдөөгийнхний ногооны хэрэглээ бага. Эх орны үйлдвэрийн ногооны эрэлт бий ч нийлүүлэлт хангалтгүй.
Авах арга хэмжээ	1.1 Чанартай үр, түргэтгэсэн тариалалт нэвтрүүлэх замаар хүнсний ногооны нийлүүлэлтийн хугацааг уртасгах төлөвлөгөө 1.2 Ногоочдод зах зээлийн баримжаат фермерийн менежментийг дэлгэрүүлэх төлөвлөгөө 1.3 ХАА-н хоршоогоор дамжуулан ХАА-н бүтээгдэхүүний түгээлтийн тогтолцоо бүрдүүлэх төлөвлөгөө 1.4 Хүнсний ногоо боловсруулах энгийн арга, хэрэглээний талаархи төрөл бүрийн сургалт, сурталчилгаа хэрэгжүүлэх төлөвлөгөө				

Зураг 4.2 Хүнсний ногооны нийлүүлэтийн сүлжээг бэхжүүлэх хөтөлбөр

Эх сурвалж: Жайка төслийн баг боловсруулав.

Монгол Улсын хүнсний ногооны нэмүү өртгийн сүлжээ нь хүн ам зүй болон нэг хүнд ноогдох хэрэглээ нэмэгдэх хандлагатай байгаа учраас тасралтгүй өсөн нэмэгдэх хэрэгцээ, өөрөөр хэлбэл дотоодын зах зээл тэлэгдэнэ гэж таамаглаж байна. Дотоодын зах зээлд эх орондоо ургуулсан хүнсний ногоогоо таашаах хандлагатай байгааг харгалзан импортыг орлох тариалалтыг тасралтгүй нэмэгдүүлэх нь зүйтэй. Импортыг орлох тариалалтыг дэмжихийн тулд өмнө өгүүлсэнчлэн нийлүүлэлтийн сүлжээний бүх үе шатны хүндрэлтэй асуудлууд, түүнийг шийдэх арга замуудыг судлан, нийлүүлэлтийн сүлжээг нийтэд нь үр ашигтай байхаар бэхжүүлэхэд салбар хоорондыг хамарсан арга хэмжээ авах шаардлагатай.

Засгийн газраас эх орны үйлдвэрийн ногоог хөгжүүлбэл зохих, тарьж ургуулсан ногоо (10 төрлийн)-нд татаас олгох, өвлийн дулааны зардал зэрэгт татаас олгох тогтолцоогоор дэмжсээр ирсэн. Эхний үед /одоохондоо/ энэ тогтолцоо үргэлжилнэ гэсэн хүлээлттэй байгаа ба энэ тогтолцоо зогсоход хамгийн бага хохиролтойгоор гарах стратегийг багтаасан судалгаа хийх нь чухал. Суурь концепц болон хөгжлийн чиглэлд суурилсан хүнсний ногооны нийлүүлэлтийн сүлжээг бэхжүүлэхэд, 1) Чанартай үр, сорт, түргэтгэсэн (эрт) ургацын тариалалт нэвтрүүлэх замаар хүнсний ногооны нийлүүлэлтийн хугацааг уртасгах төлөвлөгөө, 2) Тариаланчдын зах зээлийн менежментийг хөгжүүлэх төлөвлөгөө, 3) Тариаланчдын хоршоог хамруулсан газар тариалангийн бүтээгдэхүүний нийлүүлэлт түгээлтийн систем бий болгох төлөвлөгөө, 4) Хүнсний ногооны боловсруулалт, хэрэглээний талаар сургалт сурталчилгаа хийх төлөвлөгөөг боловсруулав. Эдгээр хөгжлийн төлөвлөгөө нь асуудлыг шийдэхэд хэр үр дүнтэй байгааг, эсвэл давуу тал, боломжийг ашиглаж байгаа эсэх, мөн хөгжлийн чиглэлтэй хэр нийцэж байгаа, тэдгээрийн хамаарлыг доорх хүснэгтэд нэгтгэн сийрүүлллээ.

Хүснэгт 4.1 Хүнсний ногооны нийлүүлэлтийн сүлжээг бэхжүүлэх хөтөлбөр, хөгжлийн чиглэлийн хамаарал

	Бодит бэрхшээл, давуу тал, хөгжлийн чиглэлийн агуулга	Ногооны нийлүүлэлтийн сүлжээг бэхжүүлэх хөтөлбөрийн арга хэмжээ: 4 төлөвлөгөө тус бүрээр			
		1.1	1.2	1.3	1.4
Бэрхшээл	ХАА-н үйлдвэрлэлийн материалын (чанартай үр, бордоо,УХБ г.м) дийлэнх нь импортоос хараат	◎		○	
	Үйлдвэрлэлийн хугацаа богино	○		◎	
	ХАА-н эмзэг технологийг түгээн хөгжүүлэх тогтолцоо		◎	○	
	Боловсруулах үйлдвэрлэлд дотоодын түүхий эд хомсдох үе байдаг	○		○	
	Түгээлтийн дийлэнх нь ченжүүдээс хараат. Агуулах дутагдалтай		○	◎	○
	Тээврийн зардал өндөр. Орон нутагт хүнсний ногооны түгээлт нийлүүлэлт хангалтгүй				◎
Давуу тал, боломж	Бордоо, УХБ-ын хэрэглээ бага тул хөрш улстай нь харьцуулбал аюулгүй үйлдвэрлэл, нийлүүлэлт хийдэг				◎
	УБ-т ОН оролцоотой зах, агуулах зэрэг дэд бүтэц байгуулагдаж эхэлж байгаа		○	◎	
	Ногоо боловсруулах ААН,мэргэжлийн холбоод байгаа	◎		◎	
	Монгол ХАА-н зохистой зохистой дадал г.м хүнсний аюулгүй байдлын тогтллцоо бүрдсэн				◎
	Дотоодын ногооны эрэлт нэмэгдэх хандлагатай байгаа	○	○	○	○
	ЭМЯ-наас хүнсний ногооны хэрэглээг дэмжиж байгаа	○	○	○	◎
	Зуны улирал нь ногооны үйлдвэрлэлд нэн тохиромжтой	◎	○	○	○
Хөгжлийн чиглэл	1-1-1 Үр тариа, тосны ургамлын үр үйлдвэрлэлийн тогтолцоог бэхжүүлэх				
	1-1-2 Чанартай үр сортыг дэлгэрүүлэхийг дэмжих	◎	○	○	
	1-1-3 Үрсэлгээ, суулгацын тариалагчдыг сурган бэлтгэх	◎	○	○	
	1-1-4 Усны нөөцийг хөгжүүлэх/усалгааны технологи хөгжүүлэлт	○			
	1-1-5 ХАА-н механикжуулалт			◎	
	1-1-6 Хүлэмжийн байгууламжийг өргөтгөх	○	○	○	
	1-1-7 Тариалалтын зохистой технологийг түгээн дэлгэрүүлэх	◎	◎	◎	○
	1-1-8 Жижиг тариаланчдын зах зээлийн баримжаатай тариалалтыг дэмжин хөгжүүлэх		◎	○	◎
	1-1-9 Түргэтгэсэн (эрт) ургацын технологийг дэлгэрүүлэхийг дэмжих	◎	○	○	
	1-1-10 Хоршоодоор дамжуулан ХАА-н бүтээгдэхүүний түгээлт нийлүүлэлтийн тогтолцоо /агуулах/ бий болгох		○	◎	
	1-1-11 Хүнсний боловсруулах үйлдвэртэй гэрээт тариалалтыг дэмжих	○		◎	
	1-1-12 Жижиг тариаланчдад хүнсний боловсруулалтын энгийн технологи эзэмшүүлэх				◎
	1-1-13 Шим тэжээл, хүнсний аюулгүй байдлын чиглэлийн сурталчилгаа хийх				◎
	1-1-14 Кластер хөгжүүлэхийг дэмжих				

Эх сурвалж: Жайка төслийн баг

Төлөвлөгөө тус бүрийн ерөнхий агуулгыг доор сийрүүлэв.

Чанартай үр сорт, түргэтгэсэн тариалалтын технологи нэвтрүүлэх замаар хүнсний ногооны нийлүүлэлтийг нэмэгдүүлж, үйлдвэрлэлийн хугацааг уртасгах төлөвлөгөө

Энэхүү үйл ажиллагааны төлөвлөгөөнд (ҮАТ) Монголын нөхцөлд тохирсон дотоод гадаадын чанартай үр сортыг нэвтрүүлэхийн зэрэгцээ сортын онцлогт тохирсон түргэтгэсэн (эрт ургацын) тариалалтыг нэвтрүүлэх замаар хүнсний ногооны үйлдвэрлэл нийлүүлэлтийн хугацааг уртасгахыг зорино. Чанартай үр сорт нэвтрүүлснээр үр өгөөж өндөртэй үйлдвэрлэл бий болж хүнсний ногооны үйлдвэрлэлийн өртгийг бууруулж, үйлдвэрлэгчдийн орлого ашгийг нэмэгдүүлнэ. ХХААХҮЯ голлон чанартай үр сортын мэдээллийн сан байгуулах, хувийн ААН, байгууллагыг татан оролцуулах хэлбэрээр зах зээлийн эрэлт хэрэгцээнд нийцсэн ногооны тариалалт, түгээлт нийлүүлэлтийн тогтолцоог нэвтрүүлнэ. Мөн үр ашиг талаас нь монголд тарьж ирсэн түгээмэл хүнсний ногоог дотоодын үрээр, шинээр тариаллалтад нэвтрүүлж буй хүнсний ногоог гадаадын элит сортын үрээр тарьдаг болох чиглэл баримтлана.

Тариаланчдад зах зээлийн баримжаатай менежментийг түгээн дэлгэрүүлэх төлөвлөгөө

Энэхүү ҮАТ-өөр жижиг тариаланчдын чадварыг бэхжүүлэх сургалтаар дамжуулан үйлдвэрлэлийн материал хэрэгсэл ба зах зээлийн хүртээмжийг сайжруулж, тариаланчдын менежментийн тогтвортой байдал, орлогыг нэмэгдүүлэхийг зорино. ХХААХҮЯ удирдан дэлгэрүүлж хэрэгжүүлэх тогтолцоог бүрдүүлэх ба мастер тренер (зааварлагч) бэлтгэх сургалт болон үйлдвэрлэгчдэд чиглэсэн төрөл бүрийн сургалт хийх каскад арга зохимжтой гэж төсөөлж байна. Мөн ХАА-н зах зээлийн баримжаатай менежментийг түгээн дэлгэрүүлэх удирдамж, заавар боловсруулж, түгээн дэлгэрүүлэх ажилтан болон өрхийн үйлдвэрлэгчдийг татан оролцуулах тогтолцоог бүрдүүлнэ. Мөн нэвтрүүлэх арга барилын хувьд ЖАЙКА (JICA) нь дэлхийн янз бүрийн улсад SHEP（Smallholder Horticulture Empowerment & Promotion）- өрхийн ногоочдыг чадваржуулж, орлогыг нэмэгдүүлэх сургалтын төсөл) нэртэй зах зээлийн баримжаат ХАА-г хөгжүүлэх аргыг дэлгэрүүлж байгаа ба энэ аргыг хэрэгжүүлнэ гэж тооцож байна.

ХАА-н хоршоодоор дамжуулан ХАА-н бүтээгдэхүүний түгээлт/нийлүүлэлтийн тогтолцоо байгуулах төлөвлөгөө

Энэхүү ҮАТ-нд ХАА-н хоршооны зохион байгуулалтыг бэхжүүлж, бизнест суурилсан ХАА-н бүтээгдэхүүний бэлтгэн нийлүүлэлт болон, анхан шатны боловсруулалтын тогтолцоо байгуулахыг зорьж байна. Хоршооны зохион байгуулалтыг бэхжүүлснээр өртгийн сүлжээний зардлыг багасгах, ашгийг дээшлүүлэх, тогтсон хэмжээ, нэр төрлөөр арилжаа хийх боломжтой болж борлуулалтын сувгийг төрөлжүүлэн, түгээлтийг сайжруулахыг эрмэлзэнэ. ХХААХҮЯ голлон хоршоолох санаачлагыг дэмжиж тоног төхөөрөмж нийлүүлэх, үйлдвэрлэлийн материал хэрэгсээр хангаж, технологийн сургалт үйлчилгээ үзүүлнэ.

Хүнсний ногоо боловсруулах энгийн арга, хэрэглээний сургалт, сурталчилгаа хийх төлөвлөгөө

Дэлхийн дундажтай харьцуулахад ногооны хэрэглээ багатай Монгол Улсад эрүүл мэндээ хамгаалахад ногооны хэрэглээг өргөжүүлэх нь зүйтэй. Энэхүү ҮАТ-нд иргэдэд эх орны үйлдвэрийн хүнсний ногооны хэрэглээний чиглэлээр соён гэгээрүүлэх болон, орон нутагт ногоо

тарих, боловсруулах хялбар технологи нэвтрүүлэх замаар дотоодын үйлдвэрийн ногооны хэрэглээ дэмжих, шим тэжээлийг сайжруулахыг эрмэлзэнэ. Ялангуяа хүнсний ногооны хангамж, хэрэглээ хязгаарлагдмал аймгуудад хүнсний ногооны үйлдвэрлэл, эрэлт хэрэгцээний орон зай өндөр байна гэж үзэж байна.

Монгол Улсын Засгийн газар болон хандивлагчдын дэмжлэг тусламжийн төслүүдийн сайн жишээнүүд ч бий болсон байгаа тул тэдгээрийн туршлага сургамжийг энэхүү YAT боловсруулахад өргөнөөр тусган ашигласан болно. Швейцарийн Хөгжлийн Агентлаг (ШХА)-ын тусламжаар хэрэгжиж буй MONVEGI (Inclusive and Sustainable Vegetable Production and Marketing - Хүртээмжтэй, тогтвортой хүнсний ногооны үйлдвэрлэл, маркетинг) төслөөр чанартай үр, сорт нэвтрүүлж, үйлдвэрлэгч тариаланчдын зохион байгуулалтыг бэхжүүлсэн нь сайн жишээ гэгдэж холбогдох талуудад үнэлэгдэж байна. Цаашилбал, энэ төслийн туршилтын үйл ажиллагааны хүрээнд Японы ААН-ийн гаргаж авсан үр, сортыг авчирч эрт ургацын (түргэтгэсэн) тариалалтад ашигласан нь ААН, үйлдвэрлэгчдийн гэрээт борлуулалтад ч бас тодорхой үр дүнгээ өгсөн. Эдгээр сургамж, үр дүнг YAT-нд тусган сайн жишээнүүдийг нийтийн хүртээл болгоход анхаарснаар асуудлыг үр ашигтайгаар шийдвэрлэх, мөн хүнсний ногооны хэрэглээг дэмжиж дотоодод тариалсан хүнсний ногооны хэрэглээг нэмэгдүүлэхэд хувь нэмэр оруулахыг зорих юм.

(1) Чанартай үр болон түргэтгэсэн тариалалтыг нэвтрүүлэх замаар хүнсний ногооны нийлүүлэлт хийдэг байгууллагуудыг олшруулан дэмжих төлөвлөгөө

YAT 1.1: Чанартай үр, түргэтгэсэн тариалалтыг нэвтрүүлэх замаар хүнсний ногооны нийлүүлэлтийн хугацааг уртасгах төлөвлөгөө	
Төлөвлөгөөний зорилт	Дотоод гадаадын чанартай үр, сорт нэвтрүүлэхийн зэрэгцээ, түргэтгэсэн тариалалтыг нэвтрүүлэх, дотоодын ногооны үйлдвэрлэл, нийлүүлэлтийн хугацааг уртасгах.
Суурь түвшин	Хүнсний ногооны үйлдвэрлэлийн хэмжээ жилд 148,859 тн (2022 он)
Төлөвлөгөөний зорилго	Чанартай үр, сорт нэвтрүүлэхийн зэрэгцээ, түргэтгэсэн тариалалт нэвтрүүлэх замаар ногооны үйлдвэрлэлийн хэмжээг жилд 9,000 тн-оор (6% орчим) нэмэгдүүлэх.
Хамрах хүрээ	Орон даяар, тэр дундаа УБ-ын орчим болон хүнсний ногоо тариалдаг бүсийг тэргүүн ээлжинд хамруулах.
Хүлээх үр дүн	(1) Чанартай үр, сортууд мэдээллийн санд бүртгэгдэнэ. (2) Дотоодын үйлдвэрлэл, нийлүүлэлт нэмэгдсээр эрэлт хангагдах боломж бүрдэнэ. (3) Чанартай үр, сорт нийлүүлэх, түргэтгэсэн тариалалт нэвтрүүлэх замаар үйлдвэрлэлийн үр ашиг илүү сайжрах боломжтой болж, ногооны үйлдвэрлэлийн өртөг буурч, орлого ашиг нэмэгдэнэ. (4) Гэрээт тариалалтын аргыг нэвтрүүлснээр үйлдвэрлэгч, худалдан авагч (боловсруулах, жижиглэн худалдаа зэрэг) хоёр хамтран зах зээлийн хэрэгцээнд илүү нийцсэн үйлдвэрлэл, нийлүүлэлт хийгдэнэ.
Үйл ажиллагаа	(1) Ногооны чанар сайтай үр сортын мэдээллийн сан бүрдүүлж,төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд шаардлагатай журам боловсруулна. ХХААХҮЯ-ны ГТБХЗГ, Судалгаа хөгжлийн төв голлон, Монгол Улсад нэвтрүүлбэл зохих чанартай үр сортын мэдээлэл цуглуулж, электрон мэдээллийн сан үүсгэх.Мөн ЖАЙКА, ШХА, АХБ зэргийн хэрэгжүүлсэн ижил төстэй төслөөс санаа авч, энэхүү төлөвлөгөөг хэрэгжүүлэхтэй холбоотой журам боловсруулах. Мөн мэдээллийн сан ба хэрэгжүүлэх журамд дотоодын сорт төдийгүй монголын цаг уурт тохиромжтой байж болох гадаадын ирээдүйтэй сортын жагсаалтыг тусгаж, тэдгээрийг бүртгүүлэхэд дэмжлэг үзүүлэх арга хэмжээг авч үзнэ.

	(2) Төсөлд хамрагдах хувийн байгууллага (боловсруулах, жижиглэнгийн ААН, ТББ гм.)-ын дунд зар тарааж сонгон шалгаруулах ХХААХҮЯ хэрэгжүүлэх журмын тухайд, төсөлд хамрагдах хувийн ААН, мэргэжлийн холбоод, холбогдох хүмүүс, ногоочдод танилцуулж зар тараана. Оролцох ААН, байгууллагуудаас жил бүр 5 компани байгууллагыг шалгаруулна. (Давхардсан тоогоор 45 компани, байгууллага) (3) Чанартай үрийн хэрэглээг дэмжих болон түргэтгэсэн тариалалтыг дэмжих чиглэлээр сурталчилгаа хийх Сонгогдсон ААН, байгууллагатай хамтран чанартай үр сортын хэрэглээг дэмжихэд чиглэсэн сурталчилгаа хийнэ. Байгууллага, ААН нь худалдан авахыг хүссэн ногоочидтой хэлэлцэн, гэрээт тариалалтаар туршилтын арилжаа /худалдан борлуулалт/ хийнэ. (4) Тариалалтын технологийн сургалт (суулгац, хүлэмжийн тариалалт зэрэг) болон гэрээт тариалалтыг түгээн дэлгэрүүлэхийг дэмжих ААН, байгууллагатай хамтран, тариалалтын технологийн (үрсэлгээ суулгац болон түргэтгэсэн тариалалт, хүлэмжийн тариалалт, талбайн усалгаа, усны менежмент зэрэг) сургалт зохион байгуулна. Мөн гэрээт тариалалт хийх хүсэлтэй ногоочдод гэрээт тариалалтын талаар сурталчилгаа, түгээн дэлгэрүүлэх үйл ажиллагаа явуулна. (5) ХХААХҮЯ, Судалгаа хөгжлийн төв нь хяналт шинжилгээ, үнэлгээ хийх ХХААХҮЯ, Судалгаа хөгжлийн төв голлон уг төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт тавьж үнэлгээ хийн, үр дүнг нэгтгэхийн хамт холбогдох хүмүүст мэдээлэл хүргэнэ. Үр сортын тухайд, ургацын хэмжээ гэх мэт тариалалтын үр дүнг мэдээллийн санд оруулна.	
Санхүүжилт	<u>Засгийн газар</u> • ХАА-н материал (үр зэрэг) болон ногоонд олгох татаас • Цахим мэдээллийн сан бүрдүүлэхтэй холбоотой зардал • Аймаг, сумдын ХААГ-н мэргэжилтэн (томилолтын болон замын зардал) • Төрийн төрийн төв байгууллагын мэргэжилтний мониторинг хийх зардал	<u>Хувийн ААН</u> • ХАА-н материал, техник хэрэгсэл • Сурталчилгаа сургалт зохион байгуулах зардал (багшийн цалин г.м) • Төслийн /бизнесийн/ түншлэлийн гэрээ байгуулахтай холбоотой үйл ажиллагааны зардал
Төслийн өртөг	Төслийн нийт өртөг: 16 тэрбум 103 сая төгрөг (6,129,000 ам. доллар)	
Ашиг, үр нөлөө	Давхардсан тоогоор 45 компани үйлдвэрлэлээ жилд 200 тн-оор (200тн/жил/компани) нэмэгдүүлж, нийтдээ 9,000 тн/жил ногоо нэмүү үйлдвэрлэнэ. 15 сая төгрөг/тн *9,000тн =135 тэрбум/жил-ийн эдийн засгийн ашигтай байна	
Бодлогын бичиг баримттай уялдсан байдал	1. Алсын хараа-2050 3.1.1 ХАА-н бүтээгдэхүүний түүхий эд болон бүтээгдэхүүний чанарыг сайжруулна. 2. УИХ-ын 36-р тогтоолын 3.2.3-т үр тарианы сорт, таримал тус бүрийн үрсэлгээ, суулгац үйлдвэрлэгчдийг бүртгэлжүүлж, цахим мэдээллийн сан бүрдүүлэх.	
Төслийг хэрэгжүүлэхэд анхаарах зүйлс	• Үр сортын мэдээллийн сан байгуулахтай холбогдуулан хэлэхэд ШХА-ийн хэрэгжүүлсэн (MONVEGI) төсөл болон ЖАЙКА-ын хэрэгжүүлсэн төслүүдийн (MONMAP-AVC, “Өвсний үндэс” хөтөлбөр (Хоккайдоогийн Такикава хот)) үр дүн, мэдээллийг судлах • Гэрээт тариалалтын тухайд, зах зээлийн хэрэгцээнд нийцсэн ХАА-н бүтээгдэхүүн байх, худалдагч (үйлдвэрлэгч) ба худалдан авагч (боловсруулах, жижиглэнгийн худалдаачид г.м) аль алинд нь ашигтай байхаар зохицуулалт хийх	

Төслийг хэрэгжүүлэх хуваарь ба төсөв

Үйл ажиллагаа	2025	2026	2027	2028	2029	2030	2031	2032	2033	2034	Нийт
(1) Үр сортын мэдээллийн сан бүрдүүлэх, хэрэгжүүлэх журам боловсруулах											
(2) Төсөлд хамрагдах хувийн ААН, байгууллагад зарлах,											

сонгох												
(3) Чанартай үр болон гэрээт тариалалтыг дэмжих ухуулга сурталчилгаа зохион байгуулах												
(4) Тариалалтын технологийн сургалт хийх, гэрээт тариалалтыг дэлгэрүүлэхийг дэмжих												
(5)Хяналт, үнэлгээ хийх												
Төслийн өртөг	сая төгрөг	353	750	1,000	1,250	1,500	1,750	2,000	2,250	2,500	2,750	16,103
	мян. ам.дол	139	285	380	475	570	666	761	856	951	1,046	6,129

Тэмдэглэл: MONMAP-AVC: Хүнсний ногооны үйлдвэрлэл нийлүүлэлтийн хугацааг уртасгах туршилтын төсөл

Монгол орны эх газрын сэрүүн уур амьсгалаас шалтгаалан ГТ-гийн үйлдвэрлэлийн хугацаа богино, байгаль орчны талаас эрсдэл өндөртэй. байгаль цаг уурын ийм нөхцөл байдлаас шалтгаалан хүнсний ногооны нэгжийн ургацын хэмжээ дэлхийн дундажтай харьцуулахад тийм ч өндөр биш. Энэхүү туршилтын төсөл нь хүнсний ногооны ургацыг нэмэгдүүлэх, дулаан хүлэмжид тарьж ургуулсан ногооны үрсэлгээ нийлүүлэх, ургац хураах, зах зээлд нийлүүлэх хугацааг наашлуулах /эрт ургац авах/ зорилго тавьсан болно. Үүнд ①Японы үрийн компанид үйлдвэрлэсэн улаан лооль, өргөст хэмхийн үр сортыг нэвтрүүлэх ②Түргэтгэсэн тариалалтын технологи боловсруулах ААН, үйлдвэрлэгчийн түүхий эдийг нийлүүлэх зорилгоор гэрээт борлуулалтын аргыг хэрэгжүүлсэн. ①-т дурьдсан шинээр нэвтрүүлсэн сортын онцлог нь ургалт түргэнтэй (болц түргэн, тариалалтын хугацаа богино), өндөр ургац өгдөг, сэрүүн орчинд ч тогтвортой ургац өгдөг, гибрид үр (F1) бөгөөд өвчинд тэсвэртэй зэрэг давуу талтай. ②-т нэвтрүүлсэн түргэтгэсэн тариалалтын технологи гэдэгт хүлэмжид үрсэлгээ бэлдэх болон тариалалтын багаж хэрэгсэл, дуслын усалгаа нэвтрүүлэх зэрэг орно.

Үр дүнд нь, ①-ийн өргөст хэмхийн туршилтын тариалалтаар доорхи зурагт харуулсанчлан ургацын хэмжээгээр орос сорт болон монголын дундаж ургацаас 20 гаруй хувиар илүү, тариалалтын хугацаанд 2 удаа ургац хураав, ②-т ургац авах хугацаа нь уламжлалт аргатай харьцуулахад 2 долоо хоногоор урагшилж, нийт ургацын хэмжээ ч мэдэгдэхүйц нэмэгдсэн байлаа. Энэхүү туршилтын төсөл хэрэгжих хугацаанд холбогдох бодлогын хүрээнд Үр, сортын тухай хуулийн нэмэлт өөрчлөлт (2022 он) хийгдсэн ба гадаадаас үр импортлох боломж бүрдсэн. Нөгөөтэйгүүр, гадаадаас үр авахад гаалийн татвар авдаг нь үйлдвэрлэгч, ААН-үүдэд хүндрэл учруулж байдаг. Бүх төрлийн ногоо тарималын үрийг дотоодоос хангана гэдэг нь бодит байдалд боломжгүй тул жишээлбэл, гол нэр төрлийн дотоодын үрээр тариалж хангадаг төмс зэрэг хүнсний ногооны үр импортлох бол гаалийн татвар ноогдуулах, бусад ногооны үрийг гаалийн татвараас чөлөөлж гадаадаас импортлох үрийг дэмжснээр дотоодын ногооны үйлдвэрлэлийг нэмэгдүүлэхэд арга хэмжээ үр дүнтэй байх гэж үзэж байна.



(2) Тариаланчдад зах зээлийн баримжаатай аж ахуйн менежментийг түгээн дэлгэрүүлэх төлөвлөгөө

YAT 1.2: Тариаланчдад зах зээлийн баримжаатай аж ахуйн менежментийг дэлгэрүүлэх төлөвлөгөө	
Төлөвлөгөөний зорилт	Жижиг ААН-үүдийн чадавхийг бэхжүүлэх сургалт хийх замаар орц материал болон зах зээлийн оролцоог сайжруулах, фермерийн менежментийг тогтворжуулах, орлого ашгийг нэмэгдүүлэх зорилготой.
Суурь түвшин	Ногоочны жилийн орлогыг 3,6 сая төгрөг гэж тооцоолов.
Төлөвлөгөөний зорилго	Чадавхижсан өрхийн тариаланчийн орлого нь 1,2 сая төгрөгөөр (30% орчим) нэмэгдэнэ.
Хамрах хүрээ	Орон даяар, тэр дундаа Улаанбаатар орчмын бүс нутаг, бүс орон нутгийн төв хотуудыг тэргүүнд ээлжинд хамруулах бөгөөд хүнсний ногооны тариалангийн голлох бүс нутгуудыг нэн тэргүүний бүс нутагт эрэмбэлэхгүй байх
Хүлээх үр дүн	(1) Төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд шаардлагатай хэрэгжүүлэх журам, Монголын зах зээлд чиглэсэн фермерийн менежментийг дэлгэрүүлэх удирдамж, заавар боловсруулах. (2) Зах зээлд чиглэсэн фермерийн менежментэд холбогдох түгээн дэлгэрүүлэх үйлчилгээ үзүүлэх хүний нөөцийн (аймаг, сумдын ХААГ-н мэргэжилтэнүүд) чадавхийг бэхжүүлэх, түгээн дэлгэрүүлэх арга хэмжээг хэрэгжүүлэх тогтолцоо бүрдүүлэх. (3) Хамрагдах ногоочид, загвар тариачны орлого, ашиг нэмэгдэх.
Үйл ажиллагаа	(1) ХХААХҮЯ голлон, төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд шаардлагатай хэрэгжүүлэх журам боловсруулах, аймаг сумдын ХАА-н бодлогын газрын мэргэжилтнүүдэд хэрэгжүүлэх журмыг тайлбарлаж танилцуулах ХХААХҮЯ-ны ГТБХЗГ, Судалгаа хөгжлийн төв голлон хүнсний ногооны эрэлт нийлүүлэлтийн байдлыг тодорхойлох зорилгоор судалгаа шинжилгээ хийх. Тэгснээр JICA-аас дэлхийн бусад улсуудад хэрэгжүүлдэг зах зээлийн баримжаат фермерийн хандлага (өрхийн ногоочдыг чадваржуулж, орлогыг нэмэгдүүлэх сургалтын төсөл SHEP: Smallholder Horticulture Empowerment and Promotion)-аас суралцан энэ төлөвлөгөөг хэрэгжүүлэх журмыг боловсруулах. (2) Төсөлд оролцох аймаг сумдыг сонгох Танилцуулах уулзалтад оролцсон аймаг сумдаас тухайн төслийг хэрэгжүүлэх хүсэлтэй аймгуудын өргөдлийг авахын тулд сонгох шалгуур үзүүлэлтийг тогтооно. Шалгуур үзүүлэлтийг тусган аймаг сумдад зарлана. Нийт 3 орчим аймаг, 10-аад сум сонгох бөгөөд аймаг, сум давхардсан байж болно. (3) Зах зээлийн баримжаат фермерийн менежменттэй холбоотой технологи сургалтад хамрагдах аймаг сумдын мэргэжилтнүүдийг оролцуулан зохион байгуулах ХХААХҮЯ болон судалгаа хөгжлийн төвийн хамтарсан технологийн сургалтад шаардлагатай сургалтын материал, маягтуудыг боловсруулна. Сургалтын материалыг JICA-ийн хэрэгжүүлдэг SHEP төслийн материалаас санаа авч, Монгол хувилбар болон хөгжүүлэх удирдамжийг боловсруулах Судалгаа хөгжлийн төв удирдан, сонгогдсон аймгийн ХАА-г бодлогын газрын мэргэжилтэн болон сумын хариуцсан ажилтанд технологи сургалт (зааварлагч бэлтгэх сургалт, ToT: Training of trainers)-ыг зохион байгуулна. (4) Сумын хариуцсан мэргэжилтнээр дамжуулан, ногоочдын бүлэгт сургалт заавар өгөх ажлыг зохион байгуулна. Дээрх зааварлагч бэлтгэх сургалт (ToT)-д хамрагдсан сумын мэргэжилтэн нь ногоочдын бүлэгт зах зээлийн баримжаат фермерийн менежментийн чиглэлийн сургалтыг хийнэ.Технологийн сургалтын зорилго нь зах зээлээ судлах, тарималаа сонгох, тариалалтын календарийг багтаасан бизнес төлөвлөгөө, маркетинг, фермерийн менежментийн удирдамж боловсруулах зэрэг байх болов уу. Бас, түрүүлээд сайн үр дүнд хүрсэн аймаг сумдын туршлага судлах аялал төлөвлөж хэрэгжүүлэх. (5) Ногоочдын бүлгээр зах зээлийн судалгаа хийлгэх, материал нийлүүлэгч ААН, зах зээлийн холбогдох хүмүүстэй холбогдоход туслах, оролцогч ногоочдын бүлгийн фермерийн менежментийн тогтвортой байдал болон орлого ашгийг сайжруулах Судалгаа хөгжлийн төв болон аймаг сумдын мэргэжилтнүүд нь ногоочдын бүлгээр зах зээлийн судалгаа хийлгэх, материал нийлүүлэгч компани зах зээлийн холбогдох хүмүүстэй (Боловсруулагч, жижиглэнгийнхэн, супер маркетууд г.м) холбогдоход туслана. Харилцан тохиролцвол гэрээт тариалалт болон гэрээт борлуулагчийн гэрээ байгуулж,

	наймааг туршиж үзнэ. (6) ХХААХҮЯ, судалгаа хөгжлийн төв нь төслийн хяналт, үнэлгээ хийх ХХААХҮЯ, судалгаа хөгжлийн төв нь төслийн хяналт, үнэлгээ хийж, хөгжүүлэлтийг өргөжүүлэх үе шатны журам болон хөгжүүлэлтийн удирдамжийг шинэчилнэ. (7) Хөгжүүлэлтийг өргөтгөх шатанд, (2)-оос (6)-ийн үйл ажиллагааг өргөжүүлэн хэрэгжүүлнэ. (2)-оос (6) хүртэлх үйл ажиллагаа нь нэг жилд хэрэгжих боломжтой байх, жил бүр 3 орчим аймаг, 10-аад сумыг сонгон, үүнтэй ижил үйл ажиллагааг хэрэгжүүлж, зах зээлийн баримжаат фермерийн менежментийг хөгжүүлэх, өргөтгөх. Хамгийн сүүлийн жилд ХХААХҮЯ төслийн үр дүнг нэгтгэн ач холбогдол, туршлага сургамжийг түүвэрлэн нэгтгэж Монгол хувилбар болон удирдамж, зааврыг эцэслэн боловсруулах	
Санхүүжилт	<u>Засгийн газар</u> • Аймаг сумдын ХААГ-ын мэргэжилтэн (багшийн цалин, томилолтын зардал) • Төрийн төрийн төв байгууллагын хяналт, үнэлгээ • Бизнесийн түншлэл тогтоох зэрэг арга хэмжээний зардал • Удирдамж, заавар боловсруулах зардал • ХАА-н орц материал болон ногоонд татаас олгох	<u>Хувийн сектор</u> • ХАА-н орц материалын зардал • Маркетингийн зардал • Гэрээт борлуулалтын төрийн / ажлын/ зардал
Төслийн өртөг	Төслийн нийт өртөг: 5 тэрбум 599 сая төгрөг (2,131,000 ам.доллар)	
Ашиг, үр нөлөө	Цуврал сургалтад хамрагдсан тариаланчид төслийн өмнөх үеэс 30%-иар илүү ашигтай ажиллаж, 1,200,000 төгрөг/жил/тариаланч * 3,500 тариаланч = 4 тэрбум 200 сая төгрөгийн эдийн засгийн үр ашиг жилд бий болно.	
Бодлогын бичиг баримттай уялдсан байдал	1. Алсын хараа-2050 3.1.1. ХАА-н бүтээгдэхүүний түүхий эд болон бүтээгдэхүүний чанарыг сайжруулна. 2. Монгол Улсын Их Хурлын 36-р тогтоолын 3.3 Монгол Улсын хөдөө аж ахуйн менежментийн системийн техникийн горимыг батлах.	
Төслийг хэрэгжүүлэхэд анхаарах зүйлс	• Технологийн сургалтын агуулгын хувьд ЖАЙКА-аас дэлхийн янз бүрийн улсад хэрэгжүүлсэн SHEP төслийн гарын авлагаас санаа авах. • Гэрээт тариалалт болон гэрээт борлуулагчийн гэрээ байгуулах үе шат, гэрээлснй дараахь туршилтын борлуулалтын үед холбогдох хүмүүсийн харилцааны эелдэг уур амьсгал бүрдүүлэхийн тулд аймаг сумдын ХААГ-ын ажилтан нь үйл ажиллагааны хяналт мониторингийг хэрэгжүүлдэг байх.	

Төслийг хэрэгжүүлэх хуваарь ба төсөв

Үйл ажиллагаа	2025	2026	2027	2028	2029	2030	2031	2032	2033	2034	Нийт
(1) Хэрэгжүүлэх журам боловсруулах тайлбарлан таниулах											
(2) Төсөлд хамрагдах аймаг сумдыг сонгох											
(3) ТАХ-дад зориулсан зах зээлийн баримжаат фермерийн менежментийн технологийн сургагч бэлтгэх сургалт											
(4) Ногоочдын бүлгийг сургалтад хамруулах											
(5) Зах зээлийн судалгаа, зах зээлд											

оролцогчидтой холбоо тогтооход туслах												
(6) Хяналт үнэлгээ												
Төслийн өртөг	сая төгрөг	599	700	700	700	700	700	700	800			5,599
	мян. ам.дол.	269	266	266	266	266	266	266	266			2,131

Тэмдэглэл: **ЖАЙКА-ын зах зээлийн баримжаатай газар тариалан эрхлэлтийг дэмжих төсөл (SHEP)**

ЖАЙКА нь Африкийн болон дэлхийн бусад 51 оронд өрхийн ногоочдыг чадваржуулж, орлогыг нэмэгдүүлэх сургалтын төсөл (SHEP)[102] хэрэгжүүлж байна (2022 оны 3 сар). Өнгөрсөн хугацаанд уг төслийн сургалтад 270 мянга гаруй тариаланч хамрагдснаас Палестины тариачдын орлого 90%-иар, Кенийн тариачдын орлого 2 дахин өссөн байна. SHEP төслийн концепц нь эдийн засгийн ухаан, сэтгэл судлалын гибрид бөгөөд, эдийн засгийн ухааны "тэнцвэргүй мэдээлэл (information asymmetry) гэдэг онолын үүднээс "Борлуулах зорилгоор тариалалт хийх" болон Сэтгэл судлалын ухааны "Бие даан шийдвэрлэх онол"-д үндэслэсэн "Тариачны урам зоригийг" өдөөх үйл ажиллагааны дизайнаас бүрдэнэ (Баруун гар талын схем).

SHEP-ийн онцлох үйл ажиллагааны арга нь "4 үе шат":

① Хамрагдах тариачныг сонгож, нэгэн зорилгод нэгдэх, төслийн үйл ажиллагааг тайлбарлах.

② Тариаланчдад сэдэл олгох боломжийг бүрдүүлж тэдний оролцоотой суурь судалгаа хийх, тариаланчид, ААН, жижиглэнгийн дэлгүүр, зах зээлийн оролцогчдын мэдээлэл солилцож бизнесээ холбох, тариаланчид өөрсдөө зах зээлээ судлах.

③ Тариаланчид зах зээлийн судалгааны үр дүнд үндэслэн тарималаа сонгох нийлүүлэх хугацаа зэрэг асуудлаар шийдвэр гаргаж, зөвлөлдөх.

④ Эрэлт хэрэгцээнд суурилсан технологийн сургалт "шийдвэрлэх арга зам"-ыг зааж өгөх, тариаланчдын зах зээлийн судалгаанд үндэслэсэн "сурмаар байгаа зүйл"-ийг сургалтын хөтөлбөрт оруулж өгнө. Ногооны нийлүүлэлтийн хэмжээ болон үнэд улирлын хэлбэлзэл ихтэй Монгол ногооны нийлүүлэлтийн сүлжээний өнөөгийн байдлаас харахад SHEP аргыг нэвтрүүлэх нь үр дүнтэй байна гэж үзэж байна.

(3)Тариаланчдын хоршоодыг ашиглан ГТ-ийн бүтээгдэхүүний нийлүүлэлтийн тогтолцоо бүрдүүлэх төлөвлөгөө

YAT 1.3: Тариаланчдын хоршоодоор дамжуулан ГТ-ийн бүтээгдэхүүний нийлүүлэлтийн тогтолцоо бүрдүүлэх төлөвлөгөө	
Төлөвлөгөөний зорилт	Тариаланчдын хоршоог ашиглан ХАА-н бүтээгдэхүүний нийлүүлэлт болон анхан шатны боловсруулалтын тогтолцоо бүрдүүлэх.
Суурь түвшин	Чадавхи бүхий 10 хоршоо байна гэж тооцож байна.
Төлөвлөгөөний зорилго	Улсын хэмжээнд 100-аад хоршооны чадавхийг бэхжүүлж, ХАА-н бүтээгдэхүүнийг нийлүүлэх. Зах зээлийн эрэлтэд суурилсан эх орны үйлдвэрийн ногооны үйлдвэрлэл нийлүүлэлтийн хэмжээг нэмэгдүүлж, 2-р шатны хоршооны жилийн борлуулалтын дүнг 1, тэрбум төгрөгт хүргэх.
Хамрах хүрээ	Улсын хэмжээнд. Улаанбаатарын ойр орчим болон орон нутгийн төв хотуудыг тэргүүн ээлжинд хамруулах.
Хүлээх үр дүн	(1) Төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд шаардлагатай бизнес төлөвлөгөө (хэрэгжүүлэх цар хүрээ, хаана борлуулах, нийлүүлэх бүтээгдэхүүний төрөл, ашиг орлогын шинжилгээ)-ний загвар боловсруулах. (2) Зохион байгуулалтад орсон ногооны үйлдвэрлэл нийлүүлэлт нэмэгдснээр, УБ орчим болон орон нутгийн төв хотын ХАА-н хоршооны гишүүдийн өрхийн орлого сайжирна.

[102] JICA Web site SHEP (Зах зээлийн баримжаат фермерийг дэмжих) арга (2023 оны 11 сарын 11-ний мэдээлэл) https://www.jica.go.jp/Resource/activities/issues/agricul/ku57pq00002cubgq-att/business_strategy_01.pdf

	(3) Эх орны үйлдвэрийн ногооны үйлдвэрлэл нийлүүлэлт нь зах зээлийн баримжаанд үндэслэсэн орлого ашиг сайтай, үйлдвэрлэгчдийн зохион байгуулалттай (анхан шатны хоршоо болон 2 дахь шатны хоршоо голлосон) тогтолцоо бий болно. (4) Хоршооны бүтэц сайжирч, засаглалын бүтэц, санхүүгийн хяналт бэхжинэ.	
Үйл ажиллагаа	(1) ХАА-н хоршооны бизнес төлөвлөгөө (байгууламжийн хэмжээ, харилцагч, нийлүүлэх бүтээгдэхүүний төрөл, ашиг орлогын шинжилгээ) боловсруулах. ХХААХҮЯ-ны ГТБХЗГ, улсын хэмжээний ХАА-н хоршоод, Монголын хөдөөгийн хөгжлийн төлөөх фермерүүдийн холбоо Mongolian Farmers Association for Rural Development (ТББ)-тай хамтран ХАА-н хоршооны хэрэгжүүлэх бизнес төлөвлөгөө (хэрэгжүүлэх цар хүрээ, хаана борлуулах, нийлүүлэх бүтээгдэхүүний төрөл, ашиг орлогын шинжилгээ)-ний загвар боловсруулах. Загвар боловсруулахдаа ШХА (Монгол ногоо төсөл: Inclusive and Sustainable Vegetable Production and Marketing- Хүртээмжтэй, тогтвортой хүнсний ногооны үйлдвэрлэл, маркетинг) төслийн хэрэгжүүлсэнтэй төстэй үйл ажиллагаанаас үлгэрлэн, энэхүү төлөвлөгөөг хэрэгжүүлэх тогтолцооны схем болон хэрэгжүүлэх журмыг боловсруулна. Уг тогтолцоо болон хэрэгжүүлэх журмын талаар хамрагдах аймаг сумдын ХААГ-ын мэргэжилтэнд танилцуулна. (2) Уг төсөлд оролцох боломжтой ногоочид ногоочдын бүлэгт зар тарааж сонголт хийх ХХААХҮЯ, аймгууд, Монголын ХАА-н хоршооллогчдын холбоо хамтран бизнес төлөвлөгөөг танилцуулж, уг төсөлд оролцох боломжтой ногоочид, ногоочдын бүлгээс өргөдөл авах зорилгоор сонгох шалгуурыг тогтооно. Сонголтын шалгуураа тодорхойлж, ногоочдын бүлэгт зарлана. Сонгох ногоочдын бүлгийн тоо нь анхан шатны хоршоог хамруулах аймаг сумдаас 10 орчим хоршоо (нийтдээ 100 хоршоо), 2 дахь шатны хоршоо нь Улаанбаатар орчмын 5 хоршоо, хүнсний ногооны үйлдвэрлэл хөгжсөн орон нутгийн төв хотуудаас 5 хоршоо нийтдээ 10 хоршоо байх. (3) Ногоочдын бүлгийг зохион байгуулалтад оруулахад туслах. Түүхий эд үйлдвэрлэл, нийлүүлэлтийг хариуцах анхан шатны хоршоо, голчлон түгээлт борлуулалт (угаалга, ялгалт, ангилал, савлах, маркетингийн ҮА багтана) хариуцах 2 дахь шатны хоршоо байгуулахад тусална. Өөрөөр хэлбэл, хоршооны ААН-ийн бүртгэл, байгууллагын менежмент, үйл ажиллагааны чиглэл (ажил үүргийн хуваарь-TOR)-д нь тусална. (4) Зохион байгуулалтад орсон хоршоонд тоног төхөөрөмжийн хөрөнгө оруулалт, технологийн сургалт хийх тусламж үзүүлнэ. 2 дахь шатны хоршоонд агуулах барих, угаах төхөөрөмж, ангилан ялгах машин нийлүүлж, эдгээрийг ашиглах маркетинг (жижиглэнгийн дэлгүүр, ресторан, сургууль, зочид буудал зэрэгтэй худалдааны хэлэлцээр хийх), цуглуулах, ялгах, ангилах, анхан шатны боловсруулалт болон хоршооны менежментийн чиглэлээр сургалт зохион байгуулна.	
Санхүүжилт	<u>Засгийн газар</u> • Бизнес төлөвлөгөө боловсруулах зардал • Агуулах барих болон, тоног төхөөрөмж авах зардал • Аймаг сумдын ХААГ-ын мэргэжилтэн (томилолт, унааны зардал)	<u>Хувийн хэвшил</u> • Агуулах барих болон, тоног төхөөрөмж авах зардал • Үр тариалалтын зардал (өөрийн хариуцах зардал) • Маркетинг, удирдлагын зардал
Төслийн өртөг	Төслийн нийт өртөг: 7 тэрбум 755 сая төгрөг (2,952,000 ам. доллар)	
Ашиг, үр нөлөө	2 дахь шатны хоршооны жилийн борлуулалт 1 тэрбум (286,000 ам.дол)/хоршоо*10 хоршоо=10 тэрбум (2,860,000 ам. дол) хүрнэ.	
Бодлогын бичиг баримттай уялдсан байдал	1. Алсын хараа 2050 3.1.1. ХАА-н бүтээгдэхүүний түүхий эд болон бүтээгдэхүүний чанарыг сайжруулна. 2. Монгол Улсын Их Хурлын 36-р тогтоолын 4.2.1 Мал, МАА-н түүхий эд бэлтгэн нийлүүлэлт, анхан шатны боловсруулалт, борлуулалтын зохистой сүлжээ бүрдүүлж, ХАА-н загвар хоршоо байгуулах.	
Төслийг хэрэгжүүлэхэд	• Худалдан авах техник төхөөрөмж болон сургалтын агуулгын тухайд, ШХА-ийн Монголын хөдөөг хөгжүүлэх тариаланчдын холбооны хэрэгжүүлсэн MONVEGI төсөл:	

анхаарах зүйлс	Хүнсний ногооны тогтвортой, үйлдвэрлэл, хүртээмжтэй борлуулалтын төсөл, түүнчлэн АХБ-ны ижил төстэй төслөөр нийлүүлэгдсэн тоног төхөөрөмжийн жагсаалт болон технологийн зааврааc санаа авах. • Ногоочдын зохион байгуулалт болон чанартай үрээр хангах асуудлыг судлах. ШХА-ийн (MONVEGI), ЖАЙКА-ын төсөл (MONMAP-AVC, “Өвсний үндэс” хөтөлбөрийн (Хоккайдогийн Такикава хот)) бүртгүүлсэн сортын үрийг ашиглах боломжтой.

Төслийг хэрэгжүүлэх хуваарь, төсөв

Үйл ажиллагаа		2025	2026	2027	2028	2029	2030	2031	2032	2033	2034	Нийт
(1) Бизнес төлөвлөгөө												
(2) Ногоочид, ногоочдын бүлэгт зарлаж сонгон шалгаруулах												
(3) Зохион байгуулалтад ороход туслах												
(4) Тоног төхөөрөмжийн хөрөнгө оруулалт, технологийн сургалтад туслах												
Төслийн өртөг	сая төгрөг	255	1,500	1,500	1,500	1,500	1,500					7,755
	мян. ам.дол	102	570	570	570	570	570					2,952

Тэмдэглэл: Швейцарийн Хөгжлийн агентлагийн төсөл (MONVEGI)

MONVEGI-д хамрагдсан сумдад анхан шатны хоршоо, Улаанбаатарт 2 дахь шатны хоршоо байгуулсан. 2 дахь шатны хоршоо нь Улаанбаатарын супермаркет, зоогийн газруудтай гэрээ хийж захиалга аван анхан шатны хоршоодоор түүхий эдээ бэлтгүүлнэ. Бас ШХА нь 2 дахь шатны хоршоодод агуулах болон анхан шатны боловсруулалтын тоног төхөөрөмж нийлүүлсэн нь үр дүнтэй тусламж болсон. Энэ бүтцийн үр дүнд 2 дахь шатны хоршооны борлуулалт жил бүр өсч, 2022 оны борлуулалт 2,7 тэрбум төгрөгт хүрсэн. Анхны төсөөллөөр сумдын анхан шатны хоршоод нь ченжээс хамааралгүй ногооны зах зээлийг хөгжүүлэх төлөвлөгөөтэй байсан болов ч ялангуяа Улаанбаатарын дэлгүүрүүдэд бөөнөөр өгөхийн тулд хэмжээний хувьд асуудал үүсч, дээр өгүүлсэн анхан ба 2 дахь шатны хоршооны тогтолцоонд орсноор зах зээлийн эрэлтэд нийцсэн үйлдвэрлэл, түгээлтийн тогтолцоог бүрдүүлсэн. Бас, MONVEGI төслөөр Европын үр үрсэлгээний компани чанартай үр бүртгүүлэх болон импортлосноор 90 сортын ногоог хянадаг болсон. Төсөл хэрэгжсний үр дүнд: ①Хоршоо байгуулагдсан, ②Чанартай үр нийлүүлсэн, ③ Төслийн холбогдох байгууллагуудаас тасралтгүй үйл ажиллагааны дэмжлэг авч чадсан.



(4) Хүнсний ногоо боловсруулах энгийн арга хэрэглээний сургалт, сурталчилгааны төлөвлөгөө

YAT 1.4: Хүнсний ногоо боловсруулах энгийн арга хэрэглээний сургалт, сурталчилгааны төлөвлөгөө	
Төлөвлөгөөний зорилт	Иргэдэд дотоодод тариалсан ногооны хэрэглээг сурталчлах ажиллагаа болон орон нутагт ногоо боловсруулах энгийн технологи нэвтрүүлэх замаар чанар сайтай, тэжээллэг Монгол ногооны хэрэглээг нэмэгдүүлэх, сайжруулахыг зорино.
Суурь түвшин	• Нэг хүнд ноогдох ногооны хэрэглээний улсын дундаж нь сард 2,1 кг
Төлөвлөгөөний зорилго	• Нэг хүнд ноогдох ногооны хэрэглээг улсын дундаж нь сард 3 кг-д хүргэх • Хүүхэд залуучуудын ногооны хэрэглээг нэмэгдүүлж шим тэжээлийн дутагдлыг арилгах • Орон нутагт дотоодын ногооны үйлдвэрлэл боловсруулалтыг нэмэгдүүлэх
Хамрах хүрээ	Орон даяар, тэр дундаа Улаанбаатар орчмын болон бүс нутгийн төв хотуудаас хүнсний ногооны үйлдвэрлэл, хэрэглээ бага газруудыг тэргүүн ээлжинд сонгоно.
Хүлээх үр дүн	(1) Эх орны үйлдвэрийн ногооны хэрэглээг идэвхижүүлэх замаар дотоодын ногооны эрэлт хэрэглээг нэмэгдүүлэх. (2) Сургуулийн хоолонд ногоо нийлүүлэх, хоол тэжээлийн боловсрол олгосноор, хүүхдүүдийн эрүүл мэндийн тухай ойлголт, шим тэжээлийн байдал сайжирна. (3) Орон нутагт өрхийн тариалан болон хүнс боловсруулах энгийн технологийн сургалт хийснээр өрхийн төсвийн ачаалал бууруулах, орон нутгийн ногооны үйлдвэрлэл (өөрийгөө хангах)-ийг дэмжих.
Үйл ажиллагаа	(1) Дотоодод тариалсан ногооны хэрэглээний сурталчилгаа хийх төлөвлөгөө гаргах ХХААХҮЯ голлон аймаг сумд болон ЭМЯ-тай хамтран эх орны үйлдвэрийн ногооны хэрэглээний сурталчилгаа хийх журам боловсруулах. Гол үйл ажиллагаа нь ① Сургууль, цэцэрлэгт ногоо, шим тэжээлийн тухай хичээл орж, дадлага хийлгэх, ② Сургууль, цэцэрлэгүүдэд орон нутгийн ногоо нийлүүлж, хэрэглүүлэх, ③ Орон нутгийн ногоо тариалалтын (өрхийн тариалан, ногоо боловсруулах энгийн арга техник) талаар сургалт хийх, ④ Орон нутгийн жижиглэн худалдаачид өөрийн орон нутгийн ногоог худалдан авч борлуулах, ⑤ Ногоотой хоолны жор заах хоол хийх арга хэмжээ зохион байгуулах зэрэг. Хэрэгжүүлэх журам боловсруулахдаа ЖАЙКА-гийн сургуулийн үдийн хоолны үйлдвэрлэлийг дэмжих төсөл болон ШХА-ийн (MONVEGI төсөл: Хүнсний ногооны тогтвортой,үйлдвэрлэл, хүртээмжтэй борлуулалтын төсөл) зэрэг өмнөх төслүүдийн туршлагаас санаа авах. Хэрэгжүүлэх журмыг хамрагдах аймаг сумдын ХААГ-ын мэргэжилтнүүдэд танилцуулах. (2) ① Сургууль, цэцэрлэгт ногоо, шим тэжээлийн тухай хичээл орж, дадлага хийлгэх. ② Сургууль, цэцэрлэгүүдэд орон нутгийн ногоог нийлүүлж, хэрэглүүлэх. 1) Сурагчид, хүүхдүүдийн хоолны нөхцөл байдал болон шим тэжээлийн тухай мэдээлэл цуглуулж нэгтгэн (хэрэгцээт шим тэжээлийн элемент, авбал зохих шим тэжээлийн лавлах түвшин, сургуулийн хоолны цэс, материал худалдан авах, захиалах арга г.м) 2) Хүнс, хоол тэжээлийн холбогдолтой лекц орж дадлага хийлгэх. 3) Авбал зохих шим тэжээлийн лавлах түвшинд үндэслэн боловсролын газар, орон нутгийн захиргаа хамтран хүнсний материалын захиалга хийж худалдан авах. (3) ③ Орон нутагт ногоо тариалах (өрхийн тариалан, ногоо боловсруулах энгийн арга техник) талаар сургалт хийх. ④ Орон нутгийн жижиглэн худалдаачид өөрийн талбайн /нутгийн/ ногоог худалдан авч борлуулах 1) ХХААХҮЯ, хүлэмжийн холбоо зэрэг мэргэжлийн холбоо боловсруулсан бэлэн байгаа ногоо тариалах зааврууд цуглуулж нэгтгэх. 2) Орон нутгийн жижиглэнгийн худалдаачид үйлдвэрлэгчид ногооны сурталчилгаа хийх, бизнесийг холбох арга хэмжээ зохион байгуулах. 3) Аймаг сумдын ХААГ-ын мэргэжилтнүүд тариалалтын сургалт зохион байгуулах. (4) ⑤ Ногоотой хоолны жор заах, сурталчилгааны арга хэмжээ зохион байгуулах г.м 1) Авбал зохих шим тэжээлийн лавлах түвшин болон хүнсний аюулгүй байдлын мэдээлэлд үндэслэсэн хоолны жор боловсруулах. 2) Телевиз, радиогоор ”Шим тэжээлийг сайжруулах, хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдал” сэдэвт нэвтрүүлэг бэлтгэж гаргах. 3) Улаанбаатар болон бүс нутгийн төв хотуудын жижиглэнгийн дэлгүүрээр борлуулалт дэмжих арга хэмжээ, соён гэгээрүүлэх арга хэмжээ зохион байгуулах.

Санхүүжилт	Засгийн газар ・ Хэрэгжүүлэх журам, маягт боловсруулах зардал ・ Шим тэжээлийн чиглэлийн судалгааны зардал ・ Сургуулийн хоолны материалын тендертэй холбоотой зардал ・ Аймаг сумдын ХААГ-ын мэргэжилтний (томилолтын болон замын) зардал	Хувийн хэвшил ・ Сургуулийн хоолны материал нийлүүлэх тээврийн зардал ・ Маркетинг, үйл ажиллагааны зардал ・ Мэдээллийн сурталчилгааны (нэвтрүүлэг хийх, арга хэмжээ зохиох зэрэг) зардал
Төслийн өртөг	Төслийн нийт өртөг: 4 тэрбум 889 сая төгрөг (1,861,000 ам.доллар)	
Ашиг, үр нөлөө	Нэмэгдсэн ногооны хэрэглээ 0.9кг/хүн/жил × 3,000 төг/кг×3.3 сая хүн＝5,670,000,000 төг/жил	
Бодлогын бичиг баримттай уялдсан байдал	1. Алсын хараа 2050 3.1.1. ХАА-н бүтээгдэхүүний түүхий эд болон бүтээгдэхүүний чанарыг сайжруулна. 2. Монгол Улсын Их Хурлын 36-р тогтоолын 5.10 Хоол хү нсний зохистой хэрэглээний талаар сургалт,сурталчилгаа, соён гэгээрү үлэх ажил хийх	
Төслийг хэрэгжүүлэхэд анхаарах зүйлс	УИХ-ын 36-р тогтоолд нийгмийн хариуцлагатай төслийн хүрээнд бүх телевиз, радио нь долоо хоног тутам тогтмол цагт “Хүнсний аюулгүй байдлын цаг” нэвтрүүлэг явуулж, иргэдийн хоол хүнсний зохистой хэрэглээнд сургахад чиглэсэн үйл ажиллагааны талаар судалгаа хийж буй бөгөөд, эдгээр нэвтрүүлэгтэй хамтран ажиллахыг судлах.	

Төслийг хэрэгжүүлэх хуваарь, төсөв

Үйл ажиллагаа		2025	2026	2027	2028	2029	2030	2031	2032	2033	2034	Нийт
(1) Төлөвлөх												
(2) Үйл ажиллагаанууд												
Төслийн өртөг	сая төгрөг	130	517	517	517	517	517	517	517	517	623	4,889
	мян. ам.дол	56	196	196	196	196	196	196	196	196	237	1,861

Тэмдэглэл： ЖАЙКА-гийн Сургуулийн үдийн хоолны үйлдвэрлэлийг дэмжих төсөл

ЖАЙКА нь Монгол Улсын БШУЯ-тай хамтран “Сургуулийн хоолны тусламжийн төсөл （2021-2025）[103]” хэрэгжүүлж байгаа. Хүүхдүүдийн хоол тэжээлийн байдлын талаархи суурь мэдээллээс үзвэл бага ангийн хүүхдүүдийн (6-11 насны) 7.3%-нь өсөлтийн хоцрогдолтой, 2.8% нь жин багатай гэж ангилагдсан бол 22% нь таргалалттай буюу шим тэжээлийн дутагдалтай ба хэт их шимтэй хоол иддэг хэсэг холимог байдалтай, шим тэжээлийн тэнцвэртэй хоолоор хангах нь бэрхшээл болоод байна. Монгол Улсын БШУЯ нь 2006 оноос үдийн цай хөтөлбөр боловсруулж, 2019 оны 10 сарын байдлаар ЕБС-д өдөрт 1 хүүхдэд 600 төгрөг (24 иэн)/хүн/өдөр (өдөрт 1 хоол) гэсэн төсөв гаргаж байжээ. МУЗГ 2019 оны 5-р сард сургуулийн үдийн хоолны тухай хууль баталж, 2020 оны 9 сараас хэрэгжиж байна. Сургуулийн үдийн хоолны хуулинд “Бүх бага сургуульд сургуулийн хоол өгөхийн тулд стандарт технологийн шаардлага хангасан байгууламж, тоног төхөөрөмж, хүний нөөцийг зохистой хуваарилах” гэж заасан ба уг хууль хэрэгжиж эхэлснээс хойш үе шаттайгаар бүх сургуулиуд дотроо хоол бэлтгэх байгууламжтай болж, бүх хүүхдэд өмнөх үдийн цайны оронд шим тэжээлийн тэнцвэр хангасан “үдийн хоол” өгч эхэлсэн ба 2022 онд дунд анги, 2023 оноос ахлах ангийн сурагчдад хоол өгөхөөр төлөвлөж байна.

Уг төслийн хүрээнд олдоц сайтай хүнсний материалаар шим тэжээлийн тэнцвэр хангасан хоол өгөх орчныг бүрдүүлэх, орон нутгийн онцлогт суурилсан хоол өгөх тогтолцоо бүрдүүлэх, аюулгүй бөгөөд шим тэжээлийн тэнцвэр хангасан хоол өгөх төрийн үүргийг бэхжүүлэх замаар улсын хэмжээнд бага дунд сургуульд аюулгүй, шим тэжээлийн тэнцвэртэй хоолоор хангах стандарт гаргаж, улсын хэмжээнд бүх бага сургуульд шим тэжээлийн тэнцвэртэй хоолоор хангах ажил нэмэгдэнэ гэсэн хүлээлттэй байна. Уг төслийн нэг үр дүн бол шим тэжээлийн тэнцвэр хангасан хоол өгөх орчин бүрдүүлэх (хүний нөөцийн сургалт, авбал зохих шим тэжээлийн норм, цэс боловсруулах г.м) зорилт биелж байна. Авбал зохих шим тэжээлийн норм, цэс боловсруулах зэрэг ажлын сайн жишээ загварыг улсын хэмжээнд дэлгэрүүлэхэд ашиглахаар судална.

[103] https://www.jica.go.jp/project////mongolia/031/index.html

4.2.2 Жимсний модны нийлүүлэлтийн сүлжээг бэхжүүлэх хөтөлбөр

Монголын жилд үйлдвэрлэх жимсний хэмжээ 1800 орчим тонн. (зэрлэг сортыг оруулбал 6,000тонн) байхад жилийн хэрэглээ нь 30,000тонноос давж байгаа, эрэлт нийлүүлэлтийн зөрүү ихтэй. Харин, нэг тэрбум мод үндэсний хөдөлгөөн нь түлхэц өгч байгаа болохоор жимсний модны үйлдвэрлэл түгээлт өргөжинө гэх хүлээлт байна. Жимсний модны нийлүүлэлтийн сүлжээг бэхжүүлэхэд 1)Дотоодын суулгац үйлдвэрлэл, нийлүүлэлтийн тогтолцоог бүрдүүлснээр нийлүүлэлтийн сүлжээг бэхжүүлэх 2)Тариалалтын зохистой технологийг хөгжүүлэх замаар үйлдвэрлэлийн хэмжээг нэмэгдүүлэх 3)Чацарганын экспортыг дэмжих нь онцгой чухал байна.

	Орц	Үйлдвэрлэл	Боловсруулалт	Түгээлт, экспорт	Борлуулалт, хэрэглээ
Оролцогч	Үйлдвэрлэлийн багаж хэрэгсэл нийлүүлэгч ААН-үүд (Үр, бордоо, УХБ)	Тариаланч, ХАА-н хоршоо, газар тариалангийн компаниуд	Боловсруулах үйлдвэрүүд	Ченж, ХАА-н хоршоо,түгээлт, экспортын ААН	Жижиглэнгийн дэлгүүр, нийтийн хоол г.м
Гол бэрхшээл	Дотоодын суулгац үйлдвэрлэл, нийлүүлэлт хангалттүй. Таримал болон зэрлэг сорт холилдсон, зохих чанарын хяналт шаардлагатай	Усалгааны хүртээмж хүндрэлтэй, шувуу идэх зэргээр бүтээмж нь 2-3 тонн/га байгаа нь төсөөлснөөс бага ургацтай. Үйлдвэрлэлийн хугацаа богино. Тариалалтын зохистой технологи , тоног төхөөрөмж шаардлагатай.	Түүхий эд худалдан авах үед сорт холилдсон, ялгамж бренджүүлэлт хангалттүй. Үйлдвэрлэлийн ашиглалт бага. ЕХ-ны нормоор УХБ илэрсэн,үйлдвэрлэл боловсууралтын шатанд сайжруулах боломжтой.	Агуулах хүрэлцээгүй.Тээврийн зардал өндөр. Ургац хураалтын үе болон үйлдвэрлэлийн бус улиралд түгээлт,үнийн хэлбэлзэл их. Чацаргана нь экспортлож байгаа цөөн жимсний нэг.	Нэг хүнд ноогдох хэрэглээ бага. Өсөн нэмэгдэх эрэлтээс үйлдвэрлэлийн хэмжээ нь бага. Хот хөдөөгийн хэрэглээний ялгаа бага.
Авах арга хэмжээ	2.1 Жимсний модны суулгацын төвд тулгуурласан нийлүүлэлтийн сүлжээг бэхжүүлэх төлөвлөгөө				
		2.2 Тариалалтын зохистой технологийг дэлгэрүүлэх төлөвлөгөө			
			2.3 Чацарганын экспортыг дэмжих төлөвлөгөө		

Зураг 4.3 Жимсний модны нийлүүлэлтийн сүлжээг бэхжүүлэх хөтөлбөр

Эх сурвалж: Жайка төслийн баг боловсруулав.

Монгол Улсын жимс жимсгэний жилийн хэрэглээ нь 30,000 тн байхад, жилийн үйлдвэрлэлийн хэмжээ нь 8,000 тн байгаа нь эрэлт нийлүүлэлтийн зөрүү хэт их байгааг харуулж байна. Мөн хүн ам зүйн талаас авч үзвэл хэдэн арван жилийн туршид хүн ам өсөхөөр байгаа, тэгэхээр эрэлт хэрэгцээ тасралтгүй нэмэгдэнэ гэж таамаглаж байна. Уур амьсгалын нөхцөл зэрэг хязгаарлах зүйл бий ч Монгол Улсын жимсний нийлүүлэлтийн сүлжээний чиг хандлагаас харахад дотоодын жимс, жимсгэний үйлдвэрлэл түгээлтийг цаашид өргөжүүлэх шаардлагатай. Бас, жимснээс чацарганын үйлдвэрлэл харьцангуй их бөгөөд гадаадад экспортлодог жимс, жимсгэний төрөл болохоор энэ бүтээгдэхүүний талаар цаашид ч экспортыг дэмжихийг зорьж байгаа. Бодлогын хувьд 2022 онд зарласан тэрбум мод тарих үндэсний хөдөлгөөн нэлээд эрчимтэй өрнөж байгаа нь анхаарвал зохих зүйл мөн.

Өнөөгийн нийлүүлэлтийн сүлжээний гол хүндрэл гэвэл, ①Үйлдвэрлэлийн хэрэгслийн шатанд дотоодын суулгацын үйлдвэрлэл нийлүүлэлт хангалттүй, таримал болон зэрлэг сорт нь холилдсон байдалтай, ②Үйлдвэрлэлийн шатанд усалгааны хүртээмж муутай, шувуу идэх зэргээр бүтээмж нь төсөөлж байснаас бага, ③Боловсруулах шатанд түүхий эд худалдан авахад сортууд холилдсон, ялгарал болон бренджүүлэлт хангалттүй байгаа явдал, ④Түгээлт, экспортын шатанд хадгалах агуулахын дутагдал , тээврийн зардал өндөр, үнийн хэлбэлзэл их, ⑤Хэрэглээний шатанд нэг хүнд ноогдох хэрэглээний хэмжээ бага, мөн үйлдвэрлэл нь эрэлт хэрэгцээгээ гүйцдэггүй.

Үндсэн үзэл баримтлал, хөгжлийн чиглэлд тулгуурласан жимсний нийлүүлэлтийн сүлжээг

бэхжүүлэх хөтөлбөр гэвэл, 1) Жимсний модны суулгацын төвд тулгуурласан нийлүүлэлтийн сүлжээг бэхжүүлэх төлөвлөгөө, 2) Тариалалтын зохистой технологийг хөгжүүлэх төлөвлөгөө, 3) Чацарганын экспортыг дэмжих төлөвлөгөө гэсэн 3 ҮАТ боловсруулсан. Эдгээр хөгжлийн төлөвлөгөө нь асуудлыг шийдэхэд хэрхэн нөлөөлж байгаа, эсвэл давуу тал, боломжийг ашиглаж байгаа эсэх, улмаар хөгжлийн бодлогын чиглэлд нийцэж буй эсэх, тэдгээрийн хамааралыг доорхи хүснэгтэд харуулав.

Хүснэгт 4.2 Жимсний нийлүүлэлтийн сүлжээг бэхжүүлэх хөтөлбөр, хөгжлийн чиглэлийн хамаарал

	Бодит бэрхшээл, давуу тал, хөгжлийн чиглэлийн агуулга	Жимсний нийлүүлэлтийн сүлжээг бэхжүүлэх хөтөлбөрийн арга хэмжээ: 3 төлөвлөгөө		
		2.1	2.2	2.3
Бэрхшээл	Дотоодын суулгацын үйлдвэрлэл нийлүүлэлт хангалтгүй	◎	○	
	Таримал болон зэрлэг сорт нь холилдсон	◎	○	○
	Бүтээмж нь 1 га-гаас 2-3 тн төдий, төсөөллөөс бага	○	◎	
	Үйлдвэрлэлийн хугацаа богино	○	◎	
	Боловсруулах шатанд түүхий эд худалдан авахад сортууд холилдсон, ялгарал болон бренджүүлэлт хангалтгүй	◎		◎
	Үйлдвэрийн ашиглалтын түвшинг сайжруулах боломж бий			◎
	Хадгалах агуулахын дутагдал, тээврийн зардал өндөр	○		◎
	Үйлдвэрлэл нь өсөн нэмэгдэж буй эрэлт хэрэгцээг гүйцдэггүй	○	◎	
Давуу тал, боломж	Байгалийн сэрүүн орчинд өвөрмөц жимс, жимсгэнийн мод тариалдаг			◎
	Жимс жимсгэнийн төрөлд хамаарах боловсруулах ААН, нийгэмлэг зэрэг байгууллагатай	○	○	◎
	ХАА-н зохистой дадал г.м хүнсний аюулгүй байдлын тогтолцоо бүрдсэн		○	○
	Дотоодод баталгаажуулалтын байгууллагатай, судалгаа, боловсролын байгууллага бас бий	◎	○	
	Тэрбум мод тарих үндэсний хөдөлгөөн ихэд эрчимтэй өрнөж байгаа	○	○	○
	Хүнсний аюулгүй байдлын талаар хэрэглэгчдийн ойлголт сайжирч, дотоодын бүтээгдэхүүний хэрэгцээ нэмэгдэж буй		○	
Хөгжлийн чиглэл	1-1-1 Үр тариа, тосны ургамлын үр үйлдвэрлэх тогтолоог бэхжүүлэх			
	1-1-2 Чанартай үр, сортыг тариалахыг урамшуулах	◎	○	
	1-1-3 Суулгац үйлдвэрлэгчдийг бойжуулах	◎	○	
	1-1-4 Усны нөөцийн зохистой ашиглалт, усалгааны систем хөгжүүлэхийг урамшуулах		○	
	1-1-5 ХАА-н механикжуулалтыг урамшуулах		○	◎
	1-1-6 Хүлэмж байгуулахыг өргөтгөх	◎	○	
	1-1-7 Тариалалтын зохистой технологийг түгээн дэлгэрүүлэх	○	◎	
	1-1-8 Жижиг тариачдыг хамруулсан зах зээлд чиглэсэн фермерийг хөгжүүлэх		○	
	1-1-9 Түргэтгэсэн тариалалтын технологийг дэлгэрүүлэхийг дэмжих		◎	
	1-1-10 ХАА-н хоршоог ашиглан, ХАА-н бүтээгдэхүүний түгээлт (хадгалалт)-ийн тогтолцоо байгуулах	○		○

	Бодит бэрхшээл, давуу тал, хөгжлийн чиглэлийн агуулга	Жимсний нийлүүлэлтийн сүлжээг бэхжүүлэх хөтөлбөрийн арга хэмжээ: 3 төлөвлөгөө		
		2.1	2.2	2.3
	1-1-11 Хүнс боловсруулах үйлдвэртэй гэрээт тариалалтыг дэмжих	○		○
	1-1-12 Жижиг тариаланчдад хүнс боловсруулах энгийн технологийг эзэмшүүлэх		○	○
	1-1-13 Шим тэжээл, хүнсний аюулгүй байдлын талаар ухуулга, гэгээрүүлэх үйл ажиллагаа явуулах			○
	1-1-14 Кластерийг дэмжих			◎

Эх сурвалж: Жайка төслийн баг боловсруулав.

Төлөвлөгөөнүүдийн товч агуулгыг доор сийрүүлэв.

2.1 Жимсний суулгацын төвд түшиглэсэн нийлүүлэлтийн сүлжээг бэхжүүлэх төлөвлөгөө

Энэхүү ҮАТ-нд тариалалтын зонхилох бүс нутаг бүрт жимсний модны суулгацын төв байгуулж, төрөл бүрийн жимсний суулгац тарьж нийлүүлэхийг үйл ажиллагааг бэхжүүлэх, жимсний дотоодын үйлдвэрлэлийн хэмжээг нэмэгдүүлэх болон чанарыг сайжруулахыг зорино. Дотоодын болон гадаадын чанартай сорт, суулгацаар тариалах замаар өндөр ургац авах, жимсний үйлдвэрлэлийн өртгийг бууруулах, орлого ашиг нэмэгдэх, түүхий эдийн чанар сайжирснаар эцсийн бүтээгдэхүүний нэмүү өртөг шингээлт сайжирч, бренджих зэргээр нөлөөлөх үр дүн их байх болно. Энэ мэтчилэн суулгацын чанар нь үйлдвэрлэлээс аваад борлуулалт хүртэлх бүх үе шатанд нөлөөлдөг тулд өндөр ач холбогдолтой хэрэгжүүлэх төлөвлөгөө гэж хэлж болно.

2.2 Тариалалтын зохистой технологийг түгээн дэлгэрүүлэх төлөвлөгөө

Энэхүү ҮАТ-нд Засгийн газар судалгаа хөгжлийн байгууллагатай хамтран жимсний модны тариалалтын зохистой технологийг түгээн дэлгэрүүлэх тогтолцоо бүрдүүлэх зорилт тавина. ХХААХҮЯ нь орон нутаг тус бүрийн онцлогт тохирсон чанартай үр сортын мэдээллийн сан бүрдүүлж, дэлгэрүүлэх тогтолцоог бий болгох, мастер дасгалжуулагч /ерөнхий агрономич/ бэлтгэх сургалт болон үйлдвэрлэгчдэд зориулсан төрөл бүрийн сургалт хийх каскад арга байна гэж төсөөлж байна. Эцэст нь жимсний модны тариалалтын зохистой технологийг нэвтрүүлэх удирдамж, заавар боловсруулж, аймаг сумдын ХХААГ, тасгийн агрономчид болон жимсний модны тариаланчид үр өгөөжтэй ашиглах тогтолцоог бүрдүүлнэ. Судалгааны бааз суурь нь ХААИС болон Дархан хот дахь Ургамал газар тариалангийн хүрээлэн байж болох юм.

2.3 Чацарганы экспортыг дэмжих төлөвлөгөө

Энэхүү ҮАТ-нд Монгол Улсад аль хэдийнэ үйл ажиллагаа явуулж байгаа чацарганын кластераар дамжуулан чацарганын бүтээгдэхүүний экспортыг дэмжих зорилт тавьсан. Тодорхой үйл ажиллагаа гэвэл төрийн албан хаагч мэргэжилтнүүдийн чадавхийг бэхжүүлэх, худалдааны бодлого боловсруулах болон төрийн байгууллагуудын бүрдүүлэлтийн журмын дэмжлэг, олон улсын зах зээлийн хэрэгцээ шаардлагыг судлах, зорилтот зах зээлийг тодорхойлох, тогтоосон зорилтот зах зээл дээрх борлуулалтыг эрчимжүүлэх зэрэг маркетингийн үйл ажиллагаа, кластерийг

бэхжүүлэх зэрэг байж болно.

Мөн, бусад зарим нэр төрлийн бүтээгдэхүүнийн адилаар өнөөг хүртэл Монголын засгийн газрын үйл ажиллагаа болон хандивлагчдын тусламжийн төслийн тэргүүн туршлагыг тодруулах боломжтой. ЕХ-ны тусламжаар Trade Related Assistance for Mongolia (EU TRAM) төслөөр Монголын ХАА-н бүтээгдэхүүний өрсөлдөх чадварыг бэхжүүлэхэд суурилан экспортлох зорилготой чацарганын кластер, сарлаг тэмээний ноосны кластер, сарлагийн ширний кластер, гоо сайхны барааны кластерууд байгуулагдсан. Эдгээр кластерийн онцлог нь тухайн салбарын том жижиг хувийн ААН-үүд, засгийн газрын байгууллага, судалгаа сургалтын байгууллага зэрэг үйлдвэрлэгч-төр-судалгааны байгууллагын оролцогчид хамтарч байгаа явдал, хамтарсан төслөөр шинэ бүтээгдэхүүн хөгжүүлэх, дотоод гадаадын стандарт хангасан шинэ технологи нэвтрүүлэх, нийтлэг бэрхшээлийг шийдвэрлэх замаар экспортын боломж бүрдүүлэх зэрэг болно. Мөн уг төслийн туршилтын үйл ажиллагаагаар Японы зах зээлд экспортлох оролдлого туршилт хийвэл зохих, EU TRAM-тай хорших хэлбэрээр чацарганаар хийсэн бүтээгдэхүүний (шүүс, чанамал, нунтаг зэрэг хэлбэрийн) найрлагын шинжилгээ, бүтээгдэхүүний үнэлгээ хийлгэсэн. Үүнээс гадна, Монголын жимсний холбоо, ХААИС-тай хамтран Борнуурын туршилтын талбайд чанартай сортын суулгац тариалах байгууламж барихыг дэмжиж буй бөгөөд тодорхой үр дүн харагдаж эхэлж байна. Эдгээр сургамж үр дүнг ҮАТ-нд тусган сайн жишээг дэлгэрүүлэн түгээхэд анхаарснаар тулгарч буй асуудлуудыг шийдвэрлэн, нийлүүлэлтийн сүлжээг бэхжүүлэхэд үр дүнтэй байна.

(1) Жимсний модны суулгацын үржүүлгийн төвд түшиглэсэн жимсний нийлүүлэлтийн сүлжээг бэхжүүлэх төлөвлөгөө

ҮАТ 2.1: Жимсний модны суулгацын төвд түшиглэсэн жимсний нийлүүлэлтийн сүлжээг бэхжүүлэх төлөвлөгөө	
Төлөвлөгөөний зорилт	Жимсний модны суулгацын төв байгуулж, бүх төрлийн жимсний модны суулгац, нийлүүлэлтийг бэхжүүлэх, жимсний модны дотоодын үйлдвэрлэлийн хэмжээг нэмэгдүүлэх, бүтээгдэхүүний чанарыг сайжруулах.
Суурь түвшин	Стандарт утгыг 0 ширхэг гэж аван, төгсгөлийн мөрөнд шинээр байгуулагдсан суулгацын төвд үйлдвэрлэсэн суулгацын тоог оруулна.
Төлөвлөгөөний зорилго	Байгуулагдсан суулгацын төвөөр дамжуулан жилд 1 сая ширхэг чанартай суулгацыг дотоодын үйлдвэрлэгч, ААН-дэд нийлүүлэх
Хамрах хүрээ	Улсын хэмжээнд
Хүлээх үр дүн	(1) Төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд шаардлагатай тогтолцоо, хэрэгжүүлэх журам, бус нутаг бүрт тохирох чанартай үр, сортын мэдээллийн сан байгуулах, орон нутаг, аймгуудын ХААГ-ын мэргэжилтэнд уг тогтолцоо, хэрэгжүүлэх журмыг тайлбарлах. (2) Төсөлд хамрагдах аймаг, хэрэгжүүлэх байгууллагыг сонгоно (Бүс нутаг тус бүрт 6 газар гэж тооцоолох). (3) Сонгогдсон нийт 18 аймаг хэрэгжүүлэгч байгууллагад техник хэрэгсэл нийлүүлж, технологийн сургалт хийнэ. (4) Бүс нугууд дахь суулгацын төвийн чанартай суулгацын үйлдвэрлэл, худалдаа. (5) Аймгуудын үйлдвэрлэгчдэд суулгац нийлүүлж, технологийн сургалт хийнэ.
Үйл ажиллагаа	(1) Төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд шаардлагатай тогтолцоо, хэрэгжүүлэх журам, бус нутагт тохирсон чанартай үр, сортын мэдээллийн сан байгуулах, бүс нутаг, аймгуудын ХААГ-ын мэргэжилтэнд уг тогтолцоо, хэрэгжүүлэх журмыг тайлбарлах. ХХААХҮЯ-ны ГТБТГ, ГТБХЗГ голлон Монголын жимсчдийн холбоо, сургалт,

	судалгааны байгууллага ЖАЙКА, ЕХ-ийн хэрэгжүүлсэн төстэй төслөөс санаа авч,энэ төлөвлөгөөг хэрэгжүүлэх тогтолцооны схем журмыг боловсруулах. Мөн дотоодын болон хилийн чанад дахь хүйтэн сэрүүн уур амьсгалтай бүс нутгуудын (Орос, Хятад, Хойд Америк гэх мэт) сайн чанарын жимс, сортуудын талаар мэдээлэл цуглуулж, бүс нутгийн онцлогт тохирсон чанартай үр, сортын мэдээллийн сан бүрдүүлэх. Жимс, жимсгэний холбооны боловсруулсан суулгацын талбайн стандартыг мөрдөх. Уг тогтолцоог хэрэгжүүлэх журмын талаар аймгуудын ХААГ-ын мэргэжилтнүүдэд танилцуулах семинар хийх. (2) Төсөлд хамрагдах суулгацын төв байгуулах аймаг, хэрэгжүүлэх байгууллагыг сонгох. Жимсчдийн холбоотой зөвшилцөн, бүс тус бүрт суулгацын төвийн кандидат болох аймаг байгууллагын сонгох. (Бүс тус бүрт 6 газар/жил). Сонгогдсон бүсэд суулгацын төв байгуулах боломжтой газар байгууламж, хүний нөөцтэй байгууллагыг (сургалт судалгааны байгууллага, аймгийн байгууламж г.м)-ыг сонгох. Тухайн байгууллага нь жимсчдийн холбоо (харьяа ААН)-той зөвшилцөж, модны суулгац худалдаалах төсөлд хамтран ажиллах гэрээ байгуулна. (3) Сонгогдсон 6 аймгийн хэрэгжүүлэх байгууллагад техник хэрэгсэл нийлүүлэх, технологийн сургалт хийх. Жимсний модны суулгац худалдаалах чиглэлээр бизнесийн түншлэлийн гэрээ байгуулсан зургаан байгууллагад үржүүлгийн газар байгуулан, материал тоног төхөөрөмж нийлүүлж, техникийн сургалт зохион байгуулна. Материал тоног төхөөрөмжийн хувьд дотоодын элит сортын суулгац, хамгаалах зурвас байгуулах материал, хүлэмж, худаг болон ус нөөцлөх төхөөрөмж, цахилгаан хангамжийн тоног төхөөрөмж нийлүүлнэ. Сонгогдсон аймаг, байгууллагын удирдлагуудыг үйл ажиллагаа явуулж буй үржүүлгийн төвтэй (Улаанбаатар хот болон Борнуур дахь ХААИС-ийн судалгааны төв) танилцуулан, жимсний модны тариалалтын технологийн зааварчилгаа боловсруулна. Мөн суулгац тариалалтын тухай сургалт зохион байгуулна. Эдгээр үйл ажиллагааг хэрэгжүүлсний үндсэн дээр жимсний модны үйлдвэрлэлийг явуулна. (4) Өргөжүүлэх үе шат болгож (2)-оос (3)-ын үйл ажиллагааг өргөжүүлэн хэрэгжүүлнэ. (2)-оос (3)-ын үйл ажиллагааг 1 жилийн дотор хэрэгжүүлэх боломжтой бөгөөд 2 дахь жилээс 3 дахь жилд үржүүлгийн төв байгуулах 6 аймаг ба байгуулгыг сонгоно. Эдгээр 6 аймаг байгуулгад мөн нэгэн адил материал, тоног төхөөрөмж нийлүүлэн, сургалт явуулж, суулгац үржүүлгийн төвийг нэвтрүүлэн дэлгэрүүлэх үйл ажиллагааг бодитоор явуулна. (5) Бүс нутаг бүрийн суулгацын төвд сайн чанарын жимсний модны суулгац үйлдвэрлэж, үйлдвэрлэл, борлуулалтын стратеги боловсруулна. Үрийн төвд сайн чанарын жимсний модны суулгац үйлдвэрлэж эхэлнэ. Төрөл бүрийн суулгац тариалалтын төв хариуцсан ажилтнууд жимсний модны суулгац тариалалт, үйлдвэрлэлийн үр дүн, асуудлыг зохион байгуулж, Монголын Жимс жимсгэнэний холбоо, ХХААХҮЯ-нд санал хүсэлтээ өгч, үйлдвэрлэл, борлуулалтын талаар зөвшилцөнө. Үйлдвэрлэл, борлуулалтын стратеги боловсруулна. (6) Аймгуудын үйлдвэрлэл эрхлэгчдэд суулгац нийлүүлж технологийн сургалт хийх. Суулгацын төв нь Монголын жимсчдийн холбоо, ХААИС-тай хамтран, аймгуудын үйлдвэрлэгчдэд суулгац өгч, технологийн сургалт хийнэ.	
Санхүүжилт	<u>Засгийн газар</u> • Цахим мэдээллийн сан бүрдүүлэхтэй холбоотой зардал • Суулгацын төл байгуулах болон техник хэрэгсэл худалдан авах зардал • Хамрагдах аймгийн хэрэгжүүлэх байгууллагын ажилтны томилолт, замын зардал	<u>Хувийн хэвшил</u> • Хөдөө аж ахуйн материал, тоног төхөөрөмж • Суулгацын төв үзэх, технологи сургалтын зардал • Төсөлтэй хамтран ажиллах гэрээ байгуулах удирдлагын зардал
Төслийн өртөг	Төслийн нийт өртөг: 9 тэрбум 400 сая төгрөг (3,578,000 ам.доллар)	
Ашиг, үр нөлөө	Суулгацын төвүүд нь жилд 1 сая ширхэг чанартай суулгацыг дотоодын үйлдвэрлэгч, ААН-үүдэд нийлүүлнэ. Мөн үйлдвэрлэгчтэй гэрээт жимсчдийн холбооны харьяа үйлдвэрүүдэд чанартай түүхий эд худалдснаар төслийн өмнөх нэгжийн үнэ (1 кг нь 17,000 төгрөг)-с 10% илүү үнээр (18,700 төгрөг) жимсний түүхий эдийг худалдах боломжтой болно. Ингэснээр	

	ажлын байр нэмэгдүүлж жилд 1 тэрбум 700 сая төгрөгийн эдийн засгийн үр ашиг гарна.
Бодлоготой уялдаж буй байдал	1. Алсын хараа 2050 6.2.4 Мод тарих,ойжуулах, ойн талбайг өргөтгөх ажлыг зохион байгуулах 2. Их Хурлын 36-р тогтоолын 3.10.2-т жимсний цэцэрлэгт хүрээлэн байгуулах төсөв, урамшууллын тогтолцоо бүрдүүлэх, судалгаа шинжилгээг өргөтгөх, тариалалтын технологийг бататгах.
Төслийг хэрэгжүүлэхэд анхаарах зүйлс	• Худалдан авах техник хэрэгсэл болон технологийн сургалтын агуулгын талаар жимсчдийн холбоо болон ХАА-н НӨС-ний Мастер төлөвлөгөөний төслийн туршилтын төслөөр боловсруулсан техник хэрэгслийн жагсаалтыг ашиглах. Суулгацын төв байгуулахдаа жимсний холбооны боловсруулсан стандартыг ашиглах. • Гэрээ байгуулсны дараа жимс, жимсгэний холбоо, хэрэгжүүлэх байгууллагатай харилцаатай байх, аймгуудын ХААГ-ын мэргэжилтэнүүд графикт мониторинг хийх.

Төслийг хэрэгжүүлэх хуваарь, төсөв

Үйл ажиллагаа		2025	2026	2027	2028	2029	2030	2031	2032	2033	2034	Нийт
(1) Хэрэгжүүлэх журам боловсруулах												
(2) Аймаг, хэрэгжүүлэгчийг сонгох												
(3) Сонгогдсон аймаг, байгууллагад техник хэрэгсэл нийлүүлж сургал хийх												
(4) Чанартай суулгац тариалж худалдаалах стратеги боловсруулах												
(5) Аймгуудад суулгац нийлүүлэх, технологи сургалт хийх												
Төслийн өртөг	сая төгрөг	200	2,000	2,000	2,000	500	500	500	500	500	700	9,400
	мян. ам.дол	79	761	761	761	190	190	190	190	190	266	3,578

Тэмдэглэл: MONMAP-AVC, Чацарганы НӨС-г бэхжүүлэх туршилтын төсөл

Чацарганы тариалалтын хувьд хураалтын улиралд шувуунд идүүлэх, усалгааны тоноглол байхгүй гэх бэрхшээлээс болж тийм ч өндөр ургац авч чадахгүй байгаа. Нийлүүлэлтийн сүлжээний нийтлэг асуудал нь таримал болон зэрлэг сорт холилдсон түүхий эд нь ялгарал бренджүүлэхэд хүндрэлтэй, өрсөлдөх чадварыг бэхжүүлэхэд бэрхшээлтэй байсаар ирсэн. Тус туршилтын төслөөр чанартай сортын суулгац үржүүлэх тогтолцоо бүрдүүлэхийг зорьж, ①Чацарганы суулгац болон тариалалтын технологийг сайжруулах (ХААИС-ийн Борнуур дахь туршилтын талбайд суулгац үржүүлэх барилга барихад туслах), ЕХ-ны худалдааг дэмжих төслийн хүрээнд чацарганын бүтээгдэхүүнийг экспортлох зорилго тавьж, ②Чацарганын найрлагын шинжилгээний дүнд үндэслэсэн маркетингийг бэхжүүлэх оролдлого, ①-ийн хүрээнд жимсний холбооны боловсруулсан суулгац үржүүлэх стандартад үндэслэсэн суулгац үржүүлэх барилга барьж, чацарганын 9 чанартай сорт дээр бусад жимсний модны чанартай сорт үржүүлж эхэлсэн. 1 тэрбум мод тарих үндэсний хөдөлгөөний хүрээнд Засгийн газар, жимсний холбоо нь уг суулгац үржүүлгээс үлгэр авч бусад бүсүүдэд мөн ижил үйл ажиллагаатай суулгац үржүүлэх талбай байгуулахаар болоод байна. ②-ийн хүрээнд найрлагын шинжилгээ, үнэлгээний үр дүнгээс үзвэл чацарганын шүүс, чанамал дотор бусад улсын бүтээгдэхүүнтэй харьцуулахад хэрэгтэй бодис агуулагдаж байгаа боловч харамсалтай нь нунтаг бараанд ЕХ-ны лавлах түвшиноос давсан УХБ-ын үлдэгдэл илэрсэн нь түүхий эд, түгээлтийн шатанд асуудал байгааг илчилсэн явдал боллоо. Хойшид, ашигтай барааны зах зээлийг сайжруулах, гадаадад гаргах боломжийг бүрдүүлж, экспортлох оролдлого хийх, асуудалтай бүтээгдэхүүний тухайн хэргийг шийдвэл экспортлох боломж нээгдэх болов уу.

(2) Жимсний модны тариалалтын зохистой технологийг түгээн дэлгэрүүлэх төлөвлөгөө

ҮАТ 2.2: Жимсний модны тариалалтын зохистой технологийг түгээн дэлгэрүүлэх төлөвлөгөө		
Төлөвлөгөөний зорилт	Судалгаа хөгжлийн байгууллагатай хамтарч жимсний мод тариалах зохистой технологийг түгээн дэлгэрүүлэх тогтолцоо бүрдүүлэх.	
Суурь түвшин	Стандарт утгыг 0 хүн гэж аван төгсгөлд нь чадавхитай болсон хүний тоог нэгтгэнэ.	
Төлөвлөгөөний зорилго	Системчлэгдсэн суулгац тариалах зохистой технологи бүрдэнэ. 2,500 үйлдвэрлэгчийн чадвар бэхжинэ.	
Хамрах хүрээ	Орон даяар. Жимсний тариалалтын гол бүс нутаг аймгуудад тэргүүн ээлжинд хэрэгжүүлэх.	
Хүлээх үр дүн	(1) Жимсний тариалалтын зохистой технологи тодорхой болж хөгжснөөр илүү системчлэгдэнэ. (2) Судалгааны болон засгийн газрын байгууллага, үйлдвэрлэгчийн мэргэжлийн мэдлэг, арга технологи бэхжинэ. (3) Илүү олон үйлдвэрлэгч ААН чанар сайтай жимс (ялангуяа түүхий эд) үйлдвэрлэж сурна.	
Үйл ажиллагаа	(1) Тариалалтын технологийг тодорхойлж хөгжүүлэх үүрэгтэй судалгааны болон засгийн газрын байгууллага сонгогдох. ХХААХҮЯ-ны ГТБХЗГ голлон тариалалтын технологийг сонгох, хөгжүүлэх үүрэг бүхий судалгааны болон төрийн байгууллагыг бусад бүс нутгуудад байгуулах. Судалгаа хөгжүүлэлтийн гол бааз нь ХААИС болон Дарханы Ургамал газар тариалангийн хүрээлэнд түшиглэх боломжтой. (2) Сайжруулбал зохих тариалалтын технологи болон газар тариалангийн техник материалыг тодорхойлж, төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд шаардлагатай журам боловсруулах. ХХААХҮЯ болон сонгогдсон судалгааны болон засгийн газрын байгууллага хамтран Монголын жимсний холбоо, Монголын сургалт судалгааны байгууллага, ЖАЙКА болон ЕХ-ноос өмнө нь хэрэгжүүлж байсан ижил төстэй хүчин чармайлтуудаас санаа авч, хэрэгжүүлэх журам, тариалалтын зохистой технологийн зааварчилгаа, чанартай сортын жагсаалт гаргах. Монголын жимсний холбоо нь жимсний үйлдвэрлэлийн ХААЗД, заавар боловсруулж буй тул түүнийг ашиглах. (3) Тариалалтын зохистой технологийг дэлгэрүүлэх үйлдвэрлэгч, хувийн ААН-ийг сонгох. (4) Судалгааны болон засгийн газрын байгууллага сургалт хийх. Судалгааны болон засгийн газрын байгууллага хамтран тодорхойлж хөгжүүлсэн тариалалтын технологийн сургалт хийх хөрөнгө техник хэрэгсэл нийлүүлэхийг сонгогдсон үйлдвэрлэгч хувийн ААН-д хэрэгжүүлэх.	
Санхүүжилт	<u>Засгийн газар</u> • Жимсний мод тариалах хөрөнгө техник хэрэгслийн татаас • Заавар, текст боловсруулах болон судалгааны зардал • ЭШБ, төрийн байгууллагын ажилтнуудын томилолт, замын зардал	<u>Хувийн хэвшид</u> • ХАА-н үйлдвэрлэлийн хэрэгслийн зардал • Сургалт сурталчилгааны зардал (багш сургагч зэрэг)
Төслийн өртөг	Төслийн нийт өртөг: 4 тэрбум 199 сая төгрөг (1,598,000 ам. доллар)	
Ашиг, үр нөлөөлөл	2,500 үйлдвэрлэгч чадавхижиж, улсын хэмжээнд нэгжийн ургац 20%-иар нэмэгдэнэ. 2,400 тн орчим байгаа жимсний модны үйлдвэрлэл 3,120 тн болж нэмэгдэнэ	
Бодлогын бичиг баримттай уялдсан байдал	1. Алсын хараа 2050 6.2.4 Мод тарих,ойжуулах, ойн талбайг өргөтгөх ажлыг зохион байгуулах. 2. Их хурлын 36-р тогтоолын 3.10 1 тэрбум мод тарих үндэсний хөдөлгөөн.	
Төслийг хэрэгжүүлэхэд	• Жимсний модны ҮАТ 2.1-ийн хүрээнд боловсруулсан жимсний мод, сортын мэдээллийн санг энэ ҮАТ-нд мөн ашиглах боломжтой.	

анхаарах зүйлс	• Үйлдвэрлэгч, хувийн ААН-ийг сонгохдоо жимс жимсгэнэ тариалдаг голлох бүс нутгийг тэргүүн ээлжинд сонгоно.

Төслийг хэрэгжүүлэх хуваарь, төсөв

Үйл ажиллагаа		2025	2026	2027	2028	2029	2030	2031	2032	2033	2034	Нийт
(1) ЭШБ, засгийн газрын байгууллагыг сонгох												
(2) Тариалалтын зохистой технологийг тодорхойлох, хэрэгжүүлэх журам боловсруулах												
(3) Үйлдвэрлэгч, хувийн ААН сонгох												
(4) ЭШБ болон ЗГ байгууллагууд сургалт хийх												
Төслийн өртөг	сая төгрөг	599	700	700	700	700	800					4,199
	мян.ам.дол	230	266	266	266	266	304					1,598

Тэмдэглэл: Тэрбум мод тарих үндэсний хөдөлгөөн

Монгол Улсын Ерөнхийлөгч НҮБ-ийн 76-р ерөнхий чуулганы индрээс уур амьсгалын өөрчлөлт, цөлжилттэй тэмцэх хамгийн үр дүнтэй арга бол ойжуулалт гэдгийг онцлон тэмдэглээд, Монгол улс 2030 он хүртэл 1 тэрбум мод тарих хөдөлгөөнийг хэрэгжүүлнэ хэмээн зарласан. Тухайлбал, салхины хаалт ойн зурвас байгуулах, жимс, жимсгэнийн төрлийн мод тарих талбайг нэмэгдүүлэх, ойн аж ахуй байгуулах (сумдад) зэргээр мод тарихыг дэмжихээр төлөвлөж байна. Мөн Япон Монголын энхтайван, хөгжил цэцэглэлтийн төлөөх тусгай стратегийн түншлэлийг хөгжүүлэх хамтарсан тунхаглалд[104]"Дэлхийн дахины бэрхшээл болох уур амьсгалын өөрчлөлт, орчны асуудалд ч хоёр улс тууштай хамтран ажиллах болно. Түүний нэг бол Монгол улсын ерөнхийлөгчийн санаачилж уриалсан "Тэрбум мод тарих" үндэсний хөдөлгөөнтэй холбогдуулан Японы Засгийн Газар нь Монголын ойжуулах төсөл болон, Монголын 20-иод мянган хүүхэд залуучуудад мод тарих үйл ажиллагааг оролцуулан байгаль орчин, гамшгаас хамгаалах чиглэлийн гэгээрэл сурталчилгааны ажлаар дамжуулан тууштай дэмжихээ илэрхийлсэн. Мөн Монголын Засгийн газар нь энэхүү төслийг саадгүй бөгөөд үр дүнтэй хэрэгжүүлэхийн төлөө бүх хүчээрээ хамтран ажиллана" гэж тунхаглалд дурьдсан байна. Ийнхүү Монгол улсад эрчимтэй өрнөж байгаа хөдөлгөөн дээр Монгол-Японы Засгийн газар хоорондын хамтарсан тунхаглал нь түлхэц өгч, салхи хаах ойн зурвас байгуулх, жимсний мод, жимсгэнэ тариалалтын талбайг өргөтгөх, ойн аж ахуй байгуулах зэргээр тариалалтын тохиромжтой технологийг буй болгох дэлгэрүүлэхийг илүү тууштай үр дүнд хүргэхийн тулд энэхүү YAT-г хэрэгжүүлэхийг хичээнгүйлэн хүснэ.

(3) Чацарганын экспортыг дэмжих төлөвлөгөө

YAT 2.3: Чацарганын экспортыг дэмжих төлөвлөгөө	
Төлөвлөгөөний зорилт	Чацарганын экспортыг дэмжинэ.
Суурь түвшин	890 сая төгрөг (254,000 ам доллар, 202 1он, FAO STAT)
Төлөвлөгөөний зорилго	Бүтээгдэхүүний экспортын мөнгөн дүн нь жилд 1,780 сая төгрөгт хүрнэ.
Хамрах хүрээ	Улаанбаатар болон улсын хэмжээнд
Хүлээх үр дүн	(1) ЕХ-ны зах зээл зэрэг зорилтот зах зээлийг баримжаалсан худалдааны бодлого боловсруулж худалдааны хэлэлцээр хийх.

[104] https://www.mofa.go.jp/mofaj/a_o/c_m1/mn/page1_001428.html

	(2) Зорилтот зах зээлтэй худалдаа хийхтэй холбогдон экспортын бүрдүүлэлт хийхэд гардаг өртгийг бууруулах болон саадыг багасгах. (3) Чацарганын экспортын кластерийг бэхжүүлэх.	
Үйл ажиллагаа	(1) ЕХ-ны зах зээл зэрэг зорилтот зах зээлийг баримжаалсан худалдааны бодлого боловсруулж, худалдааны хэлэлцээр хийх. 1) Гадаад зах зээл дэх эрэлтийн судалгаа хийх, 2-с дээш улсад зорилтот зах зээлээ тогтоох, 2) Тэрхүү эрэлтийг хангахад чиглэсэн худалдааны бодлого боловсруулах, 3) Худалдааны хэлэлцээр хийх төрийн албан тушаалтнуудын чадавхийг бэхжүүлэх, худалдааны хэлэлцээр байгуулах, (2) Зорилтот зах зээлтэй худалдаа хийхтэй холбоотойгоор, экспортын бүрдүүлэлт хийхэд гардаг өртгийг бууруулах болон саадыг багасгах. 1) Зорилтот зах зээлийн эрэлтийн талаарх мэдээллийг холбогдох талуудад түгээх. 2) Импортлох улстай байгуулсан худалдааны хэлэлцээрт үндэслэн, экспортын ААН-д тулгардаг бүрдүүлэлтийн журмыг мөрдөхөд дэмжлэг үзүүлэх. (3) Чацарганын экспортын кластерийг бэхжүүлэх. 1) Энэхүү кластер болон МҮХАҮТ, ХХААХҮЯ зэрэг төр хувийн хэвшлийн түншлэл, зөвлөлгөөнийг тогтмол хийх. 2) Олон улсын зах зээл дэх загвар хотуудыг судлах, үзэсгэлэн худалдаанд оролцох. Арга хэмжээтэй уялдуулан чацаргана зэрэг жимс жимсгэний бүтээгдэхүүнийг сурталчлах маркетингийн үйл ажиллагаа явуулах. 3) Олон улсын болон зорилтот зах зээлийн эрэлт, бусад асуудлыг холбогдох хүмүүст хүргэх. 4) Экспортын бүтээгдэхүүнийг үнэлж, сайжруулбал зохих зүйлсийг тодорхойлон сайжруулах арга хэмжээ авах. Шаардлагатай бол олон улсын баталгаажуулалтыг авах. ОУ-ын баталгаажуулалт авах тухайд “YAT 8.4 ОУ-ын баталгаажуулалт авах замаар экспортын өрсөлдөх чадварыг бэхжүүлэх төлөвлөгөө”-тэй уялдуулах асуудлыг судлаж үзэх.	
Санхүүжилт	<u>Засгийн газар</u> • ТАХ-чийн чадавхийг бэхжүүлэх зардал • Дэлхийн зах зээлийн судалгаа хийх зардал • Дэлхийн зах зээлийн үзэслэгэнг үзэх, судлах зардал	<u>Хувийн хэвшил</u> • Кластерийн зөвлөлгөөн, үйл ажиллагааны зардал • Дэлхийн зах зээлийн үзэсгэлэн худалдаа судлах зардал • Бүтээгдэхүүний шинжилгээ, үнэлгээний зардал • Баталгаажуулалтын гэрчилгээний зардал
Төслийн өртөг	Төслийн нийт өртөг: 3 тэрбум 250 сая төгрөг (1,237,000 ам. доллар)	
Ашиг, үр нөлөө	Дэлхийн зах зээлд экспортлох бүтээгдэхүүний үнийн дүн нь жилд 890 сая төгрөгөөр нэмэгдэнэ.	
Бодлоготой уялдаж буй байдал	1. Алсын хараа 2050 6.2.4 Мод тарих, ойжуулах, ойн талбайг өргөтгөх ажлыг зохион байгуулах. 2. Их хурлын 36-р тогтоолын 3.10 1 тэрбум мод үндэсний хөдөлгөөн 1.1.7 Экспортлох хүнс, ГТ, МАА-н бүтээгдэхүүний төрөл, тоо хэмжээг өргөтгөхөд чиглэсэн хуулийн төсөл.	
Төслийг хэрэгжүүлэхэд анхаарах зүйлс	• Дээр дурьдсан кластер нь EU-TRAM төслийн дэмжлэгтэйгээр үүссэн чацарганы кластер болно. • YAT 2.1, YAT 2.2, YAT 8.2, YAT 8.4-тэй уялдуулах талаар судлах.	

Төслийг хэрэгжүүлэх хуваарь, төсөв

Үйл ажиллагаа	2025	2026	2027	2028	2029	2030	2031	2032	2033	2034	Нийт
(1) Европын орнууд зэрэг зорилтот зах зээлп зорьсон худалдааны бодлого боловсруулж худалдааны хэлэлцээр хийх.											

(2) Зорилтот зах зээлийн экспортын бүрдүүлэлтийн зардлыг бууруулж, саад бэрхшээлийг багасгах.												
(3) Чацарганын экспортын кластерийг бэхжүүлэх.												
Төслийн өртөг	сая төгрөг	200	350	350	350	350	350	350	350	350	250	3,250
	мян.ам. дол	78	133	133	133	133	133	133	133	133	95	1,237

Тэмдэглэл: ЕХ-ны худалдааг дэмжих төсөл-EU TRAM

ЕХ-ны худалдааг дэмжих төсөл нь 3 бүрэлдэхүүн хэсэгтэй. ①Монголын компаний экспортын хэрэгцээг хангах худалдааны бодлогын төсөл боловсруулах, худалдааны хэлэлцээр хийх гадаад хамтын ажиллагааны чадавхийг сайжруулах, ②Худалдааг либералчлах ДХБ-ны конвенцэд үндэслэн экспортод зарцуулах өртгийг бууруулах, саадыг арилгахад чиглэсэн гаалийн болон холбогдох ТАХ-чдад туслах, ③Экспортыг дэмжихэд тулгууран MYXAYT, холбогдох мэргэжлийн холбоодын үйлчилгээг сайжруулах, Үйлдвэрлэл-төр ЭШБ-ын зөвшилцлийг сайжруулах, экспортын кластерийг хөгжүүлэх, ЕХ, дэлхийн зорилтот зах зээлд экспортлохын тулд өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх, баталгаажуулалт авах замаар экспортыг нэмэгдүүлэх хүчин чармайлт зэрэг үйл ажиллагаануудыг хэрэгжүүлж байна.

Эх сурвалж: EU-TRAM төслийн материалаас

4.2.3 Тосны ургамлын нийлүүлэлтийн сүлжээг бэхжүүлэх хөтөлбөр

Ургамлын тосны дотоодын үйлдвэрлэл нийлүүлэлтээр 2027 он гэхэд хэрэгцээгээ бүрэн хангахад чиглэсэн нийлүүлэлтийн сүлжээ байгуулах. Тосны ургамлаас Монголд хамгийн тохиромжтой нь рапс бөгөөд түүнийг тариалах болон боловсруулах тогтолцоо ч бүрдээд байгаа. Улаанбуудайтай сэлгэн тариалах системд орсон ба Хятадад экспортлодог гичтэй өрсөлдөөний байдалтай, гичнээс рапс руу шилжих байх гэж найдаж байгаа. Тэгэхийн тулд үйлдвэрлэгчийг тасралтгүй дэмжиж, рапсын дотоодын үртэй болох,рапсын худалдааны нөхцлийг сайжруулах, рапсын тосны борлуулалтыг дэмжих шаардлагатай.

	Орц	Үйлдвэрлэл	Боловсруулалт	Түгээлт, экспорт	Борлуулалт, хэрэглээ
Оролцогчид	Үр, бордоо, УХБ-ын компани	Тариаланчид, газар тариалангийн компаниуд	Хүнсний боловсруулах үйлдвэрүүд	Ченж, ХАА-н хоршоо, түгээлт, экспортын ААН	Жижиглэнгийн дэлгүүр, нийтийн хоолны газрууд
Гол хүндрэл	Рапсын үр нь импортоос хараат, худалдан авахад хүндрэлтэй. Дотооддоо үйлдвэрлэдэг болох хэрэгтэй. Орцын материалыг хөнгөлөлттэй зээлээр дэмжих	Рапс үйлдвэрлэх технологи нь төлөвшөөгүй, бүтээмж нь 0.6 тн/га буюу дэлхийн дундажийн 1/3 орчим байна. Технологийг зохистой хөгжүүлэх, дэлгэрүүлэх үйл ажиллагаа зайлшгүй шаардлагатай.	Хангалттай хүчин чадал, тоног төхөөрөмжтэй тос боловсруулагч бий ч тэр нь монополь байдалтай. Гичтэй өрсөлдөхийн тулд рапс худалдан авах уян хатан нөхцөл нь сорилт юм.	Дотоодын рапсын тос борлуулагчдын тоог нэмэгдүүлэх шаардлагатай. Дотоодын хэрэгцээг хангах нь тэргүүн зорилт ч Солонгос руу экспортлож буй	Олон төрлийн тос хэрэглэдэг ч рапсын тос нь бусад тосноос давуу талтай бөгөөд зохистой хэрэглэх нь хэрэглээг идэвхжүүлнэ.
Авах арга хэмжээ	3.1 Рапсын үрний дотоодын үйлдвэрлэл нийлүүлэлтийг бэхжүүлэх төлөвлөгөө	3.2 Рапс тариалах технологийг хөгжүүлэх болон үйлдвэрлэлийг дэмжих төлөвлөгөө	3.3 Рапсын худалдааны нөхцлийг сайжруулах төлөвлөгөө	3.4 Рапсын тосны хэрэглээг нэмэгдүүлэхэд чиглэсэн ухуулга сурталчилгаа хийх төлөвлөгөө	

Зураг 4.4 Тосны ургамлын нийлүүлэлтийн сүлжээг бэхжүүлэх хөтөлбөр

Эх сурвалж: Жайка төслийн баг

Ургамалын тосны хэрэгцээг 2027 он гэхэд дотоодын үйлдвэрлэлээр өөрийгөө хангадаг болох үндэсний зорилтыг хэрэгжүүлэхэд нийлүүлэлтийн сүлжээг бий болгох шаардлагатай. Тосны ургамлаас Монголд хамгийн ирээдүйтэй нь рапс бөгөөд түүнийг боловсруулах үйлдвэрүүд ч бий болсон байна. Рапсыг улаан буудайтай сэлгэн тариалах тогтолцоо бүрдсэн хэдий ч Хятад руу экспортлох гич нь борлуулалтын нөхцөл илүү байдаг тул гич тариалах сонирхох их байна. Гичнээс рапст шилжих байх гэсэн хүлээлт байна.Үүний тулд зайлшгүй хөгжүүлэх зүйл бол, 1) Рапсын үрийг дотооддоо тариалах ажлыг бэхжүүлэх, 2) Рапс тариалах технологийг хөгжүүлэх болон тариалалтыг дэмжих, 3) Рапсын борлуулалтын нөхцөлийг сайжруулах, 4) Рапсын тосны хэрэглээг өргөжүүлэхэд чиглэсэн ухуулга сурталчилгаа хийх. Эдгээр хөгжлийн төлөвлөгөөнүүд нь асуудлыг хэр зэрэг шийдэх, эсвэл давуу тал, боломжийг ашиглах вэ, цаашид хэрхэн хөгжлийн чиглэлд нийцэж байгаа талаар тэдгээрийн хамаарлыг доорхи хүснэгтэд нэгтгэн үзүүлэв.

Хүснэгт 4.3 Тосны ургамлын нийлүүлэлтийн сүлжээг бэхжүүлэх хөтөлбөр болон хөгжлийн чиглэлийн хамаарал

	Бодит бэрхшээл, давуу тал, хөгжлийн чиглэлийн агуулга	Тосны ургамлын нийлүүлэлтийн сүлжээг бэхжүүлэх хөтөлбөрийн арга хэмжээ: 4 төлөвлөгөө			
		3.1	3.2	3.3	3.4
Бэрхшээл	Үрийн худалдаа тогтворгүй, үнэ ихтэй	◎			
	Рапсын бүтээмж (нэгжийн ургац) муу		◎		
	Рапсын худалдан авах үнэ хямд, худалдааны нөхцөл хатуу			◎	
	Рапсын худалдаанд өрсөлдөөний зарчим үйлчилдэггүй			○	
Давуу тал, боломж	Рапсын сэлгэн тариалалт тогтворжсон		○		
	ХАА-н техник нэмж авах шаардлагагүй		○		
	Усалгаагүй талбайгаас ч тодорхой хэмжээний ургац авах боломжтой		○		
	Рапсын хоёр сорт батлагдсан	○			
	Хангалттай хүчин чадалтай тос шахах үйлдвэртэй	○		○	○
	Үйлдвэрлэлийн хэрэгсэл авахад ЗГ-с дэмжих бодлого баримталдаг		◎		
	Рапс судлаачидтай, технологийн чиглэлээр үр дүнтэй заавар өгөх боломжтой		◎		
	ХАА-н үйлдвэрлэгчдийн холбоотой			○	
Хөгжлийн чиглэл	1-1-1 Үр тариа тосны ургамлын үр үйлдвэрлэх тогтолцоог бэхжүүлэх	◎			
	1-1-2 Чанарай үр сортыг дэлгэрүүлэхийг дэмжих	◎			
	1-1-3 Үр үрсэлгээ үйлдвэрлэгчдийг бойжуулах	◎			
	1-1-4 Усны нөөцийг / усалгаатай тариаланг дэмжих		○		
	1-1-5 Механикжуулалтыг уухайлан дэмжих		○		
	1-1-6 Хүлэмжийг өргөжүүлэх				
	1-1-7 Тариалалтын зохистой технологийг нэвтрүүлэх		◎		
	1-1-8 Жижиг тариаланчдын зах зээлд чиглэсэн фермерийн АА-г дэлгэрүүлэх		○	○	
	1-1-9 Түргэтгэсэн тариалалтын технологийг дэлгэрүүлэхийг дэмжих				
	1-1-10 ХАА-н хоршоог ашиглан ХАА-н бүтээгдэхүүний түгээлт (агуулах)-ийн тогтолцоо			○	

	Бодит бэрхшээл, давуу тал, хөгжлийн чиглэлийн агуулга	Тосны ургамлын нийлүүлэлтийн сүлжээг бэхжүүлэх хөтөлбөрийн арга хэмжээ: 4 төлөвлөгөө			
		3.1	3.2	3.3	3.4
	бүрдүүлэх				
	1-1-11 Хүнсний үйлдвэртэй гэрээт тариалалт хийхийг дэмжих			◎	
	1-1-12 Жижиг тариачдад хүнс боловсруулах энгийн технологи нэвтрүүлэх				
	1-1-13 Шим тэжээл, хүнсний аюулгүй байдлын талаар ухуулгын үйл ажиллагаа хэрэгжүүлэх				◎
	1-1-14 Кластерийг дэмжих			○	

Эх сурвалж: Жайка төслийн баг ○ : Өндөр хамааралтай, ◎ : Хүчтэй хамааралтай

Төлөвлөгөөнүүдийн ерөнхий агуулгыг доор сийрүүлэв.

3.1 Рапсын үрийн дотоодын үйлдвэрлэл, нийлүүлэлтийг тогтолцоог бэхжүүлэх

Рапсын үрийн дотоодын үйлдвэрлэл, тогтвортой нийлүүлэлтэд чиглэсэн засгийн газрын хяналтын тогтолцоог нэвтрүүлж бататгах. Энэ нь улаан буудайн дээр хэрэгжиж байгаа системтэй адил, газар тариалангийн шилдэг хуулийн этгээдийг үр үйлдвэрлэгчээр баталгаажуулж, Засгийн газар үрийн рапсыг зохих үнээр худалдан авч тохирох агуухад хадгалан, дараа жилийн тариалалт болоход тариалах ААН-д зохих нөхцөлөөр нийлүүлдэг систем юм. Улаан буудайн үрийн асуудлыг хариуцдаг тариалан эрхлэлтийг дэмжих сан нь рапсын агуулахгүй тул одоогоор хувийн ААН-ийн агуулахыг түрээслэж байгаа ба урт хугацаандаа агуулах барих асуудлыг судалбал зохино.

3.2 Рапсын тариалангийн технологи хөгжүүлэх, үйлдвэрлэлийг дэмжих

Монгол Улсын га-гаас авах рапсын ургацын дундаж хэмжээ 0,6 тн бөгөөд дэлхийн дундаж болох 2 тн/га-д дөхүүлэхийн тулд технологийг сайжруулахыг зорино. Үүний тулд ХААИС, агрономчдын холбоо, ГТ эрхлэгчдийн холбоо, хувийн ААН-үүд хамтран үйлдвэрлэлийн технологийн туршилт сургалт хийхийн хамт, технологи сургалт, сурталчилгааны ажлыг тасралтгүй хийх хэрэгтэй байна. Улаан буудайнд хэрэгжүүлдэг шиг үр болон ХАА-н машин механизмийн түлш, бордоо, ургамал хамгааллын бодис худалдан авахад богино хугацаатай зээл олгох, болон ХАА-н техник авахад урт хугацаатай зээл олгох тогтолцоог үргэлжлүүлэх. Ялангуяа газар тариалангийн машин механизмын тухайд тариаланчдад зохих техник, тоног төхөөрөмжийг сонгох, ажиллуулах талаар зөвлөгөө өгөх арга хэмжээг хэрэгжүүлэх. Түүнчлэн тариалангийн талбай, тариаланчдын тоо өсөх хандлага ажиглагдахгүй байгаа тул тариалангийн талбайн зохистой менежментээр хөрсний үржил шимийг хадгалах асуудлыг анхаарч үзэх шаардлагатай. Мөн, ажиллах хүч төдийлөн нэмэгдэх төлөвгүй байгаа тул одоогийн байдлаар экспортын зориулалтаар гич тариалж байгаа талбайд дотоодын тосны үйлдвэрлэлийг хангах рапс тариалуулж, үр ашигтай байлгахын тулд тариаланчдад чиглэсэн урамшуллын тогтолцоог нэвтрүүлэхийг судлан үзэх.

3.3 Рапсын худалдааны нөхцөлийг сайжруулах

Рапс болон тосны ургамалын тариалалтыг тогтворжуулахын тулд худалдааны нөхцөлийг сайжруулж үйлдвэрлэгч тос шахах үйлдвэр хоёр урьдчилан тохиролцож байхыг дэмжих нь үр

дүнтэй. Тэгэхийн тулд засгийн газраас Газар тариалан эрхлэгчдийн холбооАА-н хоршоологчдын холбоо,эсвэл хувь тариаланч болон тос шахах ААН-ийн хооронд гэрээт тариалалтыг нэвтрүүлэхийг дэмжиж хянах.

3.4 Рапсын тосны хэрэглээг өргөжүүлэхэд чиглэсэн соён гэгээрүүлэх үйл ажиллагаа

Импортын наранцэцэг болон шар буурцгийн тос давамгайлж байгаа Монголын ургамлын тосны зах зээлд дотоодын үйлдвэрийн рапсын тосны хэрэглээний хувь хэмжээг нэмэгдүүлэхийн тулд хэрэглэчдэд түүний давуу талыг сурталчлах, хэрэглээг өрөгжүүлэхийг дэмжих шаардлагатай байна. Энэ чиглэлийн үйл ажиллагааг төрийн бодлогоор дэмжих. Мөн импортын тосноос дотодоодын үйлдвэрийн тосны үнийн давуу байдал үүсгэхийн тулд шаардлагатай дэмжлэгийн бодлогыг хэрэгжүүлэх.

(1) Рапсын үрийн дотоодын үйлдвэрлэлийг бэхжүүлэх

YAT 3.1: Тосны ургамлын тариалалтыг дэмжих төлөвлөгөө (Рапсын үрийн дотоодын үйлдвэрлэл, нийлүүлэлтийг бэхжүүлэх төлөвлөгөө)		
Төлөвлөгөөний зорилт	Хүнсний аюулгүй байдлын баталгааны нэгийн хувьд хүнсний тосны дотоодын өөрийгөө хангах хэмжээг нэмэгдүүлэхийн тулд, түүхий эд болох рапсын тариалалтыг өргөжүүлэхийг зорино. Рапс тариалах талбайг 50,000 га-д, нэгжийн ургацыг 1 тн/га, дотоодын тосны үйлдвэрт нийлүүлэх рапсын хэмжээг 50,000 тн-д хүргэж нэмэгдүүлэх (Суурь түвшин: 17 мянга га, 0,6 тн/га, 10 мянган тн гэж тооцов).	
Төлөвлөгөөний зорилго	Дотоодын тосны рапсыг дотооддоо үйлдвэрлэхэд шаардлагатай үрийг дотооддоо тариалах, үйлдвэрлэгчид зохистой нийлүүлэлт хийх боломжтой тогтолцоо бүрдүүлэх.	
Хамрах хүрээ	Орон даяар (Сэлэнгэ, Төв, Хэнтий, Булган, Дорнод, Дархан-Уул аймгууд нэн тэргүүнд).	
Хүлээх үр дүн	Монголд бүртгэлтэй сортын рапсын үр жилд 500 тн-ыг үйлдвэрлэнэ.	
Үйл ажиллагаа	(1) Рапсын үр үйлдвэрлэх ХАА-н үйлдвэрлэгчийг магадлан итгэмжлэх. Улаанбуудайтай адил тэргүүлэх тариаланч 10 орчим ААН (хувь тариаланч байж ч болно)-ийг үр үйлдвэрлэгчээр сонгох. Эдгээр хуулийн этгээдэд патент/лиценз/ олгож үрийн үйлдвэрлэлийг дэмжих. (2) Рапсын үр худалдан авалт (нийлүүлэлт?) ба хяналт. Хураалтын үед рапсын үрийн ургацын хэмжээ ба чанарыг тогтооно. Түүнээс хувийн ААН-ийн агуулахад хурааж, зохих нөөц бүрдүүлэлтийг тодорхойлно. (Патенттай үр үйлдвэрлэгч нь өөрийн компаний талбайгаас бусад хэсгийг тос шахах ААН-д нийлүүлнэ.) (3) Рапсын үрийн нийлүүлэлт. Улаанбуудайтай адил, рапсын үр үйлдвэрлэгчид өмнөх жилд дотоодод үйлдвэрлэсэн үрийг зохих үнээр худалдана. Тэгэхдээ 30%-ийг нь урьдчилгаа төлбөрөөр, 70%-ийг нь ургац хураасны дараа төлөх аргыг хэрэглэнэ. Хураасны дараах төлбөрийн хүүг засгийн газраас татаасаар олгоно.	
Санхүүжилт	<u>Засгийн газар</u> • Рапсын үр үйлдвэрлэгчийг патентжуулах, хянах (ХХААХҮЯ) • Рапсын үр нийлүүлэхэд төлбөрийг хурааж хийхтэй холбоотой татаас, хяналт (ХХААХҮЯ, ХААИС)	<u>Хувийн хэвшил</u> • Тогтвортой чанартай рапсын үр үйлдвэрлэх (ХААҮйлдвэрлэгч) • Рапсын үр худалдан авах, чанарын шинжилгээ, хадгалалт, борлуулалт (Тос шахах ААН, тариалагч ААН)
Төслийн өртөг	Төслийн нийт өртөг: 1 тэрбум 549 сая төгрөг(589,000 USD)	
Ашиг, үр нөлөө	Рапсын үрийн дотоодын үйлдвэрлэлийн хэмжээ нь 50 мянган га-д тариалахад хангалттай байхаар 500 тн-д хүрэх.	

Бодлогын бичиг баримттай уялдсан байдал	1. Алсын хараа 2050; Зорилт 2.5 Амьдрах таатай орчин бүрдүүлэх, Зорилт 8.2 Тогтвортой хөдөө аж ахуйг хөгжүүлэх. 2. Монгол Улсын их хурлын 36-р тогтоолын “3.2.3 ГТ-ийн бүтээгдэхүүний сорт болон ургамлын үрсэлгээ суулгац үйлдвэрлэгчийг бүртгэх цахим мэдээллийн сан үүсгэх”. 3. Хүнсний хувьсгал: 2027 он гэхэд дотоодоосоо 100% хангах зорилт тавьсан.
Төслийг хэрэгжүүлэхэд анхаарах зүйлс	• Улаанбуудайн үр нь ТЭДС-ийн агуулахуудад хадгалагддаг, харин рапсын үрийн агуулахгүй тул нэг хэсэгтээ хувийн агуулах түрээслэхээр тооцоолоха. Худалдан авах, хадгалах, хуваарилах явцад ч хувийн ААН-тэй хамтарч хэрэгжүүлэх.

Төслийг хэрэгжүүлэх хуваарь, төсөв

Үйл ажиллагаа		2025	2026	2027	2028	2029	2030	2031	2032	2033	2034	Нийт
(1) Үр үйлдвэрлэгчийг итгэмжлэх												
(2) Үр үйлдвэрлэх												
(3) Үр худалдан авч хадгалах												
(4) Үр нийлүүлэлтийн дэмжлэг												
Төслийн өртөг	сая төгрөг	54	77	116	154	193	193	193	193	193	193	1,549
	мян. ам.дол	20	29	44	58	73	73	73	73	73	73	589

- Үр үйлдвэрлэлтэй холбоотой гарах зардал нь тариаланчдын үйлдвэрлэлийн үйл ажиллагааны зардал болно
- Үрийн шинжилгээ, хадгалалтын зардал нь 1 тн тутамд 0.05 сая төг байх
- Үрийн урамшуулал кг үр тутмын 3,000 төгрөгийн 70%-ийн хүүгийн 16%-иар (1 кг үрэнд 336 төгрөг) тооцох.

(2) Рапсын тариалангийн технологи хөгжүүлэлт ба үйлдвэрлэлийг дэмжих

ҮАТ 3.2: Тосны ургамлын үйлдвэрлэлийг дэмжих төлөвлөгөө (Рапсын тариалангийн технологи хөгжүүлэлт ба үйлдвэрлэлийг дэмжих төлөвлөгөө)	
Төлөвлөгөөний зорилго	Хүнсний аюулгүй байдлын баталгааны нэгийн хувьд хүнсний тосны дотоодын өөрийгөө хангах хэмжээг нэмэгдүүлэхийн тулд, түүхий эд болох рапсын тариалалтыг өргөжүүлэхийг зорино. Рапс тариалах талбайг 50 мянган га-д, нэгжийн ургацыг 1 тн/га, дотоодын тосны үйлдвэрт нийлүүлэх рапсын хэмжээг 50 мянган тнд хүргэж нэмэгдүүлэх. (Суурь түвшин: 17 мянга га, 600кг, 10 мянган тн байгаа гэж тооцов)
Зорилт	Рапсын тариалангийн технологи сайжирч нэгжээс авах ургац 600кг-с 1 тнд хүрч нэмэгдэнэ.
Хамрах хүрээ	Орон даяар (Сэлэнгэ, Төв, Хэнтий, Булган, Дорнод, Дархан-Уул аймгууд нэн тэргүүнд)
Хүлээх үр дүн	(1) Рапсын тариалалтын зохистой технологи бий болох. (2) Рапс тариалалтын технологи хөгжүүлэх, сургалтыг хэрэгжүүлэх (жилд 4 удаа). (3) Рапс тариалалтанд зориулсан ЗГ-ын санхүүгийн дэмжлэг тогтворжиж, сайжрах
Үйл ажиллагаа	(1) Рапс тариалалтын зохистой технологийг хөгжүүлэх. Монголын байгаль орчин, нийгмийн байдалд зохицсон рапс тариалалтын зохистой технологийн судалгаа хийж хөгжүүлэх, үйлдвэрлэл дээр туршихыг хөхиүлэх. Түүний үр дүнд үндэслэн, тохирох технологийн холбогдолтой бичиг баримт /заавар?/ боловсруулах. (2) Рапс тариалалтын зохистой технологийг дэлгэрүүлэх. Рапсын загвар талбай гаргаж (5 байрлалд нийтдээ 50 га байна гэж төсөөлж байгаа),рапс үйлдвэрлэлийн технологийн чиглэлийн графикт семинар, арга хэмжээ зохион байгуулж (жилд 4-с доошгүй удаа), үйлдвэрлэгчийн технологийг сайжруулах. Технологийг дэлгэрүүлэх болон сургалтын материал бэлтгэх, үйлдвэрлэгчид заавар зөвлөлгөө өгөх, гэгээрүүлэхийг хөхиүлэх. (3) Рапсын тариалангийн дэмжлэгийг тогтворжуулах, бэхжүүлэх. Рапсын чанартай үрийн тогтвортой нийлүүлэлтийн тогтолцоо бүрдүүлж өргөжүүлэх, үр

	болон ХАА-н техникийн түлш авахад дэмжлэг үзүүлэх (урьдчилгаа 50%, хураасны дараа 50%-ийг төлөх)-ийг үргэлжлүүлэх. Түүний хүүг засгийн газар татаасаар өгөх. Цаашилбал, улаанбуудайд өгдөг татаасын тогтолцоо шиг рапсын үйлдвэрлэлийн хэмжээнд тохирсон татаас олгохыг судалж үзэх.	
Санхүүжилт	<u>Засгийн газар</u> • Рапсын туршилтын технологийг хөгжүүлэх туршилтын талбай, байгууламжаар хангах • Рапс үйлдвэрлэлийн технологийг дэлгэрүүлэх, сургалт хийх. • Рапсын үр болон тариалалтын үеийн түлш худалдан авахад дэмжлэг болох зардал (хүүгийн татаас). • Рапс, ургамлын тос үйлдвэрлэгчид урамшуулал татаас олгохыг судлах (1 тн тутамд багадаа 100 мянган төгрөг).	<u>Хувийн хэвшил</u> • Загвар талбай гаргаж өгөх
Төслийн өртөг	Төслийн нийт өртөг: 6 тэрбум 946 сая төгрөг (2,644,000 USD)	
Үр ашиг, нөлөө	Рапсын тариалан 50 мянган га-д хүрнэ.	
Бодлоготой хэрхэн уялдах	1. Алсын хараа 2050; Зорилт 2.5 Амьдрах таатай орчин бүрдүүлэх, Зорилт 8.2 Тогтвортой хөдөө аж ахуйг хөгжүүлэх. 2. Монгол Улсын Их Хурлын 36-р тогтоол. 3. Хүнсний хувьсгал: 2027 он гэхэд дотоодоосоо 100% хангах зорилт тавьсан.	
Төслийг хэрэгжүүлэхэд анхаарах зүйлс	• Рапсын тариаланд хэрэглэх үртэй холбоотой асуудлыг тусад нь төлөвлөж, хэрэгжүүлэх төлөвлөгөө, зардлыг тусгана.	

Төслийг хэрэгжүүлэх хуваарь, төсөв

Үйл ажиллагаа		2025	2026	2027	2028	2029	2030	2031	2032	2033	2034	Нийт
(1) Рапс үйлдвэрлэлийн зохистой технологийг хөгжүүлэх												
(2) Рапс үйлдвэрлэлийн зохистой технологийг дэлгэрүүлэх												
(3) Рапс үйлдвэрлэлд зориулсан тусламжийг тогтворжуулах												
(4) (Рапсын урамшуулал)												
Төслийн өртөг	сая төгрөг	430	646	790	740	740	720	720	720	720	720	6,946
	мян. ам.дол	167	245	300	281	281	274	274	274	274	274	2,644

- Туршилтын зардал гэдэг нь туршилтын талбай түрээслэх зардал гэж тусгана (50 га, 1 га-г урьдчилсан байдлаар 1 сая төгрөг гэж тооцов).
- Сургалтын зардлыг нэг удаагийн сургалтыг 5 сая төгрөгт багтаана гэж тусгав.
- Рапс үйлдвэрлэлийг 2025 онд 25,000 тн, 2026 онд 40,000 тн, 2027 онд 50,000 тн-д хүргэнэ гэж тооцов.
- Рапс үйлдвэрлэлд шаардлагатай материал техник худалдан авахад чиглэсэн тусламжийн бодлогыг үргэлжлүүлэх. Татааст хамруулах материал техникийг ачилтын /нийлүүлэлтийн/ үнийн дүнгийн 10% гэж тооцон (тн тутамд 0.18 сая төг), зардлын 50%-ийн хүүний 16%-ийг засгийн газар хариуцана гэж үзэв.
- Дотоодод тосны үйлдвэрт нийлүүлэх рапс болон экспортлох гичний ачилтын үнийн зөрүүг (1 тн тутамд 0.2-0.4 сая төг) багасгахын тулд татаас олгох асуудлыг судалж үзэх. Энд 1 тн тутамд 0.1 саяар тооцов.

Тэмдэглэл : Рапс тариалангийн технологийн сургалт ба тариалалтын гарын авлага боловсруулав.

Монголд рапс үйлдвэрлэл нь харьцангуй шинэ учраас, үйлдвэрлэлийн зохистой технологийг нутагшуулж, тариаланчдад түгээн дэлгэрүүлэх шаардлагатай. Төслийн хүрээнд Монгол Улсын ХААИС-ийн судлаачийн боловсруулсан рапсын тариалалтын сурах бичигт үндэслэн тариаланчдад ашиглахад хялбар тариалалтын зааварчилгааг эмхэтгэн боловсруулсан. Үүнийг рапсын тариаланчдын хурал уулзалт г.м боломжийг ашиглан тариаланчдад тарааж ажилласан. Монголд рапсын 2 сорт баталгаажуулалт хийгдсэн ба цаашид зохих технологийн туршилт хийх, бүтээмжийг нэмэгдүүлэх тал дээр хүчин чармайлт гаргаж ажиллах шаардлагатай.

Тэмдэглэл : ХАА-н дотацийн тогтолцооны чиг хандлага

МУ-д үндсэн үр тариа болох улаан буудайн үйлдвэрлэлд дотаци олгох ажил 2007 оноос хойш хэрэгжиж байна. Улаан буудайн тонн тутамд жил бүр 50,000-150,000 төгрөгийн татаас тогтоож, 200-900 үйлдвэрлэгчдэд олгож ирсэн байна. 2021 оны гүйцэтгэл нь тонн тутамд 80,000 төгрөгийг 813 үйлдвэрлэгчид олгосон ба, татаасын нийт дүн нь 23 тэрбум 122 сая (6,6 сая доллар) байв. Энэ ажил нь ТЭДС-гийн захиргааны журмаар хэрэгждэг.

Мөн 2022 оноос дотоодын өөрийгөө хангах хувь хэмжээг нэмэгдүүлэх зорилгоор хүнсний ногооны тонн тутамд 100,000 төгрөгийн дотаци олгож эхэлсэн. Энэхүү шинэ тогтолцоо нь ХХААХҮЯ-наас байгуулсан тариаланчдын мэдээллийн санд үндэслэн шууд захиргааны журмын дагуу хэрэгждэг. Өөрийгөө хангах хувь хэмжээг нэмэгдүүлэхэд хамрагдсан ургамлын тосны түүхий эд болох рапсын, үйлдвэрлэгчдэд татаас олгох тогтолцооны талаар мөн холбогдох яамд агентлагуудын түвшинд судлагдаж байгаа ч одоогоор хэрэгжих төлөв алга байна.

(3) Рапсын худалдааны нөхцөлийг сайжруулах

YAT 3.3: Тосны ургамлын тариалалтыг дэмжих төлөвлөгөө (Рапсын худалдааны нөхцөлийг сайжруулах)	
Төлөвлөгөөний зорилго	Хүнсний аюулгүй байдлын баталгааны нэг болохын хувьд ургамлын тосны дотоодын үйлдвэрлэл хангалтын хэмжээг нэмэгдүүлэхийн тулд, түүхий эд болох рапсын тариалалтыг өргөтгөхийг зорино. Тосыг нь авах рапс тариалах талбайг 50 мянга га-д, нэгж талбайн ургацыг 1тн/га-д тос шахах үйлдвэрт худалдах хэмжээг 50 мянган тнд хүргэж нэмэгдүүлнэ. (Суурь түвшин: 17 мянга га, 600кг, 10 мянган тн гэж тооцов)
Төлөвлөгөөний зорилт	Рапсын худалдааны нөхцлийг сайжруулах тариалах талбайг 17 мянган га-гаас 50 мянган гад хүргэх.
Хамрах хүрээ	Орон даяар (Сэлэнгэ, Төв, Хэнтий, Булган, Дорнод, Дархан-Уул аймгууд нэн тэргүүнд)
Хүлээх үр дүн	(1) Рапс тариалагч, тос шахах компанийн хоорондын гэрээт тариалалтыг өргөтгөх (нийт тарих рапсын 50-иас дээш хувьд хүргэх). (2) Гэрээт тариалалт хийснээр рапсын үйлдвэрлэлийн хэмжээ нэмэгдэнэ.
Үйл ажиллагаа	(1) Рапс худалдан авах нөхцлийг зохицуулах. Рапсын чанарын лавлах түвшин болон чанарт нийцсэн худалдан авах нөхцлийн талаар тос шахах компани рапсын тариалагч (ААН, холбоод)-дын дундын зохицуулах зөвлөлгөөн хийх, зөвшилцлийн механизмыг бий болгох. Мөн ачих /нийлүүлэх/ хэлбэр болон

	тээврийн нөхцлийг тохирох. (2) Рапсын гэрээт тариалалтыг дэмжих. Тариалалтын өмнө рапсын тоо хэмжээ болон чанар, арилжааны бусад нөхцлийг тос шахах компани тариалагч хоёр урьдчилан тохирч бичгээр гэрээ байгуулах. ХХААХҮЯ тэрхүү гэрээний гэрч болж хяналт тавих. (3) Рапсын гэрээт тариалалтын мониторинг. Гэрээт тариалалтын нөхцлийн талаар тариалах болон ургац хураах, арилжаа явагдах үед зохих ёсоор хэрэгжиж байгаа эсэхэд мониторинг хийнэ. Асуудал бэрхшээл үүссэн тохиолдолд холбогдох талуудын хооронд зохицуулалт хийнэ.	
Санхүүжилт	Засгийн газар • Рапсын гэрээт тариалалтын хяналт мониторинг хийхэд шаардагдах зардал (хурал зөвлөлгөөн, хүн хүчний зардал зэрэг)	Хувийн сектор • Рапсын гэрээт тариалалтыг хэрэгжүүлэх зардал (хурал зөвлөгөөн, хүн хүчний зардал зэрэг)
Төслийн өртөг	Төслийн нийт өртөг: 200 сая төгрөг (76,000 USD)	
Ашиг, үр нөлөө	Рапсын арилжааны нөхцөл сайжирснаар өрсөлдөгч нэр төрөл болох гичнээс тосны рапс тариалалт руу шилжих. Тариалах талбайг 50 мянган га-д хүргэхэд нэмэр оруулна.	
Бодлогын бичиг баримттай уялдсан байдал	1. Алсын хараа 2050; Зорилт 2.5 Амьдрах таатай орчин, Зорилт 8.2 Тогтвортой хөдөө аж ахуй. 2. Монгол Улсын Их Хурлын 36-р тогтоол. 3. Хүнсний хувьсгал: 2027 он гэхэд дотоодынхоо үйлдвэрлэл хэрэгцээг 100% хангах зорилготой.	
Төслийг хэрэгжүүлэхэд анхаарах зүйлс	• Рапсын тариаланч, тос шахах ААН хоорондын хувийн секторын арилжаанд Засгийн газар чиглэл, дэмжлэг үзүүлэх байр суурьтайгаар оролцоно. • Засгийн газар нь гэрээт тариалалтыг баталгаатай хэрэгжүүлэх ААН-д татаас олгох асуудлыг судалж үзэх.	

Төслийг хэрэгжүүлэх хуваарь, төсөв

Үйл ажиллагаа		2025	2026	2027	2028	2029	2030	2031	2032	2033	2034	Нийт
(1) Арилжааны нөхцлийг сайжруулах												
(2) Гэрээт тариалалтын гүйцэтгэлийг хянах												
(3) Мониторинг хийх												
Төслийн өртөг	сая төгрөг	20	20	20	20	20	20	20	20	20	20	200
	мян. ам.дол	8	8	8	8	8	8	7	7	7	7	76

- Арилжааны нөхцлийг зохицуулахтай холбоотой уулзалт хэлэлцүүлгийн зардалд 10 сая төгрөг төсөвлөж засгийн газар хувийн сектор хамтран хариуцах.
- Гэрээт тариалалтын гүйцэтгэлийг хянахтай холбоотой үйл ажиллагааны болон мониторингийн зардалд 10 сая төгрөг тусгаж засгийн газар хувийн сектор хамтран хариуцах.

(4) Рапсын тосны хэрэглээг өргөжүүлэхэд чиглэсэн соён гэгээрүүлэх үйл ажиллагаа

YAT 3.4: Тосны ургамлын үйлдвэрлэлийг дэмжих төлөвлөгөө (Рапсын хэрэглээг өргөжүүлэхэд чиглэсэн соён гэгээрүүлэх үйл ажиллагаа)	
Төлөвлөгөөний зорилго	Хүнсний аюулгүй байдлын баталгааны нэг болохын хувьд ургамлын тосны дотоодын үйлдвэрлэл нийлүүлэлтийн хэмжээг нэмэгдүүлэхийн тулд, түүхий эд болох рапсын тариалалтыг өргөтгөхийг зорино. Тосны рапс тариалах талбайг 50,000 га-д, нэгж талбайн ургацыг 1тонн/га, тосны үйлдвэрт нийлүүлэх хэмжээг 50,000 тоннд хүргэж нэмэгдүүлнэ. (Суурь түвшин: 17,000 га, 600 кг, 10,000 тн байгаа гэж таамаглаж байна)
Төлөвлөгөөний зорилт	Дотоодын хэрэгцээний ургамлын тосонд рапсын тосны эзлэх хэмжээ 10%-иас 20% болж нэмэгдэнэ.

Хамрах хүрээ	Орон даяар	
Хүлээх үр дүн	(1) Ургамлын тосны бүтээгдэхүүн дотроос рапсын тосны харьцангуй давуу тал ялгарна. (2) Рапсын тосны хэрэглээг нэмэгдүүлэхэд чиглэсэн соён гэгээрүүлэх үйл ажиллагаа хэрэгжинэ.	
Үйл ажиллагаа	(1) Ургамлын тосонд рапсын тосны харьцангуй давуу талыг мэдээллийн хэрэгслээр сурталчилна. Дотоодын зах зээлийг эзэлсэн импортын наранцэцгийн тосыг бодвол эх орны үйлдвэрийн рапсын тосны давуу тал болон эх орны үйлдвэрийнх болохоор аюулгүй зэрэг давуу талыг нэгтгэж хувийн сектортой хамтран хэрэглэгчдэд зориулсан сурталчилгааны материал бэлтгэнэ. (2) Рапсын тосны хэрэглээг нэмэгдүүлэхэд чиглэсэн ухуулга сурталчилгааны ажил хийнэ. Рапсын тосны сурталчилгааны материалыг ашиглан, хэрэглэгчдэд чиглэсэн төрөл бүрийн арга хэмжээний үеэр сурталчлан таниулах ажил, төрөл бүрийн мэдээллийн сувгаар мэдээлэл цацах. (3) Рапсын тосны татаасыг хэвээр үргэлжлүүлэх Засгийн газраас дотоодын тосны компанийг нэмүү өртгийн татвараас чөлөөлөх зэргээр хөнгөлөлтийн арга хэмжээ авах. Нөхцөл байдлаас хамааран импортын ургамлын тосны гаалийн татварыг нэмэгдүүлэх зэргийг судлах.	
Санхүүжилт	<u>Засгийн газар</u> • Дотоод үйлдвэрийн рапсын тосны сурталчилгааны материал бэлтгэх зардал • Сурталчлах үйл ажиллагааны зардал	<u>Хувийн хэвшил</u> • Дотоод үйлдвэрийн рапсын тосны сурталчилгааны материал бэлтгэх зардал • Сурталчилгааны ҮА-ны зардал
Төслийн өртөг	Төслийн нийт өртөг: 190 сая төгрөг (72,000 USD)	
Ашиг, үр нөлөө	Рапсын тосны талаархи хэрэглэгчдийн хандлага сайжирч, рапсын тосны хэрэглээ нэмэгдэнэ. 2022 оны рапсын тосны үйлдвэрлэлийн хэмжээ 4,000 орчим тн, үүнээс 800-д тонныг Солонгост экспортлосон. Монголын ургамлын тосны хэрэглээ 30,000 тн орчим гэж үзвэл дотоодоос хангах хангах хэмжээ нь 10%-иас давж гэж таамаглаж байна. Зорилтот түвшин болох 50,000 тн рапсаас 16,000 тн орчим тос шахна гэвэл үүгээр дотоодоос хангах хэмжээ 50% орчимд хүрнэ.	
Бодлогын бичиг баримттай уялдсан байдал	1. Алсын хараа 2050; Зорилт 2.5 Амьдрах таатай орчин, Зорилт 8.2 Тогтвортой ХАА. 2. Монгол Улсын Их Хурлын 36-р тогтоол. 3. Хүнсний хувьсгал: 2027 он гэхэд дотоодынхоо үйлдвэрлэл хэрэгцээг 100% хангах.	
Төслийг хэрэгжүүлэхэд анхаарах зүйлс	• Засгийн газар нь хувийн хэвшлийн хэрэгжүүлэх сурталчилгааны үйл ажиллагаанд, материал, контент бэлтгэх зардлын тодорхой хэсгийг хариуцах, сурталчилгаа хийх байр талбайгаар хангах зэргээр туслах.	

Төслийг хэрэгжүүлэх хуваарь, төсөв

Үйл ажиллагаа		2025	2026	2027	2028	2029	2030	2031	2032	2033	2034	Нийт
(1) Сурталчилгааны материал												
(2) Соён гэгээрүүлэх үйл ажиллагаа												
(3) Рапсын тосны урамшуулал												
Төслийн өртөг	сая төгрөг	60	50	40	20	20	0	0	0	0	0	190
	мян. ам.дол	24	19	15	7	7	0	0	0	0	0	72

・ Рапсын тосны урамшуулал гэдэг нь НӨАТ-аас чөлөөлөхийг хэлж байгаа хэрэг бөгөөд зардалд хамаарахгүй.

4.2.4 Мах, сүүний (гэрийн тэжээвэр амьтны хоолыг оруулан) нийлүүлэлтийн сүлжээг бэхжүүлэх хөтөлбөр

Монгол Улсын малын тоо социализм тарснаас хойш тасралтгүй өссөөр одоо 70 саяыг даваад байна. Нэг хүнд ноогдох МАА-н гаралтай бүтээгдэхүүний хэрэглээ их, ялангуяа махны хэрэглээгээр дэлхийд тэргүүлж байна. Гэсэн хэдий ч үйлдвэрлэл хэрэглээний тэнцвэрт байдал алдагдаж, мал өссөөр байна. Тийм учраас МАА-н арвин их нөөцийн үр дүнтэй ашиглах шаардлагатай байгаа бөгөөд үүний тулд МАА-н үйлдвэрлэлийг төрөлжүүлж, нэмүү өртөг шингээхийг дэмжиж гадаад зах зээлд гаргах зэрэг нь тулгамдсан асуудал болоод байгаа юм.Дээрх нөхцөл байдлыг харгалзан хэд хэдэн шинэ аргачлал нэвтрүүлж, МАА-н бүтээгдэхүүний нийлүүлэлтийн сүлжээг бэхжүүлэхийг зорьж байна.

	Орц	Үйлдвэрлэл	Нийлүүлэлт	Боловсруулалт	Борлуулалт, хэрэглээ
Оролцогч	Өвс тэжээл, түлш шатахуун борлуулагчид, малын эмч нар	Малчид, эрчимжсэн МАА эрхлэгчид	Мэргэжлийн боловсруулах компани болон мах сүүн бүтээгдэхүүн боловсруулах ААН	Экспортогч ААН , зарим дундын зуучлагчид	Жижиглэнгийн дэлгүүр, том супермаркет,экспортын төлөөлөгчийн газар
Тол бэрхшээл	Өргөн уудам нутагт тархан суугаа малчид, үйлдвэрийн холбоо муу, хот орчмын бэлчээрийн хомсдол, эрчимжсэн МАА-н хувьд тэжээл нийлүүлэлтийн тогтолцоо тогтворгүй	Эхлэлийн хөрөнгө оруулалт бараг байхгүй буюу хамгийн бага ч, нийлүүлэлт жигд биш, анхан шатны боловсруулалтын (хүнсний зориулалтаар төхөөрөх) үр ашгийг дээшлүүлэх зайлшгүй шаардлагатай байна. Эрчимжсэн мал аж ахуйн үр ашиг ч бага	Улирлын чанартай, жилийн туршид жигд үйлдвэрлэл эрхлэх боломжгүй, (агуулахын өгөөжтэй менежмент шаардлагатай). Шинэ үйлдвэрлэлийн системд технологийн хувьд зохицсон ААН маш цөөхөн. Эрүүл ахуйн менежмент, чанар сайжруулах ойлголт дутмаг	Нийлүүлэлтийн дийлэнх нь дундын зуучлагчдаас хараат,системчлэгдсэн бүтэц байхгүй (Ялангуяа малчдаас цуглуулж авах ажил)	Зарим орнуудад Монголын МАА н бүтээгдэхүүний эрэлт тодорхой хэмжээтэй байгаа нь тогтоогдсон ч бизнесүүдийг “холбох” боломж туйлын хомс, төрийн дэмжлэгийн тогтолцоо бүрдээгүй байна.
Авах арга хэмжээ	4.1 Малын үүлдэр угсааг сайжруулах тогтолцоо бүрдүүлэх төлөвлөгөө 4.2 Өсвөр мал бордох（хургыг оролцуулан）-ыг дэмжих төлөвлөгөө 4.3 Зах зээлийн эрэлтэд нийцсэн махны шинэ зэрэглэлийн стандарт гаргах, нэмүү өртөг шингээхийг эрчимжүүлэх төлөвлөгөө 4.4 Мал төхөөрөх үйлдвэр цех байгуулах төлөвлөгөө 4.5 МАА н бүтээгдэхүүн, түүний дайврыг ашиглан ГТА- ны хоол тэжээлийн үйлдвэрлэлийг бий болгох төлөвлөгөө 4.6 Сүү цуглуулах тогтолцоог бэхжүүлэх замаар сүүний нийлүүлэлтийг нэмэгдүүлэх төлөвлөгөө				

Зураг 4.5 Мах, сүүн бүтээгдэхүүний нийлүүлэлтийн сүлжээг бэхжүүлэх хөтөлбөр

Эх сурвалж: Жайка төслийн баг

Монгол Улсын мах, сүүний нийлүүлэлтийн сүлжээнд олон талын бэрхшээл тулгардаг. Богино хугацаанд шийдвэрлэх гарц гаргалгаа төдийлэн хялбар биш хэдий ч 3-р бүлэгт дурдсан асуудлууд, давуу талууд, хөгжлийн үндсэн чиглэл, түүн дотроо ялангуяа мах, сүүнд холбогдох асуудлуудыг нягтлан авч үзэж, Монгол Улсын давуу талыг тусган аль болох олон асуудлуудад шийдэл гаргасан, эсвэл асуудлыг хөнгөвчилсөн, хөгжлийн үндсэн чиглэлд нийцсэн төлөвлөгөө байх нь зүйтэй юм. Дээрх хүснэгтэд дурдсан зургаан төлөвлөгөө буюу “4.1.Малын үүлдэр угсааг сайжруулах тогтолцоог бий болгох төлөвлөгөө”, “4.2 Өсвөр малыг бордох ферм (хургыг оруулан) нэвтрүүлэхийг эрчимжүүлэх төлөвлөгөө”, “4.3 Зах зээлийн эрэлт хэрэгцээнд нийцсэн махны ангиллын шинэ стандарт нэвтрүүлэх, нэмүү өртөг шингээх үйл ажиллагааг дэмжих төлөвлөгөө”, “4.4 Мал төхөөрөх үйлдвэр байгуулах төлөвлөгөө”, “4.5 МАА-н болон дайвар бүтээгдэхүүнээр гэрийн тэжээвэр амьтны хоолны үйлдвэрлэл бий болгох төлөвлөгөө”, “4.6 Сүү цуглуулах тогтолцоог бэхжүүлэх замаар үйлдвэр цехэд хүлээн авах хэмжээг нэмэгдүүлэх төлөвлөгөө”-нүүдэд эдгээр асуудлуудыг харгалзан тусгасан бөгөөд доорх хүснэгтэд тус төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд тулгарч болох бэрхшээлийг хэрхэн авч үзэж, давуу талаа хэрхэн ашиглах, хөгжлийн бодлого чиглэлтэй хэрхэн уялдаж байгаа зэргийн хамаарлыг харуулав.

Хүснэгт 4.4 Мах, сүүний нийлүүлэлтийн сүлжээг бэхжүүлэх хөтөлбөр, хөгжлийн бодлогын чиглэлийн хоорондын хамаарал

	Бодит бэрхшээл, давуу тал, хөгжлийн бодлогын чиглэлийн агуулга	Мах, сүүний нийлүүлэлтийн сүлжээг бэхжүүлэх хөтөлбөрийн хүрээнд авах арга хэмжээ: 6 төлөвлөгөө					
		4.1	4.2	4.3	4.4	4.5	4.6
Бэрхшээл	Албан ёсны сувгаар дамжих махны урсгал бага		○	○	◎		◎
	Боловсруулсан бүтээгдэхүүний төрөлжүүлэх үйл ажиллагааны хоцрогдол	○	◎	◎		◎	
	Экспортын хэлцэл хийгдээгүй, мэдээлэл дутуу		○	○	○	◎	
	Ямааны махны хэрэглээ бага					◎	
	Үйлдвэрт нийлүүлж буй хэмжээ бага		◎	◎	◎		◎
	Хүйтэн хэлхээ бүрдээгүй		○	○			◎
	Зуны улирлын илүүдэл ба өвлийн улирлын хомсдол хоорондын тэнцвэргүй байдал	○	◎	○	○	○	
	Чанарын хяналт (ялангуяа сүүний эрүүл ахуй)	○	○	◎	◎		◎
Давуу тал	Зах зээлийн нөхцөл (адуу, хонины мах)	◎	◎	◎		◎	
	Экспортын хорио цээрийн нөхцөл хялбар (адууны мах, хонь ямааны өлөн гэдэс)		◎	◎	○	◎	
	Ховор чанар (хонины сүүлний өөх, сарлагийн сүү, хоормог, айраг гэх мэт)		○			◎	○
Хөгжлийн бодлогын чиглэл 1	1-2-1 Малын үүлдэр угсааг сайжруулах тогтолцоог бий болгох	◎	○				○
	1-2-2 Малын эмч, зоотехникч бэлтгэх	○	○	○	◎		
	1-2-3 Хоршоолон маллагах аргаар бага малын фермийг (түүний дотор хурганы мах) дэмжих	◎	◎				
	1-2-4 Ургац хураалт, анхан шатны боловсруулалтын тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээ, технологийн сургалт явуулах	○	○				
	1-2-5 Мал маллагааны зохистой технологийг түгээн дэлгэрүүлэх	○	◎				◎
	1-2-6 Мал төхөөрөх газар байгуулахыг дэмжих			◎	◎		
	1-2-7 Дайвар бүтээгдэхүүнээс тэжээвэр амьтны хоол үйлдвэрлэлийг хөгжүүлэх				○	◎	
	1-2-8 Малчдын хоршоодыг түшиглэн ноос, арьс, сүү цуглуулах, тээвэрлэх тогтолцоог бий болгох.		○				◎
	1-2-9 Үйлдвэрлэлийн хүний нөөцийг хөгжүүлэх (мах боловсруулах, ээрэх үйлдвэр, арьс шир)	○	○	○	○	◎	○
	1-2-10 Мөшгөлтийн системийн нэвтрүүлэх		○	◎	◎		
	1-2-11 Зах зээлийн эрэлт хэрэгцээнд нийцсэн махыг ангилах, брэнджүүлэх ажлыг нэвтрүүлэх	○	○	◎	◎		
	1-2-12 Аялал жуулчлалын хөгжилтэй уялдуулах, бэлэг дурсгалын үйлдвэрлэл		○				○
	1-2-13 Кластер хөгжүүлэх		○		○	◎	◎

Эх сурвалж: Жайка төслийн баг ○ : Өндөр хамааралтай, ◎ : Хүчтэй хамааралтай

Үргэлжлүүлээд, төлөвлөгөө тус бүрийн товч агуулгыг доор сийрүүлэв.

Юуны өмнө **“4.1 Малын үүлдэр угсааг сайжруулах тогтолцоог бий болгох төлөвлөгөө”**-ний тухайд Монгол улсад бүс нутгийнхаа орчин нөхцөлд дасан зохицсон малын сайн омог үүлдэр олонтой, гадаадаас импортлосон сайн үүлдрийг нутагшуулж, зохиомол хээлтүүлэгт ашиглах ажил ч хийгдэж байна. Нөгөөтэйгүүр бүс нутгаасаа шалтгаалаад мэдээлэл дутмаг, сайн үүлдэр омгийн мал авчирсан ч хяналт менежмент, технологи нь хангалтгүйгээс генетикийн нөөцийн ашиглалт хангалтгүй байна. Малчид малынхаа үүлдэр угсааг сайжруулж, сайн чанарын мал үржүүлсэн ч арчилгаа маллагааны зохистой менежмент хийж чадахгүй бол нөөци боломжоо бүрэн ашиглаж чадахгүй тул малчдад арчилгаа маллагааны талаар боловсрол мэдлэг олгодог байх шаардлагатай.

Малын үүлдэр угсааг сайжруулахын тулд аймаг бүрт ашиг шимтэй сайн үүлдрийн мал өсгөн үржүүлэх, сайн үүлдэр омгийн хөлдөөсөн үр ашиглах, үүлдэр угсааг сайжруулах тогтолцоог бий болгохыг зорино.

"4.2 Өсвөр малыг бордон тэжээх фермийг (хургыг оруулан) дэмжих төлөвлөгөө" Монгол Улсад малын тоо толгой 71 саяас давж, хонины тоо толгой ч олширч байгаа нь томоохон асуудал болж, малын хөлийн татвар, зуд, ган гачгийн улмаас малчдын сэтгэлгээ "мал бол өмч, статус бөгөөд урт хугацаанд тэжээж малладаг" гэсэн ойлголтоос "бүтээгдэхүүн, бараа" хэлбэрээр борлуулах сэтгэлгээ рүү өөрчлөгдөх шинж тэмдэг ажиглагдаж байна. Иймд хавар төрсөн эр хургыг тухайн жилийнхээ өвлөөс өмнө хөнгөлж, бойжуулан бордож, төхөөрөх үйлдвэр, боловсруулах үйлдвэрт худалдан борлуулснаар малчдын хөдөлмөр хэмнэх, маллагааны зардал буурах, малын хөлийн татвар багасах, бэлчээрийн даац хэтрэхгүй байх зэрэг үр ашигтайг хүлээн зөвшөөрч, тугал болон бусад төрлийн бага малыг бордон тэжээх ажлыг эхлүүлэхийг зорино.

"4.3 Зах зээлийн эрэлт хэрэгцээнд нийцсэн махны ангиллын шинэ стандарт нэвтрүүлэх, нэмүү өртөг шингээхийг дэмжих төлөвлөгөө". Үхэр, адуу, хонь, ямаанд Стандарт Хэмжил Зүйн Газраас тогтоосон махны үнэлгээний стандарт байдаг бөгөөд малын эмчийн шийдвэрээр гулууз махан дахь булчингийн хөгжил болон мах өөхний хэмжээнээс хамааран гурван зэрэглэлд ангилж, амьд малын биеийн хэмжээ хэмжээ, жингээр нь тохиролцож үнэ тогтоодог буюу эд эрхтэн, нас хүйснээс хамаарсан ялгаа төдийлэн байхгүй. Түүнчлэн сүүлийн үед хүн амын цусан дахь холестерины хэмжээ өндөр байгаа асуудал байнга яригдаж, малын мах голдуу хэрэглэх болсноор хэрэглэгчдийн хандлага таашаал өөрчлөгдөж ирсэн. Тиймээс хэрэглэгчдийн хандлага таашаалын өөрчлөлтөд тохируулан маханд зэрэглэл тогтоох шинэ стандартыг боловсруулж, шаардлагатай бол 5 түвшинд нарийвчлан зэрэглэж ангилдаг болохыг (илүү үнэ цэн шингээх) зорино. Зэрэглэл тогтоосноор компаниудын өөрсдийн брэндэд нэмүү өртөг шингээх үндэс болгон нэвтрүүлэх, түгээн дэлгэрүүлэх, яваандаа бусад малд адилхан хэрэгжүүлдэг болохыг зорино.

"4.4 Мал төхөөрөх үйлдвэр байгуулах төлөвлөгөө"-ний тухайд өнөөдрийн байдлаар Монгол улсын хэмжээнд 170 орчим хувийн хэвшлийн мал төхөөрөх газар, мах боловсруулах үйлдвэр үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд энэ тоо нэмэгдэх хандлагатай байна[105]. Хуульд эрүүл ахуйн шаардлага хангасан мал төхөөрөх газруудад нядалсан махыг зах зээлд нийлүүлэх ёстой гэж заасан ч нийт төхөөрөх 10 хүрэхгүй хувь нь албан ёсны сувгаар зах зээлд нийлүүлэгддэг байдалтай, зарим байгууламж нь хуучирч элэгдсэнээс болоод засвар, шинэчлэлт хийх шаардлагатай болсон байна. Иймээс мал төхөөрөх үйлдвэрүүдийг байгуулж (эсвэл засвар шинэчлэл хийж), баталгаажсан төхөөрөх газруудад эрүүл ахуйд нийцсэн тоног хэрэгсэлтэй орчинд эрүүл ахуйн шаардлага хангасан аргаар бэлтгэгдсэн, аюулгүй байдал хангагдсан махыг хэрэглэгчдэд тогтвортойгоор нийлүүлж, экспортыг дэмжих зорилготой юм.

"4.5 МАА-н болон дайвар бүтээгдэхүүнээр тэжээвэр амьтны хоолны үйлдвэрлэл бий болгох төлөвлөгөө" нь Монгол Улсын ашиглагддаггүй нөөцийн дунд ч ашиглалтын хувь маш бага

[105] МЭЕГ-с авсан мэдээлэл

байдаг малын дайвар бүтээгдэхүүн болон таван хошуу малын дотроос хэрэглээг нь нэмэгдүүлэх шаардлагатай хэдий ч хүнсэнд хэрэглэгдэх эрэлт бага байдаг ямааны махыг үр дүнтэй ашиглах боломж бий болгоход анхаарсан төлөвлөгөө юм. Өнөө үед гэрийн тэжээвэр амьтдын хоолны үйлдвэрлэл дэлхий даяар өсч байгаа нь уг төлөвлөгөөний ач холбогдлыг нэмэгдүүлж байна гэж хэлж болно. Монгол улсыг дэлхийн зах зээлд гэрийн тэжээвэр амьтдын хоолны түүхий эдийг нийлүүлэх шинэ бааз суурь болгохыг зорих юм.

Хамгийн сүүлийн **"4.6 Сүү цуглуулах тогтолцоог бэхжүүлэх замаар үйлдвэр цехэд хүлээн авах сүүний хэмжээг нэмэгдүүлэх төлөвлөгөө"** нь Монгол улсын хэмжээнд үйлдвэрт хүлээн авч буй сүүний хэмжээ туйлын бага байгааг нэмэгдүүлэх зорилготой. Хот суурин газрын хүн амын өсөлт маш өндөр байгаа бөгөөд энэ нь шаардлагатай хүнсний хангамжийн хэмжээ ч нэмэгдэж байна гэсэн үг юм. Үйлдвэрийн шугамаар хүлээн авдаг сүүний хэмжээ бага байгаагаас эрүүл ахуйн шаардлага хангасан, чанарын баталгаатай сүү хот суурин газарт хомсдолтой байдаг. Уг төлөвлөгөөгөөр ялангуяа хот суурин газарт аюулгүй сүүг хангалттай хэмжээгээр нийлүүлэх түгээхийг зорилго болгох юм.

(1) Малын үүлдэр угсааг сайжруулах тогтолцоо бий болгох төлөвлөгөө

YAT 4.1 : Малын үүлдэр угсааг сайжруулах тогтолцоо бий болгох	
Төлөвлөгөөний зорилго	Засгийн газрын 2022 оны 92 дугаар тогтоолоор батлагдсан малын үүлдэр, омгийг үржүүлэх бүс байршлыг тогтоох тухай журмын дагуу тухайн аймагт үржүүлж буй батлагдсан үүлдэр, омгийн малыг үндсэн сайжруулагчаар ашиглаж, төв сүргийн аж ахуй байгуулах. Гадаад дотоодын өндөр ашиг шимтэй цэвэр үүлдрийн малын арчилгаа маллагааг зохих технологийн дагуу явуулж, ашиг шимтэй үүлдрийн үрээр зохиомол хээлтүүлэг хийх зэргээр малын чанарыг сайжруулах тогтолцоог бүрдүүлэх.
Суурь түвшин	Байгаль орчин, цаг уурын онцлогт тохирсон малын үүлдэр омгийг аймаг орон нутагт үржүүлдэг ч малчин бүрт малдаа сайжруулагчаар ашиглах боломж бүрдээгүй байна. Бүс нутгаасаа (аймаг орон нутаг) хамааран шилмэл омог үүлдрийн малыг нутагшуулах болон зохиомол хээлтүүлэгт ашиглах хөлдөөсөн үрийг худалдаж авах мэдээлэл, санхүүгийн эх үүсвэр, тогтолцоо бүрдээгүй, шилмэл үүлдрийн малыг нутагшуулсан ч хяналт менежмент, технологи хангалтгүй, генетикийн нөөцийг сайн ашиглаж чаддаггүй. Тиймээс бүх аймгийн өнөөгийн нөхцөл байдлын судалгааг явуулж, аймаг бүрт малын үүлдэр угсааг сайжруулахад шаардлагатай асуудлуудыг тодорхойлж, малын үүлдэр омгийг сайжруулах үйлчилгээний тогтолцоог бий болгохыг зорино. Мөн үүнтэй уялдуулан зохиомол хээлтүүлгийн зоотехникч бэлтгэхэд дэмжлэг үзүүлнэ.
Төлөвлөгөөний зорилт	Малын шилмэл омог үүлдрийг нутагшуулан ашиглаж, 5 жилийн дараа аймгуудын 50%-д, 10 жилийн дараа бүх аймгуудад малын үүлдэр угсааг сайжруулах тогтолцоог бий болгож, Монгол Улсын хэмжээнд үүлдэр угсааг сайжруулах ажил эрчимжинэ. Мөн аймаг бүрт төрийн байгууллагатай гэрээ байгуулсан зохиомол хээлтүүлгийн техникч 2 хүн ажиллаж байгааг ойрын 10-н жилд 10 дахин нэмэгдүүлнэ.
Хамрах хүрээ	Жил бүр 2-3 аймагт нэвтрүүлж, 10 жилийн хугацаанд Монгол улсын бүх нутаг дэвсгэрт дэлгэрүүлнэ. Эхлээд одоогийн нөхцөл байдлын судалгаанд үндэслэн малын үүлдэр угсаа сайжруулахаар хийгдэж буй ажлын нөхцөл байдлыг харгалзан Төв, Дархан-Уул, Сэлэнгэ зэрэг зохиомол хээлтүүлгийн техникч олонтой, зохиомол хээлтүүлэг түгээмэл хийгддэг аймгуудаас жишиг болгон эхлүүлнэ. Мөн малын тоо толгой олонтой, мэдээлэл тоног төхөөрөмж дутагдалтай аймгуудаас эхлүүлээд, тодорхой хэмжээнд байгууламж тоног төхөөрөмж бүхий аймгуудад засвар, шинэчлэлт хийх хэлбэрээр хэрэгжүүлэх.
Хүлээх үр дүн	Малын үүлдэр угсааг сайжруулах ажил эрчимжиж, малын ашиг шим сайжирч, малчдын малаа өсгөн үржүүлэх менежмент ч сайжирна. Үүний зэрэгцээ экспортыг нэмэгдүүлэхэд хувь нэмэр оруулна.

Үйл ажиллагаа	(1) Аймаг тус бүрээр шаардлагатай дэмжлэгийг (нутагшуулах малын үүлдэр, техник, тоног төхөөрөмж, хүний нөөцийн хөгжил гэх мэт) тодорхойлох. 1) Төслийн баг бүрдүүлэх (ХХААХҮЯам, аймаг тус бүрийн ХААГ гэх мэт). 2) Үүлдэр угсааг сайжруулахтай холбоотой одоогийн нөхцөл байдлын судалгааг (эрэлт хэрэгцээний судалгааг хамруулаад) хийх (Малчид, мах үйлдвэрлэгчид, инженер технологичид, хоршоод гэх мэт). 3) Төлөвлөгөө боловсруулж, аймаг бүрт шаардлагатай дэмжлэгийг тодорхойлохын тулд холбогдох мэргэжилтнүүдийн хурал, уулзалтыг зохион байгуулах (ХХААХҮЯ, МЭЕГ, Аймгуудын ХААГ, хоршоод, бусад холбогдох байгууллагууд). (2) Малын үүлдэр угсааг сайжруулах ажилд шаардлагатай орчин нөхцлийг бүрдүүлэх 1) Менежментийн байгууламж, зохиомол хээлтүүлэг (боломжтой бол үр хөврөл шилжүүлэн суулгах) технологи, тоног төхөөрөмжийг нэвтрүүлэх. 2) Тухайн аймгийн инженерүүд шилмэл омог үүлдрийн мал (хээлтүүлэгч болон хээлтэгч) үржүүлгийн менежментийн аргад суралцах. (3) Хээлтүүлэгч мал болон зохиомол хээлтүүлэг зэрэг үйлчилгээний тогтолцоог бүрдүүлэх. (4) Аймгийн малын эмч, зоотехникчдэд зориулсан сургалт явуулах (зохиомол хээлтүүлэг, хээлтүүлсэн малыг өсгөн үржүүлэх менежментийн талаар сургалт явуулах ба сургалтын тоо, хамруулах сэдэв, ямар түвшний сургалт байх вэ гэдгийг одоогийн нөхцөл байдлын судалгаагаар тогтооно. Экспортын хувьд улс тус бүрийн стандардыг судлан, мэдээлэл өгнө). 1) Сургалтын тогтолцоог бий болгох. 2) Тогтмол сургалт явуулах. 3) Үйлдвэрлэгчдэд зориулсан сургалтын сургагч багш бэлтгэх. (5) Зохиомол хээлтүүлэг хийх мэргэжилтэн бэлтгэх сургалт явуулах багшийг сургах сургалт зохион байгуулах, оролцоог дэмжих. 1) Малын удмын сангийн үндэсний төвөөс хэрэгжүүлж буй зохиомол хээлтүүлэгийн сургалтын зохион байгуулах цар хүрээг тэлэх (оролцогчдын тоо болон зохион байгуулах тоог нэмэх). 2) Сургалтанд хамрагдсан хүн сургалтын дараа аймаг бүрт зохиомол хээлтүүлэгчээр ажиллах нөхцөлтэйгөөр сургалтанд оролцох төлбрийн хураамжийн татаас олгоно. (6) Үйлдвэрлэгчид малын үүлдэр угсааг сайжруулах ажлыг нэвтрүүлж, шилмэл мал гаргаж, үржүүлнэ. 1) Үйлвэрлэгчдэд сурталчилах гарын авлага зэрэг материал бэлдэж, малын үүлдэр угсааг сайжруулах ажлыг нэвтрүүлнэ. 2) Тухайн аймгийн зоотехникч гарган авсан үүлдэрийн малын өсгөн тэжээх аргыг зааж сургалт явуулна. 3) Малын ашиг шим сайжирч, борлуулах үнэ нэмэдэнэ. 4) Малчдын амьжиргаа дээшилснээр малаа өсгөн үржүүлэхийн утлд хөрөнгө оруулах боломжтой болно. 5) Өсгөн үржүүлэх менежмент сайжриснаар чанартай, өндөр ашиг шимтэй мал болон бүтээгдэхүүний (мах, сүү, ноос, арьс зэрэг) нийлүүлэлт тогтворжино. (7) Малын үүлдэр угсааг сайжруулах ажлын нөхцөл байдалд (захиргааны байгууллага, зоотехникчид, малчид үйлдвэрлэгчид) тогтмол хяналт тавьж, үнэлэлт дүгнэлт өгөх 1) Хяналт мониторингийн тогтолцоо бий болгох. 2) Холбогдох байгууллагуудын жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөнд хяналт мониторингийн ажлыг оруулах. 3) Хяналт мониторингийн үр дүнг холбогдох байгууллагуудтай хуваалцаж, мэдээллийн хуримтлал, эргэх холбоо үүсгэх.	
Санхүүжилт	<u>Засгийн газар</u> • Одоогийн нөхцөл байдлын судалгаа хийх • Хурлын зардал (мэргэжилтнүүд урих, мэдээлэл солилцох) • Гарын авлага боловсруулах зардал • Техникчдэд (менежер) зориулсан сургалт, болон сургалтын тогтолцоог бий болгох • Малчид үйлдвэрлэгчдэд зориулсан сургалт	<u>Хувийн хэвшил болон аймаг орон нутаг</u> (Зоотехникч) • Сургалтад хамрагдах зардал (томилолтын зардал) (Малчид, үйлдвэрлэгч)

	• Аймгууд болон малчдад сурталчлах, түгээх (үүлдэр угсааг сайжруулах талаар товхимол, сургалтын хэрэглэгдэхүүн гаргах гэх мэт) • Төслийн үр нөлөөг хянах моинторингийн зардал • Шилмэл үүлдрийн МАА-н тоног төхөөрөмж, зохиомол хээлтүүлэгт хэргэлэгдэх тоног төхөөрөмж худалдан авахад татаас олгох	• Сургалтад хамрагдах зардал (томилолтын зардал) • Шилмэл омог үүлдрийн хээлтүүлэгч мал болон зохиомол хээлтүүлэг хийхэд гарах зардал
Төслийн өртөг	Төслийн нийт өртөг: 51 тэрбум 483 сая төгрөг（19.758,000 USD）	
Ашиг, үр нөлөө	• Малын үүлдэр угсааг сайжруулж, өсгөн үржүүлэх менежментийг боловсронгуй болгох замаар удамшлын өндөр чадамжийг харуулах сургалт явуулж, малын эрүүл мэндийг сайжруулж чадвал сайн чанарын мал, малын гаралтай бүтээгдэхүүний (мах, сүү, үс, дэл, сүүл, арьс, шир) нийлүүлэлт тогтворжино. • Малын ашиг шим дээшилж, борлуулалтын үнэ нэмэгдэнэ. • Сайн чанарын МАА-н гаралтай бүтээгдэхүүнийг тогтвортой, хялбар нийлүүлэх боломжтой болж, нэмүү өртөг (бренд) бий болж, аюулгүй байдал, чанарыг баталгаажуулснаар экспортыг нэмэгдүүлэхэд хувь нэмэр оруулна. • Сайн чанарын малыг зах зээлд нийлүүлснээр малчдын борлуулалт тогтворжиж, амьжиргаа дээшилснээр аж ахуйгаа дээшлүүлэхэд хөрөнгө оруулалт хийх боломжтой болж, мах болон малын гаралтай бүтээгдэхүүний (сүү, ноос, арьс шир) чанар сайжирч, малын өвчлөл буурч, экспорт нэмэгдэнэ. • Зохиомол хээлтүүлгийг нэвтрүүлснээр үржилд ашиглагдаагүй төл, эр малыг зарж борлуулснаар хөдөлмөр хөнгөвчлөгдөж, зардал багасна. • Зохиомол хээлтүүлэг хийх техникч бэлтгэж чадвал ажлын байр бий болно. • Хивэгч малын тухайд үүлдэр угсааг сайжруулсанаар төл болон үржилд ашиглагдаагүй эр малыг борлуулж, Монгол Улсын хэмжээнд нийт малын тоо толгой буурвал, хивэгч малын хэхрэлтээс үүсэх хүлэмжийн хийн ялгаралт буурна.	
Бодлогын бичиг баримттай уялдсан байдал	1. Алсын хараа 2050 3.1.1 ХАА-н бүтээгдэхүүний түүхий эд, бүтээгдэхүүний чанарыг сайжруулна 2. Алсын хараа 2050 6. Ногоон хөгжлийн зорилт 6.1 Байгалийн үнэ цэн, өгөөжийг үнэлэн хамгаалж, анхдагч экосистемийн тэнцвэрт байдлыг хадгална. 3. Хүнс, хөдөө аж ахуйн талаар баримтлах үндэсний бодлого (2015-2025) Өртгийн сүлжээгээр бүтээгдэхүүн хөгжүүлэн, өрсөлдөх чадварыг бэхжүүлнэ (бүтээмжийг сайжруулна). 4. Монгол Улсын Их Хурлын 36 дугаар тогтоол.	
Төслийг хэрэгжүүлэхдээ анхаарах зүйлс	• Зардал, ажиллах хүч шаардагдах тул тогтвортой үргэлжлүүлэх боломжтой юу? (Хээлтүүлэгч болон хөлдөөсөн үрийн менежмент, хадгалалт, шингэн азотын зардал гм) • Удамшлын чадавхийг бүрэн хадгалахын тулд монголын нөхцөлд зохицсон үүлдрийг нутагшуулж, идэш тэжээл зэрэг маллагааны менежментийг сайтар зохицуулах. • Үүлдэр угсааг сайжруулах шаардлагатай ч нөгөө талаар монгол орны нөхцөлд зохицсон унаган үүлдэр угсааг удам зүйн нөөц болгон хадгалж авч үлдэх нь чухал.	

Төслийг хэрэгжүүлэх хуваарь, төсөв

Үйл ажиллагаа	2025	2026	2027	2028	2029	2030	2031	2032	2033	2034	Нийт
(1) Аймаг бүрт шаардлагатай дэмжлэгийг тодорхойлох.											
(2) Малын үүлдэр угсааг сайжруулахад шаардлагатай орчныг бүрдүүлэх.											
(3) Аймгуудын малын эмч, техникчдийн сургалт											
(4) Зохиомол хээлтүүлэг хийх техникч бэлтгэх сургалт зохион											

байгуулах, оролцоог дэмжих.												
(5) Үйлдвэрлэл эрхлэгчид малын үүлдэр угсааг сайжруулах тогтолцоог нэвтрүүлж, шилмэл үүлдрийн мал үржүүлж өсгөх (сурталчлах).												
(6) Малын үүлдэр угсааг сайжруулах ажлын явцын тогтмол хяналт, үнэлгээ.												
Төслийн өртөг,	сая төгрөг	5,371	5,168	5,168	5,168	5,168	5,168	5,168	5,168	5,168	5,191	51,906
	мян. ам.дол	2,046	1,967	1,967	1,967	1,967	1,967	1,967	1,967	1,967	1,976	19,758

Тэмдэглэл: Монгол болон Японы малын үүлдэр сайжруулахтай холбоотой нөхцөл байдал

ХХААХҮЯ-ны Малын удмын сангийн үндэсний төвд дотоодын малын генетик нөөцийг хамгаалах, хадгалах, гадаадаас үхэр, хонины хөлдөөсөн үр авч зохиомол хээлтүүлэг хийх замаар үүлдэр угсааг сайжруулах ажлыг хийдэг.

Японд мөн адил Малын үүлдэр сайжруулах төв, Мал үржүүлгийн байгууллагууд зэрэг малыг өсгөн үргүүлэх, генетик нөөцийг хамгаалах, маллагааны менежментийн арга техникийг боловсронгуй болгох байгууллагууд байдаг бөгөөд, дотоодын генетикийн нөөцийг хамгаалах, хадгалах, шилмэл үүлдрийг өсгөн үржүүлэх, хөлдөөсөн үр болон үр тогтсон эс нийлүүлэх зэрэг үйл ажиллагаа явуулдаг. Түүнчлэн Японд "Малын үүлдэр сайжруулах, өсгөн үржүүлэх тухай хууль" байдаг бөгөөд уг хууль нь мал сүргийг системтэйгээр сайжруулах, өсгөн үржүүлэх арга хэмжээ, хээлтүүлэгч малыг баталгаажуулах, малыг бүртгэх тогтолцоо, малыг зохиомол хээлтүүлэг, үр тогтсон эс шилжүүлэн суулгах зэргийг зохицуулсан заалтуудтай, малын үүлдэр угсааг сайжруулах, өсгөн үржүүлэх ажлыг дэмжих, мал аж ахуйг хөгжүүлэх, газар тариалангийн менежментийг сайжруулах зорилготой. Японд үүлдэр угсааг сайжруулах ажлыг үр дүнтэй болгохын тулд үхрийг 99%-с дээш зохиомол хээлтүүлэг хийх болон үр тогтсон эс шилжүүлэн суулгах аргаар үржүүлдэг. Зохиомол хээлтүүлэгийг мал аж ахуй эрхлэгчид өөрсдөө хийх тохиолдол байдаг ч хувийн хэвшил, хоршоодод харьяалалтай лицензтэй малын эмч, малын зохиомол хээлтүүлгийн техникч нар хийдэг. Монголын Махны Холбооны мэдээгээр Монгол малын гулуузны гарц хонь 47%, үхэр 49-50%, адуу 51-52% бол, Японд гулуузны гарц үхэр: 57%, адуу: 57.3-66.8%, хонь: 47%-52.2% байдаг байна.

Бухнаас үр авч байгаа нь **Зохиомол хээлтүүлэг хийж байгаа нь**

(2) Өсвөр мал бордох ферм (хургыг оруулан) нэвтрүүлэх ажлыг дэмжих төлөвлөгөө

ҮАТ 4.2 : Өсвөр мал бордох фермийн бизнесийг эрчимжүүлэх төлөвлөгөө	
Төлөвлөгөөний зорилго	Хонины хувьд, хавар төрсөн эр хургыг тухайн жилийн өвлөөс өмнө хөнгөлж, бойжуулж, бордож, төхөөрөх газар болон мах боловсруулах үйлдвэрт зарж борлуулна. Үхэр болон бусад малыг ч мөн өсвөр насанд нь бордож өсгөх эхлэл болно.
Суурь түвшин	Эр хургыг нэг нас хүрэхээс өмнө борлуулах маллагааны аргыг нэвтрүүлнэ.
Төлөвлөгөөний зорилт	2021 онд Монгол улсын хонины махны экспорт 500 орчим тн байсан бол 5 жилийн дотор хурганы махны экспорт 50,000 тн, 10 жилийн дараа 10 дахин нэмэгдэж

	(1200,000 толгой) 18 мянган тн хурганы мах экспортод гаргана.	
Хамрах хүрээ	Нийслэлтэй зэргэлдээ орших, махны чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг олон үйлдвэр компаниудтай Төв аймгаас эхлээд Хөвсгөл, Хэнтий, Дорноговь, Баян-Өлгий зэрэг мал ихтэй, бэлчээрийн доройтол асуудал болж байгаа бүс нутаг, малын тэжээл, газар тариалангийн дайвар бүтээгдэхүүний боломж өндөртэй газар тариалангийн бүстэй зэрэгцэн орших аймгуудад нэвтрүүлэх замаар цаашлаад улсын хэмжээнд хэрэгжүүлнэ.	
Хүлээх үр дүн	Эр хургыг хурдан зарж борлуулснаар малчдын хөдөлмөр, идэш тэжээлийн зардал, малын хөлийн татвар багасч, бэлчээрийн доройтол буурна. Боловсруулах үйлдвэр зэрэг махны чиглэлийн аж ахуйн нэгжүүдэд махны татан авалт баталгаажуулалт илүү хялбар болж, ажиллах хүч, тээврийн зардал гэх мэт зардлууд багасна. Түүнчлэн махны нэмүү өртөг нэмэгдэх, малын борлуулалтын үнэ өсч, малчдын маллагааны менежмент сайжирна.	
Үйл ажиллагаа	(1) Малчид нэг нас хүрээгүй эр хургаа зарж борлуулна. Мөн малчдын хоршоод малчдаас эр хургыг худалдан авч, гэрээгээр худалдан борлуулах ажлыг нэвтрүүлнэ. 1) Төслийн багийг бүрдүүлнэ (ХХААХҮЯам, Аймгуудын ХХААГ). 2) Эрэлтийг (өнөөгийн нөхцөл байдлын судалгааг мөн хамруулна) судлана (Малчид үйлдвэрлэгчид, хоршоод, төхөөрөх газрууд, боловсруулах үйлдвэрүүд зэрэг). 3) Төлөвлөгөө боловсруулах, ангилан ялгах стандарт боловсруулах мэргэжилтнүүдийн уулзалт хурал зохион байгуулах (ХХААХҮЯ, МЭЕГ, Аймгуудын ХХААГ, Хоршоод болон Махны Холбоо зэрэг холбогдох бусад байгууллагууд). (2) Малчид, хоршоод зэрэг хэрэгжүүлэх хүмүүст зориулсан сургалт зохион байгуулна (маллагааны менежментийн арга зүй гэх мэт зохион байгуулах сургалтын тоо, хамруулах сэдэв, сургалтын түвшин зэргийг өнөөгийн нөхцөл байдлын судалгааны үр дүнд үндэслэн шийдвэрлэнэ. Экспортын хувьд улс орон тус бүрийн стандарт болон хэрэгцээг судлаж мэдээллэнэ). 1) Малчид болон хоршоод гэх мэт хэрэгжүүлэх (оролцох) хүмүүсийг бүртгэх. 2) Сургалтыг зохион байгуулах багшийг бэлтгэх эсвэл шалгаруулах. 3) Өсвөр малыг бордох гарын авлага хийх, сургалт зохион байгуулах. 4) Малчид тогтвортой худалдан авагчтай болох борлуулалтын сувгийг хөгжүүлэх. 5) Маллагааны менежментийг сайжруулснаар чанар сайтай хурганы мах болон бусад бүтээгдэхүүнийг (сүү, ноос, арьс зэрэг) тогтвортой нийлүүлдэг болох. (3) Махны чиглэлийн үйлдвэр ААН, хэрэглэгчдэд сурталчлах, түгээх. 1) Сурталчилгааны зорилгоор товхимол болон бусад материал бэлтгэх. 2) Нэмүү өртөг шингэж, брэнд бий болж хурганы махны борлуулалтын үнэ өснө. 3) Малчдын амьжиргаа дээшилснээр маллагааны менежментэд хөрөнгө оруулалт хийх боломжтой болно. (4) Маллагааны менежментийн арга болон эр хурганы борлуулагдах үнийг тогтмол мониторинг үнэлгээ хийх. 1) Хяналт мониторингийн тогтолцоо бий болгох. 2) Холбогдох байгууллагуудын жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөнд хяналт мониторингийн ажлыг оруулах. 3) Хяналт мониторингийн үр дүнг холбогдох байгууллагуудтай хуваалцаж, мэдээллийн хуримтлал, эргэх холбоо үүсгэх.	
Санхүүжилт	<u>Засгийн газар</u> • Эрэлт хэрэгцээг судлах • Төлөвлөгөө боловсруулахтай холбоотой ажил хэргийн зардал • Хурал уулзалтын зардал (Хоршоодод түгээх, хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх, худалдан авагч судлах, шийдэх) • Оролцогчдыг сургах, хэрэгжүүлэх тогтолцоог бүрдүүлэх	<u>Хувийн хэвшил</u> (Махны чиглэлийн компаниуд) • Мал худалдан авахтай холбоотой зардал (тээврийн зардал гэх мэт) • Хурал уулзалтад оролцох зардал, замын зардал) (Хоршоод) • Бойжуулах фермийн тоног төхөөрөмж • Удирдлагын зардал (менежер, эм бэлдмэл, тэжээл гэх мэт)

	• Малчид үйлдвэрлэгчид болон хэрэглэгчдэд сурталчлах түгээх (товхимол, сургалтын хэрэглэгдэхүүн гаргах гэх мэт) • Төслийн үр ашгийн хяналт мониторингийн зардал	• Сургалтанд оролцох зардал (сургалтын төлбөр, замын зардал)
Төслийн өртөг	Төслийн нийт өртөг: 1 тэрбум 506 сая төгрөг (573,000 ам. доллар)	
Ашиг, үр нөлөө	• Махны чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгж болон хэрэглэгчдэд өргөн танигдаж, эр хурганы үнэд нэмүү өртөг шингээн, брэнд болгосноор, хурганы мах брэнд болж, борлуулалтын үнэ өснө. • Сургалт нь малчин ард түмний маллагааны менежментийг сайжруулж, малын эрүүл мэндийг сайжруулбал, тогтвортой, өндөр чанарын хурганы мах болон бусад бүтээгдэхүүн (арьс шир, ноос, г.м.)-ийг үйлдвэрлэх, хангах нь хялбар, боломжийн болж, аж ахуйн нэгжүүдийн ажиллах хүч, тээврийн зардал зэрэг зардал бууруулахад нөлөөлнө. • Аюулгүй байдал, чанар нь баталгаажсанаар экспортыг нэмэгдүүлэхэд хувь нэмэр оруулна. • Малчдийн хувьд тогтвортой худалдан авагчид бий болж, малын хөлийн татварыг хэмнэн, борлуулалт хийснээр мал маллахад шаардлагатай ажиллах хүчийг хэмнэнэ. Мөн, тэжээлийн зардлыг бууруулах замаар бэлчээрийн доройтлыг хянаж, амьжиргаагаа сайжруулан, маллагааны менежментэд шаардлагатай хөрөнгө оруулалтыг бий болгосоноор, мах, малын гаралтай бүтээгдэхүүн (сүү, дэл, сүүл, ноос, арьс шир гэх мэт)-ий чанар сайжирч, өвчлөл буурах ба экспорт нэмэгдэх ач холбогдолтой. • 8-10 сартай гулууз мах 15 кг ба түүнээс дээш (гол төлөв 12 кг, 15 кг байх нь Ираны худалдан авагчдын шаардлага. Зах зээл дээр үнэ хэлбэлздэг тул жинг гол үзүүлэлт болгож үздэг). • МАА-н хөгжил нь хөдөөгийн хөгжилтэй нягт уялдаатай бөгөөд өсвөр малыг бордох үйл ажиллагааны хэрэгжилт нэмэгдэж, хөдөө орон нутагт ажлын байр бий болбол, үр дүн нь хөдөлмөр эрхлэлтийг дэмжихэд ч хувь нэмэр оруулна. Мөн орон нутгийн үйлдвэрлэл хөгжвөл нийслэл дэхь хүн амын төвлөрлийг хянах боломжтой болно. • Хивэгч малын өсвөр эр төлийг борлуусанаар экспортын хэмжээ нэмэгдэж, Монгол улсын хэмжээнд малын тоо толгой цөөрвөл, хивэгч малын хэхрэлтээс үүдэлтэй хүлэмжийн хийн ялгаруулалт ч мөн буурна.	
Бодлогын бичиг баримттай уялдсан байдал	1. Алсын хараа 2050 2. Хүнд ээлтэй амьдрах орчин, зорилт 2.5 Амьдралын хэрэгцээ хангасан эрүүл, ая тухтай, таатай орчин бүрдүүлж, баталгаат хүнсээр хангана. 2. Алсын хараа 2050 4.2.6. Малыг эрүүлжүүлэх ажлыг эрчимжүүлэх замаар хүн амын хүнсний аюулгүй байдлыг хангаж, хүнсний бүтээгдэхүүний экспортын хэмжээг нэмэгдүүлнэ. 3. Алсын хараа 2050 6.2.8. Хөрс хамгаалах, газрын доройтлыг бууруулах, цөлжилттэй тэмцэх үндэсний хөтөлбөр хэрэгжүүлнэ. 4. Алсын хараа 2050 4. Эдийн засгийн тэргүүлэх чиглэлүүд, 4.2 Эдийн засгийн тэргүүлэх салбаруудыг хөгжүүлж, экспортын баримжаатай эдийн засгийг бий болгоно. 5. Алсын хараа 2050 6. Ногоон хөгжил, зорилт 6.1 Байгалийн үнэ цэн, өгөөжийг үнэлэн хамгаалж, анхдагч экосистемийн тэнцвэрт байдлыг хадгална. 6. Хүнс, хөдөө аж ахуйн талаар баримтлах үндэсний бодлого (2015-2025 он) Хүн амыг шим тэжээллэг, аюулгүй хүнсээр хангах (дотоодод үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнээр тогтвортой хангах, шим тэжээллэг, органик хүнсний үйлдвэрлэлийг дэмжих). 7. Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр (2020-2024) 1.1.5 Экспортыг дэмжих санхүүгийн шийдлүүдийг боловсруулж, экспортод гаргах бараа, бүтээгдэхүүний хэмжээг нэмэгдүүлнэ. 8. Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр (2020-2024) 3.3.12 ХААн тээвэр, борлуулалтын логистикийн сүлжээг байгуулж, хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний бэлтгэн нийлүүлэлтийн чанарын хяналт, баталгаажуулалтын оновчтой тогтолцоог бүрдүүлнэ.	

	9. Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр (2020-2024 он) 4.5.2 Эдийн засгийн гадаад харилцаанд тэргүүлэх ач холбогдол өгч, төр, хувийн хэвшлийн түншлэлд тулгуурлан экспортыг нэмэгдүүлэх, төрөлжүүлэх, гадаад худалдаанд тулгарч байгаа хүндрэлүүдийг багасгах, хөнгөвчлөх бодлогыг үргэлжлүүлнэ.
Төслийг хэрэгжүүлэхэд анхаарах зүйлс	• Ашиг орлого болон бусад хүчин зүйлийг тооцож үзэхэд, үйлдвэрлэгчид, хоршоод, компаниуд сэтгэл хангалуун байх үр дүнд хүрч чадах эсэх. • Зардал болон хөдөлмөр шаарддаг, мөн дараагийн борлуулалтын цэгийг баталгаажуулах шаардлагатай байдаг тул тус үйл ажиллагааг тасралтгүй хэрэгжүүлэх боломжтой эсэх.

Төслийг хэрэгжүүлэх хуваарь, төсөв

Үйл ажиллагаа		2025	2026	2027	2028	2029	2030	2031	2032	2033	2034	Нийт
(1) Малчид нэг нас хүрээгүй эр хургаа зарж борлуулна. Малчдын хоршоод малчдаас эр хургыг худалдан авч, гэрээгээр худалдан борлуулах ажлыг нэвтрүүлэх.												
(2) Малчид, хоршоод гэх мэт хэрэгжүүлэгчдэд зориулсан сургалт зохион байгуулах.												
(3) Махны чиглэлийн үйлвэр аж ахуйн газрууд болон хэрэглэгчдэд сурталчлах, түгээх.												
(4) Маллагааны арга болон эр хурганы борлуулалтын үнэд тогтмол мониторинг үнэлгээ хийх.												
Төслийн өртөг	сая төгрөг	331	128	128	128	128	128	128	128	128	151	1,506
	мян. ам.дол	124	49	49	49	49	49	49	49	49	57	573

Тэмдэглэл: Монголын хонины махан ашиг шимийг нэмэгдүүлэх жишээ

Жишээ 1: ТББ-ын жишээ

"Чинээлэг малчин бойжуулах төв" ТББ нь "Мон Эко Лэмб" ХХКомпанитай хамтран малчдад эр хурганы махан ашиг шимийг хэрхэн нэмэгдүүлж, зах зээлд гаргах талаар мэдлэг түгээх зорилгоор маллагааны менежментийн сургалт зохион байгуулж байна. Энэхүү төл мал бордох загварт өвөл төрсөн эр хургыг малчид өөрсдөө кастраци хийн, бордон, бойжуулж, тухайн жилийн намар нядалж зардаг. Монголын улсын ХААИС-тай хамтран хурганд зориулсан тэжээл гаргаж авсан ба уг тэжээлээр бордсон 1 настай хургыг 2 настай төлөгтэй дүйцэхүйц үнээр борлуулах боломж бүрдсэн. Борлуулсан хурга нь Баянцагаан үүлдрийх байсан ба 9-10 сартай гулууз мах нь 16.5-20 кг хүрсэн. Энгийн хурга ойролцоогоор 12 кг жинтэй байдагтай харьцуулбал нилээд тарга авсан нь илт байна.

Сургалтанд ашиглах гарын авлага

Энэхүү эр хурга бордох загварыг хэрэгжүүлэхэд тулгамдсан асуудал нь малчдын сэтгэлгээг өөрчлөх байсан ба малчид малаа удаан хугацаанд өмчлөн өсгөж, өтлөхөөс нааш зардаггүй. Гэхдээ эр хурганы борлуулалтын үнэ өндөр байвал мачдад зарах сэдэл төрнө. Мөн үржүүлгийн ажил нь богино хугацаанд явагддаг тул зардал багасч, эдийн засгийн үр ашиг өснө. Хурганы махны зах зээлийн үнэ өндөр, дотоодын зах зээл том биш учраас сайн чанарын махыг ихээр үйлдвэрлэн, экспортлохыг зорьж байна. Тус ТББ нь аль болох бордсон төлийг худалдан авч, "Монгол хурга" ресторанд нийүүлэн, бүтээгдэхүүн хөгжүүлэлт ч мөн хийдэг. Бусдыг нь малчид бие

даан зардаг. Эр хурга бордох нь малчдийн сэтгэлгээг өөрчлөх эхний алхам ба цаашдаа ямаа, үхэр, адуу зэрэг бусад малын төлийг ч мөн бордох боломжийн талаар судлах болно.

Жишээ 2: Хоршооны жишээ

Энэ нь Төв аймгийн 4-н сумын хоршоо нэгдэн, малчдаас 6 сартай нэг эр хургыг 60,000 төгрөгөөр, нийт 600 орчим толгойг худалдан авч, хоршооноос бөөнд нь кастраци хийн, 11-р сар хүртэл бэлчээрийн болон бордох аргаар бордон таргалуулж, төхөөрөх газарт нэгийг нь 85,000 төгрөгөөр зарах арга юм. Тус хоршоо нь МАШ МАХ ХХК-ын хөгжүүлсэн, зүсэлт хийлгүйгээр, зөвхөн үрийн сувгийн судасжилтыг цахилгаан соронзон долгионоор төөнөн боож, кастраци хийх аргыг ашигладаг. Энэ аргыг ашигласан, мөн бэлчээр сайн байсан нь нөлөөлөн, өсөлт сайтай, бие томтой, 10 сартай эр хурганы гулууз мах 17-20 кг болж, энгийн кастрацийн аргаар 1 эр хургыг 12-18 сар бойжуулсантай ойролцоо үр дүнд хүрсэн.

Эхэндээ Иранруу экспорт хийж байсан ч кастраци хийгээгүй (төмсөгтэй) хонины гулууз мах 15 кг ба түүнээс дээш жинтэй байна гэсэн стандарт тавьсан, өөрөөр хэлбэл, төмсөгтэй л бол үржих боломжгүй байсан ч болно гэсэн үг ба энэ нь МАШ МАХ компаний аргатай нийцэж байна. Тодорхой хэмжээгээр ашиг олж, бусад малд ч мөн хэрэглэх боломж байгаа тул загвар болгон үргэлжлүүлэх хүсэлтэй байгаа хэдий ч хэрэгжиж эхэлснээс хойш хоёр жилийн дараа COVID-19 цар тахал болон, 2 орны мөргөлдөөн гарсаны улмаас борлуулалт хийх боломжгүй болж, одоогоор зогссон байдалтай байна.

Кастрацийн технологийг боловсруулсан "МАШ МАХ" компани нь зөвхөн хонь төдийгүй үхэрт төл бордох аргыг туршилтын журмаар хэрэгжүүлж байгаа ба үхэрний хувьд 2 настай бяруу 3 настай шүдлэн үхрийн дайтай том болсон. Мөн 7-8 сартайд нь нядалсан хурга болон 18 сартайд нь нядалсан үхрийн маханд шинжилгээ хийж үзэхэд булчин чангараагүй, уургийн агууламж хэвийн нь 18% байдагаас 23-24%-д хүрч нэмэгдсэн байсан.

Кастраци хийхээр ялгасан хурга

Кастрацийн шинэ арга

Өсвөр үхэр бордох ферм

Дээрх хоёр жишээн дээр эр хургыг нийлмэл тэжээлээр бордон, кастрациын шинэ аргаар хөнгөлөн жин нэмүүлж, ердийнхөөс илүү тарга сайтай гулууз мах гаргасан. Түүнчлэн эр хургыг өвлөөс урьтаж зардаг тул өвөл, зуданд нэрвэгдэх эрсдэлгүй. Харин дээрх 2 жишээний аль алинд нь тогтвортой борлуулалтын цэгийг бий болгох зайлшгүй шаардлага байна.

(3) Махны ангиллын шинэ стандарт нэвтрүүлэх төлөвлөгөө

ҮАТ 4-3: Махны ангиллын шинэ стандарт нэвтрүүлэх төлөвлөгөө	
Төлөвлөгөөний зорилго	Үхрийн махны ангиллын шинэ стандартыг бий болгож, уг стандардыг компани тус бүрийн брэндэд нэмүү өртөг шингээх үндэслэл болгон нэвтрүүлж, түгээнэ. Үүнийг бусад малын мах бэлтгэлд ч мөн тохируулан нэвтрүүлнэ.
Суурь түвшин	Сүүлийн жилүүдэд Монголын хэрэглэгчдийн махны сонголт өөрчлөгдөж байгаа хэдий ч үхрийн махыг зэрэглэх шинэ стандарт байхгүй байна.
Төлөвлөгөөний зорилт	Үхрийн махыг ангилах шинэ зэрэглэл тогтоож, батлан, мах махан бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг аж ахуйн нэгжүүдэд нэвтрүүлнэ.
Хамрах хүрээ	Орон даяар
Хүлээх үр дүн	Үхрийн махны шинэ зэрэглэл тогтоож, батлуулан, мах махан бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг аж ахуйн нэгжүүдэд махыг брэнд болгох үндэслэл болгон нэвтрүүлж, түгээнэ. Түүнчлэн хэрэглэгчдэд өргөн танигдаж, махны аюулгүй, тогтвортой нийлүүлэлтэд хувь нэмэр оруулах, махны үнэ цэнийг нэмэгдүүлэх, малын

	борлуулалтын үнийг өсгөх, малчдийн мал маллагааны менежментийг сайжруулахад чухал ач холбогдолтой юм. Үүний зэрэгцээ махны экспорт ч нэмэгдэнэ.	
Үйл ажиллагаа	(1) Махны зэрэглэлийн шинэ стандартыг тодорхойлох. 1) Төслийн баг бүрдүүлнэ (ХХААХҮЯ, МХЕГ, Махны холбоо гэх мэт холбогдох байгууллагууд). 2) Малчид, төхөөрөх үйлдвэрүүд, боловсруулах үйлдвэрүүд зэрэг ААН, жижиглэн худалдаачид, хэрэглэгчид гэх мэт нэмүү өртгийн сүлжээнд оролцогч талуудын эрэлт хэрэгцээний судалгааг хийх. (экспортын хувьд улс орон тус бүрийн стандарт, хэрэгцээний судалгааг мөн хийх). 3) Төлөвлөгөө боловсруулах, үнэлгээний стандартыг бий болгох шинжээчдийн зөвлөл байгуулж, зохион байгуулна (ХХААХҮЯ, МХЕГ, MASM болон Монголын махны холбоо зэрэг бусад холбогдох байгууллагууд). 4) Махны зэрэглэлийн шинэ стандарт бий болно. (2) Зэрэглэлийн үнэлгээ хийх малын эмч нарт зориулсан сургалт явуулах (сургалтын тоо, агуулгыг шинэ зэрэглэлийн стандартын агуулгыг харгалзан тогтооно. Мөн экспортын талаарх улс орон тус бүрийн стандарт, хэрэгцээний талаар мэдээлэл өгнө). 1) Сургагч багш нарыг сургах эсвэл сонгон шалгаруулж, аж ахуйн нэгжүүдэд зориулсан сургалтын тогтолцоог бий болгох. 2) Сургалтын гарын авлага бэлтгэж, сургалт зохион байгуулах. 3) Тогтмол сургалт явуулах. 4) Ангиллын шинэ стандартын үнэлгээний аргыг нэгдмэл болгох зорилгоор сургалтыг тогтмол зохион байгуулж, үнэлгээ хийх мэргэжилтнүүдийг (малын эмч) оролцуулах. 5) Байгууллагын сургалтын багш нарыг сургах эсвэл сонгон шалгаруулах. (3) Мах махан бүтээгдэхүүн боловсруулах аж ахуйн нэгжүүдэд мах зэрэглэх шинэ стандардыг нэвтрүүлж, хүнсний маханд нэмүү өртөг шингээснээр брэнд болгох. 1) Шинэ ангилал нэвтрүүлэх. 2) Мах махан бүтээгдэхүүн боловсруулдаг аж ахуйн нэгжүүдэд сайн чанарын махны тогтвортой нийлүүлэгчдийг бий болгохын тулд борлуулалтын сувгийг хөгжүүлэх. 3) Чанартай мах, боловсруулсан махан бүтээгдэхүүнээр тогтвортой хангаж, экспортыг нэмэгдүүлэх. (4) Үнэлгээний шалгуурыг тогтмол хянаж, дүгнэх. 1) Хяналтын тогтолцоог бий болгох. 2) Хяналт шалгалтыг холбогдох байгууллагуудын жилийн ажлын төлөвлөгөөнд тусгах. 3) Мониторингийн үр дүнг холбогдох байгууллагуудын нэгдсэн мэдээлэлийн бааз үүсгэн цуглуулж, холбогдох этгээдэд эргэн мэдээллэх. (5) Хэрэглэгчдэд сурталчлах. 1) Сурталчилгааны материал бэлтгэх.	
Санхүүжилт	<u>Засгийн Газар</u> • Эрэлт хэрэгцээний судалгаа хийх • Төлөвлөгөө боловсруулах захиргааны зардал • Хурлын зардал (зэрэглэлийн шалгуурыг тодорхойлох) • Зэрэглэл хийх гарын авлага гаргах зардал • Зэрэглэлийг үнэлэх малын эмч нарт зориулсан сургалт ба хэрэгжилтийн тогтолцоог бий болгох • Үйлдвэрлэгч, хэрэглэгчдэд сурталчлах, түгээх (зэрэглэлийн талаарх товхимол, сургалтын хэрэглэгдэхүүн гаргах гэх мэт) • Төслийн үр ашгийн хяналт мониторингийн зардал	<u>Хувийн хэвшил</u> (Мах, махан бүтээгдэхүүн бэлтгэдэг аж ахуйн нэгжүүд) • Зэрэглэлийн шинэ стандард нэвтрүүлсэнээр мах, махан бүтээгдэхүүн үйлдвэрлэн, нийлүүлэх • Сургалтанд оролцох хураамж (сургалтын төлбөр, замын зардал) (Малын эмч) • Сургалтанд оролцох хураамж (сургалтын төлбөр, замын зардал)

Төслийн өртөг	Төслийн нийт өртөг: 2 тэрбум 76 сая төгрөг (790,000 ам. доллар)
Ашиг, үр нөлөө	• Махны ангиллын шинэ стандард боловсруулан, баталгаажуулж, мах бэлтгэн нийлүүлэгч ААН-үүдэд нэвтрүүлсэнээр, нэмүү өртөг шингэдэг болно. • Нэмүү өртөг шингээх ажил нэвтэрвэл, дундын зуучлагчдын (ченжүүдийн) зардаг махнаас ялгарах боломжтой болно. • Өндөр чанартай мах, малын гаралтай бүтээгдэхүүнийг тогтвортой, найдвартай ханган нийлүүлэх боломж хялбар болсоноор тогтвортой борлуулалтын цэгүүд бий болно. Энэ нь аж ахуйн нэгжүүдийн ажиллах хүч, тээврийн зардал зэрэг зардлыг бууруулж, хүнсний махны эрүүл ахуйн аюулгүй байдал болон чанарыг хангаж чадвал экспортод хувь нэмэр оруулах боломжтой болно. • Малчдын борлуулалтын суваг тогтворжвол, борлуулах малын тоо толгой нэмэгдэж, малын хөлийн татварыг хэмнэх, ажиллах хүч хэмнэх, тэжээлийн зардлыг бууруулах зэргээр бэлчээрийн доройтлыг бууруулахад үр дүнд гарч, а амьжиргаа сайжрана. Улмаар мал маллагааны хөрөнгө санхүүжилтийн боломж бий болно. Цаашлаад, малын эрүүл мэнд сайжирч мах, малын гаралтай бүтээгдэхүүний (сүү, үс ноос, арьс шир гэх мэт) чанар сайжирч, өвчлөл буурсанаар, экспорт нэмэгдэх боломжтой. • Махны ангиллын шинэ стандартыг 5 жилийн дараа гэхэд мах, махан бүтээгдэхүүн бэлтгэдэг ААН-үүдийн 50 хувьд, 10 жилийн дараа 100 хувьд нэвтрүүлнэ. • Хэрэглэгчид (импортлогч орнуудыг оруулаад) хямд үнэтэй бүтээгдэхүүн болон нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүнийг худалдан авах боломжтой болсоноор, сонголтын хүрээг тэлнэ. • Таалагдсан хэсгийг үнэлж дүгнэвэл, сайжруулах шаардлагатай хэсгүүд илүү тодорхой болж, үндэсний сайжруулах удирдамж болон сайжруулах зорилтыг тодорхойлоход хялбар болно. • Сайжруулах хэсгүүдийг тодорхойлсны дараа үйлдвэрлэгчийн маллагааны менежментийн зорилго, бодлого, менежментийн арга барилыг тодорхойлоход хялбар болно. • Тусгай тоног төхөөрөмж, хэрэгсэл, байгууламж шаардахгүй.
Бодлогын бичиг баримттай уялдсан байдал	1. Алсын хараа 2050 2. Хүнд ээлтэй амьдрах орчин, зорилт 2.5 Амьдралын хэрэгцээ хангасан эрүүл, ая тухтай, таатай орчин бүрдүүлж, баталгаат хүнсээр хангана. 2. Алсын хараа 2050 4.2.6. Малыг эрүүлжүүлэх ажлыг эрчимжүүлэх замаар хүн амын хүнсний аюулгүй байдлыг хангаж, хүнсний бүтээгдэхүүний экспортын хэмжээг нэмэгдүүлнэ. 3. Алсын хараа 2050 6.2.8. Хөрс хамгаалах, газрын доройтлыг бууруулах, цөлжилттэй тэмцэх үндэсний хөтөлбөр хэрэгжүүлнэ. 4. Алсын хараа 2050 4. Эдийн засгийн тэргүүлэх чиглэлүүд, 4.2 Эдийн засгийн тэргүүлэх салбаруудыг хөгжүүлж, экспортын баримжаатай эдийн засгийг бий болгоно. 5. Алсын хараа 2050 6. Ногоон хөгжил, зорилт 6.1 Байгалийн үнэ цэн, өгөөжийг үнэлэн хамгаалж, анхдагч экосистемийн тэнцвэрт байдлыг хадгална. 6. Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр (2020-2024) 1.1.5 Экспортыг дэмжих санхүүгийн шийдлүүдийг боловсруулж, экспортод гаргах бараа, бүтээгдэхүүний хэмжээг нэмэгдүүлнэ. 7. Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр (2020-2024) 3.3.12 ХААн тээвэр, борлуулалтын логистикийн сүлжээг байгуулж, хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний бэлтгэн нийлүүлэлтийн чанарын хяналт, баталгаажуулалтын оновчтой тогтолцоог бүрдүүлнэ. 8. Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр (2020-2024 он) 4.5.2 Эдийн засгийн гадаад харилцаанд тэргүүлэх ач холбогдол өгч, төр, хувийн хэвшлийн түншлэлд тулгуурлан экспортыг нэмэгдүүлэх, төрөлжүүлэх, гадаад худалдаанд тулгарч байгаа хүндрэлүүдийг багасгах, хөнгөвчлөх бодлогыг үргэлжлүүлнэ.
Төслийг хэрэгжүүлэхэд анхаарах зүйлс	• Зардал, ажиллах хүч нэмэгдэх тул одоо байгаа махны брэнд компаниуд саадгүй нэвтрүүлэх боломжтой эсэх. • Уламжлалт арга барилаар ажилладаг, эрүүл ахуйн менежментийг мөрддөггүй мал төхөөрөх газар, худалдаачин, зуучлагч нарын эсэргүүцэлтэй тулгарах эсэх.

Төслийг хэрэгжүүлэх хуваарь, төсөв

Үйл ажиллагаа		2025	2026	2027	2028	2029	2030	2031	2032	2033	2034	Нийт
(1) Махны ангиллын шинэ стандарт боловсруулах.												
(2) Ангиллын үнэлгээ хийх малын эмч нарт (ангиллын үнэлгээ хийх мэргэжилтнүүд) сургалт явуулах.												
(3) Махны чиглэлийн ААН-үүдэд махны ангиллын шинэ стандарт нэвтрүүлж, махны брэнд үүсгэх зэргээр нэмүү өртөг шингэх												
(4) Үнэлгээний шалгуурыг тогтмол хянаж, дүгнэх.												
(5) Хэрэглэгчдэд зориулсан суталчилгаа явуулах												
Төслийн өртөг,	сая төгрөг	388	185	185	185	185	185	185	185	185	208	2,076
	мян.ам.дол	151	70	70	70	70	70	70	70	70	79	790

Тэмдэглэл: Японд маханд зэрэглэл тогтоодог жишээ.

Япон дахь махны зэрэглэл тогтоох ажил нь “Гулууз махны түгээлт нийлүүлэлтийн жишиг тогтоож, үйлдвэрлэгч ба худалдан авагчийн хооронд гулууз махны чанарыг бодитойгоор үнэлэн тодорхойлж, арилжааны шудрага байдлыг хангах” зорилготой.

Жишээ 1: Үхрийн махыг ангилах жишээ.

Япон дахь махны арилжаа нь үндсэндээ гулууз хэлбэрээр улсын хэмжээний 200 гаруй махны бөөний худалдааны зах ба махны төвөөр дамжин явагдах бөгөөд махны үнэ нь фермерийн аж ахуй ба нийлүүлэгч ААН-үүдийн хувьд чухал ач холбогдолтой бөгөөд махны үнийг шудрагаар тогтоох шаардлагын үүднээс улсын хэмжээний гулууз ба өрөөл махны арилжааны стандартыг үндэслэн төвийг сахисан байрь сууринаас гулууз мах тус бүрээр нь (чанарын үнэлгээ хийж) зэрэглэл тогтоодог. Зэрэглэл тогтоох ажлын үр дүн нь фермерийн аж ахуйн хувьд бүтээгдхүүний чанартай холбоотой чухал мэдээлэл болох тул үүнийг үндэслэн хэлтүүлэгт оруулах эм үхэр ба бухыг (үр) сонгох, тэжээлийн менежментийг сайжруулах арга хэмжээ авах боломжтой болно.Бас малын үржил селекцийн байгуулга улсын хэмжээний махны зэрэглэл тогтоох ажлын үр дүнг үндэслэн сайн үүлдрийн үнээ, бухны үржил селекцийн ажил явуулдаг. Ийнхүү махны зэрэглэл тогтоох ажил нь фермерийн АА-ийн менежментийг сайжруулах үржил селекцийн ажил явуулахад ихээхэн ач холбогдолтой байдаг (Эх сурвалж: Японы мах ангилагчдын холбоо).

Энэхүү стандарт нь тугалаас бусад бүх нас, үүлдэр, хүйсийн үхрийн гулууз маханд хэрэглэгдэх бөгөөд гулууз махны 6 ба 7 дугаар хавирга хоорондын махны гарц ба чанарыг үнэлэн зэрэглэж, дараалаар нь бичиж илэрхийлнэ. Махны гарцын ангиллын хувьд А нь махны гарцын жишиг үзүүлэлт 72-оос дээш, В нь 72-оос бага, С нь 69-ээс бага гэж үзэх бөгөөд махны чанарын ангиллын хувьд “өөхний алаглалт (marbling meat)”, “махны өнгө”, “махны нягт ба бүтэц”, мөн “өөхний өнгө ба чанар” гэсэн дөрвөн үзүүлэлтээр үнэлдэг бөгөөд эдгээр 4 үзүүлэлтийн аль нэгнийх нь авсан хамгийн бага оноогоор ангилал тогтоодог.

Махны гарцын жишиг үзүүлэлт = 67.37 + 〔0.130×цээжний хамгийн урт булчингийн талбай (см²)〕 + 〔0.667×хавирганы махны зузаан (см)〕 - 〔0.025× хөлдүү өрөөл махны жин (өрөөл мах кг)〕 - 〔0.896×арьсан доорх өөхний зузаан (см)〕

Өөхний алаглалтын зэрэглэл（Эх сурвалж: ХААОЗАЯ）



1961 онд үхэрийн гулууз махны стандарт батласнаас хойш үхрийн үүлдэр угсаа сайжирч гулууз махны үзүүлэлт дээшилж ирсэн болон япон үхрийн махны онцлогийг тусгахын тулд уг стандартад 5 ч удаа өөрчлөлт оруулсан байна. Мөн ангилалын стандартыга кобэ үүлдэр, мацузака үүлдэр зэрэг японы хар үхрийн брендийн шалгуур үзүүлэлтийн нэг болгон ашиглаж байгаа бөгөөд чанарын баталгааны нэг үндэслэл болж байна.

Жишээ 2: Японы хонины махыг ангилах жишээ

Японд гадаадаас хямд хонины ноос импортлож, химийн нийлэг ашигладаг болсоноос хонины тоо толгой багассан тул ноосны хонины оронд хурга тэжээдэг болж, махны үүлдрийн хурганы импорт, хурганы махны үйлдвэрлэлийн судалгаа, хэрэглээг нэмэгдүүлэх ажлыг дэмжсэний үр дүнд дотоодын үйлдвэрийн хурганы махны хэрэглээ нэмэгдэж ирсэн. Ийнхүү хурганы махны дотоодын нийлүүлэлтийг нэмэгдүүлж, хэрэглэгчдийн эрэлт хэрэгцээнд нийцсэн, чанарын шаардлага хангасан хурганы мах үйлдвэрлэхэд стандарт шаардлагатай болсон тул 1997 онд Японы хонины нийгэмлэг “Хурганы гулууз махны стандарт ба ангилалын стандартыг” баталсан болно.

Хурганы гулууз махны стандартыг гулууз махны жин болон ууцны гол дээрх нурууны өөхний зузаан гэсэн хоёр үзүүлэлтээр тогтоох бөгөөд гулууз махны жинг 5 шатлал, нурууны өөхний зузааныг 3 шатлалд хуваах, энэ хоёрыг хослуулан 15 зэрэгт ангилдаг. Гулууз махны жин нь 15 кг-аас бага байвал SS, 15 кг-аас их 20кг-аас бага байвал S, 20 кг-аас их 25кг-аас бага байвал M, 25 кг-аас их 30 кг-аас бага байвал L, 30 кг- аас их байвал LL гэсэн 5 шатлалд ангилдаг. Нурууны өөхний зузаан нь 4 мм-ээс бага, 1. 4 мм-ээс их 7 мм-ээс бага, 2.7 мм-ээс их байвал 3 гэсэн 3 ангилалд хуваадаг.

(Эх сурвалж: МАА-н технологийн холбоо).



12-13 дугаар хавирганы завсар зүсэлт хийж нурууны өөхийг хэмжих хэсэг (Цэнхэр шугам)

Хурганы гулууз махыг стандартын шалгуур үзүүлэлтээр нь “1-р зэрэг”, “2-р зэрэг”, “3-р зэрэг”, “Муу” гэж ангилах бөгөөд стандарт ба зэрэглэлийг нэгтгээд M2, зэрэглэл өндөр байвал “M2 +” гэж илэрхийлнэ (Эх сурвалж: Sheap Japan 22 дугаар, 1997 оны 4 сар)

Хурганы гулууз махны зэрэглэлийн шалгуур

Зэрэглэл	Гаднах байдал			Махны чанар	
	Хэлбэр төрх ба махны байдал	Өөхлөлт	Боловсруулсан байдал	Нягт ба бүтэц	Өөхний өнгө ба чанар
1-р зэрэг	Бүх хэсэг нь жигд махтай, баланс сайтай, ялангуяа шөрмөсөөр баялаг байх.	Нуруу болон хэвлийн хэсгийн өөхлөлт хэвийн хэмжээнд байх.	Цусыг нь хангалттай юүлсэн, өвчний шалтгаантай гэмтэл, сорвигүй, нямбай бус ажилласнаас үүссэн бохирдлын ул мөргүй байх.	Ширхэг нарийн, нягт сайн, өнгө сайн.	Өөхний өнгө сайн, нягт, гялалзаж байх.
2-р зэрэг	Бүх хэсэг нь жигд махтай, баланс сайтай, гуяанд мэдэгдэхүйц согог байхгүй байх.	Нуруу болон хэвлийн өөхлөлтөд онцгой согого байхгүй байх.	Цус юүлэлт хэвийн, өвчний шалтгаантай гэмтэл, сорвигүй, нямбай бус ажилласнаас үүссэн бохирдлын томоохон ул мөргүй байх	Ширхэг ба нягтын хувьд онцгой согого байхгүй, өнгө хэвийн.	Өөхний өнгө хэвийн, нягтын хувьд онцгой согого байхгүй байх.
3-р зэрэг	Бүх хэсгийн баланс муу, гуя шувтан байх.	Нуруу болон хэвлийн өөхлөлт таарууу байх.	Цус хангалттай юүлээгүй, тодорхой хэмжээний гэмтэл сорвитой, нямбай бус ажилласанаас үүссэн бохирдлын ул мөртэй.	Ширхэг том, улцгар, хэт цайвар эсвэл бараан өнгөтэй.	Өөх нь хэвийн бус өнгөтэй, сайтар гялалзахгүй, нягт нь хангалттай бус байх
Муу	1. Дээрх зэрэглэлийн алинд нь ч хамаарахгүй байх 2. Гаднах байдал, махны чанар муу байх 3. Өөхний чанар муу байх		4. Заар болон бусад хэвийн бус үнэртэй байх 5. Эрүүл ахуйн үзлэгээр ихээхэн зүсэж огтолсон байх 6. Мэдэгдхүйц бохирдсон байх		
	Зэрэглэл тогтоох: Гаднах байдал, махны чанарын 5 үзүүлэлтийн аль нэгнийх нь авсан бага оноогоор зэрэглэнэ.				
	1-р зэрэг: Гаднах байдал, махны чанарын бүх үзүүлэлт сайн 2-р зэрэг: Махны чанарын бүх үзүүлэлт сайн байх		3-р зэрэг: 1 ба 2-р зэрэгт орохгүй боловч зэрэглэлийн үзүүлэлтийг хангаж байх Муу: 1,2,3-р зэрэгт тэнцэхгүй байх		

Жишээ 3: Австралийн хонины мах ангилдаг жишээ.

Гулууз махны өөх нь 1-5 зэрэгт хуваагдах бөгөөд зэрэглэлийг GR талын зузааныг үндэслэн тогтооно. GR тал нь зураг дээр харуулсанчлан голын шугамаас 110 мм зайтай 12-р хавирганы дээр байрлана. GR тал нь 5мм-ээс бага бол “1”, 5мм-ээс дээш 10мм-ээс бага бол “2”, 10мм-ээс их 15мм-ээс бага бол “3”, 15 мм-ээс их 20мм-ээс бага бол “4”, 20 мм-ээс их бол “5” гэж зэрэглэнэ.

Гулууз махыг жингээр нь ангилах бөгөөд 8кг-аас бага бол “8”, 8 кг-аас их 10 кг-аас бага бол “10”, 10 кг-аас их 12 кг-аас бага бол “12”, 12 кг-аас их 14 кг-аас бага бол “14”, 14 кг-аас их 16 кг-аас бага бол “16”, 16 кг-аас их 18 кг-аас бага бол “18”, 18 кг-аас их 20 кг-аас бага бол “20”, 20 кг-аас их 22 кг-аас бага бол “22”, 22 кг-аас их 24 кг-аас бага бол “24”, 24 кг-аас их 26 кг-аас бага бол “26”, 26 кг-аас их бол “28” гэсэн 11 шатлалд хувааж зэрэглэнэ (Эх сурвалж: Handbook of Australian Meat).



MID LINE OF CARCASE

(4) Мал төхөөрөх үйлдвэр байгуулах төлөвлөгөө

YAT 4.4: Мал төхөөрөх үйлдвэр байгуулах төлөвлөгөө	
Төлөвлөгөөний зорилго	Мал төхөөрөх үйлдвэрүүд (боловсруулах үйлдвэр оруулан) тоноглогдож эсвэл засвар шинэчлэл хийгдэж, баталгаажсан мал төхөөрөх үйлдвэрүүд эрүүл ахуйн шаардлага хангасан байгууламжид эрүүл ахуйн шаардлага хангасан нөхцөлд төхөөрч, аюулгүй байдал өндрөөр хангагдсан махыг хэрэглэгчдэд тогтвортой нийлүүлж, экспортыг дэмжинэ.

Суурь түвшин	Ирэх 10-н жилийн хугацаанд одоо улсын хэмжээнд байгаа (2023 оны байдлаар) 170 орчим мал төхөөрөх газруудад хяналт шалгалт хийж, шаардлагатай бол шинэчлэн тохижуулах эсвэл засварлаж, хүнсний хэрэглээний бүх махыг засгийн газраас баталгаажуулсан төхөөрөх газруудад бэлтгэж, боловсруулах ажлыг идэвхижүүлж, экспортыг нэмэгдүүлэхэд хувь нэмэр оруулна.
Төлөвлөгөөний зорилт	Улсын 170-н мал төхөөрөх үйлдвэрүүдийг (мах боловсруулах үйлдвэрийг оруулаад) шалгаж, шаардлагатай бол тоноглох эсвэл шинэчлэн засварласанаар, 50-с доошгүй хувь нь GHP (Эрүүл ахуйн зохистой дадал) болон GAP (ХАА-н зохистой дадал) стандартуудыг мөрдөж, HACCP, ISO22000, ISO9001 зэрэг гэрчилгээ авна.
Хамрах хүрээ	Улаанбаатар хотын ойр орчимд мал төхөөрөх газрууд төвлөрч байгаа тул эхлээд нийслэл хот болон Төв аймгийг, дараа нь баруун бүс зэрэг БНХАУ, ОХУ-тай хиллэдэг, Казакстан зэрэг улстай ойрхон, махны экспортын бааз суурь болсон аймгийн нутаг дэвсгэрийн мал төхөөрөх газрууд, улирлын хамааралгүй бүтэн жилийн турш үйл ажиллагаа явуулдаг төхөөрөх газрууд зэргийг зорилтот газраа болгоно. Эцсийн дүндээ улсын хэмжээнд бүх мал төхөөрөх газруудад хэрэгжүүлнэ. Мал төхөөрөх газрууд төвлөрсөн бүс нутаг дахь, хуучирсан болон олон тооны мал боловсруулдаг төхөөрөх үйлдвэрүүдийг тохижуулах эсвэл шинэчлэн засварлах ажлыг нэн тэргүүнд хэрэгжүүлнэ.
Хүлээх үр дүн	Мал төхөөрөх газар нь тоноглогдсон эсвэл засвар үйлчилгээ хийсэн, малын тавлаг байдлыг харгалзан үздэг, GHP-ийг дагаж мөрддөг, HACCP, ISO стандартын гэрчилгээ авсан, эрүүл ахуйн шаардлага хангасан арга барилаар нядалсан, хүнсний аюулгүй байдал өндөр хангагдсан хүнсний мах болон малын гаралтай бүтээгдэхүүн үйлдвэрлэж, стандардын шаардлага хангасан тоног төхөөрөмжөөр тоноглогдсон газарт хадгалана. Энэ нь хэрэглэгчдэд өргөнөөр танигдсан байх ба хүнсний мах гэх мэт МАА-н гаралтай бүтээгдэхүүнийг аюулгүй, тогтвортой хангахад хувь нэмэр оруулна. Ингэснээр малын борлуулалтын үнэ өсөж, малчдын мал маллагааны менежмент сайжирна. Түүнчлэн CODEX (олон улсын хүнсний стандарт, удирдамж, үйл ажиллагааны дүрмүүд)-ийг дагаж мөрдсөнөөр мах, малын гаралтай бүтээгдэхүүний экспорт нэмэгдэнэ.
Үйл ажиллагаа	(1) Мал төхөөрөх үйлдвэрүүдийг тоноглох (эсвэл шинэчлэх) тогтолцоог бий болгох. 1) Төслийн баг бүрдүүлнэ (ХХААХҮЯ, МХЕГ, Аймгуудын ХААГ гэх мэт холбогдох байгууллагууд). 2) Өнөөгийн нөхцөл байдлын судалгаа (эрэлт хэрэгцээний судалгаа болон байгууламжийн шалгалтыг оруулаад) төхөөрөх газар болон боловсруулах үйлдвэр зэргийг хамруулна. 3) Төлөвлөгөө боловсруулах, байгууламж бүрт шаардлагатай дэмжлэгийг тодорхойлохын тулд мэргэжилтнүүдийн үйл ажиллагааны уулзалтыг дэмжиж, зохион байгуулна (ХХААХҮЯ, МХЕГ, Аймгуудын ХААГ-ууд, хоршоо, бусад холбогдох байгууллага гэх мэт). 4) Баталгаажуулалтын гэрчилгээ авахын тулд тоног төхөөрөмж худалдан авахтай холбоотой хөрөнгө оруулалт, зөвлөгөөний хураамжид татаас олгох тогтолцоог нэвтрүүлнэ. 5) Төхөөрөх газарын барилга байгууламжийг тохижуулах эсвэл засварлана. (2) Мал төхөөрөх үйлдвэр цехийн ажилтнуудад гэрчилгээ олгох сургалт явуулах (сургалтын тоо, сэдэв, сургалтын түвшинг өнөөгийн нөхцөл байдлын судалгааны үр дүнд үндэслэн тогтооно). 1) Байгууллагын сургалтыг зохион байгуулах багш нарыг сургах. 2) Баталгаажуулалт авах гарын авлага гаргах. 3) Тогтмол сургалтад хамрагдах (хяналт шинжилгээний арга, эрсдэлийн удирдлага гэх мэт). 4) Шаардлагатай тохиолдолд гарын авлагыг шинэчилэх. (3) Мал төхөөрөх арга, мах боловсруулах технологи (арьс ширийг оролцуулаад) боловсронгуй болгож, боловсруулах явцад үүсэх хүнсний алдагдлыг бууруулах, экспортын зориулалттай малын гаралтай бүтээгдэхүүний эрүүл ахуйн менежмент болон боловсруулалтын арга, түгээлт хүртэлх зохистой хадгалах аргын талаарх ойлголтыг нэмэгдүүлэх (Сургалтын тоо, сэдэв, сургалтын түвшинг өнөөгийн нөхцөл байдлын судалгааны үр дүнд үндэслэн тогтооно.

	Экспортын тухайд улс орон тус бүрийн стандарт, эрэлт хэрэгцээг судалсны дараа мэдээлэл өгнө). 1) Сургалтыг зохион байгуулах багш нарыг сургах эсвэл сонгон шалгаруулах. 2) Махны үйлдвэрт мах бэлтгэх гарын авлага гаргах. 3) Төхөөрөх газрын мах бэлтгэгч технологич нарт зориулж, хүнсний мах бэлтгэлийн талаар сургалт зохион байгуулах. 4) Тогтмол сургалт зохион байгуулах 5) Шаардлагатай тохиолдолд гарын авлагыг шинэчилэх. (4) GHP болон GAP-ыг нэвтрүүлэн, HACCP болон ISO гэрчилгээ авах, мөн экспорт хийх тул CODEX-ийг дагаж мөрдөнө. 1) Мал амьтны тавлаг байдлын асуудлыг шийдсэн, эрүүл ахуйн шаардлага хангасан төхөөрөх арга барилаар нядалсан, аюулгүй байдал хангагдсан мах болон бусад малын гаралтай бүтээгдэхүүнийг (үс, ноос, арьс шир гэх мэт) тогтвортой нийлүүлэх. 2) Мал төхөөрөх ажлыг илүү үр дүнтэй болгох. 3) Малчид тогтвортой борлуулалт хийх цэгүүдийг бий болгох. (5) Засвар, үйлчилгээ зэргийг хийхийн тулд мал төхөөрөх газрын удирдлага тогтмол хяналт, үнэлгээ хийх. 1) Хяналтын тогтолцоо бий болгох. 2) Хяналт шалгалтыг холбогдох байгууллагуудын жилийн ажлын төлөвлөгөөнд тусгах. 3) Хяналтын үр дүнг холбогдох байгууллагуудын дундын мэдээлэлийн бааз үүсгэн хадгалах ба тухайн байгууллагад эргэн мэдээллэх. (6) Хэрэглэгчдээс үйлдвэрлэгчид хүртэлх хүмүүсийн хандлагыг өөрчилж, эрүүл ахуйн шаардлага хангасан аргаар бэлтгэсэн, өндөр чанартай махны эрэлтийг нэмэгдүүлэхийн тулд баталгаажуулалтыг зах зээлд болон хэрэглэгчдэд сурталчлах. 1) Мэдээллийн товхимол зэрэг сурталчилгааны зэрэг материал бэлтгэх. 2) Хүнстэй холбоотой арга хэмжээний үеэр кампанит ажил зохион байгуулах гэх мэтээр сурталчилгааны үйл ажиллагаа явуулах.	
Санхүүжилт	<u>Засгийн газар</u> • Өнөөгийн нөхцөл байдлын судалгаа хийх (баталгаажуулалт болон засвар хийх зорилгоор) • Төлөвлөлт хийх захиргааны зардал • Хурлын зардал (төхөөрөх газруудад түгээх, хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх) • Мах, махан бүтээгдэхүүн бэлтгэн нийлүүлдэг аж ахуйн нэгжүүдэд зориулсан сургалт (баталгаажуулалт авах, технологи сайжруулах) • Сургалтын материал бэлтгэх (баталгаажуулалт авах, технологи сайжруулах) • Үйлдвэрлэгч, хэрэглэгчдэд сурталчлах, түгээх үйл ажиллагаа • Сурталчилгааны зардал (материал бэлтгэх, оролцох болон зохион байгуулах хураамж гэх мэт) • Төслийн үр ашгийн мониторингийн хэрэгжилтийн зардал • Мал төхөөрөх газруудын байгууламж, засварын ажилд татаас олгох	<u>Хувийн хэвшил</u> (Мах, махан бүтээгдэхүүн бэлтгэн нийлүүлдэг аж ахуйн нэгжүүд) • Мал төхөөрөх цехийн тоног төхөөрөмж эсвэл засвар • HACCP гэрчилгээ авах,стандардаа хадгалах төлбөр • Удирдлагын зардал • Хурал (оролцох хураамж, замын зардал) • Сургалтанд оролцох хураамж (замын зардал)
Төслийн өртөг	Төслийн нийт өртөг: 52 тэрбум 156 сая төгрөг (19,853,000 ам. доллар)	
Ашиг, үр нөлөө	• Төхөөрөх ажлын үр дүн нэмэгдэж, өндөр чанартай мах, малын гаралтай бүтээгдэхүүнээр тогтвортой хангагдах, хангах боломжтой болж, баталгаажсан мал	

	төхөөрөх газрууд худалдааны давуу тал болон хэрэглэгчдийн итгэл үнэмшил нэмэгдэнэ. • Аюулгүй байдал, чанар нь экспортыг нэмэгдүүлэхэд хувь нэмэр оруулна. • Малчид тогтвортой худалдан авагчтай болно. • Засгийн газрын баталгаажуулсан мал төхөөрөх газруудын төхөөрөх хувь хэмжээ одоогийн 10 хувиас нэмэгдэнэ. • Засвар үйлчилгээний төлөвлөгөөний өргөдөл гаргах бол HACCP зэрэг гэрчилгээ заавал авсан байх шаардлагатай. • Улсын хэмжээнд (HACCP, ISO22000, ISO9001) баталгаажсан мал төхөөрөх газруудын хувь хэмжээг 10 жилийн дотор 2%-иас 50%-д хүргэнэ (2017). • Мал төхөөрөх газруудын ашиглалтын түвшин нэмэгдвэл ажлын байр бий болгох боломж байна. • Зарим мах боловсруулах үйлдвэрүүд импортын мах (голчлон тахиа, гахайн мах) ашигладаг ба тоног төхөөрөмжөө сайжруулснаар импортын махны чанар, эрүүл ахуйн хяналтыг чангатгана.
Бодлогын бичиг баримттай уялдсан байдал	1. Алсын хараа 2050 2. Хүнд ээлтэй амьдрах орчин, зорилт 2.5 Амьдралын хэрэгцээ хангасан эрүүл, ая тухтай, таатай орчин бүрдүүлж, баталгаат хүнсээр хангана. 2. Алсын хараа 2050 4.2.6. Малыг эрүүлжүүлэх ажлыг эрчимжүүлэх замаар хүн амын хүнсний аюулгүй байдлыг хангаж, хүнсний бүтээгдэхүүний экспортын хэмжээг нэмэгдүүлнэ. 3. Алсын хараа 2050 4.5.7. ЖДҮ эрхлэгчдэд дэлхийн өртгийн сүлжээнд тавигддаг шаардлагуудыг хангах удирдлагын болон ажиллах хүчний ур чадварыг дээшлүүлэх, технологийн дэвшил, инновацийг нэвтрүүлэх, бүтээгдэхүүний чанар, стандартыг сайжруулна. 4. Алсын хараа 2050 4. Эдийн засаг, зорилт 4.2 Эдийн засгийн тэргүүлэх салбаруудыг хөгжүүлж, экспортын баримжаатай эдийн засгийг бий болгоно. 5. Хүнс, хөдөө аж ахуйн талаар баримтлах үндэсний бодлого (2015-2025 он) Нэмүү өрттийн сүлжээ болон өрсөлдөх чадварыг сайжруулсан бүтээгдэхүүн үйлдвэрлэх (үйлдвэрлэлийн бүтээмжийг сайжруулах, малын халдварт өвчинтэй тэмцэх, түүхий эдийн боловсруулалтыг сайжруулах, хадгалах, тээвэрлэх сүлжээг хөгжүүлэх). 6. Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр (2020-2024) 1.1.5 Экспортыг дэмжих санхүүгийн шийдлүүдийг боловсруулж, экспортод гаргах бараа, бүтээгдэхүүний хэмжээг нэмэгдүүлнэ. 7. Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр (2020-2024) 3.3.12 ХААн тээвэр, борлуулалтын логистикийн сүлжээг байгуулж, хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний бэлтгэн нийлүүлэлтийн чанарын хяналт, баталгаажуулалтын оновчтой тогтолцоог бүрдүүлнэ. 8. Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр (2020-2024 он) 4.5.2 Эдийн засгийн гадаад харилцаанд тэргүүлэх ач холбогдол өгч, төр, хувийн хэвшлийн түншлэлд тулгуурлан экспортыг нэмэгдүүлэх, төрөлжүүлэх, гадаад худалдаанд тулгарч байгаа хүндрэлүүдийг багасгах, хөнгөвчлөх бодлогыг үргэлжлүүлнэ.
Төслийг хэрэгжүүлэхэд анхаарах зүйлс	• Мал төхөөрөх үйлдвэрүүдийн олох ашиг болон бусад хүчин зүйлсийг тооцоход тохижилт эсвэл засвар үйлчилгээг хэр хэмжээнд хийх боломжтой вэ? • Тоног төхөөрөмжийн байнгын засвар үйлчилгээг хийх боломжтой эсэх?

Төслийг хэрэгжүүлэх хуваарь, төсөв

Үйл ажиллагаа	2025	2026	2027	2028	2029	2030	2031	2032	2033	2034	Нийт
(1) Мал төхөөрөх үйлдвэрүүдоноглох, шинэчлэх тогтолцоог бий болгох.											
(2) Мал төхөөрөх цехийн ажилтнуудад гэрчилгээ олгох сургалт явуулах.											
(3) Мал төхөөрөх арга болон мах											

боловсруулах арга технологийн сургалт зохион байгуулах.												
(4) GHP болон GAP-ыг нэвтрүүлэх, HACCP болон ISO гэрчилгээ авах, мөн экспорт хийхэд CODEX-ийг дагаж мөрдөх.												
(5) Мал төхөөрөх газрын удирдлага тогтмол хяналт, үнэлгээ хийх.												
(6) Баталгаажуулалтын зах зээл болон хэрэглэгчдэд сурталчлах.												
Төслийн өртөг	сая төгрөг	5,396	5,193	5,193	5,193	5,193	5,193	5,193	5,193	5,193	5,216	52,156
	мян. ам.дол	2,060	1,976	1,976	1,976	1,976	1,976	1,976	1,976	1,976	1,985	19,853

Тэмдэглэл. Махны экспорт болон Засгийн газрын үүрэг

1971 онд ХАА, ой, загас агнуурын яамнаас батламж авсан Гүнма мужийн махны бөөний зах нь өнөөг хүртэл Японы хүнсний хэрэгцээний махны түгээлт нийлүүлэлтийн тогтолцоог сайжруулахад хувь нэмрээ оруулж ирсэн хувийн компани юм. Өнөө үед хүнсний аюулгүй байдал, сэтгэл ханамжийг чухалчилах хандлага нэмэгдэж байна. Тус компаний үхрийн мах боловсруулах үйлдвэр нь АНУ-ын эрүүл ахуйн стандартад нийцсэн, экспорт хийх зөвшөөрөлтэй Япондоо цөөн тооны байгууламжийн нэг юм. Мөн 1990 онд Эрүүл мэнд, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны зөвшөөрөл авч, улмаар Канад, Хонг Конг, Сингапур, Тайланд, Макао, Мексик, Вьетнам, ЕХ-ны гэрчилгээ авч, гадаад руу хийх махны экспортоо өргөжүүлж байна[106]. Гэсэн хэдий ч тухайн экспорт хийх орнуудын

Гүнма мужийн махны бөөний зах

эрүүл ахуйн стандартад нийцсэн боловсруулах байгууламжийг хөгжүүлэх, зөвшөөрөл авахад шаардагдах ажиллагаа, зөвшөөрөл авсан ч энэ стандардаа хойшид хадгалахад олон бэрхшээл тулгарч байсан. Байгууламжийн засвар үйлчилгээний тухайд мах эвдэх болон зүсэх, боловсруулах өрөөг HACCP концепцид үндэслэн шинэчилсэн ба хяналтын төхөөрөмж зэргийг шинээр суурилуулсан. Мөн эрүүл ахуйн хяналт, боловсруулалтын үйл явцын хувьд хяналт, шалгалтын агуулга, арга барилыг шинэчилж, боловсруулах процессыг сайжруулан, эдгээр шинэчлэлт дээрээ үндэслэн процедурын гарын авлага бэлтгэх зэрэг эрүүл

ахуйн хяналтын тогтолцоог аажмаар бий болгосон. Байгууламжийг сайжруулж, боловсруулах аргыг өөрчилснөөр тус компанийн үйлдвэрлэсэн махны эрүүл ахуйн нөхцөл байдал мэдэгдэхүйц сайжирсан бөгөөд урт хугацааны хүчин чармайлт нь АНУ зэрэг хилийн чанад дахь улс орнууд руу экспортоо өргөжүүлэх үр дүнд хүргэсэн. Түүнчлэн гадаад оронлуу мах экспортлоход хувийн хэвшлийн компаниудын хүчин чармайлт төдийгүй Японы ХАА, ой, загас агнуурын яам, Эрүүл мэнд, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамтай хамтран ажиллах шаардлага гарсан ба Төр, Хувийн хэвшлийн Хамтын ажиллагааг шаарддаг бизнес гэж хэлж болно. Тухайлбал, Японы ХАА, ой, загас агнуурын яам нь Японы экспортыг дэмжих тухай хуулийн дагуу дараахь ажлуудыг хэрэгжүүлсэн[107].

1) Экспортыг дэмжих арга хэмжээний үндсэн чиглэлийг тодорхойлох: Экспортыг дэмжих үйл ажиллагааны төлөвлөгөө гаргаж, жил бүр ахиц дэвшлийг дүгнэн, тухай бүрт нь хэрэгжүүлэх ажлыг дэмжих.

[106] Гүнма мужийн махны бөөний зах ХК, үйл ажиллагааны танилцуулах материал
[107] ХАА, ой, загас агнуурын яам, ХАА, ой, загасны аж ахуйн болон хүнсний бүтээгдэхүүн экспортлох төв оффисийн өнөөгийн байдлын талаар

2) Экспорт хийх орнуудтай зөвшилцөх: ХАА, ой, загас агнуурын сайд нь гол үүрэг гүйцэтгэн, холбогдох сайд нартай хамтран ажиллана. Хэлэлцүүлгийг үр дүн, өндөр бүтээмжтэй үргэлжлүүлэхийн тулд хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас агнуур, хүнсний аж үйлдвэрийн тогтвортой хөгжилд хувь нэмэр оруулах өндөр магадлалтай экспортын барааг экспортлох улс орнуудад нэн тэргүүнд анхаарах.

3) Экспортыг хялбаршуулах зорилгоор шаардлагатай процедурыг тодорхойлох: Бүртгэгдсэн баталгаажсан байгууллагуудыг ашиглан процедурыг хурдасгах. Холбогдох яам, агентлаг, засаг захиргааны нэгжүүдийг оролцуулан өргөдөл гаргах, гэрчилгээ олгох ажлыг нэг цэгт төвлөрүүлэх тогтолцоог бий болгохыг дэмжих.

4) Экспортлогч байгууллагуудад дэмжлэг үзүүлэх: Экспорт хийх орнуудын холбогдох дүрэм, журам зэрэг зохицуулалтын талаарх мэдээллийг нэгтгэн, хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загасны аж ахуй, хүнсний үйлдвэрлэл эрхлэгчдэд ойлгомжтой байдлаар мэдээллээр хангах. ХАА, ой, загас агнуурын яаманд аж ахуйн нэгжүүдийн төрөл бүрийн зөвлөгөөнд хариу өгөх нэгдсэн харилцагчийн үйлчилгээний цэгийг байгуулж, бизнес эрхлэгчдээс ирсэн асуудалд зөвлөх үйлчилгээ үзүүлэх. ХАА, ой, загас агнуурын яам нь экспорттой холбоотой асуудлыг яам, агентлаг, засаг захиргааны нэгж гэх мэт холбогдох байгууллагуудад түгээх сүлжээ байгуулж, идэвхтэй хариу арга хэмжээ авах.

(5)МАА-н түүхий эд ба дайвар бүтээгдхүүнээр гэрийн тэжээвэр амьтны хоол үйлдвэрлэл бий болгох төсөл

YAT 4.5: МАА-н түүхий эд ба дайвар бүтээгдхүүнээр гэрийн тэжээвэр амьтны хоол тэжээл үйлдвэрлэх төсөл	
Төлөвлөгөөний зорилго	Хэдийгээр үйлдвэрлэлийн хэмжээнд танигдаагүй байгаа ч монголд гэрийн тэжээмэл амьтны хоол хийдэг компани ЖДҮ-ийг оруулаад арав гаруй байдаг хэдий ч эдгээрийн дотор боловсруулах технологийн хувьд мэргэжлийн түвшинд хүрсэн, арилжааны хувьд амжилттай яваа компани цөөн байна. Ихэнх нь боловсруулах технологи хоцрогдсон, зах зээл дутмаг,зохих түвшний технологи нэвтрүүлэх ажил хүндрэлтэй байдалтай байна. Нөгөө талаар дэлхийн тэжээвэр амьтны хүнсний зах зээл өргөжин, төрөлжин хөгжиж, чанар нь сайжирч буй нь монголд ч гэсэн мэдрэгдэж, МАА-н салбарын томоохон үйлвэрлэгчид энэ салбарт орох хүсэл сонирхолоо илэрхийлсээр байна. Уг нь Монгол улс гэрийн тэжээвэр амьтны хоолны түүхийн эдийн арвин нөөцтэй, үйлдвэрлэгч, ханган нийлүүлэгч болох асар их нөөц бололцоотой орон юм. Иймд энэ төслийн хүрээнд эхлэл төдий байгаа монголын гэрийн тэжээвэр амьтны хүнсний эмзэг үйлдвэрлэлийг технологи, тогтолцоо, зохион байгуулалт хамтын ажиллагаа талаас нь бэхжүүлэн, бие даасан үйлдвэрлэл болгон хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх зорилго тавина.
Суурь түвшин	• Монголын үйлдвэрийн гэрийн тэжээвэр амьтны хүнсний экспортын хэмжээ = 106,310 кг (2021 онд) • Монголд үйлдвэрлэсэн гэрийн тэжээвэр амьтны хоолыг японд экспортлосон хэмжээ = 0 кг (2021 онд)
Төлөвлөгөөний зорилт	• Монголын МАА-н түүхий эд ба дайвар бүтээгдхүүнээр хийсэн гэрийн тэжээвэр амьтны хүнсний чанарыг сайжруулах, үйлдвэрлэл, экспортын хэмжээг нэмэгдүүлэх • Монголд үйлдвэрлэсэн ГТА-ны хоолны экспорт = 150,000 кг-аас дээш • Японд албан шугамаар экспортлох монголын ГТА-ны хоол = 1,000 кг
Хамрах хүрээ	Улаанбаатар хот орчмын (Эмээлт, Налайх зэрэг) мах, сүү боловсруулах үйлдвэрүүд бөөгнөрсөн бүс нутаг.
Хүлээх үр дүн	(1) Монголд гэрийн тэжээвэр амьтны хоолны үйлдвэрлэл үүсэн хөгжинө. (2) Монголын гэрийн тэжээвэр амьтны хоолны чанар сайжирна. (3) Монголын гэрийн тэжээвэр амьтны хоол хүнс төрөлжин хөгжинө. (4) Монголын гэрийн тэжээвэр амьтны хоолны нэмүү өртөг, өвөрмөц байдал хүлээн зөвшөөрөгдөнө. (5) Монголын гэрийн тэжээвэр амьтны хоолны үйлдвэрлэл, экспортын хэмжээ нэмэгдэнэ. (6) Монголын гэрийн тэжээвэр амьтны хоолны экспортын зах зээл болох орны тоо нэмэглэнэ.

	(7) Монголын гэрийн тэжээвэр амьтны хоолны үйлдвэрлэлд дотоодын хүн амын хүнсэнд бага хэрэглэгддэг, тоо толгой их, бэлчээрийн доройтолд нөлөөтэй гэгддэг ямааны махны хэрэглээ нэмэгдлэнэ.
Үйл ажиллагаа	(1) ГТА-ны хоол үйлдвэрлэгч ААН-үүдийг зохион байгуулалтад оруулах үйлдвэрлэлийн кластер байгуулахад чиглэсэн зөвшилцөлд хүрэх. ХХААХҮЯ-ны МААБХЗГ-ын удирдалага зохион байгуулалт, ХҮБХЗГ, ЖДҮГ, УБЕГ-ын манлайлал, холбогдох мэргэжлийн холбоод (Махны холбоо, Арьс ширний үйлдвэрлэлийн холбоо, Ноосны холбоо гэх мэт) ТББ-уудын (JICA-MONMAP, ОУСК, ГТАХҮХ) дэмжлэгээр одоо үйл ажиллагаа явуулж буй ААН-үүд болон гэрийн тэжээвэр амьтны хоол хүнсний үйлдвэрлэлд сонирхолтой ААН-үүдийг оролцуулан* үйлдвэрлэлийн кластер байгуулахад чиглэсэн хэлэлцүүлэг зохион байгуулж, зөвшилцөлд хүрнэ. (*Малын дайвар бүтээгдхүүний дахин боловсруулагч нийлүүлэгчээр оролцох сонирхолтой махны бизнес эрхлэгч ААН) (2) Гэрийн тэжээвэр амьтны хүнсний үйлдвэрлэлийн кластерт оролцогчдын ангилал Үйлдвэрлэлийн кластерийн хувьд органик чиг үүргийг гүйцэтгэхэж оролцох ААН-үүдийг ангилан монголын ГТА-ны хоол үйлдвэрлэгчдийн одоогийн нөхцөл байдлыг тодорхойлно. ГТА-ны хоолны үйлдвэрлэлд малын төрөл, ямар эд эрхтэн, боловсруулалтын төрөл, сав баглаа боодол, жилийн нийлүүлэлт зэрэг таван зүйл маш чухал. Иймд юуны өмнө кластерт оролцох ААН-үүдийг дээрх 5 зүйлийн дагуу ангилж үзнэ. Мөн ердийн махны үйлдвэрлэл эрхлэгчид ч хавсрага бизнес байдлаар оролцох магадлалтайг тооцно. (Доорх хүснэгтийг харна уу)

№	ААН	Мал	Эд анги	Боловсруулалт	Сав баглаа	Нийлүүлэлт/жил	Үндсэн, хавсрага
1	A	Адуу, үхэр	Яс, туурай	Хуурай	Нийлэг уут	3 тн	Үндсэн
2	B	Хонь, ямаа	Бүх төрлийн мах	Нойтон	Реторт савлагаа	10 тн	Үндсэн бизнес
3	C	Тэмээ, сарлаг	Сүү	Хатаах технологи	Тетрапак	1 тн	Хавсрага бизнес

(3) Засгийн газрын дэмжлэгтэй шинэ үйлдвэрлэлийг дэмжих төсөл хэлбэрээр төслийн төлөвлөгөөг боловсруулна.

ХХААХҮЯ-ны МААБХЗГ нь кластер хамрагдах ААН-ийн саналыг үндэслэн төслийн бизнес төлөвлөгөөг боловсруулах бөгөөд ингэхдээ шинэ үйлдвэрлэл гэдэг утгаар доор дурьдсан асуудлуудыг тусган нарийвчилсан төлөвлөгөө боловсруулна.

1) ГТА-ны <u>хоолны үйлдвэрлэлийн салбарын мэдээлэл цуглуулах（ялангуяа гадаадын）болон стратеги төлөвлөгөө боловсруулах:</u> Монголын ГТА-ны хоол үйлдвэрлэгчдийн бүтээгдхүүнийг ОХУ, БНХАУ, БНСУ гэсэн хэдхэн оронд гаргадаг бөгөөд экспортын хэмжээ, малын төрөл (үндсэндээ адууны мах), бүтээгдхүүний төрөл нь маш хязгаарлагдмал юм. Нөгөө талаар бэлчээрийн өвсөөр тэжээгдсэн мал, сарлагийн сүү зэрэг монголын давуу талыг ашиглах боломжийн талаарх мэдээлэл хомс байдаг. Иймд энэ талын мэдээллийг интернет, ЭСЯ, гадаад орнуудын ижил төстэй мэргэжлийн холбоодоос авах, мөн боломжтой бол тухайн оронд очиж цуглуулан авч шинжилгээ хийх шаардлагатай. Улмаар тухайн дүн шинжилгээний үр дүнг үндэслэн стратеги боловсруулна. Ингэхдээ өнөөгийн монголд хамгийн өндөр өсөлттэй, бэлчээрийн доройтолд хүчтэй нөлөөлж буй малын махыг эдийн засгийн эргэлтэд оруулахыг дэмжин бэлчээрийн доройтлыг нөхөх тогтолцоо бий болгох нь зүүтэй юм.

2) ГТА-ны хоолны салбарын хөгжлийг дэмжихэд чиглэсэн суртчилгаа ба дэлгэрүүлэх үйл ажиллагаа: Мэдээлэл цулуулах үйл ажиллагаан дээр үндэслэн боловсруулсан стратегээ ашиглан гадаад орнуудын ЭСЯ болон донорууддаар дамжуулан монголын ГТА-ны хоолны үйлдвэрлэлийг суртчилан таниулах, гадаад орнуудын үзэсгэлэн болон бусад арга хэмжээнд оролцуулах талаар засгийн газраас арга хэмжээ авах зэргээр бизнесийн холбоо тогтоох боломжийг бий болгоход дэмжлэг үзүүлнэ. Эерэг хариу өгсөн улсад ХХААХҮЯ-наас судалгааны баг илгээн ажиллуулах асуудлыг судалж үзнэ. (Agro-private business хариуцсан алба байгуулах, хариуцсан мэргэжилтэн ажиллуулах боломжийг ч судалж үзнэ).

3) Кластерийн гишүүдийн сургалт: Дээр өгүүлсэн кластерт оролцох сонирхолтой хэд хэдэн төрлийн ААН-үүд бие биеийн технологийг харилцан суралцаж дутуугаа нөхөх

	боломжийг олгох үүднээс харилцан суралцах сургалтыг зохион байгуулна. Мөн шинэ бизнес эхэлж буй тохиолдолд шинэ материал, тоног төхөөрөмж болон түүнийг зохистой ашиглах талаарх мэдлэг олгох шаардлагатай болно. Иймд шаардлагатай бол гадаадаас мэргэжлийн багш урьж авч ирэн сургалт явуулж болох бөгөөд үүнд ХХААХҮЯ-ны мэргэжилтэн дэмжлэг үзүүлнэ. 4) Хорио цээрийн шаардлагыг хангах арга хэмжээг бэхжүүлэх: Гадаад орнуудын хорио цээрийн хатуу нөхцөлөөс хамааран монголын бүтээгдхүүнийг экспортлох боломжгүй байж болно. Ийм тохиолдолд тухайн орны хорио цээрийн шаардлагыг биелүүлэх арга хэмжээ авах боломжтой эсэхийг тодруулан, хэрэгжүүлэх боломжтой бөгөөд ингэснээр бүтээгдэхүүнээ нийлүүлэх боломжтой нь гэж үзвэл Монголын ЗГ болон холбогдох байгууллагуудтай хамтран хөөцөлдөнө. (Жишээлбэл, Японы ХАА, ой, загас агнуурын яамны “Салаа туурайт малын махыг дулаанаар боловсруулах байгууламж”-ийн тохиролцоо гэх мэт.) (4) ХХААХҮЯ, кластерт оролцож буй ААН, холбогдох байгуулгууд тогтсон хугацаанд хяналт шижилгээ, үнэлгээ хийнэ. Дээр дурьдсан байгуулгуудын голлох оролцоотойгоор тухайн төслийн хэрэгжилийн хяналт шинжилгээ, үнэлгээг тогтмол хийж, үр дүнг нь нэгтгэн холбогдох талуудтай хуваалцаж, шинэ бүтээгдхүүн хөгжүүлэх, шинэ зах зээлд гарахад ашиглана.	
Санхүүжилт	<u>Засгийн газар</u> • Тоног төхөөрөмж, материал худалдан авах үеийн татвараас чөлөөлөх арга хэмжээ • Мэргэжлийн холбоодын зохион байгуулалтын үйл ажиллагаанд татаас олгох • Боловсруулах технологи нэвтрүүлэх мэргэжилтнийг гадаад дотоодоос урьж ажиллуулах (Урамшуулал, байр хоол,унааны зардал) • Гадаадаас судлаач урих* (Байр хоол, унааны зардал) • *Бүтээгдэхүүн экспортлох улсын хорио цээрийн байцаагчийн газар дээрх урьдчилсан шалгалт шаардлагатай тохиолдолд.	<u>Хувийн хэвшил</u> • Тоног төхөөрөмж, материал • Үзлэг шалгалт, техникийн сургалтын зардал • Боловсруулах технологи нэвтрүүлэх мэргэжилтнийг гадаад дотоодоос урьж ажиллуулах (Урамшуулал, байр хоол,унааны зардал) • Гадаадаас судлаач урих* (Байр хоол, унааны зардал) • *Бүтээгдэхүүн экспортлох улсын хорио цээрийн байцаагчийн газар дээрх урьдчилсан шалгалт шаардлагатай тохиолдолд.
Төслийн өртөг	Төслийн нийт зардал: 2 тэрбум 600 сая төгрөг, (989,000 USD)	
Ашиг, үр нөлөө	Сүүлийн жилүүдэд монголын ГТА-ны хоолны үйлдвэрлэлийн хэмжээ өсөх хандлагатай байгаа бөгөөд бүтээгдхүүний ихэнх нь экспортод гарч байгаа байдалтай байна. Тухайлбал 2020 онд 69 тонн, 2021 онд 106 тонн үйлдвэрлэсэн байна. 2022 оны 10-р сарын байдлаар 85 тонн үйлдвэрлэсэн байдалтай байгаа боловч намраас мал төхөөрөх ажил ид өрнөх тул өнгөрсөн жилийнхээс давах төлөвтэй байна. Ийм чиг хандлагатай уялдуулан энэхүү төслийг хэрэгжүүлснээр 2029 оноос хойш үйлдвэрлэлийн хэмжээ (=экспортын хэмжээ) жилд 150 тонноос давах боломжтой гэж үзэж байна.	
Бодлогын бичиг баримттай уялдсан байдал	1. Алсын хараа-2050, 3.1.1 ХАА-н түүхий эд, бүтээгдэхүүний чанарыг дээшлүүлнэ. 2. УИХ-ын 2022 оны 36-р тогтоолын хавсралтын 4.2.1: Мал, малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүн, түүхий эдийн зорилтот зах зээлийг хөгжүүлэх, бэлтгэн нийлүүлэлт, анхны шатны боловсруулалт, борлуулалтын зохих сүлжээг бий болгох, жишиг хоршоодыг байгуулах, өөрчлөн зохион байгуулах, зохион байгуулалтад оруулах ажлыг цогцоор нь явуулахад дэмжлэг үзүүлэх. 3. УИХ-ын 2022 оны 36-р тогтоолын хавсралтын 5.1.1 2: ХАА-н түүхий эдийг дотооддоо боловсруулан эцэсийн бүтээгдхүүн үйлдвэрлэх, дотоодын зах зээл дээр борлуулсан чанар, эрүүл ахуйн шаардлага хангасан бүтээгдхүүнд урамшуулал олгох тогтолцоог бэхжүүлэх. 4. Аж үйлдвэрийн кластержилтыг дэмжих засгийн газрын байр суурьт нийцэж байгаа.	
Төслийг хэрэгжүүлэхдээ анхаарах зүйлс	• Өнөөдөр ААН-үүд тус бүрдээ өөр өөрсдийн шугамаар бизнесээ хийж байгаа бөгөөд хамтран ажиллах чиглэлд зөвшилцөх үед өнөө хүртэл тухайн ААН дангаараа ашиглаж ирсэн давуу талыг бусадтай хуваалцах тухай яригдах тулд энэ асуудлыг хэрхэн зохицуулахыг бодох шаардлагатай. • Тухайн салбарын ААН-үүдийн хооронд хэт өрсөлдөөн үүсгэхээс болгоомжлох хэрэгтэй.	

	• Тухайн салбарын ААН-үүдийг нэгтгэсэн холбоо, ассоциаци байгуулагдсан тохиолдолд тухайн байгуулгуудын үйл ажиллагааны улс төрийн өнгө аяас зүй бусаар хүчтэй болохоос болгоомжлох шаардлагатай.

Төслийг хэрэгжүүлэх хуваарь, төсөв.

Үйл ажиллагаа		2025	2026	2027	2028	2029	2030	2031	2032	2033	2034	Нийт
(1) ГТА-ны хоол үйлдвэрлэгчдийг зохион байгуулалтад оруулах мэргэжлийн холбоо байгуулах чиглэлээр зөвшилцөлд хүрэх.												
(2) (Түр нэр) Монгол гэрийн тэжээвэр амьтадын хүнс үйлдвэрлэгчдийн кластер байгуулах төсөл боловсруулж, танилцуулах.												
(3) Гадаадын ГТА-ны хоолны салбарын чиг хандлагыг улс орон тус бүрээр мэдээлэл цуглуулан дүн шинжилгээ хийх замаар тодруулан стратегийн төсөл боловруулах.												
(4) Боловсруулалтын зохистой технологид суралцах, шаардлагатай материал, тоног төхөөрөмж нэвтрүүлэх, хорио цээрийн протоколын хариу арга хэмжээний төлөвлөгөө боловсруулах.												
(5) Монголд үйлдвэрлэсэн ГТА-ны хоолийг олон сувгаар сурталчлах.												
Төслийн өртөг	сая төгрөг	100	800	800	800	50	50					2,600
	мян. ам.дол	39	304	304	304	19	19					989

Тэмдэглэл: MONMAP-AVC: Хонь, ямааны махны борлуулалт, хэрэглээг идэвхижүүлэх, малын дайвар бүтээгдэхүүний ашиглалтыг дэмжих төсөл

Тус төслийн туршилтын үйл ажиллагааны хүрээнд янз бүрийн туршилт хийж үзсэн бөгөөд ямааны махны хэрэглээг нэмэгдүүлэх, дайвар бүтээгдхүүнийг нь үр өгөөжтэй ашиглах туршилтын үйл ажиллагааны зарим нь амжилттай, зарим нь амжилтгүй боллоо. Юуны өмнө Улаанбаатар хотын ердийн хэрэглэгчдэд зориулан ямааны махтай хоолны шинэ цэс гаргах, ямааны махан борц хийхийг дэмжих туршилтын үйл ажиллагааг ХХААХҮЯ болон хувийн ААН-тэй хамтран явуулж үзлээ. Карэ болон тэрияки зэрэг япончуудын дуртай хоолны амтлагчийг ашиглан ямааны махаар хийсэн хоолны амтлагаа зохион байгуулахад 230 хүн оролцсоноос 90% гаруй нь амттай байна гэж үнэлсэн боловч одоогоор арилжааны бүтээгдэхүүн болгон нэвтрүүлээгүй байна. Нөгөө талаар шүлхий зэрэг малын халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх үүднээс хонь, ямаа зэрэг хивэгч малын гаралтай бүтээгдхүүнийг японд импортлохыг хориглодог боловч эвэр туурай зэрэг дайвар бүтээгдхүүний хувьд тодорхой хэмжээний боловсруулалт хийвэл экспортлох боломжтойг тодруулан японы шаардлага өндөртэй хорио цээрийн саадыг давж чадсан. Харамсалтай нь Японы ГТА-ны хоол үйлдвэрлэгч компанид хийсэн туршилтаар хонь, ямааны туурай нь жижиг, нимгэн тул нохой залгих эрсдэлтэй, мөн ямааны эвэр ч мэрэхэд хагарах эрсдэлтэй гэсэн дүгнэлт гарч бүтээгдхүүн болгох боломжгүй болсон болно. Нөгөө талаар ОХУ-д ямааны чих, эвэр, арьс шир хэрэгцээтэй байгаа мэдээлэл бий бөгөөд эрэлт хэрэгцээ нь байнга нэмэгдэж байгаа таатай мэдээ байна. Японд хивэгч малын дайвар бүтээгдхүүн гаргах нь хүндрэлтэй боловч шөрмөс зэрэг адууны дайвар бүтээгдэхүүний хорио цээрийн саад бага байдаг тул Японы ГТА-ны хоол тэжээлийн борлуулагчдын холбоонд хандахад дээж авч яван үзэсгэлэнд тавьж үзэхэд хэрэглэгчдийн сонирхолыг ихээхэн татаж одоогийн байдлаар худалдааны хэлэлцээр хийх шатанд байгаа болно. Яг л хаядаг бурхан байхад авдаг бурхан бас бий гэдэгчлэн дахин дахин янз бүрээр оролдлого хийх нь чухал гэдэг нь харагдаж байна.

(6)Үйлдвэр цехэд сүү хүлээн авах тогтолцоог бэхжүүлэх замаар сүүний байнгын үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх төлөвлөгөө

YAT 4.6: Үйлдвэр цехэд сүү хүлээн авах тогтолцоог бэхжүүлэх замаар сүүний байнгын үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх төлөвлөгөө	
Төлөвлөгөөний зорилго	Уламжлалт цагаан идээ болох сүү, сүүн бүтээгдхүүн нь монголын өргөн хэрэглээний чухал хүнс юм. Гэвч албан ёсны сувгаар борлуулагдаж буй сүүний хэмжээ бага, улиралын чанартай хэлбэлздэг. Ялангуяа өвлийн улиралд хомсдож, хот суурин газарт хуурай сүү зэрэг импортын бүтээгдхүүний хамаарал өндөр болдог. Албан бус сувгаар борлуулдаг сүүний нийлүүлэлтийн хэмжээ их боловч тээвэрлэлтийн хугацаа урт, өөрсдөө хэрэглэдэгтэй адил ханддаг тул эрүүл ахуйн асуудал их байдаг. Ийм нөхцөл байдалд нийслэлийн ойр орчмын сүүний үйлдвэрлэлд өргөн хүрээний үйлдвэрлэгчдийг хамруулах нь улам бүр өргөжин тэлж буй том хотын (ялангуяа Улаанбаатар хотын) хэрэглэгчдэд эрүүл ахуйн шаардлага хангасан хангалттай хэмжээний сүү нийлүүлэх зорилтыг биелүүлэх үүднээс тулгамдсан асуудал болоод байна. Иймд аль болох бага зардлаар нөхцөл байдлыг сайжруулах арга хэмжээ авах замаар ААН ба төрийн байгуулга хамтран ажиллаж сүү үйлдвэрлэгчдийг албан ёсны нийлүүлэлт, борлуулалтын сувагт оруулж, албан ёсны сувгаар борлогдох сүүний хэмжээг нэмэгдүүлэхийг зорилго болгоно.
Суурь түвшин	• Эхний жил зорилтод бүсэд албан ёсны сувгаар цуглуулан авсан сүүний хэмжээ: 40,000 тн (2022 оны гүйцэтгэл) • Эхний жилд зорилтод бүсэд сүү хамтран нийлүүлэх зорилгоор байгуулагдсан сүү үйлдвэрлэгчдийн бүлэг / хоршоодын тоо: (2022 оны байдлаар)
Төлөвлөгөөний зорилт	• Дотоодод үйлдвэрлэж буй түүхий сүүний албан ёсны сувагаар цуглуулан авах, борлуулах хэмжээг нэмэгдүүлнэ. • Эхний жил зорилтот бүсэн албан ёсны сувагаар сүү цуглуулан авах хэмжээ: 40,000 тонноос 1.5дахин нэмэгдэнэ. (2024 оны үзүүлэлт) • Эхний жилд зорилтот бүсэд сүү хамтран нийлүүлэх зорилгоор байгуулагдсан сүү үйлдвэрлэгчдийн бүлэг / хоршоодын тоо 50% нэмэгдэнэ.
Хамрах хүрээ	УБ хот ба түүний ойр орчмын сүү үйлдвэрлэгч олноороо оршин суудаг бүс нутгийг (Төв аймаг) нэн түрүүнд, тэрчлэн Дархан-Уул аймаг, Орхон аймаг, Сэлэнгэ аймгийг зохих хэмжээнд хамруулаад явна. (сүү цуглуулагч ААН-үүдийн урьд нь нээсэн сүү цуглуулах маршрутын ойролцоо нь байвал сайн.)
Хүлээх үр дүн	(1) Албан ёсны сүү цуглуулах үйлдвэрт нийлүүлэх үйлдвэрлэгчдийн тоо өснө. (2) Албан ёсны сүү цуглуулах үйлдвэрээр дамжуулсан сүүний үйлвэрлэлийн хэмжээ нэмэгдэнэ. (3) Сүүний чанар сайжирна. (4) Сүү үйлдвэрлэгчийн орлого тогтворжино (5) Ирээдүйд сүүн бүтээгдхүүн экспортлох боломжтой болно.(ялангуяа сарлагийн сүү, ингэний сүү зэрэг ховор сүү)
Үйл ажиллагаа	(1) Үйлдвэрт түүхий сүү нийлүүлэх сонирхолтой сүү үйлдвэрлэгчдийн бүлэг болон хоршоолол байгуулах төлөвлөгөөг боловсруулах ажлыг ХХААХҮЯ-ны МААБХЗГ гардан, аймаг сумын ХХААГ ба мэргэжилтнүүдтэй хамтран гүйцэтгэнэ. Уг төлөвлөгөөг боловсруулахдаа дараах зүйлүүдийг харгалзана үзнэ. 1) Одоогийн сүү цуглуулах маршрутаас нэг их алслагдаагүй олон тооны үйлдвэрлэгчийг элсүүлэх боломжтой сумдыг сонгохыг хичээнэ. 2) 1)-ийн нөхцөлийг хангахгүй боловч сүү нийлүүлэх сонирхолтой үйлдвэрлэгч олонтой, их хэмжээний сүү үйлдвэрлэх боломжтой газрын хувьд сүү цуглуулах шинэ маршрут, сүү цуглуулах цэг шинээр нээх асуудлыг судалж үзнэ. 3) Энэ үед маршрут уртсах тохиолдолд сүү цуглуулах хөргүүр, эсвэл шинэ сүүний машин нийлүүлэх асуудлыг бас судалж үзнэ. 4) Үүний хамт энэхүү төлөвлөгөөг Засгийн газраас хэрэгжүүлэхээр төлөвлөж буй сүүний үйлдвэрлэлийг хоёр дахин нэмэгдүүлэх төлөвлөгөөний (≒ Цагаан хувьсгал) нэг хэсэг болгон авч үзэх боломжийг судалж үзнэ.

<table>
<tr><td></td><td colspan="2">(2) Хамрагдах магадлалтай үйлдвэрлэгчдэд танилцуулга хийнэ.
Гишүүн болсон тохиолдолд сэтгэл зүрхээ зориулж ажиллах учиртайг сайтар тайлбарлаж ойлгуулна. ХХААХҮЯ-ны зүгээс ерөнхий танилцуулгыг хийж, аймаг,сумын ХХАА хариуцсан ажилтан, эсвэл ААН-ийн төлөөллөөр нарийвчилсан тайлбар хийлгэнэ. Мөн сүү нийлүүлэх бүлгийн өдөр тутмын ажлыг бүлгийн гишүүд өөрсдөө удирдан зохион байгуулж явах тул эртнээс сүү нийлүүлж ирсэн бүс нутгийн бүлгийн ахлагчийг урьж, яриа хийлгэн туршлагаас нь суралцах нь зүйтэй.
(3) Албан ёсны сувгаар сүү нийлүүлэхэд шаардлагатай шинэ технологи эзэмших сургалт, технологи нэвтрүүлэлтийг дэмжих үйл ажиллагаа.
ААН, байгуулга, МЭЕГ-ын мэргэжилтнүүд хамтран саалийн техник болон сүүний эрүүл ахуйн сургалт зохион байгуулна. Ингэхдээ өнөө хүртэл олон үйлдвэрлэгчдэд хүрээгүй байгаа мэдлэгийг агуулсан сургалт зохион байгуулж хуучин үйлдвэрлэгчдийг бас хамруулна. (Сургалт явуулж болох сэдэв: Сүү саах үед гар, сүүний савыг угаах ба хатаах, сүү хуримтлуулах ба температурын хяналт, түүхий сүүн дэх эмийн үлдэгдэл, үхрийн стресс ба сүүний эрүүл ахуй, хялбар материал (сүүний хөнгөн цагаан сав, шүүлтүүр гэх мэт) ашиглан түүхий сүүний чанарыг хадгалах гэх мэт)
(4) Сүү цуглуулах үйл ажиллагааг эхлэх
Монголд түүхий сүүний үйлдвэрлэл улирлын шинж чанартай явагддаг, өвлийн улиралд сүүний гарц эрс багасдаг боловч хагас эрчимжсэн фермийн аж ахуйд хавар эрт 2-3 сараас эхлэн өвөл болох (11 сар) хүртэл үхэр саах боломжтой. Гэхдээ өвлийн улиралд сүүний компани сүү цуглуулах маршрутаа (сувагаа) хааснаас малчид үхрээ саасан ч борлуулах аргагүй байдалд ордог. Иймд төрийн байгуулга нь энэ байдлыг засах үүднээс нийлүүлэлтийн тогтолцоог сайжруулах асуудлыг авч үзнэ. Мөн зуны улиралд саалийн хэмжээ эрс нэмэгдэн сүүний үнэ буудаг тул ЗГ үүнийг нөхөх үүднээс үйлдвэрлэгчдээс ердийн үнээр худалдаж авахаар зохицуулан, сүүний компани хямдхан худалдан авсан илүүдэл сүүг хуурай сүү болгох ажлыг хөхүүлэн дэмжинэ. Ингэснээр том хотуудын хэрэглэгчид зуны улиралд импортын хуурай сүүнээс хамаарах нь багасна.
(5) ХХАААҮЯ, сум, сүүний компаниуд тогтмол хугацаанд хяналт шинжилгээ, үнэлгээ хийнэ.
Дээрх байгуулгууд тухайн төлөвлөгөөний хэрэгжилтэд тогтмол хугацаанд хяналт шинжилгээ, үнэлгээ хийж, түүний үр дүнг нэгтгэн холбогдох талуудтай хуваалцан, дараачийн шинэ маршрут сонгохдоо ашиглана.</td></tr>
<tr><td>Санхүүжилт</td><td><u>Засгийн газар</u>
• Шинэ тоног төхөөрөмж (сүү цуглуулах хөргүүр,шинэ сүүний машин зэрэг) худалдан авах үед татвараас чөлөөлөх арга хэмжээ
• Технологийн сургалгч багш томилох
• Татаас, зээлийн хөнгөлөлтийн арга хэмжээ: Зохион байгуулалтад орсон үйлдвэрлэгчид олгох түүхий сүүний үйлдвэрлэлийн татаас, зохион байгуулалтад орсон үйлдвэрлэгч өвлийн улиралд сүү нийлүүлэх үеийн тээврийн зардлын дэмждэг,зээлийн хөнгөлөлт</td><td><u>Хувийн хэвшил</u>
• Тоног төхөөрөмж (сүү цуглуулах шинэ цэгийн сүү цуглуулах хөргүүр, сүүний машин (байдал болон улирлаас хамаарна шийднэ, дундаа хэрэглэж болно)
• Түрээсээр олгох сүүний хөнгөн цагаан сав (дундаа хэрэглэж болно)
• Сүү хамтран нийлүүлэх үйлдвэрлэгчдийн бүлэг байгуулах нөхцөлийг хангасан үйлдвэрлэгчийг сонгох (50-100 хүн нэг бүлэг)</td></tr>
<tr><td>Төслийн өртөг</td><td colspan="2">Төслийн нийт өртөг: 77 тэрбум 400 сая төгрөг (29,463,000 USD)</td></tr>
<tr><td>Ашиг, үр нөлөө</td><td colspan="2">• Монголын дотоодын сүүний үйлдвэрлэлийн хэмжээ сүүлийн 10 жилд өсөх хандлагатай явж ирлээ. 2019 онд 1 сая тноос давсан бөгөөд энэ нь албан ёсны сувагаар борлуулсан сүүний хэмжээ юм. Томоохон сүү сүйлдвэрлэгч компаний тооцоогоор бодит байдал дээр үүнээс 8-9 дахин их сүү үйлдвэрлэсэн байх магадлалтай. Иймд энэ төслийг хэрэгжүүлснээр 2023 оноос хойш албан ёсны сувагаар цуглуулах сүүний нэмжээ нэмэгдэнэ гэж үзэж байна.
• Мөн энэхүү төслийг хэрэгжүүлснээр улирал хоорондын үйлдвэрлэлийн хэмжээний ялгаа багасна гэж үзэж байна.</td></tr>
<tr><td>Бодлогын бичиг</td><td colspan="2">1. Алсын хараа 2050: 3.1.1 ХАА-н түүхий эд, бүтээгдхүүний чанарыг дээшлүүлнэ.</td></tr>
</table>

баримттай уялдсан байдал	2. УИХ-ын 2022 оны 36-р тогтоолын хавсралт:4.2.1: Мал, малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүн, түүхий эдийн зорилтот зах зээлийг хөгжүүлэх, бэлтгэн нийлүүлэлт, анхны шатны боловсруулалт, борлуулалтын зохих сүлжээг бий болгох, жишиг хоршоодыг байгуулах, өөрчлөн зохион байгуулах, зохион байгуулалтад оруулах ажлыг цогцоор нь явуулахад дэмжлэг үзүүлэх. 3. УИХ-ын 2022 оны 36-р тогтоолын хавсралтын 5.1.1 2: ХАА-н түүхий эдийг дотооддоо боловсруулан эцэсийн бүтээгдхүүн үйлдвэрлэх, дотоодын зах зээл дээр борлуулсан чанар, эрүүл ахуйн шаардлага хангасан бүтээгдхүүнд урамшуулал олгох тогтолцоог бэхжүүлэх 4. ХХААХҮЯ-наас хэрэгжүүлэх гэж байгаа сүүний үйлдвэрлэлийг хоёр дахин нэмэгдүүлэх төлөвлөгөөнд (цагаан хувьсгал) нягт уялдаж байгаа. 5. Ерөнхийлөгчийн санаачилсан хүнсний хувьсгал үндэсний хөдөлгөөний үзэл баримтлалд нийцэж байгаа.
Төслийг хэрэгжүүлэхдээ анхаарах зүйлс	• Ихэнх үйлдвэрлэгчид хагас нүүдлийн амьдралтай, бэлчээр сэлгэн нүүж явдаг бөгөөд малаа таргалуулах, сааль сүү арвин авахын тулд хангалттай өвс тэжээлтэй болох шаардлагатай байдаг. Иймд цаг агаарын таагүй нөхцөл байдал зэрэг шалтгаанаар өвс тэжээлтэй бэлчээр хайж жил бүр өөр өөр газар нүүн сүү боловсруулах компаний тогтоосон сүү цуглуулах маршрутаас холдон одох тохиолдолд яах вэ гэдгийг хоёр тал ярилцан зохицуулах шаардлагатай (тээвэр, нийлүүлэх сүүний хэмжээг хэрхэн зохицуулах, сүүний савыг хэрхэн буцааж өгөх гэх мэт).

Төслийг хэрэгжүүлэх хуваарь, төсөв.

Үйл ажиллагаа		2023	2024	2025	2026	2027	2028	2029	2030	2031	2032	Нийт
(1) Үйлдвэрт сүү нийлүүлэх сонирхолтой сүү үйлдвэрлэгчдийн бүлэг болон хоршоолол байгуулах төлөвлөгөөг хувийн хэвшлийн сүү боловсруулах компани төрийн байгуулгатай (ЗГ ба сумын захиргаа) хамтран боловсруулна.												
(2) Хамрагдах магадлалтай үйлдвэрлэгчдэд (малчдад) танилцуулга хийнэ.												
(3) Үйлдвэрлэгчдийг (малчдыг) зохион байгуулалтад оруулах замаар сүү цуглуулах (орчин үеийн үйлдвэрүүдэд сүү ачуулах татаас (500 төгрөг/литр) болон шаардлагатай тоног төхөөрөмж худалдан авах зардал) ажлыг эхлүүлнэ.												
(4) Сүүн бүтээгдэхүүнийг төрөлжүүлэн хөгжүүлэх үүднээс гэрийн тэжээмэл амьтны хоол хүнс үйлдвэрлэх асуудлыг судалж үзнэ.												
Төслийн өртөг	сая төгрөг	100	8,600	8,600	8,600	8,600	8,600	8,600	8,600	8,600	8,500	77,400
	мян. ам.дол	44	3,273	3,273	3,273	3,273	3,273	3,273	3,273	3,273	3,235	29,463

Тэмдэглэл: MONMAP-AVC: Үйлдвэр цехэд сүү хүлээн авах тогтолцоог бэхжүүлэх замаар сүүний байнгын үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх төлөвлөгөө



Жилийн турш сүү нийлүүлсэн дундаж тоо（удаа）болон нийлүүлэлтийн дундаж хэмжээ（кг）（$n=17$хүн）

Энэхүү туршилтын төслийг ХХААХҮЯ-ны мэргэжилтны удирдлага, зааврааp, MONMAP төсөл, сүү боловсруулагч томоохон ААН-үүдтэй хамтран ажиллаж хэрэгжүүлсэн болно. Дээр өгүүлсэнчлэн хүн амын хагасаас илүү нь бөөгнөрсөн монголын хамгийн том Улаанбаатарын хүн амыг аюулгүй хүнсээр хангах нь монголын хүнсний ханган нийлүүлэлтийн сүлжээний үндсэн зорилт юм. Ялангуяа сүүний хувьд удаан хадгалах боломжгүй түүхий сүүний нийлүүлэлт бэрхшээлтэй, үйлдвэрлэгчид нь хот орчимд бөөгнөрөх хандлагтай, бэлтгэн нийлүүлэх тогтолцоо байхгүйгээс чанарын шаардлага хангасан хангалттай хэмжээний сүү нийлүүлэхэд хүндрэлтэй байсан. Ингээд энэ төслийн хүрээнд сүү цуглуулах хэмжээгээ нэмэгдүүлэхийг зорьж буй ААН-тэй хамтран ажиллаж, ААН -ийн зүгээс сүү нийлүүлэх сонирхолтой үйлдвэрлэгчдийн бүлгийн зохион байгуулалтыг дэмжиж, төслийн зүгээс бүлгийн гишүүн малчдад сааль авах, сүү нийлүүлэхэд шаардлагатай хялбар тоног төхөөрөмж нийлүүлэн, ингэснээр сүүний нийлүүлэлт өсөх эсэхийг тандан судалсан болно.Судалгааны хүрээнд 2012 онд урьд нь сүү нийлүүлэгчдийн бүлэгт нэгдээд байсан 20 малчинд сүүний хөнгөн цагаан сав, шүүлтүүр, олс зэрэг хямд энгийн төхөөрөмж өгсөн. Ингээд 2022 оны эхнээс судалгаагаа эхэлж сар бүрийн сүүний нийлүүлэлтийн үзүүлэлтийг цуглуулан, 2021 оны үзүүлэлттэй харьцуулж үзэхэд дээрх графикт харуулсанчлан судалгааны явцад гурван малчин бүлгээс гарсан бөгөөд үлдсэн малчдын сүүний нийлүүлэлтийн хэмжээ 33% өсөж, нийлүүлэлтийн давтамж 14%-иар нэмэгдсэн дүн гарсан болно. Энэ талаар сүүний үйлдвэрийн ажилтантай санал солилцоход “Шинэ бүлэг байгуулахад нийлүүлэлтийн хэмжээ өсөх нь зүйн хэрэг боловч энэ удаад хөнгөн цагаан сав, тоосны шүүлтүүр зэрэг энгийн төхөөрөмж нийлүүлснээр түүхий сүүний чанар баталгаажиж, хаягдал багассан үр нөлөө ч гарлаа.” гэж ярьж байсан юм. Иймд сүү нийлүүлэх малчдын бүлгийн зохион байгуулалтыг дэмжих бодлогын түвшний арга хэмжээ болон саалийн зохистой технологи, тоног төхөөрөмж нэвтрүүлэх гэх мэт ажлын талбар дахь сайжруулах арга хэмжээг хослуулсан хандлага цаашид ч үр нөлөөтэй гэж үзэж байна.

Сүү нийлүүлэх малчдын бүлэгт төслөөс тоног төхөөрөмж олгов: Сүүний сав (Зүүн), шүүлтүүр болон бусад

4.2.5 Ноос ноолуур, арьс ширний нийлүүлэлтийн сүлжээг бэхжүүлэх хөтөлбөр

Монгол Улсын хувьд ноос ноолуур, түүхий арьс шир нь хамгийн элбэг түүхий эдийн нэг юм. Хөгжүүлэх гол асуудал нь 1.Ноос ноолуурын түүхий эдийг чанарыг хадгалан боловсруулах үйлдвэрт нийлүүлэх тогтолцоо бүрдүүлэх, 2. Ноос ноолуур, арьс шир боловсруулах үйлдвэрийн техник хэрэгслийг шинэчлэх, сайн чанарын хагас болон бэлэн бүтээгдэхүүн үйлдвэрлэхийг дэмжих 3. Хүрээлэн байгаа орчин болон амьтны тавлаг байдлыг хангасан хандлагыг бүтээгдэхүүндээ шингээх чадвартай аж үйлдвэрийн хүний нөөцийг сургах зэргийг дурьдаж болно.

	Орц	Үйлдвэрлэл	нийлүүлэлт	Боловсруулалт	Борлуулалт, хэрэглээ
Оролцогч	Тэжээлийн худалдаачид, малын эмч, МАА-н асуудал хариуцсан тарийн байгууллагын төлөөлөл, малын эм нийлүүлэгчид	Малчид, малчдын хоршоо, МАА-н чиглэлийн ААН	Угаах ААН, утас үйлдвэрлэгч, хувцас, арьс ширэн эдлэлийн үйлдвэр	Экспортогч ААН, ноос арьс шир боловсруулагч ААН	Экспортлогч компани, хувцасны жижиглэнгийн дэлгүүр
Гол бэрхшээл	Тархмал амьдралтай малчид, ААН-ийн харилцаа дутмаг, ноос ноолуурын чанартай үүлдрийн сонгон үржүүлэг хангалттүй	Хөгширсөн малын тоо ихсэж ноолуурын микрон бүдүүрч, чанар муудаж байна. Механик гэмтлийн улмаас үүсэх эсгэлт, шимэгчийн улмаас арьс нүхжих зэрэг арьсны хорогдол их, бүтээгдэхүүний үнэ цэнийг унагадаг	Түүхий ноосны анхан шатны арчилгаа (чанараар нь ангилан ялгах) хийлгүй нийлүүлдэг. Түүхий арьсны хадгалалтын нөхцөл муу, бүтээгдэхүүний үнэ цэнийг бууруулдаг	Чанартай ноос, арьс шир худалдан авахад хүндрэлтэй. Боловсруулах техник хэрэгсэл хуучирсан. Байгал орчинд ээлтэй бүтээгдэхүүн боловсруулахад технологи хоцрогдсон	Чиг хандлагын (орчны асуудал, амьтны тавлаг байдал) мэдрэмжтэй хүний нөөц дутагдалтай.
Авах арга хэмжээ	5.1 Малын үүлдэр угсааг сайжруулах тогтолцоо бүрдүүлэх төлөвлөгөө 5.2. Малчдын хоршоонд түшиглэсэн ноос, арьс ширний бэлтгэн нийлүүлэлтийн сүлжээг бэхжүүлэх төлөвлөгөө 5.3. Сүлжмэл, арьс ширний тогтвортой үйлдвэрлэлийн тогтолцоо бүрдүүлэх төлөвлөгөө 5.4. Ноос, арьс ширний салбарын хүний нөөцийг сурган бэлтгэх төлөвлөгөө				

Зураг 4.6 Ноос ноолуур, арьс ширний нийлүүлэлтийн сүлжээг бэхжүүлэх хөтөлбөр

Эх сурвалж: Жайка төслийн баг

Монгол Улсын хувьд ноос ноолуур, арьс шир нь хамгийн элбэг түүхий эдийн нэг төдийгүй үнэ цэнэтэй бүтээгдэхүүн болгох боломж хамгийн ихтэй түүхий эд юм. Экспортын боломжтой бүтээгдэхүүн болох хүлээлттэй түүхий эд боловч зах зээлд өрсөлдөх чадвар сайтай гэж хэлэх аргагүй, нийлүүлэлтийн сүлжээг нийтэд нь шинэчлэн сайжруулах зайлшгүй шаардлагатай гэж үзэж байна. Бүр тодруулбал 1.Ноос ноолуурын чанарыг сайжруулахын тулд үүлдэр угсааг сайжруулах тогтолцоо бүрдүүлэх, 2. Ноос ноолуур, арьс ширний бэлтгэн нийлүүлэлт, хангамжийн тогтолцоог сайжруулах, 3. Ноос ноолуур, арьс ширний боловсруулах технологийг сайжруулах, 4. Ноос ноолуур, арьс ширний салбарын хүний нөөцийг хөгжүүлэх зэрэг арга хэмжээнүүдийг хөгжлийн гол зорилт болгох боломжтой. Доорхи хүснэгтэд Зураг 4.6-д үзүүлсэн төлөвлөгөө, хөгжлийн чиглэл болон хамаарлыг харууллаа.

Хүснэгт 4.5 Ноос, арьс ширний нийлүүлэлтийн сүлжээг бэхжүүлэх, хөгжлийн чиглэлийн хамаарал

	Бодит бэрхшээл, давуу тал, хөгжлийн бодлогын чиглэлийн агуулга	**Ноос, арьс ширний нийлүүлэлтийн сүлжээг бэхжүүлэх хөтөлбөрийн хүрээнд авах арга хэмжээ: 4 төлөвлөгөө**			
		5.1	**5.2**	**5.3**	**5.4**
Хөгжлийн чиглэл 1	1-2-1 Малын үүлдэр угсааг сайжруулах тогтолцоо бүрдүүлэх	◎			
	1-2-2 Малын эмч, мал зүйчийн сургалт	○			
	1-2-3 Малчид хамтран өсвөр мал (хурга) бордох ажлыг дэмжих				
	1-2-4 Бэлтгэл, анхан шатны боловсруулалтын техник хэрэгслээр хангах, технологийн сургалт хийх	○	◎		

1-2-5 Маллагааны зохистой арга түгээн дэлгэрүүлэх (нэвтрүүлэх)	○	○		
1-2-6 Мал төхөөрөх газрууд байгуулахыг дэмжих				
1-2-7 Малын дайвраар ГТА-ны хоол хийх үйлдвэрлэлийг хөгжүүлэх				
1-2-8 Малчдын хоршоонд түшиглэсэн ноос ноолуур, арьс шир, сүү бэлтгэн нийлүүлэх тогтолцоо бүрдүүлэх		◎	○	
1-2-9 Аж үйлдвэрийн хүний нөөц (Мах боловсруулах, ээрмэл, арьс шир)-ийг сургах			○	◎
1-2-10 Мөшгих тогтолцооны мөрдөлтийг сайжруулах	○		○	
1-2-11 Зах зээлийн хэрэгцээнд нийцсэн махны ангиллыг нэвтрүүлэх, бренджүүлэх				○
1-2-12 Аялал жуулчлалтай хамтран бэлэг дурсгал хийх				
1-2-13 Кластер хөгжүүлэлт		○	◎	○

Эх сурвалж: Жайка төслийн баг ○ : Өндөр хамааралтай, ◎ : Хүчтэй хамааралтай

Төлөвлөгөөнүүдийн товч агуулгыг доор сийрүүлэв.

“**5.2 Малчдын хоршоонд түшиглэсэн ноос ноолуур, арьс шир бэлтгэн нийлүүлэлтийн сүлжээг бэхжүүлэх төлөвлөгөө”** нь ноос арьс ширний үйлдвэрлэлийн бааз болох малчдын хоршоонд суурилсан ханган нийлүүлэлтийн бааз суурийг бүрдүүлэх тухай юм. Малчид бэлтгэсэн ноос ноолуур, арьс ширээ хувиараа ченжүүдэд худалддаг хэлбэрийг аажмаар малчдын хоршоо нь нэгтгэн цуглуулж нийлүүлдэг тогтолцоонд шилжих, ноос арьс ширний хэрэглэгч үйлдвэр, ААН-үүдийн шаарддаг чанарыг хангасан түүхий эд бэлтгэх тогтолцоог бүрдүүлэх юм. Тэгэхийн тулд малчдын хоршоо нь түүхий эдэд нэмүү өртөг шингээх арга хэмжээг авах (түүхий эдийн анхан шатны ангилан ялгах), түүндээ ашиглах байр сав,тоног төхөөрөмж (цахилгаан хайч, ноос пресслэгч, агуулах) хэрэгтэй болно. Малчдын загвар хоршоог НҮБ-ийн аж үйлдвэрийн хөгжлийн байгууллага-UNIDO зэрэг хөгжлийн түншлэгчдийн тусламжийн төслөөр байгуулсан бөгөөд тэр загварыг орон даяар түгээн дэлгэрүүлэх төлөвлөгөө юм.

“**5.3 Нэхмэл, арьс ширний үйлдвэрлэлийн тогтвортой систем бүрдүүлэх төлөвлөгөө**” нь 2021 онд батлагдсан “MNS 6926:2021- Нэхмэлийн тогтвортой үйлдвэрлэлийн стандарт”-ыг мөрдүүлэхийн тулд шаардлагатай тоног төхөөрөмжийн хөрөнгө оруулалтын дэмжлэг үзүүлэх, түүхий ноос, түүхий арьс шир боловсруулах хуучирч муудсан техникийг шинэчлэх болон байгаль орчинд ээлтэй бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн технологийг нэвтрүүлэх ажлыг эрчимжүүлэх зорилготой төлөвлөгөө юм. Хойшид, нэхмэл болон арьс, ширэн бүтээгдэхүүн үйлдвэрлэхдээ байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөг бууруулсан “үйлдвэрлэл” нь ОУ-ын стандартад нийцсэн байх нь дэлхийн зах зээлд өрсөлдөх чадвараа бэхжүүлэхэд чухал нөлөө үзүүлэх, заавал хийх асуудал учраас түүхий ноос, арьс шир, ялангуяа угаах, самнах, хяргах, утас ээрэх хэмжээнд хүртэл боловсруулах шат дамжлагын тоног төхөөрөмжийн санхүүжилт болон технологи нэвтрүүлэлтийг дэмжих. Харин арьс ширний тухайд, уламжлалт хромон идээлэг дээр нэмээд ургамлын хандан идээлэг хийх технологийг нэвтрүүлэхийг дэмжих, үүний зэрэгцээ технологи нэвтрүүлэхэд шаардлагатай ухмал гандах сав болон бусад тоног төхөөрөмжөөр

тоноглох.

“**5.4 Нэхмэлийн салбарын аж үйлдвэрийн кластер хөгжүүлэх төлөвлөгөө”** нь илүү өрсөлдөх чадвартай ноос, арьс ширэн хагас боловсруулсан болон эцсийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл болон экспортыг дэмжхийн тулд тус салбарын кластер хөгжүүлэлтийг дэмжих төлөвлөгөө юм. Экспортын гол бүтээгдэхүүн болох ноос, ноолуурын тухайд одоогийн байдлаар түүхий эдийн 90-с илүү хувийг угааж боловсруулсан байдалтай экспортлож байгаа ба дотооддоо боловсруулах түвшинг ахиулж, илүү нэмүү өртөг өндөртэй бүтээгдэхүүн экпортлохыг дэмжих шаардлагатай байна. 2024 онд угаасан ноолуурын экспортод хориг тавих арга хэмжээ авах магадлалтай байгаа ба текстилийн дотоодын боловсруулалтын түвшинг ахиулах Монгол Улсын ЗГ-ийн оролдлогод тогтвортой ахиц гарч байна. Нөгөөтэйгүүр, ээрэх үйлдвэрүүдийн тоо цөөн, тоног төхөөрөмж элэгдэлд орсон байна. Үүнээс үүдэн, МУ-ын дотоодын бэлэн хувцас үйлдвэрлэлд шаардлагатай чанар, стандартын утасны нийлүүлэлт хангалтгүй байгаа ба энэ нь нэхэх сүлжих үйлдвэрлэлийн салбарын хөгжилд гол саад болж байна. Тус төлөвлөгөөнд нэхмэлийн боловсруулах процесс, тэр дундаа ээрмэлийн салбар дахь төрийн дэмжлэгийг чадавхижуулахын зэрэгцээ, нэхмэлийн үйлдвэрлэлийн анхан (түүхий эд бэлтгэл), дунд (угаах, хяргах, самнах, утас ээрэх), эцсийн (бэлэн хувцас гэх мэт эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх) шатны боловсруулагчид болон дотоодын их сургууль, судалгааны болон санхүүгийн байгууллага зэргийн хамтын ажиллагааг бэхжүүлэх зорилготойгоор кластер хөгжүүлэлтийг дэмжинэ.

Түүнчлэн ”5.1 Малын үүлдэр угсааг сайжруулах тогтолцоо бүрдүүлэх төлөвлөгөө нь “Мах сүүний нийлүүлэлтийн сүлжээг бэхжүүлэх хөтөлбөрт дурьдсантай ижил агуулгатай тул энд товчлов.

(1) Малчдын хоршоонд түшиглэн ноос ноолуур, арьс ширний нийлүүлэлтийн сүлжээг бэхжүүлэх төлөвлөгөө

ҮАТ 5.2: Малчдын хоршоонд түшиглэсэн ноос ноолуур, арьс ширний нийлүүлэлтийн сүлжээг бэхжүүлэх төлөвлөгөө	
Төлөвлөгөөний зорилт	Малчдын хоршооны ноос ноолуур, арьс шир бэлтгэн нийлүүлэх, ангилан ялгах чадварыг бэхжүүлэх замаар үйлдвэрлэл, түгээлт/нийлүүлэлтийн/ шатанд чанарыг бууруулаад байгаа ноос, арьсны чанарыг сайжруулах.
Төлөвлөгөөний зорилго	Бүтэц зохион байгуулалтын хувьд бэхэжсэн малчдын хоршоогоор дамжуулан доорхи сайн чанарын ноос ноолуур, арьс шир дотоодын боловсруулагдах үйлдвэрүүдэд нийлүүлэгдэнэ. Ноос: 96 тн (1 сумын хониноос авах ноосны дундаж хэмжээ)×100 хоршоо=9,600 тн Ноолуур: 28 тн (1 сумын ямаанаас авах ноолуурын дундаж хэмжээ)×100 хоршоо =2,800 тн Үхэр, хонь, ямааны арьс шир: 10,000 ширхэг (1 сумаас дунджаар бэлтгэгдэж байгаа арьс ширний тоо)×100 хоршоо＝1,000,000 ширхэг
Суурь түвшин	Одоогийн байдлаар, малчнаас ноос ноолуур, арьс ширийг цуглуулж нийлүүлэх, нэмүү өртөг шингээгээд нийлүүлэх үйл ажиллагаа эрхэлдэг малчдын хоршоо цөөхөн байна. Таамаглаж байгаагаар: Ноос: 50 тн (ойролцоогоор), Ноолуур: 5 тн (ойролцоогоор), Үхэр, хонь, ямааны арьс шир: 3000 ш (ойролцоогоор)

Төлөвлөгөөний хамрах хүрээ	Орон даяар, бүх аймагт	
Хүлээх үр дүн	(1) Төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд шаардлагатай систем болон хэрэгжүүлэх журам боловсруулах, бүх аймаг сумдын ХХААГ-ын хариуцсан мэргэжилтнүүдэд уг систем, хэрэгжүүлэх журмыг тайлбарлах. (2) Төсөлд хамрагдах 10 газрын малчдын хоршоог сонгох. (3) Сонгогдсон 10 хоршоонд техник хэрэгсэл нийлүүлэх, технологийн сургалт хийх зэрэг туршилтын /загвар/ төслийг хэрэгжүүлэх. (4) Загвар төслийн үр дүн, сургамжийг сийрүүлэн, аймгуудын ХААГ-ын хариуцсан мэргэжилтүүдэд танилцуулах. (5) Цаашдаа, 90 газарт малчдын хоршоог сонгон, техник хэрэгсэл олгож, технологийн сургалт явуулах.	
Үйл ажиллагаа	(1) Төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд шаардлагатай систем болон хэрэгжүүлэх журам боловсруулах, бүх аймаг сумдын ХААГ-ын хариуцсан мэргэжилтнүүдэд уг систем, хэрэгжүүлэх журмыг тайлбарлах. ХХААХҮЯ-ны МААБХЗГ, ХөҮБХЗГ, ЖДҮГ голлон ЖАЙКА, ШХА, НҮБ-ын АҮХБ-ын хэрэгжүүлсэн ижил төстэй төслөөс санаа авч, энэ төлөвлөгөөг хэрэгжүүлэх системийн схем / төсөл/ хэрэгжүүлэх журмыг боловсруулна. Уг систем, журмын талаар аймаг сумдын ХААГ-ын хариуцсан мэргэжилтнүүдэд тайлбарлах хурал зохион байгуулах. (2) Төсөлд хамрагдах 10 байршилд малчдын хоршоог сонгох. Монголын ноосны болон арьс шир, ноос ноолуурын холбоо, Монголын ХАА-н хоршооллогчдын холбоодтой зөвлөлдөж, харьцангуй сайн чанарын ноос, арьс ширтэй нутаг (бас сайн чанарын ноос, арьс шир гарах үүлдэр тархсан (малтай) бүс нутаг)-ийг сонгоно. Тухайн сонгогдсон бүсэд доор хаяж 10-с дээш жил ажилласан туршлагатай малчдын хоршоодоос 10-ыг сонгоно. Тухайн хоршоог холбогдох мэргэжлийн холбоод нь сонгож боловсруулах үйлдвэртэй зөвлөлдөж, ноос арьс ширний арилжааны талаар хамтын ажиллагааны гэрээ байгуулна. (3) Сонгогдсон 10 хоршоонд нь техник хэрэгсэл нийлүүлэх, технологийн сургалт хийх зэрэг туршилтын /загвар/ төслийг хэрэгжүүлэх. Ноос ноолуур, арьс ширний арилжаатай холбоотой төслийн хамтын ажиллагааны гэрээ байгуулсан 10 хоршоонд бэлтгэн нийүүлэх орон байраар хангах, техник хэрэгсэл нийлүүлэх, технологийн сургалт хийнэ. Тэгэхдээ бэлтгэн нийлүүлэх байр савны тухайд аль болохоор нэгдлийн үеийн худалдаа бэлтгэлийн ангийн байр савыг засаж тохижуулах, техник хэрэгслийн хувьд, цахилгаан хайч, преслэгч, зөөврийн генератор бусад материал зэрэг нэмүү өртөг шингээхэд хэрэгтэй зүйлсээр хязгаарлана. Сонгогдсон хоршооны удирдлага нь хандивлагчийн тусламжаар үйл ажиллагаа явуулж байгаа өмнө нь байгуулагдсан хоршооны үйл ажиллагаатай танилцахын хамт, түүхий арьс, ноосны бэлтгэн нийлүүлэлт, ангилан ялгалт, боловсруулалт болон хоршооны менежменттэй холбоотой сургалтад сууна. Эдгээрийг гүйцэлдүүлсний дараа ноос, арьс шир бэлтгэн нийлүүлэх туршилтын арилжаа эрхэлнэ. (4) Загвар төслийн үр дүн, сургамжийг сийрүүлэн, аймгуудын ХХААГ-ын хариуцсан мэргэжилтүүдэд танилцуулах. Дээрх загвар төслийн үйл ажиллагааны үр дүнг сийрүүлж, үр дүн, сургамжийг түүвэрлэнэ. Бас уг мэдээллийг аймгуудын ХХААГ-ын хариуцсан мэргэжилтнүүдэд явуулахын хамт, загварыг түгээн дэлгэрүүлэхэд чиглэсэн удирдамж боловсруулна. (5) Цаашдаа 90 байршилд сонгогдсон хоршоонд техник хэрэгсэл нийлүүлж, технологийн сургалт явуулна. Холбогдох мэргэжлийн холбоод болон Монголын ХАА-н Хоршооллогчдын холбоотой зөвлөлдөн 50 байршилд малчдын хоршоог сонгож загвар төслийн үр дүнд үндэслэн бэлтгэн нийлүүлэх байр сав, техник хэрэгсэл нийлүүлж, технологийн сургалт хийнэ.	
Санхүүжилт	<u>Засгийн газар</u> • Бэлтгэн нийлүүлэх байр болон техник хэрэгсэл худалдан авах зардал	<u>Хувийн сектор</u> • Техник хэрэгсэл худалдан авах зардлын зарим хэсэг

	• Хоршооны менежменттэй танилцах, технологийн сургалтын зардал • Аймаг сумдын ХААГ-ын мэргэжилтний томилолтын болон замын зардал	• Хамтран ажиллах гэрээ байгуулах үйл ажиллагаа /удирдлагын/ зардал
Төслийн өртөг	Төслийн нийт өртөг: 228 тэрбум 628 сая төгрөг (87,029,000 USD)	
Ашиг, үр нөлөө	Бүтэц зохион байгуулалтын хувьд бэхэжсэн малчдын хоршоо нь хамтран ажиллах гэрээ байгуулсан боловсруулах үйлдвэрт сайн чанарын түүхий эдээ худалдан борлуулснаар, төсөл хэрэгжихээс өмнөх үеийнхээс илүү үнээр түүхий эджж борлуулах боломж бүрдэнэ.	
Бодлогын баримт бичгүүдтай уялдаж буй байдал	1. Алсын хараа 2050 3.1.1 ХАА-н бүтээгдэхүүний түүхий эд болон бүтээгдэхүүний чанарыг сайжруулна. 2. Монгол Улсын Их Хурлын 36-р тогтоолын 4.2.1 МАА-н түүхий эдийн бэлтгэн нийлүүлэлт, анхан шатны боловсруулалт, арилжааны зохистой сүлжээ бүрдүүлэх загвар ХАА-н хоршоо байгуулах.	
Төслийг хэрэгжүүлэхэд анхаарах зүйлс	• Худалдан авах техник хэрэгсэл болон технологийн сургалтын агуулгын тухайд, НҮБ-ын АҮХБ-ын хэрэгжүүлсэн SECiM төслийн боловсруулсан техник хэрэгслийн жагсаалт, техник зааварчилгааг ашиглах • Хамтын ажиллагааны гэрээ байгуулсны дараа малчдын хоршоо боловсруулах үйлдвэрийн харилцаа саадгүй байхад анхаарч аймаг сумдын ХААГ-ын хариуцсан мэргэжилтэн нь тогтоосон хугацаанд үйл ажиллагааны мониторинг хийж байх.	

Төслийг хэрэгжүүлэх хуваарь, төсөв

Үйл ажиллагаа		**2025**	**2026**	**2027**	**2028**	**2029**	**2030**	**2031**	**2032**	**2033**	**2034**	**Нийт**
(1) Төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд шаардлагатай систем болон хэрэгжүүлэх журам боловсруулах, бүх аймаг сумдын ХААГ-ын хариуцсан мэргэжилтнүүдэд танилцуулах												
(2) Төсөлд хамрагдах 10 байршилд малчдын хоршоог сонгох.												
(3) Сонгогдсон 10 хоршоонд техник хэрэгсэл нийлүүлэх, технологийн сургалт хийх зэрэг туршилтын /загвар/ төслийг хэрэгжүүлэх.												
(4) Загвар төслийн үр дүн, сургамжийг нэгтгэн, аймгуудын ХААГ-ын хариуцсан мэргэжилтүүдэд танилцуулах.												
(5) Улмаар 90 байршилд малчдын хоршоог сонгож, техник хэрэгсэлээр ханган, технологийн сургалт хийх.												
Төслийн өртөг	сая төгрөг	25,001	20,363	26,471	26,471	24,435	24,435	20,363	20,363	20,363	20,363	228,628
	мян. ам.дол	9,520	7,751	10,076	10,076	9,301	9,301	7,751	7,751	7,751	7,751	87,029

Тэмдэглэл: Ноосны цахилгаан хяргагч машин болон преэсслэгч машин нэвтрүүлэх туршилт

Сүүлийн жилүүдэд Монгол Улсад малчдын тоо цөөрч, малын тоо толгой өссөний үр дүнд нэг нүүдэлчинд ногдох хөдөлмөрийн нэгж хэмжээ ойролцоогоор зургаа дахин нэмэгдсэн байна. Үүнтэй уялдуулан МАА салбарт ажлын үр ашгийг дээшлүүлэх, ажиллах хүн олж авахтай холбоотой асуудлууд тулгарах болсон. Ийм нөхцөлд Хэнтий аймгийн Баян-овоо сумын малчдын хоршоонд хяргах машин, ноос поесслэгчийг нэвтрүүлж, хяргах ажил, ноос тээвэрлэлтийн үр ашгийг дээшлүүлэх зорилгоор баталгаажуулах туршилтыг явуулав

Туршилтын дүнд хяргах машин ашиглах нь уламжлалт гар аргаар хяргахтай харьцуулахад хонь хяргах хугацааг 2-3 дахин багасгаж болохыг харуулсан. Мөн хяргасан ноосны хэмжээ гараар хяргаснаас их байгаа нь хяргах машиныг нэвтрүүлснээр малчдын хөдөлмөрийг хөнгөвчилж, ажлын чанарыгг сайжруулахад шууд хувь нэмэр оруулах нь тодорхой юм. Пресслэгч машины туршилтаар ноос тээвэрлэлтийн үр ашиг ноос ачих машинд ачих хэмжээнээс хамааран борлуулах угаах үйлдвэрт борлуулах үнэ өөр өөр байдаг нь харагдсан. Баян-Овоо сумаас хамгийн ойрхон ноос борлуулах цэг нь Хэнтий аймагт байдаг ч пресслэгч ашиглан нэг удаад их хэмжээний ноос тээвэрлэх боломжтой болсноос хойш 11,200 кг-аас дээш ачсан ноосыг Улаанбаатар хот руу тээвэрлэж борлуулах нь илүү ашигтай болох нь харагдсан. Ноос зарж илүү их ашиг олохын тулд худалдан авах үнэ, борлуулах үйлдвэр хүртэлх зай, машины даац чадал зэргийг харгалзан үзэж борлуулах газраа шийдэх нь чухал.



Ноос тушаах үйлдвэр ба борлуулалтын ялгаа (2023)

*Баян-овоо суманд нэг удаад 11,200 кг-аас дээш ноос тээвэрлэж, Улаанбаатар хотод борлуулахад (ачааны төрөл, тоо, түлшинд өөрчлөлт ороогүй гэж үзвэл) ашиг нь илүү байна

(2) Нэхмэлийн болон арьс ширний тогтвортой үйлдвэрлэлийн тогтолцоог бүрдүүлэх төлөвлөгөө

YAT 5.3: Нэхмэлийн болон арьс ширний тогтвортой үйлдвэрлэлийн тогтолцоог бүрдүүлэх төлөвлөгөө	
Төлөвлөгөөний зорилт	Ноос, арьс ширний боловсруулах ААН-д (ялангуяа ЖДҮ) MNS 6926:2021 “Нэхмэлийн тогтвортой үйлдвэрлэлийн стандарт”-ыг мөрдүүлэхэд шаардлагатай дэмжлэг үзүүлж, бүтээгдэхүүний дэлхийн зах зээлд өрсөлдөх чадварыг бэхжүүлж, дотоодын боловсруулалтын түвшинг нэмэгдүүлнэ.
Төлөвлөгөөний зорилго	Нэхмэл эдлэлийн ээрэх сүлжих, гүйцэтгэн боловсруулалт хийх ААН: 218 компани (2018 оны байдлаар)-ас 20% нь MNS 6926:2021 стандартын шаардлага хангасан байна. Арьс шир идээлэх болон элдэх боловсруулах 437 ААН-ийн (2023 оны байдлаар) 10% нь ургамлын гаралтай идээлэх технологи нэвтрүүлсэн байна.
Суурь түвшин	• Стандарт хангасан нэхмэл бүтээгдэхүүний ээрэх, сүлжих, гүйцээх боловсруулалт хийдэг ААН: 10 орчим хувь (таамаглаж буйгаар). • Ургамлын хандан идээлэг, элдүүрийн технологитой ААН: 3-5 орчим хувь (таамаглаж буйгаар).
Хамрах хүрээ	Орон даяар бүх аймагт
Хүлээх үр дүн	(1) Төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд шаардлагатай тогтолцоо болон хэрэгжүүлэх журам боловсруулж, аймгуудын ХХААГ-ын хариуцсан мэргэжилтгүүдэд уг тогтолцоо болон хэрэгжүүлэх журмыг тайлбарлах. (2) Бүх аймаг сумдад холбогдох боловсруулах үйлдвэрт зориулсан төслийн танилцуулга уулзалт зохион байгуулах. (3) Татаас авсан боловсруулах үйлдвэр нь сүлжмэл болон арьс ширний тогтвортой үйлдвэрлэлийн тогтолцоо бүрдүүлэхэд шаардлагатай байгууламж бэлтгэнэ.

	(4) Татаастай төслийн хүрээнд бэлтгэл хангасан боловсруулах үйлдвэрийн менежментийн байдалд үнэлгээ хийнэ.
Үйл ажиллагаа	(1) Төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд шаардлагатай тогтолцоо болон хэрэгжүүлэх журам боловсруулж, аймгуудын ХХААГ-ын хариуцсан мэргэжилтнүүдэд танилцуулах. ХХААХҮЯ, ХөҮБХЗГ, ЖДҮ голлон, MNS 6926:2021 стандарт боловсруулахад дэмжлэг үзүүлсэн ЕХ-ны STeP EcoLab төслийн ажилтныг оролцуулан энэ төлөвлөгөөтэй холбоотой тогтолцооны схем, хэрэгжүүлэх журмыг боловсруулах. Гэхдээ тогтолцооны схемийн хувьд голчлон 1) хуучин байгаа барилгын засвар хийх аргачлалыг тодорхойлох зорилготой зөвлөх үйлчилгээ авах, 2) Шинээр барих засварлахад гол дэмжлэг авах. Уг тогтолцоо, хэрэгжүүлэх журмын тухайд, бүх аймаг сумдын ХААГ-ын хариуцсан мэргэжилтэнд тайлбарлах семинар хийх. (2) Бүх аймаг сумдад холбогдох боловсруулах үйлдвэрт зориулсан төслийн танилцуулга уулзалт зохион байгуулах. Бүх аймаг сумдын ХААГ-ын хариуцсан мэргэжилтнүүд голлон хариуцсан нутаг дэвсгэрийн боловсруулах үйлдвэрт MNS 6926:2021-ийн агуулга, системийн талаар тайлбарлах уулзалт хийнэ. Мөн, уг бизнесийг сонирхож байгаа боловсруулах ААН-ээс өргөдөл хүлээн авах тогтолцоо бүрдүүлнэ. (3) Төсөлд хамрагдах ААН-ийн сонгох. Урьдчилан бэлтгэсэн байгууллагын схем,хэрэгжүүлэх журмын дагуу төсөлд хамрагдах ААН-ийг сонгоно. Сонголтын шалгуур үзүүлэлтийн тухайд ХХААХҮЯ, ХөҮБХЗГ,ЖДҮГ болон холбогдох мэргэжлийн холбоодтой зөвлөлдөж байж шийднэ. (4) Төслийн дараах мониторинг Төсөл дууссаны дараа сонгож оролцуулсан ААН-ээс төслийн үр дүнгийн тайлан гаргаж өгөхийг шаардана. Мөн, төсөл дууссанаас хойш тодорхой хугацаа өнгөрсний дараа бүх аймаг сумдын ХААГ-ын мэргэжилтнүүд мониторинг хийж, төслийн өгөөжийг дүгнэнэ.
Санхүүжилт	<u>Засгийн газар</u> • Зөвлөхийн зардал (дотаци) • Байр сав шинээр барих, засварлах зардал (дотаци) • Бүх аймаг сумдын ХААГ-ын мэргэжилтний замын зардал, зэрэг <u>Хувийн сектор</u> • Зөвлөхийн зардлын зарим хэсэг • Байр сав шинээр барих, засварлах зардлын зарим хэсэг • Төсөл хэрэгжүүлэхтэй холбоотой бусад зардал
Төслийн өртөг	Төслийн нийт өртөг: 13 тэрбум 863 сая төгрөг (5,277,000 USD)
Ашиг, үр нөлөө	Дэлхийн зах зээлд өрсөлдөх чадвар сайтай ноос, арьс ширэн эдлэл үйлдвэрлэх. Ингэснээр сүлжмэл, арьс ширэн эдлэлийн экспортлох хэмжээ экспортын орлого нэмэгдэж, сүлжмэл, арьс ширний аж үйлдвэрийн ААН-үүдийн орлог ашиг өснө.
Бодлогын бичиг баримттай уялдсан байдал	1. Алсын хараа 2050 4.2.7 Ноолуурын үйлдвэрлэлийг дэмжих, самнасан ноолуур болон эцсийн бүтээгдэхүүний экспортыг нэмэгдүүлэх. 2. Алсын хараа 2050 4.2.8 Мал, амьтны арьс шир, ноос ноолуурыг бүрэн боловсруулж сүлжмэл болон нэхмэл эдлэлийн экспортыг нэмэгдүүлнэ.
Төслийг хэрэгжүүлэхэд анхаарах зүйлс	• Энэ төлөвлөгөөг хэрэгжүүлэхдээ ЕХ-ны хэрэгжүүлсэн STeP EcoLab -ийн үйл ажиллагааг үнэлж, түүний холбогдох хүмүүстэй сайтар зөвлөлдсний үндсэн дээр хэрэгжүүлэх.

Төслийг хэрэгжүүлэх хуваарь, төсөв

Үйл ажиллагаа	2025	2026	2027	2028	2029	2030	2031	2032	2033	2034	Нийт
(1) Төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд шаардлагатай тогтолцоо болон хэрэгжүүлэх журам боловсруулж, аймгуудын ХААГ-ын хариуцсан мэргэжилтгүүдэд уг тогтолцоо болон хэрэгжүүлэх журмыг тайлбарлах.											

(2) Бүх аймаг сумдад холбогдох боловсруулах үйлдвэрт зориулсан төслийн танилцуулга уулзалт зохион байгуулах.												
(3) Төсөлд хамрагдах ААН-ийн сонгох.												
(4) Төслийн дараах мониторинг.												
Төслийн өртөг	сая төгрөг	660	1,467	1,467	1,467	1,467	1,467	1,467	1,467	1,467	1,467	13,863
	мян. ам.дол	255	558	558	558	558	558	558	558	558	558	5,277

(3) Нэхмэлийн үйлдвэрлэлийн кластер хөгжүүлэх төлөвлөгөө

YAT 5.4: Нэхмэлийн үйлдвэрлэлийн кластер хөгжүүлэх төлөвлөгөө	
Төлөвлөгөөний зорилт	Монгол Улсын нэхмэл бүтээгдэхүүний дотоодын боловсруулалтын түвшин, олон улсад өрсөлдөх чадварыг бэхжүүлэх, экспортын хэмжээг нэмэгдүүлэх зорилгоор нэхмэлийн үйл явц дахь утас ээрэх салбарыг чадавхижуулахын зэрэгцээ анхан шатнаас гүйцэтгэн боловсруулалт хүртэл нэхмэлийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг холбогдох байгууллагууд болон их дээд сургууль, судалгааны хүрээлэнгүүд, санхүүгийн байгууллагуудын хамтын ажиллагааг бэхжүүлэх зорилгоор нэхмэлийн үйлдвэрлэлийн кластер байгуулах.
Төлөвлөгөөний зорилго	2034 он гэхэд нэхмэл бүтээгдэхүүний нийт экспортын хэмжээ, экспортын дүнг (бэлэн хувцас, утас гэх мэт) дараах байдлаар нэмэгдүүлнэ. Ноосон утас (HS5109) экспортын хэмжээ: 20.2 тн, 1,285,775 ам.доллар. Хувцас хэрэглэлийн экспортын хэмжээ (HS61): 908 тн, 64,221,680 ам.доллар.
Суурь түвшин	• Ноосон утасны (HS5109) экспортын хэмжээ: 7.8 тн, экспортын дүн: 495,722 ам.доллар (2021). • Хувцас болон туслах материалын экспортын хэмжээ (HS61): 558 тн, экспортын дүн: 39,426,541 ам.доллар (2021).
Хамрах хүрээ	Орон даяар
Хүлээх үр дүн	(1) Нэхмэлийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг компаниудын байгууламжид оруулах хөрөнгө оруулалт (ээрэх тоног төхөөрөмж)-д зориулсан татаас, татвараас чөлөөлөх тогтолцоог бүрдүүлнэ. (2) Санал болгож буй тогтолцооны төслийн хувьд хувийн хэвшил болон нэхмэлийн үйлдвэрлэл эрхэлдэг холбогдох байгууллагуудтай санал солилцож, нэгтгэж гаргана. (3) Шинэ тогтолцоог ашиглаж эхэлнэ. (4) Тогтолцоог ашиглалтанд оруулсны дараа үйл ажиллагааг тогтмол мониторинг хийж, үр дүнг зохих журмаар үнэлнэ.
Үйл ажиллагаа	(1) Нэхмэлийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг компаниудын хөрөнгийн хөрөнгө оруулалт (ээрэх тоног төхөөрөмж)-д зориулсан татаас, татвараас чөлөөлөх тогтолцоог төлөвлөх. ХХААХҮЯ, ХөҮБХЗГ, ЖДҮГ голлон энэ төлөвлөгөөнд хамаарах тогтолцооны схем, хэрэгжүүлэх журам боловсруулах. Тогтолцооны схемийн тухайд, ихэвчлэн, 1) Ээрэх сүлжих, гүйцэтгэн боловсруулах салбарын техникийн хөрөнгө оруулалтад татаас олгох эсвэл бага хүүтэй зээл олгох тогтолцоог бий болгох, 2) Гадаадаас боловсруулах тоног, төхөөрөмж импортлохдоо импортын татвараас чөлөөлөх, 3) Зөвхөн 1 аж ахуйн нэгж, байгууллага бус түүхий эд бэлтгэлээс эхлээд эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэл хүртэл цогц нийлүүлэлтийн сүлжээг хамарч чадах ААН болон байгууллагыг хамруулах зорилгоор тус тогтолцоог боловсруулах. Тогтолцоонд хамрагдах ААН-д нэхмэлийн үйлдвэрлэлийн кластерийн төв компаний үүрэг гүйцэтгэх гэсэн шаардлага тавих. (2) Тогтолцооны схемийн талаар нэхмэлийн салбарт үйл ажиллагаа явуулдаг хувийн хэвшлийнхэн болон бусад холбогдох байгууллагуудтай санал солилцох. Нэхмэлийн салбарт үйл ажиллагаа явуулдаг ААН болон бусад холбогдох байгууллагуудад “үйл ажиллагаа (1)”-д гаргасан тогтолцооны схемийн төслийг тайлбарлах. Тус процессын явцад ирүүлсэн санал сэтгэгдэлд үндэслэн тогтолцоонд зохих

	өөрчлөлтүүдийг оруулах. (3) Шинэ тогтолцоог ашиглаж эхлэх. Тогтолцоог хэрэгжүүлж эхэлнэ. Хэрэгжүүлэх хугацаа нь ойролцоогоор 5-н жил байх ба энэ хугацаанд татаас олгох компаниудыг сонгон шалгаруулах зарыг жилд нэг удаа нээлттэйгээр явуулна. (4) Тогтолцоог нэвтрүүлсний дараа үйл ажиллагааг тогтмол мониторинг хийж, төслийн үр дүнг зохих ёсоор үнэлэх. Төсөл дууссаны дараа сонгож оролцуулсан ААН-ээс төслийн дуусгавар тайлан гаргаж өгөхийг шаардана. Мөн, төсөл дууссанаас хойш тодорхой хугацаа өнгөрсний дараа бүх аймаг сумдын ХААГ-ын мэргэжилтэн мониторинг хийж, тухайн төслийн өгөөжийг дүгнэнэ.	
Санхүүжилт	<u>Засгийн газар</u> • Тогтолцооны схем гаргахтай холбоотой консалтинг үйлчилгээний зардал • Салбарын холбогдох байгууллагуудын үйл ажиллагааг зохион байгуулах татаас олгох • Материал, тоног төхөөрөмж худалдан авахад татвараас чөлөөлөх • Тоног, төхөөрөмж (ээрэх)-ид хөрөнгө оруулалт хийх зориулалттай бага хүүтэй зээл • Бүх аймаг сумдын ХААГ-ын мэргэжилтний унааны зардал	<u>Хувийн хэвшил</u> • Технологийн сургалтын зардал • Гадаад, дотоодын мэргэжилтнүүдийг урьж боловсруулах технологийн зааварчилгаа өгөх (цалин хөлс, хоол, унааны зардал) • Төсөл хэрэгжүүлэхтэй холбоотой бусад зардал
Төслийн өртөг	Төслийн нийт өртөг: 46 тэрбум 650 сая төгрөг (17,757,000 ам.доллар)	
Ашиг, үр нөлөө	Олон улсын зах зээлд илүү нэмүү өртөг шингэсэн нэхмэл бүтээгдэхүүн нийлүүлнэ. Ингэснээр нэхмэл эдлэлийн экспортын хэмжээ, экспортын орлого нэмэгдэж, нэхмэлийн үйлдвэрлэл эрхэлдэг ААН-үүдийн орлого ашиг өснө.	
Бодлогын бичиг баримттай уялдсан байдал	1. Алсын хараа 2050 4.2.7 Ноолуур үйлдвэрлэлийг дэмжих, самнасан ноолуур болон эцсийн бүтээгдэхүүнийг экспортыг нэмэгдүүлэх. 2. Алсын хараа 2050 4.2.8 Мал, амьтны арьс шир, ноос ноолуурыг бүрэн боловсруулж нэхмэл болон нэхмэл эдлэлийн экспортыг нэмэгдүүлнэ.	

Төслийг хэрэгжүүлэх хуваарь, төсөв

Үйл ажиллагаа		2025	2026	2027	2028	2029	2030	2031	2032	2033	2034	Дүн
(1) Нэхмэлийн салбарт үйл ажиллагаа явуулдаг компаниудын хөрөнгө оруулалтад (ээрэх тоног төхөөрөмж) зориулж татаас олгох, татвараас чөлөөлөх тогтолцоог төлөвлөх.												
(2) Санал болгож буй тогтолцооны схемийн талаар нэхмэлийн салбарт үйл ажиллагаа явуулдаг хувийн хэвшлийнхэн болон бусад холбогдох байгууллагуудтай санал бодлоо нэгтгэх.												
(3) Шинэ тогтолцоог нэвтрүүлж эхлэх.												
(4) Тогтолцоог нэвтрүүлсний дараа тогтмол мониторинг хийж, төслийн үр дүнг зохистойгоор үнэлэх.												
Төслийн өртөг,	сая төгрөг	50	8,975	8,925	9,200	9,200	9,200	275	275	275	275	46,650
	мян. ам.дол	22	3,416	3,397	3,502	3,502	3,502	104	104	104	104	17,757

4.2.6 Зөгийн балны нийлүүлэлтийн тогтолцоог бэхжүүлэх хөтөлбөр

Үйлдвэрлэл болон чанар тогтворгүй, өртөг өндөр. Дотоодын зах зээлд голчлон супермаркетуудаар борлуулдаг. Компаниуд гол тоглогч болж тогтвортой нийлүүлэлт хийж эхлээд байгаа. Гэвч, импортын хэмжээ их, байнга нийлүүлэлт нь хэрэглээгээ давдаг, ширүүн өрсөлдөөнтэй. Илүү тогтвортой нийлүүлэлт шаардлагатай. Дэлхийн зах зээлд ч маш их өрсөлдөөнтэй, Монголын зөгийн бал өрсөлдөх чадвар сул. Далайд гарцгүй нь сул тал болдог. Түгээлт болон экспортын бүрдүүлэлт гэх мэт зардал өсгөдөг хүчин зүйлүүдийг сайжруулахыг зорихын зэрэгцээ зорилтот зах зээлд нийцүүлж Монголын бүтээгдэхүүний давуу талыг харуулах шаардлага бий.

	Орц	Үйлдвэрлэл	Боловсруулалт	Түгээлт, экспорт	Борлуулалт, хэрэглээ
Оролцогч	УХБ нийлүүлэгч, зөгийчин, импортлогч, үүр хайрцаг үйлдвэрлэгч	Зөгийчин, зөгийн ААН	Зөгийчин, Зөгийн компани,бал савлагч ААН	Зөгийчин, Зөгийн компани,бал савлагч ААН	Зөгийнчин, жижиглэнгийн худалдаачин
Гол бэрхшээл	УХБ-ын зохистой хэрэглээ, УХБ үлдэх эрсдэл багатай сүрэгтэй болох нь асуудалтай. Дотоодын бараа нь олдоц муу. Сав нь импортын хараат, сонголт цөөн.	Хортон шавьж тархмал.бал хураах орчин найдваргүй, үйлдвэрлэлийн хугацаа богино. Маллагааны технологийг сайжруулах шаардлагатай.Үлдэгдлийн эрсдлийг шинжилж чадахгүй байгаа. Стандарт мөрдөх ойлголт муутай зөгийчид ч байна.	ААН-ийн бал худалдан авах өртөг өндөр. Үлдэгдэл ихтэй, ашиглалт бага.Хүнсний аюулгүй байдлын ойлголт дутуу.Чанарын шаардлага хангахгүй бараа их. Хуурамч гарал үүсэл, хуурамч бүтээгдэхүүн гэх үл итгэх байдал их.	Тээврийн зардал өндөр.Зөгийчид гар дээрээс худалдаа хийх нь элбэг,нийлүүлэлт тогтворгүй. Чанар үнийн хувьд өдөр тутмын хэрэглээний бүтээгдэхүүн байхгүй. Экспортод өрсөлдөх чадваргүй.	Нэг хүнд ноогдох хэрэглээ бага. Хэрэглэгчид балны чанар, стандартыг мэддэггүй. Худалдаалах үнэ өндөр. Бүтээгдэхүүний өрсөлдөх чадвар муу.
Авах арга хэмжээ	6.1 Зөгийн мэргэшсэн эмч бэлтгэх, хортон шавьжид тэсвэртэй зөгий өсгөх төлөвлөгөө				
	6.2 Зөгийн балыг чанарын баталгаатай болгож, өрсөлдөх чадварыг бэхжүүлэх төлөвлөгөө				
	6.3 Кластерийг бэхжүүлэх замаар зөгийн балны экспортыг дэмжих төлөвлөгөө				
	6.4 Зөгийн аж ахуйг бусад салбартай хамтран хөгжүүлэх төлөвлөгөө				

Зураг 4.7 Зөгийн балны нийлүүлэлтийн сүлжээг бэхжүүлэх хөтөлбөр

Эх сурвалж: Жайка төслийн баг

Монголын зөгийн балны үйлдвэрлэлийн салбарт (1) үйлдвэрлэлийн тогтворгүй байдал, (2) чанарын тогтворгүй байдал, (3) өртөг өндөр зэрэг асуудлууд байдаг ч дотоод болон гадаадад ирээдүйтэй зах зээл бий. Зах зээлээ тэлэхийн тулд үйлдвэрлэл болон чанарын тогтвортой байдлыг хангаж, нийлүүлэлтийг тогтворжуулах шаардлагатай. Дотоодын зах зээл дээр дотоодын үйлдвэрийн зөгийн бал өндөр үнэлэгддэг бөгөөд нийлүүлэлт тогтвортой байж чадвал импортыг орлох боломж дээшлэнэ. Дотоод зах зээлд өрсөлдөх чадварыг бэхжүүлэх гэхээс илүүтэй зах зээлийн хэмжээг тэлэхийг зорилго болгох нь зүйтэй. Зөгийн бал нь тансаг хэрэглээний бүтээгдэхүүн учраас хүнсний аюулгүй байдал талаас чухалчлан үзэх шаардлагагүй.

Хүснэгт 4.6 Зөгийн балны нийлүүлэлтийн сүлжээг бэхжүүлэх хөтөлбөр болон хөгжлийн бодлогын чиглэл хоорондын хамаарал

Бодит бэрхшээл, давуу тал, хөгжлийн бодлогын чиглэлийн агуулга		Зөгийн балны нийлүүлэлтийн сүлжээг бэхжүүлэх хөтөлбөрийн хүрээнд авах арга хэмжээ: 4 төлөвлөгөө			
		6.1	6.2	6.3	6.4
Бэрхшээл	Хортон шавьж тархах хандлагатай	◎	○		
	Үйлдвэрлэлийн хэмжээ тогтворгүй	◎	◎		◎
	Чанар тогтворгүй		◎		○
	Нийлүүлэлт тогтворгүй	○	○	○	○
	Үйлдвэрлэл, түгээлтийн зардал өндөр	◎			◎

	Дотоодын зах зээл хөгжөөгүй		○		◎
	Экспорт хийдэггүй	◎	◎	◎	○
	Брэнд танигдалт дутмаг		◎	○	◎
Давуу тал	Мал эмнэлгийн хяналтын систем	◎	◎		
	Маллагааны технологи хөгжүүлэх байгууллагууд бий	◎			
	Чанарын хяналтын тогтолцоог хөгжүүлэх	○	◎	○	
	Зөгийн балны кластер байгуулсан		○	◎	○
	Эрэгээр танигдсан балт ургамалууд ургадаг				◎
	МАА, газар тариалантай хослуулах боломж				◎
Хөгжлийн бодлогын чиглэл 1	1-2-1 Малын үүлдэр угсааг сайжруулах тогтолцоог бүрдүүлэх				
	1-2-2 Малын эмч, зоо техникч бэлтгэх	◎			
	1-2-3 Хамтын маллагаагаар өсвөр мал бордохыг (хурганы махыг оруулан) дэмжих				
	1-2-4 Ургац хураах, анхан шатны боловсруулалт хийх техник хэрэгслээр хангах, техникийн сургалт явуулах				
	1-2-5 Маллагааны зохистой арга техникийг түгээх				
	1-2-6 Махны үйлдвэр байгуулахыг дэмжих				
	1-2-7 Дайвар бүтээгдэхүүнээр гэрийн тэжээвэр амьтдын хоол үйлдвэрлэлийг хөгжүүлэх				
	1-2-8 МАА-н хоршоодыг түшиглэн ноос, арьс, сүү цуглуулах, тээвэрлэх тогтолцоог бий болгох.				
	1-2-9 Үйлдвэрлэлийн хүний нөөцийг хөгжүүлэх (мах боловсруулах, ээрэх, арьс шир)				
	1-2-10 Мөшгөлтийн системийн ашиглалтыг дэмжих	○	◎	○	
	1-2-11 Зах зээлийн эрэлт хэрэгцээнд нийцсэн мах ангилах системийг нэвтрүүлэх, брэнджүүлэх ажлыг дэмжих				
	1-2-12 Аялал жуулчлалыг хөгжүүлэхэд хамтрах, бэлэг дурсгалын үйлдвэрлэл хөгжүүлэх				◎
	1-2-13 Үйлдвэрлэлийн кластер хөгжүүлэх				

Эх сурвалж: Жайка төслийн баг ○ : Өндөр хамааралтай, ◎ : Хүчтэй хамааралтай

“**6.1 Зөгийн аж ахуйн мэргэжлийн хүний нөөцийг сургах, өвчин болон хортон шавьжид тэсвэртэй зөгийн аж ахуй хөгжүүлэх төлөвлөгөө**”-нд үйлдвэрлэлийн тогтвортой байдалд хамгийн их эрсдэл авчирдаг зөгийн бүлийн хорогдлоос сэргийлэхийн тулд өвчин, хортон шавьжтай тэмцэх шаардлагатай. Монголд өвөлжсөн зөгий 20 орчим хувиар хорогддог бөгөөд гол төлөв Варроа хачигнаас болж устдаг. Мөн монголд одоогоор бүртгэгдээгүй ч өндөр халдвартай аюулт өвчний эрсдэл ч бий. Өвчин, хортон шавьжтай тэмцэх нь тулгамдсан асуудал бөгөөд энэхүү арга хэмжээний хүрээнд хортон шавьжнаас сэргийлэх, мал эмнэлгийн үйлчилгээг сайжруулж тэмцэх арга технологийг боловсруулах, түгээн дэлгэрүүлэх шаардлагатай. Өвчин, хортон шавьжнаас сэргийлэхийн тулд зөгийн бүлийн импортод хорио цээрийн байцаагчид зохистой хяналтыг хийх, хяналт мониторинг хариуцсан зөгийн аж ахуйн талаар мэдлэгтэй малын эмч нарыг үйлдвэрлэл бүхий орон нутгуудад зохистойгоор хуваарилан ажиллуулах, зөгийн аж ахуйн техникчээр дамжуулан өвчин хортон шавьжтай тэмцэх технологийг түгээн дэлгэрүүлэх шаардлагатай хэдий ч энэ салбарын талаар мэдлэгтэй мэргжлийн хүн хүч дутмаг байна. Мал эмнэлгийн хяналт мониторинг хэрэгжүүлэх тогтолцоог бий болгох, зөгийн аж ахуйн салбарын мэргэжлийн боловсон хүчнийг чадавхижуулах үйл ажиллагааг хэрэгжүүлэх шаардлагатай.

"**6.2 Зөгийн балны чанарыг баталгаажуулах замаар өрсөлдөх чадварыг бэхжүүлэх төлөвлөгөө**" нь чанарын хяналтын тогтолцоог нэвтрүүлэх замаар дотоод болон гадаад зах зээл дээр нэмүү өртгийг сайжруулахыг зорино. Зөгийн балыг хуурамчаар үйлдвэрлэх нь түгээмэл байдаг тул үйлдвэрлэсэн газар, үйлдвэрлэлийн процессыг баталгаажуулах нь томоохон нэмүү өртгийг үүсгэх юм. Зөгийн балны чанарыг баталгаажуулж, хуурамч бүтээгдэхүүний эргэлзээг арилгах, бүтээгдэхүүний үнээс гадна өөр үнэ цэнийг бий болгож өрсөлдөх чадварыг нэмэгдүүлнэ. Хүнсний аюулгүй байдлыг хангах, түүнийг дэмжих үйл ажиллагаанууд нь экспортын зорилтыг биелүүлэхэд чухал. Ялангуяа экспортын зах зээлд монгол зөгийн бал үнийн хувьд өрсөлдөх чадваргүй учраас бүтээгдэхүүний үнээс гадна өөр онцлог шинж чанар бүхий үнэ цэн бий болгон өрсөлдөж чадах зах зээлийг олж илрүүлэн, стратеги боловсруулан нэвтрэх нь чухал.

"**6.3 Кластерийг бэхжүүлэх замаар зөгийн балны экспортыг дэмжих төлөвлөгөө**" нь зөгийн балны экспорттой холбоотой байгууллагуудын хамтын ажиллагааг бэхжүүлэх замаар зорилтот зах зээлд дүн шинжилгээ хийж, экспортын зорилтот орнуудтай протокол байгуулахыг эрчимжүүлэх зорилготой. Экспорт хийхэд тулгарч буй эхний бэрхшээл бол хамгийн тохиромжтой зорилтот зах зээлийг сонгох, дараа нь импортлогч орны тодорхой шаардлага, хэрэгцээг хангах явдал юм. Импортлогч орны шаардлага заримдаа нарийн төвөгтэй байдаг бөгөөд бүрдүүлэх ёстой баримт бичгүүд нь хатуу зохицуулалттай, бодит байдал дээр экспортын бүрдүүлэлт хийхэд хувийн хэвшил, төрийн байгууллагуудын нягт хамтын ажиллагаа чухал байдаг. Мөн хувийн хэвшил хоорондын түншлэлийг бэхжүүлэхэд дэмжлэг болдог. Зөгийчид болон компаниудын хамтын ажиллагааг бэхжүүлэх нь зөгийн балны бүтээгдэхүүний нөөцийг тэгшитгэж, нийлүүлэлтийг тогтворжуулахад хувь нэмэр оруулна. Зөвхөн зөгийн аж ахуйтай холбоотой компаниуд төдийгүй ложистикийн болон дамжуулагч компаниудтай хамтран ажиллах шаардлагатай.

"**6.4 Зөгийн аж ахуйг бусад салбартай хамтран хөгжүүлэх төлөвлөгөө**" нь бусад салбартай хамтран ажиллахыг дэмжих зорилготой. Балт ургамалын нөөцийн тогтвортой байдал нь үйлдвэрлэлийн болон чанарын тогтвортой байдалд зайлшгүй шаардлагатай. Монголд балт ургамалын нөөцийг газар тариалан, мал аж ахуйтай хамтран тогтворжуулах боломжтой. Зөгий бол маш сайн тоос хүртээгч бөгөөд зөгийн аж ахуй нь газар тариалангийн бүтээмжийг сайжруулах, бэлчээрийг хамгаалахад эерэг нөлөө үзүүлдэг. Тариалангийн талбайд цацсан эмийн үлдэгдэл зөгийн баланд нөлөөлж, бохирдуулахгүй байхын тулд газар тариалан, зөгийн аж ахуй хоёрын хамтын ажиллагаа чухал юм. Үүнээс гадна зах зээлээ тэлэхийн тулд аялал жуулчлалын салбартай хамтран ажиллахыг боломжийг эрэлхийлнэ. Хот сууринаас зөгийн аж ахуй эрхэлдэг бүс нутаг руу жуулчдын урсгалыг нэмэгдүүлэх нь иргэдийн зөгийн аж ахуйн талаарх ойлголтыг гүнзгийрүүлж, бэлэг дурсгалын худалдаа төдийгүй нийтийн хоол, хүнсний үйлдвэрүүдээр дамжуулан зөгийн балны хэрэглээг нэмэгдүүлэх юм. Дотоодын аялалыг дэмжсэнээр яваандаа экспорттой холбогдох ч боломжтой. Олон улсын зах зээл дээрх өрсөлдөөн хэдий ширүүн байгаа ч Монголд дуртай болж, Монголд зөгийн аж ахуйн талаар мэдээлэлтэй болсон гадаадын жуулчид эх орондоо буцсан хойноо ч зах зээл дээр байгаа олон зөгийн балны дундаас монгол балыг сонгон авах хүмүүс болох юм.

(1) Зөгийн аж ахуйн мэргэжлийн боловсон хүчнийг сургах, өвчин болон хортон шавжид тэсвэртэй зөгийн аж ахуй хөгжүүлэх төлөвлөгөө

YAT 6.1: Зөгийн аж ахуйн мэргэжлийн боловсон хүчнийг сургах, өвчин болон хортон шавжид тэсвэртэй зөгийн аж ахуй хөгжүүлэх төлөвлөгөө	
Төлөвлөгөөний зорилго	Зөгийн аж ахуйн талаар мэдлэгтэй малын эмч, техникч, хорио цээрийн байцаагчийг сургаж, зөгийн өвчнийг хянах.
Суурь түвшин	Зөгийчдийн 13% орчим нь малын эмчтэй гэрээ байгуулсан байдаг. Зөгийн АА-н талаар мэдлэг бүхий ажилтантай хорио цээрийн хяналтын газар байхгүй.
Төлөвлөгөөний зорилт	Зөгийчдийн 80% нь мал эмнэлгийн хяналт мониторингод хамрагддаг болох. Зөгийн бүл импортлодог хоион цээрийн хяналтын цэгүүдэд мэдлэг мэдээлэл бүхий мэргэжлийн хүмүүсийг томилон ажиллуулах.
Хамрах хүрээ	Орон даяар зөгийн аж ахуй эрхэлдэг бүс, хорио цээрийн хяналтын цэгүүд
Хүлээх үр дүн	Зөгийн өвчин хортон шавьжтай тэмцэх арга техникийг боловсруулж, түгээн дэлгэрүүлэхийн зэрэгцээ зөгийн аж ахуйн чиглэлээр мэдлэгтэй малын эмч, хорио цээрийн ажилтнуудыг зөгийн аж ахуй эрхэлдэг бүс нутгуудад хуваарилж, үр дүнтэй ажиллуулснаар, өвчин хортон шавьжийн тархалтыг хязгаарлаж, хорогдож устах зөгий бүлийн тоо буурна.
Үйл ажиллагаа	(1) Өвчин, хортон шавжид тэсвэртэй, эрүүл зөгийн бүл өсгөн үржүүлэх технологийн судалгаа, боловсруулалт хийх МЭЕГ, аймгуудын мал эмнэлгийн лаборатори, Улсын мал эмнэлгийн ариун цэврийн төв лабораториос (УМЭАЦТЛ) дотоод болон гадаадад гарч буй өвчин, хортон шавжийн талаарх мэдээллийг тогтмол цуглуулж нэгтгэн, УМЭАЦТЛ болон Мал эмнэлгийн хүрээлэнгээс (МЭХ) тархалтыг хянах технологийг боловсруулж, зөгийн аж ахуй эрхлэгчдэд зориулан техникийн мэдээллийг нийтлэх. (2) Зөгийн аж ахуйн салбарт үйл ажиллагаа явуулж буй хувийн мал эмнэлгийн үйлчилгээ эрхлэгчдийг ажиллуулах төлөвлөгөөг боловсруулах. МЭЕГ зөгийн аж ахуйн салбарт үйл ажиллагаа явуулж буй хувийн мал эмнэлгийн үйлчилгээний өнөөгийн байдлыг судалж, шаардлагатай тохиолдолд мал эмнэлгийн үйлчилгээтэй холбоотой зохицуулалтыг хянан үзнэ. Ингэсний дараа малын эмч нарыг ажиллуулах бодит төлөвлөгөөг боловсруулна. (3) Зөгийн АА-н салбарын мэргэжилтнүүдийг бэлдэх зөгийн аж ахуйн сургалтыг тогтмол явуулах. Малын эмч нарт зориулан МЭЕГ-аас малын эмчийн лиценз сунгах сургалтын хөтөлбөрт зөгийн аж ахуйн салбарыг хамруулах, сургалтын материалыг баталгаажуулах, малын эмч нарыг тогтмол сургалтад хамруулах зэрэг үйл ажиллагааг хэрэгжүүлнэ. ХААИС нь Мал эмнэлгийн сургуулийн сургалтын хөтөлбөрт зөгийн АА-н чиглэлээр сонгон суралцах хичээлийн хөтөлбөр боловсруулж, багшийг бэлтгэх. ХХААХҮЯ-ны МААБХЗГ, МЭЕГ, ХХААХҮСҮАТ болон МЭХ зэрэг байгууллагууд хамтран малын эмч нарын сургалтад суурилсан зөгийн АА-н сургалтыг хүсэлт гаргасан МАА-н мэргэжилтнүүдэд зориулан явуулах. (4) Зөгийн АА эрхлэгчдэд мал эмнэлгийн үйлчилгээний ашиг тусыг ойлгуулах. Хүнс, ХАА, хөнгөн үйлдвэрийн Судалгаа хөгжлийн төв (ХХААХҮСҮАТ) нь (1)-д дурдсан технологийн талаар зөгийчдөд зориулсан техникийн сурталчилгааны материал бэлтгэж, (3)-д дурдсан сургалтад хамрагдсан салбарын мэргэжлийн хүмүүс зөгийн аж ахуй эрхлэгчдэд хортон шавьжтай тэмцэх сургалтыг явуулна. (5) Хувийн мал эмнэлгийн зөгийн аж ахуйн үйлчилгээ болон зөгийн бүлийн хорио цээрийн хяналтыг тогтмол хийж, үнэлнэ. МЭЕГ, Гаалийн ерөнхий газар, УМЭАЦТЛ, аймгийн мал эмнэлгийн лабораториуд, МЭХ, Судалгаа хөгжлийн төв зэрэг холбогдох байгууллагуудын тус тусын хариуцах ажил үүргийг тодорхой болгож, хяналт шинжилгээний тогтолцоог бүрдүүлнэ. Зөгийн өвчний дэгдэлтийн мониторингийг МЭЕГ, ГЕГ-ын жилийн хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөнд тусгаж, мониторингийн үр дүнг хоёр байгууллагын хамтын мэдээлэл болгон

	хуримтлуулж, эргэх холбоо үүсгэнэ.	
Санхүүжилт	<u>Төрийн байгууллага</u> • Технологийн судалгаа, хөгжүүлэлтийн зардал • Төлөвлөгөө боловсруулах төрийн зардал • Сургалтын зардал • Сурах бичиг боловсруулах, сургалтын хэрэглэгдэхүүн боловсруулах зардал • Хяналт шинжилгээний зардал • Зөгийчдөд зориулсан мал эмнэлгийн гэрээний зардлын эхний 5 жилийн дэмжлэг	<u>Хувийн хэвшил</u> (Малын эмч) • Сургалтанд оролцох хураамж (курсын төлбөр, замын зардал) (Зөгийчин) • Малын эмчтэй хийсэн гэрээний зардлын зарим хэсэг
Төслийн өртөг	Төслийн нийт өртөг: 1 тэрбум 538 сая төгрөг, (585,000 USD)	
Ашиг, үр нөлөө	Өвчин хортон шаьжийн нөлөөгөөр хорогдох зөгийн бүлийг бууруулснаар бий болох эдийн засгийн үр нөлөө (10% → 3%: зөгийн бүлийн үнэ 1,103,000 ам. доллар + бал хураах боломж 3 жилийн хугацаанд 912,000 ам. доллар = нийт 2,015,000 ам.доллар)	
Бодлогын бичиг баримттай уялдсан байдал	1. Алсын хараа 2050 4.2.6.Малын эрүүл мэндийн хяналтыг бэхжүүлэх замаар иргэдийн хүнсний аюулгүй байдлыг хангах, хүнсний экспортыг нэмэгдүүлэх. 2. Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр (2020-2024) 3.3.8 Мал эмнэлгийн тогтолцоог шинэчилж, малын халдварт өвчин, бүртгэгдсэн халдварт өвчний эсрэг арга хэмжээг авч хэрэгжүүлэх, өвчин бүртгэгдээгүй газар нутгийг гэрчилгээжүүлэх, малын гаралтай бүтээгдэхүүн, түүхий эдийн экспортын боломжийг нэмэгдүүлэх. 3. Монгол Улсын Их Хурлын 36 дугаар тогтоол 4.5.2 Зөгийн балны импортыг үе шаттайгаар бууруулж, гарал үүслийн гэрчилгээтэй зөгийн балны экспортыг нэмэгдүүлэх зорилгоор бага хүүтэй зээл олгох.	
Төслийг хэрэгжүүлэхэд анхаарах зүйлс	• MJ-VET болон WB-LCP-тэй хамтран ажиллаж, ЖАЙКА-ын өвсний үндэс техникийн хамтын ажиллагааны төсөл зэрэг өмнөх төслүүдийн үр дүнг ашиглах. • Хувийн малын эмч нарын эрүүл өрсөлдөөний орчинг бүрдүүлэх, өргөн хүрээг хамарсан үйл ажиллагаа явуулах эрх олгох, өртгийн сүлжээнд нийцсэн мал эмнэлгийн үйлчилгээг үзүүлэх зэрэг уламжлалт хэлбэрт баригдаагүй арга барилыг судлах. • Гэрээ байгуулах зөгийчид малын эмчийг үнэлэх, сонгох боломжтой байхын тулд эмчийн лиценз сунгах үед малын эмчийн хамрагдсан сургалтын түүх, томоохон шагнал, шийтгэлийг холбогдох талуудад мэдээлдэг байх нь зүйтэй. • YAT 6-2, 6-3-т тусгагдсан мэдээлэл, үр дүнг харгалзан үзэх.	

Төслийг хэрэгжүүлэх хуваарь, төсөв

Үйл ажиллагаа		**2025**	**2026**	**2027**	**2028**	**2029**	**2030**	**2031**	**2032**	**2033**	**2034**	**Дүн**
(1) Хортон шавьжид тэсвэртэй, эрүүл зөгийн бүл өсгөн үржүүлэх технологийн судалгаа, боловсруулалт.												
(2) Зөгийн салбарт үйл ажиллагаа явуулах хувийн мал эмнэлгийн үйлчилгээ эрхлэгчдийг байршуулах зохих төлөвлөгөөг боловсруулах.												
(3) Малын эмч нарт зөгийн аж ахуйн сургалтыг тогтмол явуулах.												
(4) Зөгийчдөд мал эмнэлгийн үйлчилгээний ашиг тусыг ойлгуулах.												
(5) Хувийн мал эмнэлгийн үйлчилгээний зөгийн аж ахуй болон хорио цээрийн менежментэд тогтмол хяналт, үнэлгээ хийх.												
Төслийн өртөг	сая төгрөг	201	160	161	161	149	149	149	136	136	136	1,538
	мян. ам.дол	82	60	61	61	56	56	56	51	51	51	585

Тэмдэглэл: BeeDep-MONGOL төслийн үйл ажиллагаа

ЖАЙКА-гаас долоон жилийн турш зөгийн аж ахуйн чиглэлээр өвсний үндэс техникийн хамтын ажиллагааны BeeDep-MONGOL төслийг хэрэгжүүлж, маллагааны арга техникийг баталгаажуулах, түгээн дэлгэрүүлэх, үйлдвэрлэлийн процессийн хяналтад анхаарал тавьж ирсэн. Монголын зөгийн аж ахуйд өвчин, хортон шавьжны тархалт нэн тулгамдсан асуудал болоод байгаа бөгөөд зөгийн аж ахуй эрхлэгчид гадаад хэл дээр заавартай эм хувиараа импортолж, зааврыг нь ч шалгалгүйгээр зөгийтэй сархиаг руу шууд цацах зэрэг аюултай аргаар хэрэглэдэг байсан. Мөн зөгийн бүлийг хөрш орнуудаас оруулж ирэхэд хортон шавж байгаа эсэхийг шалгах хорио цээрийн ажилтан, малын эмч байдаггүй. Эдгээрийг шийдэх арга хэмжээний хүрээнд МЭЕГ-ын даргын тушаалаар "Зөгийн аж ахуй дахь эрүүл ахуйн хяналт, мал эмнэлгийн үйлчилгээний нийтлэг журам"-ыг боловсруулж, зөгийн аж ахуйн чиглэлээр мал эмнэлгийн үйлчилгээ үзүүлэх, малын эмчийн үйлдвэрлэлийн процесс дэх хяналтын эрх зүйн үндсийг бий болгосон.

Нөгөөтэйгүүр, МЭЕГ-аас малын эмчийн үнэмлэх сунгах тогтолцоог нэвтрүүлж, мал эмнэлгийн чадавхийг дээшлүүлэхээр ажиллаж байна. ДБ-ны МАА-н эдийн засгийн эргэлтийг нэмэгдүүлэх төсөл (Livestock Commercialization Project), Жайка байгууллагын Төрийн болон хувийн хэвшлийн малын эмч нарын практик чадавхийг бэхжүүлэх төсөл дэмжин ажиллаж, үүний хүрээнд MONMAP болон BeeDep төсөл хамтран зөгийн аж ахуйн сургалтын хөтөлбөр боловсруулж, малын эмч нарт зориулсан сургалт зохион байгуулж байна.

Малын эмч нарын сургалт

(2) Зөгийн балны чанарыг баталгаажуулах замаар өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх төлөвлөгөө

YAT 6.2: Зөгийн балны чанарыг баталгаажуулах замаар өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх төлөвлөгөө	
Төлөвлөгөөний зорилго	Зөгийн балны мөшгөлтийн систем болон зөгийн балны GAP-ыг орон даяар нэвтрүүлж, гарал үүслийг хуурамчаар үйлдэх, хүнсний аюулгүй байдлын эрсдэлийг бууруулж, дотоодын зах зээлд эзлэх хувь хэмжээг нэмэгдүүлж, экспортын зах зээлийг өргөжүүлнэ.
Суурь түвшин	Зөгийн балны зохистой дадлыг /GAP/ мөрдсөн, мөшгөх боломжтой балны нийлүүлэлт, жилд 0 тн.
Төлөвлөгөөний зорилт	10 жилийн дараа зөгийн балны зохистой дадалыг мөрдөж хэрэгжүүлдэг мөшгөх боломжтой Монгол зөгийн балыг жилд 200 тн-ыг зах зээлд нийлүүлнэ.
Хамрах хүрээ	Зөгийн аж ахуй эрхэлдэг аймгууд (Дархан, Сэлэнгэ, Дорнодоос эхэлж, таван жилийн дараа орон даяар өргөжүүлнэ)
Хүлээх үр дүн	Зөгийн аж ахуй эрхлэгчид Зөгийн балны зохистой дадал /GAP/ нэвтрүүлж, зөгийн балны мөшгөлтийн систем (ЗБМС) нэвтрүүлж, GAP баталгаажилттай мөшгөх системээр үйлдвэрлэлийн түүхийг харах боломжтой монгол зөгийн бал дотоод, гадаадын зах зээлд танигдана.
Үйл ажиллагаа	(1) Зөгийн аж ахуйн зохистой дадал /GAP/ боловсруулах. ХХААХҮЯ-ны ХБХЗГ–аас Салбарын хяналтын газар, Үндэсний итгэмжлэлийн хороо, СХЗГ, МЭЕГ хамтран зөгийн балны үйлдвэрлэлийн зохистой дадал боловсруулах, тохиролын үнэлгээний аргыг боловсруулна. Судалгаа хөгжлийн төвөөс GAP-ийг нэвтрүүлэх гарын авлагыг боловсруулна. (2) Зөгийн балны зохистой дадлын тохирлын үнэлгээний тогтолцоо бий болгох. Баталгаажуулах байгууллагад зориулсан зөгийн балны зохистой дадлын сургалтыг явуулж итгэмжлэл олгох. (3) Зорилтот бүсийн зөгийн аж ахуйд нэвтрүүлнэ. ХХААХҮЯ болон СХТөв голлон Дархан, Сэлэнгэ, Дорнодын зөгийн аж ахуй эрхлэгчид болон тэдний харилцагч хоршоод, аж ахуйн нэгжүүдэд зөгийн балны зохистой дадлыг нэвтрүүлэх туршилтын төсөл хэрэгжүүлнэ. (4) Зөгийн балны мөшгөх системийг зорилтот бүс нутгийн зөгийн АА-д нэвтрүүлэх.

	СХ төв нь ЗБМС ашиглах гарын авлагыг бэлтгэнэ. Дархан, Сэлэнгэ, Дорнодын зөгийн аж ахуй эрхлэгчид болон тэдний бизнесийн түнш холбоо, аж ахуйн нэгжүүдэд чиглэсэн ЗБМС нэвтрүүлэх туршилтыг ХХААХҮЯ, RD төв манлайлан явуулна. (5) GAP болон мөшгөлтийн системийн талаар зах зээлд таниулах. ХХААХҮЯ-ны Хүнсний бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар, Зөгийн балны кластертай хамтран нэмүү өртгийн сүлжээний оролцогч талуудын уулзалтыг тогтмол зохион байгуулах. СХТөв болон зөгийн балны кластер хамтран дотоод болон гадаад зах зээлд сурталчлан таниулах төлөвлөгөө боловсруулж, хэрэгжүүлэх. ХХААХҮЯамнаас эдгээр үйл ажиллагааг дэмжиж, татаас олгодог байх. (6) Зохистой дадал болон мөшгөх системийг орон даяар түгээн дэлгэрүүлэх. ХХААХҮЯ-ны Хүнсний бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар болон СҮАТөвөөс зөгийн балны кохистой дадлыг улсын хэмжээнд нэвтрүүлэх, түгээн дэлгэрүүлэх төлөвлөгөөг боловсруулах. ХХААХҮЯ-ны Хүнсний бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар, СХ төв нь улсын хэмжээнд ЗБМС-ийг нэвтрүүлэх, түгээн дэлгэрүүлэх төлөвлөгөөг боловсруулах, орон даяар сургалтыг зохион байгуулах.	
Санхүүжилт	<u>Төрийн байгууллага</u> • Зөгийн балны зохистой дадлыг мөрдүүлэхтэй холбоотой ажлын зардал • GAP сертификатын төлбөрийн дэмжлэг (эхний 6 жил) • Гарын авлага, сургалтын материал боловсруулах зардал • Гарын авлага, бүртгэлийн дэвтэр хэвлэх зардал (GAP, ЗБМС) • Аймаг сумдын сургалтын зардал • Өртгийн сүлжээнд оролцогчдын хэлэлцүүлэг зохион байгуулах зардал • Сурталчилгааны зардал	<u>Хувийн хэвшил</u> • Зөгийн балны зохистой дадал болон ЗБМС нэвтрүүлэх зардал • Зөгийн балны зохистой дадал болон ЗБМС нэвтрүүлэх ажилчдын сургалтын зардал • Зохистой дадлын гэрчилгээний зардал (7 дахь жилээс) • Шошго шинэчлэх зардал (QR код, GAP тэмдэг)
Төслийн өртөг	Төслийн нийт өртөг: 2 тэрбум 726 сая төгрөг (1,037,000 USD)	
Ашиг, үр нөлөө	Чанарыг баталгаажуулсан зөгийн балны борлуулалтыг дэмжсэнээр дотоодын зах зээлд импортыг орлоно (60%→70%; 889 сая төг). Дотоодын хэрэглээ, борлуулалт 1.5 дахин нэмэгдэнэ (130гр/хүн/жил → 200гр/хүн/жил = 4 тэрбум 788 сая төг) Экспортын зах зээлд өрсөлдөх чадвар сайжирч, зах зээл тэлнэ (Зөгийчдөөс худалдан авах үнэ 100тн = 1,800 сая төгрөг, гаалийн бүрдүүлэлтийн дараах үнэ 18 тэрбум төгрөг).	
Бодлогын бичиг баримттай уялдсан байдал	1. Алсын хараа 2050 4.2.6. Малын эрүүл мэндийн тогтолцоог бэхжүүлэх замаар үндэстний хүнсний аюулгүй байдлыг хангах, хүнсний экспортыг нэмэгдүүлэх 2. Алсын хараа 2050 4.2.23. Мэдээллийн технологийн хөгжлийг ашиглан экспортыг хөгжүүлэх механизмыг бий болгоно. 3. Алсын хараа 2050 4.5.7. ЖДҮ-ийг олон улсын зах зээл дэх нэмүү өртгийн сүлжээний шаардлагад нийцүүлэхийн тулд менежментийг бэхжүүлэх, ажиллагсдын ур чадварыг дээшлүүлэх, технологийн дэвшил, инновацийг нэвтрүүлэх, бүтээгдэхүүний чанар, стандартыг сайжруулах. 4. Монгол Улсын Их Хурлын 36 дугаар тогтоол 4.5.2 Зөгийн балны импортыг үе шаттайгаар бууруулж, гарал үүслийн гэрчилгээ бүхий зөгийн балны экспортыг нэмэгдүүлэх зорилгоор бага хүүтэй зээл олгох.	
Төслийг хэрэгжүүлэхэд анхаарах зүйлс	• Зөгийн балны GAP, ЗБМС-ийг нэвтрүүлэхдээ GAP, ЗБМС нь "Мал эмнэлэгийн үйлчилгээ болон зөгийн бэлчээрт тавигдах эрүүл ахуйн шаардлагатай холбоотой ерөнхий зааварчилгаа (зөгийн аж ахуйн ерөнхий зааварчилгаа)" нь хоорондоо нийцсэн, давхардалгүй, харилцан уялдаатай байхад анхаарах. • Зөгийчид болон зөгийн аж ахуйн нэгжүүдийн эцсийн бүтээгдэхүүний аюулгүй байдлыг баталгаажуулахын тулд тогтмол бүтээгдэхүүнээ шинжилгээнд хамруулахыг (стандарт хангаж буй эсэх, үлдэгдэл, бактери) урамшуулах.	

	• Зохистой дадлын тохирлын үнэлгээний тогтолцоо бүрдүүлэхдээ зөгийчид болон зөгийн аж ахуй эрхлэгчид зохистой дадлыг тасралтгүй хэрэгжүүлэх боломжтой бодитой систем бий болгох. • Зохистой дадлын тохирлын үнэлгээний чадавхийг бэхжүүлэх арга хэмжээг түгээн дэлгэрүүлэх төлөвлөгөөнд тусгах. • Зах зээлийн шахалт шаардлага нь чанарын хяналтыг сайжруулдаг тул зах зээлд анхаарал тавих. • Үйл ажиллагааны төлөвлөгөө 6-1 болон 6-3-тай уялдуулан хэрэгжүүлэх.

Төслийг хэрэгжүүлэх хуваарь, төсөв

Үйл ажиллагаа		2025	2026	2027	2028	2029	2030	2031	2032	2033	2034	Нийт
(1) Зорилтот бүсийн зөгийн аж ахуйд зөгийн балны зохистой дадлыг нэвтрүүлэх.												
(2) Зорилтот бүсийн зөгийн аж ахуйп ЗБМС нэвтрүүлэх.												
(3) Зохистой дадал болон мөшгөх системийг зах зээлд таниулан сурталчлах.												
(4) Зохистой дадал болон ЗБМС-ийг орон даяар нэвтрүүлэх.												
Төслийн өртөг	сая төгрөг	299	276	286	286	310	338	226	237	228	240	2,726
	мян.ам.дол	117	105	108	108	118	128	86	90	86	91	1,037

Тэмдэглэл: Чанарыг баталгаажуулснаар нэмүү өртөг үүсэх үү?

2023 оны 3-р сард ЕХ-д импортолж буй "зөгийн бал"-ны 46% нь усаар шингэлсэн эсвэл сироптой хольсон байна гэж ЕХ-ны хуурамч бүтээгдэхүүнтэй тэмцэх албанаас мэдэгдсэн. Түүнчлэн БНХАУ-аас импортолсон 89 нэр төрлийн бүтээгдэхүүний 66 нь, Энэтхэгээс импортолсон 15 нэр төрлийн бүтээгдэхүүний 14 нь Европын холбооны зөгийн балны стандартад тэнцэхгүй байжээ. Мөн гарал үүслийг хуурамчаар үйлдэх тохиолдол олон удаа гарсан байна. Зөгийн бал нь хуурамч бүтээгдэхүүн ихтэй хүнсний бүтээгдэхүүний нэг бөгөөд харамсалтай нь хямд элсэн чихэр нэмэх, гарал үүсэл, балт ургамал буюу эх үүсвэрийг хуурамчаар үйлдэх явдал түгээмэл байдаг. Зөгийн балны үйлдвэрлэл худалдаа эрхлэгчид ч эдгээрийг сайн мэддэг бөгөөд салбарынханд ил байдаг нууц юм. ХХААХҮЯ-аас Зөгийн балны үйлдвэрлэлийн зохистой дадлыг боловсруулж байгаа бөгөөд MONMAP–AVC төслөөс дэмжиж ажилласан. Зөгийн балны үйлдвэрлэлийн зохистой дадал нь хүнсний аюулгүй байдлыг хангах, сахар нэмэхээс урьдчилан сэргийлэхэд үр нөлөө үзүүлэх юм. Мөн, үйлдвэрлэлийн үе шатыг хянаж, гарал үүслийг мөшгөх боломжийг олгох зөгийн балны мөшгөлтийн системийг (ЗБМС) боловсруулсан. Одоогийн байдлаар ХХААХҮСҮАТөвөөс ЗБМС-ийг түгээн дэлгэрүүлэх ажлыг эхлүүлээд байна. Хуурамч бүтээгдэхүүн ихтэй зах зээл тусмаа хуурамч биш бүтээгдэхүүн үйлдвэрлэхэд анхаарал тавьснаар бүтээгдэхүүний үнэ цэнэ дээшлэнэ.

(3) Кластерийг бэхжүүлэх замаар зөгийн балны экспортыг дэмжих төлөвлөгөө

ҮАТ 6.3: Кластер хөгжүүлэх замаар зөгийн балны экспортыг дэмжих төлөвлөгөө	
Зорилго	Зөгийн бал экспортлох
Суурь түвшин	2022 оны экспортын гүйцэтгэл: 0.3т
Зорилт	3 жилийн дараа 20 тн, 5 жилийн дараа 30 тн, 10 жилийн дараа 100 тн экспорт хийнэ.
Хамрах хүрээ	Орон даяар
Хүлээх үр дүн	Зөгийн балны экспортод хамаарах байгууллагуудын уялдаа холбоог бэхжүүлж, зорилтот зах зээлийн тодорхойлж, экспортлох улс орнуудтай протокол тохирох. Мөн зорилтот зах зээлийн эрэлт хэрэгцээнд нийцсэн үйлдвэрлэл явуулах боломжтой болно
Үйл ажиллагаа	(1) Зөгийн балны экспорттой холбоотой байгууллагуудын хамтын ажиллагааг бэхжүүлэх.

	1) ХХААХҮЯ-ны Хүнсний бодлогын газар кластерын үйл ажиллагаанд төрийн байгууллагын оролцох хэлбэрийг судалж холбогдох байгууллагууд хэрхэн хамтран ажиллахыг судалж, шаардлагатай бол хууль эрх зүйн тогтолцоог шинэчлэх. 2) ХХААХҮЯ-ны Хүнсний бодлогын хэрэгжилтийг зохицуулах газраас экспортыг дэмжих сэдвийн дор зөгийн балны экспортын зөвлөлдөх хурлыг холбогдох төрийн байгууллага, зөгийн балны кластерыг оролцуулан тогтмол зохион байгуулах. 3) ХХААХҮЯ-ны Хүнсний бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар нь зөгийчид, зөгийн аж ахуйн компаниуд, ложистикийн компаниуд, гаалийн байгууллага зэрэгийн хооронд гэрээ байгуулах, хамтран ажиллахыг эрчимжүүлэх. (2) Экспортын зорилтот улстай протокол байгуулах. 1) ГХЯ, ХХААХҮЯ-ны Хүнсний бодлогын газар, Гадаад харилцааны хэлтэс зорилтот зах зээлийг тодорхойлж, протокол байгуулахад шаардлагатай мэдээллийг цуглуулна. 2) ГХЯ, ХХААХҮЯ-ны Хүнсний бодлогын газар, Гадаад харилцааны хэлтэс, Гаалийн алба хамтран протокол тохирох төлөвлөгөө боловсруулна. 3) ГХЯ, ГЕГ хамтран зөгийн бал экспортлох зөвлөлтэй хамтран протокол боловсруулах. (3) Зорилтот зах зээлийн шаардлага, эрэлт хэрэгцээг тодруулан судалж, холбогдох талуудтай мэдээлэл хуваалцах. 1) ХХААХҮЯ-ны Хүнсний бодлогын газар, Гадаад харилцааны хэлтэс, Гаалийн алба хамтран зорилтот зах зээлийн шаардлага, эрэлт хэрэгцээтэй холбоотой мэдээлэл цуглуулах. 2) Зөгийн балны кластерт мэдээллийн хуримтлал үүсгэх. 3) ХХААХҮЯ-ны Хүнсний бодлогын газар зөгийн балны кластерийн мэдээлэл солилцох, зах зээлд чиглэсэн арга хэмжээ, шйл ажиллагааг дэмжих.	
Санхүүжилт	<u>Төрийн байгууллага</u> • Зөвлөлдөх хурал зохион байгуулах зардал (төрийн зардал, оролцогчдын томилолтын зардал) • Экспортын зах зээлийн судалгааны зардал • Зорилтот улсад бизнес аялал хийхэд зориулсан дэмжлэг • Кластерын мэдээлэлтэй холбоотой дэмжлэг зардал • Кластерийн ҮА-ны зардлын дэмжлэг	<u>Хувийн хэвшил</u> • Кластерийн удирдлагын зардал • Кластерын үйл ажиллагааны зардал • Бизнес аялалд оролцох зардал • Үзэсгэлэн худалдаанд оролцох зардал • Чанарын хяналтын арга хэмжээний зардал
Төслийн өртөг	Төслийн нийт зардал: 2 тэрбум 83 сая төгрөг (792,000 USD)	
Ашиг, үр нөлөө	Экспортоор дамжуулан зах зээл тэлэгдэнэ (100 тн =Зөгийчдөөс худалдан авах үнэ 10 дахь жилдээ жилийн 18 тэрбум төгрөг, гаалийн бүрдүүлэлтийн дараах үнэ 180 тэрбум төгрөг).	
Бодлогын бичиг баримттай уялдсан байдал	1. Алсын хараа 2050 4.2.23. Мэдээллийн технологийн хөгжлийг ашиглан экспортыг хөгжүүлэх механизмыг бий болгоно. 2. Алсын хараа 2050 4.5.7. ЖДҮ-ийг олон улсын зах зээл дэх өртгийн сүлжээний шаардлагад нийцүүлэхийн тулд менежментийг бэхжүүлэх, ажилчдын ур чадварыг дээшлүүлэх, технологийн дэвшил, инновацийг нэвтрүүлэх, бүтээгдэхүүний чанар, стандартыг сайжруулах. 3. Таван жилийн үндсэн чиглэл (2021-2025 он) 3.3.2. Бичил, жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих тогтолцоог бэхжүүлж, тогтворжуулна. 4. Таван жилийн үндсэн чиглэл (2021-2025 он) 4.5.2. Бичил, жижиг, дунд үйлдвэрийн ханган нийлүүлэлт, борлуулалтын сүлжээг кластер хэлбэрээр хөгжүүлэх. 5. Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр (2020-2024) 1.1.5 Экспортыг дэмжих арга хэмжээг боловсруулж, экспортын хэмжээг нэмэгдүүлнэ. 6. Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр (2020-2024) 3.3.12 ХАА-н бүтээгдэхүүний тээвэрлэлт, борлуулалтын ложистикийн сүлжээг бий болгож, ХАА-н бүтээгдэхүүний нийлүүлэлтэд чанарын хяналт, баталгаажуулалтын зохистой тогтолцоог бүрдүүлнэ. 7. Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр (2020-2024) 4.5.2 Эдийн засгийн дипломат харилцааг чухалчилж, төр хувийн хэвшлийн хамтын ажиллагаанд тулгуурласан экспортыг нэмэгдүүлэх, ангилах, худалдаанд гарч буй хүндрэл, бэрхшээлийг шийдэх, бууруулах, хөнгөвчлөх бодлогыг үргэлжлүүлнэ.	

Төслийг хэрэгжүүлэхэд анхаарах зүйлс	• МУ-ын Засгийн газрын аж үйлдвэрийн кластерийг хөгжүүлэх бодлогын загвар болох. • EU-TRAM төслөөс дэмжин ажилладаг экспортын кластерийн сүлжээтэй хамтрах. • Зөгийн балны чанартай холбоотой Зохистой дадал, ЗБМС, Мал эмнэлгийн үйлчилгээний байгууллага зэрэгтэй хамтран ажиллах. • YAT 6-1, 6-2-той уялдуулан хэрэгжүүлнэ.

Төслийг хэрэгжүүлэх хуваарь, төсөв

Үйл ажиллагаа		2025	2026	2027	2028	2029	2030	2031	2032	2033	2034	Нийт
(1) Зөгийн балны экспортод оролцдог байгууллагуудын хоорондын уялдаа холбоог бэхжүүлэх.												
(2) Зорилтот улстай протокол тохирох.												
(3) Зорилтот зах зээлийн шаардлага, эрэлт хэрэгцээг судлах, холбогдох талуудтай мэдээлэл хуваалцах.												
Төслийн өртөг	сая төгрөг	342	399	183	244	156	183	114	177	110	175	2,083
	мян. ам.дол	135	151	69	92	59	69	43	67	41	66	792

Тэмдэглэл: Хамтын ажиллагааг бэхжүүлэхийн ач холбогдол

Зөгийчид өөрсдөө хэрэглэгчдэд шууд борлуулах нь түгээмэл байсан түгээлт нийлүүлэлтийн сүлжээнд компаниуд орж ирж зөгийн балны борлуулалт нийлүүлэлтэд оролцож эхэлсэн. MONMAP-AVC төслийн хүрээнд хэрэгжүүлсэн туршилтын төслөөр компаниуд зөгийчидтэй байгуулсан гэрээнд сахарын агууламжийг 80% байх ёстой гэж заасан бөгөөд түүнээс бага үзүүлэлттэй зөгийн балыг гүйлгээнээс хассан. Ингэснээр чанар дээшлэхэд ихээхэн нөлөө үзүүлсэн. Мөн компаниуд тодорхой хэмжээний зөгийн балны нөөц үүсгэснээр нийлүүлэлт тогтвортой болсон. Чанар, тоо хэмжээ, нийлүүлэлтийн хугацаа тогтвортой байх нь экспортод зайлшгүй шаардлагатай нөхцөл бөгөөд компаниуд болон зөгийчдийн хоорондын харилцаа холбоо бий болсноор үйл ажиллагаа нь улам өргөжинө гэсэн хүлээлттэй байна.

Мөн 2022 онд байгуулагдсан зөгийн балны кластер нь бизнесийн харилцаа холбоо тогтооход дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаануулыг төлөвлөж байна. Энэхүү кластер нь зөгийн аж ахуй эрхлэгчид, зөгийн балны компаниуд, ложистикийн компаниуд, санхүүгийн байгууллагуудыг татан оролцуулах зорилготой бөгөөд төр, хувийн хэвшлийн түншлэлийг сайжруулж зөгийн балны экспортын саад тотгорыг арилгах зорилготой юм. Кластерийн нээлтийн арга хэмжээн дээр экспортын туршлагатай компани Япон руу экспортлосон жишээ болон дүрэм журмын талаар мэдээлэл өгч, 2023 оны 4 сард болсон кластер танилцуулах арга хэмжээний үеэр санхүүгийн байгууллагууд зөгийчдөд санхүүгийн удирдлага болон үйлдвэрлэлийн бүтээмжийг дээшлүүлэхтэй холбоотой танилцуулга хийсэн. Зөгийн аж ахуй эрхлэгчид төдийгүй зөгийн бал үйлдвэрлэдэг компаниуд, санхүүгийн байгууллагуудын хэрэгцээг кластерт төвлөрүүлж, төрийн байгууллагуудтай хамтран ажиллах үндэс суурь бүрдүүлэх нь зүйтэй. Одоогоор Монгол Улс БНХАУ-тай зөгийн бал экспортлох протокол тохирохоор бэлтгэн ажиллаж байгаа хэдий ч HACCP-ийн баталгаажуулалтын явц зэрэг хувийн хэвшлийн талаарх сүүлийн үеийн зөв зохистой мэдээллүүдийг төрийн байгууллагууд бүрэн авч чадаагүй байна. Холбогдох мэдээллийг үр дүнтэй ашигласнаар зөвлөлдөх уулзалтууд үр дүнтэй болох болов уу.

(4) Бусад салбартай хамтран зөгийн аж ахуйг хөгжүүлэх төлөвлөгөө

YAT 6.4: Бусад салбартай хамтран зөгийн аж ахуйг хөгжүүлэх төлөвлөгөө	
Зорилго	Зөгийн балны үйлдвэрлэлийг тогтворжуулах, зөгийн балны аюулгүй байдлыг сайжруулах, зөгийн аж ахуйн орлогын эх үүсвэрийг төрөлжүүлэх, зөгийн балны хэрэглээг нэмэгдүүлэх.
Суурь түвшин	Үр цацсан ургамалаас хураах зөгийн бал 0 тн. Борлуулалтын сувгуудаар худалдаалах

	зөгийн балны хэмжээ 0 тн.
Зорилт	Өнжсөн талбай болон өвөлжөө, хадлангийн талбайд ургамалын үр цацаж дагнасан ургамалын болон түүнтэй адилтгах төрлийн бал хураах хэмжээг 1 жилд 70 тнд хүргэнэ. Борлуулалтын цэгүүдээр 1 тн зөгийн бал эргэлтэд орно.
Зорилтот бүс	Сэлэнгэ, Дархан, Булган, Хэнтий аймгууд
Хүлээх үр дүн	Газар тариалантай уялдуулснаар пестицид хэрэглэхгүйгээр зөгийн аж ахуйтай хамтрах боломжтой. Зөгийн тоос хүртээлтээр тариалангийн гарц бүтээмж сайжирч, зөгийн аж ахуйн үйл ажиллагаа тогтворжино. Мөн өнжсөн талбай болон өвөлжөө, хадлангийн талбайд үр цацаж балт ургамалын нөөц болгон ашигласнаар бал хураалт тогтворжиж, хөрс сайжрах, бэлчээрийг нэмэгдүүлэхэд хувь нэмэр оруулна. Аялал жуулчлалын салбарын нөөц болгон ашиглах боломжтой болж, жуулчдыг татаж, зөгийн балны зах зээл өргөжих боломжтой.
Үйл ажиллагаа	(1) Өнжсөн талбайд үр цацаж ургамал тариалан зөгийн бал хураах. ХХААХҮЯамны МАА-н бодлогын газар, Газар тариалангийн бодлогын газар нь Сэлэнгэ, Дархан дахь өнжсөн талбайг сонгох, зөгийчид болон газар тариалангийн компаниудтай гэрээ байгуулахад дэмжлэг үзүүлнэ. Судалгаа хөгжлийн төв нь өнжсөн талбайд үр цацаж ургамал тариалах туршилтыг явуулж, сортын бүртгэлийг хийж, Сэлэнгэ, Дарханд өнжсөн талбайд балт ургамалын үр цацах туршилтын төсөл хэрэгжүүлэх. Туршилтын төслөөр зөгий бэлчээрлүүлж газар тариалангийн бүтээмжийг сайжруулах судалгааг хийх. Зөгийчид болон компаниуд өнжсөн талбайд цацсан үрийн ургамалаас хураасан зөгийн балны брэнд үүсгэн хөгжүүлэхэд ХХААХҮЯ дэмжлэг үзүүлэх. Судалгаа хөгжлийн төв нь ургамал тус бүрээр цуврал жишээнүүдийг эмхэтгэн гарын авлага болгож, газар тариалангийн компаниуд болон зөгийчдийн хооронд хамтран ажиллах гэрээ байгуулахыг дэмжин сурталчлах, гэрээт компаниуд болон зөгийчдөд пестицидийн хэрэглээний мэдээлэл хуваалцах системийг бий болгох. (2) Малчдын өвөлжөө, хадлангийн талбайн балт ургамалаас зөгийн бал хураах. ХХААХҮЯ-ны МАА-н газраас Булган, Хэнтий аймгуудын өвөлжөө, бэлчээрийг судалж, балт ургамалыг ашиглахын ашиг тусыг малчдад сурталчлан таниулах. Судалгаа хөгжлийн төв нь Булган, Хэнтий аймгийн малчдын өвөлжөөнд балт ургамал тариалах туршилтын төслийг хэрэгжүүлэх. Мөн цуврал жишээнүүдийг эмхэтгэн гарын авлага боловсруулж, малчид зөгийчдийн хооронд гэрээ байгуулахыг дэмжин сурталчлах. (3) Аялал жуулчлалын зах зээлд зөгийн балны борлуулалтыг нэмэгдүүлэх. ХХААХҮЯамны Хүнсний бодлогын газраас зөгийчдөд зөгийн балыг боловсруулж бүтээгдэхүүн үйлдвэрлэхэд нь дэмжлэг үзүүлж, зөгийн аж ахуй эрхэлдэг бүс нутагт борлуулалтын цэгүүдийг бий болгоход татаас олгох. БОАЖЯам, зөгийн АА-тай холбогдох байгууллагуудтай хамтран аялал жуулчлалыг хөгжүүлэх төв болон аялал жуулчлалын бизнес эрхлэгчдэд борлуулах цэгүүдийн талаар мэдээлэл тараах. ХХААХҮЯамнаас хил дамнасан цахим худалдааг дэмжих замаар зөгийн бал болон боловсруулсан бүтээгдэхүүний борлуулалтыг дэмжих.
Санхүүжилт	<u>Төрийн байгууллага</u> • Соён гэгээрүүлэх үйл ажиллагааны зардал • Уриншийн талбайгаас зөгийн бал хураах туршилтын төслийн зардал • Уриншийн талбайд балт ургамал тариалахад татаас олгох • Тоос хүртээлтээр дамжин газар тариалангийн бүтээмжийг сайжруулах судалгааны ажлын зардал • Пестицидийн мэдээлэл солилцох тогтолцоо бий болгоход дэмжлэг үзүүлэх зардал • Зөгийн балны бүтээгдэхүүний борлуулалтын цэгүүд бий болгох зардал • Брэнд хөгжүүлэх, бүтээгдэхүүн борлуулах сургалтын зардал <u>Хувийн хэвшил</u> • Танилцуулга, сургалтанд оролцох хураамж • Уриншийн талбайд балт ургамал тариалалтын зардал • Бүтээгдэхүүн хөгжүүлэх зардал / борлуулалтыг дэмжих зардал • Борлуулалтын цэгийн үйл ажиллагааны зардал
Төслийн өртөг	Төслийн нийт өртөг: 1,890 сая төгрөг (719,000 USD)
Ашиг, үр	Балт ургамалын нөөцийг тогтворжуулснаар хураах зөгийн балны хэмжээ нэмэгдэнэ (20%:

нөлөө	295,000 ам.доллар). Аялал жуулчлалын зах зээлийн хувьд 1,440,000 ам.долларын зөгийн бал болон боловсруулсан бүтээгдэхүүн борлуулж, борлуулалтын цэгүүд болон боловсруулах үйлдвэрлэлд ажлын байр бий болж, жилд 16,000 ам.долларын эдийн засгийн үр өгөөжтэй байх боломжтой. Тариалангийн гарц нэмэгдэнэ (25%).
Бодлогын бичиг баримттай уялдсан байдал	1. Алсын хараа 2050 6.2.8. Хөрс хамгаалах, газрын доройтлоос урьдчилан сэргийлэх, цөлжилттэй тэмцэх үндэсний хөтөлбөрүүдийг хэрэгжүүлнэ. 2. Алсын хараа 2050 6.4.8. Ойжуулах, хүлэрт газрыг хамгаалах, газрын доройтлыг нөхөн сэргээх, ургамлын давхаргыг хамгаалах, ногоон байгууламжийг нэмэгдүүлэх замаар хүлэмжийн хийн шингээлтийг нэмэгдүүлнэ. 3. Таван жилийн үндсэн чиглэл (2021-2025 он) 3.3.4.Аялал жуулчлалын бүтээгдэхүүн, үйлчилгээ, түүний чанар, стандартыг сайжруулж, өрсөлдөх чадварыг нэмэгдүүлж, иргэд, аж ахуйн нэгжийн орлогыг нэмэгдүүлнэ. 4. Таван жилийн үндсэн чиглэл (2021-2025 он) 6.2.1.Хөрсний үржил шим, чийгийг хамгаалах, газрын доройтол, хөрсний бохирдол, цөлжилтөөс урьдчилан сэргийлэх, доройтсон, сүйдсэн газрыг нөхөн сэргээх, ашиглах.
Төслийг хэрэгжүүлэхэд анхаарах зүйлс	• Өнжсөн талбайд ургамалын үр цацсанаар ногоон бордоо болж хөрс сайжруулахад хувь нэмэр оруулах бөгөөд, тариалахад хөдөлмөр шаардахгүй, шүүс ихтэй, үр нь олдоцтой байх хэрэгтэй. Монголд ургадаг ургамал бол бүр сайн. • Рапсын талбай эсвэл жимст ургамалын өнжөөсөн талбайг ашиглах нь зүйтэй. (Гурвалжин будааны бал холилдвол зөгийн балны арилжааны үнэ цэнэ буурдаг.) • Зөгийчид болон зөгийн компаниудын хоорондын харилцаа холбоог сайжруулах үүднээс аймаг, сумдын ХАА-н газрын ажилтнууд үйл ажиллагаанд тогтмол хяналт тавьж ажиллах. • ЖАЙКА-ын аялал жуулчлалын зөвлөхүүдтэй хамтран ажиллах. ЖАЙКА-ын өвсний үндэс төсөлтэй төстэй чиглэлийн төслүүд байвал тэдэнтэй хамтран ажиллах. • Аялал жуулчлалын салбартай хамтран гадаад, дотоодын аялал жуулчлалын агентлагуудыг татан оролцуулах. Балт ургамалын тариалалтад жуулчдыг хамруулан оролцуулах зэргээр аялал жуулчлалын нөөцийг хөгжүүлэх чиглэлээр идэвхтэй ажиллах.

Төслийг хэрэгжүүлэх хуваарь, төсөв

Үйл ажиллагаа		2025	2026	2027	2028	2029	2030	2031	2032	2033	2034	Нийт
(1) Өнжсөн талбайд ургамалын үр цацаж зөгийн бал хураах.												
(2) Малчдын өвөлжөө, хадлангийн талбайгаас зөгийн бал хураах.												
(3) Аялал жуулчлалын зах зээлд зөгийн балны борлуулалтыг нэмэгдүүлэх.												
Төслийн өртөг	сая төгрөг	223	233	201	225	193	183	158	158	158	158	1,890
	мян. ам.дол	86	90	76	85	73	69	60	60	60	60	719

Тэмдэглэл: Зөгийн аж ахуй бусад салбартай хамтран ажиллах талаар

Зөгийн балны орцтой хоол, ундаа

"Аялал жуулчлал Зөгийн аж ахуй" жишээ: MONMAP-AVC төслөөс 2021 оны 11-р сард зохион байгуулсан "**Зөгийн балны долоо хоног"** аянд Улаанбаатар хотын 12 компанийн 14 салбар ресторан оролцож, үйлчлүүлэгчдэд зөгийн балны орцтой хоол, ундаагаар үйлчилсэн. 12 рестораны 8 нь зөгийн балтай хоол, ундаагаар үйлчилсэн хэвээр байгаа бөгөөд тэдгээрээс 5 нь дотоодын зөгийн бал худалдан авч байгааг тодруулсан. Энэ зун Японы аялал жуулчлалын агентлаг Монголд зөгийн аж ахуйтай танилцах аялал зохион байгуулсан. Аяллын хүрээнд Улаанбаатарт байх хугацаанд нь "Зөгийн балны долоо хоног" аянд оролцсон ресторан, хоолны газруудаар үйлчлүүлсэн. Жижиг савалгаатай жуулчид аваад явах боломжтой збгийн бал бэлэг дурсгал болгон авахад сонирхол татаж байлаа.

"Газар тариалан х Зөгийн аж ахуй" жишээ: Японд гүзээлзгэнэ, амтат гуа, өргөст хэмх зэргийн тоос хүртээлтэд балт зөгийг ашигладаг. Үүнд ашиглаж буй зөгийн бүлийн тоо 125,000 орчим байна (2014). Японы газар тариалангийн үйлдвэрлэлд ургамалын тоос хүртээлтийн эдийн засгийн хувь нэмэр ойролцоогоор 670 тэрбум иен, үүнээс

үржүүлгийн европ зөгийн үр ашиг 180 орчим тэрбум иен гэж үздэг. Зөгий нь газар тариалангийн үйлдвэрлэлд зайлшгүй шаардлагатай аж ахуй бөгөөд муж орон нутгууд болон ХАА, ой, загас агнуурын яам хамтран цэцэрлэгжүүлэлтийн аж ахуйн эрэлт хэрэгцээ, зөгийн аж ахуй эрхлэгчдийн нийлүүлэлтийн талаарх мэдээллийг цуглуулан, дүн шинжилгээ хийж, тоос хүртээх зориулалтаар зөгийн бүлийн эрэлт, нийлүүлэлтийн зохицуулалтыг хийдэг. Цэцэрлэгжүүлэлтийн аж ахуй эрхлэгчдэд зориулсан зөгийг тоос хүртээлтэд ашиглах гарын авлагыг мөн боловсруулсан байдаг. (https://www.maff.go.jp/j/chikusan/kikaku/lin/sonota/pdf/kafunkouhai.pdf)

Монголын зөгийчдийн холбооны дээд зөвлөлөөс 2019 онд Сэлэнгэ аймагт хийсэн судалгаанаас үзэхэд, рапсын талбайд 1 га-д 1-2 бүл зөгий бэлчээснээр тариалангийн гарц 50%-иар нэмэгдэж, жимст ургамал, малын тэжээлийн буурцагт ургамлын гарцыг нэмэгдүүлэхэд үр дүнтэй байгаа нь батлагдсан.

4.2.7 ХАА-н бусад бүтээгдэхүүний нийлүүлэлтийн сүлжээг бэхжүүлэх хөтөлбөр

(1) Мөөг

Монголд одоогоор мөөгний хэрэглээ бага, дотоодын үйлдвэрлэл бага байгаа хэдий ч хойшид эрүүл хооллолтын түүхий эд гэдэг утгаараа эрэлт өргөжих байх гэж төсөөлж байгаа. Тийм учраас импортоос хараат байгаа мөөгний дотоодын нийлүүлэлтийн сүлжээг бэхжүүлэхэд чиглэсэн, 1) Мөөг үйлдвэрлэлийн технологийн судалгаа, хөгжүүлэлтийг дэмжих , 2) Мөөгний үндэсний стандарттай болох, 3) Хэрэглээг өргөтгөхөд чиглэсэн ухуулга сурталчилгаа хийх. Эдгээр оролдлого нь мөөгнөөс гадна бага хэмжээний үйлдвэрлэл бүхий (minor) ургамал, бусад хүнсний хувьд ч нийтлэг байх гэж бодож байна.

	Орц	Үйлдвэрлэл	Боловсруулалт	Түгээлт, экспорт	Борлуулалт, хэрэглээ
Оролцогч	Хөрөнгө, мицели, мөөгөнцрийн үүр үйлдвэрлэгч	Үйлдвэрлэгч, холбоод, ХАА-н хуулийн этгээд	Хүнсний үйлдвэр	Менж,үйлдвэрлэгч-дийн холбоо,түгээлт, экспортлогч ААН	Жижиглэнгийн худалдаа, нийтийн хоолны салбар
Гол бэрхшээл	Монголын нөхцөлд таарсан мөөгний төрөл цөөн. Мөн үйлдвэрлэлд шаардлагатай техник хэрэгсэл худалдаж авахад хүндрэлтэй.	Мөөг үйлдвэрлэлийн зохистой технологи төлөвшөөгүй.Үйлдвэрлэх хүсэлтэй хүмүүст технологи зааж өгч, үйлдвэрлэгчдийн тоог нэмэгдүүлэх шаардлагатай байна.	Мөөгний савлагааны технологийг сайжруулах шаардлага байна. Бас, дотоодын мөөгөөр хийсэн хүнс гаргах, үйлдвэрлэлийг бэхжүүлэх шаардлагатай.	Дотоодын мөөгний бизнес эрхлэгчдийг олшруулах шаардлагатай.	Эрүүл мэндийг дэмжихэд нэмэртэй мөөгний хэрэглээг өргөжүүлэхэд чиглэсэн ухуулга сурталчилгаа хийх шаардлагатай байна.
Авах арга хэмжээ	7.1 Мөөг үйлдвэрлэх технологийн сургалт хийж дэлгэрүүлэхийг дэмжих төлөвлөгөө 7.2 Мөөг тариалах үндэсний стандарт боловсруулах төлөвлөгөө 7.3 Мөөгний хэрэглээг өргөжүүлэхэд чиглэсэн ухуулга сурталчилгаа хийх төлөвлөгөө				

Зураг 4.8 Мөөгний нийлүүлэлтийн сүлжээг бэхжүүлэх хөтөлбөр

Эх сурвалж: Жайка төслийн баг

Монгол Улсын хувьд мөөгний хэрэглээ, дотоодын үйлдвэрлэлийн хэмжээ болон нэр төрөл бага хэдий ч цаашид өргөжин тэлэх бүтээгдэхүүн гэж үзсэн. Мөөгний нийлүүлэлтийн сүлжээг бэхжүүлэхийн тулд 1) мөөг үйлдвэрлэлийн технологийг судлах, дэлгэрүүлэх ажлыг эрчимжүүлэх, 2) мөөг үйлдвэрлэлийн үндэсний стандартыг бий болгох, 3) мөөгний хэрэглээг нэмэгдүүлэх мэдлэг олгох ажлыг хэрэгжүүлэх саналыг оруулж байна. Доорх хүснэгтэд эдгээр хөгжлийн төлөвлөгөө нь асуудлыг хэр сайн шийдэх боломжтой талаар, мөн давуу тал, боломжуудыг хэрхэн ашиглаж байгааг, цаашлаад хөгжлийн бодлогод нийцэж байгаа эсэх хамаарлын зэргийг нэгтгэн харууллаа.

Хүснэгт 4.7 Мөөгний нийлүүлэлтийн сүлжээг бэхжүүлэх хөтөлбөр, хөгжлийн бодлого хоорондын хамаарал

	Бодит бэрхшээл, давуу тал, хөгжлийн бодлогын чиглэл	Мөөгний нийлүүлэлтийн сүлжээг бэхжүүлэх хөтөлбөр: 3 төлөвлөгөө		
		7.1	7.2	7.3
Бэрхшээл	Монголд тохирсон мөөгний төрөл, сортын судалгаа хангалтгүй	◎		
	Мөөгний эх бактерийн үйлдвэрлэлийн стандарт дутмаг		◎	
	Мөөгний мицелийн үйлдвэрлэгчдийн тоо хязгаарлагдмал	○	○	
	Мицелийн үйлдвэрлэлийн цар хүрээ хязгаарлагдмал	○	○	
	Мицелийн үйлдвэрлэлийн стандарт байхгүй		◎	
	Мөөг үйлдвэрлэгчдийн тоо хязгаарлагдмал	○	○	
	Мөөг үйлдвэрлэхэд шаардлагатай материал, тоног төхөөрөмжийн хангамжийн тогтолцоо хангалтгүй	○	○	
	Мөөг үйлдвэрлэлийн стандарт дутмаг		◎	
	Мөөгний дотоодын хэрэглээ маш бага			◎
	Дотоодын мөөг боловсруулах, түгээх систем хангалтгүй		○	○
Давуу тал, Боломж	Мөөгний холбоо нь мөөг үйлдвэрлэл, борлуулалтын тогтолцоог бий болгосон	◎	○	
	Хувийн ААН нь эх бактерийн үйлдвэрлэлийг эхлүүлж байгаа	◎	○	
	Сургалтын удирдамжтай холбоотойгоор ерөнхий мөөг үйлдвэрлэгчдийн тоо нэмэгдэж байна	◎	○	
	Дотоодын мөөг судлаач, багш мэргэжилтэнтэй ба их дээд сургуулийн оюутнуудын тоо нэмэгдэх хандлагатай байгаа	◎	○	○
	Мөөг үйлдвэрлэх тоног төхөөрөмжийг оруулж ирдэг хувийн ААН байгуулагдсан	○		
	Дотоодод хүнсний үйлдвэрүүд байдаг	○	○	○
Хөгжлийн чиглэл	1-1-1 Үр тариа, тосны ургамлын үр үйлдвэрлэлийн тогтолцоог бэхжүүлэх			
	1-1-2 Шалгарсан үр, сортыг дэлгэрүүлэх ажлыг дэмжих	◎	○	
	1-1-3 Үр үйлдвэрлэгчдийг сургах	○		
	1-1-4 Усны нөөц, усалгааны хөгжлийг дэмжих			
	1-1-5 ХААн механикжуулалтыг дэмжих			
	1-1-6 Хүлэмжийн аж ахуйн бүтээн байгуулалтыг өргөжүүлэх			
	1-1-7 Тариалангийн зөв арга техникийг түгээн дэлгэрүүлэх	◎	○	
	1-1-8 Жижиг ногоочдын зах зээлд чиглэсэн тариалалтыг түгээн дэлгэрүүлэх	○	○	
	1-1-9 Эрчимжүүлсэн тариалалт хийх арга технологийг түгээн дэлгэрүүлэх			
	1-1-10 ХАА-н хоршоодын ХАА-н бүтээгдэхүүн хуваарилах (хадгалах) тогтолцоог бий болгох	○	○	
	1-1-11 Хүнсний бүтээгдэхүүн боловсруулах үйлдвэрүүдтэй гэрээлсэн газар тариалан эрхлэлтийг дэмжих		○	
	1-1-12 Хүнсний бүтээгдэхүүн боловсруулах хялбар технологийг ногоочдод түгээх	○	○	
	1-1-13 Шим тэжээл, хүнсний аюулгүй байдалтай холбоотой соён гэгээрүүлэх үйл ажиллагааг			◎

	Бодит бэрхшээл, давуу тал, хөгжлийн бодлогын чиглэл	Мөөгний нийлүүлэлтийн сүлжээг бэхжүүлэх хөтөлбөр: 3 төлөвлөгөө		
		7.1	7.2	7.3
	хэрэгжүүлэх			
	1-1-14 Кластер хөгжүүлэлтийг дэмжих	◎	○	

Эх сурвалж: Жайка төслийн баг ○ : Өндөр хамааралтай, ◎ : Хүчтэй хамааралтай

Үргэлжлүүлээд төлөвлөгөөнүүдийн ерөнхий тоймыг доор нэгтгэлээ.

“7.1 Мөөг үйлдвэрлэх технологийн судалгаа, түгээн дэлгэрүүлэх ажлыг дэмжих”

Монгол Улсын хувьд өөрийн байгалийн онцлогт тохирсон мөөг үйлдвэрлэх технологийг боловсруулж, үүндээ тохирсон зүйл, сортыг сонгох, ХААИСургууль, ШУА-ийн судалгааг дэмжиж ажиллах шаардлагатай. Түүнчлэн гарсан үр дүнг мөөг үйлдвэрлэгчдэд түгээх, чиглүүлэх ажлыг идэвхжүүлэх, мөөгний үйлдвэрлэлийн зориулалттай тариалалтыг өргөжүүлэх чиглэлээр төр, хувийн хэвшлийнхэн хамтран ажиллах шаардлагатай.

“7.2 Мөөг үйлдвэрлэх үндэсний стандарт боловсруулах”

Мөөгний дотоодын үйлдвэрлэлийг өргөжүүлэхийн тулд үйлдвэрлэлийн үйл явцыг зөв удирдаж, борлуулалтын ашгийг сайжруулах нь чухал бөгөөд зохих стандартад нийцсэн үйлдвэрлэлийн тогтолцоог бүрдүүлэх шаардлагатай. Эхний шатанд үйлдвэрлэгчдийн бүлгүүд болон үйлдвэрлэл эрхлэгч ААН-үүдийн хүрээнд чанарын мэдээлэл цуглуулж эхэлнэ. Үйлдвэрлэлийн цар хүрээ өргөжиж, мэдээлэл хуримтлагдах үе шатанд тэдгээрт суурилан үндэсний стандартын гэрчилгээг MASM-ээс авч, зохих ёсоор үйл ажиллагаа явуулахад төрөөс дэмжлэг үзүүлнэ.

7.3 Мөөгний хэрэглээг нэмэгдүүлэх мэдлэг олгох ажлыг хэрэгжүүлэх

Мөөгний хэрэглээ маш бага Монгол орны хувьд хоол хүнсний хэрэглээний хэв маяг өөрчлөгдөхийн хэрээр хүнсэн дэхь мөөгний хэрэглээг нэмэгдүүлэх боломж асар их байна. Үүний тулд мөөгний тэжээллэг чанар, үзүүлэх үр нөлөө болон дотоодын мөөгний импортын мөөгнөөс давуу талыг олон нийтэд сурталчлах нь зүйтэй юм. Мөн тогтвортой нийлүүлэлт хийхийн тулд жижиглэнгийн худалдаачид болон хүнсний бүтээгдэхүүн боловсруулах үйлдвэрүүдтэй хамтын ажиллагааг бэхжүүлэх нь чухал. Цаашлаад олон нийтийг хамарсан арга хэмжээнүүдийг зохион байгуулж, сурталчилах үйл ажиллагааг төрөөс дэмжиж, бизнес тохироо хийх боломжоор хангах зэрэг дэмжлэг үзүүлнэ.

1) Мөөг үйлдвэрлэх технологийг судлах, түгээн дэлгэрүүлэх ажлыг эрчимжүүлэх

YAT 7.1: Мөөг үйлдвэрлэх технологийг судлах, дэлгэрүүлэх ажлыг эрчимжүүлэх төлөвлөгөө)	
Төлөвлөгөөний зорилго	Монгол орны байгалийн онцлогт тохирсон мөөгний үйлдвэрлэл, түгээлтийг дэмжих, импортыг орлуулах зорилготой.
Төлөвлөгөөний зорилт	Монгол орны байгалийн онцлогт тохирсон мөөг үйлдвэрлэх технологийг боловсруулж, олон нийтэд түгээнэ.

Хамрах хүрээ	Орон даяар	
Хүлээх үр дүн	(1) Монгол орны байгалийн онцлогт тохирсон мөөг үйлдвэрлэх, үр ашигтай технологийг хөгжүүлнэ. (2) Мөөг тариалах технологи олон нийтэд түгэн тархсан байна.	
Үйл ажиллагаа	(1) Монгол орны байгалийн онцлогт тохирсон мөөгний судалгаа хөгжүүлэлтийг хийх ХААИСургууль, Шинжлэх ухааны академи зэрэг байгууллагууд Монголын байгалийн онцлог болон байгаа нөөц бололцоо, материалд нийцүүлэн мөөг тариалах технологийг судлан, боловсруулалт хийж, технологийн гарын авлага эмхэтгэхэд дэмжлэг үзүүлнэ. (2) Монгол орны байгалийн онцлогт тохирсон мөөгний зүйл, сортуудыг тодорхойлох. Дотоодод хясаан мөөг болон хаан хясаа мөөг тариалж байгаа ч импортоос хамааралтай бусад мөөг (шиитакэ, эноки, шимэжи гэх мэт) тариалах боломжийг судлах үйл ажиллагааг дэмжинэ (3) Мөөг тариалах технологийг үйлдвэрлэгчдэд өргөжүүлэн түгээх. Мөөг тариалагчдын холбоотой хамтран, мөөг үйлдвэрлэгчдэд зориулан технологийн сургалт зохион байгуулна. Мөн үйлдвэрлэлд шаардлагатай тоног төхөөрөмж, материал нийлүүлэх тогтолцоог бий болгоход дэмжлэг үзүүлнэ.	
Санхүүжилт	Засгийн Газар • Мөөгтэй холбоотой судалгаа шинжилгээг дэмжинэ. • Мөөгний технологийн сургалтыг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлнэ.	Хувийн хэвшил • Мөөгний технологийн сургалт хэрэгжүүлнэ.
Зардал	Нийт өртөг: 550 сая төгрөг (209,000 USD)	
Ашиг, үр нөлөө	Мөөгний үйлдвэрлэл эрхлэгчдийн тоо нэмэгдэнэ (одоо 50орчим байгаа нь 500 орчим болно)	
Бодлогын бичиг баримттай уялдсан байдал	1. Алсын хараа 2050: Зорилт 2.5 Амьдрах таатай орчин, Зорилт 8.2 Тогтвортой ХАА 2. Монгол Улсын Их Хурлын 36 дугаар тогтоол 3. Хүнсний хувьсгал: 2027 он гэхэд дотоодын хүнсний хэрэглээг 100% хангах зорилтод нийцсэн бүтээгдэхүүнтэй болно.	
Төслийг хэрэгжүүлэхэд анхаарах зүйлс	• Шинжлэх ухааны академи болон ХААИСургууль мөөг үйлдвэрлэх технологийн судалгаа, хөгжлийг идэвхтэй дэмжинэ гэдгээ 2023 оны 3 дугаар сард болсон форумын үеэр илэрхийлсэн. ХХААХҮЯам эдгээр үйл ажиллагааг дэмжиж, зохицуулж ажиллана.	

Төслийг хэрэгжүүлэх хуваарь, төсөв

Үйл ажиллагаа		2025	2026	2027	2028	2029	2030	2031	2032	2033	2034	Нийт
(1) Үйлдвэрлэлийн технологийг хөгжүүлнэ.												
(2) Тохиромжтой зүйл, сортуудыг тодорхойлно.												
(3) Технологийг түгээнэ.												
Төслийн өртөг	сая төгрөг	70	70	70	70	70	40	40	40	40	40	550
	мян. ам.дол	27	27	27	27	26	15	15	15	15	15	209

- ХХААХҮЯ-ны судалгаа, хөгжүүлэлтийн ажлын дэмжлэг (эрдэм шинжилгээний байгууллагуудын зардлыг тооцохгүйгээр) ойролцоогоор 30 сая төгрөг байна.
- ХХААХҮЯ-наас сургалт зохион байгуулах дэмжлэг 10 орчим сая төгрөг, хувийн хэвшлийн сургалттай холбоотой зардал 30 орчим сая төгрөг байхаар тооцсон.

Тэмдэглэл: Шиитакэ мөөгний туршилтын үйлдвэрлэл

Импортын мөн эрэлт ихтэй шиитакэ мөөгийг Монголд байгаа материалаар үйлдвэрлэж болох эсэхийг судлах зорилгоор ХААИС-ийн мөөг судлаачтай хамтран, туршилтын тариалалт хийсэн. Олон төрлийн эх бактерийг хилийн чанадаас авчиран, Монголд байгаа мөөгний төрөл бүрийн материалтай хослуулан тариалж, харьцуулсан туршилт хийсэн. Одоогийн байдлаар үйлдвэрлэлийн бүтээмж хангалттай өндөр биш байгаа тул үйлдвэрлэлийн зориулалттай тариалалт явуулах нөхцөлийг олохоор туршилтыг үргэлжлүүлэх шаардлагатай байна.

2) Мөөгний үйлдвэрлэлийн үндэсний стандарт боловсруулах

YAT 7.2: Мөөгний үйлдвэрлэлийн үндэсний стандарт боловсруулах төлөвлөгөө		
Төлөвлөгөөний зорилго	Монгол орны байгалийн онцлогт тохирсон мөөгний үйлдвэрлэл, түгээлтийг дэмжиж, импортыг орлуулна.	
Төлөвлөгөөний зорилт	Монгол улсын таримал мөөгний стандарт боловсруулна.	
Хамрах хүрээ	Орон даяар (тэр дундаа УБ хотод)	
Хүлээх үр дүн	(1) Мөөг үйлдвэрлэгчдийн холбооны дотоод стандартыг тогтооно. (2) Мөөг үйлдвэрлэлийн үндэсний стандартыг тогтооно.	
Үйл ажиллагаа	(1) Мөөг үйлдвэрлэгчдийн холбооны дотоод стандарт болгон дүрмийг боловсруулна. Улсын хэмжээнд тариалж буй мөөгний чанарын хяналтын байдалтай танилцаж, үүнд үндэслэн мөөг тариалагчидад зориулсан стандарт тогтооход чиглүүлнэ. Уг стандартын дагуу тогтсон чанартай мөөг үйлдвэрлэх боломжтой эсэхийг нягтлахын тулд мониторинг хийнэ. (2) Мөөг үйлдвэрлэлийн үндэсний стандартыг тогтооно. Мөөг үйлдвэрлэгчдийн дотоод стандартын хэрэгжилтэнд тулгуурлан зах зээлийн итгэлийг олжаван , ашигтай борлуулалтыг өргөжүүлэх зорилгоор Монгол улсын дотоодын стандартыг томъёолно. Засгийн газар тус үйл явцыг дэмжиж ажиллах ба үүн дээр тулгуурлан чанартай мөөгний үйлдвэрлэл явуулж байгаа эсэхэд хяналт тавина.	
Санхүүжилт	<u>Засгийн газар</u> • Мөөгний үндэсний стандартыг тогтооход дэмжлэг үзүүлнэ.	<u>Хувийн хэвшил</u> • Үйлдвэрлэгчдийн дотоод стандарт зохицуулалтыг боловсруулж, хяналт тавина. • Мөөгний үндэсний стандартыг боловсруулж, хяналт тавина.
Төслийн өртөг	Төслийн нийт өртөг: 365 сая төгрөг (138,000 USD)	
Ашиг, үр нөлөө	Дотоодод үйлдвэрлэсэн мөөгөнд итгэх итгэл нэмэгдсэнээр, борлуулалт нэмэгдэнэ. Нэг кг мөөгийг дунджаар 10,000 төгрөгөөр борлуулж байгаа гэж үзвэл одоогийн үйлдвэрлэлийн хэмжээ 10 тн (төсөөлж буй дүн) байгаа нь 100 тн болж өснө гэж тооцоолно. Үр дүнд борлуулалтын орлого 100 сая төгрөгөөс 1 тэрбум төгрөг болж өснө.	
Бодлогын бичиг баримттай уялдсан байдал	1. Алсын хараа 2050 Зорилт 2.5 Амьдрах таатай орчин, Зорилт 8.2 Тогтвортой ХАА. 2. Монгол Улсын Их Хурлын 36 дугаар тогтоол. 3. Хүнсний хувьсгал: 2027 он гэхэд дотоодын хүнсний хэрэглээг 100% хангах зорилтод нийцсэн бүтээгдэхүүнтэй болно.	
Төслийг хэрэгжүүлэхэд анхаарах зүйлс	• Хэдийгээр стандартыг бий болгох, хэрэгжүүлэх ажлыг хувийн хэвшлийнхэн бие даан гүйцэтгэх хэдий ч төрөөс тодорхой хэмжээний дэмжлэг үзүүлэх шаардлагатай. MASM нь стандартын баталгаажуулалт хийдэг байгууллага ба ХХААХҮЯ нь түүний баталгаажуулалт болон хяналтыг дэмжиж ажиллана.	

Төслийг хэрэгжүүлэх хуваарь, төсөв

Үйл ажиллагаа		2025	2026	2027	2028	2029	2030	2031	2032	2033	2034	Нийт
(1) Үйлдвэрлэгчдийн дотоод стандартыг боловсруулна.												
(2) Үйлдвэрлэгчдийн дотоод стандартын хэрэгжилтийг хянана.												
(3) Үндэсний стандартыг тогтооно.												
(4) Үндэсний стандартын хэрэгжилтэд хяналт тавина.												
Төслийн өртөг	сая төгрөг	60	10	120	25	25	25	25	25	25	25	365
	мян. ам.доллар	27	3	45	9	9	9	9	9	9	9	138

Тэмдэглэл: Мөөгний стандарт үзүүлэлтүүдийн тухайд

Дотоодын мөөгний стандартыг Стандарт Хэмжил Зүйн Газарт мэдүүлэхийн тулд бусад орны жишигт тулгуурлан Монгол Улсын стандартын төслийг боловсруулж, мэргэжилтнүүдтэй уулзалт хийж ирсэн. Гэвч мөөгний тал дээр стандарт болгон баримтлах тодорхой тоон үзүүлэлт, өгөгдлийн мэдээлэлд өнөөгийн Монгол улсад үйлдвэрлэж буй мөөг үйлдвэрлэлийн мэдээлэл байхгүй, түүнчлэн өнөөгийн үйлдвэрлэлийн цар хүрээнд үндэслэн үндэсний стандарт гаргах зайлшгүй яаралтай шаардлага бага байгаа тул хэсэг хугацаанд бэлтгэл ажлыг хэрэгжүүлэх шаардлагатай гэсэн дүгнэлтэнд хүрлээ. Бэлтгэл ажлын явцад мөөгний өнөөгийн байдалд дүн шинжилгээ хийж, мэдээлэл цуглуулах ба үүнийг мөөг үйлдвэрлэгчдэд зориулсан тусгай стандарт болгон ашиглана. Үүний дараа MASM-д үндэсний стандарт тогтоох албан ёсны өргөдөл гаргахаар төлөвлөж байна.

Нэмүү өртөг өндөртэй боловч их хэмжээгээр үйлдвэрлэдэггүй ХАА-н гаралтай бүтээгдэхүүний хувьд анхнаасаа үндэсний стандарт гаргана гэхээсээ илүүтэй эхлээд үйлдвэрлэгчдийн бүлгүүд нэгдэн мэдээлэл цуглуулж, өөрсдийн стандартыг бий болгоод, дараа нв үндэсний стандарт болгон албан ёсоор бүртгүүлэх өргөдөл MASM-д гаргах процедурыг санал болгох байна.

3) Мөөгний хэрэглээг нэмэгдүүлэх зорилготой соён гэгээрүүлэх үйл ажиллагаа

YAT 7.3: Мөөгний хэрэглээг нэмэгдүүлэх зорилготой соён гэгээрүүлэх төлөвлөгөө	
Төлөвлөгөөний зорилго	Монгол орны байгалийн онцлогт тохирсон мөөгний үйлдвэрлэл, түгээлтийг дэмжих, импортыг орлуулна.
Төлөвлөгөөний зорилт	Монгол улсын дотоодод үйлдвэрлэсэн мөөгний хэрэглээ нэмэгдэнэ.
Хамрах хүрээ	Орон даяар (тэр дундаа УБ хотын ойр орчмын бүс)
Хүлээх үр дүн	Хэрэглэгчийн хоол хүнсний хэрэглээ сайжирсан.
Үйл ажиллагаа	(1) Мөөгний ашиг тусын талаар сурталчилах материал боловсруулна. Эдийн засгийн хөгжлийг дагаад дотоодын хоол хүнсний хэрэглээний дадал сайжирч байгаа тул мөөгний ашиг тусыг олон нийтэд сурталчлах материал хийнэ. Олон нийтийн мэдээллийн хэрэгсэл, салбарын холбоодын хуудсаар (muug.mn гэх мэт) дамжуулан мэдээлэл түгээнэ. (2) Мөөгний хэрэглээг нэмэгдүүлэхэд чиглэсэн мэдлэг түгээх үйл ажиллагаа зохион байгуулна. Төрөл бүрийн арга хэмжээний үеэр олон нийтэд мөөгний хэрэглээний талаарх мэдээллийг түгээнэ. Мөн жижиглэн борлуулалтын дэлгүүр, ресторанд амтлагааны аян зохион байгуулна. Хүүхдийн хоол тэжээлийн боловсролтой холбоотойгоор сургуулийн үдийн хоолны цэсэнд оруулах талаар судлана. (3) Жижиглэн худалдаа болон хүнсний үйлдвэрүүдтэй хамтын ажиллагаагаа бэхжүүлнэ. Жижиглэн худалдаачид, хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэгчид, мөөг үйлдвэрлэгчдийн хоорондын хамтын ажиллагааг дэмжиж, төлөвлөгөөт үйлдвэрлэл, гэрээгээр үйлдвэрлэх системийг бий болгоно.

Санхүүжилт	<u>Засгийн газар</u> • Хоолны дадалзуршлыг сайжруулах кампанит ажил (сургуулийн үдийн хоолыг оролцуулаад)зохион байгуулах	<u>Хувийн хэвшил</u> • Олон нийтийн мэдээллийн хэрэгсэл, SNS-ээр дамжуулан мэдээлэл түгээх
Төслийн өртөг	Төслийн нийт өртөг: 400 сая төгрөг (152,000 USD)	
Ашиг, үр нөлөө	Мөөгний хэрэглээг нэмэгдүүлнэ. (Одоо ойролцоогоор 1,000 тн (таамаглал) гэж үзвэл 2,000 тн хүртэл өснө)	
Бодлогын бичиг баримттай уялдсан байдал	1. Алсын хараа 2050 Зорилт 2.5 Амьдрах таатай орчин, Зорилт 8.2 Тогтвортой ХАА. 2. Монгол Улсын Их Хурлын 36 дугаар тогтоол. 3. Хүнсний хувьсгал: 2027 он гэхэд дотоодын хүнсний хэрэглээг 100% хангах зорилтод нийцсэн бүтээгдэхүүнтэй болно.	
Төслийг хэрэгжүүлэхэд анхаарах зүйлс	• Мөөгний хэрэглээний талаар албан ёсны статистик мэдээ байхгүй ч УБ хотод жилд 827 тн, улсын хэмжээнд 1,000 орчим тн мөөгний хэрэглээ байгаа гэж таамаглаж байна.	

Төслийг хэрэгжүүлэх хуваарь, төсөв

Үйл ажиллагаа		2025	2026	2027	2028	2029	2030	2031	2032	2033	2034	Нийт
(1) Мөөгний сурталчилгааны материал бэлтгэх.												
(2) Хэрэглэгчдэд мэдлэг түгээх үйл ажиллагаа.												
(3) ААН-үүдийн хамтын ажиллагааг бэхжүүлэх.												
Төслийн өртөг	сая төгрөг	105	105	80	80	30						400
	мян. ам.дол	41	40	30	30	11						152

Тэмдэглэл. Мөөгний хэрэглээг сурталчлах үйл ажиллагаа

Монголын мөөг судлаач, зөвлөхүүд Muug.mn сайтыг ажиллуулж, мөөгний талаарх ерөнхий мэдээллээс эхлээд үйлдвэрлэл, хэрэглээтэй холбоотой контент, мэдээ мэдээллийг өргөнөөр түгээж, олон нийтэд сурталчилах үйл ажиллагаа явуулдаг. MONMAP-AVC нь энэхүү сайттай хамтран мөөгний үйлдвэрлэлийн сүүлийн үеийн мэдээлэл, гэртээ хоол хийх аргын талаар видео контент бэлтгэж, үйлдвэрлэгчдийн тоо болон хэрэглээг нэмэгдүүлэх зорилгоор идэвхтэй түгээн дэлгэрүүлэхэд дэмжлэг үзүүлэн ажиллаж байна.

Мөн төрөл бүрийн арга хэмжээнд идэвхтэй оролцож, дотоодын мөөгний амталгаат худалдаа явуулсан нь олон оролцогчдын талархлыг хүлээсэн. Үйл ажиллагааны үеэр хувийн телевизээс мөөгний тухай цуврал тусгай нэвтрүүлэг хийх санал ирсэн ба хойшид энэ мэт олон нийтийн мэдээллийн хэрэгслийг сурталчилгаанд түлхүү ашиглах нь зүйтэй.



(2) Загас

Монгол улс далайд гарцгүй хэдий ч 500 км квадратаас дээш талбайтай, ашиглагдаагүй, загасны нөөцөөр баялаг хэд хэдэн нууруудтай. Олон нийтийн эрүүл мэндийн ойлголт нэмэгдэж, хүнсний бүтээгдэхүүн даяарчлагдаж байгаатай холбоотойгоор далайн бүтээгдэхүүний дотоодын хэрэглээний эрэлт, хэрэгцээ нэмэгдэх хандлагатай байна. Гэвч усны аж ахуйгаас гаралтай хүнс боловсруулах технологи хөгжөөгүй, мэргэшсэн байгууллага, мэргэжилтнүүд цөөхөн. Загасны нөөцийг тогтмол судалсны үндсэн дээр агнуурын квот тогтоон, загас үржүүлгийн төслүүдийг хэрэгжүүлж, нөөцийн менежментийг системтэй нэвтрүүлэн ашиглах шаардлагатай. Иргэдэд хоолны боловсрол олгох, хоол хийхэд хялбар, боловсруулсан бүтээгдэхүүн нийлүүлэх замаар загасны хэрэглээг нэмэгдүүлэн, дотоодод үйлдвэрлэсэн загасны хэрэглээг өргөжүүлэхийг зорино.

	Орц	Үйлдвэрлэл	Боловсруулалт	Ложистик, Экспорт	Борлуулалт, Хэрэглээ
Оролцогч	Загас агнуурын хэрэгсэл, боловсруулах тоног төхөөрөмж, хадгалах байгууламж	Загасчид, загас боловсруулах ААН, загас үржүүлгийн холбоод, ТББ-ууд	Загас боловсруулах ААН	Загасны боловсруулагч, борлуулагч ААН	Жижиглэнгийн дэлгүүр, ресторан гэх мэт.
Гол бэрхшээл	Боловсруулах, хадгалах байгууламж байхгүй тул эхнээс нь засвар үйлчилгээ хийх шаардлагатай. Боловсруулах тоног төхөөрөмж нь импортоос хамааралтай, орон нутагт худалдан авахад хүндрэлтэй байдаг.	Загас агнуурын улирал хязгаарлагдмал, жилийн турш загасчлах боломжгүй. Хэт их агнуурын улмаас нөөцийн хомсдолд орохгүйн тулд тогтмол нөөцийн судалгаа, үржүүлгийн ажил нэвтрүүлэх шаардлагатай.	Боловсруулах тоног төхөөрөмж байхгүй эсвэл боловсруулах технологи нь хоцрогдсон. Боловсруулсан бүтээгдэхүүний төрөл цөөхөн.	Түүхий эд, боловсруулсан бүтээгдэхүүнээ хадгалах хөлдөөгч, төхөөрөмж хүрэлцээгүйн улмаас жилийн турш нийлүүлэлт хийх боломжгүй.	Боловсруулсан бүтээгдэхүүнээ борлуулж, хоол хийх аргыг нэвтрүүлэх замаар хэрэглээг нэмэгдүүлэх шаардлагатай. Дотоодын загасны хэрэгцээ байгаа ч нийлүүлэлт хангалтгүй байна.
Авах арга хэмжээ	7.4 Загасан бүтээгдэхүүний хэрэглээг дэлгэрүүлэх зорилгоор загас боловсруулах цех байгуулах төлөвлөгөө				

Зураг 4.9 Түүхий загасны нийлүүлэлтийн сүлжээг бэхжүүлэх хөтөлбөр

Эх сурвалж: Жайка төслийн баг

Дотоодын түүхий загасны үйлдвэрлэл (загас агнуур хийх хэмжээ) бага. Иймээс боловсруулах үйлдвэрийн тоо, иргэдийн хэрэглээний хэмжээ бага байгаа ч сүүлийн жилүүдэд эрүүл хооллолтыг сурталчилж байгаатай холбоотойгоор өсөн нэмэгдэж буй загасны хэрэгцээг хангах, ашиглагдаагүй загасны нөөцийг ашиглах зорилгоор түүхий загас нийлүүлэлтийн сүлжээний тус хөтөлбөрийг санал оруулж байна. Дотоодын түүхий загас нийлүүлэх сүлжээ хөгжиж буй шатандаа байгаа тул үйлдвэрлэлээс эхлээд хэрэглээг хамарсан цогц үйл ажиллагааны төлөвлөгөө хэрэгтэй. “Үйлдвэрлэлийн үе шатанд” нөөцийн хомсдолоос зайлсхийхийн тулд нөөцийн судалгааг хийж, “боловсруулах үе шатанд” боловсруулах байгууламжийг хөгжүүлэх замаар боловсруулах системийг бэхжүүлж, “түгээлтийн үе шатанд” хөргүүр, хөлдөөгчтэй агуулахыг хөгжүүлж, “борлуулалт, хэрэглээний үе шатанд” иргэдэд хоол хүнсний боловсрол олгох арга замаар үйл ажиллагаа явуулахаар гол агуулгыг цогцлоосон.

Одоо байгаа загасны нөөцийн судалгааны үр дүнд үндэслэн хамгийн тохиромжтой гурван нуурыг (Дорнод аймгийн Буйр нуур, Архангай аймгийн Өгий нуур, Баян-Өлгий аймгийн Толбо нуур) зорилтот бүсээр сонгосон.

1) Загасны хэрэглээг нэмэгдүүлэх зорилгоор загас боловсруулах үйлдвэрийг хөгжүүлэх төлөвлөгөө

YAT 7.4 : Загасны хэрэглээг нэмэгдүүлэх зорилгоор загас боловсруулах үйлдвэрийг хөгжүүлэх төлөвлөгөө	
Төлөвлөгөөний зорилго	Дотоодын нууруудын загасыг хоолны орц болгон ашигласанаар, орон нутгийн иргэдийн хүнсний төрөл баяжина.
Суурь түвшин	Дотоодын загас боловсруулах үйлдвэр 2 газарт байгуулагдаж, иргэдийг загасан бүтээгдэхүүнээр тогтвортой хангана.
Хамрах хүрээ	Дорнод аймгийн Буйр нуур, Архангай аймгийн Өгий нуур гэх мэт загасны нөөц ихтэй бусад нуурууд (Баян-Өлгий аймгийн Толбо нуур гэх мэт)
Хүлээх үр дүн	(1) Төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд шаардлагатай ажлын удирдамжийг бэлтгэж, аймаг сумдын ХАА-н газар, Байгаль орчин, аялал жуулчлалын газарт танидцуулна. (2) Загас боловсруулах үйл ажиллагаа эрхэлдэг ААН-ийг сонгоно. (3) Сонгогдсон ААН-ийн загас боловсруулах үйлдвэрт шаардлагатай тохижолтыг хийж, загас боловсруулах ажлыг эхлүүлнэ. (4) Загас нутгийн иргэдийн хүнсний тогтвортой хэрэглээ (нэг хүнд ногдох жилийн хэрэглээ 0.18 кг-аас 0.3 кг болж нэмэгдэнэ) болно. (5) Загасан бүтээгдэхүүн нь бүс нутгийн онцлог бүтээгдэхүүн гэж дотооддоо танигдана. (6) Нуурын загасны нөөцийн судалгааг цаг тухайд нь тогтмол хийж, загас агнуур хийх зохимжит хэм хэмжээг тодорхойлно.
Үйл ажиллагаа	(1) Төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд шаардлагатай ажлын удирдамжийг бэлтгэж, аймаг сумдын ХААГ, Байгаль орчин, аялал жуулчлалын газруудад танилцуулна. ХХААХҮЯамны Хүнсний үйлдвэрийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар болон Жижиг, дунд үйлдвэрийн газраар ахлуулан, БОАЖЯамны Амьтан, ургамал, байгалийн нөөцийн бодлого зохицуулалтын газар, Тусгай хамгаалалттай газар нутгийн бодлого зохицуулалтын газартай хамтран МҮХАҮТанхимын Увс аймаг дахь салбар, Сансар Өгөөж компани нь 2022 онд Увс аймгийн Завхан суманд хэрэгжүүлсэн “Хяргас нуурт түүхий загас боловсруулах төсөл”-д үндэслэн тус төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд шаардлагатай ажлын удирдамжийг бэлтгэсэн. Хэрэгжүүлэх удирдамжийн үндсэн чиглэлийн талаар аймаг, сумдын ХАА-н газар, Байгаль орчин, аялал жуулчлалын газарт зохион байгуулах хурлын үеэр тайлбарлана. (2) Загас боловсруулах үйл ажиллагаа эрхэлдэг ААН-ийг сонгоно. БОАЖЯамны Амьтан, ургамал, байгалийн нөөцийн бодлого зохицуулалтын газар, Тусгай хамгаалалттай газар нутгийн бодлого зохицуулалтын газартай хамтран үйлдвэрлэлийн зориулалттай загас агнуур хийхэд тохиромжтой нууруудыг сонгоно. Сонгосон нууранд загас боловсруулах чиглэлээр үйл ажиллагаа явуулах хүсэлтэй орон нутгийн аж ахуйн нэгж, байгууллагуудаас сонгон шалгаруулалт хийх ба ингэхдээ тус нууранд загасчлах тусгай зөвшөөрөл эзэмшидэг сумын оролцоотой зөвшилцсөний үндсэн дээр үйл ажиллагаа явуулах байгууллагыг сонгоно. Үйл ажиллагаа явуулах эрх авсан байгуулага нь орон нутгийн сургуулийн үдийн хоолны материалыг үнэ төлбөргүй нийлүүлэх гэрээг давхар байгуулна. (3) Сонгогдсон ААН-ийн загас боловсруулах үйлдвэрт шаардлагатай тохижолтыг хийж, загас боловсруулах ажлыг эхлүүлнэ. Загасан бүтээгдэхүүн үйлдвэрлэхэд шаардлагатай тоног төхөөрөмж худалдан авах болон боловсруулах үйлдвэрийн орчныг тохижуулахад шаардлагатай санхүүгийн дэмжлэг үзүүлнэ. Загасан бүтээгдэхүүн үйлдвэрлэх, боловсруулах байгууламж нь “MNS 5170:2002 Загас, загасан бүтээгдэхүүн. Шинжилгээний арга”, “MNS CAC RCP 52:2011 Загас, загасан бүтээгдэхүүнтэй ажиллах дүрэм”-ийн стандартыг хангасан байна. Үйл ажиллагаа эрхлэх байгууллагын ажилтанд зориулсан цэнгэг усны загасаар хоол хийх аргын талаар мэдлэг, ур чадвар эзэмшүүлэх сургалт зохион байгуулна. Сургалтыг хэрэгжүүлэхэд Монголын загас, усны амьтдын үржүүлгийн холбоо ТББ-тай хамтран ажиллана. (4) Загас нутгийн иргэдийн байнгын хэрэглэдэг хүнс болно.

	Орон нутгийн сургуулийн үдийн хоолонд загасан хоолыг оруулж өгнө. Нуурын загас агнуурын нөөцийг удирддаг байгаль хамгаалагч нь хүүхдүүдэд загасан хоол идэх ашиг тус болон хүрээлэн буй орчны талаар зааж мэдлэг олгоно. (5) Загасан бүтээгдэхүүнийг бүс нутгийн онцлог бүтээгдэхүүн болгон дотоодод таниулна. Аймгийн Бүс нутгийн хөгжлийн асуудал хариуцсан газар, Байгаль орчин, аялал жуулчлалын газар, хувийн хэвшлийн аж ахуйн нэгжүүд хамтран бүс нутгийн онцлог бүтээгдэхүүнийг баталгаажуулах тогтолцоог бий болгоно. Загасан бүтээгдэхүүнийг бүс нутгийн онцлог бүтээгдэхүүн болгож, дотооддоо сурталчина. Аймаг бүрийн онцлог бүтээгдэхүүний газрын зураг гаргана. Загасан бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг бусад аймагуудтай (Увс аймаг г.м.) хамтран сурталчилах үйл ажиллагааг явуулснаар илүү өргөн хүрээтэй, том хэмжээний сурталчилгааны үйл ажиллагаа зохион байгуулна. (6) Нуурын загасны нөөцийн судалгааг цаг тухайд нь тогтмол хийж, загас агнуурын зохимжит хэмжээг тодорхойлно. Нуурын загасны нөөцийн судалгааг аймаг, сум, БОАЖЯамны Амьтан, ургамал, байгалийн нөөцийн бодлого зохицуулалтын газар, тусгай хамгаалалттай газар нутгийн бодлого зохицуулалтын газар, Монголын загас, усны амьтдын үржүүлгийн холбоо ТББ-тай хамтран тогтмол зохион байгуулна. Судалгааны үр дүнд үндэслэн зөвшөөрөгдөх агнуурын хэмжээг тогтоож, тогтмол нөөцийн судалгаа явуулсанаар нөөцийн хэмжээний өөрчлөлтийн хүчин зүйлийг ойлгоно.	
Санхүүжилт	<u>Засгийн газар</u> • Төв, орон нутгийн төрийн албан хаагчдын томилолтын зардал (хоол, замын зардал) • Боловсруулах үйлдвэрийн тоног төхөөрөмж худалдан авах зардал, гаалийн татвараас чөлөөлөх • Загасны нөөцийн судалгааны зардал • Орон нутгийн сургуулиудад хоол хүнс, байгаль орчны боловсрол олгох зардал (багшийн төлбөр, сургалтын материалын төлбөр) • Сургуулийн үдийн хоолонд орон нутгийн түүхий эд ашигласны урамшуулал татаас	<u>Хувийн хэвшил</u> • Боловсруулах үйлдвэрийн засвар үйлчилгээний зардал • Загасан түүхий эдийг худалдан авах, бэлтгэн боловсруулах зардал • Борлуулалтыг дэмжих, сурталчилгааны ажлын зардал • Цэвэр усны загас боловсруулах технологийн сургалтын зардал
Төслийн өртөг	Төслийн нийт өртөг: 1 тэрбум 25 сая төгрөг (390,000 USD)	
Ашиг, үр нөлөө	Нуур болгоноос жилд агнаж болох загасны хэмжээ нь Буйр нуураас 45 тн, Өгий нуураас 20 тн, Толбо нуураас 15 тн, нийт 80 тн гэсэн тооцоолол байна. Эдгээр нөөцөд тулгуурлан шинээр бүтээгдэхүүн үйлдвэрлэвэл (вакум савлагаатай) бүтээгдэхүүний нийт үнэ 544,000,000 төгрөг болно. Түүнчлэн нэг боловсруулах үйлдвэрт 3 хүн * 12 сар (28,800,000 төгрөг) ажлын байр бий болно. Мөн тухайн бүс нутагт нэг хүнд ногдох жилийн загасны хэрэглээ 0.3 кг хүрч нэмэгдэнэ.	
Бодлогын бичиг баримттай уялдсан байдал	1. Алсын хараа 2050, 6-р бүлэг Аялал жуулчлалын үйлдвэрлэл үйлчилгээний төрөл зүйлийг нэмэгдүүлэх. 2. Алсын хараа 2050, 6-р бүлэг Тухайн бүс нутгийн байгалийн дурсгалт газар, түүх, соёлын өвийн онцлогийг илэрхийлсэн соёлын брэндийг бий болгох. 3. Монгол Улсын Их Хурлын 36 дугаар тогтоол 5.6.2. Хүнсний үйлдвэрийн техник, тоног төхөөрөмжийг гаалийн албан татвараас чөлөөлөх, татвар төлөх хугацааг хойшлуулах зэрэг хэлбэрээр татварын дэмжлэг үзүүлнэ. 4. Монгол Улсын Их Хурлын 36 дугаар тогтоол 5.10.3. Иргэдийн хоолны дэглэм, хүнсний талаарх мэдлэгийг дээшлүүлэх зорилтот төслүүдийг хэрэгжүүлнэ. 5. Эрүүл хүнс-Эрүүл Монгол хүн үндэсний хөтөлбөрийн зорилго 1.3 Загас, шувууны аж ахуйг дэмжих. 6. Эрүүл хүнс-Эрүүл Монгол хүн үндэсний хөтөлбөрийн зорилт 1.6 Дотоодын хүнсний үйлдвэрлэлийг дэмжих зорилгоор татварын болон татварын бус зохицуулалтыг хэрэгжүүлнэ. 7. Эрүүл хүнс-Эрүүл Монгол хүн үндэсний хөтөлбөрийн зорилт 4.8 Орон нутгийн хүнсний үйлдвэрлэлийг тогтвортой хөгжүүлэх.	

	8. Эрүүл хүнс-Эрүүл Монгол хүн үндэсний хөтөлбөрийн зорилт 4.6 Үндэсний болон орон нутгийн төсвөөр худалдан авч буй дотоодод үйлдвэрлэсэн хүнсний бүтээгдэхүүнийг төрөлжүүлэх. 9. Ерөнхийлөгчийн санаачилсан хүнсний хувьсгал үндэсний хөдөлгөөн.
Төслийг хэрэгжүүлэхэд анхаарах зүйлс	• Нуурын загас агнуурын нөөц хомсдохоос урьдчилан сэргийлэх нь нэн тэргүүний зорилт бөгөөд нөөцийн найдвартай судалгааг хийж чадахгүй тохиолдолд тус төлөвлөгөөний хэрэгжилтийг түр зогсоох хэрэгтэй. • Загасны нөөцийг хамгаалах хамгийн чухал зүйл бол даацаас хэтрүүлэн загас агнахгүй байх, загас үржлийн газрыг тодорхойлох, тэдгээр газрыг загас агнуурын хориотой бүс болгон хамгаалах, загас барихыг хориглох хугацааг тогтоох хэрэгтэй. • Загасны нөөцийг хамгаалахын тулд үржүүлгийн технологи нэвтрүүлэх төлөвлөгөө гаргах шаардлагатай. Энэ тал дээр Хятад улсаас технологийн дэмжлэг авах боломжийн талаар судлах хэрэгтэй. • Шаардлагатай бол загас агнуурын хориотой хугацаанд түүхий эдийг хадгалах хөргүүртэй хөлдөөгч агуулахыг барьж байгуулах.

Төслийг хэрэгжүүлэх хуваарь, төсөв

Үйл ажиллагаа		2025	2026	2027	2028	2029	2030	2031	2032	2033	2034	Нийт
(1) Төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд шаардлагатай тогтолцоо, ажлын удирдамжийг бэлтгэж, зорилтот аймаг сумдын ХААГ, Байгаль орчин, аялал жуулчлалын газруудад танилцуулна												
(2) Загас боловсруулах үйл ажиллагаа эрхэлдэг ААН-ийг сонгоно.												
(3) Сонгогдсон ААН-ийн загас боловсруулах үйлдвэрт шаардлагатай тохижилтыг хийж, боловсруулалт хийнэ												
(4) Загас нутгийн иргэдийн хүнсний хэрэглээ болно.												
(5) Загасан бүтээгдэхүүнийг бүс нутгийн онцлог бүтээгдэхүүн болгон дотоодод сурталчилна.												
(6) Нуурын загасны нөөцийн судалгааг цаг тухайд нь тогтмол хийж, загас агнах зохимжит хэмжээг тодорхойлно.												
Төслийн өртөг	сая төгрөг	55	136	108	108	103	103	103	103	103	103	1,025
	мян. ам.дол	23	51	41	41	39	39	39	39	39	39	390

Тэмдэглэл: Загас боловсруулах үйлдвэр хөгжүүлэх төсөл

Увс аймгийн Хяргас нуурт түүхий загас боловсруулах цех байгуулж, боловсруулах тоног төхөөрөмж нийлүүлэн туршилтын үйл ажиллагаа явуулсан. Өнөөг хүртэл орон нутгийн иргэдийн ахуйн хэрэглээгээр хязгаарлагдан, үр дүнтэй ашиглаж чадахгүйгээс орхигдоод байсан загасны нөөцийг шинээр байгуулсан цехдээ боловсруулж, бүтээгдэхүүн үйлдвэрлэх цогц ажиллагааг эхлүүлсэнээр бодитоор арилжааны хэлбэрт оруулж, үр дүнд хүрч чадсан. Үүний зэрэгцээ, нуурын байгаль орчныг хамгаалах тухай хуульд нийцүүлэн үйл ажиллагаагаа явуулахын тулд зохицуулалт хийх, загас агнуур зөвшөөрөгдсөн хугацаа богиноос үүдэн хадгалах, агуулах байгууламж шаардлагатай болох зэрэг шинэ асуудлууд үүсэх нь тодорхой болсон.

4.2.8 ХАА-н бүтээгдэхүүний чанар, эрүүл ахуйн хяналтын тогтолцоог бэхжүүлэх хөтөлбөр

Эрүүл ахуйн хяналтын чиг үүрэг бүхий төрийн байгууллагад бүтцийн өөрчлөлт хийгдэж байгаа ба эрүүл ахуйн хяналтын ерөнхий түвшинг дээшлүүлэх шаардлагатай байгаа хэдий ч байгууллагуудын үүрэг тодорхойгүй, ойлгомжгүй байна. ААН-ийг зохих ёсоор дэмжихийн тулд төрийн хяналтын тогтолцоог яаралтай тодорхой болгох шаардлагатай байна.
Эрүүл ахуйн хяналт чухалд тавигддаг салбар бол гадаад худалдааны салбар хэдий ч хяналтын байгууллагын шинжилгээний чадавхи хангалтгүй байна. Түүнчлэн, экспортыг дэмжихэд, олон улсын түвшний чанарын хяналт, хүнсний аюулгүй байдлын баталгаажуулалтыг нэвтрүүлэхийг эрчимжүүлэх, өрсөлдөх чадварыг бэхжүүлэх шаардлагатай байна.

Оролцогч	Засгийн газрын байгууллага	Хяналтын байгууллага	Олон нийтийн байгууллага (Магадлан итгэмжлэл, баталгаажуулалтын байгууллага)	ААН, үйлдвэрлэгчид
Гол бэрхшээл	Холбогдох яам, агентлагуудын зохицуулах үүргийг нөхөх? (хариуцах) бүтэц байхгүй. Хүнсний аюулгүй байдалтай холбоотой төрийн байгууллагад бүтцийн өөрчлөлт хийгдсэн. Мэргэжлийн хүний нөөц дутагдалтай.	Шинжилгээний багаж, урвалж хүрэлцээгүй. Дээж авах болон хяналтын байгууллагын хандлагад ААН-үүд сэтгэл дундуур байдаг. Бичиг баримт боловсруулах чадвар муу. Олон улсын баталгаажуулалт авсан хэдий ч импортлогч улс нь итгэдэггүй.	Баталгаажуулалтын байгууллагын аудит хийх чадвар, итгэл үнэмшилтэй холбоотой асуудал бий. Баталгаажуулалт авахад туслах зөвлөх хүрэлцээгүй. ААН-дийн хүний нөөцөө сургах нөөц /эх үүсвэр/ байхгүй.	Мэдээлэл цуглуулалт хангалтгүй, худалдааны журам төвөгтэй. ОУ-ын баталгаажуулалт, мөшгих тогтолцоо нэвтрүүлэх зэрэг оролдлого жигд биш. ААН-ийн хүний нөөцийн сургалт хоцрогдсол.
Авах арга хэмжээ	8.1.Хүнсний аюулгүй байдлын төрийн хяналтын чадавхийг бэхжүүлэх төлөвлөгөө 8.2 Экспортын хяналтын чадавхийг бэхжүүлэх төлөвлөгөө 8.3 Бэлтгэн нийлүүлэлтийн дараах алдагдлыг бууруулах бэлтгэл судалгааны төлөвлөгөө 8.4. Эрүүл ахуй, чанарын хяналтын хүний нөөцийг сургах төлөвлөгөө 8.5 Олон Улсын баталгаажуулалт авах, экспортын өрсөлдөх чадварыг бэхжүүлэх төлөвлөгөө			

Зураг 4.10 ХАА-н бүтээгдэхүүний чанар, эрүүл ахуйн хяналтын тогтолцоог бэхжүүлэх хөтөлбөр

Эх сурвалж: Жайка төслийн баг

Өдгөө Монгол Улсад чанар, эрүүл ахуйн хяналтын удирдлагын тогтолцооны шинэчлэлтийн процесс явц дундаа байгаа бөгөөд энэхүү тогтолцоог ойрын хугацаанд үинэчлэн зохион байгуулах шаардлагатай байгаа. Чанарын хяналтыг олон улсын түвшинд хэрэгжүүлэхийн тулд, хяналт шалгалтын чадавхийг оролцуулаад ерөнхий сууриар нь сайжруулах шаардлагатай байна. Хууль хэдийгээр үйлчилж байгаа ч, ААН-д үзүүлэх дэмжлэг хязгаарлагдмал, жижиг дунд үйлдвэрүүд олон улсын түвшний чанарын хяналтыг хэрэгжүүлэхэд ААН-д оногдох ачаалал их байна. ААН, компаниудыг дэмжих мэргэжлийн боловсон хүчнийг бэлдэх шаардлагатай.

Хүснэгт 4.8 ХАА-н бүтээгдэхүүний чанар, эрүүл ахуйн хяналтын тогтолцоог бэхжүүлэх хөтөлбөр болон хөгжлийн чиглэлийн хамаарал холбоо

	Бодит бэрхшээл, давуу тал, хөгжлийн чиг баримтлалын агуулга	ХАА-н бүтээгдэхүүний чанар, ЭА-н хяналтын тогтолцоог бэхжүүлэх хөтөлбөр: 3 төлөвлөгөө			
		8.1	8.2	8.3	8.4
Бэрхшээл	Засаг төрийн байгууллагын хяналтын чадавхи хангалтгүй	◎	○	○	
	Хяналт шалгалтын байгууллагын төлөвшилт хангалтгүй	○	◎	○	○
	Олон улсын түвшний чанарын баталгааг хангах чадвар бүрдээгүй	○	○	○	◎
	ААН-н хүчин чадал дутмаг	○		◎	○
Хөгжлийн чиглэл 2-1	Хүнсний аюулгүй байдлын чанарын тогтолцоог шинэчлэн сайжруулах	◎	○		
	Хүнсний бүтээгдэхүүн, бүтээгдэхүүний хяналт шинжилгээний байгууллагын хүчин чадлыг бэхжүүлэх	○	◎	○	
	Хувийн секторт эрүүл ахуй, чанарын хяналтын хүний нөөцийг сургаж бэлтгэх	○		◎	○
	Олон улсын түвшний итгэмжлэлтэй болоход дэмжлэг үзүүлэх		○	○	◎

Эх сурвалж: Жайка төслийн баг ○ : Өндөр хамааралтай, ◎ : Хүчтэй хамааралтай

“**8.1 Хүнсний аюулгүй байдлын төрийн хяналтын чадавхийг дээшлүүлэх төлөвлөгөө**”-ний хүрээнд хүнсний аюулгүй байдлын тогтолцооны төрийн байгууллагуудын үүрэг, хууль эрх зүйн үндэслэлийг авч үзэж, хяналтын байгууллагуудын эрсдлийн хяналтын төлөвлөгөө болон мониторингийн төлөвлөгөөг боловсруулж хэрэгжүүлнэ. Хүнсний аюулгүй байдал, эрүүл ахуйн хяналт хариуцсан байгууллагын чиг үүрэг, хариуцлагыг тодорхойлж, чанар, эрүүл ахуйн хяналтын чадавхийг тасралтгүй сайжруулахын зэрэгцээ, төрийн хяналтын ажилтнуудын хүнсний аюулгүй байдлынхяналтын чадавхийг дээшлүүлж, зохистой арга хэмжээг хэрэгжүүлж чадахуйц мэдлэг туршлагатай болгохыг зорино.

“8.2 Экспортын хяналт шинжилгээний чадавхийг бэхжүүлэх төлөвлөгөө”-гөөр ХАА-н бүтээгдэхүүнийг экспортлоход шаардлагатай шинжилгээний чадавхийг бэхжүүлэхийг зорино. Хорио цээрийн талаарх мэдээллийг тогтмол шинэчилж байх тогтолцоог бүрдүүлж, шинжилгээний байгууллагыг экспортын шинжилгээг зохистой түвшинд хийж чадахуйц хэмжээнд тоноглох төлөвлөгөөг боловсруулна. Шаардлагатай шинжилгээг үр ашигтай хийж чадах, тоног төхөөрөмжөөр хангах ажлыг төлөвлөгөөтэйгөөр хэрэгжүүлэхийн зэрэгцээ шинжилгээний ажилтны мэдлэг чадварыг дээшлүүлэхийг зорино. Хяналт шинжилгээний байгууллагын туршилт шинжилгээний чадавхийг бэхжүүлж, олон улсын итгэмжлэл авах ажлыг өргөжүүлнэ.

“8.3 Бэлтгэн нийлүүлэлтийн дараах алдагдлыг бууруулах бэлтгэл судалгааны төлөвлөгөө" нь үйлдвэрлэлийн дараагийн шатнаас түгээх хүртэлх хүнсний алдагдлын бодит байдлыг тодруулж, алдагдлыг бууруулах төслийг боловсруулахад зорилготой. Бэлтгэн нийлүүлэлтийн дараах алдагдлын бодит нөхцөл байдал тодорхой бус байгаа тул энэхүү төлөвлөгөө нь бэлтгэн нийлүүлсний дараагаас жижиглэн худалдаалахын өмнөх үе хүртэлх

хүнсний бүтээгдэхүүний алдагдалд анхаач, Монгол Улсад алдагдлын түвшин өндөр байгаа хүнсний болон нийлүүлэлтийн сүлжээний үе шатуудыг тодорхой болгож, тухайн хүнсний бүтээгдэхүүний боловсруулалтын алдагдлыг бууруулах загварыг бий болгох, алдагдлыг бууруулах бизнес төлөвлөгөө боловсруулахыг зорино.

"8.4 Чанар, эрүүл ахуйн хяналтын хүний нөөцийг сургаж бэлтгэх төлөвлөгөө"-гөөр үйлдвэр, ААН-ийн чанар, эрүүл ахуйн хяналтын чадавхийг дээшлүүлэх чанар, эрүүл ахуйн хяналтын сургагч бэлтгэх тогтолцоог бүрдүүлж, сургагч багшийг бэлтгэнэ. Үйлдвэрлэлийн хэмжээнээс ялгаатай нь чанар нь үнэд шууд шилжих боломжгүй бөгөөд ихэвчлэн урьдчилсан зардал шаардагддаг. Хөрөнгийн боломжтой томоохон компаниудтай харьцуулахад жижиг, дунд компаниуд чанарын хяналтын тал дээр хоцрогдсон, чанарын хяналтын чиглэлээр мэргэшсэн нэгж тасаг, хүний нөөц дутмаг эсвэл байдаггүй. ЖДҮ-лэлийг чиглүүлж, дэмжихэд чиглэж ажиллах эрүүл ахуй, чанарын хяналтаар мэргэшсэн хүний нөөцийг бэлдэх шаардлагатай. Хүний нөөцийг тасралтгүй сургаж бэлтгэдэг тогтолцоог бүрдүүлж ЖДҮ-үүд олон улсын HACCP (Аюулын шинжилгээний чухал хяналтын цэг), FSSC22000 (Хүнсний аюулгүй байдлын удирдлагын тогтолцоо) зэрэг баталгаажуулалтуудыг авах орчныг бүрдүүлэхийг зорино.

ҮАТ 8.4-ийг хэрэгжүүлж ААН-ийн чадавхийг дээшлүүлэхийн зэрэгцээ, "**8.5 Олон улсын баталгаажуулалт авах замаар экспортын өрсөлдөх чадварыг бэхжүүлэх төлөвлөгөө**"-гөөр экспортын зорилтот зах зээлд нөлөөлж чадахуйц олон улсын баталгаажуулалт авах замаар экспортыг нэмэгдүүлэхийг зорино. ХАА-н бүтээгдэхүүний экспортын давуу тал болох олон улсын баталгаажуулалтыг тодорхойлохын зэрэгцээ олон улсын баталгаажуулалтын итгэмжлэлийн тогтолцоог бэхжүүлнэ. Мөн хяналтын байцаагчийн тоог нэмэх, хяналт шинжилгээний ур чадварыг дээшлүүлэх, баталгаажуулалтын байгууллагыг бэхжүүлэх зорилго тавина. Баталгаажуулалт авахыг зорьж буй үйлдвэр, ААН-д дэмжлэг үзүүлнэ

(1) Хүнсний аюулгүй байдлын менежментийн чадавхийг дээшлүүлэх төлөвлөгөө

ҮАТ 8.1: Хүнсний аюулгүй байдлын төрийн хяналтын чадавхийг бэхжүүлэх төлөвлөгөө	
Төлөвлөгөөний зорилт	Хүнсний эрүүл ахуй, чанарын хяналтын үйл ажиллагааг үндсээр нь сайжруулах зорилт
Суурь түвшин	Эрсдлийн удирдлагын төлөвлөгөөнд тулгуурласан бодлогын үнэлгээ байхгүй.
Төлөвлөгөөний зорилго	Эрсдлийн удирдлагын төлөвлөгөөнд үндэслэсэн бодлогын үнэлгээний үр дүнг жил бүр гаргадаг болох.
Хамрах хүрээ	Орон даяар
Хүлээх үр дүн	Хүнсний аюулгүй байдал, чанарын хяналтад холбоотой байгууллагын чиг үүрэг, хариуцлагыг тодорхой болгох, удирдлагын үйл ажиллагааны үндэслэлийг тогтоох. Чанар, эрүүл ахуйн хяналтын чадавхи тасралтгүй сайжрах тогтолцоог бүрдүүлэхийн зэрэгцээ төрийн ажилтны хүнсний аюулгүй байдлын талаарх мэдлэг чадвар дээшилж, оновчтой бодлого арга хэмжээ хэрэгжүүлэх чадвартай болох.
Үйл ажиллагаа	(1) Хүнсний аюулгүй байдлын системд холбоотой байгууллагын чиг үүргийг тодорхой болгох, хүнсний аюулгүй байдлын талаар хянан хэлэлцэх механизм форум бий болгох. ХХААХҮЯ, ЭМЯ, ГЕГ, ХАБҮЛ лаборатори, УМЭАЦТЛ манлайлан холбогдох байгууллагуудын (Мал эмнэлгийн ерөнхий газар, ЖДҮГ, Стандарт, хэмжил зүйн газар, БОАЖЯ, Хорио цээрийн алба, Хүнсний шинжилгээний хувийн лабораториуд болон

	бусад) ажил үүргийн хуваарийг эмхлэн тогтоож, тодорхой болгох. Ажил үүргийн хуваарийг тогтоохдоо гадаад улсын систем, жишээг судлан шинжилж, загвар болгон ашиглах. Хүнсний аюулгүй байдлын асуудлыг тогтмол хугацаатай хянан хэлэлцэж байхын тулд холбогдох байгууллагуудыг оролцуулсан Хороо байгуулах. (2) Хууль эрх зүйн тогтолцооны сул талыг олж тогтоох, шаардлагатай тохиолдолд хууль эрх зүйн тогтолцоог шинэчлэн сайжруулах, шинээр бүрдүүлэх. Одоо хэрэгжиж буй хууль эрх зүйн тогтолцоог эргэн үзэж, байгууллага тус бүрийн ажил үүргийн хуваарийг баталгаажуулах дүрэм журмыг боловсруулах. (3) Бүх төрийн байгууллага өөрсдийн ажил үүргийн хуваарийн дагуу Эрсдлийн хяналтын төлөвлөгөө боловсруулах. Төрийн байгууллагуудын үндсэн чиг үүргийн хувьд, үр дүнтэй бөгөөд цаг үеэ олсон шуурхай арга хэмжээг хэрэгжүүлэх үүднээс Эрсдлийн удирдлагын төлөвлөгөө боловсруулж ажиллах. Эрсдлийн удирдлагын нэг арга технологийн хувьд, ХХААХҮЯ-ны ажилд шаардагдаж буй ХАА-ийн зохистой дадал зэргийн шинжилгээний дүрэм журмыг шуурхай боловсруулах. Эрсдлийн удирдлагын байгууллага ХАА-н зохистой дадал, Эрүүл ахуйн зохистой дадал, Үйлдвэрлэлийн зохистой дадлын хяналт шинжилгээг нэвтрүүлэх гэх мэтээр аж ахуйн нэгжийн хүнсний аюулгүй байдал, чанарын хяналтын талаар хэрэгжүүлж буй үйл ажиллагаанд хяналт тавьж, үнэлгээний мониторингийн төлөвлөгөөг боловсруулах. Хариуцсан байгууллага бүр ажил үүргийн хуваарийн дагуу мониторинг хийх ажилтан болон түүний зардал төсвийг хариуцан гаргана. Мөн хяналт шалгалтын үр дүнд, зөрчил илэрсэн тохиолдолд, мэдээлэх, эргүүлэн татах ажлыг албадан явуулах, удирдлага, шийтгэл оноох зэрэгт урьдчилан тогтоосон журмыг баримтлан хэрэгжүүлнэ. Төрийн байгууллагын хүний нөөц, мэргэжлийн боловсон хүчнийг бэлтгэх системийг бий болгох, тогтмол хугацаанд сургалт хэрэгжүүлэх. (4) Дотоодын зах зээлд нийлүүлэгдэж буй хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлын хяналтын чиг үүргийг бэхжүүлэх. ХХААХҮЯ-ны Салбарын хяналтын газраас манлайлан ЭМЯ, Гаалийн алба, Хүнсний аюулгүй байдлын лавлагаа лабораторитой хамтран дотоодод үйлдвэрлэсэн болон боловсруулсан хүнсний бүтээгдэхүүн, импортын хүнсний бүтээгдэхүүнд хяналт шалгалт хийх хяналтын байгууллагыг тодорхойлох, бүртгэх. Дотоодод үйлдвэрлэсэн, боловсруулсан хүнсний бүтээгдэхүүн ((3) GAP, GHP, GMP-ийг нэвтрүүлэх замаар үйлдвэрлэлийн процессыг хянаж, аюулгүй байдлыг онолын хувьд хангах) тухайд (1)-н зохион байгуулсан ажил үүргийн хуваарилалтын дагуу хариуцна. Захиргааны байгууллага зах зээлийн гэнэтийн хяналт шалгалтын төлөвлөгөө болон үйлдвэр ААН-ийн дотоод шалгалтын төлөвлөгөөг боловсруулж, түүнийг томилсон буюу бүртгэлтэй хяналтын байгууллага шалгаж, хариуцсан захиргааны байгууллагад тайлагнана. Хариуцсан захиргааны байгууллага нь (3)-д заасан менежментийн төлөвлөгөөний дагуу нийтэд мэдээлэх, шаардлагатай захиргааны арга хэмжээг авна. Импортын хүнсний тухайд хариуцсан захиргааны байгууллага нь (1)-д зохион байгуулсан ажил үүргийн хуваарилалтын дагуу хяналтын заавар журмыг зохион байгуулж, хорио цээрийн газартай хамтран эрсдэлийн үнэлгээний стандарт, дээж авах/хяналтын төлөвлөгөөг зохих ёсоор хянах тогтолцоог бүрдүүлнэ. Тодорхой хүнсний аюулгүй байдлын янз бүрийн стандартуудад CODEX-ийн тодорхойлолтыг тодорхой хугацаанд ашиглах боломжтой. Хорио цээрийн цэг нь дээж авах/шинжлэх төлөвлөгөөг хүлээн авч, хяналт шалгалтыг явуулж, хариуцсан захиргааны байгууллагад тайлагнана. Хариуцсан захиргааны байгууллага нь үр дүнг хүлээн авсны дараа шаардлагатай бол дээж, шалгалтын төлөвлөгөөг шинэчлэн боловсруулж, үр дүн, шинэ төлөвлөгөөг зарлаж, (3)-т заасан менежментийн төлөвлөгөөний дагуу шаардлагатай захиргааны арга хэмжээг авна. (5) Хүнсний аюулгүй байдлын удирдлагын бодлогын үнэлгээг явуулах. Байгууллагуудын хийсэн үнэлгээний үр дүнг Хороогоор хэлэлцэн шаардлагатай бол засвар шинэчлэлийг хийх.	
Санхүүжилт	<u>Засгийн газар</u> • Бодлогын зөвлөх урих зардал • Судалгааны зардал • Хорооны үйл ажиллагааны зардал • Цалингийн зардал	<u>Хувийн хэвшил</u> -

Төслийн өртөг	Төслийн нийт өртөг: 1,882 сая төгрөг (716,000 USD)
Ашиг, үр нөлөө	Монголд хүнсний аюулгүй байдлын нөхцөл сайжрах, хэрэглэгчдийн итгэлийг олж авах, импортыг орлох хэмжээ дээшлэх, хүнсний үйлдвэр, ААН-үүдэд хууль дүрэм дагаж мөрдөх үйл явц сайжрах
Бодлогын бичиг баримттай уялдсан байдал	Алсын хараа 2050 2.5.20. Ард түмний хүнсний хангамж, хүнсний хүртээмжийг тогтвортой байлгах, нийлүүлэлт тээвэрлэлтийн шатанд хүнсний аюулгүй байдлыг хадгалах, хүнс үйлдвэрлэлийн салбарын төрөл бүрийн стандартыг олон улс, бүс нутаг, өндөр хөгжилтэй орнуудын түвшинд хүргэх зорилго бүхий бодлогыг хэрэгжүүлнэ.
Төсөл хэрэгжүүлэхэд анхаарах зүйлс	• Хандивлагчидтай идэвхтэй, нягт хамтран ажиллах, хандивлагч байгууллагуудын зөвлөмж тусламж авах. • Гадаадын улс орнуудын тогтолцооноос үлгэр авч, экспортод чиглэсэн тогтолцоог бий болгох. • Бусад улс, олон улсын байгууллагын мэдлэг туршлагыг идэвхтэй ашиглах, дотоодод хэрэгжүүлэх үйл ажиллагааны дэс дарааг нарийн эрэмбэлэх, чиг үүргийн сонголтыг нухацтай судлан, шийдэх. • Олон улсын байгууллага болон түншлэгч гол орнуудтай тус салбарын хамтын ажиллагааны сувгийг бий болгох.

Төслийг хэрэгжүүлэх хуваарь, төсөв

Үйл ажиллагаа		2025	2026	2027	2028	2029	2030	2031	2032	2033	2034	Нийт
(1) Хүнсний аюулгүй байдлын системийн холбогдох байгууллагын чиг үүргийг нарийвчлан тогтоох, хүнсний аюулгүй байдлын талаар авч хэлэлцэх механизмыг бий болгох.												
(2) Хууль эрх зүйн орчны дутагдалтай талыг олж тодруулах, хууль дүрэм журмыг шаардлагад нийцүүлэн шинэчлэн сайжруулах.												
(3) Төрийн байгууллага бүр өөрийн ажил үүргийн хуваарийн дагуу Эрсдлийн хяналтын төлөвлөгөө боловсруулж ажиллах.												
(4) Дотоодын зах зээлд нийлүүлэгдэж буй хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлын хяналтын чиг үүргийг бэхжүүлэх.												
(5) Хүнсний аюулгүй байдлын төрийн байгууллагад бодлогын үнэлгээ хийх.												
Төслийн өртөг	сая төгрөг	462	423	423	82	82	82	82	82	82	82	1,882
	мян. ам.дол	177	161	161	31	31	31	31	31	31	31	716

Тэмдэглэл: Хүнсний аюулгүй байдлыг хангах суурь тогтолцоо

Японы хүнсний аюулгүй байдлыг хангах тогтолцооны түүхэн өөрчлөлт: Хүнсний аюулгүй байдлыг хангах ажил нь, тухайлсан хүнсний бүтээгдэхүүнд тогтоох хязгаарлалтаас, эрүүл ахуйн шатанд бүх талыг хамруулсан хяналт тавих ажиллагаанд шилжиж, улмаар түүнийг гуравдагч этгээдээр баталгаажуулах тогтолцоо руу шилжиж ирсэн. Минамата өвчин зэрэг өргөн хэмжээний бүс нутаг дахь байгаль орчныг бохирдуулсан нийтийн аюулаас гадна хүнсний үйлдвэрт гарсан томоохон хэмжээний хэрэг явдлаас үүдэн тухай бүрт хууль эрх зүйн орчныг сайжруулах, шинээр хууль дүрэм гаргах зэрэг ажил хийгдэж ирсэн. Сүүлийн үед, 2000 онд Юкижирүши группэд гарсан хоолны хордлоготой холбогдуулан Хүнсний эрүүл ахуйн хуульд үндэслэн Ерөнхий эрүүл ахуйн хяналтын доорхи үйлдвэрлэлийн процесс (HACCP-ийг мөрдөх)-ийг шинэчлэх тогтолцоог нэвтрүүлж, 2002 онд импортын хөлдөөсөн ногоонд илэрсэн УХБ-ын үлдэгдлийн асуудлаас үүдэн үлдэгдэл УХБ-ын эсрэг тогтолцоог нэвтрүүлснээр импортын хүнсний хяналт шалгалтын тогтолцоог бэхжүүлсэн. Мөн 2001 онд дотоодод BES (Биологийн олон янз байдал ба

экосистемийн үйлчилгээ) сүлжээ бий болж, үүнтэй холбогдуулан Хүнсний аюулгүй байдлын суурь хуулийг батлан хэрэгжүүллээ. BES сүлжээ үүссэн нь, мөрдөх чадварыг нэвтрүүлэх, Мал амьтны халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх хууль, Тэжээлийн аюулгүй байдлын хууль зэргийг ч шинэчлэн сайжруулахад хүргэсэн юм. Хүнсний аюулгүй байдлын суурь хуулийг баталсан нь Японы хүнсний аюулгүй байдлын удирдлагад томоохон өөрчлөлт гаргаж, өнөөдрийг хүрлээ. Засгийн газрын харьяанд Хүнсний аюулгүй байдлын Хороо байгуулагдаж, хүний эрүүл мэндэд хүнсний нөлөөлөх үнэлгээ (эрсдлийн үнэлгээ) хийх болсон. Уг эрсдлийн үнэлгээний үр дүнг үндэслэн Эрүүл мэнд, хөдөлмөр, нийгэм хамгааллын яам болон ХАА, ой, загас агнуурын яам эрсдлийн хяналтыг хариуцдаг болсон. Эрсдлийн үнэлгээ явуулах этгээд Хүнсний аюулгүй байдлын хороо нь, эрсдлийн үнэлгээтэй холбогдох төрийн байгууллагаас хараат бусаар ажиллаж, шинжлэх ухааны мэдлэг туршлагад тулгуурлан бодитой бөгөөд албан ёсны голч байр сууринаас эрсдлийн үнэлгээг явуулдаг. Мөн эрсдлийн үнэлгээний ажилтан, эрсдлийн хяналтын ажилтан, хүнсний үйл ажиллагаа эрхлэгч нараас гадна хэрэглэгчдийн төлөөллийг хамруулан оролцогч талуудын хоёр талын байр суурийг баримтлан хэрэгжүүлж байгаа мэдээлэл, санал солилцох үйл явц нь бодлого тодорхойлох үндэс суурь болж байдаг юм.

Монгол дахь GAP/GHP/GMP (ХАА-н зохистой дадал, Эрүүл ахуйн зохистой дадал, Үйлдвэрлэлийн зохистой дадал) боловсруулан нэвтрүүлэх үйл явц: ① ОУСК-ийн дэмжлэгээр хэрэгжсэн Монгол мах төслийн үр дүнд ХАА-н зохистой дадал хөгжиж ирсэн. Мөн мах боловсруулагчдад зориулан Эрүүл ахуйн зохистой дадал, Үйлдвэрлэлийн зохистой дадлын эхний хувилбарыг боловсруулсан бөгөөд тодорхой удирдамж боловсруулах ажил удахгүй эхлэх гэж байна. Хяналт шинжилгээний байгууллагаас шаардлагатай хяналтын материал болон хяналт шинжилгээний үйл ажиллагааны стандартын журмыг боловсруулах, төр болон хувийн хэвшлийн хоёр секторт сургалт хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэхээр төлөвлөж байна. ② MONMAP-AVC төслийн хүрээнд зөгийн аж ахуй эрхлэгчид болон ХХААХҮЯ-тай хамтран зөгийн балны ХАА-н зохистой дадал боловсруулахаар ажиллаж байна. ③ Чацарганы ХАА-н зохистой дадлыг АХБ-ны дэмжлэгээр боловсруулж дуусан бөгөөд гарын авлага, ажлын дэвтэр хэвлүүлсэн.

Хүнсний аюулгүй байдлын хуулиар, хүнсний салбарын үйлдвэрлэгчид нь ХАА-н зохистой дадал, Эрүүл ахуйн зохистой дадал, Үйлдвэрлэлийн зохистой дадлыг нэвтрүүлэх үүрэгтэй бөгөөд хууль дүрэм дагаж мөрдүүлэх суурь нөхцлийг бүрдүүлэх арга хэмжээнүүд хэрэгжиж байна.

(2) Экспортын шинжилгээний чадавхийг бэхжүүлэх төлөвлөгөө

YAT 8.2: Экспортын шинжилгээний чадавхийг бэхжүүлэх төлөвлөгөө	
Төлөвлөгөөний зорилт	ХАА-н бүтээгдэхүүний экспортын шинжилгээний чадавхийг бэхжүүлэх.
Суурь түвшин	ХАА-н бүтээгдэхүүний экспортын шинжилгээний байгууллагаар тодорхойлсон байгууллага, менежментийн төлөвлөгөө байхгүй.
Төлөвлөгөөний зорилго	ХАА-н бүтээгдэхүүний экспортын шинжилгээний байгууллагаар тодорхойлсон байгууллагыг хөгжүүлэх, менежментийн төлөвлөгөөг 5 жил тутамд дүгнэдэг болох.
Хамрах хүрээ	Орон даяар
Хүлээх үр дүн	Экспортын шинжилгээг хариуцах хяналт шинжилгээний байгууллагыг тогтоож, импортлогч орны шаардлагад нийцсэн шинжилгээний үр дүнг гаргах боломжтой болно.
Үйл ажиллагаа	(1) Шинжилгээний байгууллагын өнөөгийн байдалд үнэлгээ хийж, ХАА-н бүтээгдэхүүнд экспортын шинжилгээ хийх хяналт шинжилгээний байгууллагыг тодорхой болгох. ХХААХҮЯ-ны Салбарын хяналтын газраас удирдан ГЕГ, СХЗГ, ХАБҮЛ лабораториттой хамтран шинжилгээний байгууллагын хяналт шинжилгээний чадавхи (хүний нөөц, тоног төхөөрөмж, төсөв, шинжилгээний арга хэлбэр, шинжилгээ хийх тоо хэмжээ г.м.)-ийн талаар судалгаа хийх. Хяналт шинжилгээний байгууллагуудын чадавхийг үнэлж, экспортод гаргах ХАА-н бүтээгдэхүүний хяналт шинжилгээний байгууллагыг (Экспортын шинжилгээний байгууллага) тодорхойлох. Экспортын шинжилгээг саадгүй шуурхай хэрэгжүүлж чаддаг болох, хувийн секторын шинжилгээний байгууллагыг оролцуулан бусад байгууллагуудтай чиг үүргийн хуваарилтыг тодорхой болгох. Эдгээр байгууллагад шинжилгээ явуулах хууль эрх зүйн үндэслэлийг бүрдүүлэх, аль эсвэл одоо хэрэгжиж буй “Амьтан, ургамлын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний чанарын хяналт, шинжилгээний хууль” болон “Төрийн хяналт шалгалтын хууль”-ийн шаардлагатай уялдуулан шинэчлэн тогтоох.

	(2) Хорио цээрийн мэдээллийг тогтмол шинэчлэх. ХХААХҮЯ-ны Салбарын хяналтын газар, ГХХэлтэс, ГЕГ, шинжилгээний байгууллагууд хамтран, экспортод гаргах гэж буй улсын хорио цээрийн тогтолцоо, эн тэргүүнд тавих зүйлс, хорио цээрийн шаардлага гэх зэрэг мэдээллийг цуглуулах, боловсруулах. Хорио цээрийн мэдээллийг тогтмол цуглуулах, боловсруулах чиг үүрэг бүхий газар хэлтсийг байгуулах. (3) Экспортын шинжилгээний байгууллагын хөгжлийн төлөвлөгөөг боловсруулах. Хорио цээрийн мэдээлэл болон гадаад улсын жишээ баримттай холбоотой материалыг цуглуулж боловсруулсны үндсэн дээр экспортын хяналт шинжилгээний байгууллагын шинжилгээний тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээ, ашиглалтын төлөвлөгөөний төслийг боловсруулж, 5 жил тутамд дүгнэж хянаж ажиллах. Төлөвлөгөөний төслийн тухайд, импортын гол бараа бүтээгдэхүүн болон экспортын зах зээлийн талаар эн тэргүүнд авч үзэх дэс дараа, стратегийн талаар хөндөн үзэж, шинжилгээний байгууллагын удирдлага, төсөв, шинжилгээний арга хэлбэр, хүний нөөцийн тогтолцоо, шинжилгээний чадавхийг дээшлүүлэх хэтийн төлөв зэрэг асуудлыг хамруулан тусгах. (4) Экспортын хяналт шинжилгээний байгууллагын шинжилгээний хүчин чадавхийг бэхжүүлэх. Тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээ, ашиглалтын төлөвлөгөөний дагуу багаж төхөөрөмжийн засвар үйлчилгээг явуулж, байцаагч мэргэжилтэн ажиллуулах. Шинжээч байцаагчийн шинжилгээний ажлын мэдлэг чадварыг дээшлүүлэх. (5) Олон улсын баталгаажуулалт авах ажлыг өргөжүүлэх. Шинжилгээний найдвартай байдлыг бий болгох үүднээс ISO 17025, 17020, 17043, 17045 зэрэг шалгалт шинжилгээтэй холбоотой олон улсын баталгаажуулалтуудыг авах. Экспортын түнш улстай адил тэгш түвшинд хүрэх..	
Санхүүжилт	<u>Засгийн газар</u> • Судалгааны зардал • Мэргэжилтэн урих зардал • Лаборатори тоноглох зардал • Сургалт явуулах зардал • Гадаадад сургалтад хамруулах зардал • Батламжлал авах зардал	<u>Хувийн хэвшил</u> -
Төслийн өртөг	Төслийн нийт өртөг: 7 тэрбум 600 сая төгрөг (2,893,000 USD)	
Ашиг, үр нөлөө	Монгол улсын хүнсний аюулгүй байдал сайжирч, хэрэглэгчдийн илтгэлийг олох, импортыг орлох чадвар дээшлэнэ. Экспортын зах зээл дээр, Монгол Улсад хийгдсэн шалгалт шинжилгээний үр дүн ашиглагддаг болох, импортлогч улсын хорио цээрийн түвшин буурч, экспортын журам хялбаршина.	
Бодлогын бичиг баргимттай уялдсан байдал	1. Алсын хараа 2050 2.5.13. Хүрээлэн буй орчны эрүүл мэндийн үзүүлэлтийн шаардлага, стандарт, тохирлуудыг олон улсын стандартын түвшинд ойртуулан тохируулж, сайжруулна. 2. Алсын хараа 2050 2.5.19. Хүнс боловсруулагч үйлдвэрүүдэд аюулын дүн шинжилгээ болон эгзэгтэй цэгт хяналт шинжилгээ явуулах тогтолцооны механизм, хүнсний аюулгүй байдал, чанарын хяналтын тогтолцоо, хүнсний хэлхээний хяналтын систем, стандартыг нэвтрүүлнэ. 3. Алсын хараа 2050 2.5.20. Ард түмний хүнсний хангамж, хүнсний хүртээмжийг тогтворжуулах, тээвэрлэлт нийлүүлэлтийн бүх шатанд бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах, хүнсний салбарын төрөл бүрийн стандартыг олон улс, бүс нутаг, өндөр хөгжилтэй орнуудын дэвшилтэт стандартад ойртуулахад чиглэсэн төрийн бодлогыг хэрэгжүүлнэ.	
Төсөл хэрэгжүүлэхэд анхаарах зүйлс	• Хандивлагч орнуудтай идэвхтэй, нягт хамтран ажиллах, хандивлагч орнуудаас зөвлөмж авах, хандивлагч орны төслийг ашиглах. • Экспортын хяналт шинжилгээний байгууллагын тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээ, ашиглалтын төлөвлөгөөний дагуу тоног төхөөрөмжийг үр ашигтайгаар ашиглахын тулд Монголын тал тоног төхөөрөмжийг сайжруулах санаачилгыг идэвхтэй гаргаж,	

	хандивлагч орны дэмжлэгийг давхардуулахгүй, дүрэм журмыг зөрчихгүйгээр зохицуулах. • Хяналт шинжилгээний ажилтнуудын чадавхийг дээшлүүлэхийн тулд донорууудын дэмжлэгтэйгээр олон улсын мэргэжилтэн урих, мөн гадаадад сургалтад хамрагдах, гадаад орнуудтай харьцуулсан шинжилгээний чадавхийн ялгааг багасгах.

Төслийг хэрэгжүүлэх хуваарь, төсөв

Үйл ажиллагаа		2025	2026	2027	2028	2029	2030	2031	2032	2033	2034	Нийт
(1) Хяналт шинжилгээний байгууллагын өнөөгийн байдлыг үнэлж, ХАА-н бүтээгдэхүүнд экспортын шинжилгээг хариуцах байгууллагыг тогтоох.												
(2) Хорио цээрийн мэдээллийг тогтмол хугацаанд шинэчлэх.												
(3) Экспортын шинжилгээний байгууллагын хөгжлийн төлөвлөгөө боловсруулах.												
(4) Экспортын шинжилгээний байгууллагын шалгалт шинжилгээний чадавхийг дээшлүүлэх												
(5) Олон улсын баталгаажуулалт авах ажлыг өргөжүүлэх.												
Төслийн өртөг	сая төгрөг	831	1,254	1,229	696	615	590	590	590	615	590	7,600
	мян. ам.дол	321	477	467	264	234	224	224	224	234	224	2,893

Тэмдэглэл: Хорио цээрийн дэглэмийн тогтолцоог боловсронгуй болгох нь

Японы жишээ:

"**Мал амьтны хорио цээр**" 2001 оноос шинжилгээний найдвартай байдлыг хадгалахын тулд Мал амьтны хорио цээрийн асуудал эрхэлсэн албаны тогтолцоог бэхжүүлэх үйл ажиллагааг эхлүүлж, 2002 онд мэргэжлийн байгууллага болох Хорио цээрийн албаны Хяналтын удирдлагын тасгийг байгуулсан. Түүнээс хойш 2003 онд "Мал, амьтны хорио цээрийн албаны лабораторид хяналт шинжилгээ хийх журам" гэх зэрэг холбогдох журам дүрмийг боловсруулж, шинжилгээний хариуны тэмдэглэл хөтлөх, хадгалах, шинжилгээний тоног төхөөрөмж, шинжилгээний эм урвалж бодис, шинжилгээнд ирүүлсэн материалтай харьцах арга, шинжилгээний процесст хяналт шалгалт хийх зэрэг дүрмийг тогтоож, мөрдлөг болгон, хяналт шинжилгээний найдвартай байдлыг хадгалах арга хэмжээг авч ирлээ. Эдгээр үйл ажиллагааны зэрэгцээ 2011 оноос эхлэн ISO/IEC17025 итгэмжлэлтэй болох талаар ажиллаж байна (Одоогоор Мал амьтны хорио цээрийн албаны 6 лаборатори итгэмжлэгдээд буй).
（https://www.maff.go.jp/aqs/job/reliance.html）

"Ургамлын хорио цээр" Хурааж цуглуулах бүс нутаг болон тариалангийн талбай дээр явуулах экспортын шинжилгээ, экспортын асуудлаар хийх хурал зөвлөлгөөг өргөжүүлэхийн хамт улс орнуудын импортын тэргүүлэх шаардлага зэргийг тогтмол хугацаанд шинэчилж, гарал үүсэл болон экспортлох үйлдвэрт зориулан мэдээлэл түгээх ажлыг хийдэг (http://www. maff.go.jp/pps/j/search/detail.html#yusyutu). Мөн бүтээгдэхүүнээ экспортлохыг зорьж буй үйлдвэрлэгчдийг дэмжих зорилгоор ургамлын хорио цээр болон хортон шавьжаас хамгаалах мэргэжлийн багийг зохион байгуулж, мэргэжлийн хүнээр зөвлөгөө өгүүлэх, экспорлох улсын ургамлын хорио цээрийн нөхцөл, пестицидийн үлдэгдлийн лавлах түвшин хэмжээнд зохицох тариалалтын арга зэрэг технологийн дэмжлэгийг үзүүлэх үйл ажиллагааг хэрэгжүүлж байна.

Монголын жишээ:

IFC-ийн (Олон улсын санхүүгийн корпораци) Монгол мах төслөөр, Хятадын гаалийн байгууллагад мах боловсруулагчдын бүртгэл хийлгэх болон хяналт шинжилгээ хариуцсан эрх бүхий төрийн байгууллагад тавигдах шаардлага гэх мэт гол чухал материалуудыг хятад хэлнээс монголоор орчуулж, бэлтгэсэн байдаг. Мөн мах боловсруулах болон хүнсний боловсруулах салбарын үйл ажиллагаанд холбогдох Хятадын 6 стандартыг

орчуулсан байна. Шаардлагатай мэдээлэл материалыг цуглуулах, холбогдох хүмүүст ашиглахад хялбар байдлаар танилцуулж хуваалцах нь дараа дараагийн шатны үйл ажиллагаанд тус дөхөм үзүүлэх нь дамжиггүй.

(3) Бэлтгэн нийлүүлэлтийн дараах алдагдлыг бууруулах бэлтгэл судалгааны төлөвлөгөө

YAT 8-3: Бэлтгэн нийлүүлэлтийн дараах алдагдлыг бууруулах бэлтгэл судалгааны төлөвлөгөө		
Төлөвлөгөөний зорилго	Бэлтгэн нийлүүлэлтийн дараах түгээлт нийлүүлэлтийн шатан дахь хүнсний алдагдлын бодит байдлыг тодруулж, алдагдал бууруулах төсөл боловсруулах.	
Суурь түвшин	Бэлтгэн нийлүүлэлтийн дараах алдагдлын бодит нөхцөл байдал тодорхойгүй, алдагдал бууруулах талаар ямар нэг арга хэмжээ хэрэгждэггүй..	
Төлөвлөгөөний зорилт	Бэлтгэн нийлүүлэлтийн дараах алдагдлыг бууруулах төсөл хэрэгжүүлэх	
Хамрах хүрээ	Орон даяар	
Хүлээх үр дүн	(1) Бэлтгэн нийлүүлэлтээс хойш жижиглэнгийн худалдааны өмнөх үе хүртэлх хүнсний алдагдлын тухайд Монгол улсын тухайд алдагдлын түвшин нэн өндөр хүнний бүтээгдэхүүн, нийлүүлэлтийн сүлжээний үе шатуудыг тодорхойлох. (2) Төлөвлөгөөний дагуу алдагдал бууруулах туршилтын төслийг хэрэгжүүлж, хүнсний бүтээгдэхүүний бэлтгэн нийлүүлэтийн дараах алдагдлыг бууруулах загварыг тодорхойлох. (3) (1)-д тодорхойлсон хүнсний бүтээгдэхүүн, нийлүүлэлтийн сүлжээний алдагдлыг бууруулах бизнес төлөвлөгөөг боловсруулах.	
Үйл ажиллагаа	(1) Энэхүү бэлтгэл судалгааг явуулах техникийн тодорхойлолтыг боловсруулж, нээлттэй зарлах замаар гэрээгээр гүйцэтгэгчийг сонгох. ХХААХҮЯ-ны Салбарын хяналтын газар манлайлан бодит алдагдлын нөхцөл байдлыг тодруулах, алдагдлыг бууруулах арга барилыг боловсруулах зорилгоор гэрээгээр ажил гүйцэтгэх техникийн тодорхойлолтыг боловсруулах. Хүнсний алдагдал, хаягдал нь нийлүүлэлтийн сүлжээний бүх шатанд гардгаас алдагдлын түвшин өндөр тул, мэдэгдэхүйц бууруулах үр дүн хүлээж буй хүнсний бүтээгдэхүүн, процессыг тодорхойлох шаардлагатай юм. Түүнчлэн судалгааны явцад тодорхой болсон илэрхий алдагдал өндөртэй бүтээгдэхүүн болон процесстэй холбоотой алдагдал бууруулах туршилтын төслийн төлөвлөгөө боловсруулж, хэрэгжүүлэх ажлыг гэрээгээр гүйцэтгүүлэх. (2) Гэрээгээр гүйцэтгэгчийн судалгааны ажлын явцын хяналтыг хэрэгжүүлэх. ХХААХҮЯ-ны Салбарын хяналтын газар манлайлан гэрээгээр ажил гүйцэтгэгчийн судалгааны ажлын явцыг хянах. Туршилтын төслийн тухайд зорилтот хүнсний бүтээгдэхүүн болон процессоос хамааран цар хүрээ, хэрэгжүүлэх бүс нутаг, аж ахуйн нэгж, үйлдвэрлэгч, борлуулагчдыг холбогдох байгууллагуудтай зөвшилцөн сонгоно. Мөн НҮБ-ын ХХААБ зэрэг донорын мэргэжилтнүүдээс идэвхтэй зөвлөгөө авах. (3) Гэрээгээр гүйцэтгэгчийн ажлын үр дүнг шалган дүгнэх. ХХААХҮЯ-ны Салбарын хяналтын газар нь гэрээт ажил гүйцэтгэгчийн ажлын үр дүнг шалгах дүгнэх ажлыг манлайлна. Шаардлагатай бол засварлан сайжруулалт хийхийг шаардаж, судалгааны үр дүнг нэгтгэнэ. (4) Ургац хураалтын дараах боловсруулалтын алдагдлыг бууруулах бизнес төлөвлөгөө боловсруулах. ХХААХҮЯ-ны Салбарын хяналтын газар манлайлан гэрээт гүйцэтгэгчийн судалгааны үр дүнд үндэслэн бизнес төлөвлөгөө боловсруулах. Бизнес төлөвлөгөө боловсруулахад НҮБ-ын ХХААБ-тай хамтран ажиллахыг эрэлхийлнэ. Төлөвлөгөөгөө гаргасны даранхүүжилт олох, төсөл хэрэгжүүлэх удирдамжийг боловсруулах зэрэг шаардлагатай арга хэмжээнүүдийг хэрэгжүүлнэ.	
Санхүүжилт	<u>Засгийн газар</u> • Судалгааны ажлыг гэрээгээр гүйцэтгүүлэх зардал (судалгааны зардал, туршитын төсөл хэрэгжүүлэх зардал) • Төслийн явцын менежментийн зардал (томилолтын зардал, хурлын зардал г.м)	<u>Хувийн сектор</u> -

Төслийн өртөг	Төслийн нийт өртөг: 1 тэрбум 266 сая төгрөг (481,000 USD)
Ашиг, үр нөлөө	Хүнсний бүтээгдэхүүний алдагдал буурч, хүнсний хангамж тогтворжино. Энэ нь зардлыг бууруулж, үнийн өрсөлдөх чадварыг нэмэгдүүлнэ.
Бодлогын бичиг баримттай уялдсан байдал	1. Алсын хараа 2050 4.2.38.Олон улсын тээвэр ложистикийн төвүүдийг байгуулж, дотоодын тээвэр ложистикийн тогтолцоог хөгжүүлнэ. 2. Алсын хараа 2050 6.4.2.Хог хаягдлыг бууруулах, хог хаягдлыг дахин боловсруулахад чиглэсэн эко хөтөлбөрийн хууль боловсруулж хэрэгжүүлэх. 3. Алсын хараа 2050 6.4.4.Хог хаягдал бага гаргадаг, байгалийн нөөцийг хэмнэсэн орчин үеийн ногоон технологи, техникийг нэвтрүүлж, татаасын тогтолцоогоор цэвэр үйлдвэрлэл, хэмнэлтийг дэмжинэ.
Төсөл хэрэгжүүлэхэд анхаарах зүйлс	• Алдагдлыг хэмжихдээ эдийн засгийн үнэ цэнийг бас тооцсон тоон аргыг хэрэглэх. • Бэлтгэн нийлүүлэлтийн дараах алдагдлыг бууруулах төслийн төлөвлөгөөнд хувийн хэвшлийн оруулах хувь нэмрийг тооцоолж, урамшуулал болон хязгаарлалтын хүчин зүйлсийг судлан тусгах.

Төслийг хэрэгжүүлэх хуваарь, төсөв

Үйл ажиллагаа		2025	2026	2027	2028	2029	2030	2031	2032	2033	2034	Нийт
(1) Төлөвлөгөөг хэрэгжүүлэх техникийн тодорхойлолтыг боловсруулж, нээлттэй зарлах замаар гэрээт гүйцэтгэгчийг сонгох.												
(2) Гэрээгээр гүйцэтгэх судалгааны ажлын явцын хяналтыг хэрэгжүүлэх.												
(3) Гэрээгээр гүйцэтгэгчийн ажлын үр дүнг шалган дүгнэх.												
(4) Бэлтгэн нийлүүлэлтийн дараах боловсруулалтын алдагдлыг бууруулах бизнес төлөвлөгөө боловсруулах.												
Төслийн өртөг	сая төгрөг	359	907									1,266
	мян. ам.дол	136	345									481

Тэмдэглэл: ХХААБ-ын "Дэлхийн Хүнс, ХАА-н тайлан 2019"

Дэлхийн хүнсний алдагдал, хаягдлын түвшингийн тооцоолол нь хүнсний алдагдлын хувь хэмжээ улс орноор ихээхэн ялгаатай байгааг харуулж байна. Хүнсний алдагдал шат дамжлагын аль хэсэгт хамгийн их бууруулах боломж байгааг тодруулах, олж мэдэх нь зохих арга хэмжээг тодорхойлоход маш чухал юм.

Дэлхий даяар хүнсний бүтээгдэхүүний ойролцоогоор 14% нь (эдийн засгийн үнлгээнд хөрвүүлснээр) цуглуулан авснаас хойш жижиглэн худалдаанд борлуулах хүртэлх шат дамжлагад алдагддаг. Хүнсний алдагдал, хаягдал нийлүүлэлтийн сүлжээний бүх үе шатанд янз бүрийн түвшинд тохиолддог боловч зарим хүнсний бүлгүүдэд илүү өндөр байх хандлагатай байдаг. Хүнсний төрөл нийлүүлэлтийн сүлжээний үе шат болон улс орнуудын хооронд алдагдал, хаягдлын түвшин ихээхэн ялгаатай байгаа нь алдагдал, хаягдлын түвшин өндөртэй бүс нутагт мэдэгдэхүйц бууруулах боломжтой гэдгийг харуулж байна.

(4) Чанар, эрүүл ахуйн хяналтын хүний нөөцийг сургах төлөвлөгөө

YAT 8.4: Чанар, эрүүл ахуйн хяналтын хүний нөөцийг сургах төлөвлөгөө	
Төлөвлөгөөний зорилго	Үйлдвэр, ААН-д зориулж, чанар, эрүүл ахуйн хяналтын сургалт зохион байгуулах хүний нөөцийг бэлтгэх

Суурь түвшин	Зохих шалгалтад тэнцсэн чанар, эрүүл ахуйн хяналтын сургагч багш байхгүй	
Зорилтот түвшин	Зохих шалгалтад тэнцсэн чанар, эрүүл ахуйн хяналтын 400 сургагч багш бэлтгэгдэж, ЖДҮ, ААН-үүдэд зориулан жилд 40 гаруй удаагийн сургалт зохион байгуулна.	
Хамрах хүрээ	Орон даяар	
Хүлээх үр дүн	Чанар, эрүүл ахуйн хяналтын мэргэжлийн хүний нөөцийг тасралтгүй бэлтгэх тогтолцоо бүрдэж, үйлдвэр, ААН-ийн эрүүл ахуй, чанарын хяналтын чадавхи дээшлэнэ. HACCP、FSSC22000 зэрэг олон улсын итгэмжлэл авах ажилд ахиц гарна. Дотоодын зах зээлд нийлүүлж буй дотоодын үйлдвэрийн бүтээгдэхүүний хүнсний аюулгүй байдлын эрсдэл буурна.	
Үйл ажиллагаа	(1) Чанар, эрүүл ахуйн хяналтын сургагч багшийн тогтолцоог бий болгох. ХХААХҮЯ-ны Салбарын хяналтын газраас манлайлан ХБХЗГ, ЭМЯ, их сургуулиуд, Хүнс үйлдвэрлэгчдийн холбоо зэрэг байгууллагууд хамтарч Чанар, эрүүл ахуйн хяналтын мэргэжлийн сургагч багшийн тогтолцоог бий болгоно. ①Сургагч багшийн мэргэшлийн стандарт, эрх шинэчлэх тогтолцоо, сургагч багшийн үүрэг, хяналтын болон холбогдох байгууллагын үүрэг зэрэг сургагч багшийн бүртгэлийн удирдамжийг боловсруулах. ②Холбогдох боловсролын байгууллагуудын сургалтын хөтөлбөрийг батлахдаа сургагч багш бэлтгэх хөтөлбөрийг судлан боловсруулах. ③Сургагч багшаар суралцах эрхийг тодорхойлох (жишээ нь: өмнө нь холбогдох мэргэжлийг эзэмшсэн байх (эмч, шүдний эмч, эм зүйч, малын эмч), эсвэл анагаах ухаан, шүдний эмч, эм зүй, мал эмнэлэг, МАА-н чиглэлээр их дээд сургуульд суралцсан байх. (2) Чанар, эрүүл ахуйн хяналтын сургалтын материал, хэрэглэгдэхүүн, шалгалтыг боловсруулах. ХХААХҮЯ-ны Салбарын хяналтын газар нь ①сургагч багш бэлтгэх сургалт, сургагч багшийн мэргэшлийн шалгалт, ②сургагч багш нарын аж ахуйн нэгжүүдэд явуулах сургалтын хөтөлбөр боловсруулах ажлыг дотоод, гадаадын мэргэжилтэн, их дээд сургуулиудын хүнсний салбарын мэргэжилтнүүдэд гэрээгээр гүйцэтгүүлэх ажлыг зохион байгуулах. Сургалтын материалд эрүүл ахуйн ерөнхий менежмент, HACCP, хүнсний аюулгүй байдлын менежментийн тогтолцоо, холбогдох хууль эрх зүйн тогтолцоо, захиргааны байгууллагуудын тухай тусгах. (3) Чанар, эрүүл ахуйн хяналтын ажилтнуудын бүртгэлийн системийг бий болгох. ХХААХҮЯ-ны салбарын хяналтын газарт шалгалтад тэнцсэн хүмүүсийг бүртгэх бүтэц бий болгох. Бүртгэлийн байгууллага нь сургагч багшийн сургалтыг болон сургагч багшийн эрх шинэчлэх сургалт зохион байгуулна. Мөн сургалтын байгууллагуудын хамгийн сүүлийн үеийн мэдээллийг байнга цуглуулж, хуваалцах үйл ажиллагааг дэмжиж ажиллах. (4) Чанар, эрүүл ахуйн хяналтын сургагч багш бэлтгэх. ХХААХҮЯ нь олон улсын түвшний мэргэжилтнүүдийг урьж, (2)-д боловсруулсан хөтөлбөр, сургалтын материалыг ашиглан сургагч багш бэлтгэх сургалт явуулна. (5) ЖДҮ-үдэд зориулсан чанарын хяналтын сургалтын дэмжлэг төслийг төлөвлөж хэрэгжүүлэх. ХХААХҮЯ-ны Салбарын хяналтын газар нь ЖДҮГ-тай хамтран сургагч багш нараар ЖДҮ эрхлэгчдэд зориулсан дэмжих сургалтыг зохион байгуулж, хэрэгжүүлэх цар хүрээ, удирдамжийг гаргана. Мөн, ХХААХҮЯ нь аж ахуйн нэгжүүдийг эрүүл ахуй, чанарын хяналтыг сайжруулахыг уриалахаас гадна компаниудад зориулсан сургалтуудыг зохион байгуулж, сургагч багш нарыг ажиллуулах. ХХААХҮЯ-ны ХБХЗГ нь хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг бүх аж ахуйн нэгжүүдэд эрүүл ахуй, чанарын хяналтын нэгж эсвэл хариуцсан ажилтан томилж, шаардлагатай хууль журмыг боловсруулах.	
Санхүүжилт	<u>Засгийн газар</u> • Богино хугацаагаар мэргэжилтэн урих зардал • Сургалтын материал боловсруулах зардал • Сургалт зохион байгуулах зардал • Сургагч багш нарын байгууллагын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх зардал	<u>Хувийн хэвшил</u> • Ажилтны сургалтын зардал • Сургагч багшийн эрх шинэчлэх зардал
Төслийн өртөг	Төслийн нийт өртөг: 2 тэрбум 131 сая төгрөг (811,000 USD)	

Ашиг, үр нөлөө	Үйлдвэр, ААН-ийн эрүүл ахуй, чанарын хяналтын чадавхи дээшилж, итгэмжлэллагдах урьдчилсан нөхцлийг хангаснаар олон улсын итгэмжлэллал авахад ахиц гарна. Үйлдвэр, ААН нь эрүүл ахуй, чанарын хяналтын салбарын олон улсын хандлага хэрхэн өөрчлөгдөж буй талаар мэдээлэлтэй болж, зах зээлээ зөв сонгох, авах итгэмжлэллалын сонголтоо ч зөв хийх чадвартай болно.
Бодлогын бичиг баримттай уялдсан байдал	1. Алсын хараа 2050 2.5.19. Хүнс боловсруулагч үйлдвэрүүдэд аюулын дүн шинжилгээ болон эгзэгтэй цэгт хяналт шинжилгээ явуулах тогтолцооны механизм, хүнсний аюулгүй байдал, чанарын хяналтын тогтолцоо, хүнсний хэлхээний хяналтын систем, стандартыг нэвтрүүлнэ. 2. Алсын хараа 2050 2.5.20. Ард түмний хүнсний хангамж, хүнсний хүртээмжийг тогтворжуулах, тээвэрлэлт нийлүүлэлтийн бүх шатанд бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах, хүнсний салбарын төрөл бүрийн стандартыг олон улс, бүс нутаг, өндөр хөгжилтэй орнуудын дэвшилтэт стандартад ойртуулахад чиглэсэн төрийн бодлогыг хэрэгжүүлнэ.
Төсөл хэрэгжүүлэхэд анхаарах зүйлс	• Донор байгуулагуудтай идэвхтэй, нягт хамтран ажиллах, хандивлагчдаас зөвлөмж авах. • Сургагч багш бэлтгэхдээ донорууудын дэмжлэгтэйгээр олон улсын түвшний мэргэлжилтэн урьж, дотоодын түвшинд ахиц гаргах. Мөн их сургуулийн идэвхтэй оролцоог хангах. • Сургагч багш бэлтгэх ажлыг их сургуулийн сургалтын хөтөлбөртэй уялдуулах. • Дэмжлэгийн төсөл хэрэгжиж дууссаны дараа бүртгэлийн байгууллагаас үйлдвэр, ААН-ийн хүсэлтийн дагуу төлбөртэйгөөр сургагч багш ажиллуулан, сургалт зохион байгуулдаг болох.

Төслийг хэрэгжүүлэх хуваарь, төсөв

Үйл ажиллагаа		2025	2026	2027	2028	2029	2030	2031	2032	2033	2034	Нийт
(1) Чанар, эрүүл ахуйн хяналтын сургагч багшийн тогтолцоог бий болгох.												
(2) Чанар, эрүүл ахуйн хяналтын сургалтын материал, шалгалтыг боловсруулах.												
(3) Чанар, эрүүл ахуйн хяналтын ажилтны бүртгэлийн тогтолцоог бий болгох.												
(4) Сургагч багш бэлтгэх сургалтыг зохион байгуулах.												
(5) Түгээн дэлгэрүүлэхийн тулд дэмжлэг төслийг төлөвлөж хэрэгжүүлэх.												
Төслийн өртөг	сая төгрөг	230	266	224	287	273	345	121	104	140	141	2,131
	мян. ам.дол	91	101	85	109	103	131	46	39	53	53	811

Тэмдэглэл: Хүнсний аюулгүй байдлын хяналтын атестатчиллын шалгалт

Япон Улсад 2009 оноос хүнсний шошгоны аттестатчилал явагдах болсон. “Гарал үүсэл”, “түүхий эд”, “нэмэлт бодис”, “шим тэжээлийн орц” зэргийг тэмдэглэсэн хүнсний шошго нь тухайн бүтээгдэхүүний онцлогтой холбоотой мэдээллийг дамжуулах чухал үүргийг гүйцэтгэдэг бөгөөд шошгоор дамжуулан, хүнсний үйл ажиллагаа эрхлэгч нь хэрэглэгчдэд үнэн зөв мэдээлэл өгөх ёстой. Энэхүү аттестатчиллын дээд шатны шалгалтад тэнцсэн этгээд нь хүнсний шошгололтын ахлах зөвлөх болж, хүнсний бүтээгдэхүүний талаар зөвлөх мэргэжилтний ажлыг хийх боломж бүрддэг. Мөн дээд шатны шалгалтад тэнцэгсдийн нийгэмлэг байгуулагдсан бөгөөд хүнсний аюулгүй байдлын асуудлаар сургалт судалгааны ажил, хэрэглэгчдийн мэдлэгийг дээшлүүлэх зорилготой үйл ажиллагаа явуулж байна.

Мөн 2015 оны 3 дугаар сард, хүнс үйлдвэрлэгчид зэрэг хүнсний аюулгүй байдалд холбоотой байгууллагын тэргүүн болохыг эрмэлзэж буй хүмүүст зориулсан хүнсний аюулгүй байдлын аттестатчилал (Дунд шатны аттестатчилал) явуулж эхэлсэн. 2015 оны 9 дүгээр сард хүнсний салбарт ажилладаг хүмүүсийг өргөнөөр хамруулсан анхан шатны

аттестатчиллыг эхлүүлсэн. Энэхүү аттестатчилал нь, хүнсний үйлдвэрлэл, боловсруулалтыг шинжлэх ухааны үндэслэлтэйгээр хэрэгжүүлэх болон үйлдвэрлэл борлуулалтын шатанд аюулгүй байдлыг хангах зорилготой үйл ажиллагаа юм. Аттестатчиллын шалгалттай холбогдуулан, HACCP систем болон FSSC/ISO22000 (Хүнсний аюулгүй байдлын менежментийн систем)-ийг бий болгож, хэрэглэсний үр дүнд олж авсан туршлага, мэдлэгт тулгуурлан боловсруулсан шалгалтын текстийг ч худалдаалж байгаа. 2024 онд дээд шатны аттестатчиллыг явуулах, уг шалгалтад тэнцэгсдийн байгууллагыг үүсгэн байгуулах зорилт тавьж байна.

(5) Олон улсын баталгаажуулалт авах замаар экспортын өрсөлдөх чадварыг бэхжүүлэх төлөвлөгөө

YAT 8.5. Олон улсын баталгаажуулалт авах замаар экспортын өрсөлдөх чадварыг бэхжүүлэх		
Төлөвлөгөөний зорилго	Зорилтот зах зээл дээр нөлөө үзүүлж чадах олон улсын баталгаажуулалт авснаар экспортыг өргөжүүлнэ.	
Суурь түвшин	Одоогийн тоо мэдээллийг олж авахад хүндрэлтэй байгаа тул одоогийн утгыг 0 гэж үзэж, өсөлтийн хэмжээг шалгуур болгох.	
Төлөвлөгөөний зорилт	Хүнсний аюулгүй байдал, чанарын хяналттай холбоотой олон улсын итгэмжлэл авсан компаний тоо 114 компанид хүргэх.	
Хамрах хүрээ	Орон даяар	
Хүлээх үр дүн	Экспорт хийхэд давуу тал болох олон улсын баталгаажуулалт авах боломжийг нээнэ. Монголд авсан баталгаажуулалт экспортын зах зээлд хүлээн зөвшөөрөгдөж, бүтээгдэхүүн экспортлоход шаардагдах олон улсын итгэмжлэл авах тоо нэмэгдэнэ.	
Үйл ажиллагаа	(1) Монголын ХАА-н бүтээгдэхүүнийг экспортлоход давуу тал болж чадах олон улсын баталгаажуулалтын судалгааг хийх. ХХААХҮЯ-ны ГХХ хариуцан манлайлан холбогдох байгууллагууд зөвлөлдөж, экспортын тэргүүлэх бараа бүтээгдэхүүн, ирээдүйтэй гэж үзэж буй салбар, зах зээл болон тухайн зах зээлд хүлээн зөвшөөрөгдөх олон улсын итгэмжлэлийн талаар судалгаа хийх (HACCP, ISO22000, FSSC22000, Leather WG, Мал амьтны тавлаг байдал WG, Halal (Индонез, Малайз, GAC, ESMA) г.м). (2) Олон улсын баталгаажуулалтын итгэмжлэлийн тогтолцоог бэхжүүлэх. Монгол улсын итгэмжлэлийн байгууллагын итгэмжлэлийн байцаагч нарын мэдлэг чадавхийг дээшлүүлэх. Олон улсын харилцан итгэмжлэл, тэгш байдлыг хангахад ахиц гаргах. Гадаад орны итгэмжлэлийн байгууллагыг идэвхтэй ашиглах. (3) Баталгаажуулалтын байгууллагыг бэхжүүлэх. Баталгаажуулалтын байгууллагын тоо болон байцаагч нарын орон тоог нэмэгдүүлэх, мөн байцаагчдын чадавхийг ахиулах зорилт тавих. Гадаадын баталгаажуулалтын байгууллагуудыг Монголд нэвтрэхэд дэмжих. (4) Баталгаажуулалт авахад дэмжлэг үзүүлэх төлөвлөгөө боловсруулж, үйлдвэр, ААН-үүд баталгаажуулалт авах тоог өсгөх. Зөвлөх компаниудыг бойжуулж хөгжүүлэх. ЖДҮ-үүдийг итгэмжлэл авах урамшууллын тогтолцоог бий болгож, хэрэгжих хүрээг тодорхойлох, үйлдвэр, ААН-д дэмжлэг татаас олгохоос гадна итгэмжлэл авахтай холбоотой сургалтыг ЖДҮ-үүдэд зориулж тогтмол зохион байгуулах.	
Санхүүжилт	Засгийн газар • Зах зээлийн судалгааны зардал • Зөвлөх урих зардал • Шалгалтын хянагч бэлдэх зардал • Итгэмжлэхлийн байцаагч бэлтгэх зардал • ААН-д итгэмжлэл авахад олгох татаас дэмжлэг • ААН-д сургалт зохион байгуулах зардал • ААН-ийн тоног төхөөрөмжийн хөрөнгө оруулалтын дэмжлэг зардал	Хувийн хэвшил • Зөвлөгөө авах зардал • Итгэмжлэл авахтай холбоотой ажилтан бэлтгэх сургалтын зардал • Итгэмжлэл авах зардал

Төслийн өртөг	Төслийн нийт өртөг: 14 тэрбум 990 сая төгрөг (5,706,000 USD)
Ашиг, үр нөлөө	Үйлдвэр, ААН-үүд итгэмжлэл авахад хялбар болж, олон улсын түвшний чанарын хяналт хэрэгжинэ. Монголын ХАА-н бүтээгдэхүүн импортлогч улсад хүлээн зөвшөөрөгдөхөд тус болж, экспорт өргөжинө. Монголын бүтээгдэхүүний нэмүү өртөг дээшлэнэ. Монголын байгууллагад хийгдэх чанарын хяналтын найдвартай байдал дээшилж, худалдааны саад бэрхшээл арилна.
Бодлогын бичиг баримттай уялдсан байдал	1. Алсын хараа 2050 2.5.19. Хүнс боловсруулагч үйлдвэрүүдэд аюулын дүн шинжилгээ болон эгзэгтэй цэгт хяналт шинжилгээ явуулах тогтолцооны механизм, хүнсний аюулгүй байдал, чанарын хяналтын тогтолцоо, хүнсний хэлхээний хяналтын систем, стандартыг нэвтрүүлнэ. 2. Алсын хараа 2050 2.5.20. Ард түмний хүнсний хангамж, хүнсний хүртээмжийг тогтворжуулах, тээвэрлэлт нийлүүлэлтийн бүх шатанд бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах, хүнсний салбарын төрөл бүрийн стандартыг олон улс, бүс нутаг, өндөр хөгжилтэй орнуудын дэвшилтэт стандартад ойртуулахад чиглэсэн төрийн бодлогыг хэрэгжүүлнэ. 3. Алсын хараа 2050 4.5.7. ЖДҮ-үүд глобал нэмүү өртгийн сүлжээний шаардлагыг хангахуйц хэмжээнд менежментээ бэхжүүлж, ажиллагсдын мэдлэг чадварыг дээшлүүлэн, технологийн дэвшил, инноваци нэвтрүүлж, бүтээгдэхүүний чанар, стандартыг сайжруулна.
Төсөл хэрэгжүүлэхэд анхаарах зүйлс	• Зорилтот салбар, бүтээгдэхүүн, зах зээлийн талаарх тодорхой мэдээллийг аль болох ихээр цуглуулах. • Экспортыг нэмэгдүүлснээр бий болох үр нөлөөнд ач холбогдол өгч ажиллах.

Төслийг хэрэгжүүлэх хуваарь, төсөв

Үйл ажиллагаа		2025	2026	2027	2028	2029	2030	2031	2032	2033	2034	Нийт
(1) Монголын ХАА-н бүтээгдэхүүний экспортод дэмжлэг болох олон улсын баталгаажуулалтыг судлах												
(2) Олон улсын баталгаажуулалтын итгэмжлэх тогтолцоог бэхжүүлэх.												
(3) Итгэмжлэх байгууллагыг бэхжүүлэх.												
(4) Баталгаажуулалт авахад дэмжлэг үзүүлэх төлөвлөгөө боловсруулж, итгэмжлэл авах ААН тоог өсгөх.												
Төслийн өртөг	сая төгрөг	283	533	1,619	1,692	1,559	1,647	1,744	1,850	1,967	2,096	14,990
	мян. ам.дол	113	202	616	644	593	626	663	704	748	797	5,706

Тэмдэглэл: Монгол улсын экспортыг дэмжих төсөл (ДБ-ны санхүүжилттай НҮБ-ын АҮХБ, ХХААХҮЯ-ны төсөл)

2021 оны 12 дугаар сард Монголын экспортыг дэмжих төсөл (EDP)-г ДБ-ны санхүүжилтээр хэрэгжүүлсэн. НҮБ-ын АҮХБ-аас Монгол улсын итгэмжлэх чадавхи, баталгаажуулах чадавхийг дээшлүүлэх зорилгоор техникийн дэмжлэг үзүүлж байна. Экспортод гаргах боломжтой бүтээгдэхүүний талаар олон улсын баталгаажуулалт авахад холбогдох үйлчилгээ үзүүлэх монгол мэргэжилтнүүдийг бэлтгэснээр уул уурхайн бус салбарын ЖДҮ-үүдийн экспортын чадавхи дээшилж, экспортын зах зээлд нэвтрэх үйл явцыг өргөжүүлэхэд дэмжлэг болж байна. Мөн олон улсын баталгаажуулалтын адил тэгш байдлыг хангах зорилготой арга хэмжээнүүдийг хэрэгжүүлж байна. Жишээ нь, органик баталгаажуулалтын тухайд Хятадын органик баталгаажуулалттай адил тэгш байдлыг хангах зорилгоор хууль эрх зүйн бичиг баримтуудын судалгаа хийж, боломжтой ургамал, хүнсний бүтээгдэхүүнийг сонгон, дүрэм журмыг бодитойгоор шинэчлэх ажлууд хийгдэж байна.

4.2.9 ХАА-н бүтээгдэхүүний экспортыг дэмжих бааз суурийг хөгжүүлэх хөтөлбөр

Экспортын бичиг баримт бүрдүүлэлт нь давхардал ихтэй, процедурууд нь төвөгтэй, цаг их шаарддаг. Алдаа ихтэй, ААН-үүдэд ирэх дарамт их. Худалдааны хэлэлцээр дээр ч гэсэн,яамд хоорондын мэдээллийн солилцоо хангалттүй,хувийн сектор төрийн байгууллагын уялдаа холбоо дутмаг. Ганц хоёрхон байгууллага бэлдсэн стратегигүйгээр хэлэлцээрт ордог. Бизнесийн байгууллага нь экспортлох талын нөхцлийг бүрэн мэдэхэд хувийн байгууллагын хүчээр хийхэд хүндрэлтэй, туслах байгууллага нь уялдаа холбоогүй, бизнесийн байгууллагад хангалттай тусламж хүрдэггүй.

Оролцогч	Төрийн байгууллагууд	Олон нийтийн байгууллага, (ХАҮТ, Мэргэжлийн холбоод)	Экспортлогч ААН-үүд
Гол бэрх-шээл	ААН нь олон байгууллагаас дэс дараатайгаар, экспорт хийхэд шаардлагатай бичиг авах ёстой. Үүнд цаг хугацаа, зардал их шаардагддаг, алдаа ч их гардаг. Засгийн газрын байгууллагууд хоорондоо уялдаагүй, экспортын зорилтот зах зээл болон хувийн ААН-ийн талаархи мэдээлэл хангалттүй.Хэлэлцээ хийх чадвар сул .	Хувийн сектор, төрийн байгууллагын (дундын) зуучлал сул. ААН-ийг хангалттай дэмждэггүй. ААН-ийг дэмжих төсөв ч хүний нөөц ч дутагдалтай, тусалж дэмжих хөтөлбөр бараг байхгүй.	Мэдээлэл цуглуулах үйл ажиллагаа хангалтгүй, худалдааны журам төвөгтэй. ЖДҮ эрхлэгчид дангаараа таатай зах зээл олж, тэдний шаардлагын дагуу бичиг баримт бүрдүүлэхэд хүндрэлтэй байдаг.
Авах арга хэмжээ	9.1.Худалдааны журмыг оновчтой болгох төлөвлөгөө 9.2. Худалдааны хэлэлцээр хийх чадавхийг бэхжүүлэх төлөвлөгөө 9.3.Экспортын дэмжлэгийг бэхжүүлэх төлөвлөгөө		

Зураг 4.11 ХАА-н бүтээгдэхүүний экспортыг дэмжих дэд бүтцийг хөгжүүлэх хөтөлбөр

Эх сурвалж: Жайка төслийн баг

Экспортын бичиг баримт бүрдүүлэх журмууд төвөгтэй бөгөөд цаг хугацаа, зардал мөнгөний асуудлыг үйлдвэр, ААН өөрөө хариуцаж байгаа явдал нь экспортын саад тотгорын нэг юм. Мөн худалдааны яриа хэлэлцээрийн тухайд түнш орны мэдээлэл болон хувийн секторын эрэлт хэрэгцээний талаарх мэдээлэл дутагдалтай, холбогдох байгууллагуудын уялдаа, хамтын ажиллагаа дутагдалтай байдаг. Үйлдвэр ААН-үүдэд чиглэсэн дэмжлэг арга хэмжээ хязгаарлагдмал, ЖДҮ-үүдийн хувьд экспортын босго маш өндөр байдаг.

Хүснэгт 4.9 ХАА-н бүтээгдэхүүний экспортыг дэмжих дэд бүтцийг хөгжүүлэх хөтөлбөр болон хөгжлийн чиглэлийн хамаарал

	Бодит бэрхшээл, давуу тал, хөгжлийн чиглэлийн агуулга	ХАА-н бүтээгдэхүүний экспортыг дэмжих суурь баазыг хөгжүүлэх хөтөлбөрийн арга хэмжээ: 3 төлөвлөгөө		
		9.1	9.2	9.3
Бэрхшээл	Гэрээ хэлэлцээр байгуулах ажил хангалтгүй	○	◎	○
	Худалдааны процедур төвөгтэй бөгөөд үр ашиггүй	◎	○	○
	Үйлдвэр, ААН-н чадавхи сул	○	○	◎
Хөгжлийн чиглэл 2-2	Худалдааны процедурыг хялбаршуулах, оновчтой болгох	◎	○	○
	Худалдааны гэрээ хэлэлцээний чадавхийг дээшлүүлэх	○	◎	○
	ОУ-ын үзэсгэлэн худалдаандуудад оролцоход дэмжих			◎

Эх сурвалж: Жайка төслийн баг ○ : Өндөр хамааралтай, ◎ : Хүчтэй хамааралтай

“9.1 Худалдааны бүрдүүлэлтийн журмыг оновчтой болгох төлөвлөгөө”-гөөр экспортын бичиг баримт бүрдүүлэлтийн зардал, цаг хугацааг багасгах зорилгын үүднээс

экспортлогч байгууллагын итгэмжлэллал, бүртгэлийн системийг нэвтрүүлэх, импортлогч улсаас шаардах бичиг баримт, мэдээллийг бэлтгэх тогтолцоог бий болгох, цахимжуулах зэргээр Нэг цэгийн үйлчилгээг /One stop service/ хөгжүүлэх, холбогдох байгууллагын ложистикийн чадавхийг бэхжүүлнэ. Байгууллагуудын бичиг баримт бүрдүүлэлтийн тухайд зарцуулсан цаг хугацаа, алдаа мадагийн тоонд дүн шинжилгээ хийж, нийтэд мэдээлэхийн зэрэгцээ хувийн секторын санал хүсэлтийг тусгах тогтолцоог бүрдүүлж, бүрдүүлэлтийн журмыг зохистой болгохыг тасралтгүй зорьж ажиллана.

"9.2 Худалдааны хэлэлцээрийн чадавхийг бэхжүүлэх төлөвлөгөө"-д экспортын зорилтот улс, салбарын мэдээллийг тогтмол цуглуулж, худалдаа хариуцсан захиргааны байгууллагууд болон хувийн хэвшлүүдэд тараан, зорилтот улс орнуудтай хэлэлцээ хийхдээ хувийн хэвшлийн хэрэгцээ, өнөөгийн нөхцөл байдалд тулгуурлан хэлэлцээрийн стратегийг боловсруулж, хэлэлцээрийн үр дүнг хувийн хэвшилд шуурхай мэдээлэдэг байхыг зорино. Худалдааны хэлэлцээрийг хувийн хэвшлийн хэрэгцээ шаардлагад нийцүүлэн стратегийн дагуу явуулах тогтолцоог хөгжүүлэх зорилгоор ХАА-н бүтээгдэхүүний худалдаа экспорт хариуцсан захиргааны байгууллагуудад орон тооны мэргэжилтэн томилж, хувийн хэвшил болон холбогдох байгууллагуудын хамтран ажиллах тогтолцоог бүрдүүлнэ. Байгууллагуудын хариуцсан мэргэжилтнүүдийн хэлэлцээрийн ур чадварыг дээшлүүлэх сургалтыг тогтмол явуулж суурь чадавхийг дээшлүүлнэ. ХАА-н экспортын гол нэрийн бүтээгдэхүүн болон экспортын зорилтот улсуудыг тодорхойлж, худалдааны хэлэлцээр хийхэд бэлтгэнэ.

“9.3 Экспортыг дэмжих тогтолцоог бэхжүүлэх төлөвлөгөө" нь MYXAYT-д чиглэсэн бөгөөд экспортыг өргөжүүлэх зорилгоор бизнесийн хэлэлцээрийг дэмжих, экспортлох орнуудын компаниудтай гэрээ байгуулахад дэмжлэг үзүүлэх, ашигтай тариф сонгох талаар мэдээлэл өгөх зэрэг бизнесийг дэмжих хөтөлбөрүүдийг боловсруулж, MYXAYT-ын чадавхийг бэхжүүлэх зорилготой. MYXAYT-ын чадавхийг бэхжүүлэх нь хувийн хэвшил болон төрийн байгууллагуудын хамтын ажиллагааг хөгжүүлэх, түүнчлэн мэдээлэл цуглуулах, хуримтлуулах үйл ажиллагааг дэмжих, худалдааны хэлэлцээрийн чадавхийг бэхжүүлэх, экспортын журмыг хялбарчлах, зардлыг бууруулахад хувь нэмэр оруулах юм.

(1) Худалдааны бүрдүүлэлтийн журмыг оновчтой болгох төлөвлөгөө

YAT 9.1: Худалдааны бүрдүүлэлтийн журмыг оновчтой болгох төлөвлөгөө	
Төлөвлөгөөний зорилго	Худалдааны бүрдүүлэлтийн зардлыг бууруулах
Суурь түвшин	Худалдааны бүрдүүлэлтэд зарцуулах дундаж хугацаа 260 цаг (мах)
Төлөвлөгөөний зорилт	Худалдааны бүрдүүлэлтэд зарцуулах дундаж хугацаа 106 цаг (мах)
Хамрах хүрээ	Орон даяар
Хүлээх үр дүн	Экспортод зарцуулах хугацаа, бүрдүүлэлтийн хураамж багасаж, экспорт нэмэгдэнэ.
Үйл ажиллагаа	(1) Экспортын компаниудыг баталгаажуулах, бүртгэх тогтолцоог нэвтрүүлнэ. Экспортын компаниудад урьдчилсан зөвшөөрөл, бүртгэлийн тогтолцоог бий болгоход Стандарт хэмжил зүйн газар болон Гаалийн ерөнхий газар голлох үүрэг гүйцэтгэнэ.

	(2) Экспортын зорилтот улсуудын шаардлагатай баримт бичгийн талаарх мэдээллийг бэлтгэнэ. Гаалийн байгууллага нь Гадаад харилцааны яамтай хамтран экспортын улс орнуудад шаардлагатай бичиг баримтын талаарх мэдээллийг цуглуулж, тогтмол шинэчилж байна. ГХЯ нь ХХААХҮЯ, ЭЗХЯ-тай мэдээлэл солилцож, шаардлагатай мэдээллийг Гаалийн газартай мэдээлдэг байх. Холбогдох байгууллагууд (СХЗГ, ХХААХҮГ, МЭЕГ, МҮХАҮТ, хяналтын байгууллагууд) экспортлох улс, бараа бүтээгдэхүүн тус бүрээр шаардлагатай зүйлсийн хяналтын хуудас, маягтыг багтаасан бүрдүүлэлт хийх журмыг боловсруулж, тогтмол шинэчилдэг болох. (3) Цахимжуулах замаар “Нэг цонхны үйлчилгээ”-г өргөжүүлэх. ХХААХҮЯ нь Нэг цонхны үйлчилгээний вэбсайтаар бүрдүүлэлт хийх боломжийг өргөжүүлэхийн тулд вэбсайтыг сайжруулна. Компаниуд экспортын бүрдүүлэлтийн системд цахимаар хүсэлт гаргадаг болох. Холбогдох байгууллагууд бүрдүүлэлтэд зарцуулах зорилтот хугацааг урьдчилан тогтоож, нийтэд мэдээлнэ. Холбогдох байгууллагууд компаниудаас хүсэлт хүлээн авахтай зэрэгцэн бүрдүүлэлтийг эхлүүлнэ. (4) Холбогдох байгууллагуудын бичиг баримт боловсруулах чадавхийг сайжруулах. Бүрдүүлэлтэд зарцуулсан хугацаа, болон гүйцэтгэл, бичиг баримтын алдааны тоо зэргийг жил бүр үнэлж, нийтэд зарлан, хариуцсан ажилтнуудад бичиг баримт хөтлөлтийн сургалт зохион байгуулах. Гаалийн алба нь жил бүр холбогдох байгууллагуудаас бүрдүүлэлтийн ажилтнуудыг цуглуулж, экспорт хийдэг орнуудын шаардлага, шинэчлэгдсэн журмуудын талаар танилцуулах сургалт явуулдаг байх. (5) Хувийн хэвшлийнхний саналыг авах, нийтэд мэдээлэх. Гаалийн байгууллага нь худалдааны бүрдүүлэлтийн журмын талаар хувийн хэвшлийнхнээс санал авч, нэгтгэн боловсруулж, холбогдох байгууллагуудад хүргэдэг байх. Дээрээс нь санал хүсэлтийг нэгтгэн нийтэд мэдээлдэг байх.	
Санхүүжилт	<u>Засгийн газар</u> • Экспортлогч компанийн итгэмжлэл / бүртгэлийн ажлын зардал • Цахим системийн ашиглалтын зардал (ЗГ төсвийн хүрээнд) • Мэдээлэл цуглуулах, боловсруулах зардал • Хурлын зардал • Хэрэгжүүлэх журам, маягт боловсруулах зардал • Цалингийн зардал	<u>Хувийн хэвшил</u> -
Төслийн өртөг	Төслийн нийт өртөг: 1 тэрбум 793 сая төгрөг (682,000 USD)	
Ашиг, үр нөлөө	Экспортын бүрдүүлэлтийн зардал буурна. Журмыг хялбарчлах, захиргааны байгууллагуудын мэдээлэл цуглуулж нэгтгэснээр компаниудын ачаалал буурч, экспорт нэмэгднэ. Экспортын компаниудын тоо нэмэгдэнэ.	
Бодлогын бичиг баримттай уялдсан байдал	1. Алсын хараа 2050 4.4.11.Бүс нутгийн эдийн засгийн интеграцчлалыг ахиулах, худалдааг хялбарчлах замаар эдийн засгийг урт хугацаанд өрсөлдөх чадвартай салбарт төрөлжүүлэх, экспортын боломж, зах зээлийг тэлэх алхмуудыг хийх. 2. Алсын хараа 2050 4.5.7.ЖДҮ-ийг олон улсын нэмүү өртгийн сүлжээний шаардлагад нийцүүлэхийн тулд менежментийг бэхжүүлэх, ажилчдын ур чадварыг дээшлүүлэх, технологийн дэвшил, инновацийг нэвтрүүлэх, бүтээгдэхүүний чанар, стандартыг сайжруулах. 3. Алсын хараа 2050 4.5.8.ЖДҮ эрхлэгчдэд шаардлагатай технологийн шинэчлэлийн талаарх мэдээллийг гадаад дахь дипломат төлөөлөгчийн газраар дамжуулан авах, олон улсын үзэсгэлэн, бизнес уулзалтаар дамжуулан хөрөнгө оруулалтын түншлэлийг өргөжүүлэх.	
Төсөл хэрэгжүүлэхэд анхаарах зүйлс	• Сүүлийн үеийн мэдээллийг нэгтгэн боловсруулахад анхаарах.	

Төслийг хэрэгжүүлэх хуваарь, төсөв

Үйл ажиллагаа		2025	2026	2027	2028	2029	2030	2031	2032	2033	2034	Нийт
(1) Экспортлогч үйлдвэр, ААН-ийг итгэмжлэх, бүртгэлжүүлэх тогтолцоо нэвтрүүлэх.												
(2) Импортлогч улсуудаас шаарддаг бичиг баримтын мэдээллийг цэгцлэн боловсруулах.												
(3) Цахимжуулалтын дүнд "Нэг цэгийн үйлчилгээ"-г өргөжүүлэх.												
(4) Холбогдох байгууллагын бичиг баримт боловсруулах чадавхийг дээшлүүлх.												
(5) Хувийн секторын санал хүсэлтийг хүлээн авч, нийтлэх.												
Төслийн өртөг	сая төгрөг	159	160	165	168	174	178	188	193	201	207	1,793
	мян. ам.дол	62	62	64	63	66	67	71	73	76	78	682

Тэмдэглэл: Дэлхийн Банкны экспортын тайлангаас

Экспортын гэрчилгээ, олон улсын мал амьтны эрүүл мэндийн гэрчилгээг Хяналт шинжилгээний мэргэжлийн байгууллагын байцаагчийн цуглуулсан дээж болон Улсын мал эмнэлэг, ариун цэврийн төв лаборатори болон Хүнсний аюулгүй байдлын лавлагаа лабораторит хийсэн шинжилгээний үр дүнд үндэслэн гаргадаг. Нөгөө талаар, жишээ нь Австралид мах экспортлох үйлдвэрийг хяналт тавих, баталгаажуулж итгэмжлэл олгох замаар зөвшөөрөл өгдөг бөгөөд экспортод гаргах бүх бараанд дээжийн шинжилгээ хийлгүйгээр экспортын бичиг баримт бүрдүүлдэг болсон. Мөн Монголын гааль дээр одоогоор эрх бүхий ахлах байцаагч бүх мэдүүлгийг шалгадаг бөгөөд гаалийн байцаагчдын чадавхийг сайжруулснаар ямар байцаагч шалгасан ч баримт бичгийн бүртгэл адил түвшинд хийгдэх боломж бүрдэж, цаг хэмнэхэд ач тустай байх болно. Мөн ажлыг гүйцэтгэх дүрэм, форматыг боловсруулан бэлдэх нь төрийн байгууллагын бичиг баримт бүрдүүлэлтийг жигдрүүлэхэд тустай байх болно.

(2)Худалдааны гэрээ хэлэлцээрийн чадавхийг дээшлүүлэх төлөвлөгөө

YAT 9.2: Худалдааны гэрээ хэлэлцээрийн чадавхийг дээшлүүлэх төлөвлөгөө	
Төлөвлөгөөний зорилт	Стратегийн хувьд, худалдааны яриа хэлэлцээ хийхэд хувийн секторын эрэлт хэрэгцээг тусгах.
Суурь түвшин	Холбогдох төрийн байгууллагуудад (ГХЯ, ХХААХҮЯ, ЭЗХЯ) орон тооны олон улсын хэлэлцээр хийх хүнийг томилж, мэдээлэл солилцох системийг бий болгоно.
Төлөвлөгөөний зорилго	Гадаад худалдаатай холбоотой ЗГ-ын байгууллагууд (ГХЯ, ХХААХҮЯ, ЭЗХЯ)-ад мэргэшсэн олон улсын яриа хэлэлцээний ажилтан ажиллуулж, хувийн сектортой мэдээллээ хуваалцах тогтолцоо хэрэгжинэ.
Хамрах хүрээ	Орон даяар
Хүлээх үр дүн	Гадаад худалдаатай холбоотой засгийн газрын байгууллагууд болон хувийн секторын хооронд бүтээгдэхүүн экспортлох зорилтот улс орон болон салбарын талаарх мэдээллийг байнга цуглуулах, хуваалцах. Экспортод гаргах улс оронтой хийх яриа хэлэлцээний тухайд, хувийн секторын эрэлт хэрэгцээ болон бодит байдалд үндэслэн стратегийг урьдчилан боловсруулах, мөн яриа хэлэлцээний үр дүнг хувийн секторт тэр даруйд нь мэдэгддэг байх.
Үйл ажиллагаа	(1) Газар тариалангийн бүтээгдэхүүний худалдаатай холбоотой засгийн газрын байгууллагад гадаад худалдааны мэргэшсэн ажилтан томилон ажиллуулах. ГХЯ нь ХХААХҮЯ, ЭЗХЯ, Гаалийн ерөнхий газар, МҮХАҮТ-ийн хооронд гадаад худалдааны асуудлаар байнга холбоо харилцаатай байж, ажил зохицуулахын тулд дагнан хариуцах ажилтныг яамандаа байнга ажиллуулах. ГХЯ, ХХААХҮЯ, ЭЗХЯ, Гаалийн ерөнхий газар нь өөрийн яаманд олон улсын яриа хэлэлцээний мэргэжлийн баг ажиллуулах.

	(2) Мэргэшсэн зохион байгуулагч, олон улсын яриа хэлэлцээний мэргэжилтэн болон ирээдүйд энэ ажлыг хийх хүмүүст зориулсан яриа хэлэлцээний чадавхи дээшлүүлэх сургалт хэрэгжүүлэх. ГХЯ нь гадаадаас мэргэжилтэн урьж, холбогдох яам, агентлагт Ажлын байран дахь сургалт явуулж, зөвлөгөө өгүүлнэ. ГХЯ, ХХААХҮЯ, ЭЗХЯ нь худалдааны хэлэлцээр, яриа хэлэлцээний талаар судалгааны хурал зохион байгуулж, яриа хэлэлцээний чадавхийг дээшлүүлэхийг зорино. (3) ХАА-н бүтээгдэхүүн экспортлох гол улс орон, бараа бүтээгдэхүүнийг сонголт хийж тогтооно. ХХААХҮЯ болон ЭЗХЯ нь ойрын ирээдүйн экспортын боломжийн талаар зорилтот улс орон, зах зээл болон бүтээгдэхүүний талаар судалгаа хийж, үр дүнг нь нийтлэнэ. Энэ судалгаатай холбогдуулан, судалгааны багийг байгуулж томилон илгээхээс гадна гадаад улс оронд суугаа дипломат байгууллагын эдийн засаг хариуцсан ажилтантай холбоо тогтоон, уг сүлжээг идэвхтэй ашиглана. ХХААХҮЯ нь шаардлагатай үед, тухайлан гадаад оронд суугаа дипломат байгууллагад өөрийн яамнаас ажилтан томилон явуулж, мэдээ материал цуглуулах ажил хийлгэнэ. Зах зээлийн эрэлт хэрэгцээнээс гадна холбогдох Эрүүл ахуй, ургамлын эрүүл ахуйн арга хэмжээний тухай хэлэлцээр (SPS Agreement), Худалдаан дахь техникийн саад тотгорын тухай хэлэлцээр (TBT Agreement)-тэй холбоотой мэдээлэл бүрдэж, түүнийг холбогдох байгууллагууд хамтран өмчлөх болно. Экспортын гол улс орон, бараа бүтээгдэхүүний талаар жил бүр авч үзэж нягтлах ажил хийнэ. (4) Гадаад худалдааны яриа хэлэлцээг эхлүүлснээс хойших хэлэлцээ явуулах явцын тогтолцоо бий болно. ГХЯ нь худалдааны яриа хэлэлцээ явуулах боломж гармагц шууд холбогдох байгууллагуудыг урьж, хэлэлцээ хийх багийг байгуулна. ЭЗХЯ нь МҮХАҮТ-тай хамтран яриа хэлэлцээнд голлон оролцох аж ахуйн нэгжийг тодруулж тогтооно. Хэлэлцээ явуулах баг нь түнш орны төлөөлөгчдөөс танилцуулж буй сэдвийг судлан, холбогдох салбарын хувийн секторын эрэлт хэрэгцээг харгалзан зөвлөлдөж, яриа хэлэлцээнд баримтлах чиг бодлогыг тодорхойлно. Түнш улс оронтой яриа хэлэлцээ хийсний дараа хэлэлцээний протоколыг тэр даруйд нь үйлдэж, нийтэлнэ.	
Санхүүжилт	<u>Засгийн газар</u> • Хурал зохион байгуулах зардал • Мэрэгшсэн ажилтны зардал • Судалгааны зардал • Мэдээлэл цуглуулах зардал • Мэргэжилтэн урих зардал	<u>Хувийн хэвшил</u> • Хуралд оролцох зардал • Гэрээ хэлэлцээрт оролцох зардал
Төслийн өртөг	Төслийн нийт өртөг: 7 тэрбум 852 сая төгрөг (2,988,000 USD)	
Ашиг, үр нөлөө	Гэрээ хэлэлцээрт тавигдах асуудлуудын эрэмбэ дараалал тодорхой болж, хувийн хэвшлийн эрэлт хэрэгцээ шаардлагын талаар яриа хэлэлцээнд тусгагдана. Яриа хэлэлцээртэй холбоотой бодлогын үнэлгээ хийгдэж, санал хүсэлтийг хүлээн авна.	
Бодлогын бичиг баримттай уялдсан байдал	1. Алсын хараа 2050 4.4.11. Бүс нутгийн интеграцийг хөгжүүлж, худалдааг хялбаршуулах замаар урт хугацаандаа өрсөлдөх чадвар бүхий хэд хэдэн салбарт эдийн засгийг солонгоруулж, экспортын боломжийг нэмэгдүүлэх, зах зээлийг өргөжүүлэх бодлого хэрэгжүүлнэ. 2. Алсын хараа 2050 4.5.7. ЖДҮ-үүд глобал нэмүү өртгийн сүлжээний шаардлагыг хангахуйц хэмжээнд менежментээ бэхжүүлж, ажиллагсдын мэдлэг чадварыг дээшлүүлэн, технологийн дэвшил, инноваци нэвтрүүлж, бүтээгдэхүүний чанар, стандартыг сайжруулна. 3. Алсын хараа 2050 4.5.8. Гадаад орнуудад суугаа дипломат байгууллагаар дамжуулан жижиг дунд үйлдвэрт хэрэгтэй технологийн шинэчлэлийн талаарх мэдээллийг цуглуулж, олон улсын үзэсгэлэн болон бизнесийн хурал симпозиумыг ашиглаж хөрөнгө оруулагч түншийн хүрээг өргөжүүлнэ.	
Төсөл хэрэгжүүлэхэд анхаарах зүйлс	• Холбогдох байгууллагуудын хамтын ажиллагаа, зохицуулалтыг нягт нямбай хэрэгжүүлэх.	

Төслийг хэрэгжүүлэх хуваарь, төсөв

Үйл ажиллагаа		2025	2026	2027	2028	2029	2030	2031	2032	2033	2034	Нийт
(1) ХАА-н бүтээгдэхүүний худалдаанд холбогдох засгийн газрын байгууллагад гадаад худалдаагаар дагнан ажиллах мэргэжилтэн ажиллуулах.												
(2) ХАА-н бүтээгдэхүүнийг экспортлох гол улс, бараа бүтээгдэхүүнийг тодорхой болгох.												
(3) ХАА-н бүтээгдэхүүнийг экспортлох гол улс, бараа бүтээгдэхүүнийг тодорхой болгох.												
(4) Худалдааны яриа хэлэлцээ эхэлсний дараах яриа хэлэлцээний тогтолцоог бий болгох.												
Төслийн өртөг	сая төгрөг	978	976	977	655	675	694	714	695	715	773	7,852
	мян. ам.дол	376	371	371	249	256	264	271	264	272	294	2,988

Тэмдэглэл: Япон Тайландын Эдийн засгийн түншлэлийн хэлэлцээр ба түүний дараах үйл явц

2002 оны 4 сард Ажлын Хэсэг байгуулах талаар санал нэгдсэнээс хойш, 2004 оны 2 дугаар сард яриа хэлэлцээ эхэлж, 2007 оны 4 сард гарын үсэг зурсан. Мөн оны 11 дүгээр сард хэлэлцээр хүчин төгөлдөр үйлчилж эхэлсэн. Яриа хэлэлцээнд Японы талаас ГХЯ, Эдийн засаг, аж үйлдвэрийн яам, Сангийн яам, ХАА, ой, загас агнуурын яам оролцсон. Тайландыг оролцуулаад Азийн улсуудтай яриа хэлэлцээ хийхийн тулд, ХАА, ой, усны аж үйлдвэрийн яам 2003 онд ЭЗТХ-ээр дагнан ажиллах яриа хэлэлцээний багийг 40 хүний бүрэлдэхүүнтэйгээр шинээр байгуулсан. Сайд, газрын даргын түвшний албан тушаалтнууд оролцох чөлөөт худалдааны хэлэлцээрийн үндсэн баг байгуулагдаж, яриа хэлэлцээ хийх стратегийн хурлаар стратегийг талаар хэлэлцэж, дотоод зохицуулалтыг хийсэн. ХАА, ой, загас агнуурын яам дотоодын газар тариаланд нөлөө үзүүлэхээс зайлсхийж, газар тариалангийн бүтээгдэхүүний гаалийн татварыг бууруулахаас сэргийлж ирсэн хэдий ч, Тайландын хувьд цагаан будааны худалдааг чөлөөлөх саналыг хүчтэй тавьснаас яриа хэлэлцээ удаан хугацаагаар мухардмал байдалд байсан юм. Тиймээс ХАА, ой, загас агнуурын яам хоёр улсын хувьд хоёуланд нь ашигтай байлгах үүднээс, технологийн хамтын ажиллагаа болон газар тариалангийн тогтодын амьжиргааг дээшлүүлэхэд хамтран ажиллах саналыг Тайландын талд тавьж, эрүүл ахуй, ургамлын эрүүл мэндийн асуудлаар арга хэмжээ авахад дэмжлэг үзүүлэхээр болсон. Японы нийгмийн хувьд, хүнсний импортын тогтвортой байдал төрөлжүүлэлтэд, мөн жимс жимсгэнэ зэрэг Японд үйлдвэрлэсэн газар тариалангийн бүтээгдэхүүний экспортыг нэмэгдүүлэхэд тус нэмэртэй хэмээн тооцсон. ХАА, ой, загас агнуурын яамнаас гаргасан яриа хэлэлцээний энэ шинэ чиг бодлогыг JA группийн зүгээс ч идэвхтэй дэмжиж хамтран ажилласан юм. Яриа хэлэлцээний явцад ч JA группийн ерөнхийлөгч тэргүүтэй төлөөлөгчид Тайландын газар тариалангийн хоршоодод зочилж, Нэг суурин нэг бүтээгдэхүүн төсөл болон ХАА-н хоршоодын дунд хамтын ажиллагаа хөгжүүлэхийг санал болгож, хувийн секторын шугамаар ч хандсан. Эдгээрийн үр дүнд цагаан будааны тарифийг хэвээр үлдээж, газар тариалангийн бүтээгдэхүүний экспортыг нэмэгдүүлэх боломж бий болсон юм.

2015 онд байгуулагдсан ЭЗТХ нь Японы ХАА-н салбарт хэрхэн нөлөөлж ирсэн талаар судалгаа хийсэн. Энэхүү судалгаа нь ЭЗТХ-ийг дахин хэлэлцэх болон шинэчлэн сайжруулах яриа хэлэлцээ хийхэд зориулагдсан судалгаа бөгөөд Тайландад газар дээр нь ч очиж судалгаа явуулсан юм. Судалгааны үр дүнгээс үзэхэд, Японоос Тайландад гаргасан газар тариалан, ой, загас агнуурын салбарын бүтээгдэхүүний экспортын хэмжээ 2004 онд 13 тэрбум 400 сая иэн байсан бол 2015 онд 35 тэрбум 800 сая иэн болж өсчээ.

(3) Экспортыг дэмжих тогтолцоог бэхжүүлэх төлөвлөгөө

YAT 9.3: Экспортыг дэмжих тогтолцоог бэхжүүлэх төлөвлөгөө		
Төлөвлөгөөний зорилт	MYXAYT-ын ХАА-ын салбарын ЖДҮ-ийн экспортод үзүүлэх дэмжлэг зохих ёсоор бүрэн хэрэгжинэ.	
Суурь түвшин	Экспортыг дэмжих хөтөлбөрийн хүрээнд дэмжлэг авч буй ХАА-н чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг ЖДҮ-үүдийн тоо: жилд 0	
Төлөвлөгөөний зорилго	Экспортыг нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүлэх хөтөлбөрөөс дэмжлэг авсан ХАА-ын салбарын ЖДҮ, ААН-ийн тоо жилд 1000 компанид хүргэх	
Хамрах хүрээ	Орон даяар	
Хүлээх үр дүн	Дангаараа экспорт хийхэд хүндрэлтэй ЖДҮ-үүдэд зориулсан экспортлогч үйлдвэр, ААН-ийг дэмжих хөтөлбөр хэрэгжиж, үйлдвэр, ААН-д үзүүлэх дэмжлэг бодитойгоор эхэлнэ. Энэхүү дэмжлэгийн үр дүнд экспорт нэмэгдэнэ. Мөн экспортын бүрдүүлэлтийн журам хялбарчлагдаж, зардал багасна.	
Үйл ажиллагаа	(1) ЖДҮ-ийн экспортыг дэмжих үйл ажиллагааг дэмжих зорилгоор хууль эрхзүйн орчныг судалж, урамшууллын араг хэмжээг бий болгох. MYXAYT-аас экспортыг дэмжих татаасын төслийг хэрэгжүүлэхийн тулд шаардлагатай бол хууль эрх зүйн тогтолцоог боловсронгуй болгож, шинэчилнэ. ХХААХҮЯ-ны ЖДҮГ нь ХАА-н салбарын ЖДҮ эрхлэгчдийг дэмжих хөтөлбөрийг хэрэгжүүлэх урамшууллын төслийг хэрэгжүүлэгчээр MYXAYT-ыг татан оролцуулж хамтран хэрэгжүүлэх удирдамж, удирдамжийг боловсруулна. ХХААХҮЯ, ЭЗХЯ, СХЗГ, ГЕГ, MYXAYT, ЖДҮГ-тай хамтран ажиллана. (2) Хувийн хэвшилд тулгарч буй бэрхшээл, эрэлт хэрэгцээг төрийн байгууллагуудтай хуваалцах зорилгоор ХАА-н бүтээгдэхүүний экспортыг дэмжих хэлэлцүүлэг зохион байгуулах. ХАА-н бүтээгдэхүүний экспортыг дэмжих зөвлөлийг байгуулахад ЖДҮГ голлох үүрэг гүйцэтгэнэ. Тогтмол уулзалтуудыг MYXAYT-аас төлөвлөж, зохицуулдаг байх. ЖДҮГ-аас MYXAYT-д техникийн дэмжлэг үзүүлнэ. Тус зөвлөлд ЭЗХЯ, СХЗГ, ГЕГ, салбарын мэргэжлийн холбоодын төлөөлөл оролцож, экспортыг дэмжих асуудлаар хэлэлцдэг байх. MYXAYT, ЖДҮГ-аас шаардлагатай тохиолдолд холбогдох бусад агентлаг, компанийн төлөөллийг урьж оролцуулна. Экспортыг дэмжих зөвлөл нь цуглуулах, шинэчлэх шаардлагатай мэдээллийн салбаруудыг тодорхойлж, экспортын зах зээлийн талаарх мэдээллийг MYXAYT-аас цуглуулуулан авч, хэлэлцүүлэгт оролцогчид тодорхой салбарын мэдээлэл цуглуулахад хамтран ажиллана. (3) MYXAYT-ын ажилтнуудад ААН-үүдийг дэмжих чадварыг бэхжүүлэх сургалт явуулах. ХХААХҮЯ, ЭЗХЯ, СХЗ, ГЕГ-т MYXAYT-ын ажилтнуудыг хүлээн авч ажлын байрны сургалт зохион байгуулж, боловсон хүчний харилцаа холбоог дэмждэг байх. MYXAYT-д гадаадаас мэргэжилтнүүд урьж, хүний нөөцийг хөгжүүлэх чиглэлээр ажиллуулах. Экспортыг дэмжих чиглэлээр хамтран ажилладаг гадаадын байгууллагуудад хүсэлт тавьж MYXAYT-ын ажилтнуудыг сургалтын зорилгоор томилон ажиллуулдаг болох. (4) MYXAYT-аас бизнесийг дэмжих урамжуулал бий болгох. MYXAYT нь цуглуулсан мэдээллийг боловсруулж, гишүүн болон гишүүн бус компаниудад мэдээлэл өгөх. Мөн MYXAYT-аас Экспортыг дэмжих зөвлөлөөр хэлэлцэж буй тулгамдсан нэн тэргүүний асуудлуудаар аж ахуйн нэгжүүдэд дэмжлэг үзүүлнэ. ХХААХҮЯ нь MYXAYT-аас явуулж буй бизнесийг дэмжих арга хэмжээг урамжуулж хамтрах. MYXAYT-аас аж ахуйн нэгжүүдэд зориулсан сургалтын хөтөлбөрүүдийг төлөвлөж, хүний нөөцийг хөгжүүлэхэд хүчин чармайлт гаргана. Үзэсгэлэн худалдаа, туршилтын дэлгүүрээр дамжуулан монголын ХАА-н бүтээгдэхүүний брэнд хөгжүүлэх замаар бизнес эрхлэгчдийг дэмжинэ.	
Санхүүжилт	<u>Засгийн газар</u> • Хурал зохион байгуулах зардал • Мэргэжилтэн урих зардал • Гадаадад сургалтад хамрагдах зардал	<u>Хувийн хэвшил</u> • Дэмжлэгийн хөтөлбөрийг ашиглах төлбөр (Дэмжлэгийн хөтөлбөрийн зардлын 15%)

	• ААН-үүдийг дэмжих хөтөлбөр хэрэгжүүлэх зардал • Үзэсгэлэн худалдаанд оролцоход татаас олгох, туршилтын антен дэлгүүр ажиллуулах зардал • Салбарын эргэжлийн байгууллагуудын үйл ажиллагааны дэмжлэг • Төсөл хэрэгжүүлэх дүрэм журам боловсруулах зардал	
Төслийн өртөг	Төслийн нийт өртөг: 24 тэрбум 505 сая төгрөг (9,328,000 USD)	
Ашиг, үр нөлөө	ААН-үүд худалдааны илүү ашигтай нөхцлийг ашиглах боломж бүрдэнэ. Экспортын бүрдүүлэлтийн зардал буурна. ААН-үүд бизнесийн түншээ олоход хялбар болж, ашигтай нөхцлөөр гэрээ хэлэлцээр байгуулах боломж бүрдэнэ. Засгийн газар хувийн секторын эрэлт хэрэгцээг бодитойгоор ойлгож, оновчтойгоор дэмжих боломж бий болно. ХАА-н бүтээгдэхүүний экспорт нэмэгдэнэ.	
Бодлогын бичиг баримттай уялдсан байдал	1. Алсын хараа 2050 4.4.11. Бүс нутгийн интеграцийг хөгжүүлж, худалдааг хялбаршуулах замаар урт хугацаандаа өрсөлдөх чадвар бүхий салбаруудад эдийн засгийг солонгоруулж, экспортын боломжийг нэмэгдүүлэх, зах зээлийг өргөжүүлэх бодлого хэрэгжүүлнэ. 2. Алсын хараа 2050 4.5.7. Жижиг дунд үйлдвэр нь глобал нэмүү өртгийн сүлжээний шаардлагыг хангахуйц хэмжээнд менежментээ бэхжүүлж, ажиллагсдын мэдлэг чадварыг дээшлүүлэн, технологийн дэвшил, инноваци нэвтрүүлж, бүтээгдэхүүний чанар, стандартыг сайжруулна. 3. Алсын хараа 2050 4.5.8. Гадаад орнуудад суугаа дипломат байгууллагаар дамжуулан жижиг дунд үйлдвэрт хэрэгтэй технологийн шинэчлэлийн талаарх мэдээллийг цуглуулж, олон улсын үзэсгэлэн болон бизнесийн хурал симпозиумыг ашиглаж хөрөнгө оруулагч түншийн хүрээг өргөжүүлнэ.	
Төсөл хэрэгжүүлэхэд анхаарах зүйл	• Хувийн секторын эрэлт хэрэгцээ, тулгамдаж буй асуудалд үндэслэн үйл ажиллагаа явуулах.	

Төслийг хэрэгжүүлэх хуваарь, төсөв

Үйл ажиллагаа		2025	2026	2027	2028	2029	2030	2031	2032	2033	2034	Нийт
(1) ЖДҮ-ийн экспортыг дэмжих ҮА-г өргөжүүлэх үүднээс урамшуулын арга хэмжээ бий болгох.												
(2) Хувийн салбарын тулгамдсан асуудал болон эрэлт хэрэгцээг Засгийн газартай хуваалцах Экспортыг дэмжих Зөвлөл байгуулах.												
(3) МҮХАҮТ-ийн гишүүн ААН-ийг дэмжих чадварыг ахиулах сургалт зохион байгуулах.												
(4) МҮХАҮТ-аас ААН-д дэмжлэг үзүүлэхэд зориулж татаас олгох.												
Төслийн өртөг	сая төгрөг	760	1,058	2,762	2,421	2,479	2,684	2,733	3,141	3,201	3,266	24,505
	мян. ам.дол	294	402	1,051	921	943	1,021	1,040	1,195	1,218	1,243	9,328

Тэмдэглэл: Японы Худалдааг Дэмжих Байгууллага (JETRO) "Шинээр бүтээгдэхүүнээ экспортлогч 10 мянган компани хөтөлбөр"

Одоогийн байдлаар JETRO-гоос, урьд өмнө нь бүтээгдэхүүн экспортолсон туршлагагүй үйлдвэр, хувь хүмүүст зориулж, бүтээгдэхүүнээ экспортлоход нь дэмжлэг үзүүлж байна. Дэмжлэгт хамрагдахыг хүсч буй ААН нь JETRO-гийн цахим сайтаар үнэ төлбөргүй бүртгүүлдэг. 1. Мэргэжилтний зөвлөгөө авах (төлбөргүй), 2. Бүтээгдэхүүн хөгжүүлэлт болон сурталчилгааны тусламж авах (шаардлагатай хөрөнгийн 1/2-2/3-ийг олгох), 3. Экспортын ирээдүйтэй зах зээлийн танилцуулга болон тухайн улсад нь явах зах зээлийн судалгаа (төлбөргүй), 4. Уулзалт хийх, олон улсын үзэсгэлэн худалдаанд оролцох дэмжлэг болон гэрээ хэлэлцээрт дэмжлэг үзүүлэх (зарим хэсэг

төлбөргүй) гэх зэрэг хөтөлбөр бий. JETRO-гоос гадна орон нутгийн төрийн байгууллага, санхүүгийн байгууллага, худалдааны компаниуд хамтарч консорциум байгуулан, үйлдвэр, ААН-д дэмжлэг үзүүлж байна. Мөн 19 улс, бүс нутгийн 27 хотод, дотоод сүлжээгээр холбогдсон зохицуулагч кординатор ажиллуулж байна.

ХАА, ой, загас агнуурын гаралтай бүтээгдэхүүний экспортод дагнан дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа ч бий. Тодорхой бараа бүтээгдэхүүн, тодорхой улсын экспортын хязгаарлалт болон экспортын бичиг баримт бүрдүүлэлтийн мэдээг нэгтгэн танилцуулсан мэргэжлийн сайт, улс тус бүрийн эвент календарь хийж хэвлүүлэх, экспортын бараа тус бүр, улс орон тус бүрийн зах зээлийн репорт, гадаад улс дахь японы ХАА, ой, усны аж үйлдвэрийн бүтээгдэхүүн, хүнсний бүтээгдэхүүний экспортыг сурталчлах ажлыг дагнан эрхэлдэг байгууллага юм. Япон хүнс, хүнсний бүтээгдэхүүний брэндийг сайжруулах зорилготой JFOODO нь мөн JETRO-ийн дэргэд байгуулагдсан. JFOODO нь ХАА, ой, загасны аж ахуй яам, JETRO, JA групп зэрэг 15 байгууллагыг оролцуулсан бүлэглэл болох "ХАА, ой, загасны аж ахуйн бүтээгдэхүүн болон хүнсний бүтээгдэхүүний бүх Японы экспортыг дэмжих тогтолцоог бэхжүүлэх хамтын ажиллагааны хэлэлцээрт" үндэслэн байгуулагдсан хэрэгжүүлэх чиглэлээр мэргэшсэн байгууллага юм.

4.2.10 ХАА-н салбарын ААН, хоршоодын менежментийн бааз суурийг бэхжүүлэх хөтөлбөр

ХАА-н үйлдвэрлэлийн нэмүү өртгийн сүлжээ байгуулахад холбогдох барааны түгээлт болон бүтээгдэхүүн хөгжүүлэх ААН, хоршооны менежментийн бааз суурийг бэхжүүлэх явдал зайлшгүй шаардлагатай. Хоршооны тухайд бол хоршооны хууль шинэчлэгдснээр зах зээлээс хөрөнгө босгох боломжтой болсон боловч менежментийн бааз суурь эмзэг байгаа, засаглалын систем нь саад болж зээл авах болзлыг хангаж чадахгүй байна. ЖДҮ –ийн хувьд ч мөн ялгаагүй байдалтайгаас гадна, үйл ажиллагаа, харилцагчдад үйлчлэх (ерөнхий хэлтэс, санхүү бүртгэл, боловсон хүчин, агуулахын нярав г.м) шууд бус үйл ажиллагааг сайжруулах, үр өгөөжийг дээшлүүлэх шаардлагатай.

Оролцогч	Засгийн газар (ЖДҮГ)	Санхүүгийн байгууллага	Хувийн хэвшлийн ААН	ХАА-н хоршоо
Гол бэрх-шээл	ЖДҮ, хоршоонд бага хүүтэй зээл олгох бодлого хэрэгжүүлэх. Одоогоор ААН, хоршооны менежментийн баазыг бэхжүүлэх бодлого хязгаарлагдмал байна.	Сул дорой менежментийн баазтай ААН, байгууллагад зээл олгоход хүндрэлтэй. Хөдлөх хөрөнгийн үнэлгээний арга тодорхойгүй, зээлийн барьцаа болох боломжгүй	Сул дорой санхүүгийн тогтолцоо, засаглалтай. Барьцаа хөрөнгөгүй тул зээлийн хүртээмж дутагдалтай. Хөнгөлөлттэй зээл авах боломжгүй тул бэлэн мөнгө дутагдаж, хангалттай түүхий эд авч чаддаггүй.	Хоршоод өөрийн хөрөнгөгүй байх нь түгээмэл. Дүрмийн боловсруулалт хангалтгүй, зохион байгуулалтын бүтцэд хариуцлагын тогтолцоо тодорхойгүй. Эдгээрээс үүдэн зээл авахад туйлын хэцүү.
Авах арга хэмжээ	10.1 Нэмүү өртгийн сүлжээний зээлийн тогтолцоо нэвтрүүлэх бэлтгэл судалгаа хийх төлөвлөгөө гаргах 10.2 Агуулахын үнэт цаасны тогтолцоо нэвтрүүлэх бэлтгэл судалгаа хийх төлөвлөгөө гаргах 10.3 ЖДҮ-ийн менежментийн баазыг бэхжүүлэх төлөвлөгөө 10.4 ХАА-н хоршооны менежментийн баазыг бэхжүүлэх төлөвлөгөө			

Зураг 4.12 ХАА-н чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг ААН, хоршоодын менежментийн бааз суурийг бэхжүүлэх хөтөлбөр

Эх сурвалж: Жайка төслийн баг

ХАА-н бүтээгдэхүүний нийлүүлэлтийн сүлжээ байгуулахад санхүүгийн секторыг сайжруулах нь ХАА-ийн үйлдвэрлэлийн бизнесийг өргөтгөх, бүтээгдэхүүний өрсөлдөх чадварыг буй болгох хэтийн төлвийн хувьд туйлын чухал юм. Энэ хөтөлбөрт үл хөдлөх болон хөдлөх хөрөнгийг барьцаалах зээлээс гадна санхүүгийн шинэ системд хамаарах үйл ажиллагаа, ХАА-н салбарын хувийн ААН, хоршоодын бүтцийг бэхжүүлэхтэй холбоотой Үйл ажиллагааны төлөвлөгөө (ҮАТ)-г санал болгож байна. Доорхи хүснэгтэд схем 3.3-т үзүүлсэн төлөвлөгөө болон хөгжлийн чиглэлийн хамаарлыг харуулав.

Хүснэгт 4.10 ХАА-н салбарын ААН, хоршоодын менежментийн бааз суурийг бэхжүүлэх хөтөлбөр ба хөгжлийн чиглэлийн хамаарал

	Бодит бэрхшээл, давуу тал, хөгжлийн бодлогын чиглэлийн агуулга	ХАА-н салбарын ААН, хоршоодын менежментийн бааз суурийг бэхжүүлэх хөтөлбөр: 4 төлөвлөгөө			
		10.1	10.2	10.3	10.4
Хөгжлийн чиглэл 3	3-1-1 Нэмүү өртгийн сүлжээний зээлийн тогтолцоо бүрдүүлэх	◎			
	3-1-2 Агуулахын үнэт цаасны систем нэвтрүүлэх туршилт		◎		
	3-2-1 Хувийн ААН-ийн санхүүгийн удирдлагыг бэхжүүлэх			◎	
	3-2-2 ХАА-н хоршоодын бүтэц зохион байгуулалт, санхүүгийн удирдлагыг бэхжүүлэх				◎
	3-3-1 ГТ-н салбарын хууль эрх зүйн тогтолцоог сайжруулах	○	○	○	○
	3-3-2 МАА-н салбарын хууль эрх зүйн тогтолцоог боловсронгуй болгох	○	○	○	○

Эх сурвалж: Жайка төслийн баг ○ : Өндөр хамааралтай, ◎ : Хүчтэй хамааралтай

Төлөвлөгөө тус бүрийн товч агуулгыг доор сийрүүлэв.

“**10.1 Нэмүү өртгийн сүлжээний зээлийн системийг нэвтрүүлэх бэлтгэл судалгаа хийх төлөвлөгөө”** -нд зээлийн эрсдэлийн улмаас зээл авахад хүндрэлтэй байгаа ЖДҮ, хөдөө аж ахуйн хоршоодод зээлийн хүртээмжийг сайжруулахын тулд нэмүү өртгийн сүлжээгээр түүхий эдийг худалдан авагч тал худалдан авалтын баталгаа гаргаж,түүнийг нь арилжааны банкууд барьцаалж ЖДҮ, ХАА-н хоршоодод зээл олгох механизмыг бүрдүүлнэ.

“**10.2 Агуулахын үнэт цаасны тогтолцоо нэвтрүүлэх бэлтгэл судалгааны төлөвлөгөө”**-нд тодорхой хөрөнгийн үнэлгээтэй ХАА-н бүтээгдэхүүнээ хадгалуулж буй хүмүүст агуулахын үйлчилгээ үзүүлэгч ААН агуулахын үнэт цаас гаргаж олгодог тогтолцоо бүрдүүлнэ.Агуулахын үнэт цаас нь хадгалуулсан хувь хөрөнгийг шилжүүлэх болон, ломбардад тавих гэх мэтээр захиран зарцуулах, мөн үүнийг барьцаалж банкнаас зээл авах боломжтой.Монголд ХАА-н бүтээгдэхүүний дотроос барьцаалж хадгалуулах боломжтой барааг тогтоохыг судлах шаардлагатай, тийм учраас бэлтгэл судалгааг хэрэгжүүлэх шаардлагатай юм.

“**10.3 ЖДҮ-ийн менежментийн баазыг бэхжүүлэх төлөвлөгөө”**-нд ХАА-н үйлдвэрлэл эрхэлдэг ЖДҮ-дэд илүү өгөөжтэй, тогтвортой менежментийг дэмжих тогтолцоог өргөжүүлэх.Өөрөөр хэлбэл, менежментийн салбарын зөвлөлгөө өгөх мэргэжилтэн илгээж, санхүүгийн удирдлагыг зохистой болгох, өртөг бууруулах, борлуулалтыг идэвхижүүлэх, маркетингийг сайжруулах зэрэг зөвлөмж өгөхөд хялбар орчин бүрдүүлэх.

“**10.4 ХАА-н хоршоодын менежментийн бааз суурийг бэхжүүлэх төлөвлөгөө”**-нд хөгжиж буй ХАА-н хоршоодод, ХАА-н бүтээгдэхүүнд нэмүү өртөг шингээж, борлуулалтын салбарт санаачлагатай ажиллаж буй хоршоодын туршлага судлах, хоршооны менежментийн судалгаа хийх зэргээр ХАА-н хоршооны бүтцийг бэхжүүлэх.

(1) Нэмүү өртгийн сүлжээний санхүүжилтийн систем нэвтрүүлэх бэлтгэл судалгааны

төлөвлөгөө

YAT 10-1: Нэмүү өртгийн сүлжээний санхүүжилтийн систем нэвтрүүлэх бэлтгэл судалгааны төлөвлөгөө		
Төлөвлөгөөний зорилт	Зээлийн эрсдлийн талаасаа зээл авахад хүндрэлтэй байгаа ХАА-н чиглэлийн үйл ажиллагаа явуулдаг ЖДҮ, холбоодын зээлийн хүртээмжийг сайжруулах зорилгоор нэмүү өртгийн сүлжээний зээлийн системийг нэвтрүүлэх суурь судалгаа (загвар төсөл ч багтана) хийж,уг системийн схем боловсруулж, зохион байгуулах.	
Төлөвлөгөөний зорилго	Нэмүү өртгийн сүлжээний зээлийн систем нэвтрүүлэх суурь судалгаа (загвар төсөл ч багтана) хийж, түүний үр дүнд үндэслэн Монгол Улсад хэрэгжих боломжтой нэмүү өртгийн сүлжээний зээлийн систем бүрдүүлэх.	
Суурь түвшин	Нэмүү өртгийн сүлжээний зээлийн системд хандивлагчид болон арилжааны банкууд нэвтрүүлэх судалгаа эхэлж байгаа ч одоогоор загвар төсөл хэрэгжээгүй байна.	
Хамрах хүрээ	Орон даяар	
Хүлээх үр дүн	(1) Нэмүү өртгийн сүлжээний зээлийн системийн талаар бусад орны жишээг цуглуулж, үнэлэн Монголд тохирох зээлийн тогтолцооны төсөл боловсруулах. (2) Хамтран ажиллах боломжтой арилжааны банкыг сонгож, нэмүү өртгийн сүлжээний тодорхой оролцогч талуудыг холбож, нэмүү өртгийн санхүүжилтийн загвар төслийг хэрэгжүүлэх (3) Загвар төслийн үр дүнг нэгтгэн, нэмүү өртгийн сүлжээний зээлийн тогтолцооны төслийг сайжруулах. (4) Нэмүү өртгийн сүлжээний зээлийн тогтолцоог бүрдүүлэх.	
Үйл ажиллагаа	(1) Энэ төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд шаардлагатай шалгуур үзүүлэлтийг боловсруулж, нийтэд зарлан үйл ажиллагааг хэрэгжүүлэх туслан гүйцэтгэгчийг сонгоно. ХХААХҮЯ, ЖДҮГ голлон, нэмүү өртгийн сүлжээний зээлийн системийн схем боловсруулах зорилготой гэрээгээр гүйцэтгэгчийг сонгох шалгуурыг боловсруулах. Шалгуурт бусад улсын туршлага жишээг цуглуулах,үнэлэх аж ахуйн гадна, загвар төслийн төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлэх, түүний үр дүнд үндэслэн Монгол Улсад ашиглах боломжтой нэмүү өртгийн сүлжээний зээлийн тогтолцооны схем боловсруулах хүртэлх ажлыг хамруулах. (2) Гэрээгээр гүйцэтгэх байгууллага нь хэрэгжүүлэх судалгааны төслийн явцыг удирдах. ХХААХҮЯ, ЖДҮГ голлон туслан гүйцэтгэх байгууллагын хэрэгжүүлэх судалгааны төслийн явцыг удирдах. Загвар төсөлд хамрагдах нэмүү өртгийн сүлжээ болон холбоотой ажиллах арилжааны банкийг сонгох талаар туслан гүйцэтгэх байгууллагын зөвлөмжийг хэрэгжүүлнэ. Загвар төсөлд хамрагдсан нэмүү өртгийн сүлжээнд оролцогч талуудыг холбоход ХХААХҮЯ-ны орон нутгийн бодлогын газрын ажилтан хэрэгжүүлэх боломжтой тогтолцоо бүрдүүлэх. (3) Гэрээгээр гүйцэтгэгчийн ажлын үр дүнг хянах. Гэрээгээр гүйцэтгэгчийн ажлын үр дүнгийн талаар ХХААХҮЯ, ЖДҮГ голлон нарийвчлан хянах. Мөн хөгжлийн түншлэгчид (Дэлхийн банк, Азийн хөгжлийн банк, Олон улсын санхүүгийн корпораци зэрэг (цаашид ДБ,АХБ, ОУСК гэх))-ийн мэргэжилтний саналыг авч, шаардлагатай бол туслан гүйцэтгэгчээр засвар хийлгүүлж судалгааны үр дүнг нэгтгэх. (4) Нэмүү өртгийн сүлжээний зээлийн тогтолцооны схем боловсруулах. ХХААХҮЯ, ЖДҮГ голлон гэрээгээр гүйцэтгэгчийн ажлын үр дүнд үндэслэн, нэмүү өртгийн сүлжээний зээлийн тогтолцооны схем боловсруулах. Тогтолцооны схем боловсруулахдаа хөгжлийн түншлэгчид (ДБ,АХБ, ОУСК гэх) зэрэг)-ийн мэргэжилтэн болон арилжааны банкны холбогдох оролцогчтой санал солилцож Монгол Улсад илүү тохирох тогтолцооны схем боловсруулахад анхаарах. Тогтолцооны схем боловсруулж дуусаад УИХ-аар хэлэлцүүлэн, хууль эрх зүйн чадамжтай баримт бичиг болгох.	
Санхүүжилт	<u>Засгийн газар</u> • Нэмүү өртгийн сүлжээний зээлийн тогтолцооны судалгаа хийх туслан гүйцэтгэгчийн зардал	<u>Хувийн хэвшил</u> • Байхгүй

	• Бүх аймаг, сумдын ХААГ-ын мэргэжилтний томилолт, унааны зардал	
Төслийн өртөг	Төслийн нийт өртөг: 931 сая төгрөг (354,000USD)	
Ашиг, үр нөлөө	Ялангуяа зээлийн эрсдэл өндөртэй зээл авах боломжгүй ЖДҮ, ХАА-н хоршоонд зээлийн хүртээмжийг сайжруулах, тухай тухайн бизнесийг өргөжүүлэхийг дэмжих. ХАА-н хоршоодын түүхий эд бэлтгэн нийлүүлэх, анхан шатны боловсруулалт хийх үйл ажиллагааг сайжруулах, боловсруулагч ААН, хэрэглэгчийн хэрэгцээнд нийцүүлсэн түүхий эдээр хангах боломж бүрдэх.	
Бодлогын бичиг баримттай уялдсан байдал	1. Алсын хараа 2050 4.1.17. Байгаль орчинд ээлтэй, үр өгөөжтэй цэвэр технологи, эдийн засгийн өгөөжтэй хэрэглээг дэмжсэн тогтвортой бөгөөд эрсдэл даах чадвартай ногоон эдийн засгийг хөгжүүлэхийг дэмжих ногоон санхүүжилт, татвар, төсвийн татаас, худалдан авах, урамшуулах тогтолцоог сайжруулах. 2. Алсын хараа 2050 4.3.20. Хүүг бууруулах, бизнесийн үйл ажиллагаа, хөрөнгө оруулалтыг дэмжих.	
Төслийг хэрэгжүүлэхэд анхаарах зүйлс	• Нэмүү өртгийн сүлжээний зээлийн тогтолцооны талаар ОУСК болон Монголын арилжааны банкууд түүнийг нэвтрүүлэх боломжтой эсэхийг судалж байгаа. Энэ төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд ОУСК-тай урьдчилсуан зохиулалт хийх шаардлагатайг анхаарах хэрэгтэй.	

Төслийг хэрэгжүүлэх хуваарь, төсөв

Үйл ажиллагаа		2025	2026	2027	2028	2029	2030	2031	2032	2033	2034	Нийт
(1) Уг төлөвлөгөөг хэрэгжүүлэхийн тулд шалгуур үзүүлэлт боловсруулж нийтэд зарлан туслан гүйцэтгэгчийг сонгох.												
(2) Гэрээт гүйцэтгэгчийн хэрэгжүүлэх судалгааны төслийн явцыг хянах.												
(3) Гэрээт гүйцэтгэгчийн гарц /бүтээл/-ийн нарийвчлан шалгах.												
(4) Нэмүү өртгийн сүлжээний зээлийн тогтолцооны схем боловсруулах.												
Төслийн өртөг	сая төгрөг	372	559									931
	мян. ам.дол	142	212									354

(2) Агуулахын үнэт цаасны тогтолцоо нэвтрүүлэх бэлтгэл судалгааны төлөвлөгөө

ҮАТ 10-2: Агуулахын үнэт цаасны тогтолцоо нэвтрүүлэх бэлтгэл судалгааны төлөвлөгөө	
Төлөвлөгөөний зорилт	Зээлийн эрсдлийн талаасаа зээл авахад хүндрэлтэй ХАА-н үйлдвэрлэл явуулдаг ЖДҮ, хоршоодын зээлийн хүртээмжийг сайжруулахын тулд агуулахын үнэт цаасны тогтолцоо нэвтрүүлэх суурь судалгаа (загвар төслийг хамруулан) хийж, уг тогтолцооны схем боловсруулж тогтолцоо бүрдүүлэх.
Төлөвлөгөөний зорилго	Агуулахын үнэт цаасны тогтолцоо нэвтрүүлэх суурь судалгаа (Агуулахын үнэт цаасны тогтолцооны талаар хамруулан) хийж, түүний үр дүнд үндэслэн Монгол Улсад хэрэгжих боломжтой агуулахын үнэт цаасны систем бүрдүүлэх.
Суурь түвшин	Агуулахын үнэт цаасны тогтолцооны талаар өнгөрсөн хугацаанд ХААБиржээс нэвтрүүлэх судалгаа эхлээд байгаа ч одоогоор туршилтын нэвтрүүлэлт г.м хэрэгжүүлсэн ажил байхгүй.
Хамрах хүрээ	Орон даяар
Хүлээх үр дүн	(1) Агуулахын үнэт цаасны тогтолцооны талаар бусад улсын жишээ цуглуулж үнэлэх, Монголд тохиромжтой гэж үзсэн тогтолцооны төсөл боловсруулах. (2) Агуулахын үнэт цаасны тогтолцоонд хамруулах барааг сонгох.

	(3) Загвар төслийн үр дүнг сийрүүлэн,агуулахын үнэт цаасны тогтолцооны схем боловсруулах. (4) Агуулахын үнэт цаасны тогтолцоог институтжүүлэх.	
Үйл ажиллагаа	(1) Уг төлөвлөгөөг хэрэгжүүлэхийн тулд шалгуур үзүүлэлт боловсруулж нийтэд зарлан туслан гүйцэтгэгчийг сонгох. ХХААХҮЯ, ХААБирж голлон агуулахын үнэт цаасны тогтолцооны схем боловсруулах зорилгоор туслан гүйцэтгэгчийг сонгох шалгуурыг боловсруулах. Шалгуур үзүүлэлтэд бусад улсын жишээ цуглуулах, үнэлэх ажлаас гадна тогтолцоонд хамруулах барааны сонголт хийх санал өгөх, загвар төслийн төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлэх, загвар төслийн үр дүнд үндэслэн Монгол Улсад хэрэглэх боломжтой агуулахын үнэт цаасны тогтолцооны схем боловсруулах ажлыг багтаана. (2) Гэрээт гүйцэтгэгчийн хэрэгжүүлэх судалгааны ажлын явцад хяналт тавих. ХХААХҮЯ болон ХААБиржээс манлайлан туслан гүйцэтгэгчийн хэрэгжүүлэх судалгааны ажлын явцад хяналт тавих. Агуулахын үнэт цаасны тогтолцоонд хамруулах бүтээгдэхүүний нэр төрлийг сонгохтой холбогдуулан туслан гүйцэтгэгчийн санал зөвлөмж төдийгүй холбогдох төслийн гүйцэтгэлийн баялаг туршлагатай хөгжлийн түншлэгчдийн мэргэжилтнүүдийн саналыг авсны үндсэн дээр шийдвэр гаргах. Түүнчлэн, загвар төсөлд хамруулах бараа болон хамтран ажиллах агуулахын аж ахуйн эрхлэгчийг сонгохдоо, туслан гүйцэтгэгчийн саналыг харгалзан шийдвэр гаргана. Загвар төсөлд хамрагдсан оролцогчдыг зохицуулахын тухайд, ХХААХҮЯ-ны хөдөөгийн бодлогын газрын мэргэжилтэн хэрэгжүүлэх боломжтой тогтолцоо бүрдүүлэх. (3) Гэрээт гүйцэтгэгчийн ажлын үр дүнг шалган нягтлах. Гэрээт гүйцэтгэгчийн үр дүн /бүтээл/-ийн талаар ХХААХҮЯ, ХААБ голлон нарийвчлан хянах. Мөн хөгжлийн түншлэгчид (ДБ,АХБ, ОУСК гэх) зэрэг)-ийн мэргэжилтний саналыг авах, шаардлагатай бол туслан гүйцэтгэгчээр засвар хийлгэх зэргээр судалгааны үр дүнг нэгтгэх. (4) Агуулахын үнэт цаасны тогтолцооны схем боловсруулах. ХХААХҮЯ, ХААБирж голлон, туслан гүйцэтгэгчийн хэрэгжүүлсэн ажлын үр дүнд үндэслэн, агуулахын үнэт цаасны тогтолцооны схем боловсруулах ажлыг гүйцэтгэх. Системийн схем боловсруулахдаа агуулахын аж ахуй эрхлэгч этгээдийн бүртгэл хөтлөлт, магадлан итгэмжлэх боломжтой агуулахын стандарт тогтоох зэргийг багтаасан судалгаа хийх. Түүнчлэн хөгжлийн түншлэгчид (ДБ,АХБ, ОУСК гэх) зэрэг)-ийн мэргэжилтнүүдтэй санал солилцож, Монголын нөхцөлд илүү зохицох тогтолцооны схем боловсруулахад анхаарах. Схем боловсруулж дуусаад зохих журмын дагуу УИХ-аар хэлэлцүүлэн, хууль эрх зүйн чадамжтай баримт бичиг болгох.	
Санхүүжилт	<u>Засгийн газар</u> • Агуулахын үнэт цаасны тогтолцооны судалгаа хийх туслан гүйцэтгэгчийн зардал • Бүх аймаг, сумдын ХААГ-ын мэргэжилтний томилолт, унааны зардал	<u>Хувийн хэвшил</u> • Байхгүй
Төслийн өртөг	Төслийн нийт өртөг: 655 сая төгрөг (249,000 USD)	
Ашиг, үр нөлөө	Ялангуяа зээлийн эрсдэл өндөртэй зээл авах боломжгүй ЖДҮ, ХАА-н хоршоодын зээлийн хүртээмжийг сайжруулах, тус тусын бизнесийг өргөжүүлэхийг дэмжих.	
Бодлогын бичиг баримттай уялдсан байдал	1. Алсын хараа 2050 4.1.17. Байгаль орчинд ээлтэй, үр өгөөжтэй цэвэр технологи, эдийн засгийн өгөөжтэй хэрэглээг дэмжсэн тогтвортой бөгөөд эрсдэл даах чадвартай ногоон эдийн засгийг хөгжүүлэхийг дэмжих ногоон санхүүжилт, татвар, төсвийн татаас, худалдан авах, урамшуулах тогтолцоог сайжруулах. 2. Алсын хараа 2050 4.3.20. Хүүг бууруулах, бизнесийн үйл ажиллагаа, хөрөнгө оруулалтыг дэмжих.	
Төслийг хэрэгжүүлэхэд анхаарах зүйлс	• Агуулахын үнэт цаасны тогтолцооны схем боловсруулахдаа холбогдох хөгжлийн түншлэгчдийн саналыг авах.	

Төслийг хэрэгжүүлэх хуваарь, төсөв

Үйл ажиллагаа		2025	2026	2027	2028	2029	2030	2031	2032	2033	2034	Нийт
(1) Уг төлөвлөгөөг хэрэгжүүлэхийн тулд шалгуур үзүүлэлт боловсруулж нийтэд зарлан гэрээт гүйцэтгэгчийг сонгох.												
(2) Гэрээт гүйцэтгэгчийн хэрэгжүүлэх судалгааны төслийн явцыг хянах.												
(3) Гэрээт гүйцэтгэгчийн ажлын үр дүнг нарийвчлан шалгах.												
(4) Агуулахын үнэт цаасны тогтолцооны схем боловсруулах.												
Төслийн өртөг	сая төгрөг	262	393									655
	мян. ам.дол	100	149									249

(3) ЖДҮ-ийн менежментийн бааз суурийг бэхжүүлэх төлөвлөгөө

ҮАТ 10-3: ЖДҮ-ийн менежментийн суурийг бэхжүүлэх төлөвлөгөө	
Төлөвлөгөөний зорилго	ХАА-н үйлдвэрлэл эрхлэгч ЖДҮ-ийн дотроос ялангуяа экспортын чиглэлийн үйл ажиллагаа явуулдаг ААН-ийн менежментийн суурийг бэхжүүлэх зорилготой дэмжлэгийн тогтолцоо бүрдүүлэх, менежментийн болон санхүүгийн удирдлагын чиглэлээр, бүтээгдэхүүн хөгжүүлэлт, борлуулалтыг дэмжих, маркетингийн мэргэжилтний зөвлөмж авах боломжоор хангах орчин бүрдүүлэх.
Төлөвлөгөөний зорилт	ХАА-н чиглэлийн ЖДҮ-т мэргэжилтэн томилж ажиллуулах дэмжлэг авсан компанийн тоо жилд 10 компани, нийт 100 компанид хүрэх.
Суурь түвшин	ХАА-н үйлдвэрлэлийн чиглэлийн ЖДҮ-т мэргэжилтэн томилж ажиллуулахад дэмжлэг үзүүлэх тогтолцоо байхгүй.
Хамрах хүрээ	Орон даяар
Хүлээх үр дүн	(1) Бусад улсад хэрэгжиж байгаа ижил төстэй төсөл арга хэмжээтэй танилцах. (2) Монголд тохирсон мэргэжилтэн томилон ажиллуулах тогтолцооны схем боловсруулах (3) Тогтолцоог ашигласан ХАА-н үйлдвэрлэл эрхлэгч ЖДҮ-ийн менежмент, санхүүгийн удирдлагын болон бүтээгдэхүүн хөгжүүлэлт, борлуулалтыг идэвхижүүлэх, маркетинг бэхжих.
Үйл ажиллагаа	(1) Уг төлөвлөгөөг хэрэгжүүлэхийн тулд шалгуур үзүүлэлт боловсруулж нээлттэйгээр туслан гүйцэтгэгчийг сонгох. ХХААХҮЯ, ЖДҮГ голлон ЖДҮ-т мэргэжилтэн ажиллуулах тусламжийн тогтолцооны схем боловсруулах зорилгоор туслан гүйцэтгэгчийг сонгох шалгуур үзүүлэлт боловсруулах. Шалгуурт, бусад улсын туршлага судлах, үнэлж дүгнэхээс гадна, Монгол Улсад хэрэглэх боломжтой мэргэжилтэн томилж ажиллуулах тогтолцооны схем боловсруулах хүртэлх ажлыг тусгах. (2) Гэрээт гүйцэтгэгчийн хэрэгжүүлэх судалгааны ажлын явцад хяналт тавих. ХХААХҮЯ, ЖДҮГ голлон,туслан гүйцэтгэгчийн хэрэгжүүлэх судалгааны ажлын явцад хяналт тавих. Гэрээт гүйцэтгэгч нь ХАА-н үйлдвэрлэл эрхлэгч ЖДҮ-г хамруулсан өргөн хүрээний тодруулах судалгаа хийж тусламж авах хэрэгцээг тогтоох. Мөн тусламжийн хэрэгцээнд зориулж, мэргэжилтэн ажиллуулах үйлчилгээ болон нийлүүлэгчийн хүний нөөц болон үйлчилгээний агуулгын талаар судалгаа хийх. (3) Гэрээт гүйцэтгэгчийн ажлын үр дүнг хянах. Гэрээт гүйцэтгэгчийн ажлын үр дүнг ХХААХҮЯ, ЖДҮГ голлон нарийвчлан шалгана. Гэрээт гүйцэтгэгчийн санал болгосон тогтолцооны схемийн талаар ХАА-н үйлдвэрлэлд оролцогч хувийн хэвшлийн мэргэжлийн холбоод (МҮХАҮТ, холбогдох мэргэжлийн

	холбоод) -ын саналыг харгалзан сайжруулах арга хэмжээ авах (4) ЖДҮ-т мэргэжилтэн томилох тогтолцооны схем боловсруулах. ХХААХҮЯ, ЖДҮГ голлон,туслан гүйцэтгэгчийн судалгааны үр дүнд үндэслэн мэргэжилтэн томилох тогтолцооны схем боловсруулах. Тогтолцооны схем боловсруулахдаа хөгжлийн түншлэгчдийн мэргэжилтнүүд болон ХАА-н үйлдвэрлэлийн чиглэлийн хувийн секторын холбоодын оролцогчидтой мөн санал солилцож Монголын бодит байдалд илүү нийцсэн тогтолцооны схем болгоход анхаарах. Схем боловсруулж дуусаад зохих журмын дагуу УИХ-аар хэлэлцүүлэн, хууль эрх зүйн чадамжтай баримт бичиг болгох. (5) ЖДҮГ тогтолцооны менежмент хийх. ЖДҮГ голлон мэргэжилтэн томилж ажиллуулах тогтолцооны менежментийг хэрэгжүүлж эхлэх. Энэ тогтолцоо нь менежментийн мэргэжилтэн болон ХАА-н үйлдвэрлэл эрхлэгч ЖДҮ-үүдийг хооронд нь холбох зорилготой бөгөөд тогтолцоонд зарцуулах татаас нь бага дүнтэй (тодруулбал мэргэжилтнийг томилон ажиллуулах эхний зардлыг л улс хариуцах) юм.	
Санхүүжилт	Засгийн газар • Тогтолцооны схем боловсруулахад шаардлагатай суурь судалгаа хийх туслан гүйцэтгэгчийн зардал • Мэргэжилтэн томилох тогтолцоотой холбоотой татаас • Бүх аймаг, сумдын ХААГ-ын мэргэжилтний томилолт, унааны зардал	Хувийн хэвшил • Байхгүй
Төслийн өртөг	Төслийн нийт өртөг: 500 сая төгрөг (190,000 USD)	
Ашиг, үр нөлөө	Мэргэжилтэн томилж ажиллуулснаар ЖДҮ-ийн менежментийг өөрчлөх. Үүний үр дүнд санхүүгийн хяналт, бүтээгдэхүүн үйлдвэрлэлт үр өгөөжтай болж, орлого ашиг сайжирна	
Бодлогын бичиг баримттай уялдсан байдал	1. Алсын хараа 2050 4.1.17. Байгаль орчинд ээлтэй, үр өгөөжтэй цэвэр технологи, эдийн засгийн өгөөжтэй, хэрэглээг дэмжсэн тогтвортой бөгөөд эрсдэл даах чадвартай ногоон эдийн засгийг хөгжүүлэхийг дэмжих ногоон санхүүжилт, татвар, төсвийн татаас, худалдан авах, урамшуулах тогтолцоог сайжруулах. 2. Алсын хараа 2050 4.3.20. Хүүг бууруулах, бизнесийн үйл ажиллагаа, хөрөнгө оруулалтыг дэмжих.	

Төслийг хэрэгжүүлэх хуваарь, төсөв

Үйл ажиллагаа		2025	2026	2027	2028	2029	2030	2031	2032	2033	2034	Нийт
(1) Уг төлөвлөгөөг хэрэгжүүлэхийн тулд шалгуур үзүүлэлт боловсруулж нээлттэйгээр туслан гүйцэтгэгчийг сонгох.												
(2) Гэрээт гүйцэтгэгчийн хэрэгжүүлэх судалгааны төслийн явцыг хянах.												
(3) Гэрээт гүйцэтгэгчийн үр дүнг шалган нягтлах												
(4) ЖДҮ-т мэргэжилтэн томилж ажиллуулах тогтолцооны схем боловсруулах.												
(5) ЖДҮГ уг тогтолцооны үйл ажиллагааг удирдах.												
Төслийн өртөг	сая төгрөг	160	190	30	30	30	30	30				500
	мян. ам.дол	63	72	11	11	11	11	11				190

(4) ХАА-н хоршоодын менежментийн баазыг бэхжүүлэх төлөвлөгөө

YAT 10-4: ХАА-н хоршоодын менежментийн баазыг бэхжүүлэх төлөвлөгөө		
Төлөвлөгөөний зорилт	Дэвшилттэй үйл ажиллагаа явуулж байгаа ХАА-н хоршоодтой танилцах, хоршооны зохион байгуулалтын бүтцийг бэхжүүлэхэд чиглэсэн сургалтын төслөөр дамжуулан хөгжих шатандаа яваа ХАА-н хоршооны менежментийг бэхжүүлэх, бүтцийн нэгжээр ХАА-н бүтээгдэхүүний бэлтгэн нийлүүлэлт ба нэмүү өртөг шингээх ажил эрхлэх хоршооны тоог нэмэгдүүлэх.	
Төлөвлөгөөний зорилго	ХАА-н бүтээгдэхүүний бэлтгэн нийлүүлэлт ба анхан шатны боловсруулалт зэрэг бизнесийн үйл ажиллагааг бодитойгоор хэрэгжүүлэх ХАА-н хоршооны тоог 230 хоршоо хүртэл нэмэгдүүлэх.	
Суурь түвшин	Одоогоор, ХАА-н бүтээгдэхүүний бэлтгэн нийлүүлэлт, анхан шатны боловсруулалтын бизнесийн үйл ажиллагааг бодитойгоор эрхэлдэг ХАА-н хоршоо цөөн байна.	
Хамрах хүрээ	Орон даяар	
Хүлээх үр дүн	(1) ХАА-н хоршооны хэрэгжүүлж байгаа бизнесийн үйл ажиллагаа ба менежментийн байдал цэгцрэх. (2) ХАА-н хоршоонд чиглэсэн хоршооны менежментийн баазыг бэхжүүлэх зорилготой сургалт хийгдэх.	
Үйл ажиллагаа	(1) Одоо байгаа ХАА-н хоршооны чадавхийг бэхжүүлэхэд чиглэсэн хэрэгцээний судалгаа. Бүх аймаг сумдын ХААГ-ын ажилтан нь одоо ажиллаж байгаа ХАА-н хоршооны баримтжуулах судалгаа хийх. Гол нь хоршоодын хийж байгаа бизнесийн талаар судалгаа хийх,түүний орлого ашиг болон тулгамдсан асуудлаас гадна бизнесээ өргөтгөх сургалтын хэрэгцээний чиглэлийг судлах. (2) Төсөлд хамруулах ХАА-н хоршоог сонгох. Бүх аймгийн ХААГ голлон бүтцийг нь бэхжүүлэх шаардлагатай ХАА-н хоршоог сонгох. Сонголт хийхдээ аймгуудын хөгжлийн чиглэлээс гадна, хоршооны хэрэгжүүлэх бизнесийг өргөтгөх боломж, хоршооны үйл ажиллагааны туршлагыг харгалзах. (3) Сонгогдсон ХАА-н хоршоодод сургалт хийх. Аймгуудын ХААГ голлон ХАА-н хоршоодод сургалт хийх. Сургалтын бүтэц нь 1) Дэвшилттэй үйл ажиллагаа явуулж байгаа ХАА-н хоршоотой танилцах, 2) Үйлдвэрлэлийн болон санхүү, агуулахын үлдэглийн хяналтын менежментийн чиглэлийн сургалт явуулах, 3) Хоршооны дүрмийг хянаж, засч шинэчлэх г.м. (4) Мониторинг хийх. Төсөл хэрэгжиж дууссаны дараа үр дүнг нь баталгаажуулах зорилгоор сургалтад хамрагдсан хоршоонд мониторинг хийх.	
Санхүүжилт	<u>Засгийн газар</u> • Аймаг сумдын ХААГ-ын мэргэжилтний замын зардал, хурлын зардал зэрэг • ХАА-н хоршооны сургалтын зардал	<u>Хувийн хэвшил</u> • Байхгүй
Төслийн өртөг	Төслийн нийт өртөг: 1 тэрбум 897 сая төгрөг (722,000 USD)	
Ашиг, үр нөлөө	Хоршооны засаглал бэхжиснээр гадна талын итгэл дээшилж, ХАА-н хоршоодын зээлийн хүртээмж сайжирна. Мөн хоршоодын бизнесийн үйл ажиллагаа сайжирч, хоршоодын болон гишүүдийн орлого ашиг сайжирна	
Бодлогын бичиг баримттай уялдсан байдал	Алсын хараа 2050 3.3.1-д Аймаг сумдын ҮЭХ (хоршоо)-ний бизнесийн талаар хөрөнгийн болон зах зээлд нэвтрэх боломжтой өртгийн сүлжээг бүрдүүлэх. Хоршоонд ажлын байр нэмэгдэж, хоршоо нь нийлүүлэлтийн сүлжээтэй холбогдоно.	

Төслийг хэрэгжүүлэх хуваарь, төсөв

Үйл ажиллагаа	2025	2026	2027	2028	2029	2030	2031	2032	2033	2034	Нийт
(1) Одоо байгаа хоршооны чадавхийг бэхжүүлэх хэрэгцээ шаардлагын судалгаа.											
(2) Төсөлд хамрагдах ХАА-н хоршоог сонгох.											

(3) Төсөлд хамрагдахаар сонгогдсон ХАА-н хоршоонд зориулсан сургалт хийх.												
(4) Мониторинг хийх.												
Төслийн өртөг	сая төгрөг	379	300	300	300	300	300	9	9			1,897
	мян. ам.дол	146	114	114	114	114	114	3	3			722

4.2.11 Орон нутгийн ХАА-н үйлдвэрлэлийг хөгжүүлэх хөтөлбөр

Монголд хөгжлийн түншлэгчдийн дэмжлэгтэйгээр экспортын баримжаатай төрөл бүрийн кластерүүд үүсч байна. Одоогийн байдлаар МҮХАҮТ-д төвлөрсөн гоо сайхны бараа, чацаргана, зөгийн балны кластерүүд үүсч, ЕХ, Япон, Хятадын зах зээлд экспортлох оролдлогууд хийж байна. Цаашид авбал зохих арга хэмжээ гэвэл эдгээр оролдлого нь ганц удаа хийгээд зогсчихоргүй тогтолцоо бүрдүүлэхийн хамт кластерийг дэмжих тогтолцоог өргөжүүлэх шаардлагатай байна. Дээр нь нэмээд орон нутгийн ХАА-н үйлдвэрлэлийг хөгжүүлэх зорилгоор "Нэг тосгон нэг бүтээгдэхүүн" хөдөлгөөнийг өрнүүлэх, АҮП байгуулахыг багтаасан АҮ-ийн түшиц газар байгуулах шаардлагатай.

Оролцогч	Засгийн газар (ЭЗХЯ, ЖДҮГ)	ИДС, судалгааны байгууллага	МҮХАҮТ	ХАА-н үйлдвэрлэлийн ААН, холбоод
Гол бэрхшээл	АҮ-ийн кластерийн хууль гараагүй. Ийм учраас АҮК гэдэг тодорхойлолт ч тогтсон зүйлгүй, кластерт чиглэсэн тусламжийн тогтолцоо ч бүрдээгүй байна.	Зах зээлийн өрсөлдөөн үүсгэх боломжтой технологийн судалгаа хийх ИДС, болон ЭШБ цөөн байна.Бас хувийн ААН-үүдийн хамтарч ажиллах туршлага хязгаарлагдмал	Хөгжлийн түншлэгчдийн дэмжлэгтэйгээр экспортын кластерын сүлжээ үүсгэх тусламжийн бүтэц үүсч байгаа ба бие даасан кластерт үзүүлэх үйлчилгээг илүү төгөлдөржүүлэх шаардлагатай байна.	Технологи хөгжүүлэлт болон дэлхийн зах зээл дээр маркетингээ бэхжүүлэхэд зарцуулах хөрөнгийн ба хүний нөөцийн дутагдалтай байна.
Авах арга хэмжээ	11.1 Аж үйлдвэрийн кластерийг бойжуулахад чиглэсэн дэмжлэгийн тогтолцоо бүрдүүлэх төлөвлөгөө			
		11.2 Зах зээлд өрсөлдөх чадварыг сайжруулахад чиглэсэн үйлдвэрлэл-ЭШБ-ын уялдааг бэхжүүлэх төлөвлөгөө		
			11.3 "Нэг суурин-нэг бүтээгдэхүүн" хөдөлгөөнийг өрнүүлэх төлөвлөгөө	

Зураг 4.13 Бүс нутгийн ХАА-н үйлдвэрлэлийгхөгжүүлэх хөтөлбөр

Эх сурвалж: Жайка төслийн баг

Орон нутагт ХАА-н үйлдвэрлэлийг хөгжүүлэх хөтөлбөр нь хөдөө орон нутгийн ХАА-н бүтээгдэхүүний зах зээлд өрсөлдөх чадварыг бэхжүүлэх орчныг бүрдүүлэх зорилготой хөтөлбөр юм. Доорхи хүснэгт схем 3.3-т төлөвлөгөө ба хөгжлийн чиглэлийн хамаарлыг харууллаа.

Хүснэгт 4.11 ХАА-н чиглэлийн ААН, хоршооны менежментийн бааз суурийг бэхжүүлэх хөтөлбөр ба хөгжлийн чиглэлийн хамаарал

Бодит бэрхшээл, давуу тал, хөгжлийн чиглэлийн агуулга		ХАА-н чиглэлийн ААН, хоршооны менежментийн бааз суурийг бэхжүүлэх хөтөлбөр: 3 төлөвлөгөө		
		11.1	11.2	11.3
Хөгжлийн чиглэл 4	4-1-1 Кластер хөгжүүлэх хууль. эрхзүйн орчин бүрдүүлэх	◎	○	
	4-1-2 Экспортын баримжаатай кластерийг дэмжих тогтолцоо нэвтрүүлэх	◎	○	
	4-1-3 Үйлдвэрлэгч-ЭШБийн уялдааг зохицуулагчийг ажиллуулах	○	◎	
	4-2-1 Орон нутагт ложистикийн түшиг газар байгуулах			○

	4-2-2 1 суурин нэг бүтээгдэхүүн хөдөлгөөн өрнүүлэх	◎

Эх сурвалж: Жайка төслийн баг ○ : Өндөр хамааралтай, ◎ : Хүчтэй хамааралтай

Төлөвлөгөө тус бүрийн ерөнхий агуулгыг доор сийрүүлэв.

“**11.1 Үйлдвэрлэлийн кластер бойжуулах дэмжлэгийн тогтолцоо бүрдүүлэх төлөвлөгөө**“ нь өнөөг хүртэл систем тогтолцооны хувьд тодорхойгүй байгаа үйлдвэрлэлийн кластерийг системчлэхийг зорихын хамт бий болсон кластерийг дэмжих тогтолцоо бүрдүүлэхийг зорино. MONMAP-AVC төслийн хүрээнд боловсруулсан кластерын гарын авлагад үндэслэн, кластер хөгжүүлэхэд төр хувийн хэвшлийн үүргийг тодорхой тусгасан тогтолцоо бүрдүүлэхийг зорихын хамт хувийн хэвшлийн манлайлал бүхий олон улсын зах зээлд хамтарсан маркетинг хийхийг дэмжих тогтолцоо бүрдүүлэх.

“**11.2 Зах зээлд өрсөлдөх чадварыг дээшлүүлэхийн тулд үйлдвэрлэгч- ЭШБ-ын уялдаа холбоог бэхжүүлэх төлөвлөгөө**” нь үндсэндээ ХАА-н салбар чиглэлийн их дээд сургуульд үйлдвэрлэгч-ЭШБ-ийг холбох зохицуулагчийг ажиллуулж, хоёр талыг холбох, уялдааг бэхжүүлэх төлөвлөгөө юм. Их сургуульд бий болсон мэдлэг, арга технологийг үйлдвэрлэлийн салбарт нэвтрүүлэхийг дэмжих зорилготой бөгөөд, энэ үйл ажиллагааг дэмжихэд чиглэсэн систем бүрдүүлэхийг зорино.

“**11.3 Нэг суурин нэг бүтээгдэхүүн хөдөлгөөнийг идэвхжүүлэх төлөвлөгөө**”-гөөр орон нутгийн ХАА-н онцлог бүтээгдэхүүний үйлдвэрлэл, борлуулалтыг идэвхижүүлэхийн тулд “Нэг суурин нэг бүтээгдэхүүн” хөдөлгөөний загварыг дэлгэрүүлэх юм. Мөн хөдөө орон нутгийн ХАА-н бүтээгдэхүүний брендийг баталгаажуулах брендийн зөвлөл байгуулах болон, ХАА-н бүтээгдэхүүн хөгжүүлэлтийг дэмжих бүтцийг бий болгосноор Монгол Улсын хот суурины иргэд болон жуулчдад борлуулах боломжтой бүтээгдэхүүн үйлдвэрлэх тогтолцоо бүрдүүлэх.

(1) Аж үйлдвэрийн кластер хөгжүүлэхэд чиглэсэн урамшууллын тогтолцоо бий болгох төлөвлөгөө

YAT 11-1 : Аж үйлдвэрийн кластер хөгжүүлэхэд чиглэсэн урамшууллын тогтолцоо бий болгох төлөвлөгөө	
Төлөвлөгөөний зорилт	Аж үйлдвэрийн кластер хөгжүүлэх тухайд аж үйлдвэрийн кластерийн тодорхойлолт ба шаардлагыг тодорхойлохын хамт шаардлага хангасан аж үйлдвэрийн кластерийг дэмжих тогтолцоо бүрдүүлэх.
Төлөвлөгөөний зорилго	Аж үйлдвэрийн кластерийг дэмжих тогтолцоо бүрдүүлэх.
Суурь түвшин	Одоогоор аж үйлдвэрийн кластерийг хөгжүүлэх чиглэлийн дэмжлэгийн тогтолцоо байхгүй.
Хамрах хүрээ	Орон даяар
Хүлээх үр дүн	(1) Аж үйлдвэрийн кластерийн тодорхойлолт ба шаардлагыг боловсруулах. (2) Шаардлага хангасан аж үйлдвэрийн кластерийг дэмжих тогтолцоо бүрдэх. (3) Шаардлага хангасан аж үйлдвэрийн кластерийг дэмжих тогтолцоо ажилладаг болох. (4) Бий болсон тогтолцооны үйл ажиллагаанд хяналт тавьж, үр дүнг хэмжин үнэлгээ өгөх.
Үйл ажиллагаа	(1) Аж үйлдвэрийн кластерийн институцийн хурал хийх. ХХААХҮЯ болон ЖДҮГ голлон аж үйлдвэрийн кластер хөгжүүлэх тогтолцоо бүрдүүлэх зорилготой зөвлөлдөх бүтэц байгуулж уг зөвлөлдөх бүтцээр хэлэлцэх.Аж

	үйлдвэрийн кластерийн тогтолцоо бүрдүүлэхтэй холбогдуулан MONMAP-AVC төслөөс МУИС-ын ЭЗС-тай хамтран боловсруулсан кластер хөгжүүлэх удирдамжийн дагуу кластер хөгжүүлэх концепц, Монгол Улсын болон , бусад улсын загвар жишээг авч хэлэлцэх. Энэ удирдамжид үндэслэн аж үйлдвэрийн кластерийн тодорхойлолт, кластрийн хувьд оршин тогтнох шалгуурыг сийрүүлэх. (2) Аж үйлдвэрийн кластерийг дэмжих тогтолцоо бүрдүүлэх. Шаардлага хангасан аж үйлдвэрийн кластерийг дэмжих тогтолцоог сийрүүлэх.Кластер хөгжүүлэлтэд төрийн үүрэг нь кластер хоорондын өрсөлдөөнийг идэвхижүүлэхэд онцгойлон судалж үзүүштэй байна. Өөрөөр хэлбэл, кластерийн ажлыг үнэлэх, сайн жишээг дэмжиж татаас өгөх зэрэг хэлбэртэй байж болно. Кластерт харьяалагддаг ААН-д бага хүүтэй зээлийг тэргүүн ээлжинд олгох зэрэг арга хэлбэр ч байж болохыг судлан үзүүштэй байна. (3) Аж үйлдвэрийн кластерийг дэмжих тогтолцоог хэрэгжүүлэх бүтэц бүрдүүлэх. ЖДҮГ удирдан зохион байгуулах үүрэгтэй байх ба орон нутгийн аж үйлдвэрийг хөгжүүлэх талаар ЭЗ,ХЯ болон арилжааны банк, их сургууль зэрэг ЭШБ-тай зохицуулалт хийх, бусад тогтолцоог хэрэгжүүлэхэд төрийн байгууллагын хувиар хяналтын тогтолцоо бүрдүүлэх шаардлагатай гэж үзэж байна. (4) Аж үйлдвэрийн кластерийг дэмжих тогтолцооны үйл ажиллагаа. Байгуулагдсан тогтолцоонд үндэслэн тэрхүү системийн үйл ажиллагааг эхлүүлнэ.
Санхүүжилт	<u>Засгийн газар</u> • Тогтолцоо байгуулах зорилготой мэргэжилтэн хуваарилах • Системийн үйл ажиллагааны зардал(Кластерт татаас өгөх г.м) • Хурал зөвлөгөөний зардал, замын зардал <u>Хувийн хэвшил</u> • Байхгүй
Төслийн өртөг	Төслийн нийт өртөг: 9 тэрбум 31 сая төгрөг (3,437,000 USD)
Ашиг, үр нөлөө	Аж үйлдвэрийн кластерийг дэмжих тогтолцооны бүтэц буй болохын хамт Монгол Улсын кластерийн хөгжлийн үйл ажиллагаа идэвхижнэ. Тэгснээр Дотоодын зах зээлд өрсөлдөх чадвартэй бүтээгдэхүүн хөгжүүлэлтэд ахиц гарна.
Бодлогын бичиг баримттай уялдсан байдал	Vision 2050 4.2.20. Бүтээлч аж үйлдвэрийн тэргүүлэх салбаруудыг тодорхойлж, брэнджүүлэх, аж үйлдвэрийн кластеруудыг бий болгох.
Төсөл хэрэгжүүлэхэд анхаарах зүйлс	Аж үйлдвэрийн кластер хөгжүүлэх зааварчилгааг ашиглах.

Төслийг хэрэгжүүлэх хуваарь, төсөв

Үйл ажиллагаа		2025	2026	2027	2028	2029	2030	2031	2032	2033	2034	Нийт
(1) Аж үйлдвэрийн кластерийг бүтэцжүүлэх зорилготой хурал хийх.												
(2) Аж үйлдвэрийн кластерийг дэмжих тогтолцоо бүрдүүлэх.												
(3) Аж үйлдвэрийн кластерийг дэмжих тогтолцоог хэрэгжүүлэх бүтэц бүрдүүлэх.												
(4) Аж үйлдвэрийн кластерийг дэмжих тогтолцооны үйл ажиллагаа.												
Төслийн өртөг	сая төгрөг	31	1,000	1,000	1,000	1,000	1,000	1,000	1,000	1,000	1,000	9,031
	мян. ам.дол	17	380	380	380	380	380	380	380	380	380	3,437

Тэмдэглэл: Бусад улс орнуудын кластерийн бодлогын жишээ

(1) Япон улсын жишээ

Японы ХАА, ой, загас агнуурын яам 2014 оноос хойш МАА-н кластер хөгжлийг дэмжих бодлого хэрэгжүүлж байна. МАА-н кластер гэдэг нь тухайн бүс нутгийн МАА эрхлэгчид болон холбогдох аж ахуйн нэгжүүд хамтран ажиллаж, олон нийтийг хамарсан, өндөр үр ашигтай мал аж ахуй эрхлэх тогтолцоог хэлнэ. Бодлогын зорилтод 1) МАА-н гаралтай бүтээгдэхүүн үйлдвэрлэлтэй холбоотой өртгийг бууруулах, 2) Өндөр нэмүү өртөг шингээх, 3) МАА-н үнэ цэнэтэй бүтээгдэхүүн, тэр дундаа экспортыг хэрэглэгчдэд хүргэх зорилгоор шинэ эрэлт бий болгох зэрэг багтана. Тус бодлогын хэрэгжилтийн тогтолцоог доорх диаграммд үзүүлэв. МАА-н кластерийг хөгжүүлэх сан (төсвийн эх үүсвэр нь ХАА, ой, загас агнуурын яамны татаас)-гийн хөрөнгийг олон нийтийн ашиг сонирхлын нэгдсэн холбоо захиран зарцуулах ба бүс нутаг бүрээс сонгогдсон "МАА-н кластерийн зөвлөл"-өөр дамжуулан татаасаар дэмжсэн төслүүдийг хэрэгжүүлдэг. Харин МАА-н кластерийн зөвлөл гэдэг нь бие даасан фермерүүд, хоршоод, орон нутгийн засаг захиргаа, эрүүл ахуйн хяналтын төв, тэжээл үйлдвэрлэгч, тоног төхөөрөмж үйлдвэрлэгч зэрэг аль болох олон талт оролцогчдоос бүрдсэн, тэдгээрийн хамтын ажиллагааг хангах зорилгоор татаасаар хэрэгждэг төсөл юм. Монгол Улсад кластер хөгжүүлэх бодлогын нэг хэлбэр болгон, холбогдох олон талт оролцогчдоос бүрдсэн "зөвлөл"-д дэмжлэг үзүүлэх нь хувийн хэвшил хоорондын хамтын ажиллагаа, харилцан дэмжлэг, харилцаа холбоог бэхжүүлэх талаасаа ач холбогдолтой санаачилга болно.

Зураг: МАА-н кластерийн бодлогыг хэрэгжүүлэх тогтолцоо

(2) ХБНГУ-ын жишээ

ХБНГУ-д холбооны засгийн газар олон улсад өрсөлдөх чадвар бүхий хамгийн орчин үеийн кластеруудыг бий болгохын зэрэгцээ, муж улсын засгийн газар бүр орон нутгийн бизнес, ялангуяа жижиг, дунд үйлдвэрийн хөгжлийг дэмжих зорилгоор, муж өөрөө бие даан кластерийн бодлого хэрэгжүүлж байна. Холбооны засгийн газрын кластерын бодлого нь улсын бодлогын чиглэлд нийцсэн, олон улсын хэмжээнд өрсөлдөх чадварыг бий болгох чадвартай кластеруудыг өрсөлдөөний хэлбэрээр сонгон шалгаруулж, эдгээр кластеруудад эрчимтэй дэмжлэг үзүүлэх аргачлалыг хэрэгжүүлдэг. Нөгөөтэйгүүр, муж улсын засгийн газрын түвшинд кластерын бодлого нь бүс нутгийн онцлогийг харуулсан үйлдвэрүүдийг дэмжих, хөгжүүлэх зорилготой ба муж улсын засгийн газар бүс нутгийн өсөлттэй салбарыг стратегийн хувьд дэмжих бодлого баримталдаг. Түүнчлэн, муж улсын засгийн газрын кластерийн бодлогод Төрийн оролцоо байхгүй, "үйлдвэрлэл, ЭШ-ний байгууллагын хамтын ажиллагаа"-г чухалчилдаг. Кластерийн менежментийг тухайн үйлдвэрлэлийн салбартаа холбогдох мэргэжлийн өндөр түвшний мэдлэгтэй, танилын хүрээ өргөн "кластерийн төлөөлөгч" удирдан зохион байгуулдах тохиолдол ч мөн ажиглагддаг. Энэ нь Монгол Улсын кластерийн бодлогыг боловсруулахад төрийн гүйцэтгэх үүргийг харуулсан жишээ гэж хэлж болно.

*Дотацийг зөвхөн үйл ажиллагаа, менежментэд ашиглана. Судалгаа, хөгжүүлэлтийн төсөл зэрэгт ашиглах боломжгүй.

Зураг: ХБНГУ-ын засгийн газрын кластер хөгжүүлэх тогтолцооны жишээ

(2) Зах зээлд өрсөлдөх чадварыг дээшлүүлэхийн тулд аж үйлдвэр-ЭШБ-ын уялдааг бэхжүүлэх төлөвлөгөө

YAT 11-2: Зах зээлд өрсөлдөх чадварыг дээшлүүлэхийн тулд аж үйлдвэр-ЭШБ-ын уялдааг бэхжүүлэх төлөвлөгөө		
Төлөвлөгөөний зорилт	Дотоодын зах зээлд өрсөлдөх чадвартай бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг дэмжихийн тулд үйлдвэрлэл-ЭШБ-ийн уялдаатай тогтолцоог бэхжүүлэх.	
Төлөвлөгөөний зорилго	ХАА-н чиглэлийн ИС, ЭШБ-д үйлдвэрлэгч-ЭШБ-г уялдуулах зохицуулагчийг томилон ажиллуулах зорилготой систем бүрдүүлэх.	
Суурь түвшин	Одоогоор ХАА-н чиглэлийн ИС, ЭШБ-уудад үйлдвэрлэгч-ЭШБ-г уялдуулах зохицуулагчийг томилон ажиллуулах систем байхгүй	
Хамрах хүрээ	Орон даяар	
Хүлээх үр дүн	(1) Үйлдвэрлэгч-ЭШБ-г уялдуулах зохицуулагчийг томилон ажиллуулах систем бүрдүүлэх. (2) Үйлдвэрлэгч-ЭШБ-г уялдуулах зохицуулагч тухайн системийн үйл ажиллагааг эхлүүлэх. (3) Бий болсон системийн үйл ажиллагаанд хяналт хийж, түүний үр дүнг хэмжин үнэлэх.	
Үйл ажиллагаа	(1) Үйлдвэрлэгч-ЭШБ-г уялдуулах зохицуулагчийг томилох систем бүрдүүлэх хурал хийх. ХХААХҮЯ удирдан үйлдвэрлэл-ЭШБ-г уялдуулах зохицуулагчийг томилох систем бүрдүүлэх зорилготой хурал/зөвлөл/-ийн бүтэц байгуулж, уг хурлаар хэлэлцүүлэг хийх. Ялангуяа зохицуулагчид тавигдах шаардлага болон зохицуулагчийн гүйцэтгэх үүрэг ба үр дүнг тодорхой зааж өгөх. Үйлдвэрлэл-ЭШБ-г уялдуулах зохицуулагчийн харьяалагдах байгууллага нь үндсэндээ ИДС-ууд болон судалгааны байгууллага байх, нөхцөл байдлаас хамаарч үндсэн ажилтан хавсран гүйцэтгэх хэлбэрээр ажиллах боломжийг судлах. (2) Үйлдвэрлэгч-ЭШБ-г уялдуулах зохицуулагчийг томилон ажиллуулах систем байгуулах. Дээрх хэлэлцүүлэг болон шийдвэр гаргах журмын дагуу систем бүрдүүлнэ. Ингэхдээ, бусад яамдтай зохицох шаардлагатай бол ХХААХҮЯ удирдан системийг бүрдүүлэх журмыг боловсруулна. (3) Үйлдвэрлэл-ЭШБ-г уялдуулах зохицуулагчийн ажлын албыг байгуулах. Үйлдвэр-ЭШБ-г уялдуулах зохицуулагчийн ажлын албаны бүтцийг буй болгоно. ХХААХҮЯ нэгдсэн удирдлагаар хангах бөгөөд, их сургууль, ЭШБ-ын зохицуулалт хийх, бусад тогтолцоо хэрэгжүүлэх үед ТАХ-чийн хувиар хяналтын тогтолцоо бүрдүүлэх шаардлагатай гэж үзэж байна. (4) Аж үйлдвэрийн кластерийг дэмжих тогтолцооны үйл ажиллагааг хэрэгжүүлнэ. Бүрэлдсэн системд тулгуурлан тогтолцооны үйл ажиллагааг эхлүүлнэ.	
Санхүүжилт	<u>Засгийн газар</u> • Тогтолцоо байгуулах зорилготой мэргэжилтэн хуваарилах • Системийн үйл ажиллагааны зардал (Кластерт татаас өгөх г.м) • Хурал цуглааннд оролцох, замын зардал	<u>Хувийн хэвшил</u> • Байхгүй
Төслийн өртөг	Төслийн нийт өртөг: 1 тэрбум 906 сая төгрөг (725,000 USD)	
Ашиг, үр нөлөө	Үйлдвэр-ЭШБ-ын зохицуулагчийн бүтэц бий болохын хамт Монголын дотоодын кластер хөгжүүлэлтийн үйл ажиллагаа идэвхижинэ. Ингэснээр дотоодын зах зээлд өрсөлдөх чадвартай бүтээгдэхүүн хөгжүүлэлт эрчимжинэ.	
Бодлогын бичиг баримттай уялдсан байдал	Алсын хараа 2050 4.2.20. Бүтээлч аж үйлдвэрийн тэргүүлэх салбаруудыг тодорхойлж, брэнджүүлэх, аж үйлдвэрийн кластеруудыг байгуулна.	

Төслийг хэрэгжүүлэх хуваарь, төсөв

Үйл ажиллагаа		2025	2026	2027	2028	2029	2030	2031	2032	2033	2034	Нийт
(1) Аж үйлдвэрийн кластерийг бүтэцжүүлэх зорилготой хурал хийх.												
(2) Аж үйлдвэрийн кластерийг дэмжих тогтолцоо бүрдүүлэх.												
(3) Аж үйлдвэрийн кластерийг дэмжих тогтолцоог хэрэгжүүлэх бүтэц бүрдүүлэх.												
(4) Аж үйлдвэрийн кластерийг дэмжих тогтолцооны үйл ажиллагаа.												
Төслийн өртөг,	сая төг.	31	375	375	375	375	375					1,906
	мян.ам.дол	15	142	142	142	142	142					725

(3) Нэг суурин нэг бүтээгдэхүүн хөдөлгөөнийг дэмжих төлөвлөгөө

YAT 11-3 : Нэг суурин нэг бүтээгдэхүүн хөдөлгөөнийг дэмжих төлөвлөгөө	
Төлөвлөгөөний зорилт	Нутаг бүрийн нөөц баялгийг үр дүнтэй ашиглах, газар зүйн давуу болон сул талд тулгуурлан Нэг суурин нэг бүтээгдэхүүн хөдөлгөөн өрнүүлж, орон нутгийн ХАА-н үйлдвэрлэлийг идэвхижүүлэхэд түлхэц өгөх.
Төлөвлөгөөний зорилго	Нэг суурин нэг бүтээгдэхүүн хөдөлгөөн өрнүүлж шил ажиллагаа эхэлсэн орон нутгийн тоог 22 болгох.
Суурь түвшин	Одоогоор Нэг суурин нэг бүтээгдэхүүн хөдөлгөөн өрнүүлэх болон , сурталчлах, уг үйл ажиллагааг дэмжих тогтолцоо байхгүй.
Хамрах хүрээ	Орон даяар
Хүлээх үр дүн	(1) Нэг суурин нэг бүтээгдэхүүн хөдөлгөөн өрнүүлэх,сурталчлах хүний нөөцийг сурган бэлтгэх. (2) Аймаг сумдад Нэг суурин нэг бүтээгдэхүүн хөдөлгөөн өрнүүлэх болон,сурталчлах үйл ажиллагааг хэрэгжүүлэх. (3) Аймгуудад өөрийн нутгийн брендийг баталгаажуулах зөвлөл байгуулах. (4) Аймгуудад бүтэгдэхүүн үйлдвэрлэх болон маркетингийг дэмжих бүтцийг бий болгох.
Үйл ажиллагаа	(1) Нэг суурин нэг бүтээгдэхүүн хөдөлгөөн өрнүүлэх болон,сурталчлах хүнийн нөөцийг сургаж бэлтгэх. Аймгуудын ХААГ болон ЗДТГ-ын эдийн засгийн хөгжлийн асуудал хариуцсан ажилтныг Япон болон бусад улсын “Нэг суурин нэг бүтээгдэхүүн” хөдөлгөөнийг хэрэгжүүлж буй загвартай танилцуулах сургалтад хамруулах. Түүнчлэн ойр, хөрш орнуудын (Киргиз, Казакстан) “Нэг суурин нэг бүтээгдэхүүн” хөдөлгөөний үйл ажиллагаатай танилцах сургалт хийх. (2) Аймаг сумдад “Нэг суурин нэг бүтээгдэхүүн” хөдөлгөөн өрнүүлэх болон, сурталчлах ажлыг зохион байгуулах Аймаг сумдын ХААГ болон ЗДТГ-ын эдийн засгийн хөгжлийн асуудал хариуцсан ажилтан голлон, тухайн орон нутагт байгаа давуу талтай ХАА-н бүтээгдэхүүн болон нөөц баялгийг тодорхойлох. Төр хувийн хэвшлийн холбогдох хүмүүс цуглан өрсөлдөх чадвар бүхий орон нутгийн брендийг бойжуулах үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулах. (3) Аймгуудад нутгийн брендийн баталгаажуулах зөвлөл байгуулах. Аймаг бүрт брендийн баталгаажуулах зөвлөл байгуулах. Зөвлөлийн гишүүдэд ИДС-ийн төлөөлөл, орон нутгийн том ААН-ийн төлөөлөл, бүтээгдэхүүний чанарыг шалгах чадвартай, сурталчлах нөлөөлөл бүхий хүмүүсийг оролцуулах нь зүйтэй. ХААГ болон ЗДТГ-ын эдийн засгийн хөгжлийн асуудал хариуцсан ажилтанууд тус зөвлөлийг жилд нэг удаа цуглуулж уулзалт хэлэлцүүлэг зохион байгуулах.

	(4) Бүтээгдэхүүн үйлдвэрлэх болон маркетингийн туслах бүтцийг бий болгох. "Нэг суурин нэг бүтээгдэхүүн" хөдөлгөөний хүрээнд үйлдвэрлэгдсэн ХАА-н бүтээгдэхүүний өрсөлдөх чадварыг барьцаалах зорилгоор бүтээгдэхүүн үйлдвэрлэл болон маркетингийн туслах бүтцийг тусад нь бий болгох. Орон даяар салбар нэгжүүд бүхий МҮХАҮТ тохирох байгууллага болно гэж үзэж байгаа ба орон нутгийн үйлдвэрлэлийг бойжуулах сонирхолтой хувийн ААН-тэй хамтран ажиллах шаардлагатай гэж үзэж байна. Бүтээгдэхүүн үйлдвэрлэхээс маркетинг хүртэлх нийлүүлэлтийн цогц сүлжээг бий болгож чадах байгууллага болохыг зорьж, төрөөс түүнийг дэмжих тогтолцоо бүрдүүлэх.	
Санхүүжилт	<u>Засгийн газар</u> • "Нэг суурин нэг бүтээгдэхүүн" хөдөлгөөн өрнүүлэх болон, сурталчлах сургалтын зардал • Брендийг баталгаажуулах зөвлөлийн үйл ажиллагааны зардал	<u>Хувийн хэвшил</u> • Байхгүй
Төслийн өртөг	Төслийн нийт өртөг: 1 тэрбум 90 сая төгрөг (414,000 USD)	
Ашиг, үр нөлөө	Аймгуудын онцлог бүхий, зах зээлд эрэлт өндөртэй бүтээгдэхүүний үйлдвэрлэл, борлуулалтад түлхэц өгч, орон нутгийн ХАА-н үйлдвэрлэл идэвхижинэ.	
Бодлогын бичиг баримттай уялдсан байдал	Алсын хараа 2050 4.2.20. Бүтээлч аж үйлдвэрийн тэргүүлэх салбаруудыг тодорхойлж, брэнджүүлэх, аж үйлдвэрийн кластеруудыг бий болгох.	

Төслийг хэрэгжүүлэх хуваарь, төсөв

Үйл ажиллагаа		2025	2026	2027	2028	2029	2030	2031	2032	2033	2034	Нийт
(1) Нэг суурин нэг бүтээгдэхүүн хөдөлгөөн өрнүүлэх, сурталчлах хүний нөөцийг сурган бэлтгэх.												
(2) Аймаг сумдад "Нэг суурин нэг бүтээгдэхүүн" хөдөлгөөн өрнүүлэх, сурталчлах												
(3) Аймаг бүрт өөрийн нутгийн брендийг баталгаажуулах зөвлөл байгуулах.												
(4) Бүтээгдэхүүн үйлдвэрлэх болон маркетингэд туслах бүтцийг бий болгох.												
Төслийн өртөг	сая төгрөг	200	282	83	75	75	75	75	75	75	75	1,090
	мян.ам.дол	80	107	31	28	28	28	28	28	28	28	414

Тэмдэглэл: БНКиргиз улсын "Нэг суурин нэг бүтээгдэхүүн" төслийн жишээ

ЖАЙКА-гаас БНКиргиз улсад "Нэг суурин-Нэг бүтээгдэхүүн (OVOP)" төсөлтэй холбоотой хэрэгжүүлж байгаа үйл ажиллагаа нь Киргиз улсын орон нутгийн үйлдвэрлэлийг эрчимжүүлэхэд ихээхэн хувь нэмэр оруулж байна. ЖАЙКА-гийн энэхүү санаачилга нь орон нутгийн үйлдвэрлэгчид болон хилийн чанад дахь хэрэглэгчдийг холбох үүрэг бүхий олон нийтийн байгууллагаар (нэр нь: OVOP+1) дамжуулан бүтээгдэхүүн хөгжүүлэлтээс эхлээд үйлдвэрлэлийн технологийг хөгжүүлэх, бүтээгдэхүүн борлуулдаг дэлгүүрүүд ажиллуулах, түгээх сүлжээг зохицуулах зэрэг үүргийг гүйцэтгэдэг. Одоогийн байдлаар OVOP дэлгүүрүүдийн бараа бүтээгдэхүүний тоо 2000 давж, борлуулалт нэмэгдэхийн зэрэгцээ дотоодын үйлдвэрлэгчдийг (ялангуяа эмэгтэйчүүд, залуучуудыг) ажлын байраар хангаж, орлоготой болгох боломжтой болсон.

Монголд "Нэг суурин-нэг бүтээгдэхүүн" хөдөлгөөний үзэл баримтлалыг ойлгодог төрийн албан хаагчид, хувийн хэвшлийн бизнес эрхлэгчид цөөнгүй байгаа ч санаачилгыг өөрсдөө нэвтрүүлэх тал дээр тийм ч идэвхтэй биш байна. Тиймээс Киргизийн "Нэг суурин-нэг бүтээгдэхүүн" төслөөс жишээ авч, ирээдүйд Монгол Улсад орон нутгийн үйлдвэрлэлийг идэвхижүүлэхэд тус дөхөм болох санаачилгуудыг танилцуулах юм. Нэгдүгээрт, үйлдвэрлэгч болон хэрэглэгчдийг холбох байгууллага байгуулах ба Киргиз улсын хувьд олон нийтийн байгууллага (OVOP+1) тус үүргийг гүйцэтгэдэг.

Монгол Улсын хувьд аймаг бүрт салбартай МҮХАҮТ дээрх үүргийг гүйцэтгэж болох ч гол анхаарах зүйл нь: 1) Зах зээлийн эрэлт хэрэгцээнд нийцсэн бүтээгдэхүүн боловсруулах чадвартай байх, 2) Өөрөө борлуулалтын суваг бий болгох маркетинг хийх чадвартай байх шаардлагатай ба дээрх 2 чадварыг 2-ууланг нь хослуулсан байвал хувийн хэвшил ч, ТББ ч нэр дэвших боломжтой. Хоёрдахь зүйл бол орон нутаг бүрт (тухайлбал аймгууд) "Брэндийн зөвлөл"-г байгуулах ажлыг хэрэгжүүлэх. Орон нутаг болгонд байгуулагдсан "Брэндийн зөвлөл" нь тухайн нутаг дэвсгэрт үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийг баталгаажуулах бөгөөд зөвхөн шалгалтад тэнцсэн бүтээгдэхүүн нь тухайн бүс нутгийн брэнд бүтээгдэхүүн болж баталгаажиж, брэндийн лого хэрэглэх эрх авдаг тогтолцоотой байна.

"Брэндийн зөвлөл"-ны гишүүдийг орон нутгийн төрийн албан хаагчид, хувийн хэвшлийн аж ахуйн нэгжийн төлөөлөл, их дээд сургуулийн багш нар зэрэг хүмүүсээс сонгон шалгаруулах ба нарийн шалгуураар сонгоно. Ингэхдээ баталгаажсан бүтээгдэхүүнийг хэрэглэгчдэд сурталчлах "Дэмжигч"-ийн үүргийг мөн гүйцэтгэж чадах эсэхийг анхаарч сонгон шалгаруулдаг байна. Түүнчлэн "Брэндийн зөвлөл"-ийн баталгаажуулсан бүс орон нутгийн брэнд бүтээгдэхүүнийг OVOP+1 (OVOP дэлгүүр, бэлэг дурсгалын дэлгүүр, супермаркет гэх мэт) арилжааны сувгуудад байршуулан борлуулах давуу эрх олгогддог тул бүтээгдэхүүн үйлдвэрлэгч нь орон нутгийн брэндийн баталгаажуулалт авснаар өндөр үнэ цэн бий болох, бүтээгдэхүүний шалгалтад тэнцэхийн тулд сайжруулалт хийхээр хүчин чармайлт гаргадаг байна (Зүүн талын зураг).

MONMAP-AVC төслийн хүрээнд Киргизийн "Нэг суурин нэг бүтээгдэхүүн" төсөлтэй газар дээр нь очиж танилцах сургалтыг зохион байгуулсан ба оролцсон төрийн албан хаагчид болон хувийн хэвшлийнхэн тус төслийн үйл ажиллагааны талаар сайн ойлголттой болсон. Эдгээр албан хаагчид болон хувийн хэвшлийнхнийг Монгол Улсад "Нэг суурин нэг бүтээгдэхүүн" хөдөлгөөнийг өрнүүлэхэд татан оролцуулах нь зүйтэй юм.

5.-Р БҮЛЭГ. Хөгжлийн хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх тогтолцоо

5.1 Мастер төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд холбогдох байгууллагууд

ХАА-н салбарын нэмүү өртгийн сүлжээг хөгжүүлэх Мастер төлөвлөгөөний хүрээнд ХХААХҮЯ голлон холбогдох яам агентлагууд, орон нутгийн захиргааны байгууллагууд болон хөгжлийн донорууудтай хамтран зохицуулалтыг хийж Мастер төлөвлөгөөнд тусгагдсан төслүүдийг хэрэгжүүлнэ. Холбогдох гол яам агентлагуудын хөгжлийн бодлогын чиглэлийн асуудлыг ЭЗХЯ, төсвийн зохицуулалтын асуудлыг СЯ, хандивлагч байгууллагуудын зохицуулалтыг ГХЯ, мөн БОАЖЯ зэрэг байгууллагууд хариуцан хамаарна. Засгийн газрын хэрэгжүүлэх чиг үүргийн байгууллагуудад ЖДҮГ, СХЗГ, ХАБҮЛ, МЭЕГ, УМЭАЦТЛ, МЭЭСБУЛ, ХААДС, ХААХҮСХТ, БОАЖЯ, ХААИС, ШУА, МҮХАҮТ зэргийг дурьдаж болно. Үүний зэрэгцээ, төсөл хөтөлбөрүүдийн хяналт шалгалтыг хариуцсан төрийн байгууллага болох МХЕГ нь 2022 оны сүүлээр татан буугдаж, хяналт шалгалтын чиглэлийн дагуу холбогдох яамд болон харьяа байгууллагуудад чиг үүрэг нь шилжсэн. 2023 оноос малын эмчийн хяналт, хүнсний чанар стандартын хяналт, ургамал хамгаалал, үр тарианы үрийн хяналт, мал эмнэлгийн хяналтыг ХХААХҮЯ хариуцаж, хүнсний эрүүл ахуйн хяналтыг ЭМЯ хариуцах болсон. Мастер төлөвлөгөө, ҮАТ-ний гол хэрэгжүүлэгч байгууллага болох ХХААХҮЯ, Бодлого төлөвлөлтийн газар төсөл хөтөлбөрийн ерөнхий удирдлага зохицуулалтыг хариуцан, ГТБХЗГ, МААБХЗГ, ХөҮБХЗГ, ХүҮБХЗГ нь тус тусын салбар чиглэлийн төслүүдийг удирдан чиглүүлнэ.



Зураг 5.1 Мастер төлөвлөгөөг хэрэгжүүлэх ХХААХҮЯ-ны бүтэц

Эх сурвалж: ЖАЙКА төслийн баг.

5.2 Хөгжлийн хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх механизм

5.2.1 Хөгжлийн хөтөлбөрүүдийг хариуцах бүтэц нэгжүүд

ХАА-н салбарын нэмүү өртгийн сүлжээг хөгжүүлэхтэй холбоотой тулгардаг асуудлууд ихээхэн өргөн хүрээг хамардаг. Тодорхой нэг нэр төрлийн бүтээгдэхүүн тус бүрийн үйлдвэрлэх, боловсруулах, нийлүүлэх, борлуулах, экспортлох зэрэг цогц асуудлуудыг өртгийн сүлжээний үе шат бүрт үйл ажиллагаа явуулдаг байгууллага нэгжүүд хариуцан шийдвэрлэж байдаг бөгөөд Монгол Улсад ч мөн адил байна. Тухайлбал, хүнсний ногооны үйлдвэрлэлтэй холбоотой асуудлыг Газар тариалангийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар хариуцдаг бол хүнсний ногооны түгээлт нийлүүлэлт, борлуулалт, хүнсний аюулгүй байдлыг хангах зэрэг асуудлыг Хүнсний үйлдвэрлэлийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар хариуцдаг. Нөгөөтэйгүүр ХАА-н салбарын бодлого боловсруулах, төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг газар хэлтэс тус бүрээр боловсруулдаг нь тодорхой нэр төрлийн бүтээгдэхүүний өртгийн сүлжээг хөгжүүлэхтэй холбоотой асуудлыг хөндлөн тогтолцоогоор авч үзэж, зохих арга хэмжээ авахад хүндрэлтэй байдаг. Иймээс газар тариалан, мал аж ахуй, хөнгөн үйлдвэр, хүнсний аюулгүй байдал, аж үйлдвэрийн хөгжил, хоршооны хөгжил зэрэг бүх салбарын хариуцсан мэргэжилтнүүд бүхий Бодлого төлөвлөлтийн газар нь салбар хоорондын бодлогын уялдаа холбоо, тэргүүлэх чиглэлийг тодорхойлоход оролцдог. Энэхүү Мастер төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд удирдлага хяналтыг хялбарчлах үүднээс одоо хэрэгжиж буй бодлого төлөвлөлтийн процессийг хэвээр хадгалан, хэрэгжилтийг хангахаар тусгасан. Тодруулбал:

- Хөгжлийн хөтөлбөрүүдийг Газар тариалангийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар, Мал аж ахуйн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар, Хөнгөн үйлдвэрийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар, Хүнсний үйлдвэрлэлийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар гэсэн алба нэгжүүдийн аль нэг нь хариуцна.
- Хөгжлийн хөтөлбөрүүдийг түүнийг бүрдүүлж буй Үйл ажиллагааны төлөвлөгөөний агуулгад (бүтээгдэхүүний нэр төрөл, онцлог шинж чанар) нийцүүлэн хамгийн хамаарал өндөртэй газар нэгж хариуцна.
- Хөгжлийн хөтөлбөр тус бүрийн бодлого төлөвлөлтөд салбар дамнасан болон яам агентлаг хоорондын арга хэмжээ шаардлагатай үед Бодлого төлөвлөлтийн газар эдгээрийг зохицуулах эсвэл арга хэмжээний хэрэгцээ шаардлагыг тодорхойлоход гол үүрэг гүйцэтгэнэ.

Дээрхээс гадна Бодлого төлөвлөлтийн газраас нэгтгэн боловсруулсан бодлоготой уялдуулан төсвийн удирдлагыг Санхүү, хөрөнгө оруулалтын газар хариуцан, Хяналт шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар нь Хөгжлийн хөтөлбөрүүдийн хэрэгжилтэд хяналт мониторинг хийж, хөгжлийн шалгуурт тулгуурлан бодлогын үнэлгээ хийх тогтолцоотой байна. Хэдий бодлого төлөвлөлт, төсөвлөлтийг ХХААХҮЯ хариуцах боловч, бодлогын хэрэгжилт яамны харьяа орон нутаг дахь салбар нэгжүүдэд тулгуурлан явагдана.



Зураг 5.2 Хөгжлийн хөтөлбөрүүдийн хариуцах бүтэц, удирдлагын тогтолцоо

Эх сурвалж: ЖАЙКА төслийн баг

5.2.2 Хөгжлийн хөтөлбөрүүд / ҮАТ-ний төсөв боловсруулах

(1) Төсөв боловсруулах хуваарь

2023 оны 7 дугаар сард шинэчлэн засварласан Төсвийн тухай хуульд[108] заасан дунд хугацааны стратегийн баримт бичиг, жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөний баримт бичгүүд, дагалдах төсвийн төлөвлөгөөг батлах процессийг Зураг 5.3-т харуулав. Тус Мастер төлөвлөгөөтэй холбогдох дунд хугацааны төлөвлөгөө нь “Таван жилийн хөгжлийн үндсэн чиглэл (2025-2029)”-д хамаарах бөгөөд 2024 оны 4-р сарын 15-ны дотор төсвийн төлөвлөгөөг боловсруулна. Дунд хугацааны стратегийн баримт бичгийг баталсны дараа ирэх оны жилийн төсвийн төлөвлөгөөг боловсруулж эхлэх бөгөөд 11-р сард болох их хурлын намрын чуулганаар хэлэлцүүлэн батлуулна.

Зураг 5.3 Төсвийн төлөвлөгөө батлах процесс

Эх сурвалж:МУ-ын төсвийн тухай хуульд үндэслэн ЖАЙКА төслийн баг боловсруулав

[108] https://legalinfo.mn/mn/detail/12254

(2) Төсвийн төлөвлөгөө боловсруулах

Төсвийн төлөвлөлтийг хөгжлийн хөтөлбөрүүдийн хамаарах газар хэлтэс хариуцна. Энэхүү Мастер төлөвлөгөөний хүрээнд эмхэтгэсэн ҮАТ-нүүдэд Хөгжлийн бодлого төлөвлөлтийн хуульд заасан мэдээллийг (төслийн төсвийг оруулаад) тусгасан байгаа бөгөөд нарийвчилсан төсөв боловсруулахад Бодлого төлөвлөлтийн газар, бусад холбогдох яам агентлагууд болон холбогдох салбаруудын хувийн хэвшил, ААН байгууллагын саналыг тусгасны үндсэн дээр хэрэгжүүлэх шаардлагатай. Зарим ҮАТ нь хувийн хэвшил гол хэрэгжүүлэгч субьект болж, төр хажуугаас нь дэмжлэг үзүүлж ажиллах зүйлс ч бий. Зорилтот бүтээгдэхүүнтэй холбоотой нийлүүлэлтийн сүлжээний оролцогч хувийн хэвшлийн үйл ажиллагааг идэвхжүүлэн дэмжихийн тулд холбогдох салбарын олон нийтийн байгууллага, компаниуд, малчид тариаланчдын холбоо, ААНБ, бизнес эрхлэгчдийн үйл ажиллагаанд төрийн оролцооны түвшинг тус бүрт нь судлан тодорхойлох нь чухал юм. Мөн төсвийн эх үүсвэр хангалттай биш байж болзошгүй байдлыг харгалзан төсвийн төлөвлөгөөг илүү нарийвчлалтай боловсруулах зайлшгүй шаардлагатай.

Тус Мастер төлөвлөгөөг боловсруулах явцад Хөгжлийн хөтөлбөрүүдийн хариуцах газар нэгж болон Бодлого төлөвлөлтийн газрын мэргэжилтнүүдийг хамарсан зөвлөлдөх семинар зохион байгуулж, шаталсан шийдвэр гаргах аргачлалаар[109] хариуцсан газар хэлтэст хамаарах ҮАТ-нүүдийг үнэлэн эрэмбэлсэн (Хүснэгт 5.1). Үр дүнгээс харахад, Мастер төлөвлөгөөг боловсруулах явцад нэн тэргүүнд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг газар хэлтэс тус бүрээр эхний 3 төсөл, нийт 12 төслийг сонгосон бөгөөд эдгээр нь бодлогын асуудал хариуцсан мэргэжилтнүүдийн байр сууринаас харж сонгосон ҮАТ гэдгийг тэмдэглэх нь зүйтэй. Үүнийг харгалзан төсөв боловсруулахдаа дээд шатны төлөвлөгөө, хувийн хэвшил ААН байгууллагуудын хүсэл сонирхолтой нийцэж байгаа эсэхийг харгалзан Бодлого төлөвлөлтийн газар хэрэгжүүлэх арга хэмжээг сонгох, хэрэгцээ шаардлагын зохицуулалтыг хийх шаардлагатай.

Хүснэгт 5.1 Үйл ажиллагааны төлөвлөгөөг эрэмбэлсэн жагсаалт

Хөгжлийн хөтөлбөр	Үйл ажиллагааны төлөвлөгөө	Эрэмбэ	Нэн тэргүүнд хэрэгжүүлэх ҮАТ
Газар тариалангийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар			
•1. Хүнсний ногооны нийлүүлэлтийн сүлжээг бэхжүүлэх хөтөлбөр	1-1. Чанартай үр, түргэтгэсэн тариалалтын аргыг нэвтрүүлэх замаар хүнсний ногооны нийлүүлэлтийн хугацааг уртасгах	2.593	✓
	1-2. Тариаланчдад /ногоочдод / зах зээлд чиглэсэн фермерийн менежментийг эзэмшүүлэх	2.221	
	1-3. ГТ-ын хоршоодоор дамжуулж ГТБ-ний нийлүүлэлтийн тогтолцоог бүрдүүлэх	2.395	✓
	1-4. Хүнсний ногоо боловсхуулах энгийн арга болон хэрэглээний чиглэлийн сургалт, сурталчилгаа хийх	2.127	
•2. Жимсний модны нийлүүлэлтийн сүлжээг бэхжүүлэх хөтөлбөр	2-1. Жимсний модны суулгацын төвийг түшиглэсэн нийлүүлэлтийн сүлжээг бэхжүүлэх	2.266	
	2-2. Тариалалтын зохистой технологийг түгээн дэлгэрүүлэх	2.366	
	2-3. Чацарганы экспортыг дэмжих	2.524	✓
•3. Тосны ургамлын нийлүүлэлтийн	3-1. Рапсын үрийн дотоодын үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх	2.264	

[109] Хүний гаргадаг цогц шийдвэр, үнэлгээний механизмыг шаталсан бүтэцтэй болгон задалж шийдвэр гаргадаг үйл явц. Тодорхой бус нөхцөл байдал, үнэлгээний шалгуур ялгаатай байх нөхцөлд шийдвэр гаргах аргуудын нэг.

Хөгжлийн хөтөлбөр	Үйл ажиллагааны төлөвлөгөө	Эрэмбэ	Нэн тэргүүнд хэрэгжүүлэх ҮАТ
сүлжээг бэхжүүлэх хөтөлбөр	3-2. Рапс тариалах технологийг хөгжүүлэх, үйлдвэрлэлийг дэмжих	2.329	
	3-3. Рапсын худалдааны нөхцлийг сайжруулах	2.077	
	3-4. Рапсын тосны хэрэглээг өргөжүүлэхэд чиглэсэн сурталчилгаа	2.025	
•7. Газар тариалангийн бусад бүтээгдэхүүний нийлүүлэлтийн сүлжээг бэхжүүлэх хөтөлбөр	7-1. Мөөг тарих технологийн сургалт, түгээн дэлгэрүүлэлтийг эрчимжүүлэх	2.312	
	7-2. Мөөгний үндэсний стандарттай болох	2.132	
	7-3. Мөөгний хэрэглээг өргөжүүлэхэд чиглэсэн сурталчилгаа	2.188	
	7-4. Загасны хэрэглээг дэлгэрүүлэх зорилготой загас боловсруулах үйлдвэр байгуулах төлөвлөгөө	2.065	
Мал аж ахуйн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар			
• 4.Мах, сүүний нийлүүлэлтийн сүлжээг бэхжүүлэх	4-1. Малын үүлдэр угсааг сайжруулах тогтолцоо бүрдүүлэх	3.000	✓
	4-2. Өсвөр мал (хурга) бордох бизнесийг нэвтрүүлж дэмжих	2.661	✓
	4-3. Зах зээлийн эрэлт хэрэгцээнд нийцсэн махны шинэ зэрэглэл нэвтрүүлэх, нэмүү өртөг шингээхийг дэмжих	1.577	
	4-4. Мал төхөөрөх үйлдвэр байгуулах	2.068	✓
	4-5. МАА-н болон дайвар бүтээгдэхүүнээр гэрийн тэжээвэр амьтны хоол үйлдвэрлэл бий болгох	1.277	
	4-6. Сүү цуглуулах тогтолцоог бэхжүүлж,үйлдвэр цехэд сүү хүлээн авах хэмжээг нэмэгдүүлэх	1.039	
Хөнгөн үйлдвэрийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар			
•5. Ноос арьс ширний нийлүүлэлтийн сүлжээг бэхжүүлэх	5-2. Малчдын хоршоог түшиглэсэн ноос, арьс шир бэлтгэн нийлүүлэлтийн сүлжээг бэхжүүлэх	2.433	✓
	5-3. Нэхмэл сүлжмэл, арьс ширэн эдлэлийн тогтвортой үйлдвэрлэлийн тогтолцоо бүрдүүлэх төлөвлөгөө	2.303	
	5-4. Нэхэх салбарт АҮ кластер хөгжүүлэх төлөвлөгөө	2.433	✓
•10. ХАА-н чиглэлийн ААН, хоршооны менежментийн чадавхийг бэхжүүлэх хөтөлбөр	10-1. Нэмүү өртгийн сүлжээний зээлийн тогтолцоог нэвтрүүлэх бэлтгэл судалгаа хийх	2.275	
	10-2. Агуулахын үнэт цаасны тогтолцоо нэвтрүүлэх бэлтгэл судалгаа хийх	2.065	
	10-3. ЖДҮ-ийн менежментийн бааз суурийг бэхжүүлэх	2.325	
	10-4. ХАА-н хоршооны менежментийн бааз суурийг бэхжүүлэх	2.422	✓
•11. Орон нутгийн ХААҮ-ийг дэмжих хөтөлбөр	11-1. Аж үйлдвэрийн кластер бойжуулахад чиглэсэн дэмжлэгийн тогтолцоо бүрдүүлэх	2.236	
	11-2. Зах зээлд өрсөлдөх чадварыг сайжруулах зорилгоор үйлвэрлэл-ЭШБ-ын уялдааг бэхжүүлэх	2.201	
	11-3. Нэг суурин нэг бүтээгдэхүүн хөдөлгөөнийг дэмжих	2.322	
Хүнсний үйлдвэрийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар			
•6. Зөгийн балны нийлүүлэлтийн сүлжээг бэхжүүлэх хөтөлбөр	6-1. Зөгийн мэргэшсэн малын эмч сурган бэлтгэх, өвчин, хортон шавьжид тэсвэртэй зөгийн АА-г дэмжих	2.193	
	6-2. Зөгийн балны чанарын баталгааг сайжруулж, өрсөлдөх чадварыг бэхжүүлэх	2.022	
	6-3. Кластерийг бэхжүүлэх замаар зөгийн балны экспортод түлхэц өгөх	2.171	
	6-4. Үйлдвэрлэлийн бусад салбартай хамтран ажиллаж зөгийн аж ахуйг сурталчилж дэмжих	1.967	
•8. ХАА-н бүтээгдэхүүний чанар эрүүл ахуйн тогтолцоог бэхжүүлэх хөтөлбөр	8-1. Хүнсний аюулгүй байдлын төрийн хяналтын чадавхийг сайжруулах	2.459	✓
	8-2. Экспортын хяналтын чадавхийг бэхжүүлэх	2.077	
	8-3. Бэлтгэн нийлүүлэлтийн дараах алдагдлыг бууруулах бэлтгэл судалгааны төлөвлөгөө	2.270	✓
	8-4. Чанар, эрүүл ахуй хяналтын хүний нөөцийг сургаж бэлтгэх	2.280	✓
	8-5. Олон улсын баталгаажуулалт авах замаар экспортын өрсөлдөх чадварыг бэхжүүлэх	2.183	
•9. ХАА-н бүтээгдэхүүний экспортыг	9-1. Худалдааны журмыг оновчтой болгох	2.226	

Хөгжлийн хөтөлбөр	Үйл ажиллагааны төлөвлөгөө	Эрэмбэ	Нэн тэргүүнд хэрэгжүүлэх ҮАТ
эрчимжүүлэх бааз суурийг бий болгох хөтөлбөр	9-2. Худалдааны хэлэлцээрийн чадавхи бэхжүүлэх	2.114	
	9-3. Экспортын дэмжлэгийг бэхжүүлэх	2.248	

Эх сурвалж: Жайка төслийн баг

5.2.3 Хөгжлийн хөтөлбөр / Үйл ажиллагааны төлөвлөгөөг хэрэгжүүлэх

Төсвийн төлөвлөгөөнд тусгагдсан ҮАТ-ний хэрэгжүүлэх тогтолцоо нь төрийн захиргааны болон аймаг, сумын түвшинд төрийн байгууллагууд хоорондын янз бүрийн зохицуулалт, хэрэгжилтийг хангах чиг үүргүүдээс бүрдэнэ. Энэхүү Мастер төлөвлөгөөнд төрийн захиргааны байгууллага гэдэг нь ХХААХҮЯ-г хэлж байгаа бөгөөд түүнд харьяалагдах аймаг орон нутгийн ХХАА-н газрууд ҮАТ-г хэрэгжүүлнэ. Бодлогын хэрэгжилтийг зохицуулах ажлыг төв захиргаа болон орон нутгийн засаг захиргааны байгууллагуудын хооронд одоо байгаа механизмын хүрээнд зохион байгуулж, орон нутгийн ХАА-н газрын удирдлагуудад бодлогын мэдээлэл танилцуулах, төрийн захиргааны байгууллагын албан хаагчид орон нутгийн ХХАА-н газруудад очиж, тухайлсан бодлогыг хэрэгжүүлэх талаар тайлбарлах уулзалт зохион байгуулах зэргээр ажилладаг. Энэхүү Мастер төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд мөн ижил төстэй механизмаар ажиллана гэж үзэж байгаа ч төсөв, хүний нөөц дутагдалтай нөхцөлд бодлогын хэрэгжилттэй холбоотой төрийн захиргааны болон орон нутгийн захиргааны байгууллага хоорондын саадгүй ойлголцол, ойлголтын нэгдмэл байдалд хүрэхэд бэрхшээл тулгардаг байдал олонтаа тохиолддог нь бодит байдал юм. Эдгээр асуудлыг нэг л өдөр шийдэх боломжгүй ч дараах процесийг сайтар хэвшүүлж, бодлогын хэрэгжилтийг илүү үр дүнтэй болгоход чиглүүлэх нь чухал юм.

- Бодлогын зорилтуудыг тодорхой болгох, тэдгээрийг нарийвчлан танилцуулж тайлбарлах
- Бодлогыг хэрэгжүүлэх журам, заавар, нийтлэг форматыг боловсруулах
- Хөгжлийн шалгуур үзүүлэлтүүд, тэдгээрийн мониторингийн арга, давтамж
- Төслийн хэрэгжилтийн явцын тайлантай тогтмол танилцах боломж бүрдүүлэх

Энэхүү Мастер төлөвлөгөө нь ХАА-н бүтээгдэхүүний нэмүү өртгийн сүлжээг хөгжүүлэх чиглэлээр дагнасан төлөвлөгөө гэдгийг харгалзан үзэж бодлогын ач холбогдлыг орон нутгийн удирдлагуудад зөв тайлбарлах нь чухал. Тухайлбал, малчид тариаланчдыг зохион байгуулалтад оруулах замаар түүхий эдийн нийлүүлэлтийг үр ашигтай зохион байгуулах бодлогыг хэрэгжүүлэх тохиолдолд зөвхөн барилга байгууламжаас гадна зохион байгуулалтад орсон малчид тариаланчдыг түүхий эдийн бэлтгэн нийлүүлэлтээр дамжуулан бизнесээ тогтворжуулахад дэмжих нь чухал юм. Энэ үүднээс авч үзвэл, малчид тариаланчдын бүлэглэлийг сонгох шатанд бизнесээ өргөжүүлэх хүсэл эрмэлзэл өндөр байгаа хэсэгт нэн тэргүүнд анхаарч, барилга байгууламжаас гадна бизнес үйл ажиллагааны менежментийн чадавхийг бэхжүүлэхэд түлхүү анхаарах зэргээр бодлогын зорилгыг зөв ойлгож, хэрэгжилтэд тусгах шаардлагатай.

5.2.4 Хөгжлийн хөтөлбөр / Үйл ажиллагааны төлөвлөгөөнүүдийн хөгжлийн шалгуур үзүүлэлт, мониторинг

ҮАТ-нүүдийн хөгжлийн шалгуур үзүүлэлтүүдийн тухайд суурь түвшний тоо мэдээлэл, төлөв байдал болон төлөвлөгөөний хэрэгжилтийн сүүлийн жилд хүрэх зорилтот үнэ цэнэ, төлөв байдлыг Хүснэгт 5.2-т харьцуулан харуулав. Эдгээр үзүүлэлтийн тухайд Хяналт шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар нь хяналт-шинжилгээний үр дүнг цуглуулах, нэгтгэн боловсруулах үндсэн алба байх хэдий ч бодит үйл ажиллагааны мониторинг хяналтыг ҮАТ-ний хариуцсан газар хэлтэс болон орон нутгийн ХХАА-н газрын ажилтнуудтай хамтран тогтмол явуулж байх юм. ҮАТ-нүүдийн ихэнх нь 10 жилийн урт хугацааны төлөвлөгөө байгаа хэдий ч жил бүрийн төсвийн төлөвлөгөөг боловсруулахаас өмнө хэрэгжилтийн байдал, хүрсэн түвшинг үнэлж, шаардлагатай тохиолдолд төлөвлөгөөг шинэчлэн засварлана.

Хүснэгт 5.2 ҮАТ-ний хөгжлийн шалгуур үзүүлэлт

Хөгжлийн хөтөлбөр/ҮАТ	Шалгуур	Суурь түвшин	2025	2026	2027	2028	2029	2030	2031	2032	2033	2034
• 1-1.Чанартай үр, түргэтгэсэн тариалалтын аргыг нэвтрүүлэх замаар хүнсний ногооны нийлүүлэлтийн хугацааг уртасгах	Хүнсний ногооны үйлдвэрлэлийн хэмжээ	148,859 тн	157,859 тн	166,859 тн	175,859 тн	184,859 тн	193,859 тн	202,859 тн	211,859 тн	220,859 тн	229,859 тн	238,859 тн
• 1-2.Тариаланчдад /ногоочдод/ зах зээлд чиглэсэн фермерийн менежментийг эзэмшүүлэх	Нэг ногоочны орлого	3,600,000 төг/жил	3,750,000 төг/жил	3,900,000 төг/жил	4,050,000 төг/жил	4,200,000 төг/жил	4,350,000 төг/жил	4,500,000 төг/жил	4,650,000 төг/жил	4,800,000 төг/жил		
• 1-3.ГТ-гийн хоршоодоор дамжуулж ГТБ-ний нийлүүлэлтийн тогтолцоог бүрдүүлэх	Чадавхи бүхий хоршоодын тоо	10 хоршоо	10 хоршоо	20 хоршоо	30 хоршоо	50 хоршоо	70 хоршоо	100 хоршоо				
• 1-4.Ногоо боловсруулах энгийн арга болон хэрэглээний чиглэлийн сургалт, сурталчилгаа хийх	Хүнсний ногооны хэрэглээ	2.1 кг/ хүн	2.1 кг/ хүн	2.2 кг/ хүн	2.3 кг/ хүн	2.4 кг/ хүн	2.5 кг/ хүн	2.6 кг/ хүн	2.7 кг/ хүн	2.8 кг/ хүн	2.9 кг/ хүн	3.0 кг/ хүн
• 2-1.Жимсний модны суулгацын төвийг түшиглэсэн нийлүүлэлтийн сүлжээг бэхжүүлэх	Суулгацын төвд бэлдсэн суулгацын тоо	0	0	100,000 ширхэг/ жилд	200,000 ширхэг жилд	300,000 ширхэг/ жилд	400,000 ширхэг/ жилд	500,000 ширхэг/ жилд	600,000 ширхэг/ жилд	700,000 ширхэг/ жилд	800,000 ширхэг/ жилд	1,000,000 ширхэг/ жилд
• 2-2.Тариалалтын зохистой технологийг түгээн дэлгэрүүлэх	Тариалалтын зохистой техологид суралцсан ногоочдын тоо	0	0	500 хүн	1,000 хүн	1,500 хүн	2,000 хүн	2,500 хүн				
• 2-3.Чацарганы экспортыг дэмжих	Экспортын мөнгөн дүн	890 сая төг.	979 сая төг.	1,068 сая төг.	1,157 сая төг.	1,246 сая төг.	1,335 сая төг.	1,424 сая төг.	1,513 сая төг.	1,602 сая төг.	1,691 сая төг.	1,780 сая төг.
• 3-1.Рапсын үрийн дотоодын үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх	Дотоодын үйлдвэрийн үрийн хэмжээ	0 тн	50 тн	100 тн	150 тн	200 тн	250 тн	300 тн	350 тн	400 тн	450 тн	500 тн
• 3-2.Рапс тариалах технологийг хөгжүүлэх, үйлдвэрлэлийг дэмжих	Нэгжйн ургац	0.6 тн/га	0.65 тн/га	0.65 тн/га	0.65 тн/га	0.75 тн/га	0.75 тн/га	0.75 тн/га	0.85 тн/га	0.85 тн/га	0.85 тн/га	1.0 тн/га
• 3-3.Рапсын худалдааны нөхцлийг сайжруулах	Тариалсан талбай	17,000 га	20,300 га	23,600 га	26,900 га	30,200 га	33,500 га	36,800 га	40,100 га	43,400 га	46,700 га	50,000 га

Хөгжлийн хөтөлбөр/ҮАТ	Шалгуур	Суурь түвшин	2025	2026	2027	2028	2029	2030	2031	2032	2033	2034
• 3-4.Рапсын тосны хэрэглээг өргөжүүлэхэд чиглэсэн сурталчилгаа	Рапсын тосны хэмжээ	10 %	11 %	12 %	13 %	14 %	15 %	16 %	17 %	18 %	19 %	20 %
• 4-1.Малын үүлдэр угсааг сайжруулах тогтолцоо бүрдүүлэх	Тогтолцоо бүхий аймгийн тоо	5 аймаг	5 аймаг	7 аймаг	9 аймаг	11 аймаг	13 аймаг	15 аймаг	17 аймаг	19 аймаг	21 аймаг	22 аймаг
• 4-2. Өсвөр мал (хурга) бордох бизнесийг нэвтрүүлж дэмжих	Хонины махны экспортын хэмжээ	500 тн	2,000 тн	3,000 тн	4,000 тн	5,000 тн	8,000 тн	12,000 тн	16,000 тн	20,000 тн	30,000 тн	50,000 тн
• 4-3. Зах зээлийн эрэлт хэрэгцээнд нийцсэн махны шинэ ангилал нэвтрүүлэх, нэмүү өртөг шингээхийг дэмжих	Сайжруулсан ангилан ялгах стандарт бий эсэх	Байхгүй	Байхгүй	Байгаа	Байгаа	Байгаа	Байгаа	Байгаа	Байгаа	Байгаа	Байгаа	Байгаа
• 4-4.Мал төхөөрөх үйлдвэр байгуулах	Мал төхөөрөх үйлдвэрийн эзлэх хувь	10%	14%	18%	22%	26%	30%	34%	38%	42%	46%	50%
• 4-5.МАА-н болон дайвар бүтээгдэхүүнээр гэрийн тэжээвэр амьтны хоол үйлдвэрлэл бий болгох	ГТА-ны хоолны экспортын хэмжээ	106 тн	110 тн	120 тн	130 тн	140 тн	150 тн					
• 4-6.Сүү цуглуулах тогтолцоог бэхжүүлж, үйлдвэр цехэд сүү хүлээн авах хэмжээг нэмэгдүүлэх	Үйлдвэрт хүлээн авсан сүү	40,000 тн	42,000 тн	44,000 тн	46,000 тн	48,000 тн	50,000 тн	52,000 тн	54,000 тн	56,000 тн	58,000 тн	60,000 тн
• 5-2. Малчдын хоршоог түшиглэсэн ноос, арьс шир бэлтгэн нийлүүлэлтийн сүлжээг бэхжүүлэх	Малчдын хоршоогоор бэлтгэн нийлүүлсэн ноос, арьс ширний тоо	Ноос: 50 тн Арьс шир: 3,000 ширхэг	Ноос: 50 тн Арьс шир: 3,000 ширхэг	Ноос: 1,010 тн Арьс шир: 103,000 ширхэг	Ноос: 1,010 тн Арьс шир: 103,000 ширхэг	Ноос: 2,240 тн Арьс шир: 231,000 ширхэг	Ноос: 3,470 тн Арьс шир: 359,000 ширхэг	Ноос: 4,700 тн Арьс шир: 487,000 ширхэг	Ноос: 5,930 тн Арьс шир: 615,000 ширхэг	Ноос: 7,170 тн Арьс шир: 743,000 ширхэг	Ноос: 8,450 тн Арьс шир: 871,000 ширхэг	Ноос: 9,600 тн Арьс шир: 1,000,000 ширхэг
• 5-3.Нэхмэл сүлжмэл, арьс ширэн эдлэлийн тогтвортой үйлдвэрлэлийн тогтолцоо бүрдүүлэх төлөвлөгөө	Стандартын шаардлага хангасан нэхэх үйлдвэрийн тоо, Байгаль орчинд ээлтэй технологи бүхий арьс ширний үйлдвэрийн тоо	Нэхэх үйлдвэр:21, Арьс ширний үйлдвэр:17	Нэхэх үйлдвэр:23 Арьс ширний үйлдвэр:19	Нэхэх үйлдвэр:25 Арьс ширний үйлдвэр:22	Нэхэх үйлдвэр:27 Арьс ширний үйлдвэр:25	Нэхэх үйлдвэр:29 Арьс ширний үйлдвэр:28	Нэхэх үйлдвэр:31 Арьс ширний үйлдвэр:31	Нэхэх үйлдвэр:33 Арьс ширний үйлдвэр:34	Нэхэх үйлдвэр:35 Арьс ширний үйлдвэр:37	Нэхэх үйлдвэр:37 Арьс ширний үйлдвэр:40	Нэхэх үйлдвэр:39 Арьс ширний үйлдвэр:42	Нэхэх үйлдвэр:43 Арьс ширний үйлдвэр:44
• 5-4. Нэхэх салбарт АҮ кластер хөгжүүлэх төлөвлөгөө	Ноосон утасны экспорт (HS5109), хувцас хэрэглэлийн экспортын хэмжээ (HS61)	Ноосон утас:7.8 тн Хувцас хэрэглэл:558 тн	Ноосон утас:9.0 тн Хувцас хэрэглэл:593 тн	Ноосон утас:10.3 тн Хувцас хэрэглэл:628 тн	Ноосон утас:11.5 тн Хувцас хэрэглэл:663 тн	Ноосон утас:12.8 тн Хувцас хэрэглэл:698 тн	Ноосон утас:14 тн Хувцас хэрэглэл:733 тн	Ноосон утас:15.2 тн Хувцас хэрэглэл:768 тн	Ноосон утас:16.5 тн Хувцас хэрэглэл:803 тн	Ноосон утас:17.7 тн Хувцас хэрэглэл:838 тн	Ноосон утас:19 тн Хувцас хэрэглэл:873 тн	Ноосон утас:20.2 тн Хувцас хэрэглэл:908 тн
• 6-1. Зөгийн мэргэшсэн малын эмч сурган бэлтгэх, өвчин, хортон шавьжид тэсвэртэй зөгийн АА-г дэмжих	Малын эмчтэй гэрээ байгуулсан зөгийчний тоо	13%	20%	27%	34%	41%	48%	55%	62%	69%	76%	80%

Хөгжлийн хөтөлбөр/ҮАТ	Шалгуур	Суурь түвшин	2025	2026	2027	2028	2029	2030	2031	2032	2033	2034
• 6-2.Зөгийн балны чанарын баталгааг сайжруулж, өрсөлдөх чадварыг бэхжүүлэх	Мөшгих боломжтой балны нийлүүлэлтийн хэмжээ	0 тн	10 тн	20 тн	30 тн	40 тн	50 тн	100 тн	130 тн	160 тн	190 тн	200 тн
• 6-3. Кластерийг бэхжүүлэх замаар зөгийн балны экспортод түлхэц өгөх	Экспортлосон зөгийн бал	0.3 тн	0.5 тн	1.0 тн	5.0 тн	10 тн	20 тн	30 тн	50 тн	70 тн	90 тн	100 тн
• 6-4.Бусад салбартай хамтран ажиллаж зөгийн аж ахуйг сурталчилж дэмжих	Хамтран ажилласнаар үйлдвэрлэсэн балны хэмжээ	0 t	7 тн	14 тн	21 тн	28 тн	35 тн	42 тн	49 тн	56 тн	63 тн	70 тн
• 7-1. Мөөг тарих технологийн сургалт, түгээн дэлгэрүүлэхийг эрчимжүүлэх	Мөөг үйлдвэрлэгчийн тоо	50	60	70	80	90	100	150	200	300	400	500
• 7-2.Мөөгний үндэсний стандарт боловсруулах	Мөөгний борлуулалтын мөнгөн дүн	100 сая төг.	150 сая төг.	200 сая төг.	250 сая төг.	300 сая төг.	350 сая төг.	400 сая төг.	500 сая төг.	650 сая төг.	800 сая төг.	1,000 сая төг.
• 7-3.Мөөгний хэрэглээг өргөжүүлэхэд чиглэсэн сурталчилгаа	Мөөгний хэрэглээний хэмжээ	1,000 тн	1,200 тн	1,400 тн	1,600 тн	1,800 тн	2,000 тн					
• 7-4. Загасны хэрэглээг дэлгэрүүлэх зорилготой загас боловсруулах үйлдвэр байгуулах төлөвлөгөө	Загасны хэрэглээний хэмжээ	0.18 кг	0.2 кг	0.22 кг	0.24 кг	0.26 кг	0.28 кг	0.30 кг	0.30 кг	0.30 кг	0.30 кг	0.30 кг
• 8-1.Хүнсний аюулгүй байдлын төрийн хяналтын чадавхиийг сайжруулах	Бодлогын үнэлгээний тогтолцоо	Байхгүй	Байхгүй	Байхгүй	Байгаа	Байгаа	Байгаа	Байгаа	Байгаа	Байгаа	Байгаа	Байгаа
• 8-2.Экспортын хяналтын чадавхийг бэхжүүлэх	Лаборатори байгуулах, үйл ажиллагааны төлөвлөгөө	Байхгүй	Байхгүй	Байгаа	Байгаа	Байгаа	Байгаа	Байгаа	Байгаа	Байгаа	Байгаа	Байгаа
• 8-3.Бэлтгэн нийлүүлэлтийн дараах алдагдлыг бууруулах бэлтгэл судалгааны төлөвлөгөө	Төлөвлөгөө хэрэгжилт	Байхгүй	Байхгүй	Байгаа								
• 8-4. Чанар, эрүүл ахуй хяналтын хүний нөөцийг сургаж бэлтгэх	Сургагч багшийн тоо	0 хүн	0 хүн	0 хүн	0 хүн	10 хүн	20 хүн	30 хүн	50 хүн	60 хүн	80 хүн	100 хүн
• 8-5. Олон улсын баталгаажуулалт авах замаар экспортын өрсөлдөх чадварыг бэхжүүлэх	Авсан баталгаажуулалтын тоо	0	0	10	20	30	40	50	60	70	90	114
• 9-1.Худалдааны журмыг оновчтой болгох	Бүрдүүлэлтэд зарцуулсан хугацаа /цагаар/	260	260	200	140	106	106	106	106	106	106	106
• 9-2.Худалдааны хэлэлцээрийн чадавхи бэхжүүлэх	Мэргэшсэн хэлэлцээрч мэргэжилтэн ажиллуулах	0	0	0	3	3	3	3	3	3	3	3
• 9-3.Экспортын дэмжлэгийг бэхжүүлэх	Дэмжлэг авсан ААН-ийн тоо	0	100	200	300	400	500	600	700	800	900	1000

Хөгжлийн хөтөлбөр/ҮАТ	Шалгуур	Суурь түвшин	2025	2026	2027	2028	2029	2030	2031	2032	2033	2034
• 10-1.Нэмүү өртгийн сүлжээний зээлийн тогтолцоог нэвтрүүлэх бэлтгэл судалгаа хийх	Тогтолцоо бүрдсэн эсэх	Байхгүй	Байхгүй	Байгаа								
• 10-2. Агуулахын үнэт цаасны тогтолцоо нэвтрүүлэх бэлтгэл судалгаа хийх	Тогтолцоо бүрдсэн эсэх	Байхгүй	Байхгүй	Байгаа								
• 10-3. ЖДҮ-ийн менежментийн бааз суурийг бэхжүүлэх	Дэмжлэг авсан ААН-ийн тоо	0	10	20	30	40	50	60	70	80	90	100
• 10-4.ХАА-н хоршооны менежментийн бааз суурийг бэхжүүлэх	Түүхий эд цуглуулах, тээвэрлэх, анхан шатны боловсруулалт хийдэг хоршоодын тоо	10	20	30	40	50	80	110	140	170	200	230
• 11-1.Аж үйлдвэрийн кластер бойжуулахад чиглэсэн дэмжлэгийн тогтолцоо бүрдүүлэх	Тогтолцоо бүрдсэн эсэх	Байхгүй	Байхгүй	Байгаа	Байгаа	Байгаа	Байгаа	Байгаа	Байгаа	Байгаа	Байгаа	Байгаа
• 11-2. Зах зээлд өрсөлдөх чадварыг сайжруулах зорилгоор үйлвэрлэл-ЭШБ-ын уялдааг бэхжүүлэх	Тогтолцоо бүрдсэн эсэх	Байхгүй	Байхгүй	Байгаа	Байгаа	Байгаа	Байгаа	Байгаа				
• 11-3. Нэг суурин нэг бүтээгдэхүүн хөдөлгөөнийг дэмжих	Нэг суурин нэг бүтээгдэхүүн хөдөлгөөний г эхлүүлсэн орон нутгийн тоо	0	3	3	3	8	8	13	13	22	22	22

Эх сурвалж: Жайка судалгааны баг

5.3 Хөгжлийн хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх төслийн өртөг

5.3.1 Төслийн өртөг

2025-2034 он хүртэл 10 жилийн хугацаанд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтийн хуваарь, төслийн өртгийг Хүснэгт 5.3-т үзүүлэв. Ихэнх ҮАТ 2025 оноос эхэлж 10 жилийн хугацаанд хэрэгжихээр төлөвлөсөн байна. Бүх ҮАТ-г нэгэн зэрэг эхлүүлэхэд санхүүгийн болон зохион байгуулалтын хувьд хүндрэлтэй бол Хүснэгт 5.1-д үзүүлсэн төслүүдийн эрэмбэлсэн жагсаалтыг харгалзан үе шаттайгаар хэрэгжүүлэх хувилбарыг авч үзэж болно. 10 жилийн төслийн нийт өртөг 625 тэрбум 471 сая төгрөг, үүнээс төр хариуцах зардлын хэмжээ 542 тэрбум 307 сая төгрөг байна.

Хүснэгт 5.3 ҮАТ-г хэрэгжүүлэх хуваарь, төслийн өртөг

Хөгжлийн хөтөлбөр / ҮАТ	2025	2026	2027	2028	2029	2030	2031	2032	2033	2034	Нийт өртөг
1. Хүнсний ногооны нийлүүлэлтийн сүлжээг бэхжүүлэх хөтөлбөр											**34,346**
•1-1. Чанартай үр, түргэтгэсэн тариалалтын аргыг нэвтрүүлэх замаар хүнсний ногооны нийлүүлэлтийн хугацааг уртасгах	353	750	1,000	1,250	1,500	1,750	2,000	2,250	2,500	2,750	16,103
•1-2. Тариаланчдад /ногоочдод/ зах зээлийн бармжаатай фермерийн менежментийг түгээн дэлгэрүүлэх	599	700	700	700	700	700	700	800			5,599
•1-3. ГТ-гийн хоршоодоор дамжуулж ГТБ-ний нийлүүлэлтийн тогтолцоог бий болгох	255	1,500	1,500	1,500	1,500	1,500					7,755
•1-4. Хүнсний ногоо боловсхуулах энгийн арга болон хэрэглээний чиглэлийн сургалт, сурталчилгаа хийх	130	517	517	517	517	517	517	517	517	623	4,889
2.Жимсний модны нийлүүлэлтийн сүлжээг бэхжүүлэх хөтөлбөр											**16,849**
•2-1. Жимсний модны суулгацын төвийг түшиглэсэн нийлүүлэлтийн сүлжээг бэхжүүлэх	200	2,000	2,000	2,000	500	500	500	500	500	700	9,400
•2-2. Тариалалтын зохистой технологийг түгээн дэлгэрүүлэх	599	700	700	700	700	800					4,199
•2-3. Чацарганы экспортыг дэмжих	200	350	350	350	350	350	350	350	350	250	3,250
3. Тосны ургамлын нийлүүлэлтийн сүлжээг бэхжүүлэх хөтөлбөр											**8,885**
•3-1. Рапсын үрийн дотоодын үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх	54	77	106	154	193	193	193	193	193	193	1,549
•3-2. Рапс тариалах технологийг хөгжүүлэх, үйлдвэрлэлийг дэмжих	430	646	790	740	740	720	720	720	720	720	6,946
•3-3. Рапсын худалдааны нөхцлийг сайжруулах	20	20	20	20	20	20	20	20	20	20	200
•3-4. Рапсын тосны хэрэглээг өргөжүүлэхэд чиглэсэн сурталчилгаа	60	50	40	20	20						190
4.Мах сүүний нийлүүлэлтийн сүлжээг бэхжүүлэх											**187,644**
•4-1. Малын үүлдэр угсааг сайжруулах тогтолцоо бүрдүүлэх	5,371	5,168	5,168	5,168	5,168	5,168	5,168	5,168	5,168	5,191	51,906
•4-2. Өсвөр мал (хурга) бордох бизнесийг нэвтрүүлж дэмжих	331	128	128	128	128	128	128	128	128	151	1,506
•4-3. Зах зээлийн эрэлт хэрэгцээнд нийцсэн махны шинэ зэрэглэл нэвтрүүлэх, нэмүү өртөг шингээхийг дэмжих	388	185	185	185	185	185	185	185	185	208	2,076
•4-4. Мал төхөөрөх үйлдвэр байгуулах	5,396	5,193	5,193	5,193	5,193	5,193	5,193	5,193	5,193	5,216	52,156
•4-5. МАА-н болон дайвар бүтээгдэхүүнээр гэрийн тэжээвэр амьтны хоол үйлдвэрлэл бий болгох	100	800	800	800	50	50					2,600
•4-6. Сүү цуглуулах тогтолцоог бэхжүүлж,үйлдвэр цехэд сүү хүлээн авах хэмжээг нэмэгдүүлэх	100	8,600	8,600	8,600	8,600	8,600	8,600	8,600	8,600	8,500	77,400
5.Ноос, арьс ширний нийлүүлэлтийн сүлжээг бэхжүүлэх											**289,141**
•5-2. Малчдын хоршоог түшиглэсэн ноос, арьс шир бэлтгэн нийлүүлэлтийн сүлжээг бэхжүүлэх	25,001	20,363	26,471	26,471	24,435	24,435	20,363	20,363	20,363	20,363	228,628
•5-3. Нэхмэл сүлжмэл, арьс ширэн эдлэлийн тогтвортой үйлдвэрлэлийн тогтолцоо бүрдүүлэх төлөвлөгөө	660	1,467	1,467	1,467	1,467	1,467	1,467	1,467	1,467	1,467	13,863
•5-4. Нэхэх салбарт АУ кластер хөгжүүлэх төлөвлөгөө	50	8,975	8,925	9,200	9,200	9,200	275	275	275	275	46,650
6. Зөгийн балны нийлүүлэлтийн сүлжээг бэхжүүлэх хөтөлбөр											**8,237**

Хөгжлийн хөтөлбөр / ҮАТ	2025	2026	2027	2028	2029	2030	2031	2032	2033	2034	Нийт өртөг
•6-1. Зөгийн мэргэшсэн малын эмч бэлтгэх, өвчин, хортон шавьжид тэсвэртэй зөгийн АА-г дэмжих	201	160	161	161	149	149	149	136	136	136	1,538
•6-2. Зөгийн балны чанарын баталгааг сайжруулж, өрсөлдөх чадварыг бэхжүүлэх	299	276	286	286	310	338	226	237	228	240	2,726
•6-3. Кластерийг бэхжүүлэх замаар зөгийн балны экспортод түлхэц өгөх	342	399	183	244	156	183	114	177	110	175	2,083
•6-4. Үйлдвэрлэлийн бусад салбартай хамтран ажиллаж зөгийн аж ахуйг сурталчилж дэмжих	223	233	201	225	193	183	158	158	158	158	1,890
7. ХАА-н бусад бүтээгдэхүүний нийлүүлэлтийн сүлжээг бэхжүүлэх											**2,340**
•7-1.Мөөг тарих технологийн сургалт, түгээн дэлгэрүүлэлтэд түлхэц өгөх	70	70	70	70	70	40	40	40	40	40	550
•7-2.Мөөгний үндэсний стандарттай болох	60	10	120	25	25	25	25	25	25	25	365
•7-3.Мөөгний хэрэглээг өргөжүүлэхэд чиглэсэн сурталчилгаа	105	105	80	80	30						400
•7-4. Загасны хэрэглээг дэлгэрүүлэх зорилготой загас боловсруулах үйлдвэр байгуулах төлөвлөгөө	55	136	108	108	103	103	103	103	103	103	1,025
8. ХАА-н бүтээгдэхүүний чанар эрүүл ахуйн тогтолцоог бэхжүүлэх											**27,869**
•8-1. Хүнсний аюулгүй байдлын төрийн хяналтын чадавхийг сайжруулах	462	423	423	82	82	82	82	82	82	82	1,882
•8-2. Экспортын хяналтын чадавхийг бэхжүүлэх	831	1254	1229	696	615	590	590	590	615	590	7,600
•8-3. Бэлтгэн нийлүүлэлтийн дараах алдагдлыг бууруулах бэлтгэл судалгааны төлөвлөгөө	359	907									1,266
•8-4. Чанар, эрүүл ахуй хяналтын хүний нөөцийг сургаж бэлтгэх	230	266	224	287	273	345	121	104	140	141	2,131
•8-5. Олон улсын баталгаажуулалт авах замаар экспортын өрсөлдөх чадварыг бэхжүүлэх	283	533	1,619	1,692	1,559	1,647	1,744	1,850	1,967	2,096	14,990
9. ХАА-н бүтээгдэхүүний экспортыг эрчимжүүлэх бааз суурийг бий болгох											**34,150**
•9-1. Худалдааны журмыг оновчтой болгох	159	160	165	168	174	178	188	193	201	207	1,793
•9-2. Худалдааны хэлэлцээрийн чадавхи бэхжүүлэх	978	976	977	655	675	694	714	695	715	773	7,852
•9-3. Экспортын дэмжлэгийг бэхжүүлэх	760	1,058	2,762	2,421	2,479	2,684	2,733	3,141	3,201	3,266	24,505
10. ХАА-н салбарын ААН, хоршооны менежментийн чадавхийг бэхжүүлэх											**3,983**
•10-1. Нэмүү өртгийн сүлжээний зээлийн тогтолцоог нэвтрүүлэх бэлтгэл судалгаа хийх	372	559									931
•10-2. Агуулахын үнэт цаасны тогтолцоо нэвтрүүлэх бэлтгэл судалгаа хийх	262	393									655
•10-3. ЖДҮ-ийн менежментийн баазыг бэхжүүлэх	160	190	30	30	30	30	30				500
•10-4. ХАА-н хоршооны менежментийн баазыг бэхжүүлэх	379	300	300	300	300	300	9	9			1,897
11. Орон нутгийн ХААҮ-ийг дэмжих											12,027
•11-1. АҮ-ийн кластер бойжуулахыг дэмжих тогтолцоо бий болгох	31	1,000	1,000	1,000	1,000	1,000	1,000	1,000	1,000	1,000	9,031
•11-2. Зах зээлд өрсөлдөх чадварыг сайжруулах зорилгоор үйлвэрлэл-ЭШБ-ын уялдааг бэхжүүлэх	31	375	375	375	375	375	0	0	0	0	1,906
•11-3. Нэг суурин нэг бүтээгдэхүүн хөдөлгөөнийг дэмжих	200	282	83	75	75	75	75	75	75	75	1,090
Нийт	47,149	68,254	75,056	74,143	69,839	70,497	54,480	55,344	54,975	55,734	625,471

Эх сурвалж: Жайка төслийн баг Жич: Өртгийн нэгж сая төгрөг

5.3.2 Төсвийн эх үүсвэр бүрдүүлэхийн тулд авах арга хэмжээ

(1) Хөгжлийн түншүүдтэй хамтран ажиллах

Монгол Улсад хөгжлийн олон түншүүд хөдөө аж ахуйн салбарт янз бүрийн чиглэлээр дэмжлэг үзүүлж ирсэн. Сүүлийн жилүүдэд дэмжлэг үйл ажиллагааны үр дүнг сайжруулах тал дээр хөгжлийн түншүүд хангалттай харилцан уялдаатай ажиллаагүй, мөн урьдчилсан зохицуулалтгүйгээр үйл ажиллагаа давхцах тохиолдолууд гарч байгааг харгалзан ХХААБ FAO болон АХБ-ны ADB дэмжлэгтэйгээр ХХААХҮЯ, Байгаль орчин, аялал жуулчлалын яам (БОАЖЯ) хамтран Хүнс, хөдөө аж ахуйн хөгжлийн түншлэлийн группийг (FOOD AND AGRICULTURE DEVELOPMENT PARTNER GROUP (FADPG)) байгуулсан бөгөөд зорилго нь “Хөгжлийн түншүүдийн хоорондын холбоо харилцааны чанар, давтамжийг сайжруулах, бодлогын тэргүүлэх чиглэлүүд болон төслүүдийг хянах, дүгнэх, үнэлэх аргачлалын тал дээр нэгдсэн ойлголтыг төлөвшүүлэх, үйл ажиллагаа давхардахаас зайлсхийх, олж авсан мэдлэг туршлагатай холбоотой мэдээлэл солилцохыг дэмжих, хүнс, хөдөө аж ахуйн салбартай холбоотой хөрөнгө оруулалт, дэмжлэгийн талаар хөгжлийн түншүүд болон засгийн газар хоорондын ил тод байдал, зохицуулалт, уялдаа холбоог дэмжих” гэж тодорхойлсон. Одоогийн байдлаар ХХААХТГ-д элсэх болзолд тодорхой хязгаарлалт байхгүй бөгөөд ХАА-н салбарыг дэмжих сонирхолтой хоёр талт (эсвэл олон талт) аливаа байгууллага гишүүнээр элсэх боломжтой. ХХААХТГ-ийн анхны хурлыг 2020 оны 12-р сард зохион байгуулсан бөгөөд, улирал тутам хуралдахаар төлөвлөсөн байдаг.

Энэхүү Мастер төлөвлөгөөг боловсруулах явцад бид хэд хэдэн удаагийн хуралд оролцож, ХХААХТГ-ийн гишүүдэд төлөвлөгөөгөө танилцуулан хэлэлцүүлж, санал бодлоо солилцож ирсэн. ХАА-н салбарын хөгжлийн төлөвлөгөө, тэр дундаа энэхүү Мастер төлөвлөгөөг үр ашигтай хэрэгжүүлэхэд ХХААХТГ-тэй хамтрах нь үр дүнтэй арга зам байж чадах болно. Одоогийн байдлаар ХХААБ, АХБ, ЖАЙКА гэх мэт байгууллагууд ХХААХТГ-ийн менежментийн ажлыг гүйцэтгэж байгаа ба цаашид хөгжлийн түншүүдэд даатган үлдээхээс илүүтэйгээр ХХААХҮЯ-ны тогтмол зохион байгуулдаг ажлын хүрээнд төлөвлөж, бие даан удирдан явуулах шаардлагатай. Тодруулбал, дараах байдлаар хурлын үйл ажиллагааг удирдан явуулж болох юм.

1) Ажлын албаны удирдлага, үйл ажиллагааны субьект

ХХААХҮЯ болон БОАЖЯ нь ХХААХТГ-ийг үүсгэн байгуулагдсанаас хойш хамтран ажиллаж ирсэн бөгөөд ХХААХҮЯ нь бодитоор манлайлан ажиллаж байгаа тул хойшид ч ХХААХҮЯ-наас удирдлага менежментийг үргэлжлүүлэн авч явах нь зүйтэй гэж үзэж байна. Энэ тохиолдолд ажлын алба нь Бодлого төлөвлөлтийн газрын Гадаад хамтын ажиллагааны хэлтэст хамаарч, ХХААХТГ-ийн үйл ажиллагаатай холбоотой шаардлагатай ажлуудыг хийж гүйцэтгэх юм.

2) FADPG-ийн хуралдах хугацаа

ХХААХТГ-ийг байгуулах анхны төлөвлөгөөнд улирал тутам зохион байгуулахаар төлөвлөж

байсан ч бодлого төлөвлөлт, хэрэгжилт, төсвийн төсөл боловсруулах болон бусад төрөл бүрийн арга хэмжээ зохион байгуулах зэргээр олон ажил хариуцдаг ХХААХҮЯ-ны ажилтнуудын цаг боломжийг харгалзан ажиллах шаардлагатай тул хурлын давтамжийг хамгийн бага хэмжээнд тогтоож, яамны ажилтнуудын ажлын ачаалал ихтэй цаг үеийг алгасан хугацааг товлох нь зүйтэй. Тодруулбал жилд хоёр удаа, 5-6-р сар, 11-12-р саруудад хурлыг зохион байгуулж Бодлого Төлөвлөлтийн Газар тухай бүрт зохих зохицуулалтыг хийх шаардлагатай.

3) Хүнс, хөдөө аж ахуйн хөгжлийн түншлэлийн группийн (FADPG) хэлэлцэх асуудал

ХХААХТГ-ийн хурлаар ХХААХҮЯ-аас хөдөө аж ахуйн салбарын бодлогын чиг хандлага, гарсан шийдвэр, тэр дундаа энэхүү Мастер төлөвлөгөө, хөгжлийн түншүүдээс хүсэж буй дэмжлэг үйл ажиллагааны агуулгыг танилцуулна. Хөгжлийн түншүүдэд хэрэгжиж буй төслүүдийн явц, цаашид хэрэгжүүлэх төлөвлөгөө, төлөвлөлт судалгааны шатанд байгаа төслүүдийн талаар мэдээлэл солилцох боломжийг бий болгоно. Хурлыг жилд 2 удаа зохион байгуулна гэж үзвэл Зураг 5.3-т харуулсан төсвийн төлөвлөгөөг батлах үйл явцтай уялдуулан хурлаар хэлэлцэх асуудлыг дараах байдлаар боловсруулна.

Хүснэгт 5.4 ХХААХТГ-ийн /FADPG/ хурлаар хэлэлцэх асуудлууд (төсөл)

Хурлын хугацаа	ХХААХҮЯ (БОАЖЯ)	Хөгжлийн түнш
Жил бүрийн 5-6 сар	• Дунд хугацааны төлөвлөгөөтэй холбоотой гарсан шийдвэрүүдийн талаар мэдээлэл солилцох • Ирэх оны төлөвлөгөөтэй холбоотой мэдээлэл солилцох, бодлогын хэрэгжилттэй холбоотой тулгарч буй асуудлууд • Хөгжлийн түншүүдээс хүсэж буй дэмжлэг	• Хөгжлийн түншүүдийн хэрэгжүүлж буй төслийн явцын талаар мэдээлэл хуваалцах. • Хөгжлийн түншүүд хэрэгжүүлэхээр төлөвлөж буй болон төлөвлөлтийн шатанд байгаа төслүүдийн талаар мэдээлэл солилцох • Засгийн газарт тавих хүсэлт гэх мэт
Жил бүрийн 11-12сар	• Ирэх жилийн төлөвлөгөөний шийдвэрийн талаар мэдээлэл солилцох • Дунд хугацааны төлөвлөгөөний төсөлтэй холбоотой мэдээлэл солилцох, бодлогын хэрэгжилттэй холбоотой асуудлууд • Хөгжлийн түншүүдээс хүсэж буй дэмжлэг	

Эх сурвалж: Жайка төслийн баг

(2) Хувийн хэвшил, байгууллагуудтай хамтран ажиллах

“Тогтвортой хөгжлийн зорилтууд”-ын (SDGs) зорилтот хугацаа болох 2030 оноос өмнө дэлхийн улс орнуудыг зорилтыг биелүүлэхэд хүчин чармайлтаа нэмэгдүүлэхийг шаардаж байна. Дутагдалтай байгаа хөгжлийн санхүүжилтийн хөрөнгийг хувийн хэвшлийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөдөлгөөн Монгол Улсад ч гэсэн бий болж эхэлж, тэр дундаа хөрөнгө санхүүгийн боломж өндөртэй уул уурхайн компаниуд ХАА салбарт хувь нэмрээ оруулахаар хичээж байна. Түүнчлэн НҮБ-ээс “Монгол Улсын Тогтвортой хөгжлийн зорилтын Хөрөнгө оруулагчдын

зураглал「MONGOLIA SDG Investor Map」”[110]-ыг гаргаж тус тайланд ХАА-н хөрөнгө оруулалтын боломжит салбаруудыг дараах байдлаар тусгасан байна.

- Шим тэжээл өндөртэй органик сүү, сүүн бүтээгдэхүүн боловсруулах (High nutrient and organic milk and dairy products processing)
- Ноос, ноолуур боловсруулах тогтвортой үйлдвэрлэлийн үйл ажиллагааг дээшлүүлэх (Upgrading sustainable wool and cashmere processing plants)
- Малын дайвар бүтээгдэхүүн, хаягдлаас органик бордоо гарган авах (Organic fertilizer produced from animal byproducts and waste)
- Эрчим хүчний хэмнэлттэй өвлийн хүлэмж (Energy efficient winter greenhouse)
- Малын дайвар бүтээгдэхүүнээс гоо сайхны бүтээгдэхүүн үйлдвэрлэх (Artisan cosmetics products made witragricultural byproducts)
- Чацарганы тариалалт болон боловсруулсан бүтээгдэхүүн (Seabuckthorn tree plantations and affiliated products)

Эдгээр хөрөнгө оруулалтын чиглэлүүд нь энэхүү Мастер төлөвлөгөөнд тусгагдсан тухайн чиглэлийн YAT-нүүдтэй ихээхэн нийцэж байгаа бөгөөд хувийн хэвшлийн оролцоог хангасан хэлбэрээр хамтран хэрэгжүүлэхээр төлөвлөж боловсруулсан. Дээр дурдсан ХХААХТГ-н хурлаар хувийн хэвшлийн оролцоотойгоор хэрхэн хөгжүүлэх талаар мөн ярилцлага, хэлэлцүүлэг зохион байгуулах нь зүйтэй юм.

[110] UNDP, 2023.9, MONGOLIA SDG Investor Map Report on Investment Opportunity Areas, UNDP,

6.-Р БҮЛЭГ. Дүгнэлт ба зөвлөмж

6.1 Дүгнэлт

- Энэхүү Мастер төлөвлөгөө нь Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого болох “Алсын хараа 2050”-г хэрэгжүүлэхэд шаардлагатай ХАА-н салбарт стратегийн нэмүү өртгийн сүлжээг хөгжүүлэхийг дэмжих (2025-2034) төлөвлөгөө юм. “Алсын хараа 2050”-д ядуурлын түвшинг 28%-иас 5%, ажилгүйдлийн түвшинг 8,6%-иас 3% болгон бууруулах зорилт дэвшүүлсэн бөгөөд эдгээр зорилтыг хэрэгжүүлэхэд ХАА-н салбарын оруулах хувь нэмэр чухал юм. Мөн тус баримт бичигт боловсруулах аж үйлдвэрийн ДНБ-д эзлэх хувийг 4.6%-иас 27.4% хүртэл нэмэгдүүлнэ хэмээн тусгаж, ХАА-н салбарт түүхий эдийг дотооддоо боловсруулахыг нэмэгдүүлэх чиглэлийг заажээ.
- Монгол Улсын ХАА-н салбар нь сүүлийн 10 жилд (2012-2021) ихээхэн өссөн салбар юм. ХАА-н салбарын ДНБ-ний дундаж өсөлт 4.25% байгаа нь дэлхийн дундаж болох 3.54%-иас өндөр байгаа бөгөөд тэр дундаа ХАА-н салбар онцгой хурдацтай хөгжиж буй Зүүн Ази, Номхон далайн бүс нутгийн дундажтай бараг тэнцүү байна. Нөгөөтэйгүүр, энэхүү өсөлтөд үйлдвэрлэл өргөжиж, ялангуяа тариалангийн талбайн хэмжээ нэмэгдэж, малын тоо толгой өссөн нь голлон нөлөөлсөн бөгөөд бүтээмж, нэмүү өртөг дээшилснээс орж буй хувь нэмэр бага байна гэж хэлж болно. Одоо ч өсөн нэмэгдсээр байгаа малын тоо толгой, бэлчээрийн даац хэтрэлт, уур амьсгалын өөрчлөлтийн нөлөө зэргийг авч үзвэл ХАА-н салбарын тоон тэлэлт аль хэдийн дээд хязгаартаа хүрчээ. Цаашид Монгол Улсын ХАА-н салбарт бүтээгдэхүүний бүтээмжийг дээшлүүлэх, нэмүү өртөг шингээхэд анхаарсан бодлого хэрэгжүүлэх шаардлагатай байна.
- ХАА-н салбарын тухайд юуны түрүүнд улс үндэстний хувьд хүнсний аюулгүй байдлыг бэхжүүлэхийн тулд үйлдвэрлэл, хангамжийн тогтолцоог бий болгох нь үндсэн бодлого болно. Одоогийн байдлаар улаан буудай, төмсөөр өөрийгөө 100% хангах хэмжээнд хүрсэн бөгөөд өнөөгийн үйлдвэрлэлийн цар хүрээ, ургацын хэмжээ нь хүн ам улам өсссөн 2034 онд ч 100% өөрийгөө хангах чадвартай байх төлөвтэй байгаа хэдий ч хүнсний ногоо, жимс жимсгэнэ, ургамлын тосны хувьд энэ түвшин хангалтгүй буюу 57%, 1%, 18% орчим байгаа тул энэ байдлыг сайжруулахын тулд хүчин чармайлт гаргах шаардлагатай. Монгол Улс газар тариалан эрхлэхэд төдийлөн тохиромжтой уур амьсгалтай биш тул бүтээмжийн хувьд бусад орноос доогуур байгаа ч цаашид үйлдвэрлэлийн цар хүрээг тэлэхээс гадна ургацын хэмжээг нэмэгдүүлэх арга хэмжээг эрчимжүүлэх шаардлагатай байна. Тодруулбал, чанартай үрээр хангах тогтолцоог бий болгож, түргэтгэсэн тариалалтын технологи зэрэг зохистой тариалалтын арга техникийг түгээн дэлгэрүүлэхээс гадна өвлийн хүлэмжийн тариалалт, агуулах хадгалах байгууламжаар хүнсний ногооны нийлүүлэлтийн хугацааг уртасгах нь чухал юм. Түүнчлэн хот суурин газрын хүн амын хурдацтай өсөлтөөс шалтгаалан өөрчлөгдөж буй хүнсний бүтээгдэхүүнд хандах хүмүүсийн хандлага сонирхолыг харгалзан үнийн хувьд төдийгүй чанар, эрүүл ахуй,

бүтээгдэхүүний гарал үүсэл зэргээр импортын бүтээгдэхүүнээс ялгарах шаардлагатай болж байна.

- Мал аж ахуйн салбарын хувьд газар тариалангийн салбараас ялгаатай нь хэрхэн нэмүү өртөг шингээж, дотоодын хэрэглээ, экспортыг нэмэгдүүлэх вэ гэдэг нь гол асуудал юм. Экспортыг өргөжүүлэх үүднээс гол зах зээл болох Хятадаас гадна цаашид зах зээлийн хэмжээ улам тэлэх төлөвтэй Зүүн өмнөд Ази, Ойрхи Дорнод руу экспортоо өргөжүүлэх боломжтой. Олон улсын зах зээлийн чиг хандлага нь хүнс болон бүтээгдэхүүний аюулгүй найдвартай байдал, чанар, үнэ, үр ашгаас гадна тогтвортой байдал, байгаль орчинд ээлтэй байдал, мал амьтны ая тухтай байдал зэргийг хагргалзан үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний эрэлт хэрэгцээ нэмэгдэж байгаа тул цаашид эдгээр хүчин зүйлсийг харгалзан үзсэн хүнс, бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг дэмжих нь чухал болох бизээ.
- Дээр дурдсан хөгжлийн чиглэлд үндэслэн ЖАЙКА төслийн баг нь ХХААХҮЯ, ЭЗХЯ, эрдэм шинжилгээний байгууллага, ХАА-н салбарын хувийн хэвшлийн байгууллагууд, хөгжлийн түншүүд зэрэг байгууллагуудтай хамтран ажиллахын зэрэгцээ суурь судалгаа, туршилтын төслүүдийг хэрэгжүүлснээр олж авсан мэдлэг мэдээлэл, туршлага сургамжид үндэслэн ХАА-н салбарын стратегийн өртгийн сүлжээг хөгжүүлэх зоилготой энэхүү Мастер төлөвлөгөөг боловсруулаа. Энэхүү Мастер төлөвлөгөөг боловсруулах явцад дээр дурдсан холбогдох байгууллагууд, хүмүүстэй нягт хамтран хэлэлцэж, ХАА-н нэмүү өртгийн сүлжээг хөгжүүлэх чиглэлүүд болон үйл ажиллагааны төлөвлөгөөний агуулгыг судлан тодорхойлсон. Энэхүү Мастер төлөвлөгөөнд хөгжлийн 11 хөтөлбөр, тэдгээрийн хүрээнд 43 үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулан тусгаснаас 12-ыг нь гол хамтрагч байгууллага болох ХХААХҮЯ-наас нэн тэргүүнд хэрэгжүүлэх шаардлагатай үйл ажиллагаа хэмээн эрэмбэлэн сонгосон байна.
- Энэхүү Мастер төлөвлөгөөнд тусгагдсан Үйл ажиллагааны төлөвлөгөөг Монгол Улсын хөгжлийн бодлогын төлөвлөгөө болон түүний удирдлага хяналтын тухай хуульд үндэслэн боловсруулсан. Мөн Үйл ажиллагааны төлөвлөгөө тус бүрийг бие даасан төсөл болгон боловсруулж тусгасан. Үйл ажиллагааны төлөвлөгөөний төсвийг боловсруулахад тэргүүлэх чиглэл, хэрэгжүүлэх арга хэмжээнээс хамааран зохицуулалт хийх шаардлагатай болох ч хэрэгжилтийг уян хатан зохицуулах боломжтой байхаар тусгаж, тухайлбал Үйл ажиллагааны төлөвлөгөөний зөвхөн зарим бүрэлдэхүүн хэсэг болон үйл ажиллагааг хэсэгчлэн хэрэгжүүлэх ч боломжтой байхаар боловсруулсан. Өөрөөр хэлбэл, Үйл ажиллагааны төлөвлөгөөг тухайлсан бодлогын цар хүрээ болон үйл ажиллагаагаар хязгаарлагдсан төлөвлөгөө гэж үзэхгүй, харин түүнд тусгагдсан мэдээлэл, үйл ажиллагаанд тулгуурлан хэрэгжүүлэхийг санал болгож буй арга хэмжээний удирдамж гэж үзэх нь зүйтэй юм.
- Энэхүү Мастер төлөвлөгөөний төсөв боловсруулалт, хэрэгжилтийн тухайд зөвхөн улсын төсөвт найдах бус хөгжлийн түншүүд, хувийн хэвшлийн аж ахуйн нэгж байгууллагуудтай хамтран ажиллах нь хэрэгжих боломжийг нэмэгдүүлэх үүднээс нэн чухал юм. Үүний тулд Мастер төлөвлөгөөг хэрэгжүүлэх үндсэн байгууллага болох ХХААХҮЯ нь ХАА-н салбарын нэмүү өртгийн сүлжээг хөгжүүлэх чиглэлээр хөгжлийн түншүүд болон хувийн

хэвшлийн аж ахуйн нэгж байгууллагуудтай харилцах хамтрах боломжийг санаачлан, идэвхтэйгээр зохион байгуулж, хөгжлийн шалгуур үзүүлэлтүүдийн биелэлт, бодлогын зорилтуудыг хэрэгжүүлэх хамтын ажиллагааны тогтолцоог бий болгох шаардлагатай.

6.2 Зөвлөмж

Энэхүү Мастер төлөвлөгөөнд дэвшүүлсэн **“ХАА-н бүтээгдэхүүний зах зээлийн өрсөлдөх чадварыг бэхжүүлэх замаар Монгол улсад хүчирхэг ХАА-н үйлдвэрлэлийг бий болгох”** зорилгод Хүснэгт 5.2-т заасан хөгжлийн үзүүлэлтүүдэд 2025-2034 он хүртэлх 10 жилийн хугацаанд хүрэхийн тулд арга хэмжээг хэрэгжүүлэхдээ дараах зүйлсийг анхаарах шаардлагатай.

“Таван жилийн хөгжлийн үндсэн чиглэл” болон “Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр”-т Мастер төлөвлөгөөг тусгах

Энэхүү Мастер төлөвлөгөөг Монгол Улсын хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулинд үндэслэн боловсруулсан бөгөөд эрхзүйн байдлын хувьд тухайн хуульд зааснаар "Таван жилийн хөгжлийн үндсэн чиглэл" болон "Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр"-т уялдуулан тусгаж байж төлөвлөлтийн баримт бичиг гэсэн утгаа хадгална. Дараа дараагийн залгамжлах төлөвлөгөөнүүдийг боловсруулах зорилтот хугацаа нь эхнийх нь 2025-2029 он, дараагийнх нь 2024-2028 он бөгөөд аль алийг нь 2024 оноос боловсруулж эхлэх төлөвтэй байна.

Энэхүү Мастер төлөвлөгөөний хэрэгжүүлэх үндсэн байгууллага болох ХХААХҮЯ-аас Бодлого төлөвлөлтийн газар манлайлан бодлогын тэргүүлэх чиглэл, үйл ажиллагааны цар хүрээнд зохицуулалт хийж Мастер төлөвлөгөөг дунд болон урт хугацааны төлөвлөгөөнд тусгаж ажиллахыг шаргуу зөвлөж байна. Дээр дурдсанчлан энэхүү Мастер төлөвлөгөөний хүрээнд боловсруулсан Үйл ажиллагааны төлөвлөгөө нь тухайлсан бодлого, үйл ажиллагааны цар хүрээнд хязгаарлагдахгүй. ХАА-н салбарын нэмүү өртгийн сүлжээг хөгжүүлэхийн тулд авч хэрэгжүүлэх арга хэмжээний удирдамж гэж үзэж, уян хатан хандана гэдэгт найдаж байна.

Сайн туршлагыг өргөжүүлэн дэлгэрүүлэх

Энэхүү Мастер төлөвлөгөөг боловсруулах явцад Дэлхийн банк, НҮБ-ын ХХААБ, АХБ, ОУСК, ЮНИДО, ШХА, НҮБ, ЕХ, Монгол Улсын дотоодод ХАА салбарт санхүү, техникийн хамтын ажиллагаа явуулдаг хөгжлийн олон түншүүдийн төлөөлөлтэй уулзаж ярилцан, олон сайн туршлага нэгэнт бий болсоныг тодрууллаа. Энэхүү Мастер төлөвлөгөөнд дэвшүүлсэн Үйл ажиллагааны төлөвлөгөөнд эдгээр хөгжлийн түншүүдийн ХАА-н салбарт хамтран хэрэгжүүлсэн төслүүдийн үр дүнд бий болсон сайн туршлагад тулгуурлан боловсруулсан зүйлүүд ч бий. Үнэ цэнэтэй ололт амжилтыг сарниулан бүдгэрүүлэхгүйгээр амжилттай хэрэгжсэн хүчин зүйлүүдэд задлан шинжилгээ хийж, нэгтгэн боловсруулж дэлгэрүүлэх систем туйлын чухал гэдгийг дахин ухамсарлаж, цаашдын бодлого боловсруулалтдаа тусган ажиллана гэдэгт итгэлтэй байна.

FADPG-ийг идэвхжүүлэх

5.3.2-т дурдсанчлан хөгжлийн түншүүдийн хамтын ажиллагааг дэмжих, дэмжлэг үйл ажиллагааны чиглэлийг давхардуулахгүй байх, сайн туршлага зэрэг мэдлэг мэдээллээ хуваалцах, түүнчлэн юуны түрүүнд хөгжлийн түншүүдийн хүчин чармайлт, төрийн удирдах байгууллагын арга хэмжээтэй уялдуулсан хамтын ажиллагааг бэхжүүлэхийн тулд ХАА-н салбарын төрийн захиргааны төв байгууллага болох ХХААХҮЯ нь ХХААХТГ-ийн үйл ажиллагааг удирдан чиглүүлж, зохион байгуулахад санаачлагатай ажиллах нь юуны түрүүнд чухал юм. ХХААХҮЯ-ны Бодлого төлөвлөлтийн газар нь ажлын албыг хариуцахын зэрэгцээ шаардлагатай тохиололд Газар тариалангийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар, Мал аж ахуйн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар, Хөнгөн үйлдвэрийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар, Хүнсний үйлдвэрлэлийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар зэрэг холбогдох газар хэлтсийн хариуцсан ажилтнууд мөн оролцож, илүү бодитой, хэрэгжихүйц бодлого боловсруулж хэрэгжүүлэхийн төлөөх хэлэлцүүлгийн талбар болгож ажиллахыг санал болгож байна.

Төрийн захиргааны удирдлагын тогтолцоо

Энэхүү Мастер төлөвлөгөөг боловсруулах явцад ХХААХҮЯ болон ЭЗХЯ-ны холбогдох албаны хүмүүстэй биетээр болон цахимаар уулзаж ярилцлаа. Хариуцсан мэргэжилтэнүүд өөр өөрийн хариуцсан салбарын талаар мэдлэг туршлага арвинтай, Мастер төлөвлөгөө боловсруулах явцад ач тустай олон санал шүүмж хүлээн авсан. Нөгөөтэйгүүр гадаад томилолт, хувийн асуудлаас шалтгаалж ажлаа хийхгүй байгаа зэрэг тохиолдолд яаман дотроо орлох хүн байхгүй, эсвэл ямар нэг шалтгаанаар ажлаа өгсөн бол тухайн хүний хуримтлуулсан мэдлэг мэдээлэл, аргэ техникийг дараагийн хүнд дамжуулан хүлээлгэж өгдөггүй тохиолдол ч гарсан. Хязгаарлагдмал орон тоо, төсвийн хүрээнд захиргааны ажил явагддаг гэдгийг сайн ойлгож хэдий ч газар хэлтсүүдийн хариуцсан ажил үүргийг тухайн газар хэлтсийн бүх ажилтан хариуцан гүйцэтгэнэ гэсэн урьдач үндэслэлээр асуудал хариуцсан үндсэн болон орлох ажилтнуудыг томилж, байршуулах зэргээр илүү зохион байгуулалттай уян хатан удирдлагын тогтолцоог бий болгохыг зөвлөмж болгож байна.

Хувийн хэвшилтэй хамтран ажиллах

Бусад оронтой харьцуулахад дотоодын зах зээлийн хэмжээ багатай Монгол Улсын хувьд ХАА-н бүтээгдэхүүний экспортыг нэмэгдүүлэх нь тус салбарыг хөгжүүлэхэд онцгой чухал асуудал юм. Ялангуяа хүнсний экспортын тухайд импорт экспортын нөхцөл, стандартыг зорьсон улс орнуудтай зөвшилцөн тохирох зэрэг асуудал нэн чухал хэдий ч ХХААХҮЯ-нд эдгээр асуудлыг зохих ёсоор хариуцан ажиллах хүн хүчний нөөц дутмаг байдаг гэж ойлгож байна. Бодит жишээ, ЖАЙКА-гийн төслийн багийн зүгээс Хятад руу зөгийн бал экспортлох бэлтгэл ажлын хүрээнд яамны ажилтнуудтай хамтран ажилласан боловч Хятадын талаас тавьсан асуулгад хариу өгөхөд ихээхэн хугацаа зарцуулах зэргээр удааширч төсөл хэрэгжих хугацаанд харамсалтай нь энэ ажил биелээгүй. Дахин хэлэхэд ХАА-н бүтээгдэхүүний экспортыг өргөжүүлэх нь Монгол Улсын ХАА-н салбарын хөгжилд нэн чухал арга хэмжээ бөгөөд үүнийг эрчимжүүлэхийн тулд ХХААХҮЯ-нд гадаад хэлэлцээр хариуцсан ажлын алба нэгжийг бэхжүүлэх зайлшгүй шаардлагатай байна. Үүний үндсэн дээр ХАА-н бүтээгдэхүүн экспортлох

зорилготой хувийн хэвшлийн аж ахуйн нэгж, байгууллагуудтай хамтын ажиллагааг илүү сайжруулаын тулд экспортын чиглэлийн аж ахуйн нэгжүүдээс бүрдсэн аж үйлдвэрийн кластеруудыг хөгжүүлэх, экспортыг хөгжүүлэх чиглэлээр төр, хувийн хэвшил хамтран ажиллаж шаардлага бүрийг нэг нэгээр нь шийдвэрлэж, даван туулах тогтолцоог бий болгох шаардлагатай.